Монгол Улсын Үндэсний Номын Сан

Нийтийн номын сангуудын
тайлан 2014

Редактор: Д.Энхтунгалаг /МАЗЭШХ-ийн дарга /

Эмхэтгэсэн: Г.Гүнжинлхам /Ахлах аргазүйч /

Улаанбаатар хот

2015 он

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН -2014

Ред: Д.Энхтунгалаг /МАЗЭШХ-ийн дарга/

Эмхэтгэсэн: Г.Гүнжинлхам /Ахлах аргазүйч/

Хэвлэлийн хэмжээ

Хэвлэлийн эхийг "Содпресс" хэвлэлийн компанид бэлтгэж хэвлэв.

Улаанбаатар хот, 2015 он

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аймаг, нийслэлийн нийтийн номын сангууд жил бүр хийсэн ажлынхаа үр дүн, тайланг Үндэсний номын сангийн аргазүйн хэлтэст явуулсныг бид эмхтгэн, 11 дэх удаагаа та бүхэнд хүргэж байна.

Энэхүү “Нийтийн номын сангуудын тайлан” эмхтгэл нь үйлс нэгт нөхөд өөрсдийн ажлын амжилт, үр дүнг бусад номын сангуудтай харьцуулан судлах, харилцан туршлага солилцох, өдөр тутмын ажил болоод цаашдын төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

Та бүхний илгээсэн тайланг эмхтгэхийн зэрэгцээ номын сангийнхаа давуу, сул талд дүн шинжилгээ хийхэд хялбар байх үүднээс тайлан тус бүрээс номын сангийн гол үзүүлэлтэд харьцуулсан судалгааг хийж, схем, диаграммаар хавсаргалаа.

Хамтран ажилласанд талархлаа дэвшүүлье.

НОМЫН ЦАГААН БУЯН УЛАМ ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ.

Монгол улсын Үндэсний номын сан

Мэдээлэл-аргазүй, эрдэм шинжилгээний хэлтэс

Tel: 70-11-23-97

Website: www.nationallibrary.mn

Агуулга

Өмнөх үг 3
Монгол Улсын Үндэсний Номын Сангийн 2014 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийн ажлын тайлан 6
Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн 2014 оны үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний тайлан 44
Хүүхдийн Номын Ордны 2014 оны ажлын тайлан 65
Архангай аймгийн нийтийн номын сан мэдээллийн төвийн 2014 оны жилийн ажлын тайлан 127
Баян-Өлгий аймгийн нийтийн номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 147
Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 156
Булган аймгийн төв номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 177
Говь-Алтай аймгийн нийтийн номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 209
Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 215
Дархан-Уул аймгийн төв номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 228
Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын Ордоны 2014 онд хийсэн ажлын тайлан 237
Дорноговь аймгийн төв номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 248
Дорнод аймгийн төв номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 256
Дундговь аймгийн төв номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 274
Завхан аймгийн төв номын сангийн 2014 онд хийсэн ажлын тайлан 279
Орхон аймгийн номын төвийн 2014 онд

хийсэн ажлын тайлан 304
Өмнөговь аймгийн төв номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 356
Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 375
Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 389
Төв аймгийн нийтийн номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 418
Увс аймгийн төв номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 427
Ховд аймгийн нийтийн номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 456
Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 500
Хэнтий аймгийн нийтийн номын сангийн 2014 онд
хийсэн ажлын тайлан 533

Аймгуудын судалгаа -2014 552

ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)* ***бүрээр хүрэх түвшин***	***Жинхэнэ гүйцэтгэл*** *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)*
1	2
Нэг: "Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, нээлттэй хүртээмжтэй мэдээлллээр үйлчлэх" гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	
1. "Сан хөмрөгтөө судалгаа хийж, шинэ ном хэвлэлээр баяжуулах, номын сангийн арга ажиллагаанд оруулах, уншигчдад мэдээллээр үйлчлэх ажлын хүрээнд: 1.1.Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлт, бэлэг, хандив, солилцоогоор шинэ ном авах, шинжлэх ухааны төрөл салбараар ангилах, дансанд бүртгэх, ажиллах карт бичих, Архив, Бэлтгэл фондыг шинэ номоор бүрдүүлэх, Харилцаат номын сангуудад ном илгээх, хүлээн авах	1.1. Нийт: 4740 ширхэг ном авахаас 5131 ширхэг 1662 нэрийн номоор сан хөмрөгийн бүрдүүлэлт хийсэн байна. 108.2% ➢ Шинээр 2640 ном худалдан авахаас 657 нэрийн 2585 ширхэг 43664790 төгрөгийн ном худалдан авч, 98% ➢ Бэлгийн журмаар 2000 ном авахаас 952 нэрийн 2475 ширхэг 28736664 төгрөгийн ном авч, 124% ➢ Нөхөн бүрдүүлэлтээр100 ном авахаас 53 нэрийн 71 ширхэг 25613660 төгрөгийн ном худалдан авч, 71% ➢ Эрдмийн зэрэг горилсон132 диссертац, 5 хураангуй, 44 CD хүлээн авч фактурлан ангилагчид шилжүүлэв. ➢ 4 8844 004 төгрөгийн 48 нэрийн сонин, 50 нэрийн сэтгүүл захиалсан. ➢ Тогтмол хэвлэлийг захиалгын дагуу хүлээн авч, холбогдох хэсэгт бүртгэн шилжүүлж, 5 нэрийн сонинг цахим хэлбэрээр уншуулж байна. ➢ ССАЖ-ын сайдын 2014 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/131 дүгээр тушаалын дагуу "Шилдэг ном-2013"-т шалгарсан нийт 49 нэрийн 4155 ширхэг 48.000.900 төгрөгийн ном хүлээн авахаас 47 нэрийн 4098 ширхэг 46.518.900 төгрөгийн номыг зохиогч, байгууллагуудаас хүлээн авч, хуваарилалтын дагуу аймгуудын номын сангуудад хүлээлгэн өглөө. ➢ Гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудад 3447140 төгрөгийн 105 нэрийн 295 ном илгээж, 6715050 төгрөгийн 282 нэрийн 302 ном, 180310 төгрөгийн 12 нэрийн 802 сонин, 969030 төгрөгийн 119 нэрийн 580 сэтгүүл хүлээж авсан. Нийт 3 447 140төгрөгийн ном илгээж, 7 864 390 төгрөгийн ном, хэвлэл хүлээн авлаа.

- Бүрдүүлэлтээр ирсэн номыг шинжлэх ухааны төрөл салбараар ангилж, дансалж бүртгэнэ. - Бүрдүүлэн авсан номыг ажиллана. - Бүрдүүлэлтээр ирсэн номонд карт бичиж, байрлуулна. - Архивынболон бэлтгэл фондыг шинэ номоорбүрдүүлнэ. 2014 он, жилийн туршид - Шинэ ном авах- 4740, Ангилах, данслах – 5000, Ажиллах – 5000, Карт бичих, байрлуулах – 7500, Харилцаат номын санд илгээх ном– 300, хүлээн авах ном-300, сонин – 1000, сэтгүүл-300 /ном худалдан авах зардлаас татагдсан тул төлөвлөгөөг багасгасан/	-Хандиваар ном цуглуулах ажлыг өрнүүлж, ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэл, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Хууль зүйн хүрээлэн, Ховд аймгийн Алтай сумын ЗДТГ, Mongolian mining journal сэтгүүлийн газраас 562 ном, 1227 сэтгүүлийг хүлээн авлаа. Эдгээрээс номын сангийн холбогдох фондуудад 72 ном, 16 нэрийн 961 сэтгүүл, “Ардын элч” явуулын номын санд 176 ном, ХУД-ийн “Албан бус боловсролын төв”-д 190 ном, 6 сэтгүүл, СХД-ийн 121-р сургуульд 50 ном, 12 нэрийн 260 сэтгүүл, Хэнтий аймгийн Баян-Адрага сумын номын санд 32 ном, “Хонгор нутаг” ТББ-ын номын санд 114 номыг хүсэлтийн дагуу хүлээлгэн өглөө. -Соёл Урлагийг хөгжүүлэх сангаас нийт 7 нэрийн 4539 ширхэг ном хүлээн авч, аймаг, орон нутгийн номын сангуудад түгээлээ. -Хэл зохиолын хүрээлэн, Археологийн хүрээлэн, Математикийн хүрээлэн зэрэг 15 хүрээлэнгүүдэд албан бичиг илгээж, эрдэм шинжилгээний бүтээлээс Архивын сан хөмрөгийг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар боллоо. Мөн Сэлэнгэпресс, Нэпко, Азийн сангийн Монголд зориулсан ном хөтөлбөр, Номын коллекторХХК зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. - Төрийн өмчийн Хорооны 2014 оны 06-р сарын 26-ны өдрийн 359 дүгээр тогтоолын хавсралт, Гаалийн Ерөнхий газарт хураагдаж, улсын орлого болсон, ССАЖЯ-ны харьяа байгууллагуудад балансаас балансад шилжүүлж байгаа Гурван суут судар болон 8 ш модон барыг хүлээн авлаа. - 4860 ном ангилахаас 2722 нэрийн 5059 ширхэг ном ангилж,*104%* • Сонин, сэтгүүлийн Zotera програмд 1226 карт шивж оруулсан. - 4950 ном данслахаас 2020 нэрийн 5269 ширхэг ном дансалж,*106%* • Бэлтгэл фондын нэгбүрчилсэн бүртгэлийг электрон хэлбэрт оруулах ажил хийгдэж, 22844нэрийн 127763номыг оруулсан • ТӨХ-ны зөвшөөрлийг үндэслэн гарсан захирлын 2014 оны 5 сарын 5-ны 18 тоот тушаалын дагуу номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 162 нэрийн 499662,73 төгрөгийн балансын үнэ бүхий номыг ерөнхий данснаас хасч, 152 ширхэг 1476500 төгрөгийн үнэ бүхий номыг бүртгэн авч, орлого зарлагыг холбогдох нэгдсэн бүртгэлд тусгалаа. - 4860 ном ажиллахаас 1997 нэрийн 5116 ширхэг ном ажиллаж, 105% Үүнд: худалдааны 1095 нэрийн 2354ш, солилцооны 251 нэрийн 302ш, бэлгийн 1295 нэрийн 2255ш, нөхөн бүрдүүлэлтийн 50 нэрийн 68ш, 132 нэрийн 137 ширхэг диссертац, хураангуй, CD-г тус тус ажиллав. • Монгол номын фондод шинээр ирсэн 655 нэрийн 1709 номын, 58 нэрийн 60 ширхэг диссертац, хураангуй, CD-ний мэдээллийг компьютерт шивж, бар код наан шилжүүлжээ.

	7760 ширхэг карт бичихээс 8000 ширхэг карт бичиж, 103% Үүнд: монгол 1128 нэрийн 2987 номонд 3784ш, өрнө дахины 284 нэрийн 535 номонд 1236ш, монгол судлалын 181 нэрийн 201 номонд 658ш, архивын 1116 нэрийн 1227 номонд 2322ш картыг тус тус бичив. Каталогийн ажлын талаар: - Шинээр 6839 карт байрлуулав. Үүнд: Монгол номын 3780ш, өрнө дахины 1290ш, монгол судлалын 231ш, диссертацийн 374ш, архивын 1164ш карт; - 26816 картанд редакц хийлээ.Үүнд: монгол ТАК-26-38, ҮДК – 1-5, 217-225, 312-318, орос ТАК – 74-78, 51, диссертацийн орос ҮДК А-Я картыг данс, фонд, электрон каталогтой тулгаж редакц хийв. - 7410 карт шинэчлэн хуулав. Үүнд: албаны монгол судлалын Да – Ив, орос ҮДК – 1-5, 317, монгол ТАК – 26-37, орос ТАК 75-76, диссертацийн орос ҮДК А-Я шогол. - 1111 ялгагч шинэчлэн бичив. Үүнд: албаны орос үсгийн 82-111, орос ҮДК1-8 217-225, 312-318, 523-528, орос ТАК 59-62, 65-66, орос ББК 515, 181, монгол ТАК 84-95, 111, диссертацийн орос ҮДК А-Я шогол;Архив ба бэлтгэл фондын ажлын талаар: - Архивт шинээр 1127ном хүлээн авч байрлууллаа. /103%/ Үүнд: (худалдааны 314 нэрийн 362ш, бэлгийн 324 нэрийн 356ш, нөхөн бүрдүүлэлтийн 11 нэрийн 12ш) - Архивт 99 нэрийн шинэ тогтмол хэвлэл хүлээн авахаас 48 нэрийн сонин, 51 нэрийн сэтгүүл хүлээн авч байрлуулан /100%/ Архивын 276 нэгж тогтмол хэвлэлийг хавтаслуулж хүлээн авлаа. /үүнээс: 18 нэрийн 144 нэгж сэтгүүл, 30 нэрийн 132 нэгж сонин.,/ - Бэлтгэл фондод шинээр 44 нэрийн 159 ш ном, 1 нэрийн 10 CD хүлээн авлаа. -Бэлтгэл фондоос захирлын зөвшөөрлийн дагуу 45 нэрийн 1099510 төгрөг 15 мөнгөний үнэ бүхий 159 ш ном зарлагадаж, баримтыг бүртгэлийн номын санчид өгч, дансанд тэмдэглэгээ хийлгэв. - 39 нэрийн 128 нэгж сонинд ялгагч хийж байрлуулав. -ССАЖЯ-аас ирсэн 10ш төмөр тавиурыг угсарч, орон нутгийн сонин болон өдөр тутмын задгай сонингуудыг байрлууллаа. -Архив фондонд Хууль зүйн хүрээлэнгээс хандивласан 15 нэрийн 1171 ш сэтгүүлийг хүлээн авч, карт бичиж байрлуулав. Хяналтын тооллогын талаар: - Захирлын 2014 оны 01-р сарын 17-ны 3 тоот тушаалыг үндэслэн бэлтгэл фондын нэгбүрчилсэн бүртгэлийг электрон хэлбэрт оруулан дансан дахь ном нэг бүрийг шалгаж, бүртгэл хөтлөлтийн алдааг цэгцлэн шивэх ажлыг хийж дууслаа.

1.2. Номын сангийн уламжлалт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, уншлагын танхимуудаар чанартай үйлчилгээ үзүүлэх 1.2.1.Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимаар журмын дагуу 6000 уншигч, судлаачдад 20.000 номоор 1.2.2. Их уншлагын танхимаар уншигчдад үйлчилнэ. /42000 уншигчдад 110.000 номоор/ - Солонгос мэдээллийн төв, Тогтмол хэвлэл, интернэт болон төлбөртэй үйлчилгээний танхимуудаар үйлчилнэ./3350 уншигчдад/ 1.2.3. Уншигч үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах, санал хүсэлтийг судлах, шийдвэрлэх/4 удаа/ 2014 он, жилийн турш	- Захирлын 2014 оны 04-р сарын 04-ний А/12 тоот тушаалын дагуу Монгол судлал, гар бичмэл номын фондыг тоолж дуусгалаа. Тооллогоор нийт 57550 ширхэг ном,үүнд: гар бичмэл 21149 ном, монгол судлалын 22828 ширхэг ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлүүд болон хураангуй 13574 номыг тоолохоор ажлын 3 хэсэгт хуваагдаж, номын сангийн дүрэм, журам, аргачлалын дагуу тоолон ажлын гүйцэтгэлийн тайланг Захиргааны зөвлөлийн хуралд оруулан танилцууллаа. 1.2.Тайлангийн хугацаанд 50800 ирцэд 141640 ном хэвлэл олгож үйлчлэхээс 54455 ирцэд(107.2%)162554 ном, хэвлэл олгож (114.8%) үйлчиллээ. 1.2.1.Их уншлагын танхим 43261 уншигчдад 96416 ном хэвлэлээр, Ерөнхийлөгчийн нэрэмжит танхим 7333 уншигчдад 23072 номоор үйлчилсэн ба 1222 гар бичмэл номоор үйлчилж, 1276 хүнд аман лавлагаа өгсөн. 1.2.2.Солонгос мэдээллийн төв 657 уншигчдад 2231 ном хэвлэлээр үйлчилж, 657 хүнд аман лавлагаа өгсөн. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 6 удаа, мөн Солонгос ном хэвлэлийг сурталчлах зорилгоор 2013-2014 оны хооронд ирсэн шинэ ном, сэтгүүлүүдээр 9 удаа үзэсгэлэн гарган сурталчилсан. Солонгос мэдээллийн төвийн 4101 ширхэг ном, 393 DVD, 184шномын CD, 94 толь бичиг, 260 англи хэл дээрх номуудыг сайн дурын ажилтан Jeoung Hwa-тай хамтран шинээр дансалж, ангилан, техник ажиллагаа хийж буцаан байрлуулсан. Солонгосын Үндэсний номын сантай тогтмол харилцан 221 шинэ номоор фондоо баяжуулж, номын техник ажиллагаа хийв. -Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар 2582 уншигчдад 17199 сонин сэтгүүлээр, интернэт танхимаар 622 уншигчдад тус тус үйлчиллээ. Хууль зүйн хүрээлэнтэй хамтарч ажилласны дүнд “Хууль дээдлэх ёс”, “Хууль зүйн мэдээллийн эмхтгэл” сэтгүүлүүдийг үнэ төлбөргүй захиалан авч үйлчлэх нөхцөлийг бүрдүүлсэн. -2448 уншигчид үнэмлэх сунгалт хийж, 4610 уншигчдад шинэ үнэмлэх нээв. Уншигчдад шинэчилсэн үнэмлэх олголт ИУ-2641ш., ЭШ-235 ширхэгийг тус тус олгож үйлчилсэн ба шинээр үнэмлэх нээлгэж буй уншигчдад лавламж зөвлөгөө өгч ажиллалаа. -Байгууллага хоорондын номын түр солилцоогоор үйлчлэх тухай Хамтын гэрээний төслийг шинэчлэн боловсруулж батлуулан, ном солилцооны гэрээг 6 байгууллага, их дээд сургуулийн номын сантай хийв. /ХААИС, Улаанбаатар хотын музей, Нийгмийн ухааны дээд сургууль, Отгонтэнгэр их сургууль, Техник технологийн их сургууль, Соёл урлаг судлалын хүрээлэн/ 1.2.3. Шинээр үнэмлэх нээлгэсэн 50 уншигчийн дунд судалгаа явууллаа. Мөн уншигчдаас санал авах хайрцгийг давхар бүрт ажиллуулж, захиргааны ажилтнууд 62 санал хүсэлттэй танилцан шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

1.3.Алслагдсан иргэдийн эрэлт хэрэгцээг судлах, шинэ ном хэвлэл, мэдээллээр үйлчлэх 1.3.1.Явуулын номын сангийн үйлчилгээг алслагдсан дүүргийн иргэд, хорих анги, хилийн заставын уншигчдад хүргэнэ. /8 байгууллагад/ 1.3.2. Явуулын номын сангийн үйлчилгээг сурталчлах, ном хандивлах арга хэмжээг зохион байгуулж, сан хөмрөгийг баяжуулна. 2014 он, жилийн туршид 1.4. Номын соёл, уламжлал, ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах 1.4.1. Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Номын баяр”-ыг зохион байгуулахад оролцоно. /ахмад номын санчдыг алдаршуулах, эртний, орчин үеийн ном судрыг сурталчлах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулна./ 2014 он, 9-р сард 1.4.2.“Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг ССАЖЯ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулна. 2014 он, 5-р сарын 15-ны дотор	1.3.1.“Ардын элч” явуулын номын сан үйлчилгээг: - ШШГЕГ-ын 409 дүгээр анги, Дундговь, Архангай, Дархан – Уул, Орхон, Хэнтий, Дорнод аймгуудад үйлчилгээ үзүүлсэн ба БЗД-ийн болон ХУД-ийн Албан бус насан туршийн боловсролын төв, БЗД-т байрлах “Нобелийн шагналтнууд”- Хүүхдийн номын сан төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хөдөө орон нутгуудад явуулын номын сангийн үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ номын үзэсгэлэн гаргаж, үндэсний бичиг үсгийг сурталчлах төрөл бүрийн арга хэмжээг Аймгийн төв номын сангуудтай нь хамтран зохион байгууллаа. 1.3.2.Хандивын үйл ажиллагааны хүрээнд: - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвд явуулын номын сангаас 50 гаруй ном хэвлэлийг хандивлалаа. - БЗД-ийн болон ХУД-ийн Албан бус насан туршийн боловсролын төвүүдэд57 ширхэг номыг хандиваар олгосон. -Хууль зүйн хүрээлэнгээс “Ардын элч” явуулын номын санд 92ширхэг номыг хандиваар авч уншигчдад үйлчиллээ. 1.4.Ном соёлын арга хэмжээг олон нийтэд сурталчлах, хүргэх ажлын хүрээнд: 1.4.1. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Номын баяр”-ыг 2014 оны 09 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулав. Арга хэмжээний хүрээнд:Зохиолч-уншигчдын уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд Ардын уран зохиолч Д.Гармаа, СГЗ Б.Монголхүү, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Ц.Түмэнбаяр, СУИС-ийн СБС-ийн оюутнууд, сонирхогчид, номын санчид нийт 45 гаруй хүн оролцож харилцан ярилцаж, сонирхсон асуултдаа хариулт авлаа. Арга хэмжээг багш Алтан-Очир хөтлөн явуулсан ба уулзалтын үеэр зохиолчдын уран бүтээлийн үзэсгэлэн, илтгэл бэлтгэж сонирхуулав. Номын баярт зориулсан “Ардын уран зохиолчдын бүтээлийн дээжсээс” номын үзэсгэлэнг Чингисийн талбайд гарган сурталчилж, ном зүйн тойм яриа,“Номын баяр”-ын үйл ажиллагаанд орон нутгаас ирсэн номын санчдын судалгаа авах, олон нийтэд “Уншсан номын тэмдэглэл”, “Ном унших ач тус”, “Ном унших арга, уншлагын соёл” болон “Баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийн тухай 5 төрлийн зөвлөмж бэлтгэж мэдээллийн самбарт байрлуулах, оролцогсдод түгээх, үнэт ховор номын фондыг нийтэд үзүүлэн таниулах ажлуудыг хийв. 1.4.2.Үндэсний бичиг үсгийн баярыг 2014 оны 05-р сарын 02-03-ны өдрүүдэд “Монгол бичгийн хэрэглээг өргөжүүлье” уриатай тэмдэглэж, бичиг, соёлоо хүндэтгэх, ард олноо уриалах энхүү үйл ажиллагааг анх удаа Чингисийн талбайд өргөн тэмдэглэлээ.Баярын ажиллагаанд ССАЖЯ, МҮНС, Төрийн хэлний зөвлөл, МУИС-ийн МХСС, МУБИС, Үндэсний төв архив, Хотын төв номын сан, Хүүхдийн номын ордон, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Соёлын өвийн төв, “Хүмүүн бичиг”

	сонин, “Бичиг соёл” төв, “Номын ертөнц”, Монгол хэл соёлын хүрээлэн, Нийслэлийн 84-р дунд сургууль болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаас гадна эх хэлээ дээдлэгч төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран оролцож үйл ажиллагааг олон нийтэд хүргэсэн. Онлайн сурталчилгаанд анхаарч, номын сангийн “Web хуудас”-аар мэдээлэх, “Facebook хуудас”-ыг хөтөлж шинэ мэдээллээр хангах, мөн Чингисийн талбайд “Эх хэлээ хадгалж хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй вэ?” санал асуулга явууллаа. Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгууллаа: “Монголчуудын оюуны соёлын өв – Монгол бичиг” телевизийн нээлттэй хэлэлцүүлгийг ССАЖЯ, Үндэсний номын сан, TV-9 телевизтэй хамтран зохион байгуулж, “Ардын парламент” хэлэлцүүлэг, нэвтрүүлгээр олон нийтэд хүргэсэн. Хэлэлцүүлгийн гол зорилго нь төр засгаас монгол бичгийн талаар авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажилагаа, үр дүн, цаашид монгол бичгийн хэрэглээг өргөжүүлэх арга зам, тулгамдсан асуудлаа тодорхойлох, монгол бичгийн хөгжлийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх явдал байсан юм. Боловсрол телевизийн “Эх хэл бичгийн эзэд” нэвтрүүлэгт ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэл, МУИС-ийн хэл шинжлэлийн тэнхимийн эрхлэгч, доктор, проф. М.Баярсайхан, МУ-ын Гавьяат багш, докторпроф. Чой.Цэдэнбал, ХЗХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Б.Түвшинтөгс, “Хүмүүн бичиг” сонины эрхлэгч Б.Элбэгзаяа, уран бичээч, судлаач Д.Батбаяр, мөн эх бичиг судлаачид, оюутан залуус оролцлоо. Мөн тус телевизтэй хамтран бичиг үсгийн баярт оролцохоор орон нутгаас ирсэн хүүхдүүдийн дунд “Монгол бичиг, соёлын түүхээ хэн сайн мэдэх вэ” танин мэдэхүйн АХА нэвтрүүлгийг зохион явуулсан. - “Монгол бичгийн хэрэглээг өргөжүүлье” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, МУИС, МУБИС-ийн эрдэмтэн судлаачид, багш оюутнууд, хот, орон нутгийн номын санчид, уншигчид нийт 250 гаруй хүн оролцов. Хэл шинжлэлийн “Монгол бичгийн сургалтын өнөөгийн тулгамдсан асуудлууд”, “Хэвлэл мэдээлэл дэх монгол бичгийн хэрэглээг өргөжүүлье”, “Монгол уран бичлэг хийгээд бийрийн бичлэгийн шинэчлэлийн тухай”, “Монгол бичгийн хичээлээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь”, “Монгол бичиг заах бүтээлч аргуудаас“ зэрэг тулгамдсан асуудлаар эрдэмтэн, багш нар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүллээ. - “Үндэсний бичиг соёл” монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах улсын есдүгээр уралдаан /хот, орон нутгаас 600 гаруй монгол бичигтэн сурагч, оюутан, залуус оролцсон/явагдав. - 2013 оны шилдэг номыг орон нутгийн номын сангуудад гардуулах болон зохиолч, хэвлэн нийтлэгчдэд “Батламж гардуулах ёслол” хийв. - "Уран бичлэг-2014" уран бичлэгийн уралдааныг "Бичиг соёл" төвтэй хамтран зохион явууллаа.Уралдаанд Монголын анхны сэтгүүл болох "Шинэ толь" сэтгүүлийн “Түмэн зүйлийг бадруулж, элдэв эрдмийг нэвтрүүлнэ.” гэсэн уриаг

1.4.2."Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг ССАЖЯ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.	уран бичээчид бичиж ур чадвараараа өрсөлдсөн. Тус уралдаанд: - Тэргүүн байр Э.Анхбаяр/чөлөөт уран бүтээлч/, - Дэд байр О.Ням-Очир/Бичиг соёл төв/, - Гутгаар байр Б.Билгүүн/23-р сургууль 11^{В} ангийн сурагч/ нар тус тус эзэлсэн. - "Монголчуудын бичиг үсгийн дурсгал", 1910-1940 оны эхэн үе хүртэлх хугацаанд монгол бичгээр хэвлэгдсэн болон гар бичмэл номын "Түмэн зүйлийг бадруулж, элдэв эрдмийг нэвтрүүлсэн он жилүүд", "2013 оны Шилдэг номоор шалгарсан бүтээлүүд", "Шилдэг зохиолч, уран бүтээлчдийн гар бичмэл, эх нооргийн дээжээс" зэрэг үзэсгэлэн болон цахим үзэсгэлэнгүүдийг ард олонд дэлгэн үзүүлсэн.
1.4.2."Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг ССАЖЯ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.	- МУБИС-ийн Багшийн сургуулийн оюутнуудын дунд зарласан уран бичлэгийн уралдаанд шалгарсан бүтээлүүд, Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын сургууль болон нийслэлийн 84-р сургуулийн сурагчдын бүтээлүүдийг үзэсгэлэнд дэлгэлээ. - Чингисийн талбайд номын сан, Архивын газар, Хэл зохиолын хүрээлэн, Соёлын өвийн төв, МУИС, МУБИС зэрэг соёл, боловсрол ,шинжлэх ухааны байгууллагууд монгол бичгийг сурталчилсан үзэсгэлэнгүүд гаргаж, олон нийтэд дэлгэн үзүүллээ. -Үүнээс гадна орон нутгийн удирдлагууд, аймаг сумдын номын сангуудтай хамтран /Дундговь, Архангай, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, (Хөтөл хот), Орхон-Уул/ бичиг үсгийн баярыг зохион байгуулан, арга зүйн зөвлөгөө өгч, монгол бичгийн дурсгал, ховор номоор үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. - МУИС-ийн МХСС-тай хамтран Ардын багш Д.Чойжилсүрэнгийн нэрэмжит "Монгол бичгийн улсын уралдаан"-ыг их, дээд сургуулийн оюутнуудын дунд мэргэжлийн ба мэргэжлийн бус, төрийн албан хаагч, ЕБС-ийн монгол хэл, бичгийн багш гэсэн ангиллаар, Хүүхдийн номын ордонтой хамтран "Яруу сайхан Монгол хэл" хүүхдийн зохиолчдын өгүүллэгийн уран уншлагын анхдугаар уралдааныг тус тус зохион байгуулсан.

Номын сан, ном соёл, уламжлал, ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах	-Доктор Иржи Шиматай уулзалт хийв. - Үндэсний номын сан болон Чех ба Словакт сургууль төгсөгчдийн холбоо хамтран Чехийн монголч эрдэмтэн, элчин сайд асан, доктор Иржи Шиматай уулзалт зохион байгууллаа. Уулзалтанд Чех Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Ивана Гроллова, элчин сайд асан П.Нямаа, зохиолч Одончимэд, Л.Хуушаан, Л.Дашням доктор Мөөмөө болон Чех-Монголын найрамдлын нийгэмлэгийн гишүүд, соёл урлагийн төлөөлөгчид, уншигчид оролцлоо. Доктор Иржи Шима нь өөрийн амьдрал, монгол судлалтай хэрхэн холбогдсон, зохиол бүтээлийнхээ тухай, Монгол-Чехийн соёлын харилцааны талаар дэлгэрэнгүй ярьж, дурсамжаасаа хуваалцлаа. Мөн Чех улсад “Монголын анд нөхдийн нийгэмлэг”-ийг байгуулан ажиллаж, хоёр орны ард түмний холбоо, соёлын харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа монгол судлалын нэрт эрдэмтэн юм. - Жет сургалтын төвтэй хамтран “Англи хэл сурахыг хүссэн хүн бүрийг бид дэмжинэ” уриан дор “Англи хэлний өдөрлөг”-ийг 2014 оны 02 дугаар сарын 12-нд Нийтийн уншлагын танхим, Солонгос мэдээллийн төв, Турк номын танхимуудад тус тус зохион явууллаа. Өдөрлөгийн хүрээнд Жет төвийн англи хэлний сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах, сургалтанд бүртгүүлэх, гадаадад суралцах, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах болон англи хэлний ярианы чадвараа хэрхэн хөгжүүлэх талаар зөвлөгөө авах, англи хэлний бүх түвшний танилцуулах /демо/ жишиг хичээлүүд заах, мөн цаг тутамд англи хэлний түвшин тогтоох шалгалт үнэ төлбөргүй авах, түүнчлэн бэлэгтэй, сюрпризтэй хөгжөөнт тэмцээн явуулах зэрэг үйл ажиллагаа болж өнгөрлөө. Өдөрлөгийн арга хэмжээнд номын сангийн уншигч, оюутан залуучууд, номын санчид нийт 200-аад сонирхогч хүмүүс оролцож хүссэн мэдээллээ авлаа. “Монголчууд ба газрын зураг, газрын нэрийн түүх-соёлын судалгаа олон улсын хуралд зориулсан үзэсгэлэн: “Монголчууд ба газрын зураг, газрын нэрийн түүх-соёлын судалгаа” сэдэвт Олон Улсын хуралд зориулан “Монгол газар нутгийн нэр судлалын бүтээлээс” нэртэй үзэсгэлэнг зохион байгууллаа. Үзэсгэлэнд Монгол судлал, гар бичмэл номын фондод хадгалагдаж буй 1780-1926 оныг хамарсан “Сэцэн хан аймгийн Үйзэн бэйсийн нутгийн зураг”, “Хөвсгөлийн дотоод шугамын долоон харуулын товч зураг” зэрэг 50 гаруй хошуу нутгийн зураг, мөн МУИС-ийн багш Э.Равданы дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр судлалын бүтээлийн үзэсгэлэнг гаргаж олон нийтэд дэлгэн үзүүллээ.

Номын сан, ном соёл, уламжлал, ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах	- Юнеско-гийн Монголын Үндэсний Комисс, Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран “Дэлхийн яруу найргийн өдөр”-т зориулсан “Яруу найраг хүмүүний оршихуйн үнэт зүйл мөн” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, Юнеско-ийн Монголын Үндэсний Комиссийн Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Жаргалсайхан, ШУА-ийн ХЗХ-ийн захирал, академич Л.Болд нар нээж үг хэллээ. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Утга зохиолын секторын эрхлэгч, доктор /Sc.D/ С.Байгалсайхан илтгэл тавьж, илтгэлтэй холбогдуулан СГЗ эрдэмтэн, зохиолч Д.Цэдэв, СГЗ, яруу найрагч Г.Мэнд-Ооёо, СГЗ, судлаач Я.Ганбаатар нар яруу найргийн тухай ярилцлага өрнүүллээ. Юнеско-гийн Ерөнхий захирал Ирина Бокова Дэлхийн яруу найргийн өдөрт зориулан илгээлт ирүүлснийг Юнеско-гийн МҮК-ийн мэргэжилтэн Ж.Уянга уншиж танилцуулсан. Уулзалт, хэлэлцүүлэгт Гурван эрдэм дээд сургууль, СУИС-ийн СБСургууль, утга зохиол, хэл шинжлэлийн чиглэлээр суралцдаг оюутнууд, нийслэлийн 52, 45-р дунд сургуулийн сурагчид, уншигчид, эрдэмтэн судлаач нийт 100 гаруй хүн оролцлоо. Уулзалт хэлэлцүүлэгтэй холбогдуулан зохиолчдын номын үзэсгэлэн гаргаж, сурталчлав. - ССАЖЯ-аас Чингисийн талбайд зохион байгуулсан “Нээлттэй мэдээллийн өдөрлөг”-т номын сангаа сурталчилсан төрөл бүрийн үйл ажиллагааг зохион явууллаа.Үүнд: - Үндэсний номын сангийн тухай реклам сурталчилгааг TV-5, TV-9 телевизээр нийт 20 удаа - Байгууллагын 2013 оны ажлын тайлан, бусад мэдээллийг видео хэлбэрээр - “Үндэсний номын сангаас эрхлэн гаргасан бүтээлийн дээжсээс” үзэсгэлэн - “Үлэмж цаглашгүй өвгүүд” баримтат кино болон гар бичмэл үнэт ном судрын цахим үзэсгэлэн - Номын сангийн үйлчилгээний талаар мэдээлэл сурталчилгаа - Монгол бичгээрх ном судрыг уншиж өгөх үйлчилгээ зэрэг олон арга хэмжээг зохион байгууллаа. - ОХУ-ын “Буриад Улсын зохиолч А.С. Гатаповын “Тэмүжин” 2 боть номын нээлт боллоо. Уг арга хэмжээнд Монгол Улсын ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэл, Буриад Улсын Соёлын Сайд Т.Г.Цыбиков,ССАЖЯ-ны Соёл Урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Баяраа, “НЕПКО” хэвлэлийн газрын захирал Баабар, “НЕПКО” хэвлэлийн газрын гүйцэтгэгч захирал, зохиолч, сэтгүүлч Б.Цэнддоо, Буриад улсын Үндэсний номын сангийн орлогч захиралЖ.Ч.Дымчикова, Улаанбаатар Их сургуулийн захирал, доктор, профессор С.Байгалсайхан, зохиолч, яруу найрагч Л.Дашням, яруу найрагч Л.Хуушаан нарын нэр хүндтэй хүмүүс оролцож, “Тэмүжин” номын тухай санал сэтгэгдлээ хуваалцлаа.

	Түүнчлэн Буриад Улсын Соёлын яамны соёл урлагийн хэлтсийн дарга Т.Б.Дугарова, Дуурь бүжгийн театрын захирал О.В.Цыбикдоржиева, Улсын филармонийн захирал Н.О.Балсунаева, Хүүхэлдэйн театрын дарга Б.Г.Дашидоржиева, Буриад Улсаас Монгол улсад суугаа байнгын төлөөлөгчийн газрын зөвлөх Б.Ч.Хасаранов нар оролцлоо. Энэхүү ёслолыг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт дуун хөрвүүлэгч, зохиолч, судлаач Го.Аким өөрийн биеэр хөтөлж, зохиолч А.Гатапов гарын үсэгтэй номоо зочдод бэлэглэлээ. -Хүний эрхийн Олон Улсын өдөрт зориулсан “Хүний эрхийн боловсролыг түгээх нь” уулзалт, хэлэлцүүлгийг ХЭҮК, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж “Хүний эрхийн боловсрол”, МҮНС-ийн захирал А.Нансалмаа “Номын сангуудын оролцоо” зэрэг илтгэлүүдийг тавилаа. Илтгэлтэй холбогдуулан хүний эрхийн боловсролыг түгээхэд номын сангуудын хувь нэмэр, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал бодлоо солилцов. Үйл ажиллагааны хүрээнд нийслэлийн номын сангуудад ном товхимол хандивлах ажиллагаа болж, МҮНС, ХТНС, түүний салбарууд, ИДС-ийн номын сангуудхүний эрхийн боловсролын тухай шинэ ном хэвлэлийг гардан авлаа. - Номын нээлт болов. УБИС, МҮНС хамтран Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Монголын орчин үеийн уран зохиолын түүх”: 1980-2000 онуудыг хамарсан 4 боть номын нээлтийн ажиллагаа болж, тус арга хэмжээнд 60-аад хүн оролцлоо. -“Монгол бахархлын өдөр”-т зориулж ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал доктор, профессор С.Чулуун, ШУА-ийн түүхч, Түүхийн ухааны доктор Д.Өлзийбаатар, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч, СГЗ Д.Жамъян,“Академи авардс-2013” шилдэг кино зохиол, “Монголын Нирун” зохиолын шилдгийн шилдэг номын шагналт зохиолч Б.Шүүдэрцэцэг болон түүхэн сэдэвт ном зохиолыг туурвигчдыг уншигчдын хүсэлтээр урьж, зохиолч уншигчдын уулзалт зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд: Археологийн хүрээлэн болон Түүхийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж буй Хүннүгээс дундад зуун хүртэлх үеийн Монголын эзэнт гүрний археологийн үзмэрүүд, “Шүүдэр” продакшнаас үндэсний баатруудын хувцас, эд өлгийн зүйл болон ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран 60 гаруй төрлийн номоор үзэсгэлэн гаргаж, түүхэн зохиолуудын номын худалдааг зохион байгууллаа.

1.5.1.Номын сангийн ном хэвлэлийг уншигч олон нийтэд сурталчлах 1.5.1.Шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргана. /25 удаа/ 2014 он, жилийн туршид 1.5.2.Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг номын вэб сайтанд онлайнаар гаргаж сурталчилна. 2014 он, жилийн туршид 1.5.3.Шинэ номын баяр, зохиолч уншигчдын уулзалт зохион байгуулна. /4 удаа/ 2014 он, улирал бүр	1.5.1.Тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн арга хэмжээнд зориулан сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэнг нийт 43 удаа 3837 ном, сонин, сэтгүүлээр гарган сурталчилж МАЗЭШХ болон фондын хэлтэстэй тус тус хамтран ажиллалаа. Сэдэвчилсэн номын үзэсгэлэн ➢ Үндсэн хуулийн өдөрт – 61 ном ➢ Д.Сүхбаатарын мэндэлсний 120 жилийн ойд – 55 ном ➢ Багш нарын баярын өдөрт – 83 ном ➢ Сар шинийн баярт – 91 ном ➢ Олон Улсын эмэгтэйчүүдийн баярын өдөрт – 92 ном ➢ Монголын зэвсэгт хүчний баярын өдөрт – 98 ➢ Дэлхийн эрүүлийг хамгаалах өдөрт – 125 но ➢ Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт – 121 ном ➢ Үндэсний их баяр наадмын өдөрт – 88 ном ➢ Монголын Залуучуудын өдөрт – 102 ном ➢ Соёл, урлагийн ажилтны өдөрт – 128 ном ➢ Улс төрийн хэлмэгдэгсдийн өдөрт – 65 ном ➢ Ардын уран зохиолчдын бүтээлийн дээжсээс...- 130 ном ➢ Байгаль орчныг хамгаалах өдөрт – 96 ном ➢ Олон Улсын оюутны өдөрт – 115 ном ➢ Монголын бахархалын өдөрт – 110 ном ➢ Улс тунхагласны баярын өдөрт – 71 ном ➢ Олон Улсын хүний эрхийн өдөрт –187 ном ➢ Монгол газар нутгийн нэр судлалын бүтээлээс...- 120 ном ➢ Соёл, урлагийн ажилтны өдөрт – 128 ➢ Д.Гармаа, Б.Монголхүү, Ц.Түмэнбаяр нарын бүтээлээс – 68 ➢ Хамгийн хамгийн, бяцхан номын үзэсгэлэн – 132 ном / монгол, орос, хятад ➢ Монгол газар нутгийн нэр судлалын бүтээлээс...- 120 ном ➢ Залуу хүний заавал унших номууд- 64 ном ➢ Мод тарья -51 ном ➢ Дэлхийн яруу найргийн өдөрт – 76 ном ➢ Үндэсний номын сан- 93 жил - 84 ном ➢ Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын өдөрт - 85

	“Монголчуудын бичиг үсгийн дурсгал” сэдэвт электрон үзэсгэлэнг вэб сайтанд тавьж, уншигчдад зориулсан мэдээллийн самбарын танин мэдэхүйн буланд “Ном унших зөвлөмж”, “24 цагийн үйлчилгээтэй номын сан”, “Танин мэдэхүйн шилдэг 10 ном”, “Хүүхдүүддээ ном уншиж өгөх 9 шалтгаан” зэрэг нийт 12 материалыг бэлтгэн гаргаж сурталчиллаа. Хэвлэл мэдээллийн сурталчилгаа:Үндэсний бичиг үсгийн баяр, яруу найргийн өдөр, уншигч, зохиолчдын уулзалт зэрэг томоохон соёл олон нийтийн арга хэмжээг МҮОНРТ, UBS, TV5, TV9, MN25,ETV, Eagle, Боловсрол, Рояль телевиз, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан”, www.news.mnзэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр ярилцлага, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. - ССАЖЯ-тай хамтран “Монголчуудын оюуны соёлын өв – Монгол бичиг”” сэдвээр TV-9 телевизийн “Ардын парламент” нэвтрүүлэгт., TV-9 телевизтэй хамтран сурагчдын дунд “АХА” нэвтрүүлэгт., - Үндэсний номын сангийн үйл ажиллагааны талаар 2 удаагийн ярилцлагыг ETV, Ийгл телевизийн нэвтрүүлэгт., - Боловсролтелевизээр монгол бичгийн тухай “Нээлттэй хэлэлцүүлэг” болон “Эх – хэлний ээзд” нэвтрүүлэгт., -“Шунхан Данжуур”-ыг Судар бичгийн хүрээлэнд анх О.Жамъян залж ирэхдээ хийсэн гэрээ бичиг, гэрэлт хөшөөний талаар МҮОНРТВ-ийн Мэдээллийн хүрд агентлагт ярилцлага; -2-р суваг телевизийн “Цензургүй ярилцлага” нэвтрүүлгээр Үндэсний номын сангийн тухай, зохион байгуулагдаж буй үйл ажиллагаа, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын талаар ярилцлага; NTV, SBN, FM-107.5-д номын сангийн үйлчилгээний талаар., -Royal TV, TV9, TV5 телевизэд зохион байгуулагдаж буй үйл ажиллагааны талаар тайлбар мэдээ, ярилцлага., -9-р сарын 10-нд Энэтхэгийн Аль Зажира телевизэд Үндэсний номын сангийн сэргээн засварлалтын талаар ярилцлагыг тус тус өглөө. -Чингисийн талбайд зохион байгуулагдсан “Нээлттэй өдөрлөг”-өөр номын сангийн тухай шторкийг “Хасмедиа” компаниар хийлгэж, МҮОНРТ, TV5, UBS, Эх орон зэрэг телевизээр сурталчлав. -Номын сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодын 355 хүнд танилцуулж сурталчиллаа.
Хоёр: “Эрдэм шинжилгээ, арга зүйн удирдлагыг боловсронгуй болгох” стратегийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:	

2. Эх бичиг сурвалж судлал, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд: 2.1.Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх 2.1.1.“Эрдмийн зөвлөл”-ийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, ажиллана. 2014 он, жилийн туршид 2.1.2.Юнескогийн Монгол дахь Үндэсний Комисс, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Үндэсний Хороотой хамтран бүс нутгийн хөтөлбөрт 1-2 баримтат өвийн нэр дэвшүүлнэ. 2014.11.01-ний дотор 2.1.3. Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга О.Жамьяны 150 жилийн ойг зохион байгуулах ажилд оролцоно. 2014.11.20-ны дотор	2.1.1. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн хурлаар 2014 онд хийх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлж, Дэлхийн дурсамж хөтөлбөрийн үйл ажиллагаа болон гар бичмэл барын ном судар, манж номын каталог хийх судалгааны баг бүрдүүлэх асуудлуудыг хэлэлцэв. -Гар бичмэл, монгол судлалын фондоос гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагад хадгалагдаж буй монгол ном судрын номзүйн 23 ширхэг бүтээл, дэвтэрлэсэн болон сударчилсан 43 ширхэг гар бичмэл болон барын ном сударт эх бичгийн суурь судалгаа хийв. *Үүнд:* Үндэсний номын санд хадгалагдаж буй Ганжуур, Данжуур судрын судалгааны хүрээнд: - Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимд тоон хэлбэрээр Шунхан Данжуур судрын 7 ботийг судлах, - Монгол Ганжуур, Данжуур судар дахь Майдартай холбогдол бүхий зохиол бүтээлийн лавлагаа гаргах, - Төвд “Жалзэтэмбан ганжуур” судрын номзүй, суурь судалгаатай танилцаж 12 ботийн 79 номын гарчгийн тулгалт хийж, ном зүйн бүртгэл гаргах - “Банзрагч” судрын 6 эхийг харьцуулан судлах, “Жийдаан хуушааны намтар зохиол”-ын 12 дэвтэрчилсэн эхэд эх бичгийн суурь судалгааг хийх ажлуудыг тус тус гүйцэтгэлээ. - 2008 онд Улаанбаатарт хэвлэгдсэн эхтэй “Гар бичмэл, монгол судлалын фонд”-д хадгалагдаж буй “Шин Чи Хуй хэмээх Жийдаан богд тойны түүх оршвой” зохиолын хэд хэдэн эхүүдийг тулгаж, харьцуулсан судалгаа хийсэн. - “Гар бичмэл, монгол судлалын фонд”-ын 5766/96-5782/96 данстай “Жийдаан хуушааны намтар” зохиолын 17 эхийг тулгаж, үлгэрийн эхлэл төгсгөлийн үгийг хөрвүүлэн буулгасан. -“Түшээт хан аймгийн 20 хошуу нутгийн зураг” дээрх уул усны нэрийг хөрвүүлэн 2013 онд хэвлэгдсэн “Монгол орны газар нутгийн атлас” дахь газар орны нэртэй тулган судалж байна. -Монгол судлал, гар бичмэл номын фондод хадгалагдаж байгаа гар бичмэл, барын Банзрагч /26 судар/ болон “Таравчинбо” /27/ судруудын бүтээсэн он цаг болон бичвэрийн харьцуулсан судалгааны ажлыг хийлээ. 2.1.2.БНХАУ-ын Гуанжоу хотноо болсон Юнескогийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Ази Номхон далайн бүсийн YI ээлжит хурлаар гишүүн орнуудаас дэвшүүлсэн баримтат өвийн материалыг судлан хэлэлцэж, 16 бүтээлийг шинээр бүртгэсний дотор Монгол Улсаас нэр дэвшсэн “Сахиусан дара эх” бүтээлийг

	бүртгүүлж, “Батламж”-ийг хүлээн авах ёслолын ажиллагааг зохион байгууллаа. XX зууны эхэн үед бүтээсэн Ногоон, Цагаан Дара эхийн төвд бичмэл судар гэдгээрээ алдартай уг бүтээл нь 8228 тэмдэгтийг багтаасан хосгүй бүтээл юм. - “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн дэлхийн өв номинацид Дагва дархан тэргүүтэй урчуудын урласан мөнгөн “Сандуйн жүд”, Зава Дамдины “Хорчойнжүн” бүтээлүүдийн судалгааны тодорхойлолтыг англи, монгол хэлээр бэлтгэж, ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Хороонд илгээсэн. Энэ оны 5-р сард ЮНЕСКО-гийн Үндэсний зөвлөлдөх Хорооны хурлаас шийдвэр нь гарах юм. - ЮНЕСКО-гийн Ази-Номхон далайн бүс нутгийн Хорооноос гишүүн орнуудын дунд зарласан нэр дэвшүүлэх өвийн тодорхойлолт бичих уралдаанд тус номын сан “Алтан үсгийн Монгол Жадамба” судраар оролцож, сургалтанд оролцох 10 өвийн нэгээр шалгарлаа. 2.1.3.Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга О.Жамьяны 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төсөл болон О.Жамьян гүний тухай мэдээ, материалыг бэлтгэж явуулсан. -ССАЖЯ болон ШУА-тай хамтран “О.Жамьян – 150 жил” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, “Үндэсний номын сангийн үйл хэрэгт О.Жамьяны оруулсан хувь нэмэр” илтгэлийг МҮНС-ийн Эрдмийн зөвлөлийн дарга Ш.Чоймаа тавилаа. Мөн О.Жамьяны Үндэсний номын сангийн сан хөмрөгт цуглуулж бүрдүүлсэн ном судар болон түүний бүтээл, захидлууд, архивын материалууд, Судар бичгийн хүрээлэнд цуглуулсан болон худалдаж авсан ном, данс баримт зэргийн дээжис болох 51 ном, баримт материалаар “О.Жамьян гүн ба дэлхийд данстай өвгүд” үзэсгэлэнг гаргалаа. - ОХУ-ын Чита хотын А.С. Пушкины нэрэмжит номын санд болсон “Соёлын харилцаанд номын сангийн оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “Особенности научно-методической деятельности Монгольской Национальной библиотеки”сэдвээр., - ОХУ-ын Санкт-Петербург хотын Соёл урлагийн их сургуулийн номын сангийн тэнхимээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд “Главная библиотека Монголии” сэдвээр., - МУБИС-иас зохион байгуулсан “Дондогийн Цэвэгмид-амьдрал, бүтээл 100 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “Д.Цэвэгмидийн бүтээлтэй МУ-ын Үндэсний номын сан дахь архивын бүртгэн мэдээлэх номзүйн үндсэн дээр танилцах нь” сэдвээр тус тус илтгэл бэлтгэж, оролцлоо.

2.2. Хосгүй, үнэт ховор, гар бичмэл ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах 2.2.1. ССАЖЯ-ны төлөвлөгөөнд тусгагдсан "Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр"-ийн төслийг боловсруулах, батлуулах ажилд оролцоно. 2014.08.01-ний дотор 2.2.2. ССАЖ-ын сайдын тушаалын дагуу "Түүх соёлын дурсгалт зүйлсийг журмын дагуу ангилна. 2014.10.01-ны дотор 2.2.3. "Үнэт ховор номын музей"-н ном судрын үнэлгээний асуудлыг ССАЖЯ-нд тавьж шийдвэрлүүлэх, тооллогын үр дүнд тулгуурлан баримтат өвийг хадгалах, хэлэлцэх, тооллогын үр дүнд хамгаалах төлөвлөгөө боловсруулж ажиллана. 2014.03.01-ний дотор 2.2.4. Төлөвлөгөөний дагуу үнэт ховор ном судрыг сэргээн засварлана. 2014 он, жилийн турш	- Хэнтий аймгийн номын сангийн 70 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд "Нийгэм дэх номын сангийн оролцоо" хуралд "МҮНС аргазүйн төв болох нь" сэдвээр ахлах аргазүйч Г.Гүнжинлхам; - Санкт-Петербург хотын төв номын сангаас зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд "Научно-методическая деятельность Национальной библиотеки" сэдвээр тус тус илтгэл бичиж илгээв. 2.2.1. "Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулах ажлын хэсэгт Үндэсний номын сангийн ажилтнууд оролцож, идэвхтэй ажиллалаа.Тус хөтөлбөр Засгийн Газрын 2014 оны хуралдаанаар батлагдлаа. "Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн төслийг боловсруулах ажлын хүрээнд: - Соёл, урлагийн байгууллагуудаас судалгаа авах.,/Нийт 45 байгууллагаас авсан./ - Эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн багш нар,соёл урлагийн ажилтнуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах., - Орон нутгийн соёл урлагийн байгууллагуудаас албан бичгээр, цахим шуудангаар санал авах., - Соёлын баримтат өв болон хөтөлбөрийн тухай ойлголтыг олон нийтэд өгөх зорилгоор цуврал нэвтрүүлгийг бэлтгэж, хэвлэл мэдээллээр сурталчлах., /2013 оны 09-р сарын 19-ний "Үндэсний шуудан" өдөр тутмын сонинд "Эх түүхийн гэрч-соёлын баримтат өв" нийтлэл, МҮОНТ, Royal телевизээр "Соёлын баримтат өв, түүнийг хэрхэн бүртгэлжүүлэх", "Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр"-ийн тухай, UBS телевизийн Соёл урлагийн цаг нэвтрүүлгээр соёлын өвийг хамгаалах хөтөлбөрийн тухай 6 удаагийн цуврал нэвтрүүлгийг бэлтгэж сурталчилсан./ - ССАЖЯ-тай хамтран ажлын хэсгийн нэгдсэн хуралдаанд оруулахад бэлтгэх:, - Хурлаас гарсан санал болон бусад яамдуудаас ирсэн саналуудыг тусгаж, хөтөлбөр болон төсвийг дахин боловсруулан нэгтгэх ажлуудыг тус тус хийж гүйцэтгэлээ. - "Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2015 онд хийж гүйцэтгэх ажлын ерөнхий төлөвлөгөөг гаргаж, холбогдох яаманд өгсөн. 2.2.2. ССАЖ-ын сайдын тушаалаар Үнэт ховор номын фондын ном судрыг түүх соёлын дурсгалт зүйлсийг ангилах журмын дагуу 30 бүтээлийг ангиллаа. 2.2.3. "Үнэт ховор номын музей"-н улсын тооллогын тайланг нэгтгэж, улсын тооллогын комисс болон Соёлын өвийн төвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хүлээлгэн өгсөн. -Түүх соёлын дурсгалт зүйл, баримтат өвийг Сангийн яамны сайдын тушаал болон холбогдох журмын дагуу дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хийж, 516 дэсийн 135634 иж бүрдэл, 2.974.884.400 үнэ бүхий 516 өвийн дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэж, Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн RCH програмд оруулан хадгаллаа.

	- Зава Дамдины зохиосон "Хорчойнжүн", мөн Жадамба судрын мэдээллийн санг бүрдүүлж, хуулан бичиж галиглав. - Өндөр гэгээний зохиосон хэвтээ дөрвөлжин үсгээр барлаж, бичсэн 9 өвийн мэдээллийн санг бүрдүүллээ. - Гамма зургийн студиэр бүс нутгийн болон дэлхийн өвд нэр дэвшүүлсэн 4 өвийн фото зургийн архивыг бүрдүүлэв. - “Улс, орон нутгийн музейн шилдэг үзмэрийн дээжис” каталогт орох 90 номын тодорхойлолтыг бичиж, Соёлын өвийн төвд хүлээлгэн өглөө. -"Сандуйн жүд" судрын цуврал үзэсгэлэн зохион байгуулж, Үнэт ховор номын музейд хадгалагдаж буй дэлхийн болон бүс нутгийн өвүүд, хосгүй үнэт өвүүдийг сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн “Үндэсний бичиг үсгийн баяр”, “Номын баяр” арга хэмжээний хүрээнд Үнэт ховор номын үзэсгэлэнг олон нийтэд үнэ төлбөргүй үзүүллээ. 2.2.4.Ном сэргээн засварлагч нь 536 хуудас бүхий 12 гар бичмэл, барын ном судрын хадгалалтын орчин нөхцлийг сайжруулж, сэргээн засварлаж, тэдгээрт технологийн картжуулалт хөтлөн, ном нэг бүрт тохирсон хайрцаг дугтуй хийж, хайрцгийн гадна талд номын нэрийг монгол бичгээр бичиж, дансны дугаарын хамт нааж холбогдох фондонд буцаан тушаав. Үүнд : Эрдэнэ зуугийн тухай-46, Чойжид дагиньн тууж-98, Эсрүн хурмаст тэнгэр эдүгээх цагийн байдлыг шинжлэн үнэн номлосон нь чулууны хөшөөний бичиг-28, Галын тахилга-6, Очроор огтлогчийн рашаан энэ амуй-112, Түшээт хан аймгийн Хутаг уулын хошуу нутгийн зураг-1 ш/12/, Дөрвөдийн ноёдын уг эх бололтой-1 ш /13/, Сайшаалт ерөөлтийн 2 дугаар онд жавзандамба хутагтын уг эхийг байцааж өргөсөн дэвтэр данс- 36х, Түшээт хан аймгийн засгийн хан ван гүн засаг- 34х, Зандан зуугийн домог эргэх хэмжээ ач тус лугаа хамт товчлон хураасан эрдэнэ эрх хэмээх- 21х, Бадруулт төрийн тэргүүн оны гэрийн ...- 42 хуудас тус тус болно. - Скайнерт оруулах боломжгүй 1356 хуудас бүхий 5 дэвтэрчилсэн ном болон 2 зургийг цахим мэдээллийн сан бүрдүүлэгчдээс хүлээн авч сэргээн засварлаж, буцаан хүлээлгэж өгөв. Үүнд: Баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх 8-р дэвтэр оршив-99, Дээрхийн тухай долдугаар- 475х, Түшээт хан аймгийн олон хошуудын ноёд тайж нарын гэрийн үеийн бичмэл- 1х, Монголын эртний үеийн хувцасны өгүүлбэр- 100х, Монголын чухал үгсийн тайлбар толь- 247х, Монгол эмнэлэгт хэрэглэгдэж байсан эмийн зарим зүйлсийн 2-р дэвтэр- 433х, Баруун түмт хошууны зураг-1х тус тус болно.

2.3. Засгийн Газрын тогтоолын дагуу номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажиллагааг боловсронгуй болгох 2.3.1.”Номын сангийн тухай хууль”, “Үндэсний номын сангийн эрх зүйн байдлын хууль”-ийг боловсруулахад оролцоно. 2014.12.01-ний дотор 2.3.2.”Соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулж, батлуулах ажилд оролцоно. 2014.12.01-ний дотор 2.3.3.“Номын сангийн зөвлөл”-ийн ажлыг төлөвлөж, номын сангийн ажил үйлчилгээг сайжруулахад чиглүүлэн ажиллана. 2014 он, жилийн туршид 2.4.Номын сангийн үйлчилгээг сайжруулах, номын санчдыг чадавхижуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх 2014 он, жилийн туршид	2.3.1.”Номын сангийн тухай хууль”-ийг“ боловсруулах ажлын хэсэгт номын сангаас оролцож ажиллалаа. Хууль боловсруулах ажлын хүрээнд ном хэвлэл, номын сангийн үйл ажиллагаатай холбогдолтой судалгаа хийх, хуулийн зүйл, заалтад тайлбар, үндэслэл бичих, УИХ-ын Байнгын Хорооны хуралд бэлтгэх зэрэг ажлуудад оролцож ажиллалаа. -“Номын сангийн хууль” 2014 оны 12-р сарын 19-нд УИХ-аар хэлэлцэгдэж батлагдлаа. 2.3.2. “Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр” нь 2014-2021 онд 2 үе шаттайгаар хэрэгжихээр Засгийн Газрын хуралдаанаар батлагдлаа. -СУИС-аас ирүүлсэн: <Монголын соёл урлаг судлал” эрдэм шинжилгээний бичигт хэвлүүлэх эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага>, <СУИС-ийн сургалт судалгаа шинжилгээний ажилд мөрдөх номзүй, эшлэсэн материалыг бичиж тэмдэглэх заавар>, <СУИС-ийн магистрын төгсөлтийн уран бүтээл, судалгааны үр дүнг нэгтгэн бичих, хэвлүүлэх, хүлээлгэн өгөхөд баримтлах журам>-ыг хянан, засварлалаа. (нийт 74 санал, тайлбар, бусад засвар хийсэн байна). - Стандартчилал Хэмжил зүйн Газраас ирүүлсэн “Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” стандартын зассан хувилбарыг хянаж, санал өгч, Соёл урлагийн Техникийн хорооны хуралд 2 удаа оролцлоо. - “Монгол улсын Үндэсний номын сангийн гар бичмэл, барын ном судрыг тоон хэлбэрт шилжүүлэх, хадгалах, хамгаалах журам”-ыг боловсруулж, захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж захирлын тушаалаар батлагдав. 2.3.3. “Номын сангийн зөвлөл”-ийн ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, тайлангийн хугацаанд захиргаатай хамтарч өргөтгөсөн хурлыг 4 удаа хийлээ. Зөвлөлийн хурлаар номын сангийн электрон каталогийн ажлыг эрчимжүүлэх асуудал, Marc форматын тухай, төлбөрт үйлчилгээний үнийн тариф, гар бичмэл ном судраар үйлчлэх журам, үндэсний бичиг үсгийн баярын тухай зэрэг цаг үеийн шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж, зохих шийдвэрүүдийг гаргалаа. 2.4.1. Төлөвлөгөөний дагуу Өмнөговь, Дорнод, Төв, Хэнтий, Сүхбаатар, Дархан-Уул, Архангай зэрэг 7 аймгийн номын санд биечлэн очиж арга зүйн зөвлөгөө өгч, аймгийн төв номын сангийн номын санчдад “Номзүйн бичилт” ерөнхий шаардлага”, “Номзүйн бүртгэл хийх аргачлал”, “Орон нутгийн номзүй, хуулийн картын сан зохион байгуулах”, “Соёл танин мэдэхүйн ажил” сэдвүүдээр сургалт-семинар явууллаа. - Дорнод аймагт зохион байгуулагдсан зүүн бүсийн номын санчдын ажил мэргэжлийн өдөрлөгт тус номын сангийн арга зүйч, каталогч, ангилагч нар оролцож, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймаг болон сумдуудын нийт 63 номын ажил, туршлага” сэдвүүдээр сургалт-семинар зохион байгуулснаас гадна номын

	санчдын дунд ажил мэргэжлийн уралдааныг зохион байгууллаа. Ур чадварын энэхүү уралдаанд 1-р байрыг Хэнтий аймаг, 2-р байрыг Сүхбаатар, удаах байрыг Дорнод аймаг тус тус эзэллээ. Мөн бүсийн уулзалтанд Үндэсний номын сангаас “ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн олон улсын баримтат “Монгол Улсын үндэсний баримтат 108 өв”-ийн сурталчилгааг хийж, “Түмэн зүйлийг бадруулж элдэв эрдмийг дэлгэрүүлсэн он жилүүд” сэдэвт үзэсгэлэнг дэлгэн үзүүллээ. - Энэхүү зүүн бүсийн уулзалтанд волейбол, теннисний бүсийн аварга шалгаруулах тэмцээн болсон бөгөөд Үндэсний номын сангийн баг тэргүүн байр эзэлсэн. - Тайлангийн хугацаанд Орхон, Хөтөлд Үндэсний номын сангийн явуулын номын сангийн баг томилолтоор ажиллаж, арга зүйн зөвлөгөө өгснөөс гадна ном судрын үзэсгэлэн гаргаж, үндэснийхээ бичиг соёлыг сурталчлах ажлыг зохион байгууллаа. -Дьюигийн аравтын ангиллын 21 дэх хэвлэлтийг монгол хэлнээ доктор, проф. Ж.Цэзэнгийн орчуулгын эхийн алдааг хянав. Нийт 848 хуудас - ХБНГУ-ын ГЁТЕ институттэй хамтран цаасны сэргээн засварлалтын нэр томъёоны 4 хэлний толь бичиг хийх ажилд оролцов. -“Цаасан баримтат өвийн хадгалалт, хамгаалалт сэргээн засварлалт” үндэсний гарын авлага гаргах ажилд оролцон ЮНЕСКО-д хүлээлгэн өгөв (Х.Түмэнбаяр). -Үндэсний номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор үйлчилгээний журмыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: “Үндэсний номын сангийн гар бичмэл, барын ном судрыг тоон хэлбэрт шилжүүлэх, хадгалах, хамгаалах журам”, Төлбөрт уншлагын танхимын үйлчилгээний журам /нэмэлт өөрчлөлт/., Монгол судлал, гар бичмэл номын фондын ном судрыг тоолох аргачлал зэргийг тус тус боловсруулж ажиллалаа. -“Үндэсний номын сангийн мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулах” төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж, 5,476,295,600 төгрөгийн өртөгтэй төслийн саналыг боловсруулж бэлэн болгоод байна. Уг төсөл Үндэсний номын сангийн үйл ажиллагаанд цахим үйлчилгээ нэвтрүүлэх, иж бүрэн техник технологийн шинэчлэл хийх зорилготой юм. -ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэлийн санаачилсан Британий номын сангийн 9 төрлийн аргачлал, гарын авлагыг орчуулж хэвлүүлэх зардлын төсвийг судалж, 3 хувилбараар хийв. Эдгээр аргачлал, гарын авлагын орчуулгад редакц хийж, мэргэжлийн хэл, найруулгыг нэг бүрчлэн дахин хянаж, засварлан хэвлэхэд бэлэн болгосон. Үүнд:Damaged books-16х., Cleaning-16х., Pests-16х., Mould-8х., Salvage-16х., Storage furniture-16х., Environment-12х., Building a preservation-16х., Basic preservation-12х болно.

2.4.1. Аймаг орон нутгийн номын санд томилолтоор ажиллаж арга зүйн зөвлөгөө өгнө. /4-6 аймагт/ 2.4.2.Хотын болон их дээд сургууль, ЕБС-ийн номын сангуудад биечлэн очиж арга зүйн зөвлөгөө өгнө. /16 номын санд/ 2.4.3.Нийтийн, их дээд сургууль, ЕБС, эрдэм шинжилгээний байгууллагын номын санчдад мэргэжлийн зөвлөгөө өгнө. /40 номын санч/ 2.4.4.Онол арга зүйн “Номын санч” сэтгүүлийг гаргах, нэгдсэн захиалгаар орон нутагт хүргэнэ. /4 удаа/ 2014 он, жилийн туршид	-Аймаг, хотын төв номын сангуудын СУ судалгаанд дүн шинжилгээ хийж нэгтгэн, “Нийтийн номын сангуудын тайлан-2013” эмхтгэлийг цахим хэлбэрээр вэб-д байршуулсан. -УДК-ББК-гийн харьцуулсан судалгааг хийх бэлтгэл ажил болгож 2008 онд Үндэсний номын сангаас эрхлэн гаргасан “Номын сан-номзүйн ангилал”-ын 2 боть дахь хэвлэлийн алдааг залруулах, нэмж засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: I боть 553х, II боть 215х. Нийт 768х. - Дьюигийн аравтын ангиллын 21 дэх хэвлэлтийг монгол хэлнээ доктор, проф. Ж.Цэзэнгийн орчуулгын эхийн алдааг хянав. / Нийт 848 хуудас/ ХБНГУ-ын ГЁТЕ институттэй хамтран цаасны сэргээн засварлалтын нэр томъёоны 4 хэлний толь бичиг хийх ажилд оролцов. (Х.Түмэнбаяр, Б.Отгонтуяа). -“Цаасан баримтат өвийн хадгалалт, хамгаалалт сэргээн засварлалт” үндэсний гарын авлага гаргах ажилд оролцон ЮНЕСКО-д хүлээлгэн өгөв. -Монголын номын сангуудын консерциум, ХНО хамтран зохион байгуулсан анхан шатны болон мэргэжлийн онлайн сургалтанд 7 сэдвээр хөтөлбөр, лекц бэлтгэн 14 цагийн хичээлийг 30 номын санчдад заалаа. - Баян-Өлгий, Орхон, Өмнөговь аймгуудын номын сангийн хүсэлтээр 4 сэдвээр 8 цагийн хичээлийг 29 номын санчдад заалаа. 2.4.2. Хөдөлмөрийн яамтай хамтран 2014 оны 05-р сарын 26-30-ны хооронд Сургалтын танхимд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн нийт 32 номын санчдад “Номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрхзүйн баримтууд”, “Анхан шатны бүртгэлүүд, тэдгээрийг хөтлөх аргачлал”, “Номын санчийн ёс зүй”, “Ном хэвлэл сэлбэн засах арга, ажиллагаа”, “Номын сан-номзүйн ангилал, түүний онцлог”, “Номын сангийн соёл танин мэдэхүйн ажил”, ”Ном тодорхойлох журам”, “Фондын зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт”, “Номын сангийн каталог зохион байгуулалт”, “Лавлагаа номзүйн ажил” зэрэг сэдвүүдээр нийт 40-н цагийн сургалтыг зохион байгуулсан. - Улсын Драмын театр, Наркологийн эмнэлэг, Монголын Үндэсний техникийн дээд сургууль, Монгол судлалын төв, Оюунлаг бүрэн дунд сургууль, Монгол Германы ашигт малтмал, технологийн дээд сургуулийн номын сангуудад тус тус биечлэн очиж арга зүйн зөвлөгөө өглөө. Наркологийн төвийн номын санчийг 10 хоног дагалдуулан сургаж, номын сангийн үндсэн ажиллагааны талаар зааж сургасан. 2.4. Дархан-Уул аймгийн номын санч Бадамцэцэгт “Номзүйн бичилтийн стандарт”, Дундговь аймгийн номын санч Ууганбаярт “1994 оны 83/97 дүгээр тушаал, 441-р тушаал”, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн номын санч Ц.Энхтайванд “Номын сангийн бүтэц зохион байгуулалт”,“Драмын театрын номын санч Золзаяад

	ном ангилах талаар, МУСТ-ийн номын санч Ч.Пүрэвмаад “Номонд нэмэлт ангилал хийх”, МУСТ-ийн номын санч Ж.Должинсүрэнд “Ном актлах журам” сэдвээр тус тус нийт 111 номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. -Үндэсний номын сангийн номын санчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, нийт 14 сэдвээр 22 цагийн хичээлийг бэлтгэж, 43 номын санчид 2 өдрийн сургалтыг зохион явууллаа. Уг сургалтын талаар номын санчдаас авсан “Сэтгэл ханамжийн судалгаа”-ны асуулгыг боловсруулж судалгааг 39 номын санчаас авлаа. 2.4.4. “Номын санч” сэтгүүлийн 2014 оны №1 – 4 дугааруудыг “Номын сан – номзүй судлал”, “”Номын сангийн менежмент”, “Мэдээллийн технологи, автоматжуулалт”, “Эх бичиг сурвалж судлал” зэрэг 10 салбар буланд 74 онол арга зүйн материал, мэдээ мэдээллээр бэлтгэн гаргаж, нэгдсэн захиалгын дагуу хөдөө орон нутагт хүргэж байна.
Гурав: “Номын сангийн мэдээллийн технологийн үйлчилгээг боловсронгуй болгох, шинэ технологи нэвтрүүлэх” зорилтын хүрээнд:	
3.1.Ном судрын мэдээллийн санг бүрдүүлэх, Соёлын өвийн бүртгэл-мэдээллийн ажлыг сайжруулах 3.1.1.“Үндэсний соёлын өвийн мэдээлллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд үнэт ховор номын мэдээллийн санд нэмэлт мэдээллийг оруулж архивлана. 2014 он, жилийн туршид 3.1.2.Монгол гар бичмэл ном судрыг тоон хэлбэрт оруулах, хадгалалтын найдвартай орчныг бүрдүүлнэ. 2014 он, жилийн туршид 3.1.3.OCLC олон улсын номын сангийн онлайн каталогт монгол номзүйн мэдээлэл оруулна. 2014 он, жилийн туршид 3.1.4.Сонин сэтгүүлийн өгүүллийн 1988-2008 он хүртэлх он дараалсан	3.1.1.“Үндэсний соёлын өвийн мэдээлллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн RCH улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн програмд нийт 516 өвийн мэдээллийг 22 үзүүлэлтээр тодорхойлолт бичиж оруулсан ба одоогийн байдлаар улсын бүртгэл мэдээллийн санд 2008 онд оруулсан мэдээллийг ерөнхий бүртгэлийн дэвтэрт бичигдсэн мэдээлэлтэй нь тулгаж нягтлах ажлыг хийсэн. - Фото мэдээллийн сан бүрдүүлж, 15371 зургийг 9 DVD-д архивлан хадгалж, Соёлын өвийн төвд хүлээлгэн өгөв. 3.1.2. - Дижиталчилалын ажлын хүрээнд скайнерт Дөрвөд Ойрдын түүх, Сайн ноён хан аймаг Цэцэрлэгмандалын Байнбайшир уулын хошуу нутгийн цэс, Жавзан хутагтын шавь дархадын нутгийн цэс дэвтэр, Алтан товч хэмээх оршвой, Догшин ноён хутагтын сургаал оршвой, Жүн дагины түүх, Цагаан Жамбалын сан оршвой, Монголыг хүрээлсэн эзэрхэг улсуудын хоорондын байдлыг товчлон үзүүлсэн түүх, Хутагт их үүлэн судар оршвой, Амарын зохиосон түүхэн ноорог, Гадаад Монголын Төрийг засах явдлын яамны бичиг, Юань улсын нууц түүхийн дараа зохиосон бичиг зэрэг гар бичмэл, барын 861 боть /68656хуудас/ ном судрыг тоон хэлбэрт оруулж, уншигчдад үйлчилж байна. Мөн эдгээр гар бичмэл судруудыг дансны дугаар, номын нэр, хуудасны тоо, хэмжээ, гар бичмэлийн гэмтлийн байдал зэрэг 8 үзүүлэлтээр тодорхойлох, хард дискэнд хуулж хадгалах ажлуудыг хийж байна. - Ганц хувь гар бичмэл ном судрын эх оригинал хувийг гэмтэхээс сэргийлж, уншигч судлаачдад зөвхөн тоон хэлбэрээр үйлчлэх бодлогыг баримтлан ажиллаж, эрдэм шинжилгээний уншлагын танхимаар 1560 гар бичмэл, барын ном судар, 10 газрын зураг, 12 манж номыг цахим хэлбэрээр зөвшөөрлийн дагуу уншууллаа. -“Microsoft office excel” дээр сканнерт орсон боть номуудыг 8 үзүүлэлтээр нийт 752

номзүйн бүртгэлийг номзүйчлэн Zotero програмд оруулж, лавлагаанд зориулсан мэдээллийн бааз үүсгэхажлыг хийж эхэлнэ. 2014 он, жилийн туршид 3.1.5.Тогтмол хэвлэлийн Marc форматыг орчуулж, өөрийн нөхцөлд тохируулан боловсруулна. 2014 он, жилийн туршид	номын жагсаалт хийж хадгалав. -134 диссертацийг тоон хэлбэрт оруулав. 3.1.3. АНУ-ын Дунд Теннисийн их сургуулийн номын сангийн каталогч, дэд профессор Д.Энэрэлийн санаачлагаар АНУ-ын Монгол судлалын төвийн номын сангийн тэтгэлэгт хөтөлбөрт тус номын сан хамрагдаж, олон улсын онлайн нэгдсэн каталогт элсэх хамтарсан төсөл хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд Үндэсний номын сан нь дараах ажлуудыг хийлээ. Үүнд: -OCLC олон улсын онлайн каталогт оруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор нийт 4 номын санчтай баг бүрдүүлэн ажиллаж, монгол фондоос OCLC олон улсын онлайн каталогт оруулах 500 номын жагсаалтыг гаргах., - ном судрын мэдээллийг оруулах., - номын санчдыг сургаж, дадлагажуулах ажлуудыг хийлээ. -Америкийн Нэгдсэн Улсын Дунд Теннисийн их сургуулийн каталогч Э.Энэрэл 2 удаа OCLC олон улсын онлайн каталогт оруулах ажиллагааны талаар сургалт зохион байгуулсан. - Эдгээр ажлуудын үр дүнд Үндэсний номын сангийн каталогийг OCLC-д оруулах ажлыг зохион байгуулж, төвд судар 886, монгол гар бичмэл ном 16, Монгол ном 98-ийг оруулалаа. 3.1.4. Сонин сэтгүүлийн өгүүллийн 1988-2008 он хүртэлх он дараалсан номзүйн бүртгэлийг номзүйчлэн Zotero програмд оруулж, лавлагаанд зориулсан мэдээллийн бааз үүсгэх ажлыг хийж, номзүйн мэдээллийн баазыг нэгтгэх ажлыг хийж байна. Энэхүү бүртгэл нь 20 жилийн 138 нэрийн сонин, сэтгүүлд нийтлэгдсэн мэдээ, материал, судалгаа шинжилгээний өгүүлэлийг хамарсан үндэсний хэмжээний томоохон номзүйн бүртгэл бөгөөд уншигч, судлаачид, номын санчдын лавлагааны чухал хэрэглэгдэхүүн болох юм. 3.1.5. Marc форматыг орчуулж, өөрийн нөхцөлд тохируулан боловсруулах ажлыг хийж байна. Энэ ажлын хүрээнд номын санчид болон Старсофт компанийн ажилтнуудад Marc форматын тухай мэдээлэл, танилцуулгыг хийсэн.

3.2.Мэдээллийн цахим үйлчилгээг сайжруулах 3.2.1. Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимын үйлчилгээнд дижитал уншлагын системийг боловсронгуй болгож, уншигчдад үйлчилнэ. 2014 он, жилийн туршид 3.2.2.Уншигчийн үнэмлэхийг шинэчлэх, ухаалаг IC үнэмлэхээр шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ. 2014 он, жилийн туршид 3.2.3.Номын сангийн электрон каталогийн баазад редакц хийх, нэмэлт мэдээллээр баяжуулж хэрэглэгчдэд үйлчилнэ. 2014 он, жилийн туршид 3.2.4.Номын сангийн вэб сайтын байнгын ажиллагааг хангах, “Виртуаль лавлагааны алба” вэб хуудсыг ажиллуулна. 2014 он, жилийн туршид 3.2.5.Сонины цахим мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлнэ. 2014 он, жилийн туршид	3.2.1. Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимаар орчин үеийн өндөр хүчин чадалтай техник технологийг ашиглан үнэт нандин ганц хувь бүтээлүүдийг тоон хэлбэрт оруулж, touch дэлгэцээр уншигч, судлаачдад үйлчилж байна. Тус танхимын цахим уншлагын системийг боловсронгуй болгох нэмэлт өөрчлөлтүүд болох 12 ажлын саналыг боловсруулж, “Номын сангийн зөвлөл”-өөр хэлэлцэн, гүйцэтгэгч Старсофт ХХК-д хүлээлгэн өглөө. Тус компани нь эхний ээлжинд дижитал номын програмыг сайжруулах 3 нэмэлт өөрчлөлтийг шийдвэрлэж өгсөн болно. -“Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас 2011-2013 онд хэрэгжүүлсэн төслүүдийн тайлан”, ”Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас 2011-2013 онд хэрэгжүүлсэн төслийн техник, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, үйлчилгээний зориулалт” /Нийт 28 хуудас/ тайлан, мэдээллийг бэлтгэж, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүллээ. 3.2.2. Үндэсний номын сангийн уншигчийн үнэмлэхийг шинэчлэх, IC үнэмлэх нэвтрүүлэх ажлын хүрээнд Их уншлага 4221ш, эрдэм шинжилгээний танхимд 389 үнэмлэх, нийт 4610 уншигчдад үнэмлэх олгож, шинээр үнэмлэх нээлгэж буй уншигчдад лавламж зөвлөлгөө өгч ажиллалаа. 2354 уншигчдын үнэмлэхийг IC үнэмлэхээр шинэчлэн сольж, бүртгэлийн хуудасны зургийг наах, сүлжээнд оруулан шивэх, хэвлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Уншигчийн үнэмлэх уншигчийг шинэчилж, каталогийн бүртгэлийн компьютерт програм, мөн шинэ тоон гар суурилууллаа. Шинээр уншигч бүртгэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалтыг шинэчилж, мөрдөн ажиллаж байна. 3.2.3.Монгол ном, Диссертацийн шинэ бичлэгүүдийг L-Soft системийн сервэр, ЭШ-ний уншлагын танхим, Тогтмол хэвлэлийн уншлагын тахимын каталогийн бааз, номын сангийн вэб сайтын каталогийн баазад цаг тухай бүрт нь нэмэлт хийсэн. Номын сангийн L-Soft систем, мэдээллийн баазыг найдвартай тогтвортой ажиллуулахад анхаарч Монгол номын электрон каталогийн баазад 2647 ном, Диссертацийн электрон каталогийн баазад 98 диссертаци нэмсэн. -Монгол номын электрон каталогийн баазад редакц хийх, мөн мэдээллийн баазад ойрын фондоос монгол номын фондруу 399 номыг, монгол номын фондоос ойрын фондруу 133 номыг шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. -Системийн компьютерүүдэд үзлэг хийж он, сар, өдрүүдийг тааруулах, сонин сэтгүүлийн картын сан, архив, фондуудын мэдээллийн баазыг хадгалж байна.

	-Захирлын 2014 оны 01-р сарын 17-ны 03 тоот тушаалыг үндэслэн Бэлтгэл фондын нэгбүрчилсэн бүртгэлийг электрон хэлбэрт оруулах ажлыг хийж, дансан дахь ном нэг бүрийн бүртгэл хөтлөлтийн алдааг шалган цэгцэллээ. Энэ ажлын хүрээнд нийт 22844 нэрийн 127763 номын мэдээллийг орууллаа. 3.2.4.Вэб сайтыг номын сангаас зохион байгуулж буй арга хэмжээ болон үйл ажиллагаа, үйлчилгээний тухай, мөн танин мэдэхүйн мэдээ мэдээллээр байнга баяжуулж байна. Номын сангийн вэб сайтанд мэдээ, мэдээлэл 20, “Шинэ номын мэдээ” сэтгүүлийн 1-12 дугаарыг нэмж орууллаа. - Номын сангийн сэдэвчилсэн вэб сайтанд байрлуулах вэб хуудас хийсэн. - 2014 оны 01-р сарын 01-нээс 12-р сарын 15-ны хугацаанд номын сангийн www.nationallibrary.mn сайтанд 25842 хэрэглэгч хандалт хийж, 75060 хуудсыг үзэж сонирхсон байна. Улс орноор нь ангилбал: Монгол- 23198, АНУ-288, Өмнөд Солонгос – 243, ОХУ-216, Япон-185, Хятад -116 ханджээ. - Виртуаль лавлагааны албаар нийт 120 лавлагаанд хариу өгч, өгөгдсөн лавлагаанд хяналт тавин ажиллаж байна. 3.2.5.Сонины цахим мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор өдөр тутмын Ардын эрх, Өдрийн сонин, Үндэсний шуудан, Үнэн, Ардчилал зэрэг нэрийн сонингуудын тоон хэлбэрт орсон файлуудыг: - pdf файлаас зурган файл руу хөрвүүлэх., - зурган файлыг хуваах., - тоон баазад оруулахад бэлтгэх, - баазад оруулах, хадгалах ажлууд хийгдэж байна. - “Үндэсний шуудан” сонины 142 дугаарыг зурган файл руу хөрвүүлэх, “Өдрийн сонин”-ы 2011 оны бүх дугаарууд, 2012 оны эхний улирлын дугааруудыг хуваах ажлыг хийлээ. “Монголын мэдээ” сонины 2013 оны 112ш, 2014 оны 204ш, Хөх толбо сонины 265 ш дугаарыг засч, баазад оруулан хадгаллаа. Баазад оруулсан сонингуудыг дотоод сүлжээгээр уншигчдад хүргэхээр ажиллаж байна. -Сканнердсан гар бичмэл 60 орчим номуудын зургийг шалгаж тэмдэглэл хөтлөн, Старсофт ХХК-ий боловсруулж буй цахим ном унших системд хийгдэх нэмэлт засвар өөрчлөлтүүдийг боловсруулж, мэргэжлийн зөвлөлд танилцуулж, гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өглөө.
	3.3.1. “Сонин сэтгүүлийн өгүүллийн номзүй” /1988-2008/ бүртгэл хийх ажлын хүрээнд Номзүйд зориулан “Улаанбаатарын мэдээ”, “Улаанбаатар таймс”, “Монголын

3.3.Улсын ном зүйн бүртгэлийг бэлтгэх, лавлагаа ном зүйн үйлчилгээг үзүүлэх 3.3.1. Үндэсний ном зүйн бүртгэл болох “Сонин сэтгүүлийн өгүүллийн ном зүй”/1988-2008/-г үргэлжлүүлэн хийж, 1-р ботийг хэвлэлд бэлтгэнэ. 2014 он, 4-р улиралд 3.3.2.”Монгол Улсын Үндэсний номын сангийн архивын бүртгэн мэдээлэх номзүй” номын үргэлжлэл YI ботийг бэлтгэнэ. 2014 он, жилийн туршид 3.3.3.“Шинэ номын мэдээ” сэтгүүлийг бэлтгэх, цаасан болон электрон хэлбэрээр уншигч, байгууллагуудад түгээнэ./жилд 12 дугаар гарна./ 2014 он, жилийн туршид 3.3.4.Лавлагааны төрөлжсөн сангуудыг баяжуулах,албан байгууллага уншигчдаас хүссэн аман болон сэдэвчилсэн бичгийн лавлагаа өгнө. /1360 карт жилд бичнэ./ 2014 он, жилийн туршид	эмэгтэйчүүд”, “Ардын төр” “Гоо марал”, “Ардын арми”, “Номын санч”, “Нутгийн удирдлага”, “Үг”, “Улаан-од”, “Тусгаар тогтнол” зэрэг 138 нэрийн сонин, сэтгүүлээс материал шүүж карталлаа. -Zotera програмаар 10000 гаруй материалыг номзүйчлэн шивж орууллаа. 3.3.2. 2011онд Үндэсний номын сангаас эрхлэн “Монгол улсын Үндэсний номын сангийн архивын бүртгэн мэдээлэх номзүй”-н 5 боть номын үргэлжлэл болох VI ботийг хэвлэлтэд бэлтгэж, 35041-35512 данстай нийт 198 хуудас, 3787 номын жагсаалтыг засах ажлыг бүрэн хийж, уг ажил үргэлжилж байна. 3.3.3. “Шинэ номын мэдээ” сэтгүүлийг №1-12 дугааруудыг гаргаж, цаасан болон электрон хэлбэрээр түгээж байна. Мөн Номын сангийн вэб сайтанд тавьж, дугаар бүрийг 159 байгууллага, хувь хүнд хүргэж байна. 3.3.4. Цахим хэвлэлийн өгүүллийн картын санд Монголын мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр, Үндэсний шуудан зэрэг 4 сонины нийт 2665 өгүүлэл, шүүмж, танин мэдэхүйн зөвлөгөө зэрэг мэдээ мэдээлэл,Төрийн мэдээлэл сэтгүүлээс 315 ш карт бичиж “Монгол улсын хуулиуд” картын санг тус тус баяжууллаа. -Мэдээллийн самбар болон “Веб” хуудасны танин мэдэхүйн буланд “Заавал унших зузаан 11 ном”,”Заавал мэддэг байх 11 шүлэг”, “Хүүхдүүддээ ном уншиж өгөх есөн шалтгаан”, “Ном унших зөвлөмж”, “24 цагийн үйлчилгээтэй номын сангийн нээлт”, “Танин мэдэхүйн шилдэг 10 ном” , “Таныг залуу харагдуулах 8 хоол хүнс”, “Нүдээ хэрхэн хамгаалах” зэрэг нийтдээ13 мэдээлэл бэлтгэж гаргасан. - Аман лавлагааг нийт 237 хүнд өгсөн. -Олон улсын харилцааны дээд сургуулийн захирал Д.Дашпүрэвийн бүтээл, Ауэзов М, Кунанбаев А.А нарын уран бүтээлээр, Нийслэлийн Архивын газрын хүсэлт, албан бичгийн дагуу нийслэл хот үүсч хөгжсөний 375 жилийн ойд зориулан нийслэлийн харьяа байгууллагууд, Улаанбаатар хотын үе үеийн дарга нарын тухай тогтмол хэвлэлд нийтлэгдсэн баримтын жагсаалт 218 материалаар, Стандартчилал хэмжилзүйн төвд Д.Нацагдоржийн гадаад хэл дээр хэвлэгдсэн бүтээлийн жагсаалт 13 номоор, Чойжин ламын сүм музейн тухай 6 номоор,Үндэсний музейн Х.Мэндсайханд **“**Монгол ёс заншил”-тай холбоотой 35 ширхэг номоор нийт 6 удаа 300 гаруй ном хэвлэлээр бичгийн лавлагааг бэлтгэлээ
Дөрөв: “Ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах” стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга	

хэмжээний хүрээнд:	
4.1. Ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалт, зохион байгуулалт, эмх цэгцийг сайжруулах 4.1.1. “Ном сэргээн засварлах лаборатори”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, багаж хэрэгсэлээр хангаж ажиллана. 2014, жилийн турш 4.1.2. Хяналтын системийн найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээ, хяналтыг сайжруулна. 2014 он, жилийн туршид 4.1.3. ССАЖЯ болон мэргэжлийн байгууллагатай хамтран галын дохиололын системийн найдвартай ажиллагааг хангана. 2014 он, 2-р улиралд 4.1.4.Фондын ном хэвлэлийн эмх, цэгц, байрлал, зохион байгуулалтыг сайжруулна. /101750 номыг байрлуулах, цэгцлэх/ 2014 он, жилийн туршид 4.1.5.Тооллогын дараах төлбөр барагдуулах ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ. 2014.12.01-ны дотор 4.1.6. 4620 хэвлэмэл ном сэлбэн засах, 605 нэгж сонин сэтгүүлийг хавтаслана. 277000 номыг ариутгана. 2014 он, жилийн туршид	4.1.1. Сэргээн засварлах лабораторийн вакуумжуулах, нөхөх, сэргээн засварлалтын ширээ халаах пресс зэрэг техник тоног төхөөрөмжүүдийн тусламжтайгаар гар бичмэл ном судрыг сэргээн засварлах үйл ажиллагааг тогтмол хийж байна. Тайлангийн хугацаанд 536 хуудас бүхий Эрдэнэ зуугийн тухай, Эсрүн хурмаст тэнгэр эдүгээх цагийн байдлыг шинжлэн үнэн номлосон нь чулууны хөшөөний бичиг, Чойжид дагинын тууж, Галын тахилга, Түшээт хан аймгийн Хутаг уулын хушуу нутгийн зураг, Дөрвөдийн ноёдын уг эх бололтой зэрэг 12 гар бичмэл болон барын ном судрын хадгалалтын орчин нөхцлийг сайжруулж, сэргээн засварласан. Сэргээн засварлах ажлын хүрээнд технологийн картжуулалт хөтөлж, ном нэг бүрт тохирсон хайрцаг дугтуй хийж хүлээлгэн өглөө. - Ном хэвлэлийг ариутгах ажлыг хийсний зэрэгцээ зарим хуудсууд нь хоорондоо наалдсаны улмаас скайнерт оруулах боломжгүй байсан 7987/96 дугаартай “Баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх оршив” судрын 8-р дэвтрийг мэдээллийн сан бүрдүүлэгчээс хүлээн авч, наалдсан хуудсуудыг салгах, дахин үдэх ажлыг хийж, скайнерт оруууллаа. - Дэлхийн өв, “Хосгүй үнэт” бүтээл болох Есөн Эрдэнийн Ганжуурын үг үсэг нь хоорондоо наалдаж, гэмтэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор хуудсуудын хооронд муутуу цаас хавчуулах ажлуудыг хийж гүйцэтгэв. 4.1.2.Хяналтын системийн найдвартай ажиллагааг хангаж, камеруудын бичлэгийг тогтмол шалгаж, гэмтлийг тухай бүр засварлан тэмдэглэл хөтөлж байна. Хяналтын иж бүрэн систем нэвтэрснээр номын сангийн аюулгүй ажиллагааг хангах, уншигчдын тав тухтай, тайван орчинг бүрдүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгч байна. 4.1.3.ССАЖЯ-ны санхүүжилтээр 16 бүсийн байрлал холбох боломжтой дохиоллын ерөнхий станц, фотоэлектрон хийцтэй утаа мэдрэгч 210 ш, өсөлтийн нормтой дулаан мэдрэгч 162 ш, мөн галын гар мэдээлэгч, галын хонх зэрэг галын дохиоллын систем суурилуулж, галын хор 68 ш, галын шланкны иж бүрдэл, ус сорох цахилгаан насос зэрэг тоног төхөөрөмжтэй боллоо. Засвар үйлчилгээг нэг жилийн хугацаанд үнэ төлбөргүй хийж гүйцэтгэх гэрээний дагуу тус компаний инженер техникийн ажилтнууд галын дохиоллын ажиллагааг хянаж, хамтран ажиллаж байна. Мөн номын сангийн холбогдох ажилтнуудад галын дохиоллын системийг ажиллуулах сургалт зохион байгуулсан. - “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-г шинэчлэн тодотгож, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын газраар батлуулан ажиллаж байна. - “Галын аюулгүй ажиллагааг хангах төлөвлөгөө” –г батлуулан ажиллаж, Сүхбаатар дүүргийн ОБГ-ын үзлэгээр “Сайн” үнэлгээ авлаа.

	4.1.4.Уншлаганд гарсан болон шинээр ирсэн бүх ном хэвлэлийг тавиурт байрлуулж, фондуудын эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах , ялгагчуудыг шинэчлэх ажлыг тогтмол хийж байна. - Тайлангийн хугацаанд 5957 төвд ном судрыг ялгаж цэгцэллээ. Компьютерийн каталогт орсон төвд ном судраас 5107 номыг дансанд бичиж, 1881номыг каталогт оруулж, 2758 карт бичсэн. - 6022 шхуучин хятад номын дансны дугаарыг компьютерт бичиж, хэвлэн, нааж байрлуулсан. - Өрнө дахины фондын номуудад байрын сунгалт хийж ННА-ын дагуу үсгийн дэс дарааллаар тавиурт байрлуулж, байрын зохион байгуулалт хийсэн. Үүнд:п012-п9 ангийн 27731 ном, 37-371 ангийн 7537 ном, угсаатан зүй судлал 902-902.8 ангийн 6474 ном, түүх 3к1-3к26 ангийн 2958 ном, ХАА 631-674 ангийн 5000 ном нийт 49700 номыг эмхэлж цэгцэлсэн.13 ангиас П541 ангийг дуустал нийт 45788 номыг эмхэлж цэгцэлсэн. 24000 ширхэг төрөл ангийн болон үсэг дараалтын ялгагч хийж байрлуулсан. - Тогтмол хэвлэлийн фондын эмх цэгцийг сайжруулж, шинээр авсан тавиурт 330 нэгж сонин, 80 нэрийн 330 нэгж сэтгүүлийг зөөж байрлуулав. Шинээр ирсэн 3182 сонин, сэтгүүлийг хүлээн авч, бүртгэлээ. -Монгол фондын III форматын 4000 орчим номыг төмөр тавиурт байрлуулж, эмхэлж цэгцэллээ. 4.1.5. Байгууллагын “Өмч хамгаалах комисс”-ын дүгнэлт, ССАЖЯ-ны зөвшөөрлийг үндэслэн ТӨХ-ноос данснаас ном хасах зөвшөөрлийг авч, Төрийн өмчийн хорооны 2014 оны 04 сарын 24-ний өдрийн 177 тоот тогтоол, номын сангийн захирлын 2014 оны 5 сарын 5-ны 18 тоот тушаалын дагуу номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 162 нэрийн 499662,73 төгрөгийн балансын үнэ бүхий номыг ерөнхий данснаас хасч, 152 ширхэг 1476500 төгрөгийн үнэ бүхий номыг бүртгэн авч, орлого зарлагыг холбогдох нэгдсэн бүртгэлд тусгалаа. 4.1.6. 549 нэгж сонин сэтгүүлийг хавтаслаж, 1432 урагдаж алга болсон хуудсыг хувилж,1540 ном диссертаци сэлбэн засаж, үдэж хавтаслав. 326988 ном хэвлэлийг ариутгалаа. - Хандиваар оёсон 118 ширхэг баринтагийг хүлээн авч ном судрыг баринтагласан.
Тав.Удирдлагын маркетинг, менежментийг боловсронгуй болгох стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:	
5. Удирдлагын маркетинг, менежментийг боловсронгуй болгох,	5.1.1.Сан хөмрөгийн тооллогыг зохих журмын дагуу хийх, үнэт ховор ном судрын бүртгэл мэдээллийн санг зохих журмын дагуу хөтлөх зэргээр дотоод хяналт, шалгалт зохион

5.1.Байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах, хүний нөөцийн хангамж, ашиглалтыг боловсронгуй болгох 5.1.1. "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу байгууллагын дотоод хяналт, зохион байгуулалтыг сайжруулна. 2014 он, жилийн туршид 5.1.2. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт болон "Хөдөлмөрийн гэрээ"болон холбогдох зарим журмуудад өөрчлөлт шинэчлэлт оруулна. 2014 он, 1-2-р улиралд 5.1.3. Үндэсний номын сангийн хүний нөөцийн судалгааг гаргах, стандартын дагуу орон тоог нэмэх асуудлыг боловсруулж, холбогдох байгууллагад явуулна. 2014 онд	байгуулалтыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна. - Захиргаанаас томилогдсон комисс байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах, хүний нөөцийг хангамж , ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг судлах, боловсронгуй болгох зорилгоор бүх хэлтэс, тасаг, номын санчид, ажилтнуудын ажилтай / нийт 53 номын санчид, ажилтнуудын ажлыг шалгасан / танилцаж, ажил үүргийн хуваарилалтыг зохицуулах ажлыг хийсэн. 5.1.2.Номын сангийн нийт ажилтнуудын "Ажлын байрны тодорхойлолт"-ыг шинээр боловсруулж, мөрдөн ажиллаж байгаагийн зэрэгцээ "Хөдөлмөрийн гэрээ"-г шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. 5.1.2. Байгууллагын зүгээс хүний нөөцийг чадавхижуулах, нарийн мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах, /гар бичмэл сэргээн засварлагч, инженер техникийн ажилтнууд г.м/ гадаад хэлний боловсролыг дээшлүүлэх сургалтуудыг бодлогын түвшинд зохион байгуулан ажиллаж байна. - Ажилчдын цалин, албан тушаалын болон хавсран гүйцэтгэх ажил үүргийн жагсаалт, ээлжийн амралтын хуваарийг батлан ажиллаж байна. -Ажилтнуудаас ирсэн 50 өргөдөл, санал хүсэлтийг хүлээн авч бүртгэн, цаг тухайд нь шийдвэрлэн ажиллаж байна. -Архивын лавлагааг 18 иргэнд гарган өгч, 2013 оны захирлын тушаал, ирсэн болон явуулсан албан бичгүүдийг үдэж хавтаслах, Архивын заавар журмын дагуу зарим бичиг баримтыг шинэчлэн үдэж хавтаслах ажлыг хийлээ. Үндэсний номын сангийн хүний нөөцийн судалгааг гаргаж, шаардлагатай орон тоо болон орон тоог нэмэгдүүлэх үндэслэлийг боловсруулж, ССАЖЯ-нд хүргүүлсэн. Номын санд гар бичмэл сэргээн засварлагч, эрдэм шинжилгээний ажилтан, дижитал сан үүсгэх техникийн ажилтан, сүлжээний инженер зэрэг орон тоо нэн тэргүүнд шаардлагатай байгаа юм.
5.2. Номын санчид, ажилтан албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх 5.2.1. Номын сангийн ажилтнуудын мэдлэг чадвараа дээшлүүлэхэд анхаарч, гадаад, дотоодод сурах,	5.2.1. Байгууллагын зүгээс номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, гадаад хэлний боловсролоо дээшлүүлэхэд онцгой анхаарч, суралцах боломжоор хангаж, дэмжин ажиллаж байна.Үүнд: - 2 ажилтан Засгийн Газрын тэтгэлгээр ОХУ-ын Соёл Урлагийн Академид магистрын зэрэгтэйгээр суралцаж төгслөө. - Нэг ажилтан ШУТИС, МХТС-ийн магистрын сургалтанд., -Нэг ажилтан Удирдлагын академийн мэргэшүүлэх дипломын сургалтанд.,

мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа болон гадаад хэлний чиглэлээр суралцахад дэмжлэг үзүүлнэ. 2014 он, жилийн туршид 5.2.2. Номын санчид, ажилчдад зориулсан төрөл бүрийн лекц, ярилцлага, уралдаан тэмцээн зохион байгуулна. /4удаа/ 2014 он, жилийн туршид	- OCLC олон улсын каталогийн 3 хоногийн сургалтанд 5 ажилтан., - СУИС-ийн магистрын сургалтанд 1 ажилтан., - “Монгол улс дахь соёлын өвийн хадгалалт, сэргээн засварлалт” 5 хоногийн сургалтанд 3 ажилтан., - Удирдлагын Академи, Австрийн Клагенфуртын их сургууль хамтран зохион байгуулсан “Байгууллагын хөгжил ба манлайлал” сургалтанд 1 ажилтан., - Англи хэлний сургалтанд 1 ажилтан., -Номын баярын арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Номын хэрэглээг нэмэгдүүлэх, “Номын сангийн шинэлэг үйлчилгээ” сургалтанд 4 ажилтан., - “LIBRARY UPDATE-2014 гишүүд дэмжигчдийн анхдугаар зөвлөгөөнд болон “Номын сангийн шинэлэг үйлчилгээ” сургалтанд 5 ажилтан тус тус хамрагдлаа. - Хүний нөөцийг чадавхжуулах, гадаад хэлний боловсролыг дээшлүүлэх зорилгоор байгууллагаас англи хэлний курсыг зохион байгуулж, мэргэжлийн багштай 6 сарын курст 13 ажилтныг суралцууллаа. -Гадаадын номын сангуудад 8 ажилтныг туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд, нэг ажилтан Австрали улсын Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, номын сангийн дижиталчлалын чиглэлээр суралцахаар боллоо. - Тайлангийн хугацаанд нийт 42 ажилтныг мэргэжил дээшлүүлэх, шинэ мэдлэг мэдээлэл, чадвар эзэмших, туршлага судлах гадаад дотоодын урт болон богино хугацааны сургалтанд хамруулсан байна. 5.2.2. Номын сангийн ажилтнуудад эрүүл амьдрах мөн танин мэдэхүйн мэдлэг олгох, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгууллаа.Үүнд: - “Архив бичиг хэргийн хөтлөлт” сэдэвт лекц-хичээлийг Архивын Ерөнхий газрын ахлах арга зүйч Б.Дашдолзодоор., /54 хүн оролцсон./ - ҮЭХ-той хамтран “Нийгмийн даатгал болон татварын тухай” сэдэвт лекц., - “Гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжууд” сэдэвт лекцийг номын сангийн ажилтан М.Даваасүрэн., - “Дэлхийн соёлын төв Санкт-Петербург хотоор” сэдвээр мэдээлэл, танилцуулгыг номын сангийн магистр Г.Гүнжинлхам, Б.Баяртуяа нар., - ӨМӨЗОрны номын сан, Ордос, Бугат хотын номын сангийн үйл ажиллагаа, шинэлэг үйлчилгээний тухай танилцуулгыг номын сангийн захирал А.Нансалмаа., - “Алсын хөгжил” ТББ-тай хамтран “Хүннүгээс өмнөх төрт улсын улбаа” лекцийг /нийт 6 удаа/ тус тус зохион байгуулж, номын санчид, ажилтнуудыг хамрууллаа.

	- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр, Цэргийн баярыг тохиолдуулан номын санчдын бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор волейбол, теннис, дартс, даам, дээсний 4 төрөлт тэмцээнийг байгууллагын ажилтнуудын дунд зохион байгууллаа. Уг тэмцээнд 5 баг оролцсон бөгөөд багийн нэг гишүүн нэг л спортын төрөлд оролцох эрх олгосон нь багийн хүн бүрийг хамарч оролцуулах нөхцлийг бүрдүүлсэн төдийгүй тэмцээнийг өрсөлдөөнтэй, сонирхолтой болгосон юм. Тэмцээнд С.Батбаяр ахлагчтай “Эвтэй байхдаа хүчтэй” баг түрүүлж шилжин явах цом, өргөмжлөлөөр шагнагдлаа. - Батлан Хамгаалах их сургуулийн номын сангаас зохион байгуулсан уламжлалт номын сангуудын сагс, волейбол, теннис, шатрын аварга шалгаруулах спортын тэмцээнд алт 2, мөнгө 1, хүрэл медаль 2-ийг хүртэж Үндэсний номын сангийн хамт олон багаараа номын сангийн салбарын 2014 оны аварга багаар шалгарч, шилжин явах цомоор шагнууллаа. - ССАЖ-ын Сайдын нэрэмжит соёл, урлагийн байгууллагуудын спортын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, тус номын сангийн эмэгтэй баг сагс, волейболын тэмцээнд алт, мөнгөн медаль, теннисний төрөлд мөнгөн медаль хүртэж, Үндэсний номын сан багаараа ССАЖЯ-ны хэмжээнд 2-р байр эзэлсэн. - Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан ССАЖЯ-аас соёл урлагийн байгууллагуудын дунд зохион байгуулсан олс таталт, “Уран бичлэгийн уралдаан”, “Шилдэг хос” шалгаруулах уралдаанд тус бүр 1-р байр эзэлж, “Шилдэгийн шилдэг” байгууллагаар шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнууллаа.
Зургаа:“Мэргэжлийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагуудтай стратегийн түншлэл байгуулж, харилцан ашигтай ажиллах” байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:	
6.Гадаад, дотоод хамтын ажиллагааг харилцан ашигтай өргөжүүлэх 6.1.Гадаадын үндэсний номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах 6.1.1.Гадаад орны Үндэсний номын сан, эрдэм шинжилгээний олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. /Чех улсын номын сантай 1-2 мэргэжилтэн солилцох/ 2014.11.01-ний дотор	6.1.1. Гадаадын харилцаат номын сангуудтай / ОХУ, БНСУ, БНХАУ, Япон/ зэрэг 10 гаруй номын сантай номын солилцоо хийж байна. 6.1.2. Чех Улсын Үндэсний номын сантай хамтын ажиллагааны гэрээний дагуу мэргэжилтэн солилцох, туршлага судлах ажлыг хийж байна. Энэ онд нэг ажилтныг Чех улсын Үндэсний номын санд дижиталчлалын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх 18 хоногийн сургалтанд хамрууллаа. - Монгол – Австрали 2 улсын Засгийн Газрын хэлэлцээрийн дагуу монгол оюутнуудыг сургах Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрийн магистрын сургалтанд “Номын сангийн дижиталчлал”-ын чиглэлээр нэг ажилтан суралцахаар боллоо.

6.1.2.Гадаадад номын санчдыг сургах асуудлыг боловсруулах, туршлага судлах, олон улсын хуралд номын санчдыг оролцуулна. /3-5 номын санчийг хамруулах/ 2014 он, жилийн туршид	- ОХУ-ын Буриад Улсын Үндэсний номын сангийн захирал тэргүүтэй төлөөлөгчид номын санд айлчилж, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцэж ярилцлаа. Буриад Улсын Үндэсний номын сангаас тус номын сан ном хандивлах гэрээ байгуулан ажиллаж байна. - Буриадын Үндэсний номын сантай хамтран Буриадын зохиолч А.С.Гатаповын “Тэмүжин” 2 боть номын нээлтийн ажиллагааг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэл, Буриад Улсын Соёлын сайд Т.Г.Цыбиков, нар оролцлоо. Түүнчлэн Буриад Улсын Соёлын яамны соёл урлагийн хэлтсийн дарга Т.Б.Дугарова, Буриад Улсын Дуурь бүжгийн театрын захирал О.В.Цыбикдоржиева, Буриад Улсын филармонийн захирал Н.О.Балсунаева, Буриад Улсын Хүүхэлдэйн театрын дарга Б.Г.Дашидоржиева, Буриад Улсын Их сургуулийн багш Г.В.Тартыгашива, Буриад Улсаас Монгол улсад суугаа байнгын төлөөлөгчийн газрын зөвлөх Б.Ч.Хасаранов нар оролцож, хоёр орны соёлын хамтын ажиллагаа жилээс жилд бэхжин шинэлэг хэлбэрээр өргөжин баяжиж байгааг харуулсан арга хэмжээ болсон юм. - Япон Улсын номын сан болон шинэ техник технологитой танилцах, туршлага судлах 5 хоногийн сургалтанд тус номын сангийн компьютерийн ажилтанг хамруууллаа. - ОХУ-ын Судакт болсон “Крым-2014” олон улсын хуралд тус номын сангаас нэг ажилтан оролцлоо. - Өвөрмонголын Өөртөө Засах орны номын сантай хамтран ажиллах гэрээний дагуу харилцан 6 ажилтныг солилцож, туршлага судаллаа. Монголын төлөөлөгчид ӨМӨЗОрны номын санд айлчлах үеэр 2 номын сангийн хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурлаа. - ӨМӨЗОрны номын сангийн төлөөлөгчид Үндэсний номын сангаас гадна Хотын төв номын сан, Хүүхдийн номын ордны номын сангийн үйл ажиллагаа болон Монголын түүх соёлын дурсгалт газруудтай танилцлаа. - Үндэсний номын сангийн төлөөлөгчид ӨМӨЗОрны номын сан, Хотын номын сан, Ордос болон Бугат хотын шинээр ашиглалтанд орсон шинэ барилга болон номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа. - Юнескогийн Бээжингийн салбар болон Юнескогийн Монголын Үндэсний Комисстой “Цаасан баримтат өвийн хадгалалт, хамгаалалт” төсөл болон үнэт ховор гар бичмэл ном судрыг бүс нутгийн өвд бүртгүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, “Сандуйн жүд”, “Хор чойнжүн” бүтээлүүдийг шинээр тодорхойлж илгээсэн болно.Мөн хамтын ажиллагааны

	хүрээнд "Сахиусан дара эх" бүтээл Ази-Номхон далайн бүс нутгийн өвд бүртгэгдлээ.
Долоо:"Төсөв санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах" стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:	
7.Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тооцооны системийг боловсронгуй болгох 7.1.Төсвийг оновчтой хуваарилах, санхүүгийн тайлан мэдээ, үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэлийг сайжруулах 7.1.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, 7.1.2.НББББ-г боловсруулах, 7.1.3.Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам зааврыг чанд мөрдөн санхүүгийн тайлан холбогдох мэдээг үнэн зөв, хугацаанд нь гаргана. 7.1.4.Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллого бүртгэлийг хийх. 2014 он, жилийн турш	7.1. Номын сангийн үйлчилгээ, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар тогтмол хэвлэл болон судрын тавиур 40 ш, каталогийн шүүгээ 13 ширхэгийг авч, төвдийн, тогтмол хэвлэлийн, архивын фондуудад суурилуулж, тавиур дээр багтахаа больсон ном хэвлэл, судрыг байрлууллаа. Эрдэм шинжилгээний каталогийн шүүгээг иж бүрнээр сольж, тав тухтай орчин нөхцлийг бүрдүүллээ. - Уншигчдад түргэн шуурхай үйлчлэх зорилгоор хувцас хадгалах 18 шкафыг худалдан авч, тохижуулах ажлыг хийхээр төлөвлөөд байна. 7.1.1.Тус номын сан нь Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2014 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж, уг гэрээний дагуу 890,101.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаагаар 32737,4 мянган төгрөгийн орлого олж, батлагдсан төсвийн дагуу үр ашигтай зарцууллаа. 2014 онд урсгал үйл ажиллагааны 900035017 тоот дансаар байгууллагын үйл ажиллагааны зардал болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлуудын гүйлгээг тухай бүр хийж, ажилчдын цалин хөлсийг сар бүрийн 8, 23 нд олгож цалингийн өр, авлагыг данс бүртгэлд тусган ажиллалаа. - Нэмэлт санхүүжилтийн 900035402 тоот дансаар ССАЖСайдын 2014 №А/305, СУХСангийн №63 тоот гэрээгээр батлагдсан 10 сая төгрөг, ССАЖСайдын 2014.04.17 №А/136 ,СУХСан №24 тоот гэрээгээр батлагдсан "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын 27,842.0 төгрөг,ССАЖСайдын 2014.04.14 №А/131 тоот тушаалаар батлагдсан "Шилдэг ном 2013"-ийн 600.0 төгрөг, ССАЖ-ын Сайдын 2014.04.08 №А/114 тоот тушаалаар батлагдсан "Үзмэр худалдан авах" 32,290 төгрөг, Сангийн сайдын 2014 оны №143 тоот тушаалаар батлагдсан төсвийн урамшууллын 28,648.6 төгрөгийг санхүүжилтийн эрхийг харъяалагдах дээд шатны байгууллагаар шийдүүлэн, зарлагын гүйлгээг тухай бүр гарган тайлагнан ажиллалаа. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын 2014 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Үндэсний номын сангийн 2012, 2013 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2014 оны 08 сарын 12-ны өдрөөс ажлын 20 хоногт багтаан хяналт шалгалтыг хийж тухайн байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд зөрчил дутагдал илрээгүй, бага эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан. 7.1.2.НББББ-г боловсруулах санал төсвийг холбогдох дээд байгууллагад хүргүүлээд байна.

	7.1.3. Тайлангийн хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг мөрдлөг болгон НББОУС-д нийцүүлэн үйл ажиллагаагаа тайлагнаж ирлээ.Мөн Сангийн сайдын тушаалаар батлагдсан ТТ-1, ТТ-2, МГТ-1, ЗЭБ-2 маягтаар төсвийн гүйцэтгэлийг сар бүрийн 2-ны дотор үнэн зөв гаргаж, төсвийн статистик мэдээллийг Төрийн санд өгч хэвшлээ. 7.1.4.Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, НББТХ-ийн 11.1 заалтыг үндэслэн МҮНС-ийн захирлын А/35 тоот тушаалаар 2014 оны эд аж ахуйн тооллогыг зохих журмын дагуу хийж, тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар оруууллаа. 7.1.5.Сангийн сайдын “Түүх соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох” тухай №140 тоот тушаалыг үндэслэн Үндэсний номын сангийн захирлын тушаалаар томилогдсон “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн дансны үнэ шинэчлэн тогтоох комисс нь 2013 оны 10-р сарын 31-нээс 2014 оны 1-р сар хүртэл “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” 7 дэвтэрт бүртгэгдсэн 516 дэсийн эд өлгийн зүйлийн үнийг тогтоож, нийт 2.974.884.400 төгрөгөөр үнэлсэн. - Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын 2014 оны 01-р сарын 07-ны өдрийн №05/055/10 тоот дүгнэлтэнд “...1.1.Тооллогын явцад сан хөмрөгийн үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн үнэлгээг журмын дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэжээ. Гэвч Монголд төдийгүй дэлхийд дахин давтагдашгүй бүтээлүүдийн үнэлгээ дэндүү доогуур хийгдсэн нь эрсдэл дагуулах боломжийг бий болгож байна. Иймээс Сангийн сайдын 2013 оны 06-р сарын 17-ны өдрийн 140 дугаар тушаалаар баталсан журамд өөрчлөлт оруулах, МҮНС-ийн музейн үзмэрийн үнэлгээг дахин боловсруулах ажлын хэсэг гаргах шаардлага байна.” гэж дүгнэсэн.Одоогийн байдлаар Үнэт ховор номын музейн ном судрын шинэчилсэн үнэлгээг дансанд тусгахыг түр хугацаагаар хойшлуулан дээд шатны байгууллагын санал, шийдвэрийг хүлээж байна.
Найм : “Номын сангийн орчин нөхцлийг сайжруулах”стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:	
8. Номын сангийн орчин нөхцлийг сайжруулах 8.1. Үйлчилгээний тав тухтай орчин бий болгох 8.1.1. Үндэсний номын сангийн шинэ барилгын ажлыг эхлүүлэхэд бүх	8.1.1 Үндэсний номын сангийн шинэ барилга болон өргөтгөлийн барилгын зургийн ажлыг Зураг төслийн “Эгэл” ХХК хийж дууссан бөгөөд номын сан нь шаардлагатай техникийн нөхцлийн зөвшөөрлүүдийг авч, ССАЖЯ-нд хүлээлгэн өгсөн. -Үндэсний номын сангийн шинэ барилга барих тендерт Барилга угсралтын “Акми” ХХК шалгарч, 2014 оны 08-р сарын 28-нд барилгын суурь тавих ёслолын ажиллагааг зохион байгуулж, 09-р сарын 05-нд барилгын ажил эхэлсэн. - Номын сангийн шинэ барилгын талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчиллаа. -Шинэ барилгатай холбогдолтой асуудлыг ССАЖЯ болон холбогдох байгууллагуудтай

талаар дэмжиж оролцоно. 2014 он, жилийн туршид 8.1.2. Номын сангийн дулаан, сантехник, цахилгааны аюулгүй ажиллагааг хангаж, хэсэгчилсэн засвар үйлчилгээг тогтмол хийнэ. 2014 он, жилийн туршид	харилцаж, тухай бүр нь шийдвэрлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд АНУ-ын ЭСЯ-тай газрын маргаантай асуудал гарсан бөгөөд ССАЖЯ-ны мэргэжилтнүүдтэй хамтран АНУ-ын ЭСЯ, ГХЯ, Нийслэлийн газрын алба зэрэг байгууллагуудын холбогдох ажилтнуудтай уулзаж, асуудлыг танилцуулж ажилласан. 8.1.2.ССАЖЯ-аас зарласан тендерийн дагуу тус номын сангийн галын дохиоллын системийг иж бүрэн сольж суурилуулах 29.960.000 төгрөгийн засварын ажлыг “Тэргэл Тех” компани хийж гүйцэтгэлээ. “Галын дохиоллын систем суурилуулах, галын аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжөөр хангах” тендерийн үйл ажиллагаанд номын сан хяналт тавьж ажилласан болно. - Дулаан, сантехникийн аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьж, бохир цэвэр усны системд засвар үйлчилгээ, Монгол фонд, Архив бэлтгэл фонд болон зоорийн давхрын шугаманд хэсэгчилсэн засвар, үйлчилгээг хийлээ. Мөн зоорийн давхрын цоорсон трубаг шинээр солих, гадна талбайд байрлах дулааны болон бохирын худгуудыг цэвэрлэх, шаардлагатай шугам сүлжээ, радиаторыг солих зэрэг дулаан, сантехникийн хэвийн аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна. - Номын сангийн цахилгааны аюулгүй ажиллагаанд хяналт тавьж, үзлэг шалгалтыг тогтмол хийж байна. Агааржуулалтын моторыг шинээр солих, 530 ширхэг холболтын хропыг шалгах, цахилгааны хэрэгсэлүүдийг шалгаж, солих ажлуудыг тухай бүр нь хийлээ. Ааарын гарцны 19 таних тэмдгийг шинээр хийж, 40 галын хорыг тохирох түвшинд байрлууллаа. - Хувилан олшруулах үйлчилгээг автоматжуулж, орчин үеийн BIZHUB 3 үйлдэлт ухаалаг каноныг уншлага үйлчилгээнд нэвтрүүлж, уншигч хэрэглэгчдэд түргэн шуурхай чанартай үйлчилгээг үзүүлж байна. - Номын сангийн архивын өрөөний хана тааз, шалыг засварлах ажлыг хийж дуусгалаа.
Ёс : “Ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх” стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:	
9.Номын санчдын нийгмийн асуудлыг анхаарч, урамшууллын системийг боловсронгуй болгох 9.1.Нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэх 9.1.1.Үйлдвэрчний Эвлэлийн Хороотой хамтын гэрээ байгуулж	9.1.1. Номын сангийн захиргаа нь Үйлдвэрчний эвлэлийн Хороотой хамтран ажилтнуудын нийгмийн асуудал, ажил эрхлэлт, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлс, урамшуулал, ажил амралт, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр хамтын гэрээ байгуулан ажиллаж байна. - Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хурлыг 2 удаа хийсний зэрэгцээ эх үрсийн баяр, шинэ жилийн баяраар гишүүдээ урамшуулах ажлыг зохион байгууллаа. - Номын санчдын ажлын үр дүн, амжилт бүтээлийг үнэлэн урамшуулж, дээд байгууллагын шагналд тодорхойлох, байгууллагын шилдэг ажилтныг шалгаруулах,

ажиллана. 9.1.2.Номын санчдын нийгмийн асуудалд анхаарч, халамж үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлнэ. 9.1.3.Эрүүл мэндийн үзлэгт нийт ажилтнуудыг хамруулна. 2014 он, жилийн туршид 9.1.3. Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийгхүлээн авах, хүндэтгэл үзүүлнэ. 2014.02.10-ны дотор 9.1.4.Ур чадварын нэмэгдэл, шагнал урамшууллын системийг оновчтой болгож, журмын дагуу олгоно. 2014 жилийн туршид	зэргээр номын санчдын бүтээлч санал санаачлагыг дэмжин ажиллаж байна. Энэ онд:Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1 ажилтан, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр 4 àæèëòàí , 10 ажилтан БСШУЯ-ны “Жуух бичиг”-ээр, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр 5 ажилтан, Хөдөлмөрийн яамны Тэргүүний ажилтан цол тэмдгээр 1 ажилтан, Үндэсний номын сангийн “Шилдэг ажилтан”-аар 1 ажилтан, “Захирлын нэрэмжит шагнал”-аар 5 ажилтан тус тус шагнагдлаа. - Шагнагдсан ажилтнууд болон 2014 онд ажлын амжилтаар шалгарсан 6 ажилтныг байгууллагын дотоод журмын дагуу мөнгөн урамшууллаар тус бүр шагналаа. 9.1.2. Номын санчдын нийгмийн асуудалд анхаарч, зохих хууль дүрмийн дагуу тэтгэмж, тэтгэлэг, шагнал урамшууллыг олгож байна. - Номын сангийн хоёр ажилтан орон сууцны зээлд хамрагдаж, байгууллагын дотоод журмын дагуу нөхцлийн нэмэгдэлийг 19 хүнд тус тус олголоо. -Тайлангийн хугацаанд нийт 25 хүний санал хүсэлт, өргөдлийг хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлүүлснээс гадна 2 хүнд 7.481.532 төгрөгийн тэтгэмж, 4 хүнд 1.198.461 төгрөгийн урамшуулал олгож, нийт 8.679.993 төгрөг зарцуулсан байна. Энэ онд байгууллагаас 3 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд захиргаа болон хамт олноос ажил хөдөлмөрийн амжилтыг нь тэмдэглэсэн юм. 9.1.3. ЭМШУИС-ийн эмнэлэгтэй гэрээ байгуулж, ажилтнуудыг эрүүл мэндийн оношлогоо эмчилгээнд хамруулах ажлыг ҮЭ-ийн байгууллагатай хамтарч зохион байгуулж, эмнэлгийн үзлэгт бүх ажилтнуудыг хамрууллаа. -Номын сангийн өндөр настнуудыг Сар шинийн баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. 9.1.4. Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дүгнэж, 39 ажилтанд нэмэгдэл олгосон.
Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО	

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)* ***бүрээр хүрэх түвшин***	***Жинхэнэ гүйцэтгэл*** *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)*
1	2
1.Үндэсний номын сангийн шинэ	Үндэсний номын сангийн шинэ барилга болон өргөтгөлийн барилгын зургийн ажлыг

барилгын ажлыг эхлүүлнэ.	Зураг төслийн "Эгэл" ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд номын сан нь шаардлагатай техникийн нөхцлийн зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авч, ССАЖЯ-нд хүлээлгэн өгсөн. /Дэлгэрэнгүйг нийт арга хэмжээний биелэлтийн 8.1.1-д үзнэ үү.
2. Сонины цахим мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	- Сонины цахим мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор төвийн тогтмол хэвлэлүүдээс "Үндэсний шуудан" сонины 142 дугаарыг зурган файл руу хөрвүүлэх, "Өдрийн сонин"-ы 2011 оны дугаарууд, 2012 оны эхний улирлын дугаарууд, "Монголын мэдээ" сонины 2013 оны 112ш, 2014 оны 204ш, Хөх толбо сонины 265ш дугаарыг засч, баазад оруулан хадгаллаа. Баазад оруулсан сонингуудыг дотоод сүлжээгээр уншигчдад хүргэхээр ажиллаж байна. /Дэлгэрэнгүйг Нийт арга хэмжээний биелэлтийн 3.2.5-д үзнэ үү./
	Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуурүзүүлэлт бүрээрхүрэх түвшин	***Жинхэнэ гүйцэтгэл*** *(шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)*
1	2
1. Зорилт 1: Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1.1. Төрийн албаны тухай хууль,Төрийн аудитын тухай Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөнө. 1.2Архи, тамхины хуулийг байгууллагын ажилтнууд, үйлчлүүлэгчдийн хүрээнд сурталчилж, номын сан архи тамхигүй орчин болно. 1.3. Үүрэгт ажлаа цаг хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэнэ.	1.1.Төрийн албаны тухай хууль,Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Архи, тамхины хуулийг болон бусад холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллаж байна. 1.2. Архи, тамхины хууль сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Байгууллагын арын талбайд тамхины тусгай цэг байгуулж, тамхи, архины хор хөнөөл, галын аюулгүй байдлын талаар мэдээллийн самбар, зурагт хуудсаар сурталчлах ажлыг хийж байна. 1.3. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай биелүүлж, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг зорилтуудыг хангаж, үүрэгт ажлаа цаг тухайд нь чанартай гүйцэтгэсэн.

2. Зорилт 2: Байгууллагын ил тод байдлыг хангах 2.1. Байгууллагын үйлчилгээ болон зохион байгуулж буй ажлыг уншигчдадцаг тухайд нь сурталчилна. Цахим үйлчилгээг ашиглан мэдээллийг хүргэх ажиллагааг эрчимжүүлнэ.	2.1. Байгууллагын өдөр тутмын үйлчилгээ болон зохион байгуулж буй соёл олон нийтийн ажлыг цаг тухайд нь мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ТВ, радио, интернэт, сонин сэтгүүл, өөрийн байгууллагын вэб сайт, facebook хуудсаар дамжуулан сурталчилж мэдээллийг хүргэж байна. - “Хүн төрөлхтөний оюуны охиос танд хүртээнэ” – Үндэсний номын сангийн сурталчилгааг хийж, мэдээллийн хэрэгсэлээр сурталчилж байна. - Үндэсний номын сангийн каталогийг OCLC олон улсын онлайн каталогт оруулах ажлыг зохион байгуулж, төвд судар 886, монгол гар бичмэл ном 16, Монгол ном 98, нийт 1000 номыг оруууллаа. - Уншигч хэрэглэгчдэд цахим мэдээллийг хүргэх зорилгоор гар бичмэл, ном судрын цахим үйлчилгээг нэвтрүүлж, энэ онд гар бичмэл, барын 861 боть /68656хуудас/ ном судрыг тоон хэлбэрт оруулж, уншигчдад үйлчилж байна. /Дэлгэрэнгүйг нийт арга хэмжээний биелэлтийн 3.1.2.,3.1.3., 3.2.1.,3.2.3.,3.2.4.,3.2.5-д үзнэ үү./
3. Зорилт 3:Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдал, оролцоог хангах, түүнийг зүй зохистой зарцуулах 3.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулна. 3.2. Нягтлан бодох бүртгэлийн стандарт, дүрэм зааврыг чанд мөрдөнө.	3.1. Тус номын сан нь Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2014 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж, уг гэрээний дагуу 890,101.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаагаар 32737,4 мянган төгрөгийн орлого олж, батлагдсан төсвийн дагуу үр ашигтай зарцууллаа. 3.2. Тайлангийн хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг мөрдлөг болгон НББОУС-д нийцүүлэн үйл ажиллагаагаа тайлагнаж ирлээ.Мөн Сангийн сайдын тушаалаар батлагдсан ТТ-1, ТТ-2, МГТ-1, ЗЭБ-2 маягтаар төсвийн гүйцэтгэлийг сар бүрийн 2-ны дотор үнэн зөв гаргаж, төсвийн статистик мэдээллийг Төрийн санд өгч хэвшлээ.
4. Зорилт 4:Байгууллагын эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах 4.1. Эд хөрөнгийн тооллого бүртгэлийг цаг тухайд нь үнэн зөв хийнэ.	4.1. Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, НББТХ-ийн 11.1 заалтыг үндэслэн МҮНС-ийн Захирлын А/35 тоот тушаалаар 2014 оны хагас жилийн болон жилийн эцсийн эд аж ахуйн тооллогыг зохих журмын дагуу хийж, тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар оруулаа. - Шинээр авсан ном хэвлэлийг номын сангийн зохих дүрэм журмын дагуу данс, бүртгэлд бүртгэж байна.
5. Зорилт 5:Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх 5.1. Номын санчдыг мэргэжлийн	5.1. Тус номын сан нь номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, гадаад хэлний боловсролоо дээшлүүлэхэд онцгой анхаарч, суралцах боломжоор хангаж, дэмжин ажиллаж байна.

чиглэлээр урт, богино хугацааны сургалтандхамруулахад байгууллагаас дэмжлэг үзүүлнэ. 5.2.Үйлчилгээний соёл, ёс суртахууны талаар лекц, сургалт зохион байгуулна	Энэ хугацаанд Чех, Япон, ОХУ-д мэргэжил дээшлүүлэх , туршлага судлах сургалт болон олон улсын хуралд 3 ажилтан, Австрали улсад магистрын сургалтанд тэнцэж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, гадаад хэлний боловсрол олгох төрөлжсөн сургалтанд нийт 42 номын санчдыг хамруулсан байна. 5.2.Номын сангийн ажилтнуудад эрүүл амьдрах, мөн танин мэдэхүйн мэдлэг олгох, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгууллаа. - “Архив бичиг хэргийн хөтлөлт” сэдэвт лекц-хичээл, ҮЭХ-той хамтран “Нийгмийн даатгал болон татварын тухай” сэдэвт лекц, “Алсын хөгжил” ТББ-тай хамтран “Хүннүгээс өмнөх төрт улсын улбаа” лекцийг /нийт 6 удаа/ тус тус зохион байгуулж, номын санчид, ажилтнуудыг хамрууллаа. - Үндэсний номын сангийн номын санчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, нийт 14 сэдвээр 22 цагийн хичээлийг бэлтгэж, 43 номын санчид 2 өдрийн сургалтыг зохион явууллаа. Уг сургалтын талаар номын санчдаас авсан “Сэтгэл ханамжийн судалгаа”-ны асуулгыг боловсруулж судалгааг 39 номын санчаас авлаа. /Дэлгэрэнгүйг нийт арга хэмжээний биелэлтийн 5.2.1., 6.1.2-д үзнэ үү./ -Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр, Цэргийн баярыг тохиолдуулан номын санчдын бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор волейбол, теннис, дартс, даам, дээсний 4 төрөлт тэмцээнийг байгууллагын ажилтнуудын дунд зохион байгууллаа. /Дэлгэрэнгүйг нийт арга хэмжээний биелэлтийн 5.2.2-д үзнэ үү./
Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО	

ДҮГНЭЛТ

Үндэсний номын сан нь тайлангийн хугацаанд соёл урлагийг хөгжүүлэх Шинэчлэлийн Засгийн Газрын бодлогыг хэрэгжүүлж, номын сангийн хууль эрх зүйн орчинг сайжруулахад хувь нэмрээ оруулж, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүний нөөцийг чадавхижуулах, номын сангийн үйлчилгээнд шинэ техник технологи нэвтрүүлэх, үндэсний өв соёл, бичиг үсгээ хадгалж хамгаалах, сурталчлах, хот, хөдөө, орон нутгийн номын сангуудыг арга зүйн удирдлагаар хангах, номын сангийн аюулгүй ажиллагааг хангаж, уншигч үйлчлүүлэгчдийн тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх зэрэг олон асуудлуудыг амжилттай шийдвэрлэж ажиллалаа.

2014 он нь номын сангийн салбарын хувьд Үндэсний номын сангийн шинэ барилгын ажил эхэлсэн, “Номын сангийн хууль”, “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийг батлуулсан зэрэг номын сангийн салбарт үлэмж ач холбогдол бүхий томоохон ажлуудын эхлэлийг тавьсан өгөөжтэй жил боллоо.

Цаашид ССАЖЯ-нд уламжилж нэн тэргүүнд шийдвэрлүүлэх асуудлууд:

1. Үндэсний номын сангийн орон тоог нэмэгдүүлэх, боловсон хүчнийг чадавхижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
2. / “2010-2016 оны Үндэсний номын сангийн стратеги”-ийг хэрэгжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэх

3. Дижитал номын сангийн орчинд шилжих бэлтгэл ажлыг эхлүүлж, өндөр хөгжилтэй орны их дээд сургуульд мэргэжилтэн бэлтгэх
4. Үнэт ховор сан хөмрөгүүдийг хадгалах зориулалтын фондын өргөтгөл барих хөрөнгийг 2016 оны улсын төсөвт суутгах
5. Бүх төрлийн номын сангуудыг арга зүйн удирдлагаар хангах, соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах, гадаад орнуудын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ном солилцох зардлуудыг төсөвт тусгаж өгөх

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. БОДЛОГЫН ЗОРИЛТ

Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын биелэлт

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтод тус байгууллагатай хамааралтай заалт байхгүй боловч мэдээлэл, ном зүй, соёл, танин мэдэхүйн ажлуудаа энэ дагуу төлөвлөн явуулж, биелэлтийг гарган тайлагнаж ажилладаг.

1. ***Агаар цэвэр Улаанбаатар:*** ***“****Агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулах, усны эх үүсвэрийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх”* заалтын хүрээнд төв болон салбар номын сангууд “Нарны эрчим хүчийг ашиглах энгийн халаагуур хэрхэн бүтээх вэ?”, “Хөрсний бохирдол”, “Байгаль орчны эрүүл мэнд-фото дуу хоолой”, Байгаль хамгаалах кино 7 хоног, “Нийгэмд ээлтэй бизнес эрхлэгчдийн форум” зэрэг сэдвээр уулзалт, лекцийг 6 удаа зохион байгуулж, “Агаарын бохирдол”, “Агаар, хөрс, орчны бохирдол” картын санг тогтмол хэвлэлийн материал ашиглан 2 удаа, “Агаар, ус, хөрсний бохирдолтоос орчноо хамгаалъя”, “Агаар цэвэр Улаанбаатар”, “Хөрс, орчны бохирдол”, “Ус чандмань эрдэнэ” зэрэг байнгын болон сэдэвчилсэн үзэсгэлэн, санамж өгөх ном зүйн гарын авлага, зөвлөмж, мэдээллийг нийт 11 удаа гаргаж сурталчилсан бөгөөд 512 орчим уншигч үйлчлүүлэгчдийг хамруулсан байна.

2. ***Амины сууцтай Улаанбаатар****: Гэр хорооллыг тохилог амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх* заалтын хүрээнд “Гэр хороолол-дахин төлөвлөлт” картын санг 3 төрлийн тогтмол хэвлэлийн 34 материал ашиглан хийж, “Амины орон сууц” байнгын үзэсгэлэнг 25ш фото, 29 номоор гаргаж, уншигч үйлчлүүлэгчдэд сурталчилсан.

3. ***Ажил, орлоготой Улаанбаатар****: “Найрсаг Улаанбаатар” аялал жуулчлал, соёл урлагийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ* УГЗ, Төрийн зураач Ц.Ойдов, залуу зураач О.Андимана нарын “Чингис хаан ба Хөх Монгол” уран бичлэгийн болон уран зургийн үзэсгэлэнг 148 бүтээлээр гаргаж, цаашид Номын сан- Галерей болох эхлэлийг тавьсан. Мөн “Нийслэл соёл”, “Хотын соёл” цуврал мэдээлэл, “Нийтийн ба хэрэглээний соёл”, “Хэл ярианы соёл”, “Хүний эелдэг эвч зан”, “Хувцаслах соёл ба өнгөний сонголт”, “Үндэсний соёлын биет өв” зэрэг мэдээллийн багц, “Ажил орлоготой Улаанбаатар”, “Монгол Үндэстэн” цуврал үзэсгэлэнг гаргаж, “Монгол бичиг бол Монгол хүний амин бичиг” сэдэвт уулзалт, уран бичлэгийн уралдаан зэргийг зохион байгуулсан байна. Дээрх үйл ажиллагаануудад 711 орчим үйлчлүүлэгчид хамрагдсан байна.

4. ***Аюулгүй, амгалан Улаанбаатар****: Иргэд, залуучууд, өсвөр үеийнхнийг архи, тамхи, мансуурлын хорт хэрэглээнээс татгалзах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг соёл урлагийн бүтээлээр дамжуулан хүргэх* зорилтын хүрээнд “Архи, тамхи, мансууруулах бодисын хор уршиг” цуврал үзэсгэлэн, мэдээлэл, санамж өгөх ном зүйн гарын авлагыг хийж, “Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлцгээе” уулзалт, “Залуучуудыг үе тэнгийн сургагчаар бэлтгэх” сургалт, “Мансууралгүй ирээдүй” тойм яриа, “Архигүй Монголын төлөө хамтдаа” уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулахад 375 хүүхэд залуучуудыг оролцуулсан.

Мөн хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх үүднээс “Улаанбаатарчууд уншиж байна” аяныг 03-11 дүгээр сарыг хүртэл хугацаанд зохион байгуулж, номын сантай танилцах мини аялал, шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн,

"Улаанбаатар хотын түүх"-ээс цуврал лекц, зуны уншлага, чанга уншлага, Номонд дурлагсдын өдөрлөг, Үндэсний бичиг соёлын өдөр, "Чингис хаан ба хөх монгол" уран бичвэрийн үзэсгэлэн, "Номын анд" аян, Барак Обама."Та нартаа би дуулъя"номыг унших уралдаан, 3 үеийн хүүхдийн зохиолчдын уулзалт, хэвлэлийн компаниудтай хамтран номын худалдаа зэрэг уншлага, лавлагаа мэдээлэл, соёл танин мэдэхүйн ажлуудыг явуулахад 1339 уншигч, үйлчлүүлэгч хамрагдсан.

Мөн оюутан, сурагчдын зуны амралтын чөлөөт цагаар “Зуны англи хэлний эрчимжүүлсэн сургалт”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан англи хэлний сургалт”, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдүүдийн дунд 4 төрлийн тэмцээн зохион байгуулахад нийт 406 хүн хамрагдсан байна. /Нийт 2120 хүн/

*5. **Авилгагүй Улаанбаатар**: Байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээллийг вэбсайтаар олон нийтэд сурталчилна.* “Авилгаас ангид явцгаая” сэдэвчилсэн үзэсгэлэн, “Авилгагүй Улаанбаатар” сэдэвт мэдээлэл гаргаж сурталчилсан. Байгууллагын www.pl.ub.gov.mn цахим хуудаст үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, баланс, төсөл хөтөлбөрийн танилцуулга, зохион байгуулагдах соёл, танин мэдэхүйн ажлын мэдээлэл, сул орон тооны зар гэх мэт 32 мэдээ, мэдээллүүдийг байршуулан, олон нийтэд сурталчилсан байна. Мөн иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1308 /байгууллагын твиттер 657, Америкийн соёл мэдээллийн төвийн твиттер-651/ жиргээ илгээгдэж, 492 дагагчтай, фейсбүүк хуудас 9380 /байгууллагын-4225, Америкийн соёл мэдээллийн төвийн 4805, ХУД дэх салбар-350/ дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

Өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт: Тайлант хугацаанд 56 өргөдөл бичгээр ирснийг дэвтрээр болон www.ub1200.mn цахим системд бүртгэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. Үүнээс 55 нь хугацаандаа шийдвэрлэгдэж, ээнд нь мэдэгдэж ажилласан бол 1 өргөдөл хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн. Мөн байгууллагынхаа үйл ажиллагааны онцлогт тохирсон “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг боловсруулан, тус журамд нэмэлтээр өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар тусгаж мөрдөн ажиллаж байна. Өргөдлийн 92,8% нь байгууллагын ажилтнуудаас, 7,1% нь гадны иргэдээс ирсэн ажилд авахыг хүссэн болон архивын лавлагаа олгохыг хүссэн хүсэлт байна. Төрлөөр нь авч үзвэл 100% хүсэлт бөгөөд санал, гомдол, талархал ирээгүй байна.

Өргөдлийн агуулгаар хувааж үзвэл дараах байдалтай байна.

График 1

График 2



Хариутай бичгийн шийдвэрлэлтийн байдал: Энэ онд нийт 63 албан бичиг ирснээс хариу нэхсэн 38 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн хяналт тавьж ажилласнаас 31 бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлж, 4 бичиг хугацаа хэтрүүлж шийдвэрлэн, 3 бичиг хугацаа хэтэрч шийдвэрлэгдээгүй байна. Хариу нэхээгүй 25 албан бичгийн шийдвэрлэлтэд нь хяналт тавьж ажиллалаа. Ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээг байгууллагын "Албан хэрэг хөтлөлтийн журам"-д заасны дагуу сар бүр тасаг, салбар, ажилтан бүрээр гаргаж, захиралд танилцуулж байна.

Хоёр. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРЭГ

2.1. Уншлага үйлчилгээний талаар

Төв болон салбар номын сангийн хэмжээнд 2014 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг "хүснэгт 1"-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Уншигч	13000	21233	163,3%
2	Хэрэглэгч	16000	21700	136%
3	Ирэгсэд	171000	191074	112%
4	Ном олголт	427500	409137	96%

2014 оны уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүд 96-163 хувийн биелэлттэй байна.

2010-2014 оны төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг харьцуулан харуулбал:

Хүснэгт 2

		2010		2011		2012		2014	
№	Үйлчилгээ нэр	Төлөв-лөгөө	Биелэлт	Төлөв-лөгөө	Биелэлт	Төлөв-лөгөө	Биелэлт	Төлөв-лөгөө	Биелэлт
1	Уншигч, хэрэглэгч	70000	67074	60000	66309	60000	75581	29000	42933
2	Ирэгсэд	300000	212179	210000	230846	210000	210859	171000	191074
3	Ном олголт	600000	582475	585000	605286	585000	503617	427500	409137

Тайлбар: 2013 онд төв номын санд барилгын их засвар хийгдсэнтэй холбоотой сүүлийн хагас жил ажил үйлчилгээ явагдаагүй, төлөвлөгөөт үйлчилгээний үзүүлэлтүүд эхний хагас жилээр гарах тул энд оруулаагүй болно.

График 3



	Уншигч хэрэглэгч	Ирэгсэд	Ном олголт
2010	67074	212179	582475
2011	66309	230846	605286
2012	75581	210859	503617
2014	42933	191074	409137

Уншигч, хэрэглэгч: 2010-2012 онд уншигч хэрэглэгчийн дундаж нь 69654 байсан бол 2014 онд 42933 болж 26721-ээр буюу 38,4%-аар

Ирэгсэд: 2010-2012 онд ирцийн дундаж үзүүлэлт 217961 байсан бол 2014 онд 191074 болж 26887-оор буюу 12,4%-аар

Ном олголт: 2010-2012 онд ном олголтын дундаж нь 563792 байсан бол 2014 онд 409137 болж 154655-аар буюу 27,4%-аар тус тус буурсан байна.

Дээрх төлөвлөгөөт ажлуудын тоо хэмжээ буурсан нь дараах учир шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

1. Нийтийн номын сангуудын идэвхтэй үйлчлүүлэгчдийн 95% нь оюутнууд гэсэн судалгаа байдаг бөгөөд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс их, дээд сургуулиудыг магадлан итгэмжлэхдээ сургалтын түшиц бааз номын сантай байх шалгуур, шаардлагыг тавьж байгаагаас ихэнх их, дээд сургуулиуд номын сантай болсны зэрэгцээ фонд бүрдүүлэлтээ сайн хийж байгаатай /MNS 5742: 2007 “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартад сургалтын төлбөрийн 15%-ийг ном сурах бичигт зарцуулахаар заасан/ холбоотой
2. Номын фондын баяжилт хангалттай бус. Шинэ номын төсөв бага /5 нийтийн номын санд 40 сая төгрөг/, төсвийн хэмжээ, хуваарилалтаас шалтгаалж фонд бүрдүүлэлт цаг хугацаандаа хийгддэггүй, цөөн нэр төрөл, хувиар баяжилт хийгддэг
3. Цаг хугацаа, орон зайнаас үл шалтгаалж заавал номын санд очих бус гэр, ажлын газраас өөрийн ухаалаг төхөөрөмжөөр онлайн ном, хэвлэл унших, хүссэн мэдээ мэдээллээ олж авах цахим ертөнцтэй тулгарсан
4. 2013 онд төв номын санд их засварын ажил сүүлийн хагас жилд хийгдэж, уншлага үйлчилгээ хагас жилийн турш тасарснаар уншигч хэрэглэгчээ алдсан зэрэг нь нийтийн номын сангуудын уншигч хэрэглэгчийн тоо багасахад нөлөөлж байна гэж үзэж байна.

Гэсэн хэдий боловч нийслэлийн нийтийн номын сангууд нь MNS 5742: 2007 “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартад заасаннаас /дүүргийн нийтийн номын сан жилд 3800-гаас доошгүй уншигчид 55000-аас

дээш ном хэвлэл олгох, төв номын сан нь жилдээ 7500-гаас доошгүй уншигчид 112500-аас дээш ном хэвлэл олгож үйлчлэх/ 2012 оныг хүртэл уншигч 3 дахин их, ном олголт 2 дахин их төлөвлөж ажилласаар иржээ. 2009 оноос Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн үйл ажиллагааг зогсоосон болон төв болон салбар номын сангуудын суудлын тоо, хүчин чадалтай уялдуулан авч үзэж 2013 оноос стандартад зааснаас уншигч 1,5 дахин, ном олголтыг мөн 1,5 дахин их байхаар төлөвлөж ажиллаж байна.

Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 375 жилийн ойг угтан нийслэлийн хүн амын номын сан- мэдээллийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх тэдэнд мэдээллийн соёлыг төлөвшүүлэх зорилгоор 2014 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2014 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл "Улаанбаатарчууд уншиж байна" аяныг зохион байгуулж байна. Аяны хүрээнд номын сантай танилцах мини аялал, шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн, "Улаанбаатар хотын түүх"-ээс цуврал лекц, зуны уншлага, чанга уншлага, Номонд дурлагсдын өдөрлөг, Үндэсний бичиг соёлын өдөр, "Чингис хаан ба хөх монгол" уран бичвэрийн үзэсгэлэн, "Номын анд" аян, Барак Обамагийн "Та нартаа би дуулъя" номыг унших уралдаан, 3 үеийн хүүхдийн зохиолчдын уулзалт, хэвлэлийн компаниудтай хамтран номын худалдаа зэрэг уншлага, лавлагаа мэдээлэл, соёл танин мэдэхүйн ажлуудыг явуулахад 1339 уншигч, үйлчлүүлэгч хамрагдсан.

2.2. Гэрээр ном олголт

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд 409137 ном хэвлэл олгож үйлчилснээс 16,8% буюу 68960 ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.

График 4

2.3. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2014 онд 610 нэрийн 3207 ширхэг 46,060,830 төгрөгийн шинэ ном /үүнээс 435 нэрийн 3025ш шинэ ном, 175 нэрийн 182 ширхэг номыг нөхөн бүрдүүлэлт/, 10 нэрийн 10ш /106,000 төгрөгийн/ номыг төлбөрөөр тус тус бүрдүүлэн авсан. Мөн 181 нэрийн 573 ширхэг /3,423,900 төгрөгийн/ номыг бэлэг хандиваар авсан байна.

График 5



Нийт 4720ш номонд техник ажиллагаа хийж, 2441ш номонд мэдрэгч ялтас нааж, нийт 1204 нэрийн 4720ш хэвлэмэл, дэйзи 100 нэрийн номын мэдээллийг http://koha.pl.ub.gov.mn тус тус электрон каталогт оруулан, 4820 ш баркод хэвлэсэн байна.

Төвлөрсөн номын сангийн хэмжээнд 30 нэр төрлийн /3,159,800 төгрөгийн/ тогтмол болон цахим /4 нэрийн/ хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.

2008-2014 оны ном бүрдүүлэлтийн үзүүлэлтийг харьцуулан харуулбал:

График 6

Ховор хуучин ном болон гар бичмэлийн фонд байгуулах зорилгоор Хотын төв номын сангийн үндсэн фондод байгаа судар, гар бичмэлийн номуудыг төвд хэлнээс монгол хэл рүү хөрвүүлэх, техник ажиллагаа хийх, данс бүртгэлд авах, хаяг донтор бичиж байрлуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Одоогийн байдлаар 1867 ширхэг судрыг хөрвүүлэн данс бүртгэлд авсан байна. Дансанд авч буй ном, судруудаа электрон каталогт шууд хөрвүүлэх зорилгоор тусгай хүснэгтийн дагуу бүртгэлжүүлж байна.

Зураг 1 **Зураг 2**

Хараагүй хүмүүст зориулсан DAISY төв: Хараaны бэрхшээлтэй иргэдийн DAISY төвд Айн Рэнд “Эх сурвалж”, Ш.Болд “Монголчуудын эрүүл амьдрах ухаан”, Р.Гамзатов “Миний Дагестан”, Л.Кэролл “Алиса гайхамшигийн оронд”, Сайшо Хироши “Өглөөний хүн 2”, Б.Сарантуяа “Сорхугтани хатан” зэрэг 14 дижитал ном бүтээсэн. Мөн хараaны бэрхшээлтэй уншигч залуучуудын эрэлт хэрэгцээнд тулгуурлан компьютерийн бүтэц, програм хангамжийн талаар 9 гарын авлага, сургалтын материалыг аудио сонсох хэлбэрээр бэлдсэн бөгөөд эдгээрийг MP3 форматаар сонсох боломжтой юм.

Хараaны бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай, хүртээмжтэй програм хангамжаар үйлчилж, зөөврийн компьютер, ухаалаг гар утастайгаа ирж байгаа 100 гаруй иргэнд интернэтийн орчинд мэдээлэл олж авахад нь туслах үйлчилгээ үзүүлж, компьютерийн анхан болон дунд шатны ганцаарчилсан сургалтанд хараaны бэрхшээлтэй 4 иргэн хамруулсан. /**Зураг 3**/

Хараaны бэрхшээлтэй иргэдэд “Технологийн тухай ярилцацгаая” Бямба гаригийн уулзалтыг “Хараaны бэрхшээлтэй иргэд ашиглаж болох 2014 онд шинэчлэгдсэн болон шинээр гарсан хүртээмжтэй програмууд”, “Нийгмийн сүлжээ фэйсбүүкийн анхан шатны сургалт”, “Дижитал ярьдаг ном уншигч төхөөрөмж хэрэглэх тухай”, “Монгол хэлний ярьдаг програмын танилцуулга” зэрэг сэдвээр нийт 18 удаа зохион байгуулсан./ **Зураг 4**/

Үндэсний бичиг соёлын өдрийн хүрээнд DAISY студийн үйл ажиллагааг танилцуулж, орон нутгаас ирсэн 21 аймгийн номын санд Ронда Бёрны “Нууц”, Сайшо Хирошигийн “Өглөөний хүн 1” номуудыг CD дээр буулгаж 42 ширхэгийг бэлэглэсэн.

Зураг 3 **Зураг 4**



Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж телефон лавлагаа, Library call center /LCC/ үйлчилгээг нэвтрүүлэх төсөл боловсруулан Швейцарийн хамтын ажиллагааны газарт төслийн өргөдөл бөглөж өгсөн ба бидний төсөл хараахан дэмжигдээгүй.

Вэбэд суурилсан Дэйзи номын Online daisy үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг шинээр санаачилсан бөгөөд онлайн дэйзи үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгааг хийж, гадаад дотоодын мэргэжлийн компаниудын санал хүлээн авч телефон лавлагаа үйлчилгээг нэвтрүүлэх төсөлтэй нэгтгэн боловсруулж дуусгасан бөгөөд 2015 онд шинээр гарах техник технологийн боломжуудыг судалж одоо байгаа төслийг шинэчлэн сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

2.4. Ном хэвлэл сэлбэн засах

Төв номын сангийн Чөлөөт сонголттой уншлагын танхимын урагдаж гэмтсэн 773ш номыг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Сэлбэн засагдсан 473ш номонд дахин мэдрэгч ялтас наасан. Мөн бага гэмтэлтэй 1346 ширхэг номыг номын санчид өөрсдөө сэлбэн зассан. Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын санд эрэлт хэрэгцээтэй байдаг Г.Бакей, Р.Оросоо “Эдийн засгийн ухаан”, Г.Цэдэвдорж “Янзаган зүс” зэрэг номыг сэргээн засварлалаа.

Зураг 5



Зураг 6

Төв номын сангийн тогтмол хэвлэлүүд болон санхүү, тасаг, салбаруудын баримтуудыг 328 нэгж болгон тус тус хавтасласан байна. Уншигчийн карт 4200 ширхэг, формуляр 4720 ширхэг хэвлэсэн байна.

Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангийн уншигчдын хүсэлтээр “Номтой зөв харьцах нь”, “Урагдаж гэмтсэн ном хэвлэлийг хэрхэн сэлбэн засах” талаар 2 удаа яриа хийсэн бөгөөд, уг арга хэмжээнд нийт 36 уншигч хамрагдсан.

2.5. Мэдээлэл, лавлагааны талаар

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны мессенжер, мэйл болон, бичгээр, утсаар, амаар нийт **15539** удаа лавлагаа өгсөн байна.

График 7

Нийслэлийн Засаг даргын 5А хөтөлбөрийн хүрээнд "Агаар цэвэр Улаанбаатар", "Хөрс- Орчны бохирдол" сэдэвт мэдээлэл, "Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь", "Тамхины хор уршиг", "Ус - Эрдэнэ" сэдэвт санамж өгөх ном зүйн гарын авлага, "Агаарын бохирдол", "Агаар, хөрс, орчны бохирдол", "Гэр хороолол-дахин төлөвлөлт" сэдэвт картын сангуудыг фондонд байгаа ном хэвлэл болон номын санд захиалсан 8 нэр төрлийн тогтмол хэвлэлийн хуудаснаа гарсан 191 нийтлэл, өгүүлэл, мэдээллийг ашиглан гаргаж сурталчилсан.

Санамж өгөх ном зүйн гарын авлагыг "Монгол наадам", "Хөл бөмбөгийн боловсролд-ДАШТ", "Холбоочдын өдөрт", "Авто тээвэрчдийн өдөрт", "Агаарын бохирдол", "Ус", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх", "Байгаль орчныг хамгаалах өдрүүдээр юу унших вэ", "Дэлхийн залуучуудын өдөрт", Үндсэн хуулиа баталж, улс тунхагласны өдөрт" гэх мэт 22 сэдвийн дагуу номзүйг бэлдэж koha програмын тусламжтайгаар олон нийтэд сурталчилсан. Мөн уншлагад бага гардаг Хөдөө аж ахуй, техник, эдийн засгийн номоор санамж өгөх номзүйн гарын авлага хийж, уншигчдад сурталчилсан.

Фото болон өнгөт мэдээллийн багцыг "Үндэсний баримтат соёлын өв", "Монгол туургатан", "Хотын соёл", "Агаар цэвэр Улаанбаатар", "Уншихад цаг гарга", "Авлигагүй Улаанбаатар", "Нийтийн ба хэрэглээний соёл", "Хэл ярианы соёл", "Тамхийг би давж чадна", "Хүний эелдэг эвч зан", "Хувцаслах соёл ба өнгөний сонголт" зэрэг сэдвээр 36 удаа тус тус гаргаж уншигчдад сурталчилсан.

2.6. Соёл, танин мэдэхүйн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн зорилтын дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн явууллаа. Түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн 260, шинэ номын үзэсгэлэн 57, "Ус чандмань эрдэнэ", "Агаар цэвэр Улаанбаатар", "Монгол үндэстэн", "Хөрс, орчны бохирдол", "Номын сан-Тамхигүй орчин" зэрэг байнгын 9 үзэсгэлэн, нийт 326 удаа гаргасан.

Тайлант хугацаанд уулзалт, лекц 129, уралдаан тэмцээн 21, чанга уншлага 44, сургалт 133 удаа зохион байгуулан явуулахад ойролцоогоор 21700 орчим оролцогчид хамрагдсан байна. Үүний заримаас дурдвал:

"Үндэсний бичиг соёлын өдөр": Энэ үйл ажиллагааны хүрээнд УГЗ, Төрийн зураач Ц.Ойдов, залуу зураач О.Андимана нарын "Чингис хаан ба Хөх Монгол" уран бичлэг болон уран зургийн үзэсгэлэнг 148 ширхэг бүтээлээр гаргаж, хөдөө орон нутгийн номын санчдад зориулсан туршлага солилцох сургалт, Номын баярын арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт 200 гаруй хүмүүс оролцсон.

“Номонд дурлагсдын өдөр”: “Улаанбаатарчууд уншиж байна” аяны хүрээнд Улаанбаатар хотын музей, “Өнгөт хэвлэл” ХХК, “Интерном” номын дэлгүүр, “Номонд дурлагсдын фэйсбүүк дахь холбоо” зэрэг байгууллагуудтай хамтран арга хэмжээг зохион байгуулж нийт 150 гаруй хүн оролцсон байна.

Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан МУ-ын Ардын уран зохиолч, СГЗ П.Бадарч, МУ-ын төрийн шагналт, СГЗ Д.Төрбат нартай уран бүтээлийн уулзалт хийхэд 112 уншигч оролцсон. /**Зураг 7**/

“Нийслэлийн иргэн хүний соёл” уулзалтанд МУ-ын төрийн шагналт, шилдэг нийтлэлч Б.Цэнддоог урин оролцуулж, 27 уншигч, ажиллагсдыг хамруулсан. /**Зураг 8**/

Зураг 7



Зураг 8

“Олон улсын эх хэлний өдөр”-т зориулсан үйл ажиллагаа: ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн, доктор О.Шинэбаяр “Парадокс бол зөрчилт хэлбэр”, “Буруугүй буруутан”, “Зохиолгүй зохиол”, “Гэмгүй гэмтэн”, “Буруу ярьж, зөв ойлгох”, ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн ахлах ажилтан Уганбаяр “Ламбагуайн нулимс зохиолын олон талт хэлбэр” сэдвээр, мөн бусад орны хэлний төлөөлөл болгож Хотын төв номын сангийн мэдээллийн ажилтан Б.Эрдэнэ, МУИС-ийн түүх, хятад хэл судлалын ангийн дөрөвдүгээр курсийн оюутан Цэрэндэмбэрэл, Монгол оросын хамтарсан 3-р сургуулийн 12а ангийн сурагч Г.Уянга нар герман хэл, хятад хэл, орос хэлний үүсэл, гарал, соёл уламжлалын талаар илтгэл тавилаа. Мөн энэ өдрийг угтаж ЕБС-ийн сурагчдын дунд “Миний Монголын хэл, соёл” эссэ бичлэгийн уралдааныг монгол бичгээр явуулсан бөгөөд уралдаанд байр эзэлсэн сурагчдыг шагнаж, урамшууллаа.

Дэлхийн эрүүл мэндийн өдрийг угтаж “Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлцгээе” уулзалтыг “Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг”-ийн тэргүүн Ж.Лхагвасүрэнтэй хамтран зохион явуулсан. Уулзалтанд нийт 82 уншигч оролцож мансууруулах бодисын хор хөнөөл, хүн нийгэм, эдийн засагт хэрхэн сөрөг үр дагавар авчирдаг талаар лекц сонссон.

“Залуучуудыг үе тэнгийн сургагчаар бэлтгэх” сургалт: Тус сургалтаар хар тамхи, мансууруулах бодис болон бэлгийн чиг баримжаа олгох, БЗДХ, ДОХ, ХДХВ гэсэн гурван чиглэлээр үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэсэн бөгөөд нийт 20 хүүхэд оролцсон. Сургалтыг Хар тамхи Мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран явууллаа.

Дэлхийн байгаль хамгаалах өдрийг угтаж ШУА-ийн эрдэмтэн О.Батхишигтэй уулзалт зохион байгуулж, “Улаанбаатар хотын агаарын бохирдол, экогеохимийн судалгаа” сэдвээр лекц уншихад нийт 72 уншигч оролцсон.

“Байгаль орчны эрүүл мэнд- фото дуу хоолой” лекц, фото үзэсгэлэн: ЭМШИУС-ийн хоёрдугаар курсын оюутан залуучууд байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлын тухай фото уралдаан төсөлд оролцсон болон өөрсдийн хэрэгжүүлсэн төслүүдийн тухай танилцуулж, фото зургийн үзэсгэлэнгээ уншигчдад дэлгэлээ. Лекцэнд нийт 94 хүн оролцсон байна.

“Байгаль хамгаалах кино 7 хоног”: Дэлхийн өдрийг угтан хүүхэд залуучуудад зориулан Байгаль хамгаалах кино 7 хоногийг зохион байгуулсан бөгөөд энэ нь 134 оюутан залуус, сурагчдад хүрсэн үйл ажиллагаа болсон. Энэ өдрүүдээр усны бохирдол, хог хаягдал болон хүн амын нягтшил, хот төлөвлөлтийн асуудлуудыг хөндсөн “Эрин Брокович”, “Волл И”, “Соёлентгрийн” зэрэг кинонуудыг гаргасан бөгөөд тухайн кинонд гарч буй сэдэвтэй хамааралтай байгууллагуудаас мэргэжилтнүүдийг урьж оролцуулан уулзалт хэлэлцүүлгийг давхар зохион байгуулсан.

“Монгол бичиг бол Монгол хүний амин бичиг юм” уран бичлэгийн уралдааныг 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, уралдаанд ирүүлсэн 30 гаруй сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчилсан ба эхний гурван байрыг шалгаруулж шагнасан.

2.7. Интернет мэдээллийн үйлчилгээ
Автоматжуулалтын програм хангамжийн талаар

2014 онд суурин интернет 35089, утасгүй 4572, нийт 39661 хүнд интернетийн үйлчилгээ үзүүлсэн.

Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудыг интернэтэд холбосноор нийслэлийн нийтийн бүх номын сангууд иргэд, олон нийтэд үнэ төлбөргүйгээр үйлчилгээ үзүүлэх боломж бүрдлээ. Интернетийн холболтыг хурд, холболтын төрөл, үйлчилгээ үзүүлэгч компаниудаар доор /**Хүснэгт 3**/ гаргав.

Интернэт холбогдсон төв болон салбарууд Wi-Fi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, хараани бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 30 компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжтой.

Хүснэгт 3

№	Төв, салбарын нэр	Интернэтийн хурд	Холболтын төрөл	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага
1	Төв номын сангийн үндсэн сүлжээ – гэрээгээр үнэгүй	2 mbps	Шилэн кабель	Эс Ти Ситинет ХХК
2	Төв номын сангийн олон нийтэд болон утасгүй интернэт сүлжээ – гэрээгээр үнэгүй	1,5 mbps	Шилэн кабель	Эс Ти Ситинет ХХК
3	Төв номын сангийн Хөтөлбөрийн танхимд	2 mbps	Шилэн кабель	Эс Ти Ситинет ХХК
4	Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан	1 mbps shared	Шилэн кабель	“Жимобайл нэт” ХХК
5	Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан	1 mbps shared	Шилэн кабель	“Юнивишн” ХХК
6	Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан	3 mbps	ADSL	“Миком” ХХК

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 79.23 Mbps, дунджаар 1,51 Mbps, түгээж /upload/ байгаа хурд

хамгийн ихдээ 100,21Mbps, дунджаар 367,76 Kbps хүрсэн байна. /**Зураг 9**/ Тайлант хугацаанд суурин интернет хэрэглэгчийн тоо 35089 байлаа.

Зураг 9



Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 79,72 Mbps, дунджаар 992,36 Kbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 49,45 Mbps, дунджаар 215,01 Kbps хүрсэн байна. /**Зураг 10**/



Тайлангийн хугацаанд утасгүй интернэтийн хэрэглэгчийн тоо 4572-д хүрсэн байна.

Зураг 10



КОНА програм: Хотын төв номын сангийн үйлчилгээнд Коха програмыг нэвтрүүлэх 2 дугаар шатны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулж, төлөвлөгөөнд тусгасан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ✓ Koha програм байрлаж байгаа сервер компьютерийн хард диск дээрх системийг хуулбарлан авах үүнийг хийснээр гэнэтийн системийн гэмтэл гарсан үед 1 хүртэлх цагийн хугацаанд системийг хэвийн байдалд оруулах боломжтой.
- ✓ Уншигчийн үнэмлэх хэвлэн гаргах боломжтой болсон. /**Зураг 11, 12**/

Зураг 11 **Зураг 12**

- ✓ Бүртгэлтэй уншигчдыг өөрийн бүртгэлээр Koha програм дээр нэвтрэн орох боломжтой болсон. /**Зураг 13, 14**/ Үүнийг нэвтрүүлснээр төв, болон салбар номын сангуудын хэмжээнд doorcontrol буюу үүдэнд код хийдэг системийг энэхүү програмаар өөрчлөх боломжтой.

Зураг 13 **Зураг 14**

- ✓ Ном бүрдүүлэлтийн модул турших ажлын хүрээнд гарын авлага хийж дуусгасан.
- ✓ Гадны програм хангамжийн туршлагатай байгууллагуудаас Koha-д мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авахаар тус програмын албан хаягаар хүсэлт явуулснаар Тайвань болон Шинэ Зеланд улсад төвтэй 2 байгууллагаас үнийн санал хүлээж авсан.

  Одоо ахин үнийн саналд орсон ажлыг нарийвчлан гэрээний санал авахаар захиагаар харилцаж байна.
- ✓ Koha програмаас номын сангийн тооллогоор дутсан 530 гаруй номын каталогийн мэдээлэл ба баркодыг хассан.
- ✓ Koha програмаар номын сангийн үйл ажиллагааны тайланг гаргах хүрээнд
  - Каталогжуулалт
  - Уншигч бүртгэл
  - Төлбөр тооцооны зэрэг тайлангууд гаргах боломж буй болгосон.
- ✓ Номын санд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт худалдан авах үнийн саналын судалгаа гаргаж өгсөн.



- ✓ http://koha.pl.ub.gov.mn/ онлайн каталогт төв, салбар номын сангийн номын санчид 06 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 11-ний хооронд нийт 93747 ширхэг номын мэдээллийг засаж, редактор хийсэн үзүүлэлттэй байна.

Цахим хуудас: Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн http://www.pl.ub.gov.mn цахим хуудаст 32 мэдээ мэдээлэл оруулсан бөгөөд вэбийн хэрэглээний үзүүлэлтийг Google Analytics програмын тусламжтайгаар тайлант хугацаагаар гаргахад 34137 хэрэглэгч зочилж /visits/, 96216 хуудасны мэдээллийг үзжээ.

Онлайн каталог: http://koha.pl.ub.gov.mn/ вэбийн хэрэглээний үзүүлэлтийг тайлант хугацаагаар гаргахад 120199 хандагч /Visits/ 446866 хуудас мэдээллийг үзжээ /**Зураг 15**/. Онлайн каталогийн хэрэглэгчдийн 70,1% нь шинээр орж байгаа хэрэглэгчид бол, 29,9% нь хуучин хэрэглэгчид байна. Онлайн каталогт нэвтэрсэн хэрэглэгчдийг эхний 10 орноор "**Зураг 16**"-д харуулав.

Зураг 15



Зураг 16

	Country	Acquisition: Sessions
		162,356 % of Total: 100.00% (162,356)
1.	Mongolia	155,657 (95.87%)
2.	United States	1,008 (0.62%)
3.	South Korea	900 (0.55%)
4.	(not set)	866 (0.53%)
5.	Russia	784 (0.48%)
6.	Japan	586 (0.36%)
7.	China	370 (0.23%)
8.	Germany	292 (0.18%)
9.	Kazakhstan	142 (0.09%)
10.	Taiwan	121 (0.07%)

Техник хангамж*:* Тус номын сан нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд олон нийтэд зориулсан сургалт, интернэтийн хэрэглээнд шаардлагатай програм хангамжийг Microsoft корпорацийн олон нийтийн байгууллагуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөрт 3 дахь удаагаа шалгарч 2014 оноос 2 жилийн хугацаатай 126,880.00 америк долларын үнэ бүхий багцыг үнэ төлбөргүйгээр аваад байна./**Хүснэгт 4**/ Энэхүү боломж нь Төв номын сангийн олон нийтэд зориулсан компьютерүүдийн үйлдлийн систем болон оффисын програмуудыг албан ёсны лицензтэйгээр ашиглах бололцоотой болсон.

Хүснэгт 4

Microsoft-ийн бүтээгдэхүүний нэр	Тоо	FMV*
LyncSvr LicSAPk OLP NL Dntns Qlfd	1	$5,468.00
LyncSvrStdCAL LicSAPk OLP NL Dntns UsrCAL Qlfd	40	$1,840.00
OfficeMacStd LicSAPk OLP NL Dntns Qlfd	3	$1,731.00
OfficeProPlus LicSAPk OLP NL Dntns Qlfd	70	$56,210.00
SharePointSvr LicSAPk OLP NL Dntns Qlfd	1	$10,197.00
VisioPro LicSAPk OLP NL Dntns Qlfd	10	$7,610.00
WinEntforSA UpgrdSAPk OLP NL Dntns Qlfd	35	$10,360.00
WinEntforSA UpgrdSAPk OLP NL Dntns Qlfd	25	$7,400.00
WinPro 8.1 OLP NL Dntns Legalization GetGenuine Qlfd	40	$7,520.00
WinPro 8.1 OLP NL Dntns Legalization GetGenuine Qlfd	40	$7,520.00
WinSvrStd LicSAPk OLP NL Dntns 2Proc Qlfd	3	$3,972.00
WinSvrStd LicSAPk OLP NL Dntns 2Proc Qlfd	3	$3,972.00
Windows Server CAL Lic/SA Pack OLP NL Donations User CAL Qualified	70	$3,080.00
		$126,880.00

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн тайлан мэдээ зэрэг 32 холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.

Мөн байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зорилгоор Төв болон салбар номын сангуудад "Нээлттэй мэдээлэл" самбарыг ажиллуулж, төлөвлөгөө, тайлан, дүрэм, журам, шинэ номын мэдээ зэрэг нийт 133 мэдээ материал гаргаж сурталчилсан.

3.2. Хүний нөөцийн ил тод байдал

Тайлангийн хугацаанд тус номын санд ажилтан авах зарыг номын сангийн вэб хуудас болон мэдээллийн самбарт 2 удаа шинэчлэн байршуулж сонгон шалгаруулалтанд тэнцэж шаардлага хангасан ажил горилогчоор сул орон тоог нөхөн ажиллуулж байна.

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм болон Улаанбаатар хотын нийтийн номын сангийн номын санчдын ёс зүйн дүрмийг номын сангийн цахим хуудас болон нээлттэй мэдээллийн самбарт байршуулсан.

Нийслэлийн нэгдсэн лавлагаа ub1234.mn цахим хуудаст байгууллагын хүний нөөцийн мэдээлэл шинэчилж ажилласан.

2013 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг захирал, дэд захирал, ерөнхий ня-бо, салбар номын сангийн эрхлэгч нар заасан хугацаанд нь үнэн зөв гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

3.3. Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал

Иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1308 /байгууллагын твиттер 657, Америкийн соёл мэдээллийн төвийн твиттер-651/ жиргээ илгээгдэж, 492 дагагчтай, фейсбүүк хуудас 9380 /байгууллагын-4225, АСМТ-4805, ХУД дэх салбар-350/ дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

www.pl.ub.gov.mn байгууллагын цахим хуудасны хэрэглээний үзүүлэлтийг Google Analytics програмын тусламжтайгаар тайлант хугацаагаар гаргахад 34137 хэрэглэгч зочилж /visits/, 96216 хуудасны мэдээллийг үзжээ.

Нийслэлийн мэдээллийн технологийн газраас ирсэн албан бичгийн дагуу www.ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулах байгууллагын танилцуулга, фото зураг зэрэг бусад холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлж ажилласан.

3.4. Төсөв, санхүүгийн ил тод байдал

Төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, урсгал зардлыг хэмнэх, Монгол улсын Засгийн газрын 147 дугаар тогтоол, Сангийн сайдын 77 дугаар тушаалыг хэрэгжүүлэх үүднээс дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, зарим зардлыг санхүүжүүлэх үүднээс зарим төлбөрт үйлчилгээний үнэ тарифыг өөрчилж, өөрийн үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлсэн.

2. Байгууллагын бүтэц орон тоо, чиг үүргийг хянан үзэж орон тоог нэмэгдүүлэхгүй байх үүднээс хүүхдээ асарч байгаа, өвчтэй, чөлөөтэй байгаа ажилтны оронд шинээр хүн

томилохгүйгээр ажиллагсдын ажлын ачааллыг нягтруулан 8 хүний орон тоог хэмнэн хавсран ажиллуулж, хэмнэсэн цалингаар төсвийн дутууг нөхөж ажилласан.

3. 2014 онд үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийгдэхээр орсон ажиллагсдын нормын хувцасыг солих ажлыг хойшлуулж, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг сунгалаа.

4. Салбар номын сангуудын жижүүрийн орон тоог цөөлж, харуул хамгаалалтын ажлыг галын дохиолол, хөдөлгөөний мэдрэгч, дуут дохиолол зэрэг бүрэн автоматчилагдсан гэрээт харуул хамгаалалтанд шилжүүлэхээр зохион байгуулж, ажиллагсадтай тохиролцон, 2015 оны 01 дүгээр сараас хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ. Ингэснээр орон тоог 10%-аар багасгаж, цалингийн санг 30 сая төгрөгөөр хэмнэх тооцоо гарсан

5. Суурин утаснуудын картын нэгжийн лимитийг багасгаж ажиллаж байна.

6. Ус, цахилгааны тоолуурын заалтанд хяналт тавьж, хэрэглээг багасган ажиллаж байна.

Байгууллагын 2013 оны төсөв, төсвийн гүйцэтгэл, сарын мэдээ болон бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын тайлан, 2014 оны жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2014 оны батлагдсан төсөв, төсвийн хуваарийг захиргааны хуралд танилцуулан номын сангийн дотоод сүлжээ болон веб хуудсанд тавьж нийт ажиллагсдад ил тод болгосон. Мөн Төв болон Салбар номын сангийн бүх ажиллагсдад тайлангийн хурал хийж 2013 оны санхүү, аж ахуйн тайланг дэлгэрэнгүй танилцууллаа.

2013 оны 12-р сарын 31-ний байдлаарх бүх үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны веб сайтанд нэг бүрчлэн шивж оруууллаа.

Өмчийн харилцааны газарт 2013 оны балансаа өгч нэгтгүүлсний дээр тус газрын өмч эзэмшүүлэх, гэрээ дүгнэх шалгалтаар “Хангалттай” үнэлгээ авч, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 2012, 2013 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдэж, акт, төлбөр зөрчилгүй гарсан. Мөн Нийслэлийн аудитын газраас 2013 оны санхүүгийн тайланд аудит хийж 2098,0 мянган төгрөгийн акт тогтоож, 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангууд заавар журмын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн үнэлгээ өгсөн. Актын төлбөр болох 2098,0 мянган төгрөгийг бүрэн төлж барагдуулсан.

3.5. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар

Ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, амжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс Үйлдвэрчний хороотой байгуулсан Хамтын гэрээний нэлээд олон заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлж ажилласан.

2014 онд ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэрлэхэд нийтдээ 52,706,283 төгрөг зарцуулжээ. Үүнээс нийт ажиллагсдын 34,8% буюу 30 хүнд ур чадварын нэмэгдэл олгож, мөн 8 ажилтанд цалингийн шатлалыг ахиулахад 22,360,420 төгрөг зарцуулав.

Тэтгэвэрт гарсан үйлчилгээний 3 ажилтанд гурван сарын үндсэн цалинтай тэнцэх 1,806,505 төгрөгийн, нэг хүнд Соёлын тухай хуулийн дагуу 12 сарын цалинтай тэнцэх хэмжээний буюу 11,388,450 төгрөгийн тэтгэмж олгосон.

Төр, засгийн шагнал авсан 4 ажилтан, 4 ахмадад дагалдах мөнгөн шагналд 280,000 төгрөг, 50 нас хүрсэн 6 ажилтанд 480,000 төгрөг, хүүхэд нь хуримаа хийсэн 3 ажилтанд 450,000 төгрөгийн урамшуулал тус тус өгсөн.

Гэр хороололд амьдардаг 20 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлтөнд 4,000,000 төгрөг, төрсөн нутагтаа амраад ирсэн 5 ажилтанд ирэх, очих замын зардал 463,600 төгрөг, удаан хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа болон амьдралын хүнд нөхцөлд байгаа 3 хүнд өргөдлийн дагуу 1,129,778 төгрөгийн буцалтгүй тусламж, Сар шинийн баяраар 7 ахмадад 490,000 төгрөг, гэр бүлд нь гачигдал тохиолдсон 5 ажилтанд 2,009,600 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж тус тус олголоо.

Нийт ажиллагсдын дунд зохион байгуулсан цасны баярт 1,645,000 төгрөг, Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын 57 ажилтны 0-16 насны 60 хүүхдэд 665,000 төгрөг, Соёл урлагийн ажилтны баярын өдрөөр ажиллагсдын дунд нэг өдрийн идэвхтэй амралт зохион байгуулахад 2,335,000 төгрөг, Ахмадын өдрөөр байгууллагын 52 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд 3,590,000 төгрөг зарцуулсан.

Багануур дүүргийн соёлын төв болон Батлан хамгаалах их сургуулиас номын санчдын дунд зохион байгуулсан спортын тэмцээн уралдаанд байгууллагын баг тамирчдыг оролцуулахад 996,000 төгрөг, Залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан дугуйтай эко аяллыг дэмжиж 60,000 олгожээ.

Ажиллагсдын ажиллах ая тухтай байдлыг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс шинээр халуун усны өрөөг тохижуулж засварлахад 5,385,000 төгрөг, ОХУ-ын Крым хотод зохион байгуулагдсан номын сангийн их хуралд 1 хүнийг оролцуулахад 4,272,580 төгрөг, Дархан хотын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцоход 10 номын санчийг оролцуулж 500,000 төгрөг зарцуулсан.

Төв болон салбар номын сангуудын номын санч нарт гэрээр ном олгох үйлчилгээний хураамжийн орлогоос сар бүр 12 номын санчид орлогын дүнгийн 30 хувиар бодож 8,499,770 төгрөгийн урамшуулал олгосон.

Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж амьдрал ахуйд нь дэмжлэг үзүүлэх үүднээс цалингийн картыг Улаанбаатар хотын банкинд шилжүүлж ажиллагсдын цалингийн зээлийн хүүг 2,2% байсныг 1,4-1,7 хүртэл хувиар бууруулж, цалингийн карт болон бичиг баримтуудыг шинээр бүрдүүлэн шилжүүлж гэрээ хийлээ.

3.6. Ажилтан, албан хаагчдын мэргэжил дээшлүүлэлт, ажлын байрны сургалтын талаар

Номын санчдын мэргэжил дээшлүүлэх 16 удаагийн цуврал сургалтуудыг зохион байгуулахад Төв болон салбар номын сангийн номын санчид болон Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн номын санчид, Идэр дээд сургууль, Хууль зүйн яам зэрэг байгууллагын нийт 364 гаруй номын санчид оролцсон байна. Үүнд: "21-р зууны нийтийн

болон эрдэм шинжилгээний номын сангууд", "Өсөж хөгжих үү", "Номын санчид бол эх зохиол судлалын манлайлагчид" сэдвээр зохион байгуулсан ба сургалтыг Олон улсын сургуулийн номын сангийн эрхлэгч Жулдриф удирдан явуулав.

Төв болон салбар номын сангийн 30 гаруй номын санчдын дунд Коха программаар каталогжуулах сургалтыг 2 удаа, салбарын 12 номын санчдад ажлын байран дахь сургалтыг 3 удаа тус тус зохион байгууллаа. Сургалтыг мэдээллийн технологийн мэргэжилтэн, каталогич нар удирдан явуулав.

2013 онд гадаадын улс оронд болсон хурал зөвлөгөөн, сургалт, туршлага солилцох уулзалт семинарт оролцсон 5 ажилтантай уулзалт ярилцлага зохион байгуулав. Уг уулзалт ярилцлагад төв болон салбарын эрхлэгч, номын санчид оролцов.

2014 оны 03-р сарын 10-нд "Номын сангийн үйлчилгээнд Social media-г ашиглах нь" сэдэвт сургалтыг номзүйч Түвшинтогтох, мэдээллийн ажилтан Эрдэнэ нартай хамтран зохион байгуулж. Уг сургалтад нийтийн болон их дээд сургуулиудийн номын сангуудын төлөөлөл оролцлоо. Мөн Америкийн монгол судлалын төв, АНУ-аас ирсэн каталогч Энэрэлтэй хамтран МБАТ болон Олон нийтэд үйлчлэх тасгийн зарим номын санчдад каталогжуулалтын гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулсан.

2014 оны 05 дугаар сар 04-нд Үндэсний бичиг, соёлын баярын хүрээнд “Төв болон хөдөө орон нутгийн номын санчдын сургалт, семинар”-ийг анх удаагаа шинэлэг хэлбэрээр ССАЖЯ, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Монголын номын сангуудын консорциум хамтран зохион байгуулж төв болон орон нутгийн номын сангаас ирсэн төлөөлөгчдөөс сонгогдсон номын сангийнхан хагас жилийн хугацаанд Монгол улсын номын сангийн салбарт шинэ, шинэлэг үйлчилгээ, хөтөлбөрүүдээ танилцуулж хэлэлцүүлэг явагдсан.

2014 оны 05 дугаар сарын 29-нд Аймгуудын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон ЕБС-ийн 20 гаруй номын санч нарт Улаанбаатар хотын төв номын сангийн үйл ажиллагаа, техник технологи болон програм хангамжийн талаар танилцуулав.

Дөрөв. ШИНЭ САНААЧЛАГА, ҮР ДҮН

1. 2014 оны 2 дугаар улиралд интернэтэд холбогдоогүй байсан Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудыг интернэт сүлжээнд холбож, номын сангийн автоматжуулалтын Коха програмын каталогийн модулийг салбар номын сангуудад нэвтрүүлж, http://koha.pl.ub.gov.mn онлайн каталогт 33973 номын мэдээллийг оруулаад байна. Мөн салбар номын сангийн уншигчид номын сангийн орчинд интернэт ашиглах боломжтой болж байна. Дээрх үйлчилгээ бий болсонтой уялдан уншигчдын сэтгэл ханамж дээшилсэн нь санал асуулгын дүнгээс харагдаж байна.

2. Гэр бүлийн уншлага зохион байгуулах ажлын хүрээнд “Гэр бүлийн уншигчийн карт” бий болгож, байнгын идэвхтэй 265 уншигчийн картаар тэдний гэр бүлийн 671 хүнд үйлчилж, гэр бүлийн уншлагыг дэмжиж ажилласан. Мөн гэр бүлийн уншлагыг төв

номын санд зохион байгуулж, 31 дүгээр сургуулийн 1б ангийн 40 сурагчид аав, ээжүүдийн хамтаар оролцсон. Энэ үеэр хүүхдийн уншлагын танхимтай танилцуулан, үнэ төлбөргүй карт нээж, аав, ээжтэйгээ богино хэмжээний зурагт үлгэрүүдийг уншихын зэрэгцээ "Хүүхдийг номонд дуртай болгох аргууд" зөвлөмжийг гаргаж, танилцуулсан. Мөн 1-6 насны хүүхэд аав, ээжтэйгээ хамт ирж, ном уншиж, тоглоход зориулсан "Гэр бүлийн уншлагын танхим"-ыг байгуулах ажлыг реппер дуучин Цэцээ санаачилсныг дэмжиж хамтран ажиллаж байна.

3. Хараааны бэрхшээлтэй иргэдэд зориулж телефон лавлагаа, Library call center /LCC/ үйлчилгээг нэвтрүүлэх төслийг санаачлан боловсруулсан. Улмаар Швейцарийн хамтын ажиллагааны газарт төслийн өргөдөл бөглөж өгсөн ба бидний төсөл хараахан дэмжигдээгүй. Уг үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай шинэ техник технологийн шийдлийг 2015 онд дахин судлах шаардлагатай байна.

4. Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Монголын номын сангуудын консорциум хамтран "Төв болон хөдөө орон нутгийн номын санчдын сургалт, семинар"-ыг анх удаагаа шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, Төв болон орон нутгийн номын сангийн төлөөлөгчид монгол улсын номын сангийн салбарт нэвтрүүлсэн шинэлэг үйлчилгээ, хөтөлбөрүүдээ танилцуулж, харилцан туршлага солилцсон. Уг уулзалтыг онлайнаар шууд дамжуулж, орон нутгийн мэргэжил нэгтнүүд үзэх боломжийг бүрдүүлсэн.

5. Хүүхдийг багаас нь ном унших идэвх сонирхолтой болгох үүднээс Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан "Бэлэгтэй уншлага"-ыг санаачлан зохион байгуулж явуулснаар хүүхдүүдийн ном унших идэвх сонирхол дээшилж, эцэг эхчүүдийн талархлыг хүлээгээд байгаа бөгөөд улмаар хүүхдийн уншлагын танхимын фондын эргэлт 20%-аар нэмэгдсэн байна.

Тав. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

1. Төвлөрсөн номын сангуудын хэмжээнд уламжлалт болон онлайн хэлбэрээр "Мэдээллийн нөөц /ном/ бүрдүүлэлт ба фондын баяжилт", "Хамгийн их уншигддаг номын рейтинг тогтоох" зэрэг сэдвээр 3 удаа 609 уншигч хэрэглэгчийн дунд

2. Тасаг, салбар номын сангууд тус бүр "Номын сан-миний орчин", "Номын сан-мэдээллийн төв" , "Номын сан ба интернэт", "Үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ" зэрэг сэдвээр уламжлалт болон онлайн хэлбэрээр 10 удаа 716 уншигч оролцуулан тус тус санал асуулга авч, санал хүсэлтийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Санал асуулгад тусгагдсан санал хүсэлтийг жагсаавал:

Фондын баяжилт, хүрэлцээ хангамж: Номын баяжилт тун муу, шинээр гарч буй номууд хамгийн түрүүн номын санд ирдэг байх ёстой гэж үзсэн байна. Сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлал, анагаах, физик, япон хэлний сурах бичиг, эдийн засаг, хүний хөгжил, эрхзүй/гэрээний, татварын/, гүн ухаан, банк, нягтлан бодох бүртгэл, кино гэсэн нэр төрлийн номуудыг авах шаардлагатай. Мөн номыг олон хувьтай авч байх тухай дурдагдсан бөгөөд цөөн хувьтай болохоор ашиглах гэхээр уншлагад гарсан байдаг гэсэн байна.

Электрон каталог: Номын санд байдаг номууд электрон каталог дээр гарч ирдэггүй. Мөн электрон каталогт номуудыг зурагтай нь оруулбал сайн байна.

Мэдээллийн технологи: Цахим уншлагын компьютеруудын гаранд монгол үсэг наах, уншлагын танхимуудад утасгүй интернетийн сүлжээ буюу Wi-fi төхөөрөмж тавих, номын сангийн вэбийг байнгын ажиллагаатай байлгах тухай санал бичсэн байна.

Номын санчийн харьцаа: Нийт номын санчдыг сайн харилцаатай гэсэн боловч өлгүүрийн үйлчлэгч болон зарим номын санчдыг харилцаа муу, ааштай, асуусан

асуултад зөв боловсон хариулдаггүй, зааж өгдөггүй гэсэн байна. Мөн номын санчдыг утасныхаа дууг хаадаггүй, ном уншиж байхад их төвөгтэй байдаг гэжээ.

Номын сангийн орчин нөхцөл: Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангийн уншлагын танхимын зай талбай бага, ширээ сандал шаардлага хангадаггүй

Интернет үйлчилгээ: Салбар номын сангуудад интернэт зайлшгүй хэрэгтэйг илэрхийлсэн байна.

Номын сангаас үзүүлж байгаа мэдээллийн чанар: Төрөл бүрийн мэдээллийн багц бэлтгэн гаргаж байгаа нь уншигчдын сэтгэлд нийцэж, сэтгэл хангалуун байгаа талаар илэрхийлсэн байна.

Бусад: - Уншигчдыг хог хаяхгүй байх талаас арга хэмжээ авах
- Цагийн хуваарийг уртасгах
- Хоёр танхимын номыг хооронд нь оруулдаг байх
- Хувийн номтой номын санд ордог болгох
- Ариун цэврийн өрөөнд саван, ариун цэврийн цаас зэрэг зүйлүүдийг худалдаж авахаар байлгах
- 2 танхимдаа том цагтай болох гэсэн саналууд тус тус гарсан байна.

Хамгийн их уншилттай ном:

1. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” роман- 14%
2. Зян Рун “Чонон сүлд” - 11%
3. Ц.Оюунгэрэл “Ногоон нүдэн лам” - 9%
4. Маркес А.Г. “Зуун жилийн ганцаардал” - 8%

Дүгнэлт: Дээрх санал асуулгуудын дүнгээс

1. Фондын бүтэц, чанарыг сайжруулах, бүрдүүлэлтийг тогтмолжуулах
2. Салбар номын сангуудыг интернетэд холбох
3. Мэдээллийн технологид суурилсан шинэ үйлчилгээ нэвтрүүлэх
4. Электрон каталог ашиглах сургалт, арга зүйг тогтмол явуулах
5. Номын санчид болон өлгүүрийн үйлчлэгч, нийт ажиллагсдад зан харилцааны соёл, ёс зүйн хичээл сургалт явуулах
6. Баянзүрх дүүрэг дэх салбар номын санд стандарт орчинг бүрдүүлэх
7. Уншигчдыг номын сангаар үйлчлүүлэхэд тав тухтай байлгах үүднээс ахуйн ариун цэврийн зүйлсээр хангах шаардлагатай нь харагдаж байна.

Судалгааны мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1. Тасаг, салбар номын сангуудын эрхлэгч, номын санч нараар нь зохих төсөвт нийцүүлэн тасаг, салбар номын сангуудын байршлын болон уншигчдын бүтцийн онцлогт тохируулан номыг бүрдүүлэх, худалдахаар санал болгож буй номуудыг тасаг, салбар бүрт танилцуулж худалдан авах саналыг хүлээн авах маягаар номын бүрдүүлэлтээ хийж байна. Үүний үр дүнд тасаг, салбар бүрээс ирэх татгалзлын дэвтэрт бичигдсэн номын тоо зохих хэмжээгээр буурсан үзүүлэлттэй байна.

2. Интернетэд холбогдоогүй байсан Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудыг интернетэд холбож, суурин болон утасгүй интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр үзүүлэх боломжтой болсон бөгөөд одоогийн байдлаар утасгүй интернетийн үйлчилгээг үзүүлж байна.

3. Салбар номын сангуудад номын сангийн автоматжуулалтын КОХА програмын онлайн каталогийн модулийг нэвтрүүлж, онлайн каталогт 33973 номын мэдээллийг оруулаад байна.

4. Хэрэглэгчдэд зориулсан электрон каталог ашиглах гарын авлага бэлтгэн төв номын сангийн хайлтын хэсэгт байрлуулан ашиглуулж байна. Мөн уншигчдад электрон каталог ашиглах арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажилласан. 2014 онд шинээр

бүрдүүлэн авсан 4720 ширхэг номын нүүр хавтасны зургийг электрон каталогт оруулсан байна.

5. “Номын санчийн ёсзүй”, “Номын сангийн ёс зүй” гэсэн сэдвээр хоёр удаа номын санчдын дунд сургалт явуулж, “Номын санчийн мэргэжлийн ёс зүй” сэдвээр 2 хуудас материал бэлдэж, номын санчдад тараасан.

6. Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан нь орон сууцны нэг давхрын 3 өрөө байранд байрладаг бөгөөд тус салбар номын сангийн өргөтгөлийн зураг төсвийг гаргуулах ажлыг байгууллагын 2014 оны төлөвлөгөөнд тусгасан боловч төсөв, мөнгөний байдлаас шалтгаалж хийгдээгүй.

7. Уншлагын танхимуудад тав тухтай орчинг бүрдүүлэх үүднээс ус цэвэршүүлэгч тавьж, цахилгааны уртасгагч, заалны гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн.

Мөн Төв болон Салбар номын сангийн уншлагын заал, танхимуудын Санал хүсэлтийн дэвтрээр 248 уншигч, хэрэглэгч санал хүсэлтээ бичиж уламжилсныг мөн шийдвэрлэж ажилласан байна.

ТАЙЛАНД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ

2014 онд 105 ажил үйлчилгээ хийхээр төлөвлөснөөс 98 нь 20-310%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн бол 6 ажил огт хийгдээгүй тасарсан бөгөөд нийт 96%-ийн биелэлттэй байна. Огт хийгдээгүй ажлын 2 нь /“Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангийн өргөтгөлийн зураг, төсөв зохиолгох”, “Ажиллагсдын албаны хувцас болон энгэрийн тэмдэгийг шинэчлэх”/ төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбоотой, 2 нь /“Тооллогоор дутагдаж фондноос хасагдахаар тооллогын комиссын шийдвэр гарсан ном хэвлэлийн асуудлыг Өмчийн харилцааны газраар шийдвэрлүүлэх”, “Номын сан-хууль эрх зүйн орчин сургалт”/ цаг үеийн шаардлагаар ирэх онд хийхээр хойшлуулсан, 2 нь /“Гамшигийн үед ажиллах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж гаргах”, “IPAD төхөөрөмжийг ашиглан хүүхдүүдэд хөгжмийн боловсрол олгох үйлчилгээ”/ холбогдох ажилтны хариуцлага, ажлын зохион байгуулалт муугаас шалтгаалан тасарсан байна.

Цаашид анхаарах шаардлагатай дараах чухал асуудлууд байна. Үүнд:

1. Жил ирэх тусам буурч байгаа номын сангийн уншигч хэрэглэгч, ном олголтын тоог нэмэгдүүлэх үүднээс номын сангийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амд зөөврийн болон нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэх, үйлчилгээг явуулах авто машины асуудлыг шийдвэрлэх

2. Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд дотоод нөөц бололцоог бүрэн ашиглаж ажилтан бүр идэвх, санаачлагатай ажиллах шаардлагатай.

ХНО-НЫ 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг: Удирдлагын *үйлчилгээ*

- Монгол Улсын засгийн газрын хууль тогтоомж, УИХ, ССАЖЯ-аас гаргасан хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан болно.
- "Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ"-г ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэлтэй байгуулж 2014 онд Хүүхдийн номын ордноос хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан.
24, 14-р сургуулийн номыг санчид, СБС-ийн 3 оюутан, РТДС-ийн 2 оюутан, СХД-ийн 12-р хорооны засаг дарга, Говь-Сүмбэр, Хөвсгөл аймгийн номын санч, Баянхонгор аймгийн төв номын сангийн номзүйч, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын сургуулийн номын санч, МУИС-ийн Урлаг судлалын 3-р курсын оюутан Батсүмбэр, 123-р сургуулийн номын санч Цолмон, МУБИС-ийн номын санч, Тусгал дунд сургуулийн номын санч, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн цогцолборын номын санч-3 удаа, БЗД-ийн 8-р хорооны иргэн нарт тус тус ХНО-ноос зохион байгуулдаг мэдээ, мэдээллийн ажил болон СОНА-ын талаар, шинээр уншлагын танхим зохион байгуулах, өдөр тутмын бүртгэл хөтлөлт, номзүйн жагсаалт гаргах аргачлал, уншигчдыг номын сандаа хэрхэн татах талаар, номоор хүүхдийг хэрхэн хүмүүжүүлэх, ном хөтөлбөрийн тайланг хэрхэн бичих, шинэ номын мэдээний бичилт, санамж өгөх номзүйн талаар e-mail хаяг болон утсаар нийт 28 удаа мэргэжил аргазүйн зөвлөгөөг өгсөн.

6.2. Танхимын номын санчдад заавар зөвлөгөө өгөх: Арга зүйч Л.Батболор:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	4	100%

- Өрнө дахины уншлагын танхимыг зохион байгуулах ээлжит бус тооллогын ажлын үеэр танхимын номын санчдад заавар зөвлөгөө өгч ажилласан.
- Өрнө дахины танхимын номын санчид энэ жил ой нь тохиож буй оросын зохиолчдын тухай мэдээллийг бэлтгэж өгч харилцан ярилцсан.
- Мөрөөдөл танхимын номын санч Т.Бямбасүрэнтэй хамтран “Би ном унших дуртай” сэдэвт ном уншлагын 7 хоногийг хөтөлбөр боловсруулан зохион явууллаа.
- Дорно дахины уншлагын танхимаас зохион байгуулж буй уран бичлэгийн дугуйлангийн талаар харилцан ярилцаж зөвлөгөө өгсөн.

6.3. Сургалт семинар зохион байгуулах:

6.3.1. ЕБС-ийн номын санчдын сургалт: Арга зүйч Л.Батболор:

2014 онд 9 удаагийн сургалт семинарт нийт **293** сургуулийн номын санчид хамрагдлаа. Үүнд:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
6	9	130%

- **2014.2.24-28нд.** “**ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь**“ сэдэвт анхан шатны мэргэшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийслэлийн ЕБС-ийн-13 номын санчид хамрагдлаа. Сургалтын бэлтгэл ажил болон “Номын сангийн каталог зохион байгуулалт”, ”Электрон номын сан”, ”Номын сангаас хүүхэдтэй ажиллах ажил” зэрэг сэдвээр хичээл зааж номын санчидтай харилцан санал болдоо солилцсон. Номын санчдад гарын авлага болох хэрэгцээт материалыг бэлтгэж өгөв.
- **2014.03.03нд.** “**ЕБС-ийн номын сангийн үйлчилгээг боловсронгуй болгох нь**” **сэдэвт** сургалтыг Төв аймгийн ЕБС-ийн номын санчдын дунд зохион байгууллаа. Сургалтын хөтөлбөр боловсруулах болон бэлтгэж ажлыг хийж гүйцэтгэв. Төв аймгийн сумдын ЕБС-ийн -31 номын санч хамрагдлаа. Сургалтын хөтөлбөрт: ЕБС-ийн Нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн Халиунаа **“**Сурах бичгийн талаар“, ХНО-ны фондын номын санч Д.Энхчимэг “Цахим номын сан” READ хүүхдийн электрон номын сангийн талаар, ХНО-ны зөөврийн номын санч Б. Баярмаа ХНО-оос зохион байгуулж буй шинэлэг ажил сэдвээр “Эртэч хүүхэд” ХНО-ны номын санч Ө. Бадамсэд **“**Номын санчийн ёс зүй” **с**эдвээр, ХНО-ны арга зүйч Л.Батболор “ХБНГУ-ын Вюрцбург хотын номын сангийн үйлчилгээ”-ний талаар ХНО-ны мэргэжилтнүүд хичээл заасан.

- **2014.04.11-нд. “Миний мэргэжил сайхан”өдөрлөг.** ЧД-ийн 39-р сургуулийг түшиглэн “Миний мэргэжил сайхан” сэдэвт өдөрлөгийг дүүргийн номын санчидтай хамтран зохион байгууллаа. Өдөрлөгийн гол зорилго хамгийн сайн үзүүлэн (presentation) бэлтгэсэн номын санчийг шалгаруулах явдал байлаа. Дүүргийн номын санчид хийсэн ажлынхаа талаар үзүүлэнт мэдээлэл бэлтгэн өрсөлдөв. Уралдааны шүүгчээр ХНО-ны арга зүйч Л.Батболор, ЧД-ийн ахлах Ч.Энхтуяа, БЗД-ийн ахлагч Н.Уранчимэг нар ажиллалаа. Нийт- 12 номын санч оролцсоноос “Хамгийн шилдэг илтгэгч”-ээр 17-р сургуулийн номын санч Н. Жаргалсайхан шалгарч дүүргийн хамт олноос шагнал гардан авав. Мөн дүүргийн номын санчид номын сангийн үйл ажиллагааныхаа талаар үзэсгэлэн гаргасан байлаа.
- **2014.05.27-нд. “Сургуулийн номын сан” хэлэлцүүлэг**. БЗД-ийн сургуулийн номын сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн ахлагчтай хамтран “Сургуулийн номын сан ” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг 97-р сургуулийн номын санд зохион байгууллаа. Тус дүүргийн сургуулийн 17 номын санчид оролцов. Дүүргийн номын санчдын нэгдсэн судалгааг авч нэгтгэн номын санчидтай харилцан санал бодлоо солилцсон. Цаашид номын санчдын дунд зохион явуулах ажлаа танилцуулж, харилцан ярилцлаа.
- **2014.10.03-нд.** Баруун бүсийн аймгийн ЕБС-ийн номын санчдад ХНО-ны уншлагын танхимаас зохион байгуулж буй соёл танин мэдэхүйн ажлыг танилцуулж номын санчидтай харилцан туршлага солилцлоо. Нийт-100 номын санч оролцсон. Мөн танхимын үйл ажиллагаатай номын санчдыг танилцуулсан.
- **2014.09.18-нд. “Номын сангийн үйчилгээг боловсронгуй болгох нь” сэдэвт сургалт.** Баян-Өлгий аймгийн сургуулийн номын санчдад дээрх сэдвээр 1 өдрийн сургалтыг зохион явууллаа. Сургалтаар ХНО-оос зохион байгуулж буй шинэлэг үйлчилгээг сурталчлах зорилгоор танхимууд зохион байгуулсан соёлын ажлаа үзүүлэнт мэдээллээр бэлтгэж номын санчдад танилцуулан харилцан туршлага судлав. Сургалтанд нийт-13 номын санчид хамрагдсан.
- **2014.10.24-нд.** Олон улсын сургуулийн номын санчдын өдрийг дэлхий нийтээрээ 10 сарын 27 өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай болсон билээ. Олон улсын сургуулийн номын санчдын өдрийг угтаж “ЕБС-ийн номын санчдын анхдугаар уулзалт”-ыг Баянбуурал амралтын газар зохион байгуулж, 85 номын санчийг хамруулллаа. Анхдугаар уулзалтын гол зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үйл ажиллагааг сайжруулах, номын санчид хоорондоо нэгдэх, ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн холбоо байгуулж үйл ажиллагааг идэвхжүүлэхэд оршиж байлаа. Уулзалтаар дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:
    - Дүүргийн номын санчдын дунд боолцоот тэмцээн уралдаан зохион байгуулах
    - Номын санчдыг шагнаж урамшуулах
    - Номын санчид харилцан ярилцаж, чөлөөт цагаа өнгөрүүлэх, туршлагаа солилцох.
- **2014.10.15-29.** Монголын номын сангуудын консерциумтай хамтран “Номын сангийн анхан шатны мэдлэг олгох” 14 хоногийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтын хөтөлбөрийн дагуу лекц болон бие даалтын хичээлийг бэлтгэж, “Номын сангаас зохиох соёл олон нийтийн ажил” сэдвээр- 6 цагийн хичээл заасан. Нийт-13 номын санч хамрагдсан.
- **2014.11.03-07нд.** “**ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь**“ сэдэвт анхан шатны мэргэшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийслэлийн ЕБС-ийн -9 номын санчид хамрагдлаа. Сургалтын бэлтгэл ажил болон “Номын сангийн каталог зохион байгуулалт”, “СОНА”, ”Номын сангаас хүүхэдтэй

ажиллах ажил” зэрэг хичээлийг заасан. Номын санчдад гарын авлага болох хэрэгцээт материалыг бэлтгэж өгөв.

ЕБС-ийн номын санчдын сургалт семинарт хэлтсийн ажилтнуудын оролцоо:

Ном ангилагч С.Адъяаням: 2-р сарын 24- 28, 11-р сарын 3-7-ны өдрүүдэд Улаанбаатар хотын сургуулийн номын санчдад “Номын сан ном зүйн ангилал”, “Үндсэн бүртгэл хөтлөлт”, “Өдөр тутмын бүртгэл хөтлөлт” сэдвээр тус бүр 6 цаг нийт 12 цагийн хичээл зааж дадлага хийлгэсэн.

Номзүйч С.Тунгалаг: 2014-03-24-нөөс 28-ны өдрүүдэд сургуулийн номын санчдад “Ном бүрдүүлэлт”, “Картын сан зохион байгуулах”, “Фонд зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт”, “Номын сангийн үйлчилгээ” сэдвээр, 2014-10-02-нд Багшийн хөгжлийн ордонд баруун аймгийн ЕБС-ийн 100 номын санчдад “Фондын хадгалалт хамгаалалт” сэдвээр, 2014-10-29-нөөс 3 хоног монголын номын сангуудын консорциумтай хамтран “Номын санчдад зориулсан мэргэшүүлэх сургалт” –нд “Сан хөмрөгийн тухай ойлголт”, “Сан хөмрөгийн байрлал”, “Сан хөмрөгийн бүрдүүлэлт”, “Сан хөмрөгийн тооллого”, “Тооллогын тайлан (акт) гаргах”, “Сан хөмрөгт хөтлөгдөх бүртгэлүүд, тэдгээрийг бүртгэх” зэрэг сэдвээр тус тус хичээл заасан.

<u>6.3.2. Бусад сургалт</u>. Номзүйч С.Тунгалаг:

- “Эх орон” цэцэрлэгийн хүүхдүүдэд “Сайн нохой Бөөмбий” номоор чанга уншлага хийж, номыг хэрхэн унших талаар зөвөлгөө өгсөн.
- 2014-06-18-нд Нийслэлийн 74-р цэцэрлэгийн ажилтнуудад “Бага насны хүүхдийн уншлагыг удирдахуй” сэдвээр сургалт зохион байгууллаа.

- 2014-11-20-нд 70-р цэцэрлэгт СБД-ийн цэцэрлэгийн 50 аргазүйч, багш нарт “Бага насны хүүхдийн уншлагыг удирдахуй” сэдвээр сургалт явууллаа.

<u>6.4. Аргачлал боловсруулах</u>: Арга зүйч Л.Батболор

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
6	9	130%

- Номыг үр дүнтэй унших аргачлал
- СӨНХ-ийг яаж номтой нөхөрлүүлэх вэ?
- Шилдэг номын санч уралдааны удирдамж
- “Би ном унших дуртай ” сэдэвт ном уншлагын 7 хоногийн хөтөлбөр
- Ном унших соёлын талаар аргачлал
- Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх
- “Монгол ардын аман зохиолыг сурталчлах”
- “Номын сангийн клуб” хэрхэн зохион байгуулах

- МЗЭ-ийн шагналт зохиолч Шагжийн Ванчаарай "Амьдралаа би өөрөө босгосон" уран бүтээлийн өдөрлөгийн хөтөлбөр зэрэг аргачлалыг боловсруулав.

<u>6.5. "Номын санч" сэтгүүлд мэдээ, мэдээлэл бэлтгэх</u>:

Онол арга зүйн 7 нийтлэл, соёл танин мэдэхүйн ажлын талаарх 10 мэдээлэл, **бүгд 17 нийтлэл, мэдээллийг** тус сэтгүүлд нийтлүүлэхээр өгөв. Үүнд:

Арга зүйч Л.Батболор:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	4	100%

- "Яруу сайхан Монгол хэл" хүүхдийн зохиолчдын өгүүллэгийн уран уншлагын анхдугаар уралдаан
- Ном ухааралд хүрэх толь
- Номыг үр дүнтэй унших аргачлал
- Ном ангиллын түүхээс зэрэг сэтгүүлийн материалыг бэлтгэхээс гадна танхимаас зохион байгуулж буй ажлын талаарх дараахь мэдээ мэдээллийг номын санчдаас авч редакц хийж, "Номын санч" сэтгүүлд нийтлүүлэхээр өгсөн .

Үүнд: Герман танхимын соёлын ажлын талаар Г.Буянцэцэг:

- "Номын сан дахь зугаатай үдэш"
- "Улаан өндөгний баяр "

"Мөрөөдөл" танхимын номын санч Б.Батцэцэг:

- "Спортлог сурагчид ба Хүүхдийн зохиолчид"

"Боловсрол хөгжил" танхимын номын санч Н.Адьяа:

- "Монгол бахархал, цагаан сар"

ЗАА-н хэлтсийн эрхлэгч С. Тунгалаг:

- Орон нутгийн номын сангийн менежмент
- "Хүүхдийн уншлагыг удирдах нь" илтгэл.
- Хүүхдийн уншлагыг удирдахад интернэтийг ашиглах нь

ХНО-ны уншлага үйлчилгээний хэлтсийн эрхлэгч Г. Дарьсүрэн

- "Олон Улсын Хүүхдийн Номын баяр-2014"
- "Монгол үндэсний бичиг соёл" улсын 9-р уралдаан

Зөөврийн номын санч Б.Баярмаа

- "Номын сангийн шинэлэг үйлчилгээ"
- "Эртэч хүүхэд хөтөлбөр"

Ном бүрдүүлэгч Энхтуяа

- Хүүхэдтэйгээ том хүн шиг ярьж байгаарай!

Уншигч бүртгэлийн номын санч Ө.Бадамсэд

- ЕБС-ийн номын сангаас зохиох соёл олон нийтийн ажлын тухай зэрэг материалууд болно.

<u>6.6. Танхимуудын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд хийсэн тооллогын ажил</u>**:** *Арга зүйч Л.Батболор:*

Өрнө дахины уншлагын танхимын тооллого

2014.1.6-наас эхлэн 14 хоногийн хугацаатай Англи уншлагын танхим, Орос уншлагын танхимын ном хүлээлцэх ээлжит бус тооллогын ажлыг хийж гүйцэтгэх комиссыг захирлын тушаалаар баталсаны дагуу ном тооллогын комисст орж ажиллаа. Англи уншлагын танхим нь ойрын фондны олон хувьтай болон уншигчийн хэрэгцээ шаардлага хангахгүй номыг ялгаж актлуулахаар доод фондонд оруулахдаа баркодонд орсон номны баркодыг бичилгүй доош оруулсан нь дахин номыг шүүж бичин баркодыг уншуулах, баркодгүй номны дансыг дахин бичиж нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэх зэрэг ажлыг хийсэн нь нилээд цаг хугацаа орсон ажил боллоо.

Мөн нэг данстай номыг 2-3 баркод давхардуулж баркод наасан -18 ш номыг ялгаж нэг бүрчилсэн бүртгэлтэй дахин тулгаж баркодыг заслаа

Тооллогын ажлыг хийх явцад нилээд бэрхшээл гарсан учир заасан хугацаанд ном хүлээлцэх ажлыг дуусгаж чадалгүй хугацаа их орсон ажил болсон бөгөөд тооллогын акт үйлдэн тооллогыг захиргааны хуралд танилцуулсан.

Номзүйч С.Тунгалаг:

2014 оны 1-р сарын 5-наас эхлэн ажлын 20 хоног Япон номын болон Мөрөөдөл танхимын ээлжит бус тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тооллогыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь чанартай хийж, тооллогын дүнг Захиргааны Зөвлөлийн Хуралд танилцуулсан. Мөрөөдөл танхимын уран зохиолын номыг байрлуулцсан. Актлагдах номын жагсаалтыг зөвлөж, номын санчдаар нь гаргуулав.

6.7. Арга зүйн бусад ажил: Номзүйч С.Тунгалаг:

- Ардын урлагийг дэмжих төв “IOV” ТББ-ын сэтгүүлд “Цагаан идээг боловсруулах арга” сэдвээр материал бэлтгэж өгсөн.
- СУИС-ийн Соёлын сургуулийн 2 оюутны дадлага ажлын хуваарийг гарган удирдаж, хийлгэв.
- Номын тэмдэглэл хөтлөх зааварчилгааг 2 насны ангиллаар гаргаж, уншигчдад түгээсэн.
- Дархан-Уул, Хөвсгөл, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгийн номын сангуудын вэб сайттай танилцаж, мэдээлэл бичлээ**.**

7. Лавлагаа, номзүйн ажлын хүрээнд: Номзүйч С.Тунгалаг:

7.1. Шинэ номын мэдээ

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	4	100%

Бүх уншлагын танхимуудын 568 шинэ номоор мэдээллийг гаргаж уншигчдын хүртээл болгосон.

7.2. Номзүйн жагсаалт

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
11	17	154%

Ховд аймгийн Дарви сумын алтартнуудын номзүй, Ардын уран зохиолч Т.Галсан, Ш. Дулмаа, Д. Цоодол нарын намтар, уран бүтээлийн ном зүйн жагсаалт, бүх уншлагын танхимуудын улгэрийн номын номзүйн жагсаалт, Олон улсын хүүхдийн номын баярт зориулсан номзүйн жагсаалт, Англи хэл эхлэн суралцагчдад зориулж санамж өгөх номзүйн жагсаалт, С. Надмидын уран бүтээлийн номзүйн жагсаалт, Гавьяат багш Энхтүвшингийн уран бүтээлийн ном зүйн жагсаалт, Д. Гармаагийн уран бүтээлийн номзүйн жагсаалт, Их уншигдсан номын жагсаалт, ХНО хэвлэлийн хуудаснаа ном зүйд 2003-2007 оны 25 нэрийн 31 хуудас, 2010-2014 онуудад “Номын санч” сэтгүүлд хэвлэгдсэн 15 нэрийн 22 хуудас нийт 40 нэрийн 53 хуудас материалыг нөхөн бүрэн эхээр нь шивж оруулсан ба 17 ном зүйн жагсаалт гаргасан.

7.3. Лавлагаа амаар болон бичгээр өгөх

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1520	1855	122 %

Орчуулагч Г. Амарын орчуулгын бүтээл, Сингапур улсын эдийн засгийн хөгжилт, 8 нэр төрлийн шувууны зураг, хөдөлмөрийн тухай хууль, Грекийн номын сангийн хөгжил англи хэлнээс орчуулж, Өнөөгийн монголын нийгмийн өнгө, Ахмад дайчин М. Гэзэгтийн тухай, Харилцааны ёс зүйн талаар, Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга, Хумс арчилгааны тухай, Гадаад хэл заах арга зүй, МУҮНС-гаас 1924 онд хэвлэгдсэн Гүнсэнноровын Монгол утгын сургах бичиг 1-8 боть, Бат-Очирын Мандах нарны туяа, Намсрайн Манай цэцэрлэг, Миний шинэ гутал, Миний шинэ дээл, Манай Монголын таван хошуу мал, Д. Нямаагийн “Сансрын нисгэгч хүүхэд байлаа” шүлэг, Философич Расселийн үзэл баримтлал, газрыг өмчлөх эрхийн асуудал зэрэг бичгийн лавлагааг 1-3 хоног хайлт хийн биеэр болон утсаар цахим хаягаар өгсөн.

Арга зүйч Л.Батболор: ЧД-ийн 23-р сургуулийн бага ангийн багш Х.Нарангэрэлд хүүхдийн зохиолоор бичгийн, Оросын зохиолч Л.Н.Толстойн зохиолоор, “Уран гулгалт”-ын тухай, зохиолч Саруулбуяны уран бүтээлээс уншигчдад аман лавлагааг тус тус өгсөн байна.

<u>10. Ном хэвлэлийг сэргээн засварлах талаар</u>:

<u>10.1. Сэргээн засварлах үйл ажиллагаа:</u> 2014 онд бүгд 586 номыг сэргээн засварлажээ.
Үүнээс: Сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг:

<u>Ном</u> : Нийт – 555 ширхэг

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
550	555	100.9%

“Боловсрол хөгжил” танхим	- 340ширхэг ном
“Герман мэдээллийн номын сан“	- 16 ширхэг ном
“Мөрөөдөл” танхим	- 131 ширхэг ном
“Их мэдэх” танхим	- 56 ширхэг ном
Дорно дахины танхим	- 5 ширхэг ном
Өрнө дахины танхим	- 2 ширхэг ном
Санхүү	- 3 ширхэг баримт

<u>Сонин</u>: 85 хавтас сонинг тус тус нэг бүрчлэн шигшин, үдэж хавтаслав. Мөн даалимбаар шил наав.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
78	85	108.9 %

Ном бүрдүүлэгч Ч.Энхтуяа:

31 ширхэг ном сэргээн засварласан байна.

<u>10.2. Сэргээн засварлах сургалт арга зүйн ажил</u>.

ЕБС-ийн болон бусад номын санчид, цэцэрлэгийн багш нар, нийт 35 хүнд ном сэргээн засварлах талаар онол практик хосолсон 4 удаагийн сургалт явуулав.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	4	100%

Үүнд:

- 2-р сарын 27-нд ЕБС-н 18 номын санч номын санчид
- 10-р сарын 3 - 10-рсарын 7-ны өдрүүдэд ЕБС-н номын санч 8 хүнд
- 10-р сарын 22-нд СБД-ийн 69-р цэцэрлэгийн 3 багш тус тус хамрагдсан болно.
- 12-р сарын 24-нд МУИС-н 6 номын санч ном сэргээн засварлах сургалт авах захиалга өгөөд байна.

2. Төлөвлөгөөт ажил буюу уншлага үйлчилгээ:

2. 1. Уншигчийн үнэмлэх нээлт: Бүртгэлийн номын санч Бадамсэд:

Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө	Биелэлт	Гүйцэтгэл
ЕБС-ийн уншигч/1000төг/	1400	1873	133%
Насанд хүрэгчид, оюутан /2000төг/	1900	2077	109%
Нийт	3300	3950	119%

2014 онд Lib4U программын дагуу өдөр тутмын бүртгэлийг тогтмол хөтлөн нийт 3950 уншигчдад үнэмлэх нээж, 9 926 000 мянган төгрөгний орлогыг санхүүд тушаалаа. Үүнээс ЕБС-ийн сурагч 1873 ш, насанд хүрэгчид, оюутан 2077 ш. Уншигчийн үнэмлэх шинээр нээлгэж байгаа уншигчдад ХНО-ны уншлагын танхимууд болон тэдгээрээр хэрхэн үйлчлүүлэх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн мэдээллийн санд орсон уншигчдын мэдээлэл дутуу , 1 уншигчийн мэдээлэл олон дахин давхардсан зэрэг алдаануудыг зассан.

2014.03.05-аас эхлэн ХНО-ны уншигчийн үнэмлэх шинэчлэгдэн пластик картан дээр хэвлэгдэх болсон тул үнэмлэх нээлтийн төлбөр ЕБС-ийн сурагчид 2500 төг, насанд хүрэгчид, оюутан 3500 төг болон шинэчлэгдэж, үнэмлэхний хугацаа 2 жил болсон.

Хуучин үнэмлэхний чанар муу, хурдан салж урагддаг, эдэлгээ муутай байсан бол пластик уншигчийн үнэмлэх өнгө үзэмж сайтай, удаан эдэлгээтэй, номын санчийн ажлыг хөнгөвчилсөн, уншигчдад хурдан шуурхай үйлчлэх боломжийг хангасан зэрэг олон давуу талуудтай болсон.

2.2.Танхимын ирц, ном олголт:

№	**Танхимууд**	**Ирц**			**Ном олголт**			**Байрлуулалт**		
		төл	**бие**	**гүйц**	**төл**	**бие**	**гүйц**	**төл**	**бие**	**гүйц**
1	Боловсрол хөгжил	26000	29724	114%	37000	37058	100%			
2	Монгол фонд				37000	40348	109%	37000	40024	105%
3	Мөрөөдөл	13000	13080	101%	24000	24110	100%	24000	30000	125%
4	Их мэдэх	4260	4732	111%	6000	9594	150%	6000	5464	128%
5	ГМНС	4500	6298	140%	8000	9789	122%	8000	6298	139%
6	Өрнө дахин уншлагын танхим	3830	4211	109%	5600	6908	123%	6908	4295	112%
7	Дорно дахин уншлагын танхим	600	1037	172%	1500	1648	109%	1500	1160	193%
8	Зөөвөр		12998			7514				
	дүн	52190	72080	138%	119100	136969	115%	83408	87241	104%

2.3. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: 22 байгууллага төвүүдтэй хамтран ажиллаж, 4018 ном хүргэгдсэнээс 12998 ирцэд 7514 ном олгож үйлчилсэн байна.

3. Танхимуудын дотоод ажил:

Хүснэгт 1

Танхимууд	Ангилсан номын тоо	Дансалсан номын тоо	Эл каталогт нөөц үүсгэсэн номын тоо	Зохиогчийн тэмдэгт зассан ба Редакц хийсэн номын тоо	Таагжуулах
Монгол фонд				165 ш ном, 19ш Жавзанпагма- 37, Нийт 228 ш номонд редакци	
БХ				28 ред	
Мөрөөдөл				850 ред	
Их мэдэх	-	-	-	-	197
ГМНС	423 ш ном аудио визуал мат	423 ш ном аудио визуал мат	423	521 ш номонд редакц хийж, 145 ш номонд түлхүүр үг болон товч агуулгыг нэмж засварлав.	423
Өрнө ДУТ					
Дорно ДУТ	123	123	хятад хэлний 10 нэр төрлийн 26 ш ном, солонгос хэлний 7 ш ном нийт 33 ш		123
Дүн	546	546	430	1627	743

Хүснэгт 2

Танхимууд	Фонд баяжилт /ш/	Зураасан коджуулсан, таагжуулсан номын тоо	Сэргээн засвар-лагчид /ш/	Солилцоо Зөөвөрт	Хянал-тын карт	Шинэ номын мэдээнд
1.Монгол фонд	1386 ш. ном, 19 ш CD Архивт 328 ш ном, 8 ш CD		340 ш ном Өдөр тутмын 85 хав.сонин	Солилцоо- ХИДС-63 Зөөвөрт 323,	600	95
2.Мөрөөдөл	511 ш ном, 27 CD		131	374 зөөвөрт		
3.Их мэдэх	30CD, 272ш ном,450 ш англи ном	450 тааг	28	354 зөөвөрт 108 солилцоо		
4.ГМНС	184 ном, 220 АВ мат, нийт 404 ш ном, АВ мат	423 ш ном аудио визуал мат	20			10 CD, 6 ном

5.Өрнө дахин	32 ном, 52CD 6 төрөл 36 сэтгүүл	15 номонд баркод наасан		503 солилцоо 2 удаа 50 ш ном зөөвөрт	250	
6.Дорно дахин	123 ном, 87сэтгүүл	японы 5 ш номын bar code-ийг	5 ном, 2 хав сонин	9 солилцоо 30 зөөвөрт	50	
Дүн	3286 ном, 356 CD 123 ш сэтгүүл	443 ш зур. Код, 450 тааг	524	1131 зөөвөрт 683 солилцоо	960	101 ном, 10 CD

5.5.Лавлагаа:

Боловсрол хөгжил танхим болон монгол фонд:
Уншигч, оюутан залуучуудад электрон каталог ашиглах, электрон каталогоос ном шүүх арга, захиалгын хуудсын бичилт, фондоос гэрээр ном авах үйлчилгээний талаарх мэдээ мэдээлэл, Хүүхдийн Номын Ордоны үйл ажилгаатай танилцахаар ирсэн оюутан залуучууд, сурагчид, эцэг эхчүүд, хөдөө орон нутгаас ирсэн номын санчид болон хэвлэл мэдээллийн ажилтнуудад цаг тухайд нь танилцуулга мэдээлэл өгсөн.

Боловсрол хөгжил танхим, зөөврийн номын санч Б. Баярмаа:

- Боловсрол хөгжил танхимын ажилтан Баярмаа facebook –д Ном унших сонирхолтой 10 хүүхэд залуусын асуултанд хариулт өгч унших номын талаар лавлагаа өгч үйлчилсэн.
- 2014.3.3 Төв аймгийн сумдын сургуулийн номын санчдад шинэ үйлчилгээ болох "Эртэч хүүхэд" сургалтыг хийлээ. Сургалтанд 35 номын санчид хамрагдсан.
- 2014.10.3 Баруун бүсийн аймгийн сургуулийн 100 номын санч нарт номын сангийн шинэлэг үйлчилгээ болох "Эртэч хүүхэд" хөтөлбөрийг танилцуулах сургалт хийлээ.
- Герман танхим: Орос хэлний орчуулагч Хандсүрэнд герман улсын архины хуулийн тухай мэдээллийг файлаар олж өгөв.
- 5-р сарын 14-нд 1616 мэдээллийн лавлах-д танхимын үйл ажиллагааны талаарх мэдээллийг өглөө.
- 6-р сарын 18-нд Антоон Мостаэрт Монгол судлалын төвийн номын санчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, номыг цавуутай хавтсаар хавтаслах талаар зааж үзүүлэв.
- "Шинэ номын мэдээ"-нд орох номын мэдээллийг номзүйчээс авч редакц хийлээ.

Герман танхим: Герман номын санг танилцуулах үзүүлэн таниулах сурталчилгааг \Presentation\ 5 удаа хийж, Гёте-Институтийн герман хэлний сургалтын нийт 127 оролцогчийг хамруулав. Үүнд:

1-р сарын 20нд 13,
5-р сарын 23-нд 27,
6-р сарын 19-нд 13,
8-р сарын 6-нд 10,
8-р сарын 27-нд 34
9-р сарын 29-нд 30 оролцогч тус тус хамрагдлаа.

9-р сард танхимын ажилтан Г.Буянцэцэг "ГМНС-аас явуулж байгаа соёл, танин мэдэхүйн ажил" сэдвээр үзүүлэнт мэдээлэл бэлтгэн Баян-Өлгий аймгийн номын санчдад танилцууллаа.

Дорно дахины танхим:

Хятад болон япон хэлний сурах бичиг, толь бичиг, хятадын цайны соёлын талаар танхимд байгаа номоо танилцуулж давхардсан тоогоор 36 удаа лавлагаа өгч ажиллалаа.
Соёлын дээд сургуулийн номын сангийн ангийн 1, 3 дамжааны оюутнууд танхимтай танилцаж сонирхсон асуултанд нь лавлагаа мэдээлэл өгөв.
Хятад, япон, солонгос хэл дээрх 30ш номоор "Таньд санал болгох ном" нэртэйгээр тараах материал бэлдэж байнгын уншигчдаар дамжуулан сургуулиудад нь өгч, мөн жижүүрийн хэсэгт тавьж тараав.

Их мэдэх танхим:
ХНО-оор үйлчлүүлэх, уншигчийн карт нээлгэх тухай, Хүүхдийн насанд тохирсон номыг яаж сонгох тухай аман лавлагааг тогтмол өгч ажиллаж байна.

Мөрөөдөл танхим:
1-р сарын 20-нд Үлэг гүрвэлийн музейн номын сангийн 2 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Өрнө дахины танхим:
TOEFL, SAT, IELTS-ийн шалгалтын номын тухай
Дэлхийн сонгодог уран зохиолын тухай /орос, англи хэл дээр хэвлэгдсэн /
Монголын түүх, соёл урлаг, уран зохиолын номын тухай /орос, англи хэл дээр хэвлэгдсэн/

6.Соёл олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажил:
6.1. Сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн:
Сэдэвчилсэн үзэсгэлэн: 40 удаа нийт 790 ш ном, 74 ш CD ээр гаргасан байна.
Шинэ номын үзэсгэлэн: 34 удаа 617 ш ном, 68 CD, Вэбд 40 ш номоор

Д / д	Сэдэв	Тоо. ш. ном/	танхим
1	4-сарын 26-нд "Зохиолчдын анхны ном" үзэсгэлэнд гаргасан 129 ширхэг номыг хүлээн авч тавиурт байрлуулсан. "Монгол бахархал цагаан сар", "Гэгээн хайр", Ховд аймгийн Дарви сумын эрдэмтэн, зохиолчид,Г.Амарын орчуулгын , "Бүсгүйчүүд"сэдэвт, "Монгол цэргийн жавхаа", "Ардын уран зохиолчид","Эх хэл хэрэглээ","Үндэсний бичиг үсгийн баяр" -т "С.Надмидын уран бүтээлээс","Хувилай хааны дөрвөлжин үсгийн хэвлэлийг тодруууллаа"сэдэвт,Дэлхийг чимсэн Монгол наадам,"Эрдмийн элч –Их багш" "Хэлмэгдэгсэдийн дурсгалын өдөрт" "Мод тарих үндэсний өдөрт" "Нийслэлийн 375 жилийн ойд" "Ш.Гаадамбын уран бүтээл"- ээр ЭШХ-д "Чингис хааны төрсөн өдөрт"	16удаа 406 ш ном	БХ, МФ
2	2010-2013 онд хэвлэгдсэн шинэ сурах бичиг, Зохиолч уншигчдын уулзалтанд зориулж, "Дэлхийн шилдэг үлгэр" С.Надмидын зохиолоос, Үндэсний хэмжээний "Номын баяр"-ын	5 удаа 129 ш номоор	Мөрөөдөл

	15 дахь арга хэмжээний хүрээнд		
3	Шинжлэх ухааны хялбаршуулсан ном Монгол ардын үлгэр Шинжлэх ухааны хялбаршуулсан ном Бага насны хүүхдэд зориулсан ном Дэлхийн шилдэг үлгэр	5 удаа 91 ш номоор	Их мэдэх
4	Сэдэвчилсэн үзэсгэлэнг нийт 109 ном CD-гээр гаргалаа. 6-р сард хөгжмийн 17CD, 8-р сард рок поп дууны 25 CD, 9-р сард сонгодог хөгжмийн 11 CD, 10-р сард хүүхдийн дууны 11ном CD, хүүхдийн уран зохиолын 10 номоор танхимдаа, коридорын шилэн хоргонд 3-р сарын 26-нд Олон улсын хүүхдийн номын өдөрт зориулан “Дэлхийн үлгэрүүд“ сэдэвт үзэсгэлэнг 11 ном, 5 DVD, 4 CD, нийт 20 ном болон аудио видео материалаар, 9-р сард “Номын баяр”-аар хүүхдэд зориулсан 15 ном болон аудио видео материалаар тус тус гаргав.	6 удаа 35 ш ном 74 CD	Герман
5	Х.К.Андерсаны мэндэлсний 209 жилийн ойд зориулж үзэсгэлэн, Дэлхийн хүүхдийн номын баяр	5 удаа 109	Өрнө дахины танхим
6	Дэлхийн хүүхдийн номын баярт зориулж хятад болон япон хэлээр хэвлэгдсэн Х.К.Андерсен болон бусад үлгэрийн номоор	3 удаа 20	Дорно дахины танхим
	Нийт	40 удаа 790 ш ном 74 ш CD	ХНО
	Шинэ номын үзэсгэлэн		
	1 сарын 20 ,2 сарын 16,3 сарын 13,7 сарын 28 9 сарын 30,12 сарын 9	12ш, 24ш, 41ш, 31 ш 26ш, 21ш 9 удаа 221ш	“Боловсрол хөгжил” танхим
	01-р сарын 20,02-р сарын 14, 03-р сарын 12 04-р сарын 12 , 04-р сарын 3, 06-р сарын 18 08-р сарын 21, 09-р сарын 30,12-сарын 09 Вэб сайтад шинэ номын үзэсгэлэнг ширхэг 7-р сарын 4-нд 10 ширхэг номоор 8-р сарын 12-нд 10 ширхэг номоор 8-р сарын 14-нд 10 ширхэг номоор 11-р сарын 16-нд 10 ширхэг номоор тус тус гаргаж уншигчдад сурталчилсан.	12ш, 24 ш,42 ш, 11 ш, 40 ш,12 ш, 31 ш, 28 ш, 21 ш 9 удаа 221 ширхэг 4 удаа 40 ширхэг	Монгол фонд

	2014. 9 сар 2014. 3 сар 2014. 6 сар 2014. 10сар	31 16 15 16 4 удаа 78 ширхэг	Их мэдэх
	1-р сард 2-р сард 3-р сард	26 ш DVD 6 ном, 12 DVD, 8 ном, 23 ш CD, 7 CD 3 удаа 95 ширхэг	Герман
	11 сард	1 удаа 24 ширхэг	Мөрөөдөл
	Шинэ номын үзэсгэлэнг хятад хэл дээрх 20 ш номоор, солонгос хэл дээрх 39 ш номоор 3 удаа гаргалаа.	20 ш 39ш Нийт 3 удаа 59 ш номоор	Өрнө
	Нийт	34 удаа 617 ш ном, 68 аудио визуал материал Вэбд 40 ном	ХНО

6.2. Мэдээлэл сурталчилгааны ажил: Танхимын ажилтнууд танхим болон хийсэн ажлаа байнга сурталчлан ажиллаж байна. Үүнд :
2014.9.18. ХНО-ны танхимын ажилтнууд Баян–Өлгий аймгийн номын санчдад зориулан танхимд зохиогдож байгаа соёлын ажлын онцлогийн талаар танхимын ажилтнууд товч танилцуулга хийв. Үүнд:

Боловсрол хөгжил танхимын үйлчилгээний онцлог

Мөрөөдөл танхим: “Зохиолч-Уншигчийн уулзалт”, “Соёлын ажил”,

Их мэдэх танхим: Бага насны хүүхдэд зориулсан соёлын ажлын онцлог”, “Залуу эцэг эхэд зөвлөгөө”,

Өрнө дахины уншлагын танхимын номын санч И.Пүрэвбат “Клубын үйл ажиллагаа“

Дорно дахины танхимаас номын санч Д. Алимаа “Сэдэвчилсэн соёлын ажил болон цуврал лекц”,

Герман танхимын ажилтан Г. Буянцэцэг “ГМНС-аас явуулж байгаа соёл танин мэдэхүйн ажил” сэдвээр,

Зөөврийн номын сангийн ажилтан Б. Баярмаа шинэлэг үйлчилгээ болох “Эртэч хүүхэд” үзүүлэнт мэдээлэл бэлтгэн Баян-Өлгий аймгийн номын санчдад танилцууллаа.

Номын санч Бадамсэд Төв аймгийн нийтийн номын санчдын сургалт семинарт “Номын санчийн ёсзүй” гэсэн сэдвээр хичээл орсон.

Герман танхимд:

- Танхимын танилцуулгыг шинэчлэн хэвлүүлэхээр Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газарт мэдээллийг файлаар өгч, герман монгол хэлээр 2500 ширхэгийг хэвлүүлэв.
- Танхимын шинэ танилцуулгыг Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газар болон танхимаар уншигчдад байнга түгээж байна.
- 1-р сарын 3-нд ETV танхимд зураг авлаа.
- Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газрын цахим хуудсанд танхимын үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл бүхий блог байнга тавигдсан.

- МонЦаМэ агентлагаас Герман-Монголын хамтын ажиллагааны 40 жилийн ойд зориулан фото зургийн цомог гаргахаар болсон бөгөөд тус цомогт оруулах танхимын үйл ажиллагааны зураг авалтыг 2 сарын 27-нд хийлээ.
- 5-р сарын 3-нд Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын санд "Номын сангийн консерциум"-аас зохион байгуулсан номын санчдын нээлттэй уулзалт ярилцлаганд танхимын ажилтан Г.Буянцэцэг оролцож ГМНС-аас зохион байгуулж буй "Шөнийн уншлага"-ын талаарх мэдээллийг номын санчдад өглөө.
- 7-р сарын 7-нд байгууллагын цахим хуудсан дахь танхимын мэдээллийг шинэчлэв.

Зөөвөр :

2014.04.02 Арга зүйч Батболортой хамт Хан-Уул дүүргийн "Бяцхан мэргэд" номын сангийнханд номын сангийн үйлчилгээний талаар зөвөлгөө өгч хамтран ажиллахаар болсон.

2014.05.03 ССАЖЯ, Монголын номын сангийн консерциум, хотын төв номын сангийн хамтран зохион байгуулсан төв орон нутгийн нийтийн номын санч нарын уулзалт семинарт оролцлоо. Тус уулзалтанд шинэ үйлчилгээ болох "Эртэч хүүхэд" хөтөлбөрийн талаар танилцуулж, сурталчиллаа.

Дорно дахины танхимд: 14.05.08. Японы Хүүхдийн хөгжмийн чуулгын удирдаач Эндо сан японы газрын зураг болон бэлэг дурсгалын зүйлийг танхимд бэлэглэв.

Сургууль хамт олноороо ирж номын сангийн уншигч боллоо:

- Танхимын номын санч Баярмаа 2014.11-12 сард Гёте дунд сургуулийн 2-12-р ангийн 198 хүүхдэд уншигчийн карт нээлгэж үнэмлэх нээлтэнд 495 000 төгрөгний тооцоог хийв.
- Г. Дарьсүрэн Сант сургуулийн Сансартуяа багштай хамтран ахлах ангийн 250 орчим сурагчдыг үнэмлэхжүүлэв.
- 18-р сургуулийн 3, 67-р сургуулийн 3, 24-р сургуулийн 4 ангийн хамт олон Их мэдэх танхимын байнгын уншигчид боллоо
- 6.3. Танхимуудад болсон соёлын ажлууд:

6.3.1. Шинэлэг үйлчилгээнд 6 төрлийн ажил
6.3.2. Зохиолч уншигчийн уулзалт: 14 удаа.
6.3.3. Номын баяр: Танхимуудад 7 удаа
6.3.4. Эрдэм шинжилгээний бага хурал: Боловсрол хөгжил танхимд 2 удаа
6.3.5. Уралдаан тэмцээн, мэтгэлцээн - 4 удаа
6.3.6. Чанга уншлага: 12 удаа

6.3.7. Клубын уулзалт, ярилцлага: 29 удаа
6.3.8. Өдөрлөг: 8 удаа өдөрлөг зохион явуулсан байна.
6.3.9. Зөөврийн номын сангийн соёлын ажлын хүснэгт

6.3.1. 2014 онд танхимуудаас явуулж байгаа шинэлэг үйлчилгээнд доорх 6 төрлийн ажлыг нэрлэж байна.

1.“Их мэдэх” танхимд бага насны хүүхдүүдэд зориулсан: “Үлгэрийн цаг” - 7 удаа
2.“Их мэдэх” танхимд “Эцэг эхэд зориулсан зөвлөгөө”- 4 удаа
3.“Мөрөөдөл” танхимд : “Уншлагын 7 хоног”
4.Герман танхимд сургуулийн бага ангийн хүүхдүүдэд зориулсан: “Шөнийн уншлага” – 3 удаа
4.Зөөврийн номын санд захын хорооллын гэр бүлийнхэний хөгжилд зориулсан “Эртэч хүүхэд” хөтөлбөр -12 удаа
6.Дорно дахины танхимд “Уран бичлэгийн дугуйлан”- 2 удаа

1. “Их мэдэх” танхимд бага насны хүүхдүүдэд зориулсан “Үлгэрийн цаг”

Их мэдэх танхимын ажилтан Дарьсүрэн “Хүүхэд хөгжил” ТББ, СУИС-ийн багш Тунгалаг, номын сан-мэдээлэл зүйн ажилтны 2 –р дамжааны оюутнуудтай хамтран 7 удаа үлгэрийн цагийг явуулж 140 гаруй хүүхдүүдийг хамруулсан байна.
2014.10.11 ны 12.00 цагт "Хүүхэд хөгжил" ТББ , ХНО-ны "Их мэдэх" танхим хамтран ХНО-ны “Их мэдэх” танхимд "Үлгэрийн цаг" өдөрлөгийг зохион явууллаа. “Үлгэрийн цагт” оролцохоор ирсэн хүүхдүүдэд "Доголон шаазгай" монгол ардын үлгэрийг ярьж өглөө. Үлгэрийн цагт 20 гаруй хүүхдүүд эцэг эхийн хамт оролцов.

Үлгэрээ сонссоны дараа уншигч хүүхдүүд үлгэрийн тухай ярилцаж , үлгэрийн сэдвээр зураг зурж, үлгэрийн баатруудтай танилцаж, ном уншиж цагийг зугаатай өнгөрүүллээ.
"Хүүхэд хөгжил" ТББ-аас санаачлан номын хандив аяныг явуулж “Аз хур” компани 50,000 төгрөгийн, Хүүхэд хөгжил ТББ-аас явуулсан хандивын 50.000 төгрөгийн номыг ХНО-ны “Их мэдэх” танхимд бэлэглэв.
2014 оны 10 сарын сүүлээс эхлэн СУИС-ийн Соёлын сургуулийн багш Тунгалагтай хамтран “Номын сан-мэдээлэл зүйн” 2-р дамжааны оюутнуудыг удирдан Үлгэрийн цагийг 6 удаа явуулав. 6 удаагийн үлгэрийн цагт ойролцоогоор 140 гаруй хүүхдүүд эцэг эхийн хамт оролцлоо. Үлгэрийн цагийн дараагаар 30 минутанд бүтээлийн цагийг явуулж хүүхдүүдэд

баримлын шавраар чимэглэл хийх, шинэ жилийн чимэглэл хийх, цаасаар цэцэг нугалахыг зааж өглөө. Энэхүү ажилд эцэг эхчүүд идэвхтэй оролцсон бөгөөд уншигч Энх-Ертөнц, уншигч Маргадын ээж нар илүү идэвхитэй оролцож нугалбар, шинэ жилийн чимэглэл хийг зааж өгөхөөс гадна өөрсдөө материалаа гаргалаа.

11 сарын 25 нд “Алтан загасны үлгэр”
11сарын 1нд “Улаан малгайт”
11 сарын 8 нд “Өнчин цагаан ботго”
11сарын 15нд “Оньсого таалцацгаая
11сарын 22 нд “Өнхрүүш”
11сарын 29 нд “Гурван баавгай”
12 сарын 6 нд “Манжин үлгэр” үлгэрийг жүжигчилсэн хэлбэрээр явуулж хүүхдүүдэд үзүүллээ.

2.Эцэг эхэд зориулсан сургалт. Энэ жилд 4 удаа явуулж 327 эцэг эхийг хамруулсан.
1.“Их мэдэх” танхимд 3 сарын 15 нд 21-р сургуулийн 5 ангийн сурагчдын эцэг эхэд “Өсвөр нас буюу шилжилтйн насны хүүхдүүдийн насны онцлог, тэдэнд зориулсан ном”- ын талаар үзүүлэн таниулах сургалтыг явуулав. Үүнд: 15 эцэг эх, 1 багш оролцов.
2. 2014.04.29. Төв аймгийн Баяндэлгэр сумын 2-р ангийн сурагчдын эцэг эхийн урилгаар “Залуу эцэг эхчүүд хүүхдүүдээ яаж ном уншуулж сургах вэ?” Сумын төвийн улаан буланд ХНО-ны тухай, номын тухай яриа таниулгыг хийгээд ирсэн. Энэ ажилд нийт сумын төвийн

200 гаруй эцэг эх, 9 жилийн дунд сургуулийн 2-р ангийн 18 сурагчид тэдний эцэг эх нийлээд 250 гаруй хүмүүс оролцсон.
3. 2014. 4.2. 42-р цэцэрлэгийн ахлах бүлгийн 35 эцэг эхэд сургалт явуулсан.
4. 2014.12.22. 24-р сургуулийн 1ж ангийн эцэг эхчүүдэд “ХНО-ны танхим, үйлчилгээний тухай” “Ном уншуулах эрүүл ахуй” сэдвээр зөвлөгөө өгсөн. Энэ ажилд 24 эцэг эх оролцсон.

3.“Мөрөөдөл” танхимд “Уншлагын 7 хоног”
Мөрөөдөл танхимд “Уншлагын 7 хоног” арга хэмжээг 2014.11.17 – 23 ны хооронд арга зүйч Батболортой хамтран зохион явуулав. Арга хэмжээний үеэр:

- 2014-11-17. 67-р сургуулийн 3в ангийн сурагчдад Соёлын боловсролын номын сангийн ангийн 2-р курсын оюутнууд “Алт мөнгө хоёр” монгол ардын үлгэр уншиж, сэтгэгдэлийг зургаар илэрхийлүүлж урамшуулав.
- 2014-11-18. 16-р сургуулийн Энхцэцэг багштай 5в ангийн хамт олныг урьж оролцуулан 5 багт хуваан, баг тус бүрт Монголын нэгэн хүүхдийн зохиолчийн намтар уран бүтээлийг уншуулж танилцуулан, ойлгосноо хэрхэн танилцуулж буй байдлаар нь шалгаруулан “Алимтай асуулт хариулт”-ын тэмцээн зохион байгуулав. Арга хэмжээний үеэр MNC телевиз бичлэг хийн, ном зүйч С.Тунгалагаас ярилцлага авав. 2014-12-14-ний “Өдрийн хэмнэл” мэдээллийн хөтөлбөрөөр цацагдав.
- 2014-11-19. 84-р сургуулийн Удаанжаргал багштай 5в ангийн сурагчдад Соёлын боловсролын сургуулийн Соёлын менежментийн ангийн оюутнууд Лодойдамбын “Малгайтай чоно” туужийн хэсгээс уншиж, харилцан ярилцав. Ангийн багшийн хамт Монголын Нууц товчоо хөлөгт таавар тоглоом тоглов.
- 2014-11-21. 15-р сургуулийн 2в ангийн сурагчид өөрсдийн хамгийн сайн мэддэг шүлгийг уран яруу уншсанаар нь шалгаруулж номын бэлгээр урамшуулав.
- 2014-12-05. Соёлын сургуулийн номын сангийн 2-р курсын оюутнууд “Нууцыг задруулсан захидал” өгүүллэгээр 84-р сургуулийн 7-р анги, Спортын сургуулийн 8-р ангийн сурагчдад урнаар уншин, зохиолын үйл явдлаар зураг зуруулав
- 10-р сарын 10. 67-р цэцэрлэгийн ахлах бүлгийн 96 хүүхэд эцэг эхийн хамт ирж номын санч Бямбасүрэн тус бүрт нь “Болдоггүй бор өвгөн” “Нэг төө өвгөн” зэрэг үлгэрийг уншиж өгөв.

4.Шөнийн уншлага: 2014 онд шинэлэг үйлчилгээ болох шөнийн уншлагыг Герман танимд 2 удаа, нийслэлийн 67-р сургуулийн 3-р ангийн хамт олны хүсэлтээр Их мэдэх танхимд 1 удаа нийт 2 танхимд 3 удаа явуулав.
Герман танхимд:

4-р сарын 18-нд 38-р сургуулийн 5в ангийн 19 сурагчдад “Шөнийн уншлага” зохион байгууллаа. Танхимын ажилтнууд ХНО-ны болон герман танхимын талаар хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд танилцууллаа. Гёте-Институтийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал ноён Сэбастиан Войч хүүхдүүдэд сонирхолтой сэдвээр хөгжимт уншлага хийлээ. Английн алдарт хөгжимчин Дэймон хүрэлцэн ирж, амьд хөгжим тоглож үзүүлэв. ХНО-ны хэлтсийн эрхлэгч Г.Дарьсүрэн “Хүүхдийг номтой нөхөрлүүлэхийн ач тус, ном унших эрүүл ахуй” сэдвээр “Их мэдэх” танхимд эцэг эхчүүдэд лекц, Герман уншлагын танхимын ажилтнууд хүүхэд

бүрт хялбар унших сэдвийг тараан өгч ганцаарчилсан уншлага зохион байгууллаа. Оройн хөнгөн зуушны дараа хүүхэд бүр өөрийн уншсан сэдвээ бусдадаа ярьж өгөв. Хүүхдүүд богино хэмжээний хүүхдийн кино үзэж, номын санд найз нөхдийн хамт хоножүйлчлүүллээ.
10-р сарын 24 –нд ““Lesenacht MOMO” уншлагын шөнө үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд 18-р сургуулийн 4-р ангийн 10 настай 20 хүүхэд герман хэлний багшийн хамт оролцож, номын сантай танилцав. Хүүхдүүд хамт олноороо ном уншиж, кино үзэж, тоглож, дуулж үдшийг хөгжилтэй өнгөрүүлэв. Манай "Уншлагын үдэш"-ийн үйл ажиллагаа оройн 19:00 цагаас өглөөний 09:00 цагийн хооронд:

Номын санчид танхимын тухай танилцуулга хийх.
2. Герман-Монгол хэл дээрх уншлага. "МОМО" номын хэсгээс унших.
3. Хүүхдүүд бие биедээ ойлгосноо ярьж өгөх.
4. Оройн хоол. /Пицца, жүүс, ус/
5. Хүүхдүүд "Момо" номын тухай дууг сурах, дууны бичлэг үзэх
6. Uno болон Scrabble үг үсэг таах танин мэдэхүйн тоглоом тоглох, өөрийн дуртай номыг сонгон авч унших.
7. Сугалаа сугалаад бэлэг авах.
8. Хүүхдийн кино үзэх.
9. Унтлагын цаг 23.00-08.00
10. Өглөөний цай 08.30- 09.00 гэсэн төлөвлөгөөний дагуу явагдлаа. Хүүхдүүд аяны хөнжил, шүдний оо, сойзоо авчирч номын санд хонож үйлчлүүлэв.

Их мэдэх танхимд: 2014 оны 10 сарын 31 ний орой 19 цагт 67-р сургуулийн Дэлгэрцэцэг багштай 3-р ангийн 12 сурагчид ХНО-ны “Их мэдэх” танхимд шөнийн уншлага хийлээ. Шөнийн уншлагын гол зорилго нь 1 өдрийн оройн цагийг телевиз, утасгүй ном уншиж, үлгэр сонсож, хөгжилтэй тоглоом тоглож өнгөрүүлэх явдал байлаа. Шөнийн уншлагын ажлын үеэр.

Ном унших эрүүл ахуй сэдвээр эцэг эхэд

Уншлагын цаг Мөрөөдөл танхимд хүүхдүүд 30 минут ном уншив.

“Үлгэрийн цаг” – А.С. Пушкиний “Алтан загасны үлгэр”-ийг СУИС-ийн номын сан мэдээлэл зүйн 2 курсын оюутнууд ирж жүжигчилсэн тоглолт тоглож үзүүлсэн.

“Бүтээлийн цаг“- “Алтан загасны үлгэр” сэдэвт ханын сонин хийлээ. Бүх хүүхдүүд хамтран зурж, будаж, чимэглэж ханын сонин хийцгээв.

“Унтлагын цаг”
Оройн хоолыг 67-р сургуулийн цайны газрын хамт олон бэлдэж өгсөн. Тогооч эгч хүүхдүүдэд оройн хоол хүлээлгэн өгсөн. Өглөөний цайг ХНО-оос бэлтгэж өглөө.

“Би зураач”: уншсан үлгэрээсээ сэдэвлэн подволкон дээр зураг зурав.

5.Зөөврийн номын сан.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг гэр бүлийн гишүүдэд хүртээмжтэй хүргэж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох, эцэг эх хүүхдүүдийн хоорондын харилцааг сайжруулах зорилготойгоор энэ оноос эхлэн сард 1 удаа “Эртэч хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх боллоо. Энэ хөтөлбөрийг Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн 58 гишүүн гэр бүлээрээ хамрагдаж зөөврийн номын сангаар хамтран ажилладаг ДЗМОУБ-ын Баянхошуу төвтэй хамтран 12 удаа явууллаа.

Үйл ажиллагаа:

2014.1.27 “Эртэч хүүхэд”-1. 2014 оны 1 сарын 27-ны ням гаригт өглөөний 7.00-7.30 цагийн хооронд боллоо. Хөтөлбөрт хамрагдаж байгаа өрхүүдийн эхний хүмүүс өглөөний 6.45 цагт төв дээрээ хүрэлцэн ирсэн нь зохион байгуулж байгаа бидний хувьд тун таатай байлаа. Энэхүү хөтөлбөрт 5 өрхийн 18 гишүүн хүрэлцэн ирж идэвхитэй оролцлоо.

2014.2.23 “Эртэч хүүхэд”-2. ХНО-ны дэргэдэх “Оюунлаг сэтгэл” клубын гишүүд, ХНО-ны “Их мэдэх” танхимын номын санч Г.Дарьсүрэн нар хамтран зохион явууллаа. Бид уламжлал ёсоор гэр бүлийн гишүүдэд зориулан хүүхэд насны дурсамжийг сэргээх “Шилдэг өглөөний цай”- гаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн билээ. Хөтөлбөрийн үйл ажиллагааг “Оюунлаг сэтгэл” клубын гишүүн МУИС-ийн оюутан Б.Мандалмаа, Г.Цэрэнхорлоо, Б.Мөрөндалай нар өглөөний цайны ач тус, чихрээр нэгдэе, ном хүүхэд хоёрын нөхөрлөл, танилцаад хүчтэй болцгооё, гэр бүлийн цэцэг, тэврэлт гэсэн сэдвүүдээр явууллаа.

2014.3.23 “Эртэч хүүхэд”-3. Энэ удаагийн хөтөлбөрт Д.Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч О.Сундуй, ХНО-ны захирал Д.Оюунбилэг нар хүрэлцэн очлоо. Уулзалтаар хүүхдийн зохиолч О.Сундуй хүүхдүүдэд уран бүтээлийнхээ дээжээс уншиж сонирхуулж, тэдний дунд хамгийн хурдан шүлэг цээжлэх уралдаан явууллаа. О.Сундуйн “Аав хүү хоёр” шүлгийг хүүхдүүд богино хугацаанд цээжлэж түрүүлсэн хүүхдүүд зохиолчоос номын бэлэг гардан авсан юм. Өрхүүдийг гэр бүлийн цэцгээ арчилхад нь зориулж ХНО-ны захирал Д.Оюунбилэг цэцгийн арчилгааны талаар мэдээлэл хийлээ. Мөн гэр бүлийнхэнд зориулан гэр бүлийн хадгаламж, хүүхдийн хүмүүжлийн талаар мэдээлэл хийж, хүүхэд багачууддаа чанга уншлагыг хийлээ.

2014.04.27 “Эртэч хүүхэд”-4. “Дэлхийн гэр бүлийн өдөр”-т Монголын номын сангийн консерциумын удирдах зөвлөлийн гишүүн Л.Гантулга оролцлоо. Бид гэр бүлийн бүх гишүүдийг үйл ажиллагаанд оролцуулж тэднийг амьдрах ухааны болон өөрийгөө хөгжүүлэхэд сургах зорилготойгоор “Бид бүгдээрээ тогооч” шинэ ногооны амтат салат хийж, “Гэр бүлийн цэцэг”-ээ тарьж, гэр бүлийн модоо хамтран бүтээх сонирхолтой ажлуудыг зохион явууллаа. Мөн аав, ээж, хүүхдүүдийн төлөөллүүд өөрсдийн мөрөөдлийн тухай бусадтайгаа хуваалцсан нь оролцогч гэр бүлүүдийг бие биенээсээ суралцаж, танилцахад дөхөм болсон юм. Энэхүү арга хэмжээнүүд нь гэр бүлийн гишүүдэд цаашид хөтөлбөртөө идэвхитэй оролцох сэдлийг өгч чадлаа.

2014.05.24 “Эртэч хүүхэд”-5. Энэ удаа олон улсын хүүхдийн баярыг угтаж хийж байгаагаараа онцлог байлаа. Бид МЗЭ-ийн шагналт зохиолч Ц.Энхтүвшинг урьж оролцуулсан юм. Зохиолч маань хөтөлбөрт оролцогч гэр бүлүүдэд өөрийн зохиол бүтээлээ танилцуулахаас гадна цаасан урлалын сургалтыг явууллаа. Гэр бүлээрээ бүтээл хийх нь эцэг эх хүүхдүүдэд сонирхолтой байлаа. Мөн үлгэрийн баатрууд хүүхэд багачууддаа баярын бэлгийг нь гардуулсан юм.

2014.7.25 “Эртэч хүүхэд”- 6. Хүүхдийн номын ордон, МЗЭ-ийн дэргэдэх Хүүхдийн зохиолчдын үндэсний төв хамтран "Хөгжилтэй зуслан-Хүүхдийн зохиолч" арга хэмжээг Нарлаг хүүхдийн зусланд зохион явууллаа. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь зусланд амарч буй хүүхэд багачуудыг номтой нөхөрлөх, номонд шимтэн дурлах хүсэл сонирхолыг төрүүлэх, тэдний утга уран зохиолын авьяас билгийг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд оршиж байлаа. МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Б.Нацагдорж, О.Сундуй, Н.Мандал, Л.Мөнхбат нар Хандгайт зуслангийн хүүхэд багачуудтай уулзаж өөрсдийн зохиол бүтээлээ танилцуулж, тявган аялалд хамтдаа явж нэг өдрийг өнгөрүүлсэн юм. МЗЭ-ийн шагналт О.Сундуй хамгийн сүүлд бичсэн шүлгүүдээ уншиж, Н.Мандал шинэхэн бүтээл "Солонгон улсад худалдагдсан нь", Л.Мөнхбат "Амтат мөрөөдөл", "Дүрсгүйчүүлийн сургууль" бүтээлээ танилцуулж, Б. Нацагдорж "Хүүхдүүд инээмсэглэн дуулдаг" шүлгээ уншиж, "Ээжийн бүүвэйтэй хэл" "Харц" дууныхаа тухай дурсамжаа хүүхдүүдтэй хуваалцлаа.

2014.7.29
“Эртэч хүүхэд” - 7. Энэ удаа гэр бүлүүдэд гарсан өөрчлөлтийн талаар ярилцлага зохион байгуулж, Зуны амралтаар болсон хөгжилтэй явдал сэдвээр “Хамгийн сайн онигоочин”-г шалгаруулаа.

2014.8.17 “Эртэч хүүхэд” – 8**.**
"Нэг дэлхий, нэг улс, нэг гэр бүл" уриатайгаар хэрэгжүүлж "Зуны аялал - Зугаатай уншлага" сэдвийн хүрээнд явууллаа. Бид гэр бүлээрээ үүргэвчтэй номын аялалд гарч, хээрийн амтат цай уусан нь хүүхдүүдийн хувьд сонирхолтой байлаа. Энэ өдрийг гэр бүлээрээ номтой нөхөрлөж, хөгжилдөн тоглож, номноос авсан мэдлэгээ найз нөхөд, аав ээжтэйгээ хуваалцаж өнгөрүүлсэн юм. Г.Жамба, Б.Гүнбилэгт нар уншсан номынхоо талаар бусадтайгаа хуваалцаж, Г.Мөнх-Оргил "Янзага" хэмээх цээжилсэн шүлгээ уншиж, Мөнхдэлгэр эгч Мөнхзаяатайгаа номноос сурсан шинэ дуугаа найз нөхөддөө дуулж сонирхуулаа. Мөн аялалд оролцсон бүх өрхийн хүүхдүүд аав ээжүүдтэйгээ олон төрлийн тоглоомуудыг хамтран тоглосон юм. Аялалын төгсгөлд гэр бүлүүд бие биендээ талархалын үгтэй тэврэлт хийж урам хайрласан билээ.

2014.9.28 "Эртэч хүүхэд" – 9. Энэ өдөр өрх бүрийн гэрийн цайны амталгаагаар эхлэсэн юм. Өрхүүд өөр өөрсдийн хийж ирсэн гэрийн цай, амттан, дарсан ногоо, зуушаар бие биенээ дайлсан юм. Мөн эртэч хүүхдүүд үндэсний XVI дахь номын баярт оролцсон сэтгэгдлээ зургаар илэрхийлж аав ээж нартаа тайлбарлаж өгсөн. Номын баярын үеэр хүүхдүүдийн сэтгэлд хамгийн тод үлдсэн нь улаан хивсний баяр байсан нь тэдний зурсан зурагнаас харагдаж байлаа. Тус

хөтөлбөрт UBS телевизийн “Номын ертөнц” нэвтрүүлгийнхэн зочлон “Эртэч хүүхэд” нэвтрүүлгийн бичлэг хийлээ.

2014.10.26 “Эртэч хүүхэд”- 10. Хөтөлбөрийн хүрээнд өрхүүдэд “Алтан намар” ногоо даршлах сургалт хийлээ. Сургалтыг хөтөлбөрт хамрагдаж буй өрхийн гишүүн Тунгалагтуул хийсэн нь хүн бүр өөрсдийн мэддэг зүйлээ бусдад хуваалцах нь чухал гэдгийг харуулсан зүйл болж чадлаа. Гэр бүлийн гишүүдийнхээ дунд ардын уламжлалт тоглоом болох шагайгаар морь уралдаж наадах тэмцээнийг зохион явууллаа.

2014.11.23 “Эртэч хүүхэд-11 Шинэ жилийг угтах хөтөлбөр, 2014 онд хийсэн ажлаа ярилцав.

2014.12.14 “Эртэч хүүхэд -12 “Эртэч хүүхэд” хөтөлбөрийн үр дүнгийн хаалтын үйл ажиллагаа, шинэ жилийн баярын үйл ажиллагаа боллоо. Хөтөлбөрт хамрагдсан гэр бүлүүд өөр өөрсдийн гэр бүлд гарсан өөрчлөлтийн талаар ханын сонингоор илэрхийлж, гэр бүлийн гар урлалын зүйлс, гэр бүлийн цэцгээр үзэсгэлэн гаргалаа. Мөн тус хөтөлбөрт хамрагдсан өрхүүдээс гэр бүлдээ хамгийн их өөрчлөлтийг гаргаж чадсан гэр бүлүүд номтой нөхөрлөгч- оюунлаг, нөхөрсөг, авъяаслаг, бүтээлч, манлайлагчаар шалгарч өргөмжлөл, номын бэлэг гардан авлаа. Энэхүү хөтөлбөрт хамрагдсан өрхийн хүүхэд багачууд өөрсдийн цээжилсэн шүлгээ уншиж уригдаж ирсэн зочиддоо сонирхуулж, “Хүслэн” хамтлагийн охид гэр бүлүүдэд зориулан ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

Хаалтын үйл ажиллагааг UBS телевизийн “Номын ертөнц” нэвтрүүлгийн хамт олон өвлийн өвгөний хамт зочлон телевизийн бичлэг хийж, хүүхдүүдэд бэлэг гардууллаа.

6.Дорно дахины танхимаас шинэлэг ажил зохион байгуулахын үндсэн дээр дорнын гайхамшиг гэгддэг уран бичлэг түүн дотроо монгол уран бичлэгийг үндэсний бичиг соёлоо дээдэлж, монгол бичгээр уран бичиж сурах зорилгоор хуучны уламжлалаар дугуйлан хэлбэрээр сар бүр үнэ төлбөргүй хичээллүүлэхээр болсон юм. Энэхүү саналыг залуу уран бүтээлч, уран бичээч Э.Найдандорж хүлээн авч хамтарч ажиллаж байна. . Дугуйланг 10-р сарын 25, 11-р сарын 29-нд тус тус зохион явуулсан. 3 дахь хичээл 12-р сарын 20-нд орно. Одоогоор 10 оюутан суралцаж байна.

Анхны хичээлд ирсэн оюутнуудад өөрсдийн нэрийг нь уран бичлэгээр бичиж гэнэтийн бэлэг өгч нэгэн сайхан дурсамж үлдээлээ. /2014.11.25./

2 дахь хичээл дээр. /2014.11.29/

6.3.2. Танхимуудад зохиолч уншигчийн уулзалт: 14 удаа болсон.
Боловсрол хөгжил танхимд - 3 удаа
Мөрөөдөл танхимд – 2 удаа
Их мэдэх танхимд - 2 удаа
Герман танхимд -1 удаа
Зөөвөр – 6 удаа

2014.3.19. - Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан Төрийн шагналт Ардын Уран Зохиолч Д. Цоодол, Ш. Дулмаа нартай уншигчдыг уулзууллаа.
- Залуу үеийнхэнд Ардын Уран Зохиолчдыг таниулах зорилгоор зохиолчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.
- Т. Галсангийн "Монгол хүний зүрхний бичээс", Д. Цоодолын "Харамчийнхан" дууль, Ш. Дулмаагийн "Бүсгүй" шүлгийг СУИС-ийн оюутан Бат-Ирээдүй, Цэмбэл, ШУТИС-ийн оюутан Түмэнцэцэг нар уншиж сонирхуулсан.
- "Нүүдэлчний их урлаг" ТББ-ын дуучин Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын гоцлол дуучин СТА Л. Дэжидмаа, Үндэсний хүмүүнлэгийн элч дуучин СТА Содонбаяр нар оролцож Ардын уран зохиолчдын бүтээлээс дуулж сонирхууллаа.

<u>9. Соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулах хүрээнд:</u>

Арга зүйч Л.Батболор: 4 үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

2014.04.02. Олон улсын хүүхдийн номын баярын өдөр. Энэ өдрийг "Дэлхийн үлгэрүүд" сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүлэв.

Тус үйл ажиллагааны хөтөлбөрт оролцох урлагийн номер, жүжигчилсэн тоглолтыг сургуулийн номын санчидтай хамтран зохион байгууллаа.

Авьяаслаг хүүхэд багачууд Андерсений үлгэрээр сэдэвлэн бэлтгэсэн "Гахай маллагч", Орос ардын үлгэр "Манжин", "Хааны шинэ хувцас" зэрэг зохиолоос жүжигчилсэн тоглолтыг авьяаслаг хүүхэд багачууд найз нөхөддөө тоглож сонирхуулсан.

Номын баярын тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажилд оролцохоос гадна үзэгч хүүхдүүд авчрах болон хөтлөгчийн ажил үүргийг гүйцэтгэлээ.

2014.05.01. ***"Яруу сайхан Монгол хэл" хүүхдийн зохиолчдын өгүүллэгийн уран уншлагын анхдугаар уралдаан.***

Хүүхдийн зохиолчдын шилдэг өгүүллэгийг хүүхэд багачуудад таниулах, хүүхдийн уншлагыг удирдаж номтой нөхөрлүүлэх, номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тэдний бүтээлч ажлыг өрнүүлэх, номын сан уран уншлагыг холбох, өгүүллэгийн утга санааг уран тод гаргаж уран сайхан уншихад юуг анхаарах болон дунд

сургуулийн сургалтын хөтөлбөрт орсон зохиолчдын өгүүллэгийг яруу сайхнаар унших, хүүхэд багачуудын ном унших идэвхийг өрнүүлэхэд уралдааны зорилго оршино.
Жил бүр болдог бичиг үсгийн баярыг тохиолдуулан хүүхдийн зохиолчдын өгүүллэгийн уран уншлагын анхдугаар уралдааныг ХНО, МЗЭ-ийн хүүхдийн зохиолын үндэсний төвтэй хамтран зохион байгууллаа. Уралдаанд хүүхдийн зохиолчид өөрсдийн бүтээлийг унших хүүхдүүдээ сонгож оролцов.
Тус уран уншлагын анхдугаар уралдаанд хүүхдийн зохиолчдын 30 өгүүллэгээс хүүхдүүд урнаар уншиж өрсөлдлөө.
"Яруу сайхан Монгол хэл" хүүхдийн зохиолчдын өгүүллэгийг анхдугаар уран уншлагын уралдаанд:

1-р байр – Наранцэцэгийн "1-р ангийн сурагч" өгүүллэг 24-р сургуулийн 3а ангийн сурагч М.Энхжорлоо

2-р байр- Саалуутын "Тогоруухай" өгүүллэг Монгени цогцолбор сургуулийн 4б ангийн сурагч Н.Билгүүн

3-р байр – Д.Нямаагийн "Хөөрхий дөө Дулмаа гуай" өгүүллэг Орхон аймаг лаборатари VIII сургууль 8в ангийн сурагч Г.Өлзийхишиг

Тусгай байр- Доржсүрэнгийн "Чихтэй нар" өгүүллэг Амгалан цогцолбор сургуулийн 10е ангийн сурагч О.Оюун-Эрдэнэ

Тусгай байр- Б.Нацагдоржийн "Зарлал" өгүүллэг "Цоглог энтертайнмент" сургуулийн сурагч Б.Наран-Эрдэнэ нар тус тус шалгарлаа. Уралдааныг уламжлал болгон бичиг үсгийн баяраар зохион байгуулахаар боллоо.
Уралдааныг зохион байгуулах ажиллагааг хариуцан ажиллаж, тайланг нэгтгэн Үндэсний номын сан болон Соёл урлагийн санд e-mail хаягаар явууллаа.
Монгол бичгийн улсын уралдааны нээлтийн үйл ажиллагаанд оролцох урлагийн тоглолтын номерийг ХУД-ийн 18-р ,СХД-ийн 83-р сургуулийн номын санчидтай хамтран оролцуулсан. Мөн уралдаанд оролцож шагналт байранд шалгарсан 7-р ангийн хүүхдүүдийн гарын бэлгийг гардуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

2014.05.31. ***Олон улсын хүүхдийн баярын өдөр***

Олон улсын хүүхдийн баярын өдрийг ХНО-ны "Боловсрол хөгжил" танхимд тэмдэглэн өнгөрүүлэв. Энэхүү өдрийг хамгаас хайрт бяцхан хүүхэд багачуудтайгаа ээж аав эмээ өвөө нь хөөр баяртайгаар хөгжилдлөө. Авьяаслаг бяцхан хүүхдийнхээ дуу бүжгийн тоглолтыг сонирхон үзэж баяр хүргэн "Алтан загасны үлгэр" "Гахайн гурван тоорой" тоглолтоо ээж аав эмээ өвөө нар нь хүүхэддээ тоглож сонирхуулав. Энэхүү баярын өдөр хүүхэд багачуудын инээд хөөр бялхсан сайхан өдөр болж өнгөрлөө. Хүүхдийн баярын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж хөтлөгчийн үүргийг гүйцэтгэсэн.

- 2014.10.26 "Сэтгэлд дотно номууд" уулзалтыг UBS-телевизийн "Номын ертөнц" нэвтрүүлгийн редактор Б.Сувдтай хамтран зохион байгууллаа. Уулзалтаар уншигч хүүхэд залууст номтой нөхөрлөхийн ач тусын талаар болон номын тухай сонирхолтой мэдээллүүдийг өглөө.
- 2014.11.19 Хошин урлагийн "Шинэ үе" продакшны жүжигчин СТА Ундармаатай "Ухаан далай номоос эхтэй" номтой нөхөрлөх аяны хүрээнд "Миний мөрөөдөл биелэнэ" уулзалтыг "Нобелийн шагналтнууд" хүүхдийн номын сантай хамтран зохион байгууллаа. Уулзалтад оролцогч хүүхдүүд сургамжит өгүүллэгээс ярилцлага хийж, зүйр цэцэн үгийн утгыг дэлгэрүүлэн ярилцаж, оньсого таалцаж хүүхэд насаараа аялсан юм.

Мөрөөдөл танхимд: 2 удаа

- 2014.2.27. Хүүхдийн зохиолч Г. Ганболд, Д. Доржсүрэн нартай Зохиолч уншигчийн уулзалт хийж Спортын сургуулийн 4 ангийн сурагчдыг урьж оролцуулав. Уулзалтын үеэр сурагчдын дунд хөгжөөнт тоглоом, асуулт хариултын тэмцээнийг зохион явуулж, сурагчид сонирхсон асуултаа зохиолчдоос асууж, харилцан ярилцлаа.
- 2014.10.20. Спортын сургуулийн Дэжид багштай 4-р ангийн сурагчидтай Хүүхдийн зохиолч Л. Самбуу, Доржсүрэн нар уулзалт хийж сурагчид сонирхсон асуултандаа хариулт авч, 2 зохиолчийн бүтээлийг уран яруу тод уншсан сурагчдыг номыг бэлгээр мялаав.

Их мэдэх танхим: 2 удаа

- 2014.03. 13. Хүүхдийн зохиолч Надмидын Мандалтай хийх уулзалтад 14-р сургуулийн 5-р ангийн 36 сурагч оролцсон.
- Мандал зохиолчийн уран бүтээлийг сурталчилж PPT-ээр хүүхдүүдэд танилцуулсан.
- Зохиолч Надмидын зохиолыг 14 хоног уншуулж, уншсан номын баатраар нь номын хавчуурга хийлгэж номын хавчуургыг ашиглах тухай хэлж, тайлбарлаж өглөө.
- Хүүхдүүд Мандал зохиолчийн зохиол бүтээлийг уран яруу уншиж сонирхуулсан.

2014.11.27. Сонгино хайрхан дүүргийн 67-р сургуулийн 3 “з” анги, 52-р сургуулийн 3 ангийн сурагчдыг О. Сундуйтай уулзууллаа. Уулзалтыг угтаж:

- Сундуй зохиолчийн зохилыг уншуулах, зохиолыг сурталчлах 1 сарын аяныг явуулав.
- Хүүхдүүдээр шүлэг яруу найргаас нь цээжлүүлж,
- “Учиртай бэлэг” номыг уншиж дуусгав.

Уулзалтанд оролцсон хүүхдүүд зохиолчоос асуулт асууж, зохиолчийн уран бүтээлээс уншиж, ярьж өгч сонирхуулав. Мөн хүүхдүүд бэлдэж ирсэн гарын бэлгээ зохиолч Сундуйд бэлэглэв.

Сундуй зохиолчийн уран бүтээлийг PPT танилцуулав.

Уулзалтад 80 гаруй хүүхэд

Хүүхдүүд зохиолчид өөрсдийн бэлгээ бэлгэлэв.

Сундуйгийн зохиол “Халиартай бин” үлгэрээр хийсэн хүүхэлдэйн кино үзүүлэв

Герман танхимд - 1 удаа

2014.05.09. Герман танхимд Ричард Давид Прехтийн “Би хэн бэ? Тийм гэвэл хэдэн би вэ?” номын тухай Др. С.Молор-Эрдэнэтэй уулзалт, “Гүн ухааны аялал - 2 хэлний уншлага” зохион байгуулж 60 гаруй хүн оролцов. Тус уулзалтанд “Би хэн бэ? Тийм гэвэл хэдэн би вэ?” номоор орчуулагч С. Молор-Эрдэнэ, Гёте-Институтийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал ноён Сэбастиан Войч нар герман-монгол хэлээр уншлага хийлээ.
Зөөврийн номын санд – 6 удаа
2014.04.17. Налайх дүүргийн 119-р лаборатори сургууль дээр СТА зохиолч Х.Болор-Эрдэнэ, яруу найрагч Эрдэнэ-Солонго нартай зохиолч уншигчийн уулзалт зохион байгууллаа. “Би бид хоёр”, “Диваажингийн хоригдлууд” түүврүүдийг уншсан хүүхдүүдэд 2 зохиолчоос асуух асуултууд чамгүй их байсан юм.
2014.05.30. Хорих 411-р ангийн 110-р сургуулийн нээлттэй хаалганы өдрөөр МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ишхүү, Сэр-Одын шагналт зохиолч Баттулга, Сэр-Одын шагналт яруу найрагч Минжинсайхан, Цэнд-Аюуш нар оролцож хүүхэд залууст өөрсдийн уран бүтээлийг уншиж, тус сургуулийн номын санд номын бэлэг гардуулсан юм.

2014.7.28-30. 2 удаа Хүүхдийн номын ордон, Хүүхдийн зохиолчдын үндэсний төв хамтран "Нарлаг" зусланд Зохиолч-Уншигчийн уулзалт өдөрлөг зохион байгууллаа. Уулзалтанд хүүхдийн зохиолч Ч.Наранцэцэг, Л.Мөнхбат, зохиолч , яруу найрагч Ц.Энхтүвшин нар оролцож уншигч хүүхэд багачууддаа уран бүтээлээсээ толилууллаа. Мөн зохиолчид зуслангийн номын өргөөг нээж номын бэлгээр мялаасан юм. Уулзалт өдөрлөгийн үеэр ХНО-оос хүүхдүүдийн дунд АХА тэмцээн, "Хэн хамгийн сайн уншигч вэ" зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион явуулж амрагч хүүхдүүд идэвхтэй сайн оролцлоо. "Хэн хамгийн сайн уншигч вэ?" уралдаанд Буд бүлгийн Бүтэнжаргал, Сугар бүлгийн Туул, Бархас бүлгийн Гончигсүрэн, Санчир бүлгийн Анужин, Дэлхий бүлгийн Алтанзул, Ангараг бүлгийн Сарнай нар шалгарлаа.

2014.10.20. Төрийн шагналт, СГЗ хүүхдийн зохиолч Д. Гармаатай “Үгсийн чуулган” зохиолч уншигчийн уулзалтыг Хан-Уул дүүргийн албан бус боловсролын төв, 18-р сургуультай хамтран зохион явууллаа.

2014.10.29 “Нобелийн шагналтнууд” хүүхдийн номын сантай зөөврийн номын сангаар хамтран ажиллах гэрээ хийлээ. Тус номын сангаас зохион байгуулсан “Бид ирээдүйн нобелийн шагналтнуудыг төрүүлсэн” сэдэвт эцэг эхчүүдтэй уулзалт ярилцлаганд оролцлоо. Ярилцлаганд хүний хөгжлийн институтын захирал Алтанцэцэг, Энхзаяа нар оролцож эцэг эхчүүдэд мэдээлэл өглөө.

6.3.3. Номын баяр: Танхимуудад 7 удаа болсон байна.

1. Олон улсын хүүхдийн номын баяр Х.К.Андерсений мэндэлсний 209 жилийн ой.

2014.3.24. Анх Монгол улсад Хүүхдийн номын өдрийг 2004 онд Хүүхдийн зохиолч Ж. Дашдондогтой хамтран зохион байгуулсанаас хойш 11 жил өнгөрчээ. Түүнээс хойш бид жил бүр уламжлал болгон Андерсений төрсөн өдрийн тэмдэглэдэг уламжлалтай болсон. Баярын үеэр Олон орны үлгэрээс нийслэлийн ЕБС-ийн хүүхдүүдийн жүжигчилсэн тоглолт, , Хүүхдийн Номын ордонд байгаа дэлхийн орон орны үлгэрийн номоор “Дэлхийн үлгэр” номын үзэсгэлэн, Хүүхдийн дуу шүлгийн мэндчилгээ, Хүүхдийн зохиолчдын мэндчилгээг явуулсан. Хүүхдийн зохиолч Ш. Энхбаяр, Сундуй, Лхагвасүрэн нар шүлэг уншиж сонирхууллаа.

Монголын Үндэсний телевизийн 2-р суваг хүүхдийн зохиолч Д. Норовтой хамтран бичлэг хийж орон даяар сурталчилсан.

“Боловсрол хөгжил” танхимд 4 удаа болсон:

- 2014.1.11. МЗЭ-ийн гишүүн Хүүхдийн зохиолч Ц.Энхтүвшингийн "Зоосон нүдэт" номын нээлт боллоо.
- 2014.2.10. Монгол Улсын Төрийн шагналт, зохиолч Р.Чойномын өвийг хамгаалах "Өд" сангийн бүтээл "Р.Чойномын нүүрний хэв" ном, "Р.Чойномын гэрээслэл" баримтат кино, "Гэрээслэл" шүлгэн клипний нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажлуудыг БХ танхимын ажилтнууд хамтран зохион байгууллаа.
- 2014.2.6. Яруу найрагч А. Эрдэнэ-Очирын "Жинтэй ном" хандивын номыг хүүхдийн зохиолчдоос 60 ш, ХНО-оос 100 ш номыг тус тус цуглуулах ажлыг зохион байгууллаа.
- 2014.08 сар. Танхимын уншигч хүүхэд залууст зориулан шинэ номын танилцуулгыг МСХ ледир сурагч Мандах, Номин нартай хамтран явууллаа. Тус арга хэмжээн дээр 9-11-р ангийн сурагчид болон ном унших сонирхолтой боловч ямар номыг сонгож уншихаа мэдэхгүй байгаа найз нартаа "ном уншсанаар юунд хүрэх вэ?" "ном унших хэнд хэрэгтэй вэ?" сэдвээр ном унших арга зөвлөгөө өглөө. Мөн хүүхдийн номын ордны картыг 60 хүүхэд нээлгэж үүний үр дүнд сар болгон 7 хоногийн 1 өдрийг ном унших өдөр болгосон байна.

Герман танхимд: 1 удаа

9-р сарын 26-нд Германы нэрт зохиолч Михайл Эндегийн "Момо" ном монгол хэлээр орчуулагдахэвлэгдэн гарсантай холбогдуулан 2 хэлний уншлага, номын танилцуулгын үйл ажиллагааг зохион байгуулж 80-аад хүн оролцов. Тус үйл ажиллагаанд монгол герман жааз хөгжимчид амьд тоглолт үзүүлж, Хүүхдийн ордны болон Герман хэлний сургалттай 18-р сургуулийн сурагчид ая дуугаараа мэндчиллээ. Хүүхдийн зохиолч Ж.Дашдондог нэрт зохиолч Михаэль Эндетэй уулзаж байсан дурсамжаа ярьж, монгол, орос, англи хэлээр өөрийн шүлгээсээ уншив. Гёте-Институтийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Сэбастиан Войч болон "Момо" номын орчуулагч Х.Хулан нар номын хэсгээс герман, монгол хэлээр уншиж сонирхууллаа. Момо нь цаг хугацааны хулгайч нараас алдагдсан цагийг нь хүмүүст эргүүлж авчирсан Момо охины гайхамшигт түүхийг өгүүлсэн зохиол юм.

6.3.4.

Эрдэм шинжилгээний бага хурал Боловсрол хөгжил танхимд 2 удаа болсон.

2014.3.13 нд Самбуугийн Надмидийн 80 насны ойд зориулсан "С.Надмид ба түүний нөхдийн туурвил зүй"эрдэм шинжилгээний бага хурлын удирдамжийг Б. Баярмаа гаргасан.

2014.05.09 С.Надмидын 80 насны ойд зориулсан “С.Надмид ба түүний нөхдийн туурвил зүй” эрдэм шинжилгээний бага хурал боллоо.Олон арван бүтээлээрээ үе үеийнхнийг гайхшруулж явсан нэрт зохиолч Самбуугийн Надмидын бүтээлүүд хийгээд хүүхдийн утга зохиолын талаар эрдэм шинжилгээний бага хурал нь илтгэл, найз нөхдийн дурсамж гэсэн 2 хэсгээс амжилттай болж өндөрлөлөө.Энгүй их авъяастай хэр нь эгэлгүй даруу амьдарч бидний үе үеийнхнийг зохиол бүтээлээрээ хүмүүжүүлж, баярлуулж, гайхшируулж явсан түүний тухай найз нөхөд нь, үзэг нэгт андууд нь, уншигчид нь олон сайхан илтгэл тавьж бас дурсан ярьцгаалаа. Ийнхүү нарны дор Надмид зохиолчийгоо, найзыгаа, багшийгаа, аавыгаа дурсацгаасан юм.
2014.05.09 С.Надмидын 80 насны ойн арга хэмжээний талаар Сансар телевизэд мэдээлэл ярилцлага өгсөн.
Монгол улсын Төрийн шагналт, Хэлбичгийн шинжлэх ухааны доктор, профессор Ш.Гаадамбын мэндэлсний 90 жилийн ойд зориулсан “ХХ зууны монголын уран зохиолын онолын сэтгэлгээний уламжлал шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд зориулсан танхим засав.
6.3.5. Уралдаан тэмцээн, мэтгэлцээн - 4 удаа
2014.1.21-23. Монголын үндэсний баяр цагаан сарын ёс заншилтай холбогдуулан хүүхэд багачуудад уламжлалт арга ухаан мэндлэх хүндлэх ёсыг сурталчлах зорилготойгоор “Монгол бахархал цагаан сар” сэдэвт илтгэх урлаг, яруу найргийн тэмцээнийг нийслэлийн ЕБС-ийн 7-11-р ангийн сурагчдын дунд 2 дахь жилдээ 2 үе шаттайгаар амжилттай зохион явууллаа.
2014.4.19. Германы Эрдмийн Солилцооны Албанаас Герман хэлний мэтгэлцээн зохион байгуулж, 30 гаруй оюутнууд хамрагдлаа.

Мөрөөдөл танхимд:
2014-10-10нд 5-р сургуулийн 5г ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран номын сан, танхимтай танилцаж, танин мэдэхүйн чиглэлээр АХА тэмцээн зохион явуулж сурагч Болороо түрүүлэв.
6.3.6. Чанга уншлага: 12 удаа зохион явуулсан.
Мөрөөдөл танхимд - 2 удаа
4-р сарын 9,10-ны өдрүүдэд “Чихэртэй уншлага”- ыг ” Койка”-ийн ажилтан Ким Мён Хуатай хамтран зохион танхимаар үйлчлүүлж ном уншсан сурагч, багачуудыг чихрээр дайлж 200 орчим сурагчдыг хамруулав.
Зөөвөр 2 удаа

2014.3.3. БГД-ийн 66-р цэцэрлэгийн Баянхүү багштай бага бүлгийн 28 хүүхдэд “Миний бие” номоор танилцуулга, чанга уншлага хийж, зөөврийн 25 номыг хүргэн өгч үйлчиллээ.
“Их мэдэх” танхим: 8 удаа чанга уншлагыг явуулав.
2014.1.29. 21-р сур 3 анги” Алтан загасны үлгэр” ,
2014.2.19. 24-р цэцэрлэг Номын сангийн дүрэм, “Сайн нохой Бөөмбий”
2014.2.27. 42-р цэцэрлэг Номын сангийн дүрэм, “Сайн нохой Бөөмбий”
2014.3.11. 21-р сур 4 б анги О. Сундуйгийн “Зуны нар мөхөөлдсөнд дуртай”
2014.3.15. 14-р сур 5 анги Мандал зохиолчийн уран бүтээлээс
2014. 10.19. 63-р цэцэрлэг “Улаан алчуурт” зохиол
2014. 10.23. 42-р цэцэрлэг “Сайн нохой бөөмбий”
2014. 10.23. 21-р сур 4б анги Түмэнжаргалын “Голын жараахай” зохиолоос чангаар уншиж танилцуулав. Уншсан зохиолын дараа хүүхдүүдээр утгыг нь яриулах, зургийг нь зуруулах ажлыг хийж байлаа.
6.3.7. Клубын уулзалт, ярилцлага: 29 удаа болж 410 хүүхэд залуусыг хамруулсан.
Өрнө дахины танхимд англи, орос хэлний клубын уулзалт Үүнд: Орос хэлний “Берёзка” клуб, “Хөгжлийг инженерчилэгч”, “Crazy Monkes Speaking Club” англи хэлний клубын хүүхдүүд кино ярилцлага, чанга уншлага, Щвейцарийн иргэн Анита щвейцарьт хэрхэн суралцах зөвлөлгөө өгч тэнд сурч төгссөн төгсөгчид, монголд ажиллаж амьдарч байгаа щвейцарийн мэргэжилтнүүдтэй чөлөөт уулзалт ярилцлага хийлээ.
Герман танхимд: 10-р сарын 25-наас Герман хэлний ярианы клуб Бямба гарагт ажиллаж байна.

6.3.8. Өдөрлөг: Яам болон бусад байгууллагатай хамтран 2 удаа, Танхимуудад 6 нийт 8 удаа өдөрлөг зохион явуулсан байна.
6 сарын 08. ССАЖЯ-ны харъяа байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрт зориулан ХНО-ы танхимууд танхимын үйл ажиллагааны танилцуулга, соёлын ажлын тухай самбар гарган байгууллагаа сурталчлав.
6 сарын 30. “Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих” төслийн хүрээнд Номын сангийн үйлчилгээгээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хамтарсан хөтөлбөр өдөрлөгийг Төв аймгийн Зуунмод хотын төв талбайд Хүүхдийн Номын Ордон, Америк монгол судлалын төв, Зуун мод хотын иргэний танхим хамтран зохион явуулав. Өдөрлөгийн үеэр:

- Орон нутгийн болон тус төсөлд хамрагдсан 20 байгуулагуудад англи хэл дээрх 2000 ном хандивлах
- Хүүхдүүдийн дунд “Ном уншиж мөрөөдлөө зурья”
- Зөөврийн Номын сангийн чөлөөт үйлчилгээг үзүүлж ном уншуулав.
- Номтой нөхөрлөхөд эцэг эхийн оролцоо зэрэг ажлуудыг явуулав.

Зургийн уралдаан цэрдээр цардмал зам дээр зурах, харандаагаар цаасан дээр 2 төрлөөр явагдсан. Уралдаанд 43 хүүхэд оролцсон..
Өдөрлөгт ХНО- ы Дарьсүрэн, Баярмаа, Пүрэвбат, Энхчимэг, Бямбасүрэн нар оролцож ХНО- ны тухай, зөөврийн номын сангийн тухай сурталчилгаа хийж, 100 орчим хүнд ном уншуулав.
“Боловсрол хөгжил” танхим: 1 удаа
2014.2.13. Гэгээн хайрын өдөрт зориулсан өдөрлөгөөр 2013 оны “Боловсрол хөгжил” танхимын тэргүүний уншигч МУИС-ийн оюутан Жаргалмаа, Жавзмаа нар нийт уншигч

оюутан залуусын дунд “Гэгээн хайр” сэдэвт сонирхолтой тэмцээн уралдааныг зохион байгуулж өнгөрүүллээ. Мөн хайрын тухай богино хэмжээний кино үзүүлсэн нь оюутан залуусын өдөрлөгт оролцох урмыг сэргээсэн зүйл болж чадсан юм.

“Их мэдэх” танхим: 1 удаа

2014. 09.09. ОУ-ын бичиг үсгийн өдөрт зориулан “Их мэдэх” танхимд АНУ-ын Азийн сан, Америкийн Монгол судлалын төв, ерөнхий боловсролын 24-р сургуулийн сурагчидтай хамтран тэмдэглэлээ. Өдөрлөгийн ажиллагаанд Азийн сангийн ажилтан Цэрэнханд, Оюундэлгэр нар оролцлоо.

- ХНО-ы “Их мэдэх” танхимд бага насны хүүхдүүдэд зориулсан 450 гаруй номыг бэлгэлэв.
- Азийн сангийн ажилтан Оюундэлгэр хүүхдүүдэд англи номыг чангаар уншиж өгөн хүүхдүүдтэй хамтран орчуулж, уншсан номынхоо тухай харилцан ярилцсан.
- Бэлэглэсэн 450 гаруй номноос хүүхдүүд таалагдсан номоо сонгон авч уншаад зургийг нь подволкон дээр зурцгаасан.

Энэ өдөрлөгийн ажиллагаанд 24-р сургуулийн 6-р ангийн 15 сурагч оролцлоо.

Герман танхимд: 1 удаа

4-р сарын 23-нд “Улаан өндөгний баяр” –ыг зохион байгуулан герман хэлний сургалттай 38-р сургуулийн 6-7-р ангийн 30 сурагчид герман хэлний 2 багшийн хамт оролцлоо. Танхимын ажилтнууд ХНО-ны болон герман танхимын үйл ажиллагааг сурагчдад танилцуулж, тус баярын тухай богино хэмжээний кино, баримтат мэдээлэл, өндөг урлан чимэглэх талаар үзүүлэн бэлтгэж телевизээр үзүүллээ. “Hoppelsong - Kinderlied zum Osterfest” улаан өндөгний баярын дууны үгийг хүүхдүүдэд өгч, дууны бичлэгийг үзүүлэн, зааж сургав. Хүүхдүүд өөрийн гараар өндөг будаж чимэглэх, туулай урлах зэрэг улаан өндөгний баяраар хийдэг ёс заншлын үйлийг 5 баг болон гүйцэтгэж, хоорондоо бүтээлээрээ өрсөлдөв. Номын сангаас ялагч багт шоколадан өндөг, оролцогч бүх хүүхдүүдэд өндгөн тоглоом бэлэглэв. Хүүхдүүдээр нуусан өндөгийг олуулах, ном бэлэглэх, хөгжөөнт тоглоом тоглуулах зэрэг сонирхолтой үйл ажиллагааг багш нар нь хөтлөн явууллаа.

Зөөврийн номын сан: 3 удаа

- 2014.11.28 Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хараавы бэрхшээлтэй хүүхдийн 116-р тусгай сургуультай хамтран "Бидний ирээдүй хүүхдээс эхлэлтэй" өдөрлөг зохион явууллаа.
- 2014.12 ."Бидний ирээдүй хүүхдээс эхлэлтэй" өдөрлөгийг хараавы бэрхшээлтэй хүүхдийн 116-р тусгай сургуультай хамтран зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрт зориулан явуулснаараа онцлог болж чадсан юм. Өдөрлөгөөр ангиуд баг болж уралдаан оролцсон юм. Нийт 5 ангийн баг оролцож багийн мэндчилгээ, дүрийн тоглолт, өөрсдийн бүтээсэн том ном шалгаруулах, асуулт хариулт гэсэн сэдвүүдээр уралдааныг дүгнэлээ. Эрхэс ахлагчтай 8а ангийн "Гэрэлт ирээдүй" баг, Ядамдорж ахлагчтай 11а ангийн "Хамтдаа чадна" баг, Билэгжаргал ахлагчтай 10б ангийн "Арга билэг" багууд I, II, III байрыг эзэлж өргөмжлөл номын бэлэг гардан авлаа.
- 2014.06.08 ССАЖЯ-ны нээлттэй өдрийн хүрээнд байгууллагаа сурталчлах нэг өдрийн арга хэмжээнд оролцож, тараах материал тарааж танилцуулга хийж, танхимын танилцуулга зурагт самбар хийж ажилласан.

6.3.9. Зөөврийн номын сангийн соёлын ажлын хүснэгт

Д/Д	Оролцсон байгууллага	Огноо	Оролцсон хүний тоо
1	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 11 өрхийн гишүүд	1 сарын 27	18
2	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 11 өрхийн гишүүд	2 сарын 23	49
3	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	3 сарын 23	31
4	Налайх дүүргийн 119-р лаборатори сургуульд зохиолч уншигчийн уулзалт	4 сарын 17	49
5	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 11 өрхийн гишүүд	4 сарын 27	18
6	Хорих 411-р ангийн нээлттэй хаалганы өдөрт яруу найрагч зохиолчдийн уулзалт өдөрлөг	5 сарын 30	82
7	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 11 өрхийн гишүүд	5 сарын 23	49
8	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	6 сарын 23	31
9	Нарлаг хүүхдийн зуслан	7 сарын 25	190
10	Хандгайт хүүхдийн зуслан	7 сарын 28-30	258
11	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	7 сарын 29	42
12	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	8 сарын 17	39
13	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	9 сарын 28	52
14	18-р сургууль, Хан-Уул дүүргийн албан бус боловсролын төв	10 сарын 20	185
15	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	10 сарын 26	38

16	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	11 сарын 23	50
17	Хараány бэрхшээлтэй хүүхдийн 116-р тусгай сургууль	11 сарын 28	64
18	Сонгинохайрхан дүүргийн 9,10-р хорооны 10 өрхийн гишүүд	12 сарын 14	69
	Нийт	18 удаа	1314

7.Ажилтнуудын мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд
6-р сарын 23 нд “Library update 2014” гишүүд дэмжигчдийн анхдугаар зөвлөгөөнд номын санч Энхчимэг, Бямбасүрэн, Бадамсэд нар сургалтанд суусан.
9-р сарын 20 нд Номын хэрэглээг нэмэгдүүлэх, Олон улсын номын сангуудын туршлагуудаас танилцуулах үйл ажиллагаа хөтөлбөр сургалтанд номын санч Бадамсэд, Пүрэвбат нар суусан.
12 сард номын санч Батцэцэг Олон Улсын “Найрамдал” зусланд аргазүйч С.Тунгалагийн хамт сургалт семинарт суусан.

8.Бусад ажил:
2014.09.12. Байгууллагын их цэвэрлэгээний өдөр болгон номын сангийн бүх өрөө тасалгааг цэвэрлэв. Цэвэрлэгээнд бүх ажилтнууд оролцов.
2014.09.20 Танхимын ажилтнууд Үндэсний XVI дахь номын баярын хүрээнд Чингисийн талбайд болсон арга хэмжээний үзэсгэлэнгийн тавиур зөөж, гар зургийн үзэсгэлэн гаргаж талбай дээр ажилласан. Номын баярын бэлтгэл ажилд бүх номын санчид олролцсон.
10-р сарын 17-нд ХНО-ы танхимуудад шавьжны устгал, “Боловсрол хөгжил“ танхимд болсон арга хэмжээний байр засах, шинэ жилийн чимэглэлээ зүүх зэрэг номын санг хамарсан ажилд бүх номын санчид тухай бүр оролцож байв.

Номын санч Бадамсэд:
Орос уншлагын танхимаас Швейцарь уншлагын танхим руу ном зөөж, номын санч Оюунчимэг, Пүрэвбаттай хамт номыг тавиурт байрлуулсан.
Х.К. Андерсений мэндэлсний 209-н жилийн ой буюу олон улсын хүүхдийн номын баяр арга хэмжээнд оролцон заал танхим зассан.
“Үндэсний бичиг үсгийн баярын бэлтгэл ажилд оролцсон. Улсын уралдааны оролцогчдын мандат тараасан. Боловсрол хөгжил танхимын заал чимэглэсэн.

Мөрөөдөл танхим:
2-р сарын 25 Зохиолч уншигчдын уулзалтанд зориулж 15ш ном 3 зураг, 3-р сарын 11-нд Хүүхдийн зохиолч Мандалын 20 гаруй ном,3-р сарын 19-нд төрийн шагналт зохиолдын 9 ном, Мандалын 20 номыг бүрэн эхээр, 3-р сарын 26 нд номын баярт зориулж 6-р сарын 18нд 45 ш номны нүүр скайнердсан 37ш номын нүүрийг Мөрөөдөл танхимын ажилтан Арьяа скайнардав.
Танхимын ажилтан Бямбасүрэн 3-р сарын 19, 3-р сарын 28, 10-р сарын 23-нд өдрүүдэд БХ танхимын уншигчдад үйлчлэв.

- 3-р сарын 31. Танхимын хэрэгцээний шинэ сандлын бүрээсийг солив.
- 7-р сарын 8. Номын сангийн консерциумын хурлын урилга тараасан.
- 8-р сарын 1. Танхимд их цэвэрлэгээ хийсэн.
- 9-р сарын 18, 23 Зөөврийн хүүхэлдэйн театрын тайзыг хамтран угсарсан.
- 9-р сарын 25нд:”Их мэдэх” танхимд азийн сангаас ирсэн хайрцагтай номнуудыг зөөсөн.
- 10-р сарын 14-нд танхимын цоож түлхүүр эвдэрснийг шинэчлэн нөөцөд 1 хувийг хадгалуулав.

- 10-р сарын 24нд: Хүүхдийн зохиолчдын “Пен” төвийн хурал болов.

Өрнө дахины танхим:

Танхимын ажилтан Д.Оюунчимэг Дэлхийн хүүхдийн номын баяр, Х.К.Андерсаны мэндэлсний 209 жилийн ойд зориулсан үйл ажиллагааны танхим чимэх ажилд оролцсон.
И. Пүрэвбат номын санчдын дунд уламжлал болгон зохион байгуулдаг гар болон сагсан бөмбөгийн тэмцээн, ССАЖЯ-ны сайдын нэрэмжит тэмцээний гар болон сагсан бөмбөгийн тэмцээнд тус тус оролцсон.

Дорно дахины танхим:
2014. 02.02. Хариуцлагатай жижүүр хийв.

Герман танхимд :

- 5-р сард Мод барилгын чадавхийн төвд сонин сэтгүүлийн 3 ширхэг модон тавцан захиалан шинээр хийлгэж, 2 талтай тавиурандаа тогтоолгов.
- Цавуутай формуляр, аудио видео материалын наалтыг Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газарт захиалав.
- 6-р сард Гёте-Институтээс компьютерийн ширээний ар талын цонхонд хулдаасан хөшиг, уншлагын танхимын ширээний дэргэд уртасгагч залгуурыг шаланд бэхлэн хийлгэв.
- 7-р сард танхимын гадна цонхонд байршуулсан мэдээллийн том самбарыг Гёте-Институтийн туслах ажилтны хамт угааж цэвэрлэн, гадаад үзэмжийг нь сайжрууллаа.
- 7-р сард тараах материал хийхэд зориулж Мод барилгын чадавхийн төвөөр тэвштэй модон тавиур захиалгаар хийлгэж танхимын орох хаалганы дэргэд байрлуулсан.
- 8-р сарын 11-нээс 11 сарын 28-нд Гёте-Институтийн герман хэлний курсийн сургалтын цагаар 1-5 дахь өдрүүдэд ажлын дараа танхимыг хариуцан ажилласан.
- 9-р сарын 9-нөөс танхимын ажилтан Г.Буянцэцэг МУИС-ийн герман хэлний 4-р дамжааны оюутан Хулан, Ганчимэг нарын дадлагыг удирдан 1 сарын хугацаанд хийлгэв.
- 11 сарын 20-нд Ханс Зайделийн сангаас “Spiegel”, “Focus” сэтгүүлийн 120 гаруй хуучин дугаарыг хүлээн авч уншигчдад өгч байна.
- Танхимд барилгын засвар хийхтэй холбогдуулан гүйцэтгэгч 3 байгууллагаас үнийн санал авч Гёте-Институтэд явуулсны дагуу “Уудам” компани сонгогдон 11 сарын 29-12 сарын 14-нд танхимд их засвар хийлээ. Танхимыг засварт бэлтгэн ном болон тавилга зөөх, засварын дараа дахин зөөж байрлуулах, бүх номын тоосыг соруулж, цэвэрлэгээ хийх, зул сарын баярын чимэглэлийг хийх зэрэг ажлыг танхимын ажилтнууд гүйцэтгэн 12 сарын 15 наас танхимын үйлчилгээг эхлүүллээ.

Боловсрол хөгжил танхим:
2014.2.18нд Төрийн банкны зээлийн эдийн засагч нар нийт ажилчдад зориулан зээлийн талаар мэдээлэл хийлээ
2014.05.01 Бичиг үсгийн баярын хүрээнд зохион байгуулагдсан Монгол бичгийн улсын уралдааны тэргүүн байрын эздэд шагнал гардуулах үйл ажиллагаанд оролцож ажилласан.
2014.04.30. MNB-2 суваг Соёлын өвийн төвөөс Морин хуурын тухай нэвтрүүлгийн бичлэгийг танхимд хийв.
NTV телевиз Театрын түүхийн талаарх цуврал нэвтрүүлэгийн бичлэгийг танхимд хийв.

Танхимуудад хийгдсэн дотоод ажил:

- Уншигчдын эрэлтэд нийцүүлэн танхимуудын бүтцэд өөрчлөлт хийх саналыг захиргаанд тавьсанаар: 2014 оноос эхлэн Дунд ангийнханд үйлчилдэг Мөрөөдөл, Өрнө дахины номын уншлагын танхимыг 2 ээлжээр 7 хоног тасралтгүй ажилладаг болгов.
- Хятад, Япон номын танхимыг нэгтгэн Дорно дахины уншлагын танхим, Англи орос номын танхимыг нэгтгэн Өрнө дахины танхим болгон бүтцийг нь өөрчиллөө.
- Орос хэл дээрх 3245 ш, англи хэл дээрхи 4853 ш номыг тоолж хүлээлцсэн. 2014 оны 2 сарын 03 өдрөөс эхлэн танхимын үйлчилгээ 2 ээлжээр ажиллаж эхэллээ.
- Англи хэлний шинээр ирсэн 32 номнуудыг хавтаслан, 58 CD-г хувилан уут, ялгагч хийж байрлуулж уншлаганд гаргаж байна.

Дорно дахины уншлагын танхим:

- 2014 оны 1-р сарын 6 - 9 хүртэл япон хэлний ном хүлээн авах тооллого хийж, 1338 ш номоос 1335 ш ном хүлээн авлаа.
- Дорно дахины танхимтай болсонтой холбогдож хамтын ажиллагаатай “KOICA” Олон улсын байгууллагаас солонгос номын бүрдүүлэлт хийж болох саналыг минь байгууллагын захиргаа дэмжсэнээр ном бүрдүүлэгч Ч:Энхтуяа, “KOICA” ийн сайн дурын гишүүн Гэрлээтэй хамтарч эхний ээлжинд хэл шинжлэл, түүх, уран зохиол, орон судлал, байгалийн шинжлэх ухаан, соёл урлагийн шинжлэх ухааны ном захиалсан.
- Танхимд шинээр 3 ш цэцэг тарьсан.
- Дорно дахины танхим болсоноор танхимд зай гаргах номын тавиур нэмж оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Номын санч Т.Бямбасүрэнгээр CD хувилах програм суулгуулж уншигчдад гэрээр болон танхимаар тухай бүрд нь CD хувилж олгож байна.
- Номын баярын арга хэмжээнд зориулан номзүйч С.Тунгалагт танхимаар их уншигдсан номын жагсаалтыг гаргаж өгөв.

Мөрөөдөл танхим:

- Мөрөөдөл танхимын тооллогын ажлыг 1-р сарын 7-ноос 1-р сарын 20-ны хооронд Б.Арьяа, Т.Батцэцэг, С.Тунгалаг нар хийж гүйцэтгэв.
- Фондын 11 000 орчим номыг зохиогчийн үсэг дараалаар байрлуулав.1385 ш сурах бичиг, уран зохиолын номыг тавиураас актанд ялган, компьютерт шивж номын сангийн захиргаанд танилцуулах ажлын бэлтгэл хангав.
- Мөрөөдөл танхимын ажилтнууд 10-р сарын 15, 16 ны өдрүүдэд 57-рсургуулийн 4,6,7, 16- р сургуулийн 4,6,7-р ангийн сурагчдаас номын сантай холбоотой сэдвээр 200 гаруй судалгаа авав.
- Мөрөөдөл танхимын ажилтан Бямбасүрэнгийн хийсэн ажил:
    - 7-р сарын 14-нөөс 8-р сарын 1-ний хооронд Консерциумд болон инженер Сүхбаатар, Консерциумын Гантулгатай хамтран Microsoft –руу программ авах саналыг өгч програм авсан.
    - Баяр ёслол, сургалт семинарын үед, ашиглах техник хэрэгслийг хэрхэн ажиллуулах
    - Компьютер форматлах, Windows Xp –ээр install уншуулах, Restore хийж компьютерын үйл ажиллагааг хэвийн болгох арга, компьютерын удаашралтыг хэрхэн хурдасгах, каталогийн компьютерийн үйл ажиллагааг хэвийн болгох заалгасан, компьютерийн дотоод бүтэцийг заалгасан.
    - 8-р сарын 11. Нийт ажиллагсадын ажлын үнэмлэхийг Хэлтсийн дарга Тунгалагтай хамтран хийсэн

“Койка” Олон Улсын Байгууллагын ажилтан Ким Мён Хуатай хамтран хийсэн ажил:

- Сайн дурын ажилтан Ким Мён Хуа нь 2013-оны 2-р сарын 19-ний өдрөөс эхлэн “Мөрөөдөл “ танхимд ажилласан. Тус танхимд ажиллах хугацаандаа номын сангийн үйлчилгээний бүх ажилд гар бие оролцон ажиллаж байгаа.
- Уншигчдад ном, сонин, сэтгүүлээр үйлчилж, гэрээр ном олгох, хүлээн авах, уншлаганд гарсан номыг тавиурт байрлуулах, шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргах, номын сангаас зохион байгуулсан соёл олон нийтийн ажилд тусласан. Үүнд:
  - Уншигчдад зориулан “Чихэртэй уншлага” номын үзэсгэлэн гаргах, “Алимтай асуулт хариултын тэмцээн” зохиох зэрэг соёлын ажлуудыг хамтран явууллаа.
- Дорно дахины танхимд бүрдүүлсэн 70 ш номын ангиллыг солонгос хэлнээс монгол хэл дээр орчуулсан. DDC ангилалаар ангилсан.
  Номын санч Арьяатай хамтран танхимын акталсан номыг тоолсон.
- МҮНС-ийн Түмэнбаяртай хамтран “Ном хэрхэн үдэх тухай” солонгос номноос монгол хэлрүү орчуулга хийсэн.
- Танхимын номын санч Т.Батцэцэг ажилтан Ким Мён Хуад 2 сарын хугацаанд монгол хэлний анхан шатны хичээл зааж, ажилтан Ким Мён Хуа танхимын номын санч Т.Батцэцэг, бүртгэлийн номын санч Бадамсэд нарт солонгос хэлний анхан шатны хичээл заасан.
- Ажилтан Ким Мён Хуа танхимын хэрэгцээнд зориулан: Агааржуулагч 1 ш, ламинатор 1ш, тоос сорогч 1ш, номын шахагч 50 ш, амны хаалт 200 ш, ажлын бээлий 120 ш, бичгийн шүүгээ 1ш, принтерийн хор 5ш, 3 үйлдэлтэй принтер 2ш авч өгөв.
- Мөрөөдөл танхимын хананд хүүхдийн сонирхол татахуйц наадаг зургийг байршуулсан.

Герман танхим:

- Шинээр ирсэн 134 ш хэлний сургалтын ном болон хуучин 23ш ном, нийт 157ш номыг цавуутай гялгар уутаар хавтаслав.
- Номын дагалт CD болон DVD шинээр их ирсэнтэй холбогдуулан нэмэлт шинэ шоголд аудио видео материалыг байршуулж, 14 ш ялгагч шинээр хийж, ламинатордан байрлуулав.
- Чөлөөт сонголтоор байрлуулсан CD болон DVD-нд зориулж бичгийн цаасаар 94 ш уут хийж, дансны дугаараар шоголд байрлуулав.
- Илүү хувьтай, хэлний хялбар унших ном, CD нийт 48 ш ном АВ материалыг мэдээллийн баазаас хасалт хийн Гёте-Институтийн төлөөлөгчийн газрын хэлний салбарын ажилтан Свеня Кренскид хүлээлгэн өгөв.
- 6-р сард герман хэлний сургалтанд зориулж 45 ном, 31 CD, нийт 76 ш герман хэлний сургалтын шинэ ном АВ материалыг каталогийн болон дансны бүртгэлээс хасч, Гёте-Институтийн төлөөлөгчийн газарт шилжүүлэв.

Монгол фонд:

- Монгол фондын ажилтан Д. Энхчимэг, инженер Б.Сүхбаатартай хамтран вэб сайтад зарим content, category нэмж, бүтцийг нь шинэчлэн өөрчлөв.
- Монгол фондын ажилтнууд фондын чийгшилийн савтай усыг тогтмол сольж, фондын чийгшил, дулаан хэмжилтийг өдөр бүр хянаж бүртгэл хөтөлж байна. Усыг 12 удаа сольсон.
- Зөөврийн номын сангийн үйлчилгээнд байсан 494 ш номыг хүлээн авч байрлуулан, 2010 оноос хойш зөөврийн номын сангийн үйлчилгээнээс дутсан 91 ш номын жагсаалтыг гаргаж зөөврийн номын санч Баярмаад өгсөн.

- 74, 76, 77, 78, 84, 86, 87, 88 ангийн номнуудын байрлалыг шилжүүлсэн. Мөн архивын номыг цэгцэлж янзалсан.

Зөөврийн номын сан:

- 2014.2.27 Зөөврийн номын сангийн 15 төвд ном хүргэлт хийж, төв тус бүртэй энэ оны хамтран ажиллах гэрээг шинэчилж хийв.
- 2014.2.5 Beyond access-д оролцсон үйл ажиллагааны дагуу тайлан мэдээг Монголын номын сангийн консерциумын захирал Гантулгатай хамтран явуулсан.
- 2014.04.16 Азийн сангийн хөтөлбөрийн зохион байгуулагч Цэрэнхандтай хамтран “Эртэч хүүхэд” төслийн материалийг боловсруулж бэлтгэв.
- 2014.06.09 Зөөврийн номын сангийн төвүүдээс номоо татаж, дутуу номын тооцоог гаргав.
- 2014.9.19 Үндэсний XVI дахь номын баяраар иргэдэд танилцуулах “Эртэч хүүхэд” хөтөлбөрийн танилцуулгыг номын санч Энхчимэгтэй хамтран хийлээ.
- Хүүхдийн зуслангуудаар аялах номын жагсаалтыг гаргаж Мөрөөдөл танхимаас 47 ш, Боловсрол хөгжил танхимаас 15 ш номыг татан авч багц бэлтгэсэн. Хичээлийн шинэ жилд зориулан зөөврийн номын сангийн төвүүдэд тараагдах шинэ багцыг Их мэдэх танхимаас номын санч Дарьсүрэнтэй хамтран 314 ширхэг ном, мөрөөдөл танхимаас номын санч Батцэцэгтэй хамтран 200 ширхэг номоор бэлтгэв.

4. Гадаад харилцаа:

Герман танхим:

- Танхимын үйл ажиллагааны 2013 оны дэлгэрэнгүй тайланг 1-р сарын сүүлчээр Сөүл дэх зүүн Азийн бүсийн номын сангийн захирал Андреа Бах, Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Сэбастиан Войч нарт электрон шуудангаар явууллаа.
- Танхимын үйл ажиллагааны талаар Гёте-Институтийн төлөөлөгчийн газартай утсаар болон электрон шуудангаар харилцаж, сард 1 удаа уулзаж ярилцан мэдээлэл солилцож ирлээ.
- Хөгжмийн CD болон CD-Rom-ын жагсаалт, 2013 онд фондоос хасагдсан бүх материалыг кассет, ном, CD, CD-Rom, DVD гэсэн 5 төрлөөр гаргаж, мөн Гёте-Институтийн цахим хуудсанд тавигдах шинэ номын зурагт мэдээлэл, уран сайхны киноны жагсаалт, шинээр захиалах танин мэдэхүйн тоглоомын жагсаалт зэргийг бэлтгэн Гёте-Институтийн төлөөлөгчийн газарт явууллаа.
- 2014 оны 1.2-р улирлын үйлчилгээний статистик мэдээллийг герман тайлбартайгаар тоон үзүүлэлтээр болон графикаар гаргаж Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Сэбастиан Войч-д электрон шуудангаар илгээв.
- 4-р сарын 4-нд Гёте-Институтийн Сөүл дэх зүүн Азийн бүсийн ерөнхий захирал танхимд зочлон, үйл ажиллагаатай танилцлаа.
- Мэргэжлийн номын захиалгын хүрээнд Германд төгсөгчдийн санал хүсэлтийг номын бүрдүүлэлтэнд тусгах талаар Гёте-Институттэй санал солилцож, 7-р сард Монгол-Германы Гүүр ТББ-тай электрон шуудангаар харилцаж, мэдээллийг Гёте-Институтэд өгсөн.

Дорно дахины танхим:

- Тайваний Үндэсний номын сангийн Гадаад солилцооны номын санч шинээр ирсэн ажилтанд өөрийн холбогдох хаяг болон байгууллагын хаяг, шуудангийн хаягийг э-майл-ээр явуулсан.

- Тайваний Үндэсний номын сангаас 819312 төгрөгийн 60ш хүүхдийн уран зохиол, үлгэрийн ном хүлээж авлаа.
- Мөн Дорно дахины танхимтай болсонтой холбогдож хамтын ажиллагаатай “KOICA” Олон улсын байгууллагаас солонгос хэл дээрх номын бүрдүүлэлт хийж болох санал оруулсаныг байгууллагын захиргаа дэмжсэнээр хэл шинжлэл, хүүхдийн сонгодог уран зохиол, түүх, соёл урлаг, хүүхдийн танин мэдэхүйн нийт 63ш /1302770 төгрөгийн/ ном хүлээж аваад байна.

12. Бусад ажлын хүрээнд:

12.1. Хэлтсийн нийт ажилтнууд:

12.2. *Ном бүрдүүлэгч Ч.Энхтуяа:*

- “Интернэт банкны” үйлчилгээний талаар Голомт банкны ажилтнаар сургалт явуулав.

12.3. Ном ангилагч С.Адъяаням:

- Архивын фондын номын ангилал, дансыг шинэчлэх мөн номын давхардлыг арилгах ажлын хэсэгт орж ажиллан 200ш номыг ангилан 140ш номыг дансалж байрлуулан 60 гаруй номыг уг фондонд байх шаардлагагүй гэж үзсэний үндсэн дээр ялгаж авсан байна. Мөн хүүхдийн уран зохиол, аман зохиолын төрлөөр ялгаж байрлуулж цэгцлэх ажлуудыг хийж эхлээд байна.
- Орос номын фондын нэг бүрчилсэн бүртгэлийн үнэ бичигдээгүй буюу дахин үнэлгээнд ороогүй ном ойролцоогоор 100 гаруй байгааг жагсаалт гарган, орос номын фондонд орж ажиллан тавиураас 14ш номыг олж тулгаж үнийг нь олж дансанд бичлээ. Мөн үнэгүй номууд нь ихэвчлэн 1954 оноос өмнөх номууд байгааг олж тогтоон нэрсийг захиргаанд танилцуулсан.
- Орос номын танхимын дансанд алдаатай, буюу үнэгүй байгаа 86ш номын нэрсийн жагсаалтыг гаргаж асуудлыг шийдвэрлүүлэхээр өгсөн.
- Дууссан дансны үнийн дүнг нягтлан бодогчоор бодуулж баталгаажуулсан дансны гарчиг дугааруудыг хэвлэн гаргаж данснуудаа хавтасласан.
- Хуучин данснуудын жагсаалтыг гаргаж, нийт 7ш орос, 7ш монгол номын нийт 14ш дансыг бичиг хэрэгт өгч архивлуулсан.

12.3. Каталогчид:

- Каталогийн хуучин шүүгээг шинээр авсан шүүгээгээр сольж байршуулан, каталогийн бүх картыг шилжүүлэн байрлуулж, сэлгэж хийсэн. Мөн каталогийн бүх шинэ шүүгээнд нүүр хаягыг шинээр сольж, мэдээллийг шинэчлэн гаргаж байршууллаа.

12.4. Каталогч Б.Хажидмаа:

- 5-р сарын 6,7 нд Номын санчдын дунд зохиогдсон спортын арга хэмжээнд оролцсон.
- 5-р сарын 20, 21-нд ССАЖЯамны нэрэмжит спортын арга хэмжээнд оролцсон.

12.5. Каталогч Д.Жавзанпагма:

- Уншигч бүртгэлийн номын санчийг өвчтэй байх 8-р сарын 14-нөөс 9-р сарын 10-ны хооронд уншигчийн үнэмлэх нээх, сунгалт хийх ажлыг давхар гүйцэтгэж, уншигчийн үнэмлэх 217ш-ийг нээсэн.

12.6. Номзүйч С. Тунгалаг:

- Ажлын цахим хавтасыг 13 удаа эмхэлж, цэгцлэн хадгалсан.
- Ажилтнуудын тайлан төлөвлөгөө, зарлал, үзэсгэлэнгийн хаяг зэргийг бэлтгэж нийт 84 хуудас материалыг хэвлэж өгсөн.
- Тайлан төлөвлөгөөг цаг тухайд хүлээлгэн өгч ажилласан.

12.7. Арга зүйч Л.Батболор:

- 2014.06.09 нд Залуучуудын үнэн сонины 90 жилийн ойд зориулсан Монголын залуучууд 5 боть ном гардуулах ёслолын үйл ажиллагаанд оролцсон.
- ССАЖЯ-ны харьяа байгуулагуудын дунд зохион байгуулсан спортын уралдаан тэмцээнд идэвхтэй оролцсон. Моналтинус биеийн тамирын дээд сургуулийн захиргаатай ярилцаж тус тэмцээнд бэлтгэл хийх спорт заалыг байгууллагынхаа ажилтнуудад 3 хоног үнэгүй авсан.
- “Сурагчдын холбоо”-ноос Чингис зочид буудалд зохион байгуулсан Монголын тэргүүний сурагчдын “Алтан дэвтэр” ном гардуулах ёслолын ажиллагаанд ном зүйч С.Тунгалагийн хамт оролцсон.
- 2013 оны СУ-3, 5, 15, 10-ны номын сангийн үйл ажиллагааны судалгааг үндэсний номын сангийн мэргэжилтэнд e-mail хаягаар явууллаа.
- Захиралд 2005-2013 онуудад зохион байгуулсан сургалтыг нэгтгэж өгөв.

12.8. Компьютерийн инженер Б.Сүхбаатар:

- Их мэдэх танхимын цахилгаан халаалтын автомат удирдлагыг 3 удаа шинэчлэв.
- 2014 онд явагдсан үйл ажиллагаанд 10 удаа техник хэрэгсэл бэлтгэж дуу хөгжмийн тохируулгын ажлыг гүйцэтгэв. Олон улсын хүүхдийн номын баяр ба Хүүхдийн номын баярын үйл ажиллагаанд оролцож ажиллав. Тус ажлыг хэрхэн гүйцэтгэхийг номын санч Т.Бямбасүрэнд сургаж энэ ажлыг бие даан гүйцэтгэх чадвартай болгосон.
- ССАЖЯ-ын яамны мэргэжилтэнд 2 удаа шинэ төлөвлөлтийн зураг бүхий баримт үйлдэж имэйлээр явуулав.
- ХНО-ны сурталчилгааны 2 төрлийн богино хэмжээний кино үзүүлэнг Windows Movie Maker програм ашиглан боловсруулсан.
- ХНО-ны үндсэн хөрөнгөөс номыг хасах болон нэмэх коммисын хуралд оролцов.
- Номын санчдын сургалтын хичээлээс админ ажилтан Д.Энхчимэгт зааж зааварлаж өгөв.
- Номын санч Т.Бямбасүрэнд ХНО-ны техник болон програм хангамжийн ерөнхий танилцуулгыг хийж, Nero програмын суулгалт ба ашиглалтыг заасан.
- Номын сангуудын консерциумын өрөөнд интернэт холболт хийхэд шаардлагатай свитч, сүлжээний кабель зэргээр хангаж өгч хэрхэн хийхийг номын санч Т.Бямбасүрэнд зааж хийлгүүлсэн.
- Захирлын явуулах сургалтанд зориулан “Номын сангийн маркетинг” үзүүлэнг хийв.

4. Аж ахуйн ажлын хүрээнд:

- Бэлгээр болон хандиваар орж ирсэн Азийн сангаас 1531700 төгрөгний 144 ширхэг ном , 10 аудио визуал материал**,** ААНБайгууллага хувь хүнээс 372 ширхэг 4574397 төгрөгний ном , Тайваниас 60 ширхэг 819320 төгрөгийн ном тус тус шивж үндсэн хөрөнгөндөө тусгасан.
- ССАЖЯамнаас тус бүр нь 562000 төгрөгний үнэ бүхий нийт 5058000 төгрөгний каталогийн 9 ширхэг шүүгээ хөрөнгө оруулалтаар өгснийг
  үндсэн хөрөнгөндөө бүртгэсэн.
- Гёте Институтийн хөрөнгө оруулалтаар Герман уншлагын танхимд их засварын ажил хийж гүйцэтгэлээ. Мөн 7-р сард тараах материал хийхэд зориулж Мод барилгын чадавхийн төвөөр тэвштэй модон тавиур захиалгаар хийлгэсэн. Суудлын бүрээсийг иж бүрэн шинэчлэв.
- Компьютер 2, Чихэвч-15ш авч танхимуудад, Ламинатор-2ш авч каталог, үнэмлэх нээлтэнд, Эрэгтэй 00-ийн бохирын хоолой, Жижүүрийн өдрийн гэрлийн суурь,

сандалын бүрээс хүрээс хүлээн авч, Байгууллагын төслийн зураг угаалсан зэрэг зүйлүүдийг худалдан авч зохих танхимуудад хүлээлгэн өгч засварлуулсан.

- 1-р давхарын 00, капитал засвар оруулах талаар СТӨ-ний аж ахуйн дарга болон бусад холбогдох хүмүүстэй **5** удаа очиж уулзан танхимуудыг үзүүлж жижиг засвар үйлчилгээг хийлгэж, утсаар **39** удаа ярьсан.
- СТӨ-ний дулааны инженер болон цахилгааны инженертэй холбоо барин тухай бүрд гарсан гэмтлүүдыг дуудаж үзүүлсэн, эрэгтэй 00-ийн бохирын 6 суултуурын помф, өдрийн гэрлийн суурийг солиулан, хаалганд цоож авч хийлгэсэн, нярав, ня-бо-ын өрөөнд хөшиг тогтоогч, 2 ширхэг оффис өлгүүр авч санхүү, катологийн өрөөнд, үйлчлэгч нарт индүү тус тусыг авч өгсөн.
- Ажлын байрны зохион байгуулалтыг өөрчилж, няравын өрөө, орос номын уншлагын танхим, катологч нарын өрөө, инженерийн өрөө, агуулах зэрэг өрөө танхимын ном, эд хогшлыг зөөж байрлуулсан. Сургалтын өрөөнөөс эд хогшлийг 3 удаа зөөж, агуулах 1-д байрлуулсан. Каталогийн шүүгээг шинээр сольж, 1-р давхарт байрлуулж, хуучин шүүгээг доод агуулахад зөөсөн. А. Оюунгэрэл, Б. Энхзул нар каталогийн картыг шүлжүүл байрлуулахад 2 өдөр тусалсан.
- Нярав солигдох явцад няравын тооллого, бичиг хэрэг болон санхүүгийн архивын тооллого хийн баримтыг 3 хувь хийн ажлыг нь хүлээлцсэн. Мөн жолооч солигдохтой холбогдуулан коммисын гишүүдтэй фургон автомашин болон сэлбэгийг тоолон хүлээн авч, машины явалт, дуугаралтыг шалгаж, хотын захаар явж үзсэн. Тооллогын протоколыг хөтлөж, түлхүүрийг байгууллагад хүлээлгэн өгсөн. Тооллого хийх явцад ямар нэгэн зөрчилгүй, дутагдсан зүйл байгаагүй.
- 2014 оны соёлын төвийн болон өөрийн байгууллагын эд аж ахуйн тооллогоор явж, эд аж ахуйн картыг бичиж, хяналт тавин ажилласан.
- **Харуулын ажилтнууд** 2014 онд **96** удаа гарч нийт **2304** цагийн үүрэг гүйцэтгэн, **21029+** хуудсыг уншигчдад олгон, **234 280** төгрөгийн орлогыг цаг тухайд нь тушааж ажилласан. Мөн уншигчийн үнэмлэх олгож байна. Ажил хүлээлцэх бүрдээ рапорт тогтмол хөтөлж ажилласан. Гадна талбайн цэвэрлэгээгээ тогтмол хийж, загасны усыг улиралд 1 удаа сольж цэвэрлэж байна.
- Эвдэрсэн 4 ширээг засаж, Боловсрол хөгжил танхимд хүлээлгэн өгч, 3-р давхарын коридорын эд зүйлсийг зөөж доод агуулахад хийн цэвэрлэгээ хийсэн.
- **Хувцас хадгалагч нар** 2014 онд **26 800** уншигч үйлчлүүлэгчдийн хувцас эд зүйлсийг алдаж үрэгдүүлэхгүй үйлчилсэн. Мөн уншигчдыг хувийн номтой оруулахгүй байх талаар шаардлага тавьж ажилласан. Үйлчлэгчийг ажиллахгүй үеэр нь 1-р давхарын 00-ыг цэвэрлэж байсан.
- Мөрөөдөл, Дорно дахины уншлагын танхим, Өрнө дахины уншлагын танхим, Их мэдэх танхимуудын номын тоосыг арчиж, цэвэрлэсэн байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн нийтийн номын сан-Мэдээллийн төв нь аймгийн нийт иргэдийг мэдээлэлээр хангах, соёлын үнэт зүйл ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, дэлхий нийтийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн технологитой “Олон нийтийн мэдээллийн төв”-ийг бий болгож орчин үеийн үйлчилгээг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэн хүн амын ном, хэвлэл, мэдээллийн хангамжийг сайжруулахыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

1.Уншлага үйлчилгээний мэдээлэл сурталчилгааны ажлууд

Хүүхдийн номын ордны шинэ барилга ашиглалтанд орж, уншигчдын мэдээллийн эрэлт шаардлагад нийцүүлэн үйлчилгээний 4 төрөлжсөн танхимаар уншлага үйлчилгээг зохион байгуулж ирлээ.

Төрөлжсөн танхимаар үйлчлүүлсэн байдал /2014 оны байдлаар/



Дээрхи танхимуудын үйл ажиллагаа тогтмолжиж ирсэнээр уншигчдын тоо өсөж ном олголтын эрэлт хэрэгцээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь номын сангийн үйлчилгээний хүрээ тэлж уншигчдын ном унших хүсэл сонирхол ихсэж байгааг илэрхиилж байна. 2014 оны уншигч ном олголт, ирэгсдийн дүн өмнөх онуудтай харьцуулахад өссөн харагдаж байна. Мөн Зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 8 байгууллагын 160 ирэгсэдэд 480 ном олгож үйлчиллээ. Уншлагын танхимаар:

Нийтийн уншлагын танхимаар 350 уншигч шинээр бүртгэж, 7100 ирэгсэдэд 21300 ном, тогтмол хэвлэлээр үйлчилсэн.

Хүүхдийн уншлагын танхимаар 288 уншигч шинээр бүртгэж, 10122 ирэгсэдэд 30366 номоор үйлчиллээ. Өмнөх онуудтай уншлага үйлчилгээний явцыг харьцуулан үзэхэд дараах дүгнэлт гарч байна.

Нийтийн номын сангийн уншигч, ирэгсэд, ном олголт

/2012-2014 он/



“Их мэдэх” танхим

Тус танхим нь сургуулийн өмнөх 3-6 насны хүүхдүүдийн нас, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогт тохирсон зурагт номууд, үлгэрийн болон хүүхдийн кино үзэх телевиз, тоглоом наадгай, зориулалтын ширээ сандал, эрvvл ахуйн шаардлага хангасан тохилог танхимаар үйлчилдэг. 2014 оны байдлаар зөвхөн “Их мэдэх” танхимаар цэцэрлэгийн бэлтгэл, ахлах бүлгийн 3-6 насны 1283 хүүхэд багш, эцэг эх, асран хамгаалагч нарт үлгэр, аман зохиол, танин мэдэхүйн чиглэлийн 5132 номоор vйлчлvvлжээ. Цаашид энэ тоо буурахгvй, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

" Их Мэдэх " танхим
2014 оны 4-р сарын 25

"Их мэдэх" танхимаар:
Цэцэрлэгийн бэлтгэл, ахлах бүлгийн 3-6 насны 1283 хүүхэд, тэдний эцэг эх, багш, асран хамгаалагч нарт үлгэр, аман зохиол,танин мэдэхүйн чиглэлийн 5132 номоор үйлчиллээ.

2.Фондын баяжилт, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт

2013 îíä çàõèàëñàí òîãòìîë õýâëýëèéг ¿äýæ õààâòàñëàí ñîíèí ñýòã¿¿ëèéí äàíñàíä бүртгэн ¿íäñýí ôîíäîä àâëàà. Àæèëëàãàíäûí àæèë ä¿ãíýõ ¿ç¿¿ëýëò, ¿ð ä¿íãèéí ãýðýýíä òóñãàãàñàíû äàãóó íèéò óðàãääàæ ãýì òñýí 3200 øèðõýãíîìîíä ñýëáýí çàñàëò õèéæ óíøëàãà ¿éë÷èëãýýíä àøèãëàæ áàéíà. Шинээр авсан номуудад техник ажиллагааг хийн дансанд авч электрон католог оруулан уншигчдын хүртээл болголоо. Аймгийн нийтийн номын сангийн сан хөмрөгийг 564 ширхэг 9,761,640 төгрөгийн номоор, соёлын төвүүдийн 18 номын санд 1070 ширхэг 24,399,604 төгрөгийн номоор фондûí áàÿæèëò õèéñýí. Хүүхдийн номын ордонд гàë, óòàà, õóëãàéãààñ õàì ãààëàãäñàí äîõèîëëûí ñècòåì, аваарын гэрэл тавьж, камержуулсан.

Номын фондын баяжилт / Аймгийн нийтийн номын сан 2012-2014 он

**тоо ширхэг,
мөнгөндүнгээр/**



Номын сангийн фондын баяжилтын тоо жилд өсөж байгаа нь хэрэглэгчдэд чанартай мэдээ мэдээлэлийн хүргэхэд асар их ач холбогдол өгч байна. Аймгийн нийтийн номын сангийн сан хөмрөгийн баяжилтыг хиихээс гадна сумдын номын сангуудад хандив тусламжаар ирсэн номнуудыг хувиарлан тарааж өгч сан хөмрөгийн баяжилтыг хийсэн.

Сумдын номын сангийн фондын баяжилт
/2012-2014 он тоо ширхэг, мөнгөн дүнгээр/



Сумдын номын сангийн сан хөмрөгийн баяжилтын сүүлийн жилүүдэд тогтмол баяжуулж байгаа нь хөдөө орон нутагт ном хэвлэл хүргэх ажил ерөнхийдөө тогтмолжиж байгаа нь харагдаж байна.

3. Барилга, Хөрөнгө оруулалт тавилга тоног төхөөрөмж

Аймгийн нийтийн номын сангийн барилга ГХХБГ-н дүгнэлтээр 90%-ийн гүйцэтгэлтэй ашиглалтанд ороогүй байгаа ба ашиглалтанд оруулж өгөх хүсэлтийг Аймгийн Засаг дарга, ГХБХГ-т хүргүүлсэн. Хүүхдийн номын санг ашиглалтанд оруулан тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж үйлчилгээг хүргэж байна. Нийтийн номын санд ширээ, сандал, тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор өөрийн санхүүгийн эх үүсвэрээр 9,400,000 төгрөгийг Аймгийн Засаг даргын захирамжаар, СУХСанд бичиж явуулсан төслөөс 9,208,000 төгрөгийн, ССАЖГ-с 14,637,480 мянган төгрөгийн тавилга тоног төхөөрөмжийг аван нийтийн номын санг ашиглалтанд ороход тавилга тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Номын сангийн үйлчилгээнд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх номын сангуудын сан хөмрөгийг электрон каталогт шилжүүлэх, цахим номын сангийн үйлчилгээг эхлүүлэõўä соронзон хаалга, ялтас, болон бусад шаардлагатай òîíîã òºõººðºì æүүдээр хангаж чөлөөт сонголтын үйлчилгээг íèéòèéí íîìûí ñàíä зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

А.Хөрөнгө оруулалт тавилга тоног төхөөрөмж
/2012-2014 он нийтийн номын сан/
/Мян.төг/



Б.Сумдын номын сангуудын хөрөнгө оруулалт / 2012-2013 он/



4.Соёл олон түмний болон мэдээлэл сурталчилгааны ажил

Уншигчдын чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх, шинэ мэдлэг мэдээлэл олгох, түүх, соёл, өв уламжлалаа танин мэдэх, сурталчилан таниулах зорилгоор соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж ажиллалаа. Нийт давтагдсан тоогоор 25 удаа номын үзэсгэлэн 10 гаруй удаа Соёл олон түмний ажил зохион байгуулан явууллаа. Үүнд:

“Номын ертөнц” нэвтрүүлэг 2014. 01.15., 2014.02.01. “Тамир” телевизтэй хамтран “Номын ертөнц” нэвтрүүлгийг *Их мэдэх танхим*-д цэцэрлэгийн 3-6 насны хүүхдүүдийг оролцуулан 2 удаа бэлтгэн явууллаа.

“Эх түүх-Бидний бахархал” уралдаан 2014.03.14. “Ном” хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэбулган сумын III сургуулийн номын сантай хамтран сурагчдын бүтээлчээр ном унших чадварыг хөгжүүлэх, Чингис хааны түүхийг судлах, багаар ажиллах чадварт суралцуулах зорилгоор 8 дугаар ангийн сурагчдын дунд “Чингис хаан” 20 цуврал комикс номоор гар зураг, шүлэг, эсээ, зохион бичлэг, бяцхан ном, ханын сонин, дүрийн тоглолтын уралдааныг зохион байгуулж дүгнэлээ. Тус уралдаанд 8 дугаар ангийн 5 бүлгийн 125 сурагч хамрагдлаа.

Танин мэдэхүйн АХА тэмцээн. 2014.04.16. Дэлхийн үлгэрийн хаан Даниулсын их зохиолч Ханс Кристиан Андерсений мэндэлсэн өдөр 4 дүгээр сарын 2-ныг дэлхий дахинаа олон улсын “Хүүхдийн номын баярын өдөр” болгон тэмдэглэхтэй холбогдуулан сурагчдыг номтой нөхөрлүүлэх, утга, уран зохиолын мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх, тэдний оюун ухааны чадвар, сэтгэлгээний хурдыг сорих зорилгоор Эрдэнэбулган сумын ЕБС-иудын ахлах бүлгийн сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг 2014 оны 04-р сарын 16-ны өдрийн 15.00 цагт нийтийн уншлагын танхимд зохион байгууллаа. Тэмцээнд 35 хүүхэд хамрагдаж, 1,2,3-р байр эзэлсэн сурагчдыг дурсамж, номоор урамшууллаа.

8-р Цэцэрлэг "Номын Ертөнц " Үзэсгэлэн
2014 оны 4-р сарын 25

" Номын ертөнц* үзэсгэлэн " 2014.04.25. "Ном " хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрдэнэбулган сумын 8-р цэцэрлэгтэй хамтран багш, эцэг эх, хүүхдийн хамтын бүтээлээр үзэсгэлэн гаргаж, хүүхдийн зохиолч С. Бараанасан, залуу яруу найрагч Наранбаатарыг урьж зохиолч-уншигчдийн уулзалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр тус цэцэрлэгийн бэлтгэл, ахлах, дунд, бага бүлгийн хүүхдүүдийн урлагийн тоглолт боллоо. Мөн *Номын ертөнц* уралдаан зарласныг дүгнэж 1,2,3 –р байр эзлүүлэн өргөмжлөл, медаль, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. Тус арга хэмжээнд нийт 120 хүүхэд,120 гаруй эцэг эхчүүд , 25 багш ажиллагсад нийт 265 хүн хамрагдлаа.

“Үндэсний бичиг үсгийн баяр”
2014.05.12-13.

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, “Монгол бичиг” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд улс орон даяар жил бүрийн 5-р сарын эхний долоо хоногийн ням гаригт “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тэмдэглэдэг уламжлалын дагуу зургаа дахь жилдээ зохиогдож буй Үндэсний бичиг үсгийн баярыг энэ жил МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор Архангай аймгийн ЗДТГ, Бичиг соёл боловсролын төв, аймгийн нийтийн номын сан хамтран “Олон улсын уран бичлэг” нэрийн доор зохион байгууллаа. Монгол бичгийн гайхамшгийг харуулсан уран бичлэгийн үзэсгэлэнгийн үеэр гурван орны уран бүтээлчдийн хамтарсан уран бичлэгийн үзүүлбэр арга хэмжээ зохиогдож, мөн “Бичиг соёл боловсролын төв”-ийнхөн иргэдэд монгол бичгээр нэрийг нь зориулалтын цаасан дээр буулгаж өгөх үйлчилгээг үзүүллээ.

05-р сарын 12-13-ны өдрүүдэд уламжлал болгон зохиогддог “Түргэн уншлага”, “Хичээнгүй бичигтэн”, “Архангайн сайхан бичигтэн” бүтээлийн уралдааныг ЕБС-ийн сурагчид, их дээд сургуулийн оюутнууд, насанд хүрэгчдийн дунд зохион байгууллаа. “Түргэн уншлага”-ын уралдаанд 125 хүүхэд, 26 оюутан болон насанд хүрэгчид, “Хичээнгүй бичигтэн” шалгаруулах уралдаанд ЕБС-ийн дунд ахлах бүлгийн 108 сурагч, 14 насанд хүрэгчид, зөвхөн насанд хүрэгчдийн дунд зохион байгуулсан “Архангайн сайхан бичигтэн” бүтээлийн уралдаанд 10 оролцогч бүтээлээр оролцлоо.

Үндэсний " БИЧИГ ҮСГИЙН БАЯР 2014"
2014 оны 5-р сарын 12-13

"Үндэсний бичиг үсгийн баяр" 2014.05.12-13. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, "Монгол бичиг" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд улс орон даяр жил бүрийн 5-р сарын эхний долоо хоногийн ням гаригт "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тэмдэглэдэг уламжлалын дагуу зургаа дахь жилдээ зохиогдож буй Үндэсний бичиг үсгийн баярыг энэ жил МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор Архангай аймгийн ЗДТГ, Бичиг соёл боловсролын төв, аймгийн Нийтийн номын сан хамтран *Олон улсын уран бичлэг* нэрийн дор 2014 оны 05-р сарын 12, 13-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Тус үзэсгэлэнд "Бичиг соёл боловсролын төв"-ийн тэргүүн Д. Ганбаатар,Ерөнхийлөгчийн тамгын газрын референт Г. Баттогтох, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Монгол уран бичлэгчдийн нийгэмлэгийн тэргүүн Б. Оргил, ОХУ-ын Буриад улсын "Очир зам"сэтгүүлийн эрхлэгч Дамбаева Маргарита, нарын тэргүүтэй 30-аад хүний бүрэлдэхүүнтэй баг ирж оролцлоо.

" Ном Гардуулах " ёслолын ажиллагааны нээлт 2014 оны 6-р сарын 29

БНХАУ-ын ӨМӨЗО-ны соёлын өдрүүд Архангай аймагт
2014.06.28-30.

Монгол улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой Монгол, Хятадын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд Архангай аймагт зохиогдсон ӨМӨЗО-ны соёлын өдрүүдийн арга хэмжээний хүрээнд *Ном бэлэглэх ёслолын ажиллагааны нээлт*-ийг 2014 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 11.30-12.30 цагт аймгийн Нийтийн номын сан дээр зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны төвийн үндэстний хэвлэлийн хорооны монгол хэлний редакторын газрын дарга Вань Ши, Ляонин мужийн үндэсний хэвлэлийн хорооны монгол хэлний редакторын газрын дарга Бао Мандал, Өвөр монголын хэвлэл мэдээлэл хэвлэлийн хороод радио телевизийн газрын Өвөр монголын төрийн монгол хэвлэл удирдах төвийн захирал Өлзийтогтох,

Өвөр монголын хэвлэл мэдээлэл хэвлэлийн хороод радио телевизийн газрын хэвлэл мэдээлэл сонин сэтгүүлийн газрын дарга Ша Ли, Хэвлэлийн группын тараалтын төвийн дарга Мөнх, Өвөр монголын боловсролын хэвлэлийн хорооны дэд захирал Сийлэнхуар, Өвөр монголын ардын хэвлэлийн хорооны дэд ерөнхий редактор Гүй Рүн, Өвөр монголын үндэстний хүүхэд залуучуудын сэтгүүлийн эрхлэгч, ерөнхий редактор Наранцогт,

.

Монгол бичгийн уран бичлэгийн сургалт
2014.06.30-07.07

Монгол бичгийн уран бичлэгийн сургалт
2014.06.30-07.07.

Бичиг соёл боловсролын төв, аймгийн Боловсролын газартай хамтран 8 хоногийн 64 цагийн монгол бичгийн уран бичлэгийн сургалтийг Нийтийн номын сан дээр зохион явууллаа. Тус сургалтийг монгол бичгийг бийрээр бичих, компьютерээр бичих, төмөр үзгээр бичих, түүнчлэн эвхмэл бичиг, монгол бичгийн хэрэглээний программууд зэрэг агуулгын хүрээнд Бичиг соёл боловсролын төвийн тэргүүн Ганбаатар удирдан зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан монгол хэл, уран зохиолын 20 багшид тус төвөөс гэрчилгээ олгов.

“Номын баяр”
2014.10.27.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны “Номын баяр” тэмдэглэх тухай 158 дугаар зарлиг, МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Номын баяр-2014” арга хэмжээний нээлтийг 10 дугаар сарын 27-ны өдөр Г. Дэмидийн талбайд зохион байгууллаа.

Нээлтийн арга хэмжээний хүрээнд Эрдэнэбулган сумын ЕБС-иудын сурагчдын урлагийн тоглолт, “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт, ЕБС-иудын дунд, ахлах бүлгийн 12 сурагчийг “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн” шагналаар шагнаж урамшууллаа. Г.Дэмидийн талбайд “Номын хандив”-ын хайрцаг аялуулж, шинэ номын үзэсгэлэн гарган, номын худалдаа зохион байгууллаа. Энэхүү нээлтийн арга хэмжээнд 300 хүн хамрагдсан. “Номын баяр-2014” арга хэмжээний хүрээнд “Амжилтын төлөө уншицгаая” уриатай “Нэг анги-Нэг ном” 2 сарын аяныг 10 дугаар сарын 10-аас 12-р сарын 10 хүртэл зарлан, Нийтийн номын сангийн дэргэд “Ном-Эрдэнэ” клубыг нээн ажиллуулж эхлээд байна.

“ НОМЫН БАЯРЫН ӨДӨР “
Г.Дэмид Жанжины талбай
2014.10.27

МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны “Номын баяр” тэмдэглэх тухай 158 дугаар зарлиг, МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, унших хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, номыг хайрлах сэтгэлгээнд сургах, номоор дамжуулан амьдралын арга ухааныг олж авахад туслах, унших чадварыг сайжруулах, номын ач холбогдлыг ойлгуулах зорилгоор “Номын баяр-2014” арга хэмжээний нээлтийг 10 дугаар сарын 27-ны өдөр Г. Дэмидийн талбайд зохион байгууллаа.

Нээлтийн арга хэмжээний хүрээнд Эрдэнэбулган сумын ЕБС-иудын сурагчдын урлагийн тоглолт, “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтууд 8 дунд, ахлах бүлгийн 12 сурагчийг “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн” шагналаар шагнаж урамшууллаа.

"Номын баяр-2014"

"Амжилтын төлөө уншицгаая"

2 сарын аяны хүрээнд "Номын баяр-2014" номын баярын арга хэмжээг хөдөөгийн алслагдсан сумдын иргэдийг хамруулах зорилгоор Чулуут, Өндөр-Улаан суманд 2014 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Номын баярын арга хэмжээний хүрээнд сурагчдын урлагийн тоглолт, "Зохиолын баатрууд амилсан нь" дүрийн тоглолтууд, "Ном" хөтөлбөрийн хүрээнд хийсэн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, сумын номын сангийн номын үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

Энэ үеэр аймгийн Нийтийн номын сангаас хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан шинэ номын үзэсгэлэн, шинэ номын худалдааг зохион байгуулж, алслагдмал сумдын иргэдэд ном, мэдээллийн үйлчилгээг хүргэн ажиллаа.

Тус арга хэмжээнд сумдын удирдлага, төрийн албан хаагчид, багш сурагчид, эцэг эхийн төлөөлөл, иргэд оролцсон нийт 750 хүн хамрагдлаа.

Уншигчдын шинэ жил

"Номын баяр-2014" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан " Уншигчийн шинэ жил"-ийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга Ч. Мөнхбат, аймгийн Засаг даргын орлогч М. Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн Хөгжлийн Хэлтсийн дарга Ш.Нямдаваа, аймгийн Боловсролын газрын дарга Амгаланбаатар оролцож хүүхэд багачуудад шагнал гардуулсан ба аяны хүрээнд сурагчдын дунд зохион байгуулсан Дүрийн тоглолтонд Тэргүүн байр эзэлсэн Ирвэс лицей сургуулийн 5а ангийн хамт олныг бэлтгэсэн монгол ардын үлгэр "Бэтгэлжин бор шувуу" дүрийн тоглолт, Дунд бүлгийн сурагчдын Дүрийн тоглолтонд Тэргүүн байр эзэлсэн Хүмүүн 1-р сургуулийн Эрдэнэцэцэг багштай 6а ангийн сурагчдын дүрийн тоглолтууд болон аймгийн хүүхэд багачууд ая дууны мэндчилгээ дэвшүүллээ

Бэтгэлжин бор шувуу

Номын үзэсгэлэн-мэдээлэл сурталчилах ажил

Тэмдэглэлт үйл явдал, уншигчдын мэдээллийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг сард 2 удаа, жилдээ 25 нэрийн үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчиллаа. "Номын баяр -2014" арга хэмжээний хүрээнд уншигчдын санал хүсэлтийг үндэслэн "Номын худалдааны цэг " байгуулан ажиллаж байна.

5. Бусад ажлууд
Компьютерийн сургалт

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд Эрдэнэбулган сумын ЗДТГ-аас зарласан “Өөрчлөлтийг өрх, гэр бүлээс” хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэбулган сумын III, IV багийн иргэн Л.Мөнхтуяа, Б.Золзаяа нарыг 2014.4.7-2014.06.07-ыг хүртэл 2 сарын компьютерын сургалтанд үнэ төлбөргүй хамруулллаа.

Сургалтыг Нийтийн номын сангийн мэдээлэл-технологийн ажилтан Б.Энхтайван хариуцан зохион байгуулж Цэцэрлэг, Хайрхан, Эрдэнэ-мандал, Жаргалант сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцан “”MON BIBLIO” программыг ашиглан номоо шивэх, зохион байгуулан явуулсан үйл ажиллагааныхаа тайланг хэрхэн оруулах талаарх арга зүйн зөвлөлгөөг газар дээр нь өгч ажиллалаа.



Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар

2014. 03. 09. “Хүүхдээ сонсох өдөр” - Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 74 тоот тогтоолоор сар бүрийн 9-ний өдрийг “Хүүхдээ сонсох өдөр” болгон зарласантай холбогдуулан аймгийн Нийтийн номын сангийн Хүүхдийн номын ордонд зохион байгуулж Эрдэнэбулган сумын ЕБС-иудын бага, дунд, ахлах бүлгийн сурагчдын төлөөллийг аймгийн ННХ-ийн дарга Ш. Нямдаваа, БГ-ын дарга А. Амгаланбаатар, Нийтийн номын сангийн захирал О. Мөнхтуяа, ХГБХХ-ийн дарга Ч. Уранцэцэг нар сонсож, тэдэнд тулгамдаж буй асуудалд хариулт өгч, шийдвэрлэвэл зохих асуудлуудыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлсэн.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2014 оны аймгийн Засаг даргатай хийсэн Үр дүнгийн гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу номын сангийн үйлчилгээг орчин үеийн дэвшилтэт арга хэлбэрээр баяжуулж, уншигч бүрийн оюуны хэрэгцээ шаардлагыг хангахуйц хүссэн мэдээллийг цаг тухайд нь хүргэж, түргэн шуурхай үйлчлэв. Ажлаа жилээр, сараар болон долоо хоногоор төлөвлөн ажиллав. Тайлант онд бүтээлч ажлууд багагүй хийж, шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэв.

2014 онд байгууллагын өмнөө тавьсан зорилго:

Номын санг цахим номын сан, мэдээллийн төв болгон, чанартай үйлчилгээ үзүүлэх.

Дэвшүүлсэн зорилт:

1. Менежмент, удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийг оновчтой болгох
2. Номын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл–мэдээллийн ажлыг эрчимжүүлэх
3. Үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх
4. Хүний нөөцийн чадавх, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх

Зорилго, зорилтонд хүрэхийн тулд нийт 62 ажил төлөвлөсөн.

Дутуу биелэгдсэн – 1 ажил /Номын санг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр/

Огт биелэгдээгүй – 2 ажил /"Цахим номын сан" төсөл хэрэгжүүлэх, Дорнод Казахстан улсын Өскемен хотод номын санчдын мэргэжлийг дээшлүүлэх/

Биелэгдсэн – 59 ажил

<u>Тайлант он – ажлын үр дүн</u>

- Шинэ байр - тохилог орчин бүрдэв.
- Үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн
- Үйлчилгээний шинэлэг хэлбэр нэвтрүүлсэн
- Материаллаг баазын бэхжилт хийгдсэн
- Номын хадгалалт хамгаалалтын стандартыг хангасан
- СТМАжлын чанар, үр ашиг, хүртээмж дээшилсэн
- Сумдын номын сангуудын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж, ХШҮ хийж чадсан.

<u>Төсвийн зарцуулалт</u>

- Нийт зардал – 127944.5
- Цалин – 70644.9 сая
- Бараа үйлчилгээний зардал - 41835.8
- Түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, шуудан холбоо – 30978.7
- Эд хогшил худалдан авах – 1270.7

Хэмнэлттэй зардал – тогтмол зардлаас гарсан. Хэмнэлттэй зардлаас цалинд 1.5 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 3764.5 төгрөг, тавилгад 1306.0 төгрөг, бичиг хэргийн зардалд 650000 төгрөг нийт 5135.5 төгрөг зарцуулах эрхийг аймгийн Төрийн сангийн хэлтэсээс авч зарцуулсан болно.

Батлагдсан орон тоо – 11 боловч ажлын шаардлагаар 2014 онд нэг манаач, нэг цэвэрлэгчийг гэрээт ажилтнаар ажиллуулж ирэв.

<u>Үйл ажиллагаа, гарсан үр дүн</u>

Номын сангийн шинэ барилгын дуусгалтын ажил 580.0 сая төгрөгийн өртөгтэйгээр хийгдэж ашиглалтанд орсоноор номын сангийн тохилог орчин

бүрдэв. Уншигчдын таатай орчин, номын хадгалалтын стандартыг хангасан байртай болов.

Уншлагын танхим нэгээр нэмэгдэж, 3 танхим чөлөөт уншлагын үйлчилгээтэй болов. Соёл, танин мэдэхүйн танхимыг шинээр нээгдэв.

- Номын хадгалалт хамгаалалтын стандартыг хэрэгжүүлэх зорилгоор галын дохиоллын системтэй болж, ном хадгалагдаж байгаа 6 танхим хяналтын камертэй болсон ба 2014 онд шинэлэг үйлчилгээ явуулж, сурталчилсан байдлыг үнэлэн, яамнаас хөрөнгө оруулалтаар Соронзон хаалга өгөв. 25000 номоо ялтасжуулж, номын хадгалалт хамгаалалтыг сайжруулав.

- Номын сангийн үйлчилгээг бүрэн автоматжуулав. /Уншигчийн карт, уншигч ба олгосон ном, статистик мэдээ, ном хаялт, номын бүртгэл гэх мэт/
- Сумдын номын сангуудыг арга зүйн удирдлагаар хангаж, байнгын хяналт тавьж ажилласаны үр дүнд "Open biblio" програм дээр номоо 100% оруулж, номын электрон катологгтой болж, үйлчилгээгээ автоматжуулав..

- Аймгийн номын сангийн захирал, 3 номын санч, сумын 10 номын санч, нийт 13 ажилтан Улаанбаатар хотод болсон номын баярт биечлэн оролцож, 3 хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдав. Мөн Баянхонгор аймгийн

Бууцагаан сумын Соёлын төв, Говь – Алтай, Ховд аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, туршлага судлав.

- "Сумдын номын сангийн Openbiblio програмын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь" сэдэвт сургалтыг соёлын төвийн эрхлэгч, номын санчдыг оролцуулан зохион байгуулав.
- **Дэлхийн Зөн ОУБ – ын ОНХХөтөлбөрөөс 3400000 төгрөгийн тэтгэлэгээр доорхи ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:**

1. Музейтэй хамтран "Соёлын элч" сургалчилгааны ажлыг хөдөө 12 сум, 10 багаар аялан зохион байгуулав. /Шатахууны зардалд 700000₮/

2. “Хэн олон ном унших вэ” зуны хөтөлбөр зарлан, түрүүлсэн 6 уншигчдын гэрийн номын санд 600000 төгрөгийн 180 ном хандивлав.

3. Өлгий сумын бүх ерөнхий боловсролын сургуулиудаар “Номын аялалд гарцгаая” сэдэвт ажлыг зохион байгуулж, эцэг эхчүүд болон багш нарт номтой нөхөрлөхийн ач тусын талаар ухуулан, шинэ номын үзэсгэлэн гаргаж, шинэ номын жагсаалт ба 2014 оны календарь гэх мэт 300000 ₮ - ийн гарын авлага тараав.

4. **“Хүүхэд ба хөгжил”** төсөл хэрэгжүүлэн, Тогыз хумалах, зуун буудалт даам, шатрын дугуйланд 60 гаруй хүүхэд багачуудыг хамруулан тэдний оюун ухааныг хөгжүүлсэн ба 1 800 000 төгрөгөөр дугуйлангийн багш нарыг цалинжуулав.

- “Ухаан далай номноос эхтэй 45 хоногийн аян”-г сумдын номын сангууд амжилттай зохион байгуулав.
- Байгууллагын ажилтнууд казах хувцасаар жигдэрч, Наурызын баяраар аймагт 3 дугаар байр эзлэв.

- Акталсан номноос хөдөө сумдын 20 дотуур байрыг 4000 хүүхдийн номоор хангав.
- Абай Хунанбаевийн уран бүтээлээс аймгийн уран уншлагын уралдааныг зохион байгуулан, улмаар ОХУ –ын Хош–Агач мужад болсон ОУ–ын уран уншлагын уралдаанд аймгаас 10 сурагчийн бэлтгэлийг хангаж, амжилттай оролцуулж, бүх сурагчид шагнал хүртэв.
-

- Зөөврийн номын санг Өлгий сумын албан байгууллагуудаар ажиллуулан нийт 576 уншигчдад 2325 ш ном уншуулав.

- Номын санчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор долоо хоног бүр “Нэг номын санч – нэг ном” сурталчилгааны ажлыг тогтмол хийж хэвшсэнээр номын санчид нийт 70 гаруй номын агуулгыг мэдэж, олны өмнө ярих чадвараа дээшлүүлэв.

- Алдар көсегийн 13 үлгэрээр дүрийн тоглолтыг цэцэрлэгүүдээр тоглуулан “Үлгэрч хүү” – г шалгаруулав. Мөн дүрийн тоглолтын бичлэгийг хийлгэж гарын авлага болгон цэцэрлэгүүдэд тараав. Инээдмийн баярыг тохиолдуулан “Хожанасырдын хоржыны” дүрийг бүтээж, Өлгий сумын бүх цэцэрлэгүүдээр аялав.
- Цэцэрлэг, ЕБСургуулийн сурагчид хуваарийн дагуу номын сангаар тогтмол үйлчлүүлж хэвшсэн нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд нөлөөлөв.

Уншигч, олгосон номын байдал:

2014 онд 33195 уншигчдад 44385 ном олгож үйлчлэн, төлөвлөгөөгөө биелүүлэн ажиллав. Үүнд:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
Уншигч	25000	33195	132%
Олгосон ном	43000	44385	103%

Материаллаг баазыг бэхжүүлж, тохилог орчин бүрдүүлэв. Үүнд:

Номын сан 2013 онд 7 625 999 төгрөгийн хөрөнгө оруулалтаар материаллаг баазаа бэхжүүлсэн бол 2014 онд хөрөнгө оруулалт, хандиваар 21 697 760 төгрөгийн, улсын төсвөөс 6 050 000 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга авч материаллаг баазаа **27747760** төгрөгөөр бэхжүүлсэн болно. Үүнд:

2013 он		**2014 он**		
Компьютер, зурагт, өнгөт ба хар принтер, прожектор, дэлгэц, самбар, ширээ	5084999₮	Каталогийн шүүгээ	396000₮	ССАЖЯам
Ажилтнуудын ширээ сандал	2541000₮	Сэтгүүлийн тавиур	370700₮	
		Соронзон хаалга	5560500₮	
		Чөлөөт уншлагын номын тавиур /49ш/	10950000₮	“Көшелик” ХХК
		Цонхны хөшиг/40ш/	4420560₮	
		Дотоод тохижилт	8350000 ₮	Улсын төсвөөс
Нийт дүн	**7 625 999₮**		**31047760₮**	

Номын баяжилт:

2014 онд улсын төсвөөс 6230880 төгрөгийн 980 ширхэг ном, 957800 төгрөгийн тогтмол хэвлэлээр, хандиваар 3986752 төгрөгийн 469 ширхэг номоор номын фондоо баяжууллаа. 1423800 төгрөгийн 447 ш цахим номоор фондоо баяжуулж, Таблет төхөөрөмжөөр ном унших боломж бүрдэв./номын тоонд орсон/



- Сумдын номын сангууд яамны хөрөнгө оруулалтаар 34 419 671 төгрөгийн номын тавиур, каталогийн шүүгээ, сэтгүүлийн тавиураар материаллаг баазаа бэхжүүлэв.

Өөрийн үйл ажиллагааны орлого 50000 төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 1200000 төгрөг оруулсан. /Актлагдсан номноос 1200000 төгрөг/

Тэргүүн туршлага

- Гарын доорхи материалыг ашиглан үлгэр, танин мэдэхүйн эмхэтгэл, цуглуулга хийв.
- Бүтээлийн аудио болон дүрс бичлэгийн хоёр CD гаргав.
- Байгууллагуудтай хамтран ажиллах арга, туршлагатай болов.
- Сумдын номын санг удирдлага, арга зүйгээр хангах ажлын арга барилтай болов.

2015 онд хийх ажлын чиглэл:

- Цахим номын сан болох, номын сангийн дэвшилтэт технологи, үйлчилгээний шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх;
- Номын фондыг хэвлэмэл болон электрон хэлбэрийн номоор баяжуулах;
- 25000-30000 номоо соронзон ялтастай болгож, номын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;
- Интернет танхим нээж, үйлчлэх;
- Соёл, танин мэдэхүйн ажлын танхимыг тохижуулан, үйл ажиллагааг жигдрүүлэх;
- Аудио бичлэг сонсох үйлчилгээ нэвтрүүлэх;
- Бяцхан уншигчдын танхим нээх;
- Насанд хүрэгчдийн дунд ном унших хөдөлгөөн өрнүүлэх
- Казах номоор номын фондоо баяжуулах төсөл хэрэгжүүлэх;

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

1. **Номын сангийн үйлчилгээ:**

Арга зүй, лавлагаа, ном зүйн ажил.

Цахим программын бүртгэлийг ашиглан 524 уншигчдад амаар, 68 уншигчдад утсаар лавлагааг өгч, 112 уншигчдад электрон каталог ашиглах, 108 уншигчдад цаасан каталог ашиглах заавар зөвлөгөөг өгч, бүртгэл хөтөллөө. Нэгж тасгуудаас нийт 35 номыг татгалзлаар бүртгэн авч 25 номын татгалзлыг бүрдүүлсэн. "Их Хаадын хөрөг", "Онч мэргэн үгс", Т.Галсангийн намтар уран бүтээлээ, "Нурууны өвчний үед хийх эмчилгээний биеийн тамирын дасгал", "Электрон каталог гэж юу вэ" зэрэг ном зүйн болон санамж өгөх ном зүйн уншигчдад зориулсан 11 гарын авлагыг бэлтгэн гаргасан.

Арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд, ХҮДС, "Эрдэм", Номундалай, МСҮТ, Номгон, Баян-Ойт, Эрдэнэмандал, Соого сейкео сургууль, Залуучуудын хөгжлийн төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Барилгын цэргийн 339 дүгээр ангийн номын санд, орон нутгийн 19 сумын нийтийн номын сан, сургуулийн номын сангуудын ажил байдалтай танилцан, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт шинжилгээ хийлээ.

Хангайн 10 сум, говийн 9 сум, сургуулийн номын сангуудын ажил байдалтай танилцаж, арга зүйгээр хангаж ажилласан.

ХҮДС-ийн номын санч, Жинст сумын сургуулийн номын санчид удирдамжийн дагуу дадлага хийлгэн, номын сангийн анхан шатны мэдлэг олгож, Сертификат олгосон. Электрон каталогт шинээр орсон номын 1600 ширхэг байрлагдаагүй каталогийн картаас 1000 ширхэг картыг төрөл анги, үсэг дараалаар байрлуулсан.

Орон нутгийн картын санг 108 ширхэг карт, мэдээллийн санг "Монгол тулгатны 100 эрхэм" цуврал DVD-ээр баяжуулсан.

Фондын ажил.

Фондноос цахим үйлчилгээгээр 1375 номыг уншлагын танхим, гэрээр ном олгох тасгаар олгож, электрон каталогит оруулсан номуудыг 1-17 бүртгэлтэй тулгаж дууссан. 4 нэр төрлийн сонин, сэтгүүлүүдийг 40 нэгж болгон үдэж, "Ном сэргээн засварлах лаборатори" ашиглан 400 ном сэргээн засварлан уншлаганд гаргасан. Номын фондыг худалдаа болон хандиваар 657 ширхэг, 491 нэр төрлийн 13.036.338 төгрөгийн номоор баяжуулж, улирал тутам 7 нэр төрлийн тогтмол хэвлэл захиалж уншигчдад үйлчилж байна.

Ховор номын бүртгэл мэдээллийн санг "Монгол улсын газарзүйн атлас", "Дэлхийн түүхийг бүтээсэн 100 хүн", "Хүн төрөлхтөний хувцасны загварын бүрэн

түүх”, “Амьтдын амьдрал” номуудаар баяжуулсан. Аймгийн хэмжээнд хувьдаа номын сантай хүмүүсийн судалгаа гаргаж, Ч.Доржсэмбээ, Ё.Шийхар, Эрдэнэмандал сургуулийн багш Энхбат нарын хувийн номын сангийн талаар телевизийн бичлэг хийлгэж олон нийтэд сурталчлан алдаршуулсан.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд морин хуур, уртын дуу, хөөмий, бий биелгээ, өв соёлоо сурталчлан таниулах зорилгоор “Овоо тахих зан үйл”, “Монгол ганжуур данжуур”, “Эрдэнийн товч”, “Баянхонгор аймгийн уртын дуучид” зэрэг гарын авлага бэлтгэв.

Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 24 удаа 800 гаруй номоор гаргаж уншигч, ард иргэдэд сурталчилсан.

Уншигчдад үйлчлэх үйлчилгээ: Байнгын 3986, ирцээр 31238 хүнд, 53855 ном олгож үйлчилжээ. Электрон цахим үйлчилгээгээр нийт 650 уншигчдад, цахим номыг 50 гаруй уншигчдад танилцуулж, интернэтээр 632 гаруй хүнд үйлчилжээ.



Электрон каталогт 1559 ном оруулж бар код, формуляр, цаасан каталогийг хэвлэн, бар кодыг нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэсэн.

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг нийт 490 номоор ЕБС-иуд, банкууд, Музей, Хөгжимт драмын театр, Өндөр настны асрамжийн төв, барилгын цэргийн 339 дүгээр анги, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Байгаль орчны газар болон Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт сумдад очиж ард иргэдэд хүргэн нийт 500 гаруй хүнийг хамрууллаа. Номын сан хоорондын ном солилцооны үйлчилгээг АЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Номгон ахлах сургууль, Эрдэнэцогт, Баян-Овоо сумдад 147 номоор үйлчилгээ явуулсан.

Соёл олон түмний ажил:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээждээ бичих захидал” зургийн уралдааныг зарлан, ЕБС-ийн 5-7 дугаар ангийн 68 сурагч оролцсоноос Тэргүүн байрыг Номгон ахлах сургуулийн 5в ангийн сурагч Д.Нармандах, дэд байрыг Номундалай ахлах сургуулийн 6а ангийн сурагч С.Гантуяа, 3-р байрыг Баян-ойт цогцолбор сургуулийн сурагч Э.Аззаяа нар эзэллээ. Шагналын санд 28500 төгрөг зарцуулсан. Эдгээр хүүхдүүдийн бичсэн захидлыг ээжид нь хүргэж өгч, TV10 телевизээр “Сэтгэлийн үг” нэвтрүүлгийг бэлтгэн гаргалаа.

2. Монгол цэргийн өдөрт зориулж “Аавдаа бичсэн захидал” шилдэг захидлын уралдаан зарлан, нийт 51 захидал ирснээс онцлох 4 захидлын эздийг шалгаруулсан. Үүнд: Номундалай цогцолбор сургуулийн 11в ангийн сурагч Сэржмаа, Соогo Сейкео сургуулийн сурагч Бүрэнхишиг, Өнөрхишиг, Оюунбилэг нар тус тус шалгарлаа. Шагналын санд нийт 54,000 төгрөг зарцуулсан.



3. Дэлхийн яруу найргийн өдрийг Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын газар, аймгийн зохиолчдын холбоо, Хүүхдийн Тэмүжин театртай хамтран 2 дахь жилдээ тэмдэглэлээ. Урилгаар Ардын уран зохиолч, Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн Т.Галсан, Монголын “Үндэсний цахим өв” академийн тэргүүн Ж.Төмөрхуяг нар оролцож, нийт 250 гаруй хүнийг хамрууллаа. Үйл ажиллагаанд нийт 83500 төгрөг зарцуулжээ.

4. Аймгийн шатрын холбоотой хамтран ЕБС-ийн сурагчдын дунд шатар, даамны дугуйланг хүүхдийн уншлагын танхимын дэргэд хичээллүүлж эхэлсэн. Дугуйланд 5-15 насны нийт 30 хүүхэд багачууд суралцаж байна.

5. Аймгийн Ахмадын холбоотой хамтран “Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь” уулзалт, арга хэмжээг “Ахмадын ордон”-нд зохион байгуулж, урилгаар Ж.Галбаа, Ш.Баасанжав, Ш.Гомбосүрэн нарын ахмад зохиолчид, уншигчид, оюутнууд нийт 300 гаруй ахмад, залуу үеийн төлөөлөл оролцсон. Энэ үеэр шинэ номын үзэсгэлэнг 30 номоор гаргаж, хамгийн олон гэрийн номын сантай ахмадаар Ж.Галбаа, залуу үеэс Сооко Сейко сургуулийн багш С.Мөнхтогтох нар шалгарч “Талархал” гардан авлаа. Ахмадуудын дунд “АХА” тэмцээн, “Азын сугалаа” явуулж, шагналын санд 60.000 төгрөг зарцууллаа.

6. “Монгол үлгэрийн цаг” нэвтрүүлгийг Хөгжлийн ертөнц ТҮ-10 телевиз, Улсын тэргүүний 1-10 дугаар цэцэрлэгүүдтэй хамтран бэлтгэж жүжигчилсэн тоглолтыг Бямба, Ням гаригуудад 20.00-20.25 минутанд, Даваа гаригт өглөө давтан нэвтрүүлж Баянхонгор аймгийн хүүхэд багачуудад толилуулж байна.

7. Үлгэрийн их хаан Дани улсын хүүхдийн зохиолч Х.К.Андерсены мэндэлсэний 209 жилийн ой, хүүхдийн номын баярын өдрийг тохиолдуулан ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Үлгэрийн дараагийн хуудас” уралдааныг зохион явуулсан. Уралдаанд сургууль бүрээс 1 сурагч оролцож шилдгийн шилдэг “Оюунлаг” сурагчаар Номундалай ахлах сургуулийн 11а ангийн сурагч Янжиндулам тодорсон. Шагналын санд 21500 төгрөг зарцуулсан.

“Үлгэрийн дараагийн хуудас” уралдаан.

8. **“**Өсвөрийн номын санч” дугуйланг 21 хүүхдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, сурагчдыг номын сангийн үйл ажиллагаатай танилцуулан, үнэт ховор номын музейг үзэж сонирхуулсан.

9. “Ном унших соёл” сургалтыг Нийтийн уншлагын танхимаас 4 удаа “Эрдэм”, “Эрдэнэмандал” ахлах сургууль, Соого Сейкео сургууль, Эрдэнэцогт, Баян-Овоо сумын сургууль, нийт 230 гаруй хүүхдэд, “Их мэдэх” хүүхдийн уншлагын танхимаас ЕБС-ийн 3-7-р ангийн 74 сурагчидад тус тус зохион явууллаа. Сургалтанд “Ном” гэж юу вэ? “Соёл” гэж юу вэ?, номыг хэрхэн өөртөө ашигтайгаар

хурдан уншиж сурах талаар дэлгэрэнгүй ярилцсан. Хүүхдийн уншлагын танхимаас “Хүүхдээ хэрхэн номонд дуртай болгох вэ” эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг цэцэрлэгүүдтэй хамтран 3 удаа 90 гаруй багш, эцэг эхчүүдэд зохион байгуулж, уншигчид болон эцэг эхчүүдэд зориулан “Ном унших соёл” “Хүүхэдээ хэрхэн ном унших дуртай болгох вэ” сэдвээр гарын авлага гаргасан.

“Ном унших соёл” сургалт.

10. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй өнгөрүүлэх “Номын зугаатай уншлага” арга хэмжээг чанга уншлага, электрон цахим үйлчилгээ, АХА тэмцээнээр тус тус зохион явууллаа. Уншлаганд 6-дээш насны 33 хүүхэд хамрагдсан.

11. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүрийн 9 дүгээр сард тэмдэглэдэг “Номын баяр-2014” арга хэмжээг 9 сарын 12-нд аймагтаа зохион байгууллаа. Номын баярын нээлтэнд урилгаар Нийгмийн хөгжлийн хэлтсийн соёл хариуцсан түшмэл Ч.Очирбат, ССАЖГ-ын соёлын мэргэжилтэн Д.Мөнхцэцэг болон Зохиолчдын холбооны тэргүүн, гишүүд нар оролцож, Баянхонгор аймгийн зохиолчдын уран бүтээлийн үзэсгэлэн, Баянхонгор аймгийн зохиолчдын холбооны тэргүүлэгч, яруу найрагч С.Мөнхтогтохын “Амраг сарын дуулал” шинэ номын нээлт, хэлэлцүүлэг, цахим электрон ном сурталчлах, шилдэг 13 уншигчид “Нацагдорж дүр” тэмдэг олгох, уншигчдын дунд “Оюунлаг уншигч-2014” оюун ухаан хөгжүүлэх асуулт хариултын тэмцээн, сэтгэл ханамжийн судалгаа авах ажлуудыг зохион явуулсан. Уг арга хэмжээнд аймгийн төвийн сургуулиудын номын санч, багш, уншигч хүүхдүүдийн 300 гаруй төлөөлөл идэвхтэй сайн оролцож, нийт 327,550 төгрөг зарцууллаа.



“Номын баяр”-2014 Нээлтийн үйл ажиллагаа, урлагийн тоглолт.

Электрон номын танилцуулга.

Тэргүүний уншигч "Д.Нацагдорж дүр тэмдэгтэн" шалгаруулалт.

С.Мөнхтогтохын "Амраг сарын дуулал" шинэ номын нээлт, хэлэлцүүлэг.

"Оюунлаг уншигч-2014" АХА тэмцээн.

Номын баярын хүрээнд Эмэгтэй хүний заавал унших номуудаар /Жон Грейны Ангарагаас эрчүүд, Сугараас бүсгүйчүүд, Баабарын "Доори Идэр Дүүдээ", "Та охинтой бол заавал уншаарай", "Эмэгтэй хүний амьдрал 20 наснаас эхэлдэг", Б.Шүүдэрцэцэгийн "Домогт Ану хатан" хэлэлцүүлэг зохион явуулсан. Уг хэлэлцүүлэгт 2 багш, 2 уншигч, номын санчид оролцож нийт 5 нэрийн номыг танилцуулан, хэлэлцүүлэг явуулсан.

Мөн 9 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотод "Номын баяр-2014" арга хэмжээнд захирал Б.Түвшинчимэг, номын санч О.Наранцэцэг нар оролцож, Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 70 жилийн ойн үзэсгэлэнг гарган, бусад сургалтуудад хамрагдан мэдээлэл сонсож, туршлага судаллаа.

12. Уншигч хүүхэд багачуудыг Монгол хэлний арвин баялаг сантай танилцуулж, зохиох, туурвих урлагт сургах, цаашид жил бүр уламжлал болгон явуулах зорилгоор өсвөр үеийнхний дунд **“Өсвөрийн яруу найрагч бид”** яруу найргийн тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд 6 сургуулийн 26 сурагч оролцсоноос, гурван даваагаар эцсийн шалгаруулалтыг явуулж, тэргүүн байранд Эрдэнэмандал ахлах сургуулийн 11Д ангийн сурагч Х.Дамбажав, дэд байранд тус сургуулийн 11Д ангийн сурагч Р.Гантогтох, гутгаар байранд Соого Сейкео сургуулийн 9Б ангийн сурагч Д.Тунгалаг нар шалгарч, тусгай байрыг Номундалай цогцолбор сургуулийн 12Ё ангийн сурагч И.Цэрэн, Соого Сейкео сургуулийн 11А ангийн сурагч Г.Юмжирмаа, Б.Пагмадулам нар тус тус эзэллээ. Шүүгчээр Баянхонгор аймгийн зохиолчдын холбооны тэргүүн Б.Жавзандулам, гишүүн Х.Тунгалаг, Д.Жавхлан, Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг нар ажиллалаа. Мэдээллийн ивээн тэтгэгчээр TV10 телевиз, Баянхонгор телевиз, Хонгор нутаг FM 102.5 байгууллагууд ажиллаж, эхний 3 байр эзэлсэн хүүхдүүдийг Хонгор нутаг FM 102.5-н “Зочны цаг” нэвтрүүлэгт оролцуулсан. Мөн яруу найрагч н.Оюунсүрэн багшийн “Мянган хүүхдийн шүлэг” номонд энэхүү уралдаанд оролцсон нийт яруу найрагчдын бүтээлийг хэвлэх болсон. Тэмцээний үеэр шилдэг уншигч “Д.Нацагдорж дүр тэмдэгтэн” гардуулах ёслол болж, аймгийн зохиолчдын холбооны тэргүүн Б.Жавзандулам, гишүүн Х.Тунгалаг, Д.Жавхлан нар хүртэж, зохиолчдын холбооны яруу найрагчид шүлэг, найраглал уншиж залуу үедээ сургамж хайрласан.

“Өсвөрийн яруу найрагч бид-2014” анхдугаар уралдааны оролцогч, шүүгч, зохион байгуулагчид.

“Өсвөрийн яруу найрагч бид-2014” анхдугаар уралдааны ялагчид.

13. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит “Хүрэн морь” яруу найргийн наадмыг 25 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Уг наадамд яруу найрагч, сонирхогч 19 хүн оролцож, шүлэг найргаа уншсанаас 1-5 байр шалгаруулж, “Хүрэн морь”-ны эзнээр Галуут сумын засаг даргын орлогч Дүүрэнбилэг шалгарлаа. Шүүгчээр Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг, Хүүхдийн Тэмүжин театрын дарга Б.Ганчимэг, зохиолчдын холбооны дарга Б.Жавзандулам, Энхбат, Монголын зохиолчдын холбооны гишүүн, зохиолч, яруу найрагч З.Түмэнжаргал нар оролцсон. Наадмыг 250 гаруй хүн үзэж сонирхлоо.

“Хүрэн морь” яруу найргийн наадам.

14. 2014 онд уншлага үйлчилгээнд идэвхтэй хамрагдаж, олон ном уншсан уншигчдыг шалгаруулж, “Нацагдорж дүр” тэмдэг олгож, Шилдэг уншигчийн “Сүлд модны наадам” зохион явууллаа. Төсөвт 100.000 төгрөг зарцуулсан.

“Нацагдорж дүр” тэмдэгтнээр Соого Сейкео сургуулийн 2в ангийн сурагч Б.Алтанцэцэг, Номгон ахлах сургуулийн 5Д ангийн сурагч Э.Ууганцэцэг, Эрдэм ахлах сургуулийн 6Г ангийн сурагч Х.Нандин-Эрдэнэ, Номгон ахлах сургуулийн 9Ё ангийн сурагч Б.Хонгорзул, Номундалай лаборатори сургуулийн сурагч 12Б ангийн сурагч Г.Уртнасан, 9 дүгээр багийн иргэн З.Маяа, Номундалай лаборатори сургуулийн 11Е ангийн сурагч Г.Дорждэрэм, Г.Доржгочоо нар тус тусшалгарчээ.

“Шилдэг уншигч-2014”-д Номундалай лаборатори сургуулийн 5А ангийн сурагч Г.Одончимэг, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн НББ-ын 4 дүгээр дамжааны оюутан А.Цээлхам, Номгон ахлах сургуулийн Энхмаа багштай 9Ё ангийн хамт олон тус тус шалгарлаа.

“Шилдэг уншигч-2014” тодруулж “Өргөмжлөл” тууз олголоо.

Номгон ахлах сургуулийн Энхмаа багштай 9Ё ангийн хамт олон.

5 дугаар цэцэрлэг. “Үнэг, чоно, зараа гурав” жүжигчилсэн тоглолт.

“Ном эрдэм” хөтөлбөрийн хүрээнд:

“Ном эрдэм” хөтөлбөрийн 15 дахь удаагийн нээлтийн арга хэмжээг 01 сард “Ном эрдэм” ТББ-тай хамтран зохион байгуууллаа. Нээлтэнд ЕБС-иуд, цэцэрлэг, МСҮТ-ийн багш сурагчид, НХХ-ийн соёл хариуцсан түшмэл М.Мөнхдалай, ССАЖГ-аас соёлын хариуцсан мэргэжилтэн М.Мөнхцэцэг, бусад зочид төлөөлөгчид урилгаар оролцлоо.

“Ном эрдэм” хөтөлбөрийн нээлт.

Удирдамжийн дагуу уншлага үйлчилгээг өдөр тутамд зохион явуулж аймгийн төвийн сургууль, цэцэрлэгүүд, МСҮТ-ийн шинээр **1462** уншигчдад, **14922** ирцэд, **20952** ном олгож, электрон цахим үйлчилгээгээр **351** уншигчдад үйлчилсэн байна. ЕБС, МСҮТ-ийн номын сангууд байнгын **9472** ирцээр уншигчдад **26594** ном олгож үйлчилжээ. Орон нутгийн номын сангуудын хувьд, Заг, Өлзийт, Баянцагаан, Баянбулаг, Бууцагаан, Галуут сумууд **5353** ирцээр уншигчдад **16929** ном олгож үйлчилсэн байна.

“Ном эрдэм” аяны хүрээнд төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж, Дэлхийн яруу найргийн өдөрлөг, “Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь” уулзалт, ЕБС-ийн сурагчдын дунд “Монгол бичгээр хэн сайхан бичих вэ” уралдаан, “Ном эрдэм” аяны 15-н жилийн ойд зориулсан Эссэ-Илтгэлийн уралдаан, Цэцэрлэг, ЕБС-иудын дунд “Шилдэг зохиолын дүр” тоглолт, Миний анхны ном-Алтан агшин” зохиолч уншигчдын уулзалт, “Угийн бичиг” сургалт, сурагчдын дунд гадаад хэлний түвшинг сайжруулах, гадаад хэл дээрх ном уншиж орчуулах, гадаад хэл дээр бяцхан, комикс ном хийх, гадаад хэл дээрх зохиолыг өөрийн үгээр илэрхийлэх гэх мэт 10 гаруй соёл олон түмний ажлыг зохион явуулж нийт 2167 хүн хамрагдсан байна. Орон нутгийн номын сангуудаас, Заг, Өлзийт, Баянцагаан, Баянбулаг, Бууцагаан, Галуут, Гурванбулаг сумууд аяны хүрээнд 43 соёл олон түмний ажлыг ард иргэд, хүүхэд залуучуудын дунд зохион явуулжээ.

1. “Монгол бичгээр хэн сайхан бичих вэ” уралдааныг ЕБС-ийн 151 уншигчидын дунд 2 насны ангиллаар явуулж, 8 хүүхдийг шагналт байранд шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. Шагналын санд 129000 төгрөг зарцуулж, уралдаанд оролцсон нийт оролцогчидын материалаар үзэсгэлэн гаргаж, сурталчилаа.

2. “Ном эрдэм” аяны 15-н жилийн ойд зориулсан Эссэ-Илтгэлийн уралдааныг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зарлаж, уралдаанд нийт 47 сурагчид хамрагдлаа. 1-р шатны шалгаруулалтанд 12 сурагч тэнцэж, 2-р шатанд орж, эссэгээ илтгэлээр тавьж хамгаалан эхний 5 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Тэргүүн байрыг Заг сумын 7а ангийн сурагч Ж.Хонгорэрдэнэ, дэд байрыг МСҮТ-ын БӨҮ-ийн 2а ангийн сурагч Дүйсэнсанги, нар эзэллээ. Шагналын санд 100.000 төгрөг зарцуулсан.

3. “Ном эрдэм” хөтөлбөрийн хүрээнд сурагчдын гадаад хэлний түвшинг сайжруулах, гадаад хэлний мэдлэг чадварыг дээшлүүлж бусдад түгээх зорилгоор гадаад хэл дээрх ном уншиж, орчуулах, гадаад хэл дээр бяцхан, комикс ном бүтээх, гадаад хэл дээрх зохиолыг өөрийн үгээр илэрхийлэх уралдааныг гурван үе шаттайгаар зохион явагдлаа. Уг уралдаанд 60 хүүхдийн бяцхан, комикс номоор үзэсгэлэн гаргаж нэг шилдэг анги, нэг шилдэг хувь хүүхдийг шалгаруулахад Шилдэг ангиар Номгон ахлах сургуулийн 9В ангийн хамт олон, Шилдэг хувь хүүхдээр Эрдэнэмандал ахлах сургуулийн 9Е ангийн сурагч Д.Билгүүнтөгөлдөр нар шалгарсан. Уралдааны эхний шатанд “Гадаад хэл сурах аргачлал” сургалт зохион явуулж нийт 96 уншигч хамрагдаж, МСҮТ-ийн Гадаад хэлний мэргэжлийн зөвлөл багаараа ирж уншигчидад сургалт явуулсны үндсэн дээр 3-р үе шат болох уншсан номоо гадаад хэлээр, өөрийн үгээр илэрхийлэх уралдаан явагдаж Тэргүүн байрыг Эрдэнэмандал ахлах сургуулийн 10в ангийн сурагч Ө.Даваабаяр, Дэд байрыг Номгон ахлах сургуулийн 9а ангийн сурагч Ц.Мажигсүрэн нар тус тус байр эзэллээ. Мөн энэхүү уралдаанд идэвхи санаачлагтай бусдыгаа манлайлан оролцсон сургуулийн “Гадаад хэлний мэргэжлийн зөвлөл”-ийг “Шилдэг хамт олон”-оор өргөмжилж, үүнд “Номгон ахлах” сургуульд “Шилдэг хамт олон” өргөмжлөл, цомыг гардууллаа. Уралдаанд нийт 82300 төгрөг зарцуулсан.

4. “Угийн бичиг” сургалтыг 4 сард МСҮТ, “Ном эрдэм аян” ТББ-тай хамтран 8 багийн иргэд, багийн мэдээллийн ажилтан, МСҮТ-ийн оюутнууд, Зэвсэгт хүчний 339-р ангийн бие бүрэлдэхүүнийг хамруулан зохион явуулсан. Сургалтыг ахмад багш Г.Цэрэн удирдан явуулж, 200 гаруй хүн оролцлоо. Угийн бичгийн талаарх ном хэвлэл, гарын авлага, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж, сургалтанд оролцсон 8 багийн оролцогчдоос тус бүр нэг, 339-р ангийн бие бүрэлдэхүүнээс нэг хүнийг сонгон “Угийн бичиг”-ийн сургагч багшаар сонгож Сертификат олгосон.

5. “Ном эрдэм” хөтөлбөрийн хүрээнд “Миний анхны ном-Алтан агшин” зохиолч уншигчдын уулзалтыг утга зохиол сонирхогч, уншигч, сурагчдын дунд зохион байгуулж, Баянхонгор фондын ном, анхны номын зохиолчийн 80 гаруй номоор үзэсгэлэн гаргалаа. Арга хэмжээнд

60 гаруй хүн оролцож, “Миний анхны ном”-н эзнээр МСҮТ-ийн 2-р курсын оюутан Э.Цогбадрах оролцсон. Төсөвт нийт 96400 төгрөг зарцуулсан.

6. Цэцэрлэг, ЕБС-иудын дунд “Шилдэг зохиолын дүр” тоглолтыг 4 насны ангиллаар 2 төрлөөр зохион явуулж, нийт СӨНХ-ийн ангилалд театрчилсан төрлөөр 6-н баг, хүүхэлдэйн төрлөөр 4-н баг, сургуулийн бага насны ангилалд театрчилсан төрлөөр 8-н баг, хүүхэлдэйн төрлөөр 3-н баг, ахлах ангийн ангилалд 3-н баг тус тус оролцсон. Шүүгчээр аймгийн Хөгжимт драмын театрын найруулагч, жүжигчин Бямбаням, Хүүхдийн Тэмүжин театрын найруулагч, жүжигчин Батболд, “Ном эрдэм аян” ТББ-ын зохицуулагч М.Мянган нар ажилласан.

Үйл ажиллагаанд уг хөтөлбөрийн санхүүжилтээс нийт 210.000 төгрөг зарцуулсан

“Ном эрдэм” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж сум, сургуулийн номын сангуудаас материалыг ажлын хэсэг хүлээн авч шалгаруулан, шилдэг материалуудаар үзэсгэлэн гаргаж, хаалтын ажиллагааг 05 сард зохион байгууллаа.

Мэдээллийн үйлчилгээ: Байгууллагын бүх компьютерын дотоод сүлжээ, LIB4U программийн хэвийн ажиллагааг хангаж, интернэтээр 632 хүнд үйлчилж, бичиг хэргийн i-office программыг үйл ажиллагаанд нэвтрүүллээ. “Аймгийн Нийтийн номын сан” нэртэй facebook хаяг нээж, мэдээлэл солилцож, аймгийн вэб сайтад цаг үеийн холбогдолтой мэдээллүүдийг тухай бүр нэмлээ. Орон нутгийн номын сангаас Openbiblio программд ном оруулсан тухай тайлан, баазыг авч нэгтгэн ССАЖЯаманд мэдээллэн нэгтгүүлж байна. Openbiblio программын талаар орон нутгийн номын санчдад байнга заавар зөвлөгөө өгч, гарын авлага гаргасан.

Удирдлагын үйлчилгээ. Байгууллагын үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд явуулж, номын сангийн дүрэм, дотоод журам, дээд байгууллагаас гарсан тогтоол, шийдвэр, Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд орсон

холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажилчидтай хөдөлмөрийн гэрээ сунгаж, Соёл, спорт, аялал жуулчлалын газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулж, гэрээний дагуу мэргэжлийн 5 ажилчидтай үр дүнгийн гэрээ байгууллаа. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зориулалтаар зарцуулж, төсвийн ил тод байдлыг ханган ажилчид, сар бүр хамт олонд мэдээллэн, ард иргэдэд төсвийн самбараар дамжуулан сурталчилдаг.

ССАЖЯ-наас 7 сард хөрөнгө оруулалтаар номын тавиур 5 ширхэг 3134945 төгрөг, каталогийн шүүгээ 1 ширхэг 396000 төгрөг, тогтмол хэвлэлийн тавиур 1 ширхэг 370700 төгрөг, нийт 3.901.645 төгрөг; 11 сард дохиоллын соронзон хаалга 3866000 төгрөг, ном уншигч 1 ширхэг 721500 төгрөг, лавлагааны ширээ 1 ширхэг 769000 төгрөг нийт 5.356.500 төгрөгийн хөрөнгийн оруулалт тус тус ирсэн. /нийт 9.258.145 төгрөг/.

Мэргэжил боловсролоо дээшлүүлэх чиглэлээр номын санч Ц.Сарантуяа Соёлын боловсролын сургуулийн "Номын сан судлал" ангийг онлайнаар сурч байна. Нийт 200 гаруй уншигч, ард иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, соёл олон нийтийн ажил, уншлага үйлчилгээний талаар судалгаа, санал асуулга авч нэгтгэхэд номын сангаар байнга үйлчлүүлдэг, дэмждэг хүмүүс 98 хувь эзэлж байлаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэст "Хүүхдэд ээлтэй аюулгүй эко орчин" тохижилтын төсөл бичиж нийт 7.000.0 төгрөгний төслийг шийдвэрлүүлсэн. Ингэснээр хайс хийж гадна талын тохижилт, өнгө үзэмж сайжран, машин орж ирж явган хүний зам, талбайг эвдэхгүй байх, ногоон байгууламж сүйтгэхгүй байх, бага насны уншигчдын аюулгүй байдалд анхаарах зэрэг олон давуу талтай болсон.

Энэ жилийн онцлог ажлуудын нэг бол манай Нийтийн номын сангийн түүхт 70 жилийн ой тохиож, 2014 оны 10 сарын 10-11-нд тэмдэглэн өнгөрүүллээ. Төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын болоод бусад олон ажлуудыг хамт олны хүчээр хийж бүтээсэн. Байгууллагын гадна талбайд "Баянхонгор аймгийн Нийтийн номын сан-70 жил" номын эхийг төв номын санд болон орон нутгийн номын санд ажиллаж байсан хүмүүсээс материал цуглуулан бэлтгэж, "Мөнхийн үсэг" ХХК-д 300 ширхэгийг хэвлүүлсэн. Байгууллагын гадна тохижилт, зүлэгжүүлэлт, бүтээн байгуулалтыг сайжруулж, уншигч үйлчлүүлэгчдийн ая тухтай үйлчлүүлэх орчныг нэмэгдүүлсэн.

Үе үеийн удирдлагуудын "Зурагт самбар" гаргах, Ховор номын музей байгуулах, байгууллагын өргөмжлөл, шагналуудаар алдарын булан байгуулах, "Зураг түүх өгүүлнэ" фото зургийн үзэсгэлэн гаргах, "Ном эрдэм" аяны шилдэг материалуудаар үзэсгэлэн гаргах зэрэг олон ажлыг хугацаандаа хийж дуусгасан.

Улаанбаатар хотоос болон бусад аймгуудаас номын санд ажиллаж байсан үе үеийн эрхлэгчид, номын санчид, ажилчид, ахмад настнууд, орон нутгийн соёлын төвийн эрхлэгчид, номын санчид, манай байгууллагатай хамтран

ажилладаг албан байгууллагуудын төлөөлөл, үе үеийн уншигчид, “Ном эрдэм” аяны шагналтнууд гээд нийтдээ 400 гаруй зочид төлөөлөгчид ойн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн.

Ойг тохиолдуулан “Хонгор нутагт 10000 ном” төслийн зохицуулагч Ганзориг хүрэлцэн ирж, Хонгор нутгийн хөгжлийн танхимыг нээж, номын дээжээс гардууллаа.

Баярын хурал ***Шагнал гардуулах ёслол.***

Хүндэтгэлийн концерт. ***Зохиолын шилдэг дүрийн тоглолт.***

“Эргэн дурсахуй” уулзалтанд номын санд ажиллаж байсан үе үеийн ахмадууд, номын санчид, орон нутгийн номын санчид оролцож, ахмад номын санч, МУСТА Б.Байгалмаагийн алдрыг тэмдэглэлээ.

“Эргэн дурсахуй” уулзалт.

Хүндэтгэлийн хүлээн авалт

Дотоод хяналт: Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахад санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд ноцтой зөрчил дутагдал гараагүй, хэвийн явагдлаа. Уншлагын танхимууд уншигчийн төлөвлөгөөгөө оны эхнээс шахаж ажиллах, үйл ажиллагааны мэдээллийн самбарт байгууллагын тайлан төлөвлөгөө сар бүр тавигдаж байгаа, бусад хариуцсан хүмүүс нь мэдээллээ байнга тавьж байх хэрэгтэйг анхааруулж ажиллалаа.

Байгууллагын захиргаанд, ажлын байрны тодорхойлолт шинэчлэх, цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, самбар шинэчлэн хийх, давхар ажил хавсран гүйцэтгэж байгаа хүмүүст өгч байгаа урамшууллыг жигд болгох, номын сангийн 17 бүртгэл маягтыг хөтлөх эдгээр асуудлуудыг санал болгосон.

Сургалт семинар: Үйлдвэрчний эвлэлтэй хамтарч "Хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ"-ний талаар Номын сан, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Хөгжимт драмын театрын нийт 25 албан хаагчид, мөн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн Д.Сосорбарамтай хамтран ХАБЭА-н талаар сургалтуудыг тус тус явууллаа.



Үйлдвэрчний эвлэлтэй хамтран явуулсан сургалт.

ХАБЭА-н сургалт.

Эрдэнэт хотод 6 сард зохион байгуулагдсан "Салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь" сэдэвт хангайн бүсийн зөвлөгөөнд захирал, нягтлан бодогч, жолооч нар оролцоод ирсэн. Зөвлөгөөнийг ССАЖЯ-ны ТЗУХ-

ийн дарга Н.Энхтүвшингээр ахлуулсан яамны ажлын хэсэг удирдан явуулж нийт 8 аймгийн 300 гаруй салбарын мэргэжилтнүүд, төлөөлөгчид оролцсон.

ССАЖГ-аас зохион байгуулсан “Соёлын ажилтны сургалт семинар”-т захирал Б.Түвшинчимэг оролцож, ССАЖГ-ын бүтэц зохион байгуулалт, соёлын байгууллагуудын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл сонсож, орон нутгийн соёлын төвийн эрхлэгчдэд “Номын сангийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомжууд, номын санчийн ажлын байр”-ны талаар мэдээлэл бэлтгэн хүргэлээ.

Жил бүр уламжлал болгон зохиогддог “Үндэсний бичиг үсгийн баяр” арга хэмжээ УБ хотод 2014 оны 05 сарын 02-04-ны хооронд зохион байгуулагдаж, эрхлэгч, ном зүйч, мэдээллийн ажилтан нар оролцоод ирсэн. ”Монгол бичгийн хэрэглээг өргөжүүлье” хэлэлцүүлэг, үзэсгэлэн, ”Ховор ном судар, бичиг үсэг” цахим үзэсгэлэн, уран бичлэгийн уралдаан, үзүүлбэр, сургалтууд хөтөлбөрийн дагуу явагдсан. Монгол Улсын Засгийн газраас жил бүр шалгаруулдаг “Шилдэг ном-2013”-д шалгарсан 45 нэр төрлийн 281 ширхэг 232820 төгрөгний хандивын номыг хүлээн авсан.

“Үндэсний бичиг үсгийн баяр” нээлт, арга хэмжээ УБ хотод.

Орон нутгийн номын санчдад “Үндэсний бичиг үсгийн баяр” арга хэмжээг 05 сарын 16-ны өдөр аймагтаа зохион байгуулж, программын сургалт, “Шилдэг ном 2013”-аар шалгарсан номуудыг гардуулж өгөх, сумдын номын сангийн электрон каталогт ном оруулах ажлыг идэвхжүүлэх, Хүүхдийн номын ордны туршлага “Шөнийн уншлага”, “Эртэч хүүхэд” арга хэмжээнүүдийг шинээр зохион байгуулахаар зорилт тавин ажиллаж байна.



"Үндэсний бичиг үсгийн баяр" сургалт Баянхонгор аймагт.

Соёл, спорт, аялал жуулчлалын газраас "Соёл урлагийн байгууллагуудын үнэлгээ, онцлох ажил" сургалтыг 12 сард соёлын байгууллагын дарга, архив, бичиг хэргийн ажилтан, хүний нөөцийн ажилтан, орон нутгийн сургуулийн номын санчдын дунд зохион явууллаа. Сургалын явцад 2014 оны жилийн ажлын тайланг дүгнэж, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг танилцуулсан.

Мөн Архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэг архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах чиглэлээр сургалт өгсөн.



Архив, бичиг хэргийн ажил: Архив, бичиг хэргийн ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг цаг хугацаанд нь гүйцэтгэж ирлээ. Энэ онд захирлын тушаал 43 , хурал 45 удаа, өргөдөл гомдол 9, ирсэн бичиг 139, явуулсан бичиг 144 байлаа.

2014 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын ББНШК-той хамтран боловсруулж, аймгийн архивын тасгийн дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар батлуулаа. Аймгийн Засаг даргын нэрэмжит архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг, шалгалтанд бэлтгэн, төлөвлөгөөний дагуу архивын баримтын хадгалалтыг сайжруулан 1 сейф нэмж, ХХНЖ, бүртгэлүүдийг шинэчлэх, ажилчдад сургалт явуулах, гарын авлага гаргах, Төрийн архивын санд 2005-2006 оны баримтуудыг цахим хэлбэрээр шилжүүлэх болон бусад олон ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

Аймгийн архивт Нийтийн номын сангийн 70 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлсэн тухай илтгэх хуудас, 60 ширхэг зурагтай зургийн цомог, "Баянхонгор аймгийн Нийтийн номын сан-70 жилд" ном, бусад холбогдох баримт материалуудыг бүрдүүлж, архивын цахим сангийн ажилтан С.Баярсүрэнд хүлээлгэн өглөө.

Архив, бичиг хэргийн ажил:



Төлөвлөгөөнөөс бусад ажил:

Байгууллагын харуул хамгаалалт, орчныг сайжруулах үйлчилгээ: Үйлчлэгчийн ажлын байрны тодорхойлолтонд заасны дагуу цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулж, ажилчид болон үйлчлүүлэгчдийн ая тухтай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Харуул хамгаалалтын тухай хууль, ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг хэрэгжүүлэн, Нүүдлийн номын сангаар алслагдсан албан байгууллага, хөдөө орон нутгаар явж, “Ажлын хэрэгцээний автомашиныг ашиглах, хэрэглэх журам”-ыг мөрдөн хариуцлагатай ажиллаж байна.

Төлөвлөгөөнөөс бусад ажил: ССАЖГазар, ХААН банктай хамтран зохион байгуулсан “Түйн голын жавар-2014” мөсний баярт хамт олноороо бүх тэмцээнүүдэд идэвхитэй оролцож, байгууллагын захиргаанаас 45400 төгрөг зарцуулсан.

3 сард Улс орон даяар зохион байгуулсан Онцгой байдлын үеийн “Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах” ажлын хүрээнд төлөвлөгөө гарган, албан хаагчдад гамшиг ослын үед хэрхэн ажиллах тухай байгууллагын удирдлагаас зөвлөгөө өгч, объектоос гарах чиглэлд дадлага хийв. Ослын нэгдсэн дохионы үед объектоос албан хаагчид болон уншигчдыг гадаах аюулгүй талбайд гаргаж, нийт 67 хүнийг гамшгийн бэлэн байдалд шилжүүлэн ажиллалаа.

Баянхонгор аймгийн түүхт 73 жил, Ламын гэгээн Лувсанданзанжанцаны мэлмий гийсний 375 жилийн ойн Даншиг наадмын нээлтийн үйл ажиллагаанд оролцож, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран 4000 ширхэг хадгийг наадамчин олонд тараах үүргийг биелүүлэн ажилласан. Мөн Дуурсахын хөндийд зохион байгуулагдсан “Дээлтэй монгол-375” арга хэмжээг манай байгууллагын зүгээс хариуцан ажиллаж, соёлын мэргэжилтэн Мөнхцэцэг, хэвлэл мэдээллийн ажилтан Хишигбаяр нартай хамтран 7 сарын 24-нд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд оролцох нийт 130 хүнд мандат олгож, 7 номинацаар шалгаруулалтыг явуулж шүүгчээр Д.Батсайхан, Б.Хишигбаяр нар ажилласан.

Даншиг наадмын нээлт. ***“Дээлтэй монгол-375” наадам.***

Ардын урлагын их наадам, “Нарны алхалт”-2014, Соёлын ажилтны өдрийн арга хэмжээнүүдэд оролцлоо.

Ардын урлагийн их наадам. Соёлын ажилтны өдөр.

Нийгмийн салбарыг сурталчилах 14 хоногийн аяны хүрээнд удирдамж төлөвлөгөөний дагуу шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг Баганат талбайд болон Баруун бүсийн худалдааны төвд гаргаж, 70 гаруй хүн үзэж сонирхсон. Гэрээр ном олгох үйлчилгээг 23 хүнд үзүүлж, электрон номын танилцуулгыг 24 хүнд танилцуулсан.

__Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөр талбайд__

Баянхонгор сумын хойд болон баруун хэсгээр ойн зурвас байгуулах ажлыг аймаг даяар өрнүүлэхэд байгууллагаараа идэвхтэй оролцож, нийт 90 ширхэг модыг суулгаж усаллаа.

БУЛГАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

2014 онд: 3649 уншигч, 19726 ирэгсэдэд, 21226 ном үүнээс тогтмол хэвлэл 5139 олгож үйлчиллээ.Өмнөх оныхтой харцуулахад уншигч-570 буюу 18,5 %-иар өссөн, ирэгсэд-7090 буюу 26,4%-иар, ном олголт-12895 буюу 30,3 %-иар тус тус бага байна.

ФОНД БАЯЖИЛТ:

2014 онд: 362 нэр төрлийн, 752 ширхэг, 9,184,730 төгрөгний ном хэвлэлээр фонд баяжилт хийлээ. Үүнээс: улсын төсвөөр 239 нэр төрлийн, 509 ширхэг, 5,394,000 төгрөгний ном худалдан авч, 414,550 төгрөгний үнэ бүхий сонин сэтгүүл захиалан, яамны хөрөнгө оруулалтаар 47 нэр төрлийн, 76 ширхэг 1.256.460 төгрөгний, бэлэг болон хандиваар 77 нэр төрлийн, 152 ширхэг, 2,119,720 төгрөгний номоор фонд баяжилт хийлээ. Өмнөх оныхтой харьцуулахад 18 нэр төрлөөр илүү, 83 ширхэгээр бага, 2,4 сая гаруй төгрөгөөр илүү байна.

Сүүлийн 3 жилийн фонд баяжилтын тоон үзүүлэлтийн доор харууллаа.





Фонд баяжилт шинжлэх ухаанаар ангилсан нь өмнөх оныхтой харьцуулсан байдлаар дор харуулсан. Энэ онд ХАА, социологи, статистик гэсэн 2 шинжлэх ухаан нэмэгдэж улс төр, цэргийн шинжлэх ухааны номоор фонд баяжилт хийгдээгүй байна.


Уншигчдын ангилал
160
32
48
664
989
585
686
1
34
Ажилтан албан хаагч
Хувиараа хөдөлмөр...
Бусад
Сургуулийн өмнөх нас
I-IV анги
V-IV анги
IX-XI анги
Их, дээд сургууль,...
Мэргэжлийн боловсрол

Боловсролоор ангилсан байдал
1580
720
55
22
158
Бага
Суурь
Бүрэн дунд
Тусгай дунд
Дээд


Насны ангилал
2296
22
73
105
39
18 нас хүртэлх
18-24 насны
25-35 насны
36-50 насны
51-ээс дээш насны

Хүйс
Эрэгтэй 41%
Эмэгтэй 59%



НҮҮДЭЛ, ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

МХГ, ХААН банк, Гангат баг, ЦУОША, ШШГ хорих 439-р анги зэрэг газруудад гэрээгээр зөөврийн номын үйлчилгээ 6,3,5,4,1-р багуудад “Нээлттэй хаалганы өдөр”-үүдэд явуулын үйлчилгээ, зуны явуулын номын сангийн үйлчилгээг 1,4,5-р багуудад ажиллуулсан. Зөвхөн АТНСангийн нүүдэл зөөврийн уншигч-450, ирэгсэд-1100, ном олголт-2150 Аймгийн Мэргэжлийн Хяналтын газар, МСҮТ, ХААН банк, Гангат баг, Тэшиг сум, ШШГЕГазрын харьяа хорих 439-р ангид нүүдэл зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Цэцэрлэгүүдээр ажиллуулсан зөөврийн номын үйлчилгээ салбар номын сан 7 удаа 35 номоор чанга уншлага хийж, 58 номыг зөөврөөр өгсөн байна.

Сумын номын сангуудын нүүдэл зөөврийн номын мэдээ

№	Сумын нэр	Номын санчийн нэр	Нүүдлийн номын сан			
			Нүүдлийн номын сангаар ажиллсан баг, албан газрын нэрс	уншиг ч	ирэгсэ д	ном олгол т
1	Баян-Агт	Алимаа	Тамгын газар, цэцэрлэг	57	177	203
2	Баяннуур	Төгсчулуун	Шар тал 2-р баг, Шороон бумбагар, Өндөр цохио, Далын гол	80	200	99
3	Бугат	Гүндэгмаа	Хан жаргалант, Баян төгөл баг	36	42	54
4	Бүрэгхангай	Баярмаа	Сургууль, Тамгын Газар, цэцэрлэг, Бумбат, Дэрст баг	256	695	2690
5	Гурванбула г	Цэрэнханд	Агт баг, Тогоо бригад	20	55	21
6	Дашинчилэ н	Мөнгөнтуяа	Доргонт, Хараат, Лах багууд	30	897	1454
7	Могод	Оюунчимэг	Жаргалант, Баян-Уул, Баясгалант, Ихт, Баянгол баг	57	769	1500
8	Рашаант	Гантулга	Хөгнөхаан, Аргал хайрхан, Тарна	110	329	691
9	Сайхан	Оюунтунгала г	Угалз, Хулж, Хүрэмт	50	500	854
1 0	Сэлэнгэ	Ганзориг	Хангалтай, Сэлэнгэбүрэн, Тариахтай	25	120	264
1 1	Орхон	Амарцэцэг	Халиун, Бөхт, Мандал, Мааньт	216	4256	4560
1 2	Тэшиг	Алгирмаа	Ерэн баг, Далан баг, Гэр цэцэрлэг	22	70	40
1 3	Хангал	Алтанчимэг	1-р баг, Зөөхий, Гэр цэцэрлэг	76	120	110
1 4	Хишиг-Өндөр	Цолмон	Банзар, Хүрэмт, Жаргалант, Тээг	21	112	85
1 5	Хутаг-Өндөр	Наранчимэг	Хантай, Хонгор, Тээл, Уньт, Төвийн баг	32	600	95
1 6	Хялганат	Баянбаатар	Тамгын газар, эмнэлэг	12	35	20
НИЙТ				**1100**	**8977**	**12740**

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧИД:

2014 онд 17 сурагч “Д.Нацагдорж тэмдэг”-тэн болж, Баян-Агт, Хутаг-Өндөр, Могод сумдаас “Тэргүүний анги хамт олон” шалгарлаа.

2014 онд идэвхтэн уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн болсон сурагчдын нэрс

1-р 12 жилийн сургууль

1. 10Б ангийн сурагч Э. Өлзий-Орших
2. 5А ангийн сурагч Б Лхагва-Эрдэнэ
3. 5В ангийн сурагч М. Жавхлан
4. 5В ангийн сурагч У. Бат-Эрдэнэ
5. 4А ангийн сурагч Ч. Сумъяадорж
6. 5А ангийн сурагч М. Номин
7. 7А ангийн сурагч Б.Батбаяр
8. 12Б ангийн сурагч Б.Байгальмаа

ЭӨЦСургууль

9. 5А ангийн сурагч Б. Энхтуул
10. 5Г ангийн сурагч П. Хүслэн
11. 5Б ангийн сурагч Б. Хаянхярваа
12. 11Д ангийн сурагч Х. Мөнх-Эрдэнэ

Бугат сум

13. СБС-ийн 7А Б.Энххүлэг

Хутаг-Өндөр сум

14. СБС-ийн 5А Ү.Эмүжин

Тэшиг сум

15. 5А Б.Энхманал

ХААМСҮТ

16. ГАЦТТЗ-ны 2 А ангийн оюутан Г. Эрдэнэбулган
17. ГАЦТТЗ-ны 2 А ангийн оюутан Б. Болд-Эрдэнэ

“Тэргүүний уншигч анги хамт олон”

Баян-Агт сум

Бүрэнд дунд сургуулийн Ц.Долгор багштай 3 А анги

Хутаг-Өндөр сум

Бүрэн дунд сургуулийн М.Алтанчимэг багштай 5 А анги

Могод сум

Суурь боловсролын сургуулийн Б.Уранчимэг багштай 4 А анги

НОМЫН МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА:

“Үндэсний бичиг-бидний бахархал”

Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу монгол бичиг соёлын өдрийн арга хэмжээг аймгийн төв номын сангаас боловсролын газар, Булган сумын соёлын ордонтой хамтран зохион байгуулав.

Номын сангийн уншлагын танхимд монгол бичгийн мэдээллийн булан гаргаж сурталчилсны дээр болзол боловсруулж албан байгууллагуудад хүргүүлсний үндсэн дээр “Үндэсний бичиг-бидний бахархал” сэдвээр уралдаанд өрсөлдүүллээ. Уралдаанд Булган сумын ЗДТГ, сум дундын шүүх, онцгой байдлын газар, аймгийн төвийн хоёр, зургадугаар цэцэрлэгийн “Босоо хийморь”, “Дэнс”, “Аврагч”, “Титэм”, “Зохист аялгуу” багууд оролцож мянган жилийн түүхтэй монгол бичгээр мэдлэг, чадвараа сорьцгоов.

Үүсгэн байгуулагч: «Эвэл» ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 999
Эрхлэгч: Г.НОРЖМАА
Утас: 99013466

Сэтгүүлч: Г.Маа
Менежер: Л.Золбаяр
Эх бэлтгэгч: Б.Туяа

Эхийг “Булганы мэдээ” сонины газарт бэлтгэж, «Чөлөөт хэвлэл» сонины үйлдвэрт хэвлэв.
ХААН банк 5270464387

...улган нутгаа хөгжүүлье
...МЭДЭЭ

2014.03.22 Үнэ 600 төг

АЙРАГ СӨГНӨХ мөчид

Инээдмийн баяраар хошин шүлгийн тэмцээн болно

Булган сумын ахмадуудын номтой нөхөрлөх аян

Hîìûí ¿çýñãýëýíãíèéò 32 óäàà 2350 ãàðóé үүнээс сэдэвчилсэн номын үзэсгэлэн 21 удаа 600 гаруй шинэ номоор 11 удаа 1750 íîìûãóíøèã÷, èðãýäýä ñóðòàë÷èëñàí. 175 ном бүхий хавтасны зураг, номын товч агуулга бусад мэдээллүүдийг багтаасан шинэ номын мэдээ, нэрийн жагсаалт бэлтгэж уншигчдад цахимаар хүргэсэн.

Хуулийн буланг 2 удаа шинэчилж, урсдаг самбар, номын сангийн фэйсбүүк хуудаст цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрд нь байрлуулж МОЦАМЭ-д 4 удаа бусад газруудад 30 гаруй удаа мэдээллүүдийг түгээж ажиллаа. Удирдах ажилтнуудын цуглаан дээр шинэлэг ажлуудаасаа мэдээлэл хийж, шинэ номын сурталчилгаа хийсэн. Булганы мэдээ сонинд 3 удаа мэдээлэл гаргасан.

2014 онд хамгийн их уншигдсан ном

НУТанхим:
Нууцын цуврал
Анна Франкийн өдрийн тэмдэглэл
Хүүхдийн цахим ном
Дэлхийн хүүхдийн шилдэг зохиол 108
С.Эрдэнэ Уянгын туужууд
Капусын аугаа хайр
Дэлхийн түүх
Дэлхийн улс орнууд
2013 оны ЭЕШ-ын тестүүд, сурах бичиг, гарын авлага
Нийгмийн тухай мэдлэг 1,2
Хүүхдэд зориулсан 237 номтой цахим ном
ГНО:
Дэлхийн түүх
Ц.Оюунгэрэл Ногоон нүдэн лам
Халхын шоронгийн амьд түүх
Ертөнцийн тайлагдашгүй нууцууд
Л.Сарантуяа Тавилан
Б.Сарантуяа Сорхугтани
Салбар:
Л.Сарантуяа Тавилан
Л.Сарантуяа Газрын нулимс
Ц.Оюунгэрэл Ногоон нүдэн лам
Я.Арслан, А.Түмэндэлгэр 1000 өвчнийг анагаах арга

Үндсэн фонд:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

№	Хаанаас	Хөрөнгийн нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар	Сонин судрын тавиур	1ш	880,000
2		Каталогийн шүүгээ	2ш	1,124,000
3		Тогтмол хэвлэлийн тавиур	1ш	526,500
4		Ресепшин ширээ	1ш	769,000
5	Өөрийн хөрөнгөөр	НУТ, үндсэн фондод цонхны хөшиг, МТ, ня-бо, номзүйчийн өрөөнд төмөр сэйф, ня-бо болон даргын өрөөнд дрожж, ширээ, үндсэн фонд, МТ-д хулдаас зэрэг		3,244,400
Дүн				**6.543.900**

НОМЫН САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ:

НУТ-д электрон каталог, цахим ном бүхий хайлтын 2ш компьютер, ХУТ-д 1ш, ГНО-Мэдээллийн танхимд хайлт хийх, цахим ном, интернэтэд холбогдсон 4ш, Салбар номын сан мөн 5ш компьютерээр үйлчилгээ үзүүлж байна. Уншигчдын уулзалт, сургалт мэдээлэлийг зохион байгуулахдаа проектор дэлгэц ашиглаж үзүүлэн таниулгаа хийж байна. Энд онд 30 гаруй хүнд цахим ном суулгаж өгсөн. Уншлагын танхимд цахим ном уншигч 1888 ,200 хүн интернэтээр үйлчлүүлсэн.

2014 оны програм д аж лласан мэдээ

№	Сум ын нэрс	Номын санчийн овог нэр	Суудлын тоо	Номын фондын тоо	Оруулсан ном	Хувь
1	Баян-Агт	Д.Алимаа	12	8921	3820	42
2	Баяннуур	З.Төгсчулуун	20	3456	200	5.7
3	Бугат	П.Гүндэгмаа	20	4374	428	9.70%
4	Бүрэг ангай	Ц.Б ярмаа	20	12465	3100	24.8
5	Гурванб лаг	Б.Цэрэнханд	16	00	510	9.8
6	Дашин илэн	Д.Мөнгөнтуяа	12	5635	14 0	24.8
7	Могод	Г.Оюунчимэг	2	87	3209	36.8
8	Рашаант	Ц.Гантулга	32	4800	1200	25
9	Сайхан	Ч.Оюунтунгала	10	12000	4934	41.1
10	Сэлэнгэ	С.Ганзори	20	7800	230	2.9
11	Орхон	Б.Амарцэц г	24	9500	3 00	41
2	Тэшиг	С.Алгирмаа	12	1 70	590	43
13	Хангал	Б.Алтан имэг	27	3829	3800	9.2
1	Хишиг Ө дөр	Г.Цолмон	16	9950	1299	13
15	Хутаг-Өндөр	Б.Наранчимэг	20	100	392	18.6
16	Хялганат	Г.Баянбаатар	10	1 94	1194	100

Аймгийн Төв номын сан болон сумдын номын сангийн үнэлгээ

№	Сум ын нэрс	Номын худал даа	Интернэт эд олбогдс он байдал	Нүүдли йн номын сан	"Олуул аа уншъя" аян	Нийт авах ёстой үнэлгэ э	Үүнээс авсан үнэлгэ э
1	Баян-Агт	80	80	0	60	400	**220**
2	Баяннуур	8	100	100	0	400	**280**
3	Бугат	80	80	100	70	400	**330**
	Бүр гханг ай	100	90	1	70	00	**350**
5	Гурванбул аг	0	00	100	0	400	**200**
6	Дашинчил эн	80	00	100	80	400	**360**
7	Могод	80	80	100	100	400	**360**
8	Рашаант	0	80	100	0	400	**250**
9	Сайхан	80	80	100	100	4 0	**370**
0	С лэнгэ	80	80	100	90	400	**350**
11	Орх н	80	100	100	1 0	00	**3 0**
12	Тэшиг	0	00	1 0	95	4 0	**295**
13	Хангал		100	100	95	400	**295**
14	Хишиг-Өндөр	8	100	100	100	400	**380**
15	Хутаг-Өндөр	80	100	100	85	400	**365**
16	Хялгана	0	100	100	70	400	**270**
18	АТНС	00	100	00	100	400	**400**

ТАЙЛБАР:

1. Сумын төв дээр ном худалдаалах цэгтэй бол 100%, дэлгүүрээр хувь хүмүүс ном худалдаалдаг бол 80% гэж авсан
2. Сумын соёлын төв нь интернэтэд холбогдсон бол 100%, өөрсдийн модем ашиглаж байгаа бол 90% өөр газрын интернэт ашиглан мэдээлэл авдаг бол 80% гэж үзлээ.
3. Сумынхаа алслагдсан баг, албан газруудад нүүдэл зөөврийн үйлчилгээг хүргэсэн зэргийг харгалзан үзсэн
4. Аймгийн Төв номын сангаас зохион байгуулдаг үйл ажиллагаанд хэрхэн оролцдог болон “Олуулаа уншъя” аян, “Номын баяр” зэрэг ажлуудыг харгалзан үзэж дүгнэсэн.

ЛАВЛАГАА, НОМЗҮЙН АЖИЛ:

Номын сангийн хэмжээнд нийт 603 лавлагаа, мэдээлэл арга зүйн талаар 161 лавлагаа өгсөн байна. Арга зүйн лавлагааны дэвтэр тусгайлан хөтөлж номын санчдад өгсөн 103 лавлагаа мэдээлэл бүртгэгдсэн байна.

Номын татгалзал хөтлөх дэвтэрт бүх уншлагын заалнууд нийтдээ 113 ном бүртгэгдсэн байна.

Үндсэн фондноос захиалгын хуудсаар НУТ-95, ГНО-433, Салбар-15, ХУТ-30 ном тус тус авсан байна.

Мэдээллийн самбарыг цаг үеийн мэдээ мэдээлэлээр 20 гаруй удаа баяжуулж, шинэчилж ажилласан.

Уншигчийн картыг стандартын дагуу хэвлэж заал танхимуудаа ашиглаж байна.

2014 онд 362 нэр төрлийн, 752 ширхэг, 9,184,730 төгрөгний ном хэвлэлээр фонд баяжилт хийсэн ба эдгээр бүх ном хэвлэлийг нэгдсэн бүртгэл болон нэг бүрчилсэн бүртгэлд дансалж анхан шатны техник ажиллагааг хийж, электрон каталогт оруулж заал танхимуудад хувиарлан уншлаганд гаргасан.

760 номны хавтасны зургийг скайнердэж зарим ном сонингийн зургийг нэтээс татаж каталогт оруулсан.

175 ном бүхий хавтасны зураг, номын товч агуулга бусад мэдээллүүдийг багтаасан шинэ номын мэдээ, нэрийн жагсаалт бэлтгэж уншигчдад цахимаар хүргэсэн.

Орон нутгийн номзүйн бүртгэл гаргах ажлын судалгаа хийж, баримт материал цуглуулж бүртгэж эхэлж байгаа. Бүртгэлд 23 ном бүртгэсэн байгаа.
Электрон каталогт ороогүй байсан Монгол, гадаад 118 номыг каталогт оруулж техник ажиллагааг хийж хувиартай заал танхимуудад нь өгсөн. Мөн тооллогын үеэр гарсан каталогт ороогүй номнуудыг оруулсан.

Номын сангийн ээлжит тооллогыг 6 сарын 1-ээс эхэлж ерөнхий данс, электрон каталог, ойрын фондын гар данстай тулгаж тоолсон тул хугацаа их орсон. Мөн каталогт номын түлхүүр үгийг нэмэх, зарим буруу орсон номзүйн бичилтийг засах, сэлбэн засах зэрэг ажлуудыг энэ үеэр хийсэн.

2014 оны тогтмол хэвлэлийг нэгжлэн үдэж, дансалж үндсэн фондод шилжүүлсэн. Улиралаар нэгжлэхэд 49 нэгж болсон байна.
Электрон каталогт ажилласан талаарх программаас гаргасан графикт тайланг дор оруулла.









Номын фондын хадгалалт хамгаалалт, ном сэлбэн засалт:

Үндсэн фондод 25600 гаруй ном хэвлэл хадгалагдаж байна. Энд онд номын сангийн фондын ээлжит тооллогыг хийлээ.НУТ, ХУТ, ГНО, Салбар номын сангийн ойрын фондууд, үндсэн фондод байгаа бүх ном хэвлэлийг тоолсон. Гадуур ном

олгодог заал танхимууд, нүүдэл зөөврөөр явуулсан номнуудын эргэн таталт удааширч байгаа тул нэгдсэн дүн гараагүй байгаа.

Үндсэн фондод улирал бүр шавж устгал хийж, номын тоосыг соруулж улиралд нэг удаа их цэвэрлэгээ хийсэн.Үндсэн фондод байгаа ховор хуучин 4 судрыг соёлын өвийн бүртгэлийн маягтаар бүртгэсэн./Дутуу/





Энэ нь тооллогын үеэр ихэнх номыг сэлбэн зассан.

СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙ.

Орон нутгийн номын санчдад сургалт мэдээллийг 2 удаа зохион явуулсан.

ХААМСҮТ, МСҮТ, Спортын дунд сургуулийн номын санчид шинээр орсон тул өөрсдийнх хүсэлтээр газар дээр нь очиж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөх, номыг хэрхэн дансанд авах, ангилах, зохиогчийн тэмдэгт ашиглах зэргийг зааж өгсөн.

Рашаант, Хутаг-Өндөр сумын номын санчид шинээр орсон тул дадлага сургалтыг АТНС дээр ирж 3 хоног хийсэн.

Номын санчдад хэрэгтэй мэдээ мэдээлэл, гарын авлагуудыг флашаар, мэйлээр, цаасаар хүргэсэн.

2014 оны 01 сарын 14-ны өдөр сумдын соёлын төвийн эрхлэгч, соёлын байгууллагын удирдах ажилтнуудын семнарыг АТНС-ын нийтийн уншлагын танхимд зохион байгуулан явууллаа. Сургалт семнарт Баяннуур, Баян-Агт, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Хангал, Бугат, Сайхан, Могод, Орхон, Тэшиг,Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганат, Булган сумын соёлын төвүүдийн эрхлэгч /15 сум/, ХЖТ-ын дарга, Музейн дарга, АТНС-ын захирал, ССАЖГ-ын мэргэжилтнүүд оролцлоо. Рашаант, Сэлэнгэ сумд ирээгүй. Энэ семнарын хөтөлбөрт АТНС-аас номын сангийн автоматжуулалт, номын санд хөтлөгдөх бүртгэлүүд, 2013 оны ажлын тайлан зэргийг оруулсаны дагуу мэдээлэл хийлээ. Сумдад ашиглаж байгаа соёл урлагийн байгууллагын тайлангийн программ “Monbiblio” программын талаар танилцуулгыг мэдээллийн ажилтан Г.Энхбилэг, АТНС-ын 2013 оны ажлын тайлан, номын санд хөтлөгдөх бүртгэлүүдийн талаар Т.Мөнгөнтуяа нар мэдээлэл хийлээ.Мөн сумын номын санчдын ажлын талаар цаашид хамтран ажиллах талаар ярилцлаа. Дээрх үйл ажиллагаанд 34 хүн оролцсон.

Сумын номын санчдын сургалт

2014 оны 04 сарын 27-28-ны өдрүүдэд сумын номын санчдад “Номын сангийн шинэлэг үйлчилгээ, Monbiblio програм” сэдэвт сургалтыг 2 өдөр зохион байгуулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү сургалтанд Баян-Агт, Бүрэгхангай, Дашинчилэн, Сайхан, Могод,Орхон, Хишиг-Өндөр, Рашаант, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр, Хялганат, Булган сумын соёлын ордны номын санч зэрэг 14 сумын номын санч хамрагдлаа. Баяннуур, Гурванбулаг, Бугат зэрэг 3 сумын номын санчид тодорхой шалтгааны улмаас оролцоогүй. Сургалтанд хамрагдсан номын санчдад Сертификат олгосон.

Бэлтгэл ажил:

- Удирдамж төлөвлөгөө боловсруулж, удирдлагуудаар батлуулж тараах
- Бүх сумдад утсаар холбоо барьж мэдээ хүргэх
- Номын санчдын албан хэрэгцээнд зориулсан зөвлөмж, гарын авлага, түүнийг тараасан жагсаалт хэвлэн хийсэн
- Номын санчдаас авах судалгааны маягт
- Бэлгээр ирсэн номыг сумдад хувиарлан баримтын хамт бэлтгэсэн
- Сургалт явуулах заал танхимыг бэлтгэн уртасгагч залгуурууд, проектор, дэлгэц байрлуулах

Сургалтын өдрүүдэд:

Монголын Номын сангуудын конерциумын дарга, Соёлын дээд сургуулийн багш Т.Хайдав, Удирдлагын академийн номын сангийн дарга Мөнх-Эрдэнэ нар ирж дараах сургалтуудыг явуулсан. **2014.04.27-ны өдөр Т.Хайдав багш:**

- Номын сангийн шинэлэг үйлчилгээ
- Номын санчийн шаардлага
- Технологийн чиг хандлага
- Уншигчдын эрэлт хэрэгцээ

Мөнх-Эрдэнэ багш:

- Судалгаа, түүний төрлүүд, ач холбогдол
- Судалгааны үндсэн дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд
- Төлөвлөгөө гэж юу болох, төлөвлөгөөний ач холбогдол
- Номын сангийн төлөвлөгөө боловсруулах алхмууд
- Номын сангийн тоон тайлан
- Номын сангийн бичгийн тайлан
- Тайлан бичихэд анхаарах зүйлс

АТНС-аас өгсөн арга зүйн зөвлөгөө:

- Сумын номын санчдын авч ирсэн бүртгэлүүдийг үзэж мэргэжлийн зөвөлгөө өгч буруу зөрүү хөтөлсөн бүртгэлүүдийг цаашид засах талаар зөвөлсөн.
- АТНС-н 2013 оны үйл ажиллагааны тайланг үзүүлж санаа авах зүйлийг хэлж танилцуулсан
- Зохион байгуулсан СОНА баримтуудыг жишээ болгон үзүүлсэн
- Номын санд хөтлөгдөх бүртгэлүүдийг танилцуулан, номын санчдын албан хэрэгцээнд зориулан гаргасан гарын авлага тараасан

2014.04.28-ны өдөр: Т.Хайдав багш:

- Сервэрийн алдааны мэдээлэл хаах
- Байгууллага, номын сангийн тохиргоо хийх
- Програмд ном оруулах
- Баркод оруулахдаа анхаарах зүйлс
- Firefox програмд хийх тохиргоо
- Мэдээллийн сангийн нөөц бэлдэх
- Нэгдсэн каталогийн мэдээ
- Нэгдсэн тайлан бэлдэх
- Бэлдсэн мэдээг аймгийн нийтийн мэдээллийн технологийн ажилтанд илгээх
- Цахилгаан тасалдах болон бусад шалтгаанаар програм гэмтэхэд засах арга
- Нууц үг мартсан тохиолдолд сэргээх
- Оруулах зургаа бэлдэх
- Програмд номын хавтасны зураг оруулах зэрэг асуудлуудаар дэлгэрэнгүй харилцан нээлттэй сургалт явууллаа.

АТНС-аас:

- Зөвлөгөө авч амжаагүй үлдсэн сумын номын санчдад бүртгэл хөтлөлт, номын ангилал зэрэгт заавар зөвлөгөө өгсөн
- Сумдад хувиарласан бэлгийн номоо тараасан
- Томилолт бусад хэрэгтэй мэдээ материалыг хэвлэж хувилж өглөө

Дүгнэлт:

Энэхүү сургалт нь цаг үетэйгээ нийцсэн сайн мэдээлэл агуулсан сайн сургалт боллоо. Сумын номын санчдын хувьд MONBIBLIO программын давтан сургалт байсан учраас програм дээр ажиллахдаа чадахгүй байсан бүх зүйлээ мэдэж авсан. Шинээр Соёлын ордны номын сан MONBIBLIO програмыг суулган авсан. Мөн Сайхан, Орхон, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт, Могод, Хангал зэрэг сумын номын санчид данс бүртгэлүүдээ авч ирж заавар зөвөлгөө авсан нь мэдэхгүй байсан зүйлүүдээ мэдэж авч цаашид данс бүртгэлтэй ажиллахад хүндрэл гарахгүй болсон гэж үзэж байна.

Рашаант, Хутаг-Өндөр сумын номын санчдад өгсөн мэргэжил арга зүйн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хийж гүйцэтгэх ажлууд	Хийж гүйцэтгэсэн ажлууд
1	Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлтүүд, номын ангилал, техник ажиллагаа, номын сангийн үйл ажиллагаа	-Номын сангийн өдөр тутмын бүртгэл хөтлөх заавар өгч /уншигч, ирэгсэд, ном олголт, соёл олон нийтийн ажлын/ НУТ-ын өдөр тутмын бүртгэлээр жишээ болгон дадлага хийлгэлээ. -Номын нэгдсэн бүртгэл хөтлөх -Номын нэгбүрчилсэн бүртгэл -Өгөгдсөн лавлагааны бүртгэл, -Номын татгалзал бүртгэх, -Үрэгдүүлсэн номын оронд авсан номын бүртгэл, -Сонин сэтгүүлийн бүртгэлүүдийг хэрхэн хөтлөх талаар -Номын сан номзүйн ангилалаар номыг шинжлэх ухаанаар ангилах, -Зохиогчын тэмдэгттэй хэрхэн ажиллах -Формулярын уут хайчлах наах -Номын бар код наах -Төлөвлөгөө боловсруулах, тайлан бичих талаар АТНС-ын тайлан, ном хөтөлбөрийн төлөвлөгөө, номзүйчийн жилийн ажлын төлөвлөгөөг үзүүлэн жишээ баримт дээр ажиллаж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өглөө. -АТНС-с зохион байгуулдаг соёл олон нийтийн ажлыг танилцуулан санаа болгон тусгаж авах ажлуудыг бичиж тэмдэглэл хийлгэсэн. -Ном хөтөлбөр, номын сангийн холбогдолтой мэдээ мэдээлэл, маягтуудыг хувилж хэвлэж өгсөн.
2	Monbiblio программ дээр дадлага ажил	-Шинэ ном бүртгэн номзүйн бичилт хийх, бичлэг засах -Уншигч шинээр бүртгэх, засах -Ном уншлаганд гаргах,буцаах, -Соёл олон нийтийн ажлын бүртгэл, -Баркод ажиллуулах баркод -Формуляр, уншигчийн үнэмлэх, каталогийн карт хэвлэх, - Скайнер ашиглаж номын хавтасны зураг оруулах дадлага хийж 5 ном шинээр программд оруулж дадлага хийлгэж программ дээр ажиллахад шаардлагатай заавар зөвөлгөөг өглөө.
3	НУТ-ын үйлчилгээтэй танилцан дадлага хийх	Заалны дотоод зохион байгуулалт, ойрын фонд, электрон каталогыг үзэж танилцан уншлага үйлчилгээн дээр 1 цаг дадлага хийсэн.
4	ХУТ-ын үйлчилгээтэй танилцан дадлага хийх	Дотоод зохион байгуулалт 1-5-р ангийн сурагчдад үйлчлэх үйлчилгээ, сургуулийн өмнөх насбуюу цэцэрлэгийн насныханд хэрхэн үйлчилдэг, хүүхэд багачуудын дунд зохиодог соёл олон нийтийн ажлын талаар мэдээлэл өгсөн.
5	Мэдээллийн танхимын үйлчилгээ дадлага ажил	Гэрээр ном олгох, архив бичиг хэрэг хөтлөлт, интернэт цахим, номын чөлөөт сонголт, тогтмол хэвлэлийн үйлчилгээний талаар мэдээлэл авч дадлага хийлээ. Сэтгэл ханамжийн судалгааны маяг хэвлэн өгсөн
6	Үндсэн фондтой танилцан дадлага ажил	Үндсэн фондын зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт, ном сэлбэн засах, номын ангилал, ялгагч, ном, тогтмол хэвлэлийн байрлуулалт, байршлыг үзэж танилцсан.
7	АТНС-с мэргэжил арга зүйн зөвөлгөө авсан тухай илтгэх хуудас	Дээрх өдрүүдэд хийж гүйцэтгэсэн, сурч мэдсэн дадлага хийсэн ажлынхаа талаар илтгэх хуудас бичиж, томилолтоо бөглүүлсэн

Бүх аймгийн номын сангуудын номзүйч, мэдээллийн ажилтануудад зориулсан сургалтанд сууж сумдад ашиглаж байгаа Monbiblio програмын тохиргоог хэрхэн зөв хийх, мэдээллийн нөөцийг өдөр бүр хадгалах, Mozilla firefox тохиргоо хийх, серверийн мэдээний алдааг засах,нууц код мартах, нэгдсэн тайлан бэлдэх, тайлан мэдээ ирүүлэх бусад түгээмэл гарах гэмтлүүдийг арилгах талаар мэдээлэл авлаа.



8 сард Сайхан, Хутаг-Өндөр сумын номын сангуудын ажил байдалтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Эрдэнэт хотод болсон ССАЖуулчлалын салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь хангайн бүсийн зөвлөгөөнд номын санчид оролцон мэдээлэл авлаа.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ, “ОЛУУЛАА УНШЪЯ” аян, “НОМ” хөтөлбөр:

Сургуулийн өмнөх насныханд буюу цэцэрлэгүүдээр:

1-3-р сард 1,2,4,6-р цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээн явуулж тус бүрд шалгарсан хүүхдүүдийг шагнаж урамшууллаа.
3-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн дунд “Уран жиргээ” шүлгийн тэмцээнийг явуулж
1-р байр:
Ц.Буянзаяа –“Барилдъя” шүлэг 4 настай
Х.Оюунсувд –“Би зураач боловол” шүлэг 4 настай
2-р байр:
Ганхөлөг –“9-н эрдэнийн орон” шүлэг 4 настай
Сайнзаяа –“Тариа” шүлэг 4 настай
3-р байр:
Бямбадорж –“Саарал даага” шүлэг 5 настай
Бүжинлхам –“Үнэг”, “Чийдэн” шүлэг 5 настай
Мөнгөнзул –“Эмээгийн бор авдар” шүлэг 5 настай

Уянга –“Ээж” шүлэг 3 настай тус тус шалгарсан.

4-р цэцэрлэг дээр “Номын ач тус” сэдэвт уулзалт хийж хүүхдийн зохиолч Ц.Чинбат хүүхдүүдэд шүлгээсээ уншиж сонирхуулж мөн хүүхдүүд зохиолчийн шүлгийг уншиж, үлгэрийн номоор чанга уншлага хийж, хүүхдийн шинэ номын дээжээс сонирхууллаа.

СӨН-ныхан Төв номын сан болон салбар номын сангаар танилцах аялал хийж, үлгэрийн чанга уншлага хийлгэлээ.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хүүхдийн зохиолч Ц.Чинбатын нэрэмжит “Миний хайртай үлгэрийн баатрууд” дүрийн тоглолт, Ц.Чинбатын шүлгийн “Хэн сайн мэдэх вэ?” уран уншлагын тэмцээний шалгаруулалтыг 5 сарын 26-нд явуулж шалгарсан тоглолтыг хүүхдийн баяраар талбай дээр тоглуулж шагналыг нь гардууллаа. 6-р цэцэрлэг “7 нар”, 7-р цэцэрлэг “Муурын байшин”, 3-р цэцэрлэг “Муур багш” зэрэг үлгэрүүдээр дүрийн тоглолт хийж 3,4,2,6-р цэцэрлэгийн уран уншигч хүүхдүүд оролцлоо. 7-р цэцэрлэгийн “Муурын байшин” дүрийн тоглолт шалгарлаа.

Өвөө эмээгийн үлгэрийн цагаар 5 настай Биндэръяа өвөө эмээгийн хамт ирж үлгэр ярьж, оньсого таалгаж 7-р цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүд "Алтан залаат тахиа" жүжигчилсэн тоглолтоо үзүүллээ.

ЕБС-ийн сурагчдын дунд

1 сарын 15-нд 6-8-р ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохиож 30 гаруй сурагч оролцсоноос 1-р 12 жилийн 7Б ангийн сурагч Б.Мөнхжин түрүүллээ., “Дараагийн хуудас” тэмцээнд 1-р 12 жилийн 7Б ангийн сурагч Н. Анужин, 1-р 12 жилийн 6А ангийн сурагч Б. Гоёцэцэг, 1-р 12 жилийн 6Б ангийн сурагч З. Энхзул,1-р 12 жилийн 7А ангийн сурагч А. Отгонцэцэг, 1-р 12 жилийн 6Б ангийн сурагч Т. Элбэгзаяа,1-р 12 жилийн 7Б ангийн сурагч А.Долгоржав нар оролцон Ф.Бөрнэт “Сайхан сэтгэлт бяцхан эзэнтэн” гэдэг номын[redacted] үргэлжлэлийг бичлээ.

1-р сарын 21-нд “ТА ТА ТУНГА” тэмцээнийг 6-8-р анги, 10,11-р ангийн сурагчдийн дунд тус тус зохион явуулж 32 хүүхэд оролцсоноос 6-8-р ангиас 1-р 12 жилийн 7А ангийн сурагч Баян-Өндөр, Бум-Эрдэнэ нар, ахлах ангиас 1-р 12 жилийн сургуулийн 10 А ангийн сурагч Б. Баасансүрэн, Уртнасан нар түрүүллээ.

2 сарын 20-нд Олон улсын “Эх хэлний өдөр”-т зориулсан Монгол ардын ёс заншил жүжигчилсэн тоглолт, монгол бичгийн тэмцээнд 1-р 12 жилийн 7 а, 7 б, 8 в, 8 г ангиуд тус бүр нэг сэдэвээр тоглолт бэлтгэн өрсөлдсөнөөс 1-р байр 8Г анги “ Битүүлэх ёс”, 2-р байр 8В анги

“Хүүхдийн даахь үргээх ёс”, 3-р байр 7Б анги “Эрийн гурван наадам”, 4-р байр 7А анги “ Шинийн 1-ний ёс” тоглолтоороо тус тус эзэлсэн. Мөн баг бүр Монгол бичгээр гэрийн даалгавар хийж оролцсон.

1-р 12 жилийн 6,7,8-р ангийн 52 сурагчийн дунд оюун ухаан сорих Даамны тэмцээн зохиолоо.

1-р байр: 6Б ангийн сурагч Эрдэнэтөгс
2-р байр: 6Б ангийн сурагч Булгансэлэнгэ
3-р байр: 8В ангийн сурагч Идэр нар тэргүүллээ.

“Дэлхийн номын өдөр”-өөр

Дэлхийн нийтээрээ уламжлал болгон тэмдэглэдэг энэхүү өдрийг тохиолдуулан номын өдөрлөг зохиолоо. Тус өдөрлөгийн удирдамж, урилгыг ЭӨЦС-ийн 5-р ангийн 3 бүлэг, 1-р 12 жилийн 5,6,7,8,9-р ангийн бүлгүүдэд хүргүүлсэн. Өдөрлөгт нийт 42 сурагч оролцсон

Оролцогч 4 ангийн жүжигчилсэн тоглолт, нîì ûí áààòðóóäûí ä¿ðä õóâèð÷ èðñýí. Ñóðàã÷èä õîîðîíäîî ном солилцох, бэлэглэх, “Уншсан номынхоо тухай ярилъц” ярилцлага өрнүүлэх, “Тэргүүний уншигчид”-ын ярилцлага, урлагийн үзүүлбэр, cóðàã÷äûí ãàðãàñàí хувийн “Номын үзэсгэлэн”, Уншигчдаас хамгийн сайн номын баатрын дүрд орсон 2 уншигчийг шалгаруулсан

ЭӨЦС-ийн 10А, 10Б болон 1-р 12 жилийн 10Д, 10Е ангиудад "Ном чиний дотны найз" сэдэвт ном уншлагын 30 хоногийн аян зарлаж. Танин мэдэхүйн АХА тэмцээн, Номын сантай танилцах аялал

Мэргэжлийн Хяналтын Газар “Ном уншлагын 14 хоног”-ийн аян

2014 оны 02 сарын 28-ны өдөр Мэргэжлийн Хяналтын Газар “Ном уншлагын 14 хоног”-ийн аянг эхлүүллээ.Тухайн өдөр аяны удирдамжийг танилцуулан, номын сангийн үйл ажиллагаанаас товч мэдээлэл хийж, зөөврийн номын үйлчилгээг хүргэж 30 шинэ номоор үзэсгэлэн гаргаж, 14 хүнд карт нээн 18 ном олгож үйлчиллээ.Угийн бичиг хөтөлж буй иргэдийн судалгааг авч, цахим номыг танилцуулан ажиллагсадад суулгуулахаар үлдээлээ.Шинэ номын мэдээг цаасан хэлбэрээр хүргэлээ. Энэ үйл ажиллагаанд 37 хүн оролцлоо. Шинээр хэвлүүлсэн аяны уриа бүхий сурталчилгааны самбарыг байрлуулсан.

2014 оны 03 сарын 14-ний өдөр МУГБагш Ш.Шийтэрийн “Угийн бичиг хөтлөх” сургалт, Ардын аман зохиолын тэмцээнүүдийг зохион явууллаа. Сургалтанд 28 хүн, тэмцээнд 24 хүн оролцлоо. Тэмцээнд СХНХХХ-Лабораторийн нэгдсэн “Хамаг Монгол”, захиргаа аж ахуйн “Дөрвөн бэрх”, ДББОУУХХ-ийн “Арга билэг”, ЭМБХААҮҮХХ-ийн “Арга билэг” багууд өрсөлдсөнөөс “Арга билэг” баг тэргүүн байр, “Хамаг Монгол” баг 2-р байр, “Арга билэг” баг 3-р байрыг тус тус эзэлж ном, дурсгалын зүйлээр урамшууллаа. 8 уншигч авсан номоо буцаан өглөө. Аян зохион байгуулах хугацаанд тухайн байгууллагуудад “Аялах дэвтэр”-ийг ажиллуулж үйлчлүүлэгчдийн санал сэтгэгдлийг авч ажиллаж байна. МХГазар дээрх аянд давхардсан тоогоор 105 хүн хамрагдлаа. 2 уншигч 3 ном захиаллаа. 03 сарын 17-нд захиласан 3 номыг аваачиж өгч урд нь өгсөн 2 ном буцаан авлаа. 5 уншигчид 8 ном үлдсэн 7 хоногийн дараа буцаан авна.

ХААН банкны хамт олны дунд “Ном уншлагын 14 хоног”-ийн аян

2014 оны 03 сарын 04-ны өдөр ХААН банкны төв дээр ажиллагсадын мэдээллийн цагаар мэдээлэл хийж, аяны удирдамжийг танилцуулан, зөөврийн номын үйлчилгээг хүргэж 30 шинэ номоор үзэсгэлэн гаргаж, 15 хүнд карт нээн 22 ном олгож үйлчиллээ. Угийн бичиг хөтөлж буй иргэдийн судалгааг авч, цахим номыг танилцуулан ажиллагсадад суулгуулахаар үлдээлээ. Шинэ номын мэдээг

цаасан хэлбэрээр хүргэлээ. Энэ үйл ажиллагаанд 22 хүн оролцлоо. Шинээр хэвлүүлсэн аяны уриа бүхий сурталчилгааны самбарыг байрлуулсан.

2014 оны 03 сарын 17-нд ажиллагсадын дунд явуулсан ардын аман зохиолын тэмцээнд захиралын зөвлөлийн "Монгол хүмүн", теллерүүдийн "Тумбааш", эдийн засагчдын "Ухаан далай номоос эхтэй", захиргаа аж ахуйн "Дөрвөн бэрх" багууд өрсөлдсөнөөс "Ухаан далай номоос эхтэй" баг тэргүүлж, "Монгол хүмүн" баг удаалж, "Тумбааш"баг 3-р байранд орж АТНС болон ХААН банкнаас өгч буй дурсгалын зүйлсийг гардлаа. Өмнө захиалсан байсан 13 номыг авч очиж 3 хүн 5 ном авлаа. Энэ тэмцээнд 19 хүн оролцлоо. Аяны хугацаанд давхардсан тоогоор 59 хүн хамрагдлаа. Уншигчид үлдсэн номыг 7 хоногийн дараа очиж авна.

"Ижийдээ захидал бичээрэй-2" шилдэг захидлын уралдаан

"Олуулаа Уншъя" аян, **"Ном хөтөлбөр"**-èéã хэрэгжүүлэх ажлын õ¿ðýýí ä нийт ард иргэдийн Монгол хэлний яруу сайхан үгийн баялаг, эх хүний хайр халамжийг дээдлэн сурталчилах зорилготойгоор тус уралдааныг 02 сарын 24-ны өдөр зарлалаа. Уралдаанд 150 орчим захидал ирснээс 120 орчим ЕБС-ийн сурагчдын захидал, 30 орчим нь насанд хүрэгсдээс ирсэн захидал байлаа. Уралдааны эцсийн дүнг 03 сарын 05-ны өдөр шалгаруулж, захидлуудаар үзэсгэлэн гаргалаа. 03 сарын 08-ны өдөр шалгарсан хүмүүсийг дурсамж дурсгалын зүйлсээр урамшуулав.

Уралдаанд шалгарсан хүмүүсийн нэрс: Үүнд: ЕБС-иас тэргүүн байрыг ЭӨЦС-ийн 11.2-р ангийн сурагч Б. Энхномуун, дэд байрыг 1-р 12 жилийн 8В ангийн сурагч Н. Идэр, гутгаар байрыг 1-р 12 жилийн 9а ангийн сурагч Э.Болор-Эрдэнэ, шагналт байрыг 1-р 12 жилийн 11В ангийн сурагч Ч. Мөнхжаргал нар тус тус шалгарлаа.

Насанд хүрэгдээс тэргүүн байрыг Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмч Оюун-Эрдэнэ, дэд байрыг Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн бичиг хэргийн ажилтан Э.Нандинцэцэг, гутгаар байрыг ЭӨЦС-ийн багш Баянжаргал, шагналт байрыг Булган аймгийн "Замын цагдаагийн тасаг"-ийн дарга Уганбаяр нар шалгарлаа.

“Ахмадууддаа зориулсан өдрүүд”

2014 оны 03 сарын 14, 21, 24-ны өдрүүдэд ахмадуудад зориулсан дараах арга хэмжээнүүдийг зохион явууллаа. 14-ны өдөр: Ахмадуудыг номын сангаар аялуулан явуулж байгаа үйл ажиллагаанаасаа танилцуулан, шинэ болон ховор хуучин номын танилцуулга үзэсгэлэнг үзүүлж сурталчилсан. 23 хүн оролцлоо.

21-ны өдөр: “Өвөө эмээгийн үлгэрийн цаг”-аар 7-р цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүд, 5 настай Биндэръяа эмээгийн өвөөгийн хамт ирж үлгэрийн ертөнцөөр аяллаа. 7-р цэцэрлэгийн бяцхан хүүхдүүд “Алтан залаат тахиа” үлгэрээр дүрийн тоглолт хийлээ. 37 хүн оролцлоо.

24-ны өдөр: Онцгой байдлын газрын аврагч нар “Миний мэргэжил миний бахархал” уншигчидтай уулзалт, ярилцлага хийлээ. Аврах багийн аврагчийн өмсгөл хувцас хэрэглэл зэргийг оролцогчдоос сонгон өмсгөж сонирхууллаа. Энэ үйл ажиллагаанд МСҮТ-ийн гагнуурийн 1-р курсын оюутнууд, 1-р 11 жилийн сургуулийн 3-р ангийн сурагчид 2 ахмад настан оролцлоо. Энэ өдрийн үйл ажиллагаанд 58 хүн оролцлоо. Энэ өдөр ахмадуудын дунд хөгжөөнт цэнгээнт тэмцээн явуулах байсан ч 2 ахмад л ирсэн учраас тэмцээнийг явуулаагүй.

Инээдмийн баярын өдөр тохиолдуулан зохион явуулсан “Инээвэл залуужина” тэмцээн

Тус тэмцээнийг 03 сарын 17-ноос эхлэн онигоо, элэглэл, хошин шог зураг гэсэн 3-н төрлөөр явуулахаар зарлаж, удирдамжыг 35 байгууллагад тарааж танилцуулсан. Гэвч байгууллагуудын оролцоо хангалтгүй байснаас зааланд оролцохоор ирэгсэдийн дунд 04 сарын 01-ны өдөр онигоо, элэглэл, хошин зураг төрлөөр тэмцээн явууллаа.

Тэмцээнд онигоо төрөлд нэгдүгээр байр 6-р цэцэрлэгийн М.Хангэрэлт, Элэглэл төрөлд нэгдүгээр байр өндөр настан Б.Товуу, хоёрдугаар байр 6-р цэцэрлэгийн О.Төгөлдөр, гуравдугаар байр 6-р цэцэрлэгийн Б. Даваабаатар, Шог зураг төрөлд нэгдүгээр байр 1-р 12 жилийн 6а ангийн сурагч Б. Гоёцэцэг, хоёрдугаар байр 1-р 12 жилийн 5-р ангийн сурагч Б. Учиралзаяа нар шалгарлаа.

МСҮТ-ийн номын сантай хамтран зохион байгуулсан “Нээлттэй өдөрлөг”

2014 оны 4 сарын 24-нд МСҮТ-ийн номын санч Гүндэгмаатай хамтран “Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан дараах арга хэмжээг зохион явууллаа. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 28 номоор гаргаж номын сангийн

танилцуулга, “Ном унших соёл”-ын талаарх мэдээллийг цахим хэлбэрээр үзүүлж оролцогчидтой чөлөөт ярилцлага хийлээ. 3 хүнд карт нээн 5 ном олгосон.

Оюутнуудын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж гагнуурын 1б ангийн оюутан Б.Батцэрэн түрүүллээ. МСҮТ-ийн номын сангаас мэргэжлийн шинэ номын үзэсгэлэн, номын сангийн үйлчилгээний талаарх танилцуулга, электрон каталог ашиглах заавар зэргийг цаасан хэлбэрээр хийж тараалаа. Энэ өдрийн үйл

ажиллагаанд 106 хүн оролцсон. М.Майцэцэг, Б.Мөнхгэрэл, Г.Намнанбаяр, Ганжаргал, Энхцэцэг нар бусдыгаа хошуучлан идэвх сайтай оролцлоо. Номын санч Ч.Цэндмаатай хамтран ажилласан.**“ҮНДЭСНИЙ БИЧИГ-БИДНИЙ БАХАРХАЛ-3” уралдаан**

Дээрх уралдааныг зохион байгуулах тухай Булган сумын Засаг даргын тамгын газар, Соёлын ордон, Боловсролын газар, аймгийн Төв номын сан хамтарсан удирдамж гарган 30 гаруй байгууллагуудад хүргэж хамтран зохион байгууллаа.

Энэхүү уралдаанд төрийн албан хаагчид 5 хүний бүрэлдэхүүнтэй баг болон оролцож дараах чиглэлээр монгол бичгийн чадвараа сорин уралдлаа.

- Багуудын мэндчилгээ
- Гэрийн даалгавар / “Ухаан далай номоос эхтэй” гэсэн үгийг монгол бичгээр үйс, торго, муутуу цаас, эвхмэл, уралз, бийр, гэх мэт төрлийн аль нэгийг сонгон бичсэн байна./

Тус уралдаанд Булган сумын ЗДТГ-ын П.Батсайхан ахлагчтай “Босоо хийморь” баг Тэргүүн байр, ОБГ-ын Х. Чинзориг ахлагчтай “ Аврагч” баг Дэд байр, Шүүхийн Л.Наянтай ахлагчтай “Дэнс” баг Гутгаар байр эзэллээ. Булган сумын 6-р цэцэрлэгийн С.Ганцэцэг ахлагчтай “Титэм” баг, 2-р цэцэрлэгийн Ч.Оюундэлгэр ахлагчтай “Зохист аялгуу” багууд амжилттай оролцлоо.

Багууд гэрийн даалгавраа үнс, бийр, наамал, угалзан хайчилбар, торго зэргээр өвөрмөц байдлаар бичиж ирүүлсэн нь өмнөх жилүүдийнхээс ахиц гарсан байна. 70 гаруй хүн оролцсон.

“Монгол бичгийн хэрэглээг өргөжүүлье” үндэсний бичиг үсгийн баяр

2014 оны 05 дугаар сарын 1-ээс 6-ны өдрүүдэд захирал Ч.Баярмаа, мэдээллийн ажилтан Г.Энхбилэг нарын хамт Улаанбаатар хотод болсон “Монгол

бичгийн хэрэглээг өргөжүүлье" үндэсний бичиг үсгийн баярын арга хэмжээнд оролцохын зэрэгцээ, номын санчдын сургалтанд сууж, ном бүрдүүлэлт хийлээ.Үүнд:

- Монгол бичгийн 9-р уралдааны нээлт арга хэмжээ энэхүү уралдаанд аймаг тус бүрээс шалгарсан 139 шилдэг уншигч оролцон авъяас билгээ сорьсон.
- ҮНСан дээр болсон "Монгол бичгийн хэрэглээг хөгжүүлье" ярилцлага хэлэлцүүлэгт оролцож үндэсний бичиг үсгээ хөгжүүлэх талаар хийж байгаа эрдэмтэн судлаачдын бүтээлүүд, судалгааны ажлуудын талаар мэдээлэл авч Аймгийн номын сандаа Монгол бичгийн булантай болох талаар санаа авсан
- Улаанбаатар хотын төв номын сан дээр болсон номын санчдын уулзалт, семнарт оролцож бусад аймаг хотуудын номын сангуудын шилдэг шинэлэг ажлуудтай танилцаж өөрийн номын санд хэрэгжүүлж болох санаануудыг тусгаж авсан
- Хотын төв номын сангийн боловсруулсан мастер төлөвлөгөөтэй товч танилцан зорилтуудыг нь бичиж авсан
- Энэ сургалтын үеэр аймгийн номын сангуудад харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Нууц", "Өглөөний хүн" гэсэн 2 ш daisy номыг хүлээн авсан.
- "Шилдэг ном-2013" сонгон шалгаруулалтаар аймаг, сумдад хувиарлагдсан 68 нэр төрлийн 278 ширхэг 2,570,280 төгрөгний номнуудыг хүлээн авсан
- "Номын коллектор"-оос 2,000,0 төгрөгний 96 нэр төрлийн 192 ширхэг шинэ ном худалдан авсан

"Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"

Хүүхдийн баярын үйл ажиллагаа спортын ордон дотор болж Аймгийн төв номын сангийн өртөө ажиллуулж дараах ажлуудыг зохион явууллаа.

- 45 хүүхдийн шинэ номоор, соёлын төвийн номын сантай хамтран хүүхдэд зориулсан англи хэл дээрх 11 номоор үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.
- Хүүхэд багачуудын дунд Монгол наадгай шагаа "ТААЛЦАХ ТЭМЦЭЭН", "ТА ТА ТУНГА" зэрэг тэмцээнүүдийг явууллаа. "ШАГАА ТААЛЦАХ" тэмцээнд 15 хүүхэд оролцуулсанаас 2-р 12 жилийн сургуулийн 4 А ангийн сурагч Б.Мөнхзул тэргүүн байранд, "ТА ТА ТУНГА" тэмцээнд 12 хүүхэд 2:2-оороо хос болон оролцсоноос Бум-Эрдэнэ, Б.Отгонбилэг нар түрүүлж Номын сан, Соёлын төвөөс шагнаж урамшууллаа. Оролцох хүүхэд олон байсан тул тэмцээнийг сунжруулахгүйн тулд хүүхдийн тоо заан тэмцээнээ явуулсан.
- Хүүхдийн зохиолч Ц.Чинбатын шүлгийг "Хэн сайн мэдэх вэ?" уран уншлагын уралдаан, "Миний хайртай үлгэрийн баатрууд" дүрийн тоглолтонд шалгарсан багуудын шагналуудыг гардуулан дүрийн тоглолтонд тэргүүн

байранд шалгарсан 7-р цэцэрлэгийн “Бяцхан туулайн байшин” тоглолтыг хүүхдийн баярын төв тайзан дээр тоглууллаа.

- Дүрийн тоглолт, уран уншлагын тэмцээнд 2,3-р байр эзэлсэн хүүхдүүд, дүрийн тоглолтын багуудын шагналыг өртөөн дээрээ гардуулсан.
- Номын худалдагч Ганчимэгт ном худалдаалах нөхцлийг бүрдүүлэн өгч номын худалдаа ажиллуулсан.
- “Өвөө эмээгийн үлгэрийн цаг”-аар ахмад настан Мөнхбаярыг урьж бяцхан хүүхдүүдэд сонирхолтой үлгэр яриулсан.
- Тэргүүний уншигч “Д.Нацагдорж тэмдэг”-ээр шагнуулахаар тодорхойлолт ирүүлсэн хүүхдүүдээс шалгаруулж болзол хангасан хүүхдийн шагналыг гардууллаа.

300 гаруй хүн үзэж сонирхсон тэмцээн уралдаан үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо 73 нийтдээ 370 гаруй

“Нээлттэй хаалганы өдөр”

1. “Нээлттэй хаалганы өдөр”-үүдэд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаа.
2. Заал танхим бүр “Уншигчтай дотно харилцах дэвтэр” ажиллуулж, 20 саналын хуудсаар насанд хүрэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэлт хийлээ.
3. Шинэ номын үзэсгэлэн сурталчилгааг 6-р багийн өдөрлөгөөр 40 ном, Зүүн түрүү 40 ном, Шинэ хороонд 40 ном, Спорт хороон дээр болсон байгууллагуудын нээлттэй өдөрлөгт 45 шинэ номоор, элсэлтийн шалгалтанд бэлтгэгчдэд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийтийн уншлагын зааланд 87 номоор тус тус хийлээ.
4. 1,3,6-р багуудад явуулын номын сангаар үйлчилж дээрх номын үзэсгэлэнгүүдийг гарган сурталчилж, үйл ажиллагааны зурагт тайланг

дэлгэн, “Сонсдог ном”-ын танилцуулга хийж, сэтгэл ханамжийн санал асуулга авсан. Багуудад ажиллахад хүрч үйлчилсэн, мэдээлэл хүргэсэн хүний тоо ...

- Тэргүүний уншигч “Д.Нацагдорж тэмдэг”-ээр шагнуулахаар тодорхойлолт ирүүлсэн хүүхдүүдээс шалгаруулж болзол хангасан хүүхдийн шагналыг гардууллаа. 300 гаруй хүн үзэж сонирхсон тэмцээн уралдаан үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо 73

5. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг номын сангаар танилцах аялал зохион байгуулж 3,4,6,7-р цэцэрлэгийн бага дунд бүлгийн 118 хүүхэд багш нарын хамт оролцлоо.
6. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан сонсдог номыг сурталчилан танилцуулж нэг хараагүй хүн үйлчлүүлсэн.
7. Нийтийн уншлагын заалны уншигчдын дунд “ТА ТА ТУНГА” тэмцээнийг явуулж 12 ахлах ангийн хүүхдүүд оролцож 1-р 12 жилийн 10 А ангийн сурагч Б.Баасансүрэн, Уртнасан түрүүлж номын сангаас ном бэлгэллээ
8. Оюун ухаан тэтгэгч, мунхагийн харанхуйгаас гаргах “Ламаадан” номыг Дашчойнхорлон хийдтэй хамтран төгсөх ангийн хүүхдүүдэд зориулсан айлдууллаа.
9. Спортын ордон дээр болсон байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт шинэ номоор үзэсгэлэн танилцуулга, номын сангаас зохион байгуулсан ажлуудын зурагт тайлан, шинэ номын мэдээллийг цахимаар проектороор үзүүлж, 30 хүнээс үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.

“Номын баяр”

Монгол улсын Ерөнхийлөгч 2012 оны 8-р сарын 24-ний өдөр “Номын баяр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигийг соёрхон баталж, жил бүрийн 9-р сарын гурав дахь долоо хоногийн Бямба гаригийг “Номын баярын өдөр” болгон өргөнөөр ёслон тэмдэглэх болсон мөн Аймгийн Засаг даргын “Шинэ Булган” хөтөлбөр, “Ном хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10 сарыг “Соёлын сар” болсонтой холбогдуулан 2014 оны 10 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд дараах ажлуудыг зохион байгууллаа. Нийт 200 гаруй хүн оролцсон.

“Ном чиний дотны найз” аянд Баян-Агт сумын бүрэн дунд сургуулийн Ц.Долгор багштай 3 А анги, Хутаг-Өндөр сумын бүрэн дунд сургуулийн 5 Б анги, Могод сумын суурь боловсролын сургуулийн 4 А анги “Тэргүүний уншигч хамт олон”-оор тус тус шалгарч, Тэшиг сумын суурь боловсролын сургуулийн 5 А анги Б.Энхманал, Бугат сумын суурь боловсролын сургууль 7 А Б.Энххүлэг, Хутаг-

Өндөр сум 5 А анги Ү.Эмүжин, 1-р 12 жил 7 А ангийн сурагч Б.Батбаяр, 1-р 12 жил 12 Б ангийн сурагч Б.Байгалмаа нар тэргүүний уншигч “Д.Нацагдорж тэмдэг”-ээр шагнууллаа. Мөн “Бүтээлч уншигч”-аар Г.Амаржаргал, “Цахим ном уншигч”-аар Н.Наранчимэг, “Номын утгыг түгээн дэлгэрүүлэгч уншигч”-аар Ч.Ишдорж, “Уран яруу уншигч”-аар М.Номин-Эрдэнэ, “Сайн яригч уншигч”-аар Б.Хишигжаргал, “Үр дүнтэй уншигч”-аар О.Номин-Эрдэнэ,“Бусдыг дагуулан уншигч”-аар Ц.Соёл-Эрдэнэ, “Хурдан уншигч”-аар Ч.Сумъяадорж нар тус тус шалгарч урамшууллаа.

Албан байгууллага, хувь хүмүүс,сурагчид хоорондоо ном солилцох, бэлэглэх арга хэмжээнд аймгийн Цагдаагийн Газар, Онцгой Байдлын Газар, Улсын Бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, “МЭЭЖ” ХХК зэрэг албан байгууллагууд, 1,2-р 12 жилийн сургуулийн сурагчид оролцлоо.

Аймгийн Төв номын сан, Соёлын ордны номын сан, Баян-Агт, Сайхан, Бугат, Хангал гэсэн 4 сумын сум, сургуулийн номын сангууд, Могод, Сэлэнгэ, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр сумын номын сангууд ирж өөрсдийн үйл ажиллагааны зурагт тайлан, үзүүлэн таниулах материалуудыг дэлгэн сурталчиллаа.

- Орон нутгийн сум, сургуулийн номын санчдад АТНС-с арга зүйн сургалт, мэдээлэл, хийж номын санчид өөрсдийн номын сангийн үйл ажиллагаа цаашид хийх ажлын талаар ярилцлаа.





Оны шилдэг “Оюунлаг хүүхэд шалгаруулах” уралдаант, цэнгээнт, танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээн

Монгол улсын Ерөнхийлөгч 2012 оны 8-р сарын 24-ний өдөр “Номын баяр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигийг соёрхон баталж, жил бүрийн 9-р сарын гурав дахь долоо хоногийн Бямба гаригийг “Номын баярын өдөр” болгон өргөнөөр ёслон тэмдэглэх болсон мөн Аймгийн Засаг даргын “Шинэ Булган” хөтөлбөр, “Ном хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд АЗДТГ, ХАС БАНК, СОЁЛЫН ОРДОН-той хамтран “Номын баяр”, оны шилдэг “Оюунлаг хүүхэд” шалгаруулах уралдаант, цэнгээнт, танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 10 сум, 1,2-р 12 жил, Спортын дунд сургууль, МСҮТ-ийн сурагчдаас дунд насны ангилалд 16, ахлах насанд 17 сурагч оролцсоноос дунд насны ангилалд 1-р байр Могод сумын 8а ангийн сурагч Д.Ганжаргал, 2-р байр Сайхан сум 8б анги Б.Баржавхлан, 3-р байр Хутаг-Өндөр сум 8а анги М.Майдар, ахлах насны ангилалд 1-р байр Хутаг-Өндөр сум 11а анги А.Бат-Эрдэнэ, 2-р байр Хишиг-Өндөр сум 10б Б.Сэлэнгэ, 3-р байр Хангал сум 9а Б.Түвшинтөгс нар тус тус шалгарлаа.

“Соёлын гудамж” фистивали

“Соёлын гудамж” өдөрлөгөөр Аймгийн Төв номын сангаас “Номын ертөнц” өртөөг байрлуулж түүн дээрээ дараах арга хэмжээг зохион явуулсан.

- Номын ертөнцийг Монгол уламжлалтай уялдуулан Монгол гэр, тавилга байрлуулан тоглоом наадгайг тоглох боломжийг бүрдүүлсэн
- Шинэ болон Монгол ардын уламжлалыг сурталчилсан номын үзэсгэлэн
- Цахим ном байршуулж уншуулах
- Тараах материал гарын авлага /Ном унших соёл, Монгол тоглоом наадгайг хэрхэн тоглох г.м/
- Монгол ардын тоглоом наадгай тоглуулах /Шагай, даам, шатар, хөлөгт тоглоомууд/
- Сургуулийн өмнөх насныханд үлгэрийн чанга уншлага
- “Алтан хонх” цэнгээнт тэмцээний бэлтгэл ажлыг хангаж зохион явуулсан
- Номын сангаас зохион байгуулсан СОНА зурагт тайланг дэлгэн сурталчилсан зэрэг
  ажлуудыг хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 439-р ангид “Ном-соёл-урлаг”сэдэвт өдөрлөг

Аймгийн Төв номын сан, Булган сумын соёлын ордон, Хөгжимт жүжгийн театр хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих 439-р ангид “Ном-соёл-урлаг” сэдэвт өдөрлөг зохион байгуулж дараах ажлуудыг зохион явууллаа. Соёлын ордноос 7, Номын сангаас 3, Хөгжимт жүжгийн театраас 2, “Сайхан Монгол” телевизээс 1, илтгэгч Б.Энхтайван, зохиолч Ц.Чинбат зэрэг 15 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаа.

- Урлагийн тоглолт
- Номын сан тус бүрт нь Төв номын сангаас 60 монгол ном, Соёлын ордны номын сангаас англи ном хандивлав ном хандив
- Хүмүүжигчдэд Б.Энхтайван “Номтой нөхөрлөе” лекц уншлаа.
- Хүүхдийн зохиолч Ц.Чинбат уран бүтээлээсээ мэндчилгээ дэвшүүлж өөрийн зохиосон номыг номын сангуудад нь бэлгэллээ.
- Ажиллагсадын компьютерт цахим ном суулгаж өглөө /320 ном бүхий 6 ном/
- Ажилтан албан хаагчдын дунд танин мэдэхүйн, цэнгээнт “Алтан хонх”, “ТА ТА ТУНГА” тэмцээнүүдийг зохион явууллаа. “Алтан хонх” тэмцээнд 32 хүн оролцсоноос а/ч Г.Нямбаяр тэргүүн байр, а/ч Д.Отгонням дэд байр, “ТА ТА ТУНГА” тэмцээнд 7 баг оролцсоноос Д.Батгэрэл, Алтантунгалаг нар тэргүүн байр, О.Нямбаатар, Золжаргал нар дэд байранд шалгарч дурсамж үнэ бүхий зүйлээр урамшууллаа.
- 150 номоор үзэсгэлэн гаргаж, Аймгийн төв номын сангаас зохион байгуулсан СОНА фото зурагнуудаас дэлгэн сурталчиллаа.
- Нүүдлийн номын сангийн гэрээ байгуулан 46 ном үлдээлээ.

- Ажилтан албан хаагчдын хүүхдүүдийн цэцэрлэгээр орж хүүхдийн зохиолч Ц.Чинбат уран бүтээлийн дээжээсээ өргөн барьж зохиолч өөрийн номын

дээжээс гардуулж Номын сан болон Соёлын ордон хүүхдэд зориулсан монгол англи нийлсэн 20 гаруй ном бэлгэллээ.Дээрх өдөрлөгт ажилчин албан хаагчид, хүмүүжигчид нийтдээ 350 гаруй хүн оролцлоо.

Халхын Цогт Хунтайжин “Дуутын хадны бичээс” 390 жилийн ойн баярын үеэр сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргалаа.

БУСАД:

Ажиллагсад өөрсдийн хийсэн ажлын тайлангаа тавьж жилийнхээ алдаа оноог хэлэлцэн цаашид хийх ажлын төлөвлөгөөгөө танилцууллаа.

6 сард ÑÑÀÆÃàçàðûí Ìóçåé, Ñî¸ëûí îðäîí,ÕÆÒ,çýðýã áàéãóóëëàãóóäûí õàì òàðñàí "Òàâàí öàãàðèã" áàã ßâãàí àÿëàë-2014 àðãà õýìæýýíä àìæèëòòàé îðîëöîæ 3-ð áàéðàíä

8 сард байгууллагын ажиллагсад Архангай, Хөвсгөл аймгийн нутгаар аялалаа. Аялахдаа тухайн 2 аймгийн номын сангуудаар орж туршлага судлан үйл ажиллагаатай нь танилцлаа.Мөн зам дагуух байгалийн болон соёлын дурсгалт газруудыг үзлээ.

Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах талаар анхаарч төмөр торон сав хийж багаж хэрэгсэлийг байрлуулсан.

Номын санчдын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан.Энэ тэмцээн АТНС-ийн номын санчид болон сум,сургуулийн номын санчид оролцлоо.

Ахмадын баяраа байгууллагын өндөр настнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлж тэдний дунд бяцхан хөгжөөнт тэмцээн зохиолоо.

Хөдөлмөрийн хэлтэс, нийгмийн даатгалын газар, Цагдаагийн газрын тайлан мэдээлэлд сууж мэдээлэл авсан мөн “Ухаалаг төр” төрийн албан хаагчийн хариуцлага хэлэлцүүлэгт байгууллагын ажиллагсад оролцсон.

Орон даяар явагддаг гамшигаа хамгаалах арга хэмжээний үеэр дуут дохиогоор номын санд байсан уншигчид болон ажиллагсад талбай дээр бэлэн байдалыг хангаж гарсан.

Булган нутгийнхаа алдар гавъяатнуудыг сурталчилах, хүүхэд залуучуудад танин мэдүүлэх зорилгоор сум бүрээр нь нэрсийг нь гаргаж номын сандаа байрлууллаа.Мөн номын сангийнхаа мэдээллийн самбаруудыг шинэчиллээ. Сумдын номын сангуудын товч танилцуулган бүхий самбарыг байрлууллаа.

ШИНЭЛЭГ АЖИЛ:

- Оюун ухаан тэтгэгч, мунхагийн харанхуйгаас гаргах “Ламаадан” номыг Дашчойнхорлон хийдтэй хамтран төгсөх ангийн хүүхдүүдэд зориулсан айлдууллаа.
- Булган нутгийнхаа алдар гавъяатнуудыг сурталчилах, хүүхэд залуучуудад танин мэдүүлэх зорилгоор сум бүрээр нь нэрсийг нь гаргаж номын сандаа байрлууллаа
- Анх удаа Аймгийн Төв номын сан, Булган сумын соёлын ордон, Хөгжимт жүжгийн театр хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих 439-р ангид “Ном-соёл-урлаг” сэдэвт өдөрлөг зохион байгуулсан
- “Өвөө эмээгийн үлгэрийн цаг” арга хэмжээг улирал бүр зохион байгуулсан.
- Ажиллагсад Монгол үндэсний хэв маяг шингэсэн жигд хувцастай болсон
- Идэвхтэн уншигчдыг 9 номинациар шалгаруулсан.

ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ:

2014 онд номын сангийн фондын ээлжит тооллого хийсэн нэлээд хугацаа орсон ажил болсон. Номын сангийн ээлжит тооллогыг 6 сарын 1-ээс эхэлсэн. Тооллогыг ерөнхий данс, электрон каталог, ойрын фондын гар данстай тулгаж тул хугацаа их орсон. Мөн каталогт номын түлхүүр үгийг нэмэх, зарим буруу орсон номзүйн бичилтийг засах, сэлбэн засах зэрэг ажлуудыг энэ үеэр хийсэн. Гадуур ном олгодог заал танхимууд, нүүдэл зөөвреөр явуулсан номнуудын эргэн таталт удааширч байгаа тул нэгдсэн дүн гараагүй байгаа.

Тооллого хийхэд уншлага үйлчилгээг түр хугацаагаар хаасан учраас ирэгсэд ном олголт бага гарсан, явуулын номын сангийн үйлчилгээ цөөн, баг

байгууллагууд дээр зохион байгуулах “Ном уншлагын аян” төлөвлөсөн хэмжээнд хүрч чадаагүй байна.

Төлөвлөгөөт СОНА зохион байгуулж чадсан.

Уншигчдаас санал асуулга болон сэтгэл ханамжийн судалгааг удаа дараа авч дүгнэлт хийн үр дүн гаргахаар ажиллаж байгаа ч номын сангийн үйлчилгээнд хангалтгүй санагдаж байгаа зүйлүүд нь уншигчид хүйтний улиралд уншлагын зааланд суухад халаалт муу байдаг их даарч тав тухгүй, дотроо 00-гүй, номын хүрэлцээ муу, байр савны багтаамж бага зэрэг асуудлууд байна. Эдгээр асуудлуудыг шийдэхэд бидний зүгээс авч болох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ч төсөв хөрөнгөөс хамаарах учраас шийдэж чадахгүй байгаа.

Сумын номын сангуудад ашиглаж байгаа номын сангийн програм хангамж ашиглалт удаашралтай хангалтгүй байгаа нь харагдаж байна. Програмын талаар тайлан мэдээ ирүүлэлт муу байна.

Шинэ ном худалдан авахад номын үнэ өндөр төсөв бага байгаагаас номын фонд баяжилт муу хийгдэж байна. Ирсэн ном уншигчдад хүрэлцэхгүй байгаа талаар уншигчдаас байнга санал гомдол ирж байна.

СОНА-д насанд хүрэгчдийн оролцоо, идэвхи, санаачлага муу байгаа. СОНА зохион байгуулахдаа албан байгууллагуудад урилга өгөөд ч ирж оролцдоггүй.Нэгнийхээ хийж байгаа ажлыг дэмжих ажил муу байна.

ЦААШИД ХИЙХ АЖЛУУД

- 2016 онд болох Номын сангийн 70 жилийн ойг угтаж орон нутгийн номзүйн бүртгэл, ном товхимол гаргах ажлыг хийх
- 2015 онд каталог, картын сан зохион байгуулах
- Барилгын өргөтгөлийн ажлыг хийх
- Дохиолол, хамгаалалттай болох

SWOT шинжилгээ

2013 онд гаргаж байсан SWOT шинжилгээнд дүгнэлт хийж үзэхэд сул талд байсан барилга байгууламж үйлчилгээний шаардлага хангахгүй болсоныг засах боломжтой болсон. Мөн Аюулаас энэ талын асуудал авраҡдсан байна.

Манай номын сангийн SWOT шинжилгээ

Давуу тал:

- Уншлага үйлчилгээний шинэ нөхцөлд зохицуулан, шинэлэг хэлбэрээр явуулах ажлын чиг баримжаатай болсон
- Боловсон хүчнийг чадваржуулах тогтолцоо бий болсон
- Интернэт үйлчилгээний дэвшилтэт арга хэлбэрийг бүтээлчээр ашиглах боломж бүрдсэн
- Техник хэрэгсэлийн хангамж сайжирсан
- Номын сан байршил сайтай хэрэглэгчид ойр
- Уншигч иргэсдийн тоо нэмэгдэж байгаа
- Өөрийн номын сандаа авто машинтай

Сул тал:

- Мэргэжлийн боловсон хүчин цөөн
- Алслагдсан сум, багуудад хүрч үйлчлэхэд бинзен шатахууны төсөв хөрөнгө хүрэлцээгүй
- Одоо ашиглаж байгаа барилга байгууламж үйлчилгээний шаардлага хангахгүй болсон

- Үйлчилгээг өргөжүүлэх санхүүгийн дэмжлэг бодит байдлаас хоцорч байгаа
- Шинэ номын хүрэлцээ муу
- Номын санчдын цалин хангамж хангалтгүй
- Номын санчийн орон тоо дутуу /Стандарт тоонд хүрэхгүй/

Боломж:

- Аймгийн төр, төрийн бус байгууллага, олон нийттэй хамтран ажиллах тэдний дэмжлэгийг авах боломжтой
- Нийт иргэд, хүүхэд залуучуудын мэдээллийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа

Аюул занал:

- Интернэтийн үйлчилгээ эрхлэгчид олширч өрсөлдөөн нэмэгдэх
- Дохиолол, хамгаалалт байхгүй
- Номын сангийн байрны багтаамж нөхцөл, хүрэлцээ муу
- Цахилгаан монтаж шаардлага хангахгүй болсон
- Сантехник, халаалт муу
- Шинэ номын үнэ өртөг өндөр

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.Удирдлага зохион байгуулалтын талаар:

Аймгийн Соёл,Спорт Аялал Жуулчлалын газрын даргатай байгуулсан Менежерийн үр дүнгийн гэрээг үндэслэн Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ханган биелүүлэх зорилгоор баталгаажуулан ажиллаа.

Аймгийн нийтийн номын сан нь Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газар, БСШУЯ-ны сайдын тушаал ССАЖГазрын заавар, зөвлө мжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.

Орон тоо бүтэц зохион байгуулалтын хувьд үндсэн 12, гэрээт 1 орон тоотойгоор үйл ажиллагааг явагдаж байна. Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үүрэгт ажлыг ханган биелүүүлэх зорилгоор ажлын зохион байгуулалтыг сайжруулж ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж бүтээгдэхүүн нийлүүлэлтийг ханган биелүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж ажиллалаа.

2.Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:

Шинэ уншигч 1352 бүртгэж, 12838 ирцэд 21424 ном олголт хийж, уншигч үйлчлүүлэгчдийг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилтын хүрээнд, иргэд олон нийтэд хүрч ажиллах үүднээс зөөврийн номын санг ХААН банк, Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн алба, Нийгмийн даатгалын Хэлтэс,Татварын хэлтэс ,Засаг Даргын Тамгын Газар, Соёл Спорт Аялал Жуулчлалын Газар, Хөдөө Аж Ахуйн Газар,Улаан Загалмайн Хороо ,Орон нутгийг судлах музей, Хөдөлмөрийн хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтэс, Төрийн банк, Хас банк, Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Иргэдийн хурал, Цахилгаан холбоо, Мэргэжлийн Хяналтын газар, Орифлеймийн салбар, Хатан плаза дэлгүүрийн хамт олонтой хамтран ажиллах гэрээ хийн 180 шинэ уншигч бүртгэж, 7 хоногоор номоо сольж нийт 930 ном олголт хийж, зөөврөөр ном авч үйлчлүүлдэг уншигчдын хүсэлтээр хүүхдийн фонднoос 65 ном авч хүүхэд багачуудад уншуулсан байна.

Алслагдсан сум багийн иргэдэд хүрч үйлчлэх төлөвлөлтийн дагуу Рашаант багт очин 10 шинэ уншигч бүртгэн 26 ном олголоо. Мөн Бигэр, Цогт, Цээл, Алтай, Бугат, Төгрөг, Тайшир, Гуулин, Дэлгэр, Чандмана, Эрдэнэ зэрэг сумдаар явж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч Цээл сумд "Би монгол эр хүн ", Алтай сумд "Монгол наадгай", Бугат сумд "Уламжлалт соёл" сэдвүүдээр, Гуулин тосгонд А.С Пушкины "Алтан загасны үлгэр"-ээр дүрийн тоглолт, Тайшир сумд Ш.Дулмаагийн уран бүтээлээр дууны, яруу найргийн тэмцээнийг насанд хүрэгчдэд зориулсан танин мэдэхүйн ажил зохион явуулсан. Энэ арга хэмжээнд нийт 500 гаруй хөдөөгийн иргэд хамрагдан 650 ном олголоо.

Шинэ болон хандиваар ирсэн 880 ширхэг номоор фондоо баяжуулж, данс бүртгэлд авч техник ажиллагаа хийсэн. Аман болон бичгийн лавлагаа электрон хайлтаар 450 ширхэг өгч үйлчиллээ. Говь-Алтай аймаг хэвлэлийн хуудаснаа орон нутгийн ном зүй, З.Гүнсэн амьдрал уран бүтээл, С.Пүрэв амьдрал уран бүтээл, Ч.Лодойдамба амьдрал уран бүтээл, Цагаан идээний гайхамшиг, Р.Эмүжи амьдрал уран бүтээл, Ш.Дулмаа уран бүтээл, Эрүүл биед саруул ухаан оршино зэрэг бүртгэн мэдээлэх ном зүйн бүртгэл, Монголын хамгийн хамгийн, Таны гоо сайханд,Монгол дээл, Амжилтанд хүрэх зөвөлгөөнүүд, Ном унших ашиг тусын тухай 10 зөвлөмж, Говь-Алтайн 7 брэнд, Говь-Алтайн 9 гайхамшиг, Суль сулихарын тухай, Ээж хайрханы домог, Морины тухай зэрэг лавлагааны гарын авлага бэлтгэж уншигчдад үйлчиллээ.

Үндсэн фонд, Хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох тасгийн номын санчид нийт 1060 ширхэг номыг сэргээн засварлаж уншлага үйлчилгээнд гаргасан байна. Үндсэн фондны номыг 12-р сарын 01-08-ны хооронд тооллоо.

Номын үзэсгэлэнг 03 дугаар сарын 03-ний өдөр Тайшир сумд Ш.Дулмаагийн ном, эмэгтэй зохиолчдын номоор, 03 сарын 18-24-ний өдрүүдэд “Зэвсэгт хүчний 93 жилийн ойд зориулан байгууллагын үүдэнд цэрэг дайн, халхын голын холбогдолтой 41 ширхэг ном, шинээр ирсэн үлгэрийн ном, Спорт Цогцолборт болсон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн ажлын хүрээнд МСҮТ, Хөдөлмөрийн Хэлтэсээс зохион байгуулсан “Хөдөлмөрийг дэмжих жил” арга хэмжээнд мэргэжлийн ном, Жанчивын талбайд Шатрын ном, 5 дугаар сарын 23-нд “Үндэсний бичиг үсгийн баяраар “Хувийн номын сан”-тай иргэдийн номоор, Шинэ болон шилдэг ном, ховор ном, номын үзэсгэлэн худалдаа, 06 дугаар сарын 01-нд Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнд оролцон Жанчивын талбайд хүүхдийн номын үзэсгэлэн, номын худалдааг, 09 сарын 19-нд Номын баяраар номын үзэсгэлэн, номын худалдаа,10 сарын 20-нд Нээлттэй хаалганы өдрөөр ховор болон хүүхдийн ном, гадаад ном, хоолны номын үзэсгэлэн тус тус гаргасан.

3.Фонд, каталоги зохион байгуулалт:

Үсэг дараалал төрөл ангийн каталоги зохион байгуулалт 90 %-тай , гадаад номын фондноос 719 ширхэг ном програмд оруулан 40%-тай явагдаж байна. Шинэ болон хандиваар ирсэн номыг Lib4U програмд оруулан бар коджуулан фонд тасгуудад хуваарилан каталоги хэвлэн байрлуулсан байна.Фондын чийгшилт номын хадгалалтыг сайжруулан ажиллаж байна.

4.Сургалт, аргазүйн зөвлөгөөний чиглэлээр:

2014 оны 05 дугаар сарын 14-16, 19-21-ний өдрүүдэд тус тус 2 баг болгон хувааж Openbiblio програмын сургалтыг 15 сумын Соёлын төвийн номын санчдад сургалт явуулж програмд оруулсан номын номзүйн бичилт, алдаатай хийснийг нь

засуулж флашинд хуулж авч, аргазүйн зөвлөгөө өгсөн. 4 дүгээр сард Бигэр, Цогт, Цээл, Алтай, Бугат, Төгрөг, Шарга, 5 дугаар сард Тайшир, Гуулин, Дэлгэр, Чандмана, Эрдэнэ сумдад явж програмын явцтай биечлэн танилцаж, аргазүйн зөвлөгөө өгч, зарим сумдад Соёл олон түмний ажил зохион явууллаа**.** Соёл Спорт Аялал Жуулчлалын Яамны серверт Алтай, Гуулин, Цогт, Чандмана, Дарив, Тонхил, Шарга, Хөхморьт, Бугат, Халиун, Эрдэнэ, Цээл, Төгрөг сумуудын номуудыг оруулсан байна.

5.Соёл олон түмний ажлын чиглэлээр: 2014 оны 03 сарын 03-ний өдөр Ш.Дулмаагийн уран бүтээлийн үдэшлэгийг Тайшир сумд зохион явуулах үйл ажиллагаанд Номзүйч Б.Одсурмаа, Мэдээллийн ажилтан Б.Оюун, Фондоч Д.Ундармаа, Жижүүр Д.Мандахзул нартай хамтран зохион явууллаа.

Хүүхдийн уншлагын танхимаас зохион явуулсан 2014 оны 02 сарын 22-ний өдрөөс 04 сарын 22 хүртэл "Номын ертөнцөөр аялацгаая" 2 сарын аяныг хэлэлцэн дүгнэсэн.Тус арга хэмжээнд ЕБС-ын 12 жилийн 1-р сургуулийн Баярмаа багштай 5-б анги тэргүүн байр, Оюуны түлхүүр бага сургуулийн 4-а анги дэд байр, 12 жилийн 2-р сургуулийн 2-а анги гутгаар байр тус тус эзлэн амжилттай сайн оролцлоо.

Говь-Алтай аймгаас төрөн гарсан зохиолч Ч.Лодойдамба, З.Гүнсэн, Д.Норов, С.Пүрэв, Р.Эмүжин нарын уран бүтээлээр "Утгын чимэг богино" өгүүллэгийн наадам 2014 оны 04 сарын 30-ний өдрийн 15 цагаас Хүүхдийн уншлагын танхимд амжилттай боллоо. Наадамд 1-р сургуулийн 10а ангиийн сурагч А.Энхчимэг "Шаргачин" өгүүллэгээр 1-р байр, 3-р сургуулийн 10а ангийн сурагч Сумъяабазар "Уйдахын аргагүй орчлон"өгүүллэгээр 2-р байр , 3-р сургуулийн 10а анги Барсболд "Гэрээслэл" өгүүллэгээр 3-р байр 3-р сургуулийн 10а ангийн сурагч О.Батчимэг "Гүүгүүл морь" өгүүллэгээр тусгай байр эзэллээ.

Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж "Монгол бичгийн хэрэглээг өргөжүүлье" сэдэвт сайхан бичгийн уралдаанд нийт 20 гаруй бүтээл ирсэнээс "Оюуны түлхүүр" бага сургуулийн захирал Н.Хишигбаяр "Тэргүүн байр", 11-жилийн II сургуулийн багш Нарантуяа "Дэд байр", Цагдаагийн дэд дарга Эрдэнэ-Очир "Гутгаар байр", Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтэсийн мэргэжилтэн М.Алтангэрэл "Тусгай байр" тус тус эзэлсэн байна.

"Миний номын сан" үзэсгэлэнд оролцсон Жаргал, Ш.Цоодол, Д.Цоож, М.Мянганбуу, Х.Чимэдрэгзэн нарт "Батламж, дурсгалын зүйл" гардуулсан бөгөөд 2-р сургуулийн 9в ангийн сурагч Ц.Номин-Эрдэнэ, 5а ангийн сурагч М.Маралмаа, 1-р сургуулийн 11ё ангийн сурагч Б.Мянганбаяр, 5-р сургуулийн 11а ангийн сурагч Б.Сувд-Эрдэнэ, 3-р сургуулийн 9г ангийн сурагч А.Амгалан, 11б ангийн сурагч Г.Ундрам, М.Түмэнжаргал нарыг "Нацагдорж" тэмдэгээр тус тус шагнаж урамшуулсан.

Хүүхдийн уншлагын танхимаас 05 сарын 20-ноос 06-р сарын 04 хүртэл ЕБСургуулиудын 4-5 ангийн сурагчдын дунд Ж.Дашдондог "Өнчин хайлаасны үлгэр"-ээр дүрийн тоглолтыг зохион байгуулж явуулав. Дүрийн тоглолтонд Оюуны түлхүүр цогцолбор сургуулийн 4-а анги, 12 жилийн 2-р сургуулийн 5-а,в ангиуд,12 жилийн 1-р сургуулийн 5-б,в,4-в ангиуд тус тус оролцов.Дүрийн тоглолтонд баг бүр 5 сурагчидтай оролцон өөрсдийн авьяас чадвараа сорилоо. Дүрийн тоглолтын 1-р байрт 12 жилийн 2-р сургуулийн 5-в анги,2-р байрт 12 жилийн 1-р сургуулийн 5-б анги, 3-р байрт Оюуны түлхүүр цогцолбор сургуулийн 4-а анги тус тусэзэлж дурсамж ,дурсгалын зүйлээр шагнуулав.

2014 оны уншлага үйлчилгээний тоон үзүүлэлт

/ хүснэгт № 2/

Төрөлжсөнтэнхим		байнгынуншигч	Ирэгсэд	олгосонном
1.	Номынсан	**1587**	**17418**	**33027**

2.	Салбар номын сан	**348**	**6193**	**13355**
3.	Нүүдлийн номын сан	**204**	**612**	**1836**
4.	Төрөлжсөнтэнхим	**1613**	**12308**	**24078**
Үүнээс:	Байгалийнухаан	334	1247	1985
	Гадаадхэл	204	791	1052
	Гэр бүлийн танхим	6	16	191
	Цахимном-мэдээлэл	864	9012	19011
	Эххэл-уранзохиолын	205	1242	1839
Нийт		**3752**	**36531**	**72296**

Уншигчдын бүтэц: / насны ангиллаар/

/ график № 1 /



Хүйсийн ялгаа:

/ график № 2/



Ирцын байдал: / сар бүрээр/

/ график № 3/



Ном олголт: / шинжлэх ухааны ангилалаар/

/ график № 4/



Аймгийн засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан“Ном” аймгийн дэд хөтөлбөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн орон нутгийн хөгжлийн сан /“ном” хөтөлбөр/ 2.000.000 төгрөгийнхөрөнгө оруулалтаар “Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхим”-ыг тохижуулж, 2014 оны 5-р сарын 30-нд нээн үйл ажиллагаа эхлэв.Мөн тухайн танхимын үйлчлүүлэгчдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон 1000000 гаруй төгрөгийн ном сэтгүүл,тоглоомыг худалдан авч байршууллаа.

3. **<u>СОТА-ын талаар:</u>**

“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд:

БШУЯ-наас хэрэгжүүлж буй “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих, бага насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, ардын аман зохиолоос суралцах зорилгоор 5-р цэцэрлэгтэй хамтран “Шилдэг ерөөлч, магтаалч хүүхэд” шалгаруулах тэмцээнийг энэ жил 5 дахь жилдээ уламжлал болгон зохион явууллаа.

“Ном” хөтөлбөрийн хүрээнд:

Дэлхийн номын өдөр: Монгол улсын ерөнхийлөгчийн “Номын баярыг тэмдэглэх” тухай зарлиг, Дархан-Уул аймгийн засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн “Ном” дэд хөтөлбөрийн хүрээнд 4-р сарын 21,24-ны өдрүүдэдДархан-Уул аймгийн Төв номын сан, “Номын Ундраа” дэлгүүртэй хамтран 3 дахь жилдээ зохион байгууллаа.

Арга хэмжээний хүрээнд: Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн, Ардын уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэн, Соёлын гавьяат зүтгэлтэн Ардын уран зохиолч Пунцагийн Бадарч, Д.Нацагдоржийн, Болор цомын шагналт яруу найрагч А.Эрдэнэ-Очир, Д.Нацагдоржийн, Болор цомын хошой шагналт яруу найрагч Б.Ичинхорлоо, МЗЭ-ийн шагналт зохиолч Б.Золбаяр нартай “ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ”-ыг Дархан,Хонгор сумын ард иргэд, хүүхэд багачуудын төлөөлөл 500 гаруй идэвхтэн уншигчидын дунд зохион байгуулав.

Төсөл:Номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн технологийг номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлэх, түүгээр дамжуулан шинэлэг үйлчилгээг бий болгох, иргэдийн мэдлэг боловсрол, бүтээлч чадварыг хангах зорилгоор 11.280.000 төгрөгийн санхүүжилт бүхий “Цахим номын сан” төслийг ССАЖЯ, аймгийн ХБХ-т хүргүүлсэн.

Лекц, уулзалт:“Ном” хөтөлбөрийн хүрээнд “Ном унших учир” зөвлөмж лекцийг захирал Л.Мөнхбаатар ЕБС-д10 гаруй удаа, сумдын сургуулиудад 5 удаа, Номын санч Н.Сэлэнгэ 1-р сургууль дээр 1 удаа тус тус зохион байгуулаж, шинэ ном танилцуулав. Уг арга хэмжээнд нийт 1500 гаруй сурагч, 29 багш нар хамрагдан ном унших арга барилыг төлөвшүүлэхэд хүүхдүүдийг чиглүүлжээ.

Телевизийн нэвтрүүлэг:“Ном“ аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд ”ЛХА” телевизтэй хамтран “Ном шүтэх цаг” нэвтрүүлгийн ээлжит дугаарыг Дархан сумын 2-р багийн иргэн, баялаг номын сантай А.Цэрэг гуайн гэрээс бэлтгэн, 2014 оны 04-р сарын 22-нд үзэгчдийн хүртээл болголоо.

Уралдаан тэмцээн: ОИ Цогцолбор, “Од” цогцолбор сургууль дээр анги нийтээр уран унших уралдааныг зохион байгуулахад хамтран оролцолж, шүүгчээр номын санч Н.Ганзориг, Н.Мөнгөншагай ажиллаж, амжилттай оролцсон анги хамт олонд өргөмжлөл, дурсгалын зүйлс гардуулав. Уг арга хэмжээний үеэр шинэ номын болон хамгийн их эрэлттэй, уран зохиолын номуудаар сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 100 гаруй боть номоор гаргав.

Оюутны “Хорол эрдэнэ” яруу найргийн наадмыг Зохиолчдын салбартай хамтарч 2014 оны 03-р сарын 21-ны 13 цагт ХНО дээр зохион байгууллаа. Наадамд 5 сургуулийн 21 оюутан оролцож шүлгээ уншлаа. Уг арга хэмжээний үеэр залуу уран бүтээлчдийн яруу найргийн номын үзэсгэлэн гаргасан.

“Бид ирлээ” соёл урлагийн арга хэмжээ:Дархан-Уул аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, хөдөө орон нутгийн ард иргэдэд соёл, урлаг, нийтийн биеийн тамирын үйлчилгээг хүргэх, сурталчлан таниулах, хамтран ажиллах зорилгоор ХНО, ССАЖГ, Залуучууд театр, Төв номын сан, Музей, Номын ундраа дэлгүүр хамтран 2014 оны 10-р сарын 8,9,13-ны өдрүүдэд “Бид ирлээ” арга хэмжээг Шарын гол, Хонгор, Орхон сумдуудад зохион

байгууллаа. Уг арга хэмжээнд тус ХНО-гоос Шинэ номын үзэсгэлэнг 56 боть номоор, эрэлт ихтэй 6 төрлийн сэтгүүлээр үзэсгэлэн гаргаж, Шарын гол сумын II сургуулийн идэвхтэн уншигчдын "Болжмор" клубтэй 24 боть номоор зөөврийн номын сан ажилууллаа.

Мөн сум тус бүрийн ЕБ-ийн сургуулийн ахлах ангийн сурагчдад "Ном унших чиг хандлагыг төлөвшүүлэх нь" сэдэвт лекцийн захирал Л.Мөнхбаатар хийж нийт 160 гаруй сурагчид хамрагдсан байна.

Хүүхэд, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, номын орчинг илүү өргөн хүрээнд хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх зорилгоор " Тэргүүний уншигч- Д. Нацагдорж тэмдэгтэн" шалгаруулах журмын дагуу болзол хангасан 3 анги, хамт олон, 5 хүүхдийг шагнаж урамшууллаа.

Тус арга хэмжээ нь тухайн сумдуудын " Нээлттэй хаалганы өдөрлөг"-тэй давхцаж, олон нийтийг хамран, үр өгөөжтэй арга хэмжээ боллоо.

" Step by step" тэмцээн:Дэлхийн хэл болох англи хэл, англи хэлтэй орнуудын түүх, соёлыг судалдаг сурагчдын англи хэл сурах сонирхлыг өрнүүлэх, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх, бахархах сэдлийг хөхиүлэн дэмжих, англи хэлний сонсгол болон хэлзүйн чадварыг хөгжүүлэх, Хүүхдийн Номын ордны үйл ажиллагааг бусдад таниулах үүднээс зохион явуулсан **"Step by Step"** сэдэвт англи хэлний уралдааныг Хуучин Дарханы 5 сургуулийн дунд амжилттай зохион явууллаа.

Номын үзэсгэлэн: Дархан-Уул аймаг байгуулагдсаны 53 жилийн ойн баярын хүрээнд Монголын зохиолчдын эвлэлийн Дархан-Уул аймаг дахь зохиолчдын салбарын гишүүдийн номын үзэсгэлэнг 67 боть номоор, Монгол-Оросын найрамдлын сарын ажилд зориулан Орос хэл дээрх хүүхдийн номын үзэсгэлэнг 45 боть номоор гаргаж, өөрийн фондоо уншигчиддаа сурталчиллаа

Нээлттэй хаалганы өдөрлөг: Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97-р зарлиг, МУ-ын засгийн Газрын 190-р тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Дархан-Уул аймгийн ССАЖ Газрын Соёлын байгууллагуудын "Нээлттэй хааллганы өдөр"-ийн арга хэмжээг 2014 оны 9-р сарын 12-ны 11.00-14.00 цагийн хооронд Дархан захын гаднах талбайд зохион байгуулалцан хамтран оролцлоо.

Уг арга хэмжээний хүрээнд тус Хүүхдийн Номын Ордны зүгээс Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхим, Тосгон дахь салбар номын сангийн үйл ажиллагааг сурталчлан, Уншигчийн карт үнэ төлбөргүй нээж, гэрээр ном олгох үйлчилгээг үзүүллээ. Мөн хамгийн их уншигддаг ном, шинэ ном, өөрсдийн гараар бүтээсэн Бүтээлч ном, хандивын номын үзэсгэлэнг гаргаж, уншигч олонд толилууллаа. " Нээлттэй хаалганы өдөр"-т хүрэлцэн ирсэн уншигч, хэрэглэгчдийн дунд зохион байгуулсан хонжворт сугалааг ССАЖГ,ТНС, Номын ундраа дэлгүүртэй хамтран зохион байгуулж, үнэ төлбөргүй карт нээх эрх 30ш, супер хонжвор болох номын багц 1 ш-ийг азтануудаа гардууллаа. Уг арга хэмжээнд Дархан захын түрээслэгчид, үйлчлүүлэгчид хамрагдсан болно.

Уламжлалт ажлууд:

Номын үзэсгэлэн, Шилдэг уншигч, Хамгийн олон уншигдсан ном, "Ургалч санаа-Уран бодолт" өгүүлбэртэй бодлогын уралдаан, "Шилдэг шүлэг", "Тэргүүний уншигч -Д.Нацагдорж" ,тэмдэгтэн шалгаруулах зэрэг арга хэмжээнүүд болзол журмын дагуу зохион байгуулагдлаа.

4.Фондын баяжилтийн талаар:

Номын сангийн фондын сан хөмрөгийг баяжуулах зорилгоор , орон нутгийн байгууллагуудаар **“Ном хандивлах аян ”** хайрцаг аялуулах ажлыг зохион байгуулав. Оны эхнээс эхэлсэн уг ажлын хүрээнд 10 байгууллагаас 451ширхэг ном хандивлаад байна. Эдгээр номоос хэрэгцээ шаардлага, утга агуулгаар тэнцсэн 71 номыг ялган авч фондондоо авч уншлага үйлчилгээндээ ашиглаж байна.

Хэвлэл захиалга:

Тогтмол хэвлэлийн захиалгыг улирал бүр хийж, 13 нэр төрлийн тогтмол хэвлэл /6 сонин, 8 сэтгүүл/ захиалснаар уншигчдын эрэлт хэрэгцээ хангагдаж, мэдээ мэдээллийг цаг тухайд нь түргэн шуурхай хүргэж байна.

Хандиваар:Америкийн Монгол судлалын төвийн Монголд зориулсан ном хөтөлбөрийн хүрээнд Англи хэл дээр хэвлэгдсэн 375000 төгрөгний 77 нэр төрлийн 125 ширхэг ном, ССАЖЯ, Соёл Урлагийг хөгжүүлэх сангаас хамтран зохион байгуулсан “Шилдэг ном-2013”-д шалгарсан 1119460 төгрөгийн 44 нэрийн 62 ширхэг ном, Үндэсний бичиг үсгийн баярын арга хэмжээний хүрээнд хандиваар өгсөн 90000 төгрөгийн 3 нэрийн 18 ширхэг ном, БНХАУ-ын ӨМӨЗ-ны хэвлэлийн хорооноос 300000 төгрөгний 85 нэрийн 100 ширхэг ном, “Ном хандивлах аян-2014” арга хэмжээний хүрээнд цугларсан 92500 төгрөгний 71 нэрийн 85 ширхэг номыг тус тус хүлээн авч, техник ажиллагаа хийж уншлага үйлчилгээнд оруууллаа. Хандиваар нийт 1.976.960 төгрөгний 280нэрийн 390ширхэг ном хүлээн авсан байна.

Бага насны хүүхдийн нас, сэтгэхүйд тохирсон хялбаршуулсан 60 хуудастай зурагт каталогийг хийж үйлчилгээндээ ашиглаж байна.

Номын сангийн үйлчилгээнд электрон каталог нэвтрүүлэх зорилгоор шинэ ирсэн номын цаасан болон электрон каталогийг бүрдүүлж програмд 1652 уншигчдын мэдээллийг шивж оруулсан. Номын сангийн автоматжуулалтын Monbiblio програмд 11-р сарын байдлаар 7558 номын мэдээллийг шивж оруулаад байна. Уншигчдад зориулан электрон каталог ашиглах талаар заавар зөвлөмж гаргасан. Сан хөмрөгийн өрөөний номуудыг ангиллын дагуу байрлуулсан.

Фондын хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих, шаардлагатай ном хэвлэлээр нөхөн бүрдүүлэлт хийх зорилгоор фондын бүх номын тооллогыг жилд 2 удаа /ээлжит бус, болон ээлжит/ “Номын нэг бүрчилсэн дансаар тоолох” хэлбэрийг сонгон зохион байгууллаа. Тооллогын дүнд дутагдсан 3 номыг “Алдагдсан буюу дутагдсан номыг нөхөн төлөх” журмын дагуу ижил номоор орлуулах буюу хэрэгцээ шаардлага хангах эрэлт хэрэгцээт номоор нөхөн бүрдүүлэлт хийсэн.

5.Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар:

Ажиллагсдыг худам “Монгол бичигтэн” болгох хөдөлгөөн эхлүүлж, Монгол хэл, бичгийн уншлага үйлчилгээний танхимын номын санч О.Даваасүрэнгийн удирдлага дор монгол бичиг сурах өдрийг товлон хичээллэж эхэллээ.

Цахим мэдээллийн хэрэгслээр ажил хэргийн асуудлын хүрээнд харилцахдаа төрийн албан ёсны хэлээр харилцах хэвшлийг бий болгож ажилдаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

Ордны нийт ажиллагсдын компьютерийн мэдлэгийг дээшлүүлэх, бичиг хэргийн хөтлөлтийг стандартын түвшинд хүргэх, интернетийн орчинд ажиллаж мэдээлэл олж авах чадварийг нэмэгдүүлэхийн тулд компьютерийн сургалтыг долоо хоног бүрийн лхагва гарагт зохион байгуулж байна. Уг сургалтыг Цахим ном-Мэдээллийн танхимын номын санч мэдээллийн ажилтан Н.Ганзориг, бичиг хэргийн ажилтан Г.Уянга нар удирдан зохион байгуулж байна.

2014 оны 03-р сарын 14-16-ны өдрүүдэд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Аймгийн Засаг даргын тамгын газраас хамтран зохион

байгуулсан “Бодлого боловсруулалт, хэрэгжилтийг төлөвлөх” сэдэвт 20 цагийн сургалтад тус ордны захирал Л.Мөнхбаатар хамрагдаж төгссөн.

Захирал Л.Мөнхбаатар, ахлах номын санч Т.Цэрэннадмид, номын санч Н.Сэлэнгэ нар 2014 оны 05 дугаарсарын2-4-нийөдрүүдэдУБ хотноо зохион байгуулагдсан “Үндэснийбичигүсгийн баяр-2014” арга хэмжээнд оролцож, Үндэсний номын сан дээр зохион байгуулагдсан “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлье” сэдэвт хэлэлцүүлэг, номын сангийн “Monbiblio” программын сургалт, Улаанбаатар хотын төв номын сан дээр зохион байгуулагдсан номын санчдын сургалтад тус тус оролцлоо.

ХНО-ны нийт номын санч, ажиллагсдад зориулан Монгол хэл, бичгийн танхимын номын санч-мэдээллийн ажилтан О.Даваасүрэн “Эсээ хэрхэн бичих вэ”, Математикийн танхимын номын санч-мэдээллийн ажилтан Г.Гэрэл “Тайлан бичих арга зүй” сэдэвт илтгэлүүдийг бэлтгэж ажлын байран дээр ажиллагсдад сургалт явуулав.

Дархан-Уул аймагт Орчин үеийн номын сан үүсч хөгжсний 50 жилийн ойг тохиолдуулан зарласан “Ном унших орчин үеийн чиг хандлага” сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд номын санч Ч.Буяннэмэх,Н.Сэлэнгэ, Т.Цэрэннадмид нар материалаа хүргүүллээ.

2014.09.19-20 нд Монгол улсын хэмжээнд 16 дахь удаагаа зохион байгуулагдаж буй “Үндэсний номын баяр”-т тус ордны захирал Л.Мөнхбаатар оролцов.

6.Мэдээлэл, сурталчилгааны талаар:

Хүүхдийн Номын ордны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хүүхэд багачуудыг номын сангийн үйлчилгээнд хамруулах зорилгоор “1000 айл” аяны үйл ажиллагааг Дархан сумын нийт багуудын айл өрхүүдэд зохион байгуулж, сурталчилгааны материал тараав. Үүнд нийт 18 багийн 1463 айл өрхүүдэд мэдээллийн хуудас түгээсэн байна. Энэ ажлыг зохион байгуулахад айл өрхүүд эзэнгүй, хүүхэдгүй, нохойгоо хорихгүй гэсэн хүндрэл бэрхшээлүүд гарсан. Нийт 3500 сурталчилгааны материал хэвлэгдсэнээс 870 үлдсэн байна. Эдгээр үлдсэн материалуудыг ЕБС-иудын нийт ангиудад сурталчилгааны зорилгоор тараасан байна.

Тайлангийн хугацаанд ЕБС-ийн 12 ангийн 400 гаруй сурагч, СӨБ-ын 12 байгууллагын 32 ангийн 700 гаруй хүүхэд, 2 албан байгууллагын 12 насанд хүрэгчид, удирдах дээд байгууллагын / ССАЖЯ-ын номын сангийн мэргэжилтэн, Үндэсний болон хотын номын сангийн удирдлагууд, 21 аймгын номын сангийн эрхлэгч нар, Аймгийн ЗДТГ , сумын багын дарга , ССАЖГ-ын мэргэжилтэн нар гэх мэт/ төлөөлөл, нийт 1500 гаруй үйлчлүүлэгчийг номын сантай танилцуулж, чанга уншлага хийх, цахим ном сурталчилах зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

Соёлын байгууллагуудын нээлттэй хаалганы өдрөөр Дархан захад ажиллаж, ард иргэдийн санал хүсэлтийг авах зорилгоор Дархан захад ажилладаг иргэдийн дунд 8 асуулттай санал асуулага явуулсан. 15-с дээш насны хүмүүсийг хамруулсан. Нийт 200 хүн оролцохоос 58 нь хамрагдаж, 29%-тай санал асуулганд хариулсанбайна.

7.Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийтийн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлэх зорилгоор ССАЖ Газраас уламжлал болгон зохион байгуулдаг “Мөнгөнөвөл-Салхины амт” цасны баярын арга хэмжээнд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож, уралдаан тэмцээнүүдэд тасралтгүй оролцов.

04-р сарын 05-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан “Өглөөний нарны алхалт” арга хэмжээнд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцлоо.

2014 оны 05-р сарын 21-ны өдөр “Улаан-Үд- Дарханхотуудынэдийнзасаг, соёлын өдөр-2014” үйлажиллагааныхүрээнд зохион байгуулагдсанУлан-Үдэ, Дархан хотын удирдлагууд, хүүхэд залуус, ахмад настан, урлаг спортынхон, төрийн байгууллагын700 гаруй хүний төлөөллөөс бүрдсэн Найрамдлын жагсаалд байгууллага хамт олноороо оролцлоо.

2014.05.24-ний өдөр Аймгийн ССАЖГ, ЭМГ санаачлан зохион байгуулсан “Соёлтой хотын эрүүл иргэд” бүх нийтийн биеийн тамирын арга хэмжээнд байгууллага хамт олноороо оролцож, ажлын байранд хийх дасгал, хийн дасгал зэргийг суралцан, бүх нийтийн гүйлтэнд оролцож, артерийн даралт, биеийн жингийн индекс, бүсэлхийн тойрог тодорхойлох зэрэг эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа.

8.Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

2013 оны жилийн эцсийн болон 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, хөрөнгийн тайлан татварын болон НДШ-ийн тайлан гаргаж, ССАЖГ Төрийн сан, Нийгмийн даатагалын хэлтэс, Татварын хэлтэс аймгийн өмчийн мэргэжилтэн зэрэг газруудад өгсөн.

Номын санчид ,ажилчдын цаг ашиглалтын бүртгэлийн тооцоо хийж нийт ажилчдын цалинг тухай бүрд нь хугацаанд нь олгохын зэрэгцээ сар бүр төсвийн зарцуулалтын тайланг тухайн харьяалагдах байгууллагуудад өгсөн. Хөрөнгийн зарцуулалтанд тогтмол хяналт тавьж, хагас жилээр номын тооллого хагас бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж сар бүрийн тогтмол зардлын болон бусад зардлын гүйлгээ хийж байв.

2015 оныбайгууллагынтөсвийнтөслийггаргажССАЖГ-т хүргүүлсэн.
2014 оны жилийн эцсээр тогтмол болон урсгал зардлын өр авлагагүй гарсан.

Хөрөнгө:
Төсвийн хөрөнгөөр: 5050,9 төгрөгний ном, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Ном” хөтөлбөрийн хүрээнд Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхим тохижуулахад 1556,5 төгрөгнйи тавилга эд хогшил, 141,5 төгрөгний ном 302.0 төгрөгний эргэлтийн хөрөнгө худалдан авсан байна.
Хандиваар:. Хандиваар нийт 1.976.960 төгрөгний 280 нэрийн 390ширхэг ном хүлээн авсан байна.
Урьд оны төсвийн хэмнэлтээр: буцаан олгогдсон 3553,9төгрөгийг 559.6 төгрөгийг ном, 1808,6 төгрөгийг тавилга эд хогшил, ажилчдын цалингийн урамшуулалд1185.7 төгрөгийг зарцуулсан.

9.Бусад ажлын талаар:

Тохижилт үйлчилгээ:

- 201, 202, 103 тоот танхимд 28 ширхэг гэрлийн шил сольсон.
- Ордны төв хаалганы цоожыг засч янзалсан.
- 2 давхрын коридор, 102 тоот танхимын тааз нурсныг заслаа.
- Ордны бүх дүүжин таазанд урьдчилсан үзлэг хийж нийт 78 ширхэг суларсан бэхэлгээг шинэчилж сольсон байна.
- 103 тоот танхимд -4, 301 тоот танхимд -3, 202 тоот танхимд -6, 104 тоот танхимд -4, нийт 17 ширхэг хөшиг шинээр тогтоож бэхлэв.
- 103 тоот танхимын пар, хэвтээ турбаг будсан.
- Хайлаас моднуудыг 2 удаа хайчилж, заслаа.

- Портер элс татан авчирч, гараашын хананд шавардлага хийв.
- Ордны үүдний саравчны дээврийг буулгаж, шинэчлэн янзлав.
- Зулзагын голын нүүдлийн номын сангийн байранд засвар хийв.
- Гараашийн дээвэрт цементэн хучилт хийлээ.

Сантехник, засварын ажлын талаар:

- 1 давхрын 00-ын өрөөний халуун усны труба задарч, пойлуурын өрөөнд труба цоорсныг засч янзлав.
- 1-3 давхрын жорлонгийн почки, суултуурыг шинэчилж сольсон.
- Зулзагын голын нүүдлийн номын сангийн байрны гэрлийн суурийг шинэчилж, нийт 9 ширхэг потрон суурьлуулсан.
- 2 давхрын коридорт 1, 202 тоот танхимд 7 разетка шинээр суурьлуулж, цахилгааны холболт хийв.
- Талбайн гэрэлтүүлгийн суурь хугарч унасныг засч янзлав.
- 6 дугаар сарын 01-03 хүртэлх хугацаанд зулзагын голын зуслангийн байранд их засвар хийсэн.
- Мод бут тэгжилж, зэрлэг зулгаасан.
- 2 давхрын коридор -1, 202 тоот танхим-1, 203 тоот танхим-1 ширхэг цонхны портчикны нугасыг шинэчилж солив.
- 1 давхрын 00-ын өрөөнд тосгуурын крантны уян хоолой, босоо трубанд шинээр крант хийв.
- Талбайн гэрэлтүүлэг засч янзлав.
- Хашааны урд талын ёроолын өвсийг зулгааж, цэвэрлэв.
- 202 тоот танхим, 2 давхрын коридор, 102 тоот танхимын таазыг сэлбэн заслаа.
- 202 тоот танхимд 3 ширхэг разетка шинээр тавьж, цахилгааны холболтыг хийв.
- 1-3 давхрын 00-ын коридорын гэрлийн монтажыг засч асдаг болгов.
- 201, 302 тоот танхим, 1 давхрын өдрийн гэрлүүдийг сольж тавив.
- Пойлуурын минометрийг авч баталгаажуулж тавив.
- Гадна хаягийг шинэчилж сольж тогтоов.

Автомашины үзлэг, оношилгоо, засвар үйлчилгээ:

- Автомашиныг авто тээврийн байгууллагаас жил бүр шалгадаг үзлэг оношилгоонд бэлдэж оруулсан.
- Автомашины найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор шаардлагатай тос тосолгоо, засвар үйлчилгээг хийсэн.

- Уншигчыг үнэмлэхжүүлэх ажлын хүрээнд эхний хагас жилд 1740 ширхэг үнэмлэх шинээр хэвлэн гаргалаа.
- Төрөлжсөн танхимуудын үүдний хаяг, танилцуулгыг шинээр бэлтгэж тавьсан.
- Интернетийн хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар холбогдох газарт хүсэлт илгээсэн боловчтодорхой шалтгааны улмаас хойшлогдсон
- Их цэвэрлэгээ, хурал цуглааны хуваарь боловсруулж, баталгаажуулав
- Өмчийн хөдлөл, өөрчлөлтийн тайлан гаргав.

Тулгамдаж буй асуудал:

✓ Номын санг цахимжуулах;

- ✓ Явуулын болон нүүдлийн номын сангийн үйлчилгээг өргөтгөхөд бензин шатахууны зардал төсөвт тусгагдаагүй түүнийг хэрэгжүүлэхэд орон нутаг дэмжлэг үзүүлэх;
- ✓ СОТ-ын ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллээр үйл ажиллагаагаа сурталчлах зардал байдаггүй;

Дорноговь аймгийн Төв номын сангийн

2014 оны үйл ажиллгааны тайлан

2015.01.07

Зорилт	Биелэлт
Уншлага үйлчилгээнд шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлж, тогтмол хэвийн явуулна.	1. Номын сангийн Lib4U программыг нэвтрүүлж нийт номын 40% -ийг оруулаад байна. Энэхүү программийг нэвтрүүлсэнээр уншигч үйлчлүүлэгчдийнхээ цаг хугацааг хэмнэж, номын санчдын бүртгэл хөтлөлт цахимжих юм. 2. “Дорнын чимээ” аймгийн зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд АУЗ Б.Догмид, СГЗ Ш.Гүрбазар, Л.Одончимэд, МЗЭ-ийн гүйцэтгэх захирал Г.Мөнхцэцэг тэргүүтэй 30 гаруй зохиолчид оролцлоо. 3. ШШГАлбаны Цагдан хорих байранд хүмүүжиж байгаа иргэдийн дунд Хайртай Эжийдээ /ханьдаа, эгчдээ/ хэлж чадаагүй, хэлэхийг хүсдэг сэтгэлийн нандин үгсээ хэлэх боломжийг олгох зорилгоор “Захидлын уралдаан” зарлан дүгнэж Дурсамж, бэлэг бэлгийн дээд номоор шагнаж урамшуулан уралдаанд ирүүлсэн захидлуудыг канондон авч архивласан. /Уралдаанд 9 хүн оролцож захидлаа ирүүлсэн/ 4. Хүүхдийн уншлагын танхим нь “Нүүдлийн номын сан”-г 5, 2, 6-р цэцэрлэг болон 5, 2-р сургуульд нийт-175 номоор үйлчилж, нүүдлийн номын сангийн санал сэтгэгдлийн дэвтэр гарган ажиллаж байна. Мөн гэрээр ном олгох үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж нийт-20 ширхэг ном олгосон 5. Хүүхэд залуус, олон нийтэд ном унших соёлыг сурталчлах, ном унших урлаг, унших явц, арга ухаан зэргийг таниулах зорилгоор уншигч оюутан сурагчдыг католог картын сантай танилцуулан катологоос хэрхэн яаж унших сэдвээ сонгох унших талаар зөвлөж ажилласан. 6. Үндсэн фондын шинээр ирсэн номыг Аймгийн Тамгын газар, Иргэний бүртгэл мэдээллийн төв, Архивын ажилтан албан хаагчдад танилцуулж шинэ номын мэдээллийг тарааж сурталчилсан.

	7. Хүүхэд багачуудыг бие хүн болон төлөвших, мэргэжил сонгох, эрүүл ахуй, гоо зүйн мэдлэг, хүмүүжил олох, ном унших, номыг эрхэмлэх үзлийг төлөвшүүлэх, туслах зорилгоор 11-р анги төгсөгч уншигч хүүхдүүдтэй харилцан ярилцаж ЭЕШалгалтанд бэлтгэх булан гаргаж ажиллуулсан. 8. Хүүхдийн уншлагын танхим нь “Ном хөтөлбөр”-ийн хүрээнд хүүхэд багачуудын заавал унших номын жагсаалтыг интернэтээс татан авч Үндсэн фондонд байхгүй 5 номыг ГНО тасгаас солилцоогоор авч уншуулан үйлчилсэн.
Иргэд уншигчдын дунд ном унших хөдөлгөөн өрнүүлнэ.	1. Гэрээр ном олгох тасаг нь олон улсын хүүхдийн номын өдрийг тохиолдуулан хүн төрөлхтний оюуны сан хөмрөгт үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан хүүхдийн зохиолч Ханс Кристиан Андерсений тухай 3 хуудас, Дэлхийн номын өдрийг тэмдэглэдэг болсон тухай, Ном уншихын ач тус зурагт мэдээлэл, Хүүхдээ жилээр нь шинжихүй, Номын зорилготойгоор унших нь, Болор цом-2013, ЭЕШалгалтын хуваарь зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүрд нь уншигчдад хүргэсэн. Мөн УЦУОШГазар, ШШГАлба, ХХҮХ, Архивын тасаг, УБГазар, АЗДТГазрын албан хаагч, 1-11 жилийн 11г ангийн сурагчдад Зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн 65 албан хаагчийг шинээр картжуулж, 300 хүнд 700 гаруй ном олгож үйлчилсэн. 2. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан бага ангийн сурагчдад ном уншихын ач тусын талаар сурталчилан тойм яриа хийлээ. Уг арга хэмжээнд 2-12 жилийн Б.Мөнхцэцэг багштай 1а анги, Б.Болор-Эрдэнэ багштай 1г анги, Оюунчимэг багштай 2г ангийн 108 сурагч хамрагдсан байна. 3. ЭМШУИС-ийн 1-р курсын оюутнуудад тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номын сангийн үйлчилгээг сурталчилах, номын сангийн үйлчилгээнд шинэ оюутнуудыг хамруулах зорилгоор “Урилгат үйлчилгээ”-г зарлаж уг үйлчилгээнд 23 оюутан карт нээлгэн үйлчлүүлсэн. 4. Уншигчдын ном унших идэвх сонирхлыг дээшлүүлэх, дэмжих зорилгоор “Урамшуулалт үйлчилгээг” уншигч Аззаяа, Анхмаа, Чинбат, Буянчимэг нарт үзүүлж нэг удаагийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлснээр уншигчдын талархлыг хүртэв. 5. Номын баяраар “Тэргүүний уншигч” болох 1-р сургуулийн 8а-гийн сурагч Б.Есүхэй, 2-р сургуулийн $12^{б}$-гийн сурагч М.Хосбаатар нарыг шалгаруулан шагнал гардуулан өгсөн. 12 жилийн 1-р сургуулийн 2-а ангийн сурагч Ө.Одбаярт очиж тэргүүний уншигч тэмдэг

	гардуулан өглөө.Тэргүүний уншигч хүүхдүүдийн зургийг шинэчлэн хүндэт самбарт байрлуулж, хуучин зургийг архивлан авлаа. Номын баяраар 1-12 жилийн 3б ангийн сурагч Б.Анарт Тэргүүний уншигч тэмдэг гардууллаа. 6. 1-12 жилийн 5б ангийн Б.Дашдолгор багштай хамт олон “ Ном хөтөлбөрийн хүрээнд” Тусч аян зарлаж хүүхдийн номын санд 5 ширхэг цавуу, ОО-н утас-4, бичгийн цаас 1 боодол, ватом цаас-3, тэвнэ-4, кардон цаас-5 ширхэг цуглуулж хандив өргөсөн юм. Энэхүү үйл ажиллагааг номын сангийн сайтад оруулан талархалын сэтгэгдэлүүдийг авч байлаа. /Материалуудыг ажилчдад тарааж өгсөн/ 7. 5-р сургуулийн Саранцэцэг багштай 2в ангийн хамт олонд “Хүүхдээ номонд хэрхэн дуртай болгох вэ” мөн бяцхан үлгэрч ярилцлага зохион байгуулав. 20 ширхэг номоор нүүдлийн номын сан ажиллуулан номын сангийн сайтад танилцуулга тавьсан 8. Хүүхдийн номын фондонд байхгүй 16 ширхэг номыг 5 сургуулийн Уранцэцэг багшаас номын солилцоогоор авчирж уншлага үйлчилгээнд 7 хоног чөлөөт сонголтоор гаргаж хүүхэд багачуудад үйлчлэв. /Номын сангийн сайтад танилцуулга тавьсан/ 9. Хүүхэд багачуудад өөрийн боломжоор тоглоом цуглуулж,7 хоногийн 5 өдөр өөрсдийн тоглоомтой ирж тоглоом тоглох өдөр болгон ажиллаж байна. Эр цэргийн баярыг угтан Ж.Дашдондогийн 25 номоор номын үзэсгэлэн гаргасан. Инээдмийн баярыг угтан “Инээцгээе номын үзэсгэлэн гаргасан./20/ номоор нийт-150 хүүхэд хамрагдсан. 10. 6-р цэцэрлэгийн Уртнасан багштай дунд ангийн 20 хүүхдэд болон 2-р цэцэрлэгийн ахлах ангийн хүүхэд багачуудыг номын санд урьж номын сангийн талаар танилцуулж, монгол ардын үлгэрээс уншиж, үлгэрийн баатруудыг нэрлүүлэн чанга уншлага зохион байгуулж номын сангийн сайтад танилцуулгыг тавьсан байна. 11. Номын баярыг угтан 4-12 жилийн 5-р ангиудаас нэг ангийг сонгон “Миний унших дуртай ном” сэдэвт бяцхан номын уралдаан зарлаж нийт 65 бүтээл оролцсноос 3 байр шалгаруулан хүүхэд багачуудыг шагнаж урамшуулан бүтээлээр нь үзэсгэлэн гаргалаа. 12. Манай цахим номын тасгаас өсвөр насны хүүхэд залуусыг номонд дуртай, сонирхолтой болгох алдарт зохиолчдынхоо намтар түүх, гайхалтай зохиолуудтай танилцуулах, хамгийн их борлуулалттай шилдэг номыг уншуулах, тэдний амьдралд ирээдүйд хандив болохуйц

	оюунд нь хөрөнгө оруулах зорилгоор "Номын амт" тойм яриаг Б.Шүүдэрцэцэгийн Домогт Ану хатан, Ц.Оюунгэрэлийн Америкт суралцсан тэмдэглэл, Р.Чойномын намтар уран бүтээлээр слайд бэлдэн 1-р сургуулийн 10-р ангид тойм яриаг амжилттай хийлээ. 13. Мэргэжлийн онцлог, номын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг бусдад сурталчлах зорилгоор "Мэргэжил бүхэн сайхан" хишиг өдрийг 3-р сарын 6-7-ны өдрүүдэд 5-р цэцэрлэгийн хамт олонтой зохион байгууллаа. Уг үйл ажиллагаатай уялдуулан хоёр байгууллагын хамт олныг танилцуулах тэдний хамтын ажиллагааг сайжруулахаар хөгжилтэй буухиа тэмцээнийг санаачлан тэмцээний удирдамж, тэмцээний төрлүүдийг боловсруулан бэлдэж тэмцээнийг амжилттай явууллаа. Амьд цэцэг, номыг цэцэрлэгийн хамт олонд гардуулан өгсөн байна. 14. Мөн 5-р цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлэгт багшилж тэдэнд ном наахыг зааж өгч хамтдаа номоо сэлбэн зассан. Баримлын шавраар тэмээ хийхийг зааж, эрх бяцхан хулгана хэмээх үлгэр уншиж өгч үлгэрийн утга санааг тайлбарлан өгсөн. 15. 1-р 80 айлын айл өрхүүдэд сонсдог ном гэрээр олгох үйлчилгээг зарласаны хүрээнд 43 тоот айлд нэг үлгэрийн CD-г 3 хоногийн хугацаатай цэцэрлэгийн насны Ган-Эрдэнэ хүүд хүргэж өглөө. 16. Ахмад настан уншигч үйлчлүүлэгчдээ номын санд ирэх ном унших идвэх санаачлагыг дэмжих, өрнүүлэх үүднээс "Номтой богц" явган аялал хийлээ. Аялалын хугацаанд их хөлгөн судар Ганжуур, Данжуур, Сүмбэн хэмээх судруудыг өртөөчлөн үүрч гороолон явж буян хураалаа. Аялалын явцад номын үзэсгэлэн гаргаж, АХА тэмцээн, азын сугалаа явуулж 4 азтанг шалгаруулан урамшууллаа. 17. 12 жилийн 2-р сургуулийн 3б ангийн хамт олонд цэцгийн тухай номоор үзэсгэлэн гаргав. Үзэсгэлэнгийн үеэр цэцэг тарих, арчлах талаар зааж өглөө. 18. "Нэг минут-нэг ном" үйл ажиллагаа. Тунгалагтуяа багштай өдөр өнжүүлэх төвийн хүүхдүүдэд номын тухай яриа таниулага хийлээ. Энэ үеэр хүүхдүүдэд үлгэр уншиж өгч, сонирхолтой сонин содон зүйлүүдийн талаар ярьж өглөө. Номоо хэрхэн шинээр нь хэрэглэж болох, хуудсыг гэмтээхгүй, халтар болгохгүй байх гэх мэт аргуудыг зааж өглөө. Энэ үеэр хүүхдүүдийн дунд "Нэг минут – Нэг ном" тэмцээн явуулж хөгжилдүүллээ. Тоглоомын дүрэм "Нэг минут Нэг сая" шоуны дүрмээр явуулсан болно. 5 настай Мөнх –Од түрүүлж үлгэрийн

	номоор шагнууллаа. 2-р байранд Төгөлдөр орж мөн үлгэрийн номоор шагнууллаа. Тунгалагтуяа багштай цаашид хамтарч ажиллах талаар ярьж тохирлоо. 5ш үлгэрийн ном хүүхдийн уншлагын танхимаас авч 5 хоногийн хугацаатай өглөө. 19. Дорноговь аймгийн ЗДТГазраас зохион байгуулж байгаа "Монгол тэмээ" арга хэмжээг дэмжиж энэ аяны хүрээнд "Тэмээ" сэдвээр 7-12-р анги, цэцэрлэгийн насны хүүхдүүдэд гар зургийн уралдаан явууллаа. Гар зургийн уралдааныг дүгнэж байр эзэлсэн хүүхдүүдийг шагнаж урамшуулав. 20. **"Цахим номын сан аялж эхэллээ"** ажлын хүрээнд: Сайншанд сумын 5-р цэцэрлэгт 9ш бүтээлийг 14 хоног, Халамж үйлчилгээний хэлтэст 5ш бүтээлийг 14 хоногийн хугацаатай аялуулав. Мөн ХААН банкны хамт олон, Асрамжийн газар буюу НХҮХэлтэст Сонсдог номыг аялууллаа.
Эх хэл үндэсний зан заншлыг хүүхэд багачуудад уламжлуулах талаар арга хэмжээ зохионо	1. 2-р сургуулийн 3б ангид "Монгол гэрийн эзэгтэй", "Монгол хүний гэрт суух суудал", "Цай барих ёс" сэдвээр хичээл заан хүмүүжлийн ажил зохиож ангийн хүүхдүүдийг 4 баг болгон хувааж уг сэдвүүдээр өрсөлдүүлэн дүгнэж түрүүлсэн багийг өөрийн зүгээс үлгэрийн номоор шагнаж урамшууллаа. 2. Монгол ардынхаа ёс заншил, өдөр тутмын зан үйлийг хүүхэд ахуй насанд нь суулгаж өгөх, тэднийг монгол ахуй соёлтой танилцуулах зорилгоор 2-р сургуулийн 3а ангид ёс заншил сэдвээр хүмүүжлийн ажил зохион байгуулж хүүхдүүдээр биечлэн хийлгэж зааж өглөө. Нэг үлгэрийн ном ангийнх нь номын санд хандив болгон анги удирдсан багшид нь өглөө.
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон иргэдэд ном хүргэж уншуулах	1. Аймгийн "Нийгмийн халамж үйлчилгээний төв"-өөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг авч хөгжлийн бэрхшээлтэй 1-р багийн Б.Аюушмаад гэрээр нь 5 ширхэг ном хүргэж өгөв. 2. Цахим номын үйлчилгээгээр "Халамж үйлчилгээний хэлтэс"-т 5ш бүтээлийг 14 хоногийн хугацаатай аялуулав.
Уншигчдын оюуны хэрэгцээг хангахуйц шинэ болон ховор хуучин номуудыг худалдаа	1. Аймгийн Төв номын сан нь фондын номыг эргэлтэнд оруулах зорилгоор уншигчдын лавласан номуудыг каталогоос хэрхэн хайж олох талаар мэдээлэл өгч , нийт 360 ширхэг номыг захиалгаар гаргаж ажилласан байна. 2. Номын сангийн номын сан хөмрөгийг нэмэгдүүлэн, шинжлэх ухааны салбаруудын 256 ш

болон хандивын хэлбэрээр авч баяжилт хийнэ.	шинэ номыг төсвийн хөрөнгөөр бүгд 3.7 сая гаруй төгрөгөөр худалдан авч баяжуулалт хийж, Шинэ ном болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 58 удаа зохион байгуулж , 2982 ном хэвлэлийг сурталчилсан байна . Мөн хандиваар 103 ширхэг 1086160 төгрөгний номоор фондын баяжилт хийсэн байна. 3. Хуучин номын хандив цуглуулах тухай аймгийн FM101.5 радио болон DSB телевизээр зар түгээж 70 ш орчим хандивын ном цуглараад байна. 4. 2014 оны 12 дугээр сарын 31-ний байдлаар 1438 хүнд уншигч карт нээж, давхардсан тоогоор 18695 хүнд үйлчилж, 29362 ном хэвлэл , лавлагаа- мэдээллээр үйлчилсэн байна. 5. Иргэдийн хөгжил төв нь иргэдийн хөгжих, мэдээлэл солилцох, сурч мэдэх ая тухтай таатай орчиныг бүрдүүлж, нээлттэй төв болон ажилласнаар үйл ажиллагаа нь тогтмолжиж, Иргэдийн хөгжил төвийн үйлчилгээнд олон шинэлэг хэлбэрийг санаачилан нэвтрүүлснээр , үйлчлүүлэгчийн тоо байнга өсч жилийн байдлаар 3100 хүнд үйлчилж , 779,9 мянган төгрөгний орлого оруулсан байгаа нь байгууллагын жилийн орлогын төлөвлөгөөг 10 дахин давуулан биелүүлсэн сайхан амжилт гарган ажиллаж байна 6. Иргэдийн хөгжил төвийн үйлчилгээнд “ Хичээлийн компьютер” – үнэ төлбөргүй үйлчилгээг нэвтрүүлж , оюутан , сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд , уншигчид суралцах, хичээлээ хийх бололцоогоор ханган ажилласнаар 58 хүн 188 цаг сууж, хичээлээ хийж, компьютер сурч , юм шивсэн байна. “Хичээлийн компьютер” –ээр үйлчлүүлэгчдийн тоо урд сарынхаас 3 дахин өссөн байгаа нь үйлчлүүлэгчдийн хэрэгцээтэй, сэтгэлд нийцсэн үйлчилгээ болсны бодит үр дүн харагдаж байна. 7. “Хичээлийн компьютер”-ийн үйлчилгээг өргөтгөж, интернэтэд холбосон нь хүүхдүүд шивсэн зүйлээ mail хаягаараа авах боломжийг бүрдүүлсэн. Цаашид үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах зорилгоор интернэтийн 15 ширхэг компьютеруудыг шинэчлэх, чихэвч, флаш, мемори карт зэргээр хангах, интернэт танхимыг камержуулах зайлшгүй хангах шаардлагатай байна. 8. Иргэдийн хөгжил төвийн ая тухтай, тохилог орчинг бүрдүүлэх, үйлчлүүлэгчдийн соёлтой үйлчлүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор нэг ээлжиндээ 15 хүн гадуур хувцасаа өлгөж орох боломжтой хувцасны өлгүүрийг шинээр хийж, хувцасаа өлгөж , орох талаар санамжуудыг бичиж орох хаалга, мэдээллийн самбарт ил бичиж хадаж, үйлчилгээний цагийн хуваарь, Хичээлийн компьютерийн үйлчлэх журам, бусад хаягуудыг шинээр хийж

	ил тод хадаж, үйлчлүүлэгчдийн дэг журмыг сайжруулж, “Соёлч үйлчилгээ” –г нэвтрүүлж эхлээд байна. 9. Иргэдийн хөгжил төвөөс ЭМШУИС -тай хамтран иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “ Хөдөлгөөн – эрүүл мэнд”, байгууллагын захиргаатай хамтран “Зөв энерги”,”Монгол эх хэлээ зөв бичиж сурья” , “Гоо сайхан- амьдрах ухаан”, Мэргэжлийн хяналтын газартай хамтран ” Дотоод хяналт зохион байгуулах туай”, ”Тамхи- Эрүүл мэнд”,”Үйлчилгээний байгууллагын дотоод орчны бохирдлоос сэргийлье” – зэрэг сэдвүүдээр сургалтуудыг 6 удаа зохион байгуулав. 10. Иргэдийн хөгжил төвөөс зохион байгуулсан 2014 онд 13 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 97 ажилчид , 21 удаагийн арга зүйн зөвлөгөөнд давхардсан тоогоор 96 ажилчид хамрагдсан байна. Энэ жилд бүгд сургалт, арга зүйн зөвлөгөөнд давхардсан тоогоор нийт 193 ажилчин хамрагдсан нь энэ онд нэг ажилчин дундажаар сургалт, арга зүйн зөвлөгөөнд 12 удаа хамрагдсан үр дүн гарч байгаа урд байгаагүй амжилт гарч байна
Номын сангийн барилгын дээврийн их засварын зураг, төсвийг хийлгэнэ.	11. Аймгийн МХГ-ын байцаагчаар дүгнэлт гаргуулан, Монгол улсын тэргүүлэх төсөвчин Х.Оюунчимэгээр зураг төсөв хийлгэж “Аймгийн Төв номын сангийн өрөөнүүдийн тааз, төмөр дээврийн ажлын төсвийн тооцоо”-г гаргуулсан. /Энэ ажилд 28 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан/ 12. Өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан 83 м гялгар хулдаас аван дээврийн доторхыг хулдааслан, бороо орох нүх сүвийг бөглөсөн.
Номын фондыг гал, усны аюулаас хамгаалах хамгаалалтыг сайжруулан, хамгаалалтын системтэй болгоно.	1. Онцгой байдлын хэтсийн дарга А.Ганжаргалд 2014.03.11ний өдрийн 23 дугаар тоот, Аймгийн Мэргэжлийн Хяналтын газарт 2014.03.17-ны өдрийн 26 дугаар тоотоор “Цахилгааны монтаж шалган дүгнэлт гаргуулах тухай” хүсэлт явуулсан. МХГ-ын 2013 онд гаргасан дүгнэлтийг үндэслэн МУ-ын мэргэшсэн төсөвчин Д.Доржпүрэвээр “Номын сангийн барилгын цахилгаан угсралт засварын ажлын төсөв” гаргуулсан. /Энэ ажилд 10 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан/ 2. Энэхүү хүсэлтийг ССАЖГазраар дамжуулан Яаманд уламжилж, ирэх оны төсөвт шаардлагатай мөнгөн хөрөнгийг тусгаж өгсөн гэсэн бичиг ирээд байна.

Аймгийн Төв номын болон сумдын номын санд шаардлагатай байгаа электрон каталогийн программыг нэвтрүүлж эхэлнэ.	1. Номын сангуудын мэдээллийн технологийг сайжруулах зорилгоор ССАЖЯ, СУИС, ШУТИС –тай хамтран “Номын сан, соёл урлагийн байгууллагын тайлангийн Monbiblio програм”-ыг аймгийнхаа 13 сумдын номын сангийн компьютерт суулгаж , Номын сангийн тайлан, лавлагаа, тооллого, Номын сангийн уншигчийн бүртгэл, ном олголтын програм, , Ном бүрдүүлэлт, захиалга, Ном электрон катологт оруулах ажлыг зохион байгуулж, 2014 оны байдлаар 12587 гаруй ном оруулсан байна. Дэлгэрэх сум бүх номоо буюу 5700ш ном оруулсан амжилттай байна. 2014 ондоо бүх номоо шивж оруулах зорилт тавин ажиллаж байна. 2. Сумдын номын сангуудын 1,2-р улиралд Monbiblio программд оруулсан номын байдалтай танилцаж, ССАЖЯамны Вэб сайтад мэдээ нь тавигдаагүй байгаа Айраг, Иххэт, Өргөн сумын номын санч нартай утсаар ярьж, мэдээгээ ирүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгсөн. 3. Сумдын номын санчдад номын сангийн програмыг нэвтрүүлэх ажил мэргэжил арга зүйн зөвлөгөө 3 удаа өгч ажилласнаар Дорноговь аймгийн бүх сумдын номын сангууд одоогоор ном хэвлэлийг электрон катологт оруулж эхлээд байна 4. Өргөн ,Улаанбадрах, Айраг ,Даланжаргалан, Алтанширээ сумдын номын санд аймгийн төв ноын сангийн номын санчид өөрийн биеэр очиж, Сумын номын сангийн номыг Openbiblio программд электрон катологт оруулсан байдалтай танилцаж, номоо электрон катологт оруулж дуусгах, бар код хэвлэх, наах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн 5. Эрдэнэ , Мандах, Иххэт, Даланжаргалан, Зүүнбаян, Дэлгэрэх,Айраг зэрэг сумын номын санчид аймгийн төв номын сан дээр өөрийн биеэр ирж, сумдын номын сангийн Openbiblio программд ном хэрхэн оруулах , шинэ принтер өгч интал суулгаж бар код хэрхэн хэвлэх, наах талаар арга зүйн зөвлөгөө авсан. 6. Электрон каталогийн программ болох Lib4U-г авч 11 сарын 01-ний байдлаар 10 мянган номыг тус программд оруулсан байна. Энэхүү программ нь номоо бүрэн шивж оруулсанаар уншигчийг бүртгэх, номоо хайх, мөн номын санчдын анхан шатны бүртгэлүүд бүгд энэ програмаар хөтлөгдөх юм. Цаашид номын тооллогыг электрон хэлбэрээр явуулах гэх мэт цаг хугацаа хэмнэсэн олон давуу тал гарч ирж байгаа юмаа.

ДОРНОД АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Зорилго: Мэдээллийг нээлттэй хүргэх,түшиц газар.
Зорилт: Номын сангийн үйлчилгээг нэгжид хүргэх, каталог ном зүйг сайжруулах

Нэг Төрөөс баримтлах соёлын бодлогыг хэрэгжилтийг хангах, байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд.

1. Монгол улсын хосгүй соёлын өв ЮНЕСКО-гийн “Дэлхий дурсамж” олон улсын өвд бүртгэгдсэн “Лу алтан товч” судрыг Дорнод аймгийн оюуны брэнд болгосон билээ. Уг судрыг 9 эрдэнээр чимэглэх төсөв зургийг гаргаж аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн 2015 оны төсөвт 9 сая төгрөгийг батлуулаад байна.

“Ном хөтөлбөр”

Үндэсний зан заншил, иргэний нийгмийн соёлыг хамтад нь эзэмших чухал хэрэглүүр болох ном унших соёлыг дэлгэрүүлэх, бүтээлч хандлагыг бий болгох зорилгоор МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн дагуу “Номын баярын өдөр”-ийг 3 дахь жилдээ Аймгийн төв номын сан, Боловсролын газар хамтран олон нийтэд 2014 оны 09-р сарын 12-нд тусгаар тогтнолын талбайд зохион байгууллаа.

Номын баярын үйл ажиллагааг нээж Аймгийн Засаг Даргын орлогч М.Бадамсүрэн, Боловсролын газрын мэргэжилтэн Б.Эрдэнэтуяа, Аймгийн төв Номын сангийн захирал Ж.Цагаан нар үг хэлж мэндчилгээ дэвшүүллээ.

“Номын баярын өдөр”-ийн арга хэмжээнд 3,10-р цэцэрлэгийн бяцхан багачууд “Алтан загасны үлгэр”,”Туулайн байшин”,”Гурван тоорой” үлгэрээр таягт хүүхэлдэй, хуруун хүүхэлдэйн тоглолт, Шинэ-хөгжил цогцолбор сургуулийн сурагчид Д.Содномдоржийн “Норовын намтар” зохиолоор дүрийн тоглолтыг тус тус тоглож сонирхууллаа.

“Номын баяр-Номын чуулган”-ыг “Ном” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ЕБС, Цэцэрлэгүүдийн багш сурагчдын бүтээсэн бүтээлийн үзэсгэлэнгүүд, “Шинэ номын үзэсгэлэн”, “Хуучин номын үзэсгэлэн”, “Хамгийн олон уншигдсан номын үзэсгэлэн”, “Жижиг, том номын үзэсгэлэн”, “Номын үзэсгэлэн худалдаа”, “Дугуйтай аялал”, “Чихэртэй уншлага, ”Оюуны чихэр”, ”5 хором 5000” асуулт хариултын тэмцээн зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулсан нь уншигч иргэд багш сурагчдын сэтгэлд нийцсэн сайшаан үнэлсэн ажил болсон.
Номын баяраар айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгж бүрийг Номын сантай болох уриалгыг дэвшүүллээ.

Дугуйтай аялал:

Дугуйтай аялал номын богцоо алслагдсан багийн ард иргэд, албан байгууллага аж ахуйн нэгжийн уншигчдад захиалгаар 4 удаа 8 айлд 20 ном хүргэж ажиллалаа. Дугуйтай аяллын гарааг Номын баяраар аймгийн засаг даргын орлогч М.Бадамсүрэн хүүхдүүдийн хамт дугуй унаж номын богц үүрэн ном хүргэх аяллын гарааг эхлүүлээ. Дугуйтай аялалын багт номын сангийн идэвхтэн 18 уншигч хүүхдүүд 2-р багийн өндөр настан Н.Лхамдулам, Г.Гансүхийн гэр бүлд номын богцыг хүргэн очлоо. Энэхүү аяллыг 2 дахь жилдээ зохион байгуулж байна.

LIB4U NET VERSION номын сангийн цахим программд оросын уран зохиол, байгалийн шинжлэх ухаан, техник, анагаах, хэлний шинжлэх ухаан, 2012 ширхэг орос номыг оруулж бар код нааж тавиурт байрлуулсан..

Вэб сайт, Facebook-д зохион байгуулагдсан номын баяр, үндэсний бичиг үсгийн баяр,бэлэг бэлгийн дээд ном үзэсгэлэн худалдаа, дэлхийн хүүхдийн номын баяр, зохиолчдын шинэ номны нээлт, уран жиргээ, хүрэл тулга, уншигчдын бага хурал, үе, үеийн тэргүүний уншигчдын уулзалт,явуулын зөөврийн номын үйлчилгээ ”Номын хур” зэрэг соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж телевизүүдээр 11 удаа сурталчилан мэдээг тавьсан.

Сумдын номын сангийн цахим программыг хяналтад авч мэдээллийг ССАЖЯаманд дамжуулж байна. Нийт сумын хэмжээнд “Монбиблио” нэгдсэн программд 13966 ном оруулаад байна. ССАЖЯамнаас 13 сумын номын санд тус бүр номын тавиур 3 ш, каталогийн шүүгээ 1ш, сэтгүүлийн шүүгээ 1 ш нийт 34.419.671 төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн.

Уншлага үйлчилгээ, зөөвөр номын сан

Тайлангийн хугацаанд 3522 байнгын уншигч, /насанд хүрэгсэд 928, хүүхэд 2114/ 62222 ирцэд 93766 ном олгож, зөөвөр явуулын номын санг Сэргэлэн, Баян-Уул, Цагаан-Овоо, Баяндун, Гурванзагал, Чойбалсан сумын нийтийн номын сангуудад хүргэн, 0132 анги, Гаалийн газар, Эрүүл мэндийн газар, Цаг уурын газарт, ЕБС-ийн 5, 6, 8,12, Шинэ хөгжил цогцолбор сургууль, Шинэ зуун, МСҮТ, Политехникийн коллежид ном хур, номын элч явуулын үйлчилгээг хүргэн, АХА , “5 хором 5000” зэрэг асуулт хариултын тэмцээн уралдааныг зохион байгуулан номын сангийн үйлчилгээг хүргэснээр явуулын, зөөвөр номын сангаар нийт 35 сургууль цэцэрлэг, аж ахуй нэгжид 471 шинэ карт нээж 2939 хүнд 2659 ном олгож үйлчилсэн.

Уншигчдаас татгалзалын бүртгэлээр 83 номын захиалгын санал ирсэний 23 номыг худалдан авч 56 номыг Улаанбаатар хотын номын сан, сумдын номын

сангуудаас солилцоогоор авч уншигчдын хэрэгцээг хангаж ажиллалаа.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



Хүснэгтнээс харахад уншигч 1.5%-иар, ном олголт 3.8%, ирц 15.7%-иар өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Үлгэрийн цаг

“Үлгэрийн цаг“ уншлагыг 7 хоног бүрийн 2 өдөр зохион байгуулдаг. Энэ онд нийт 2089 хүүхдэд 100 удаа дүрстэй 1206 үлгэр уншиж өгсөн. Үлгэрээ сонсох гэж хүүхдүүд хүсэн хүлээдэг болсон. Бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохируулан Монгол ардын үлгэр, Сургамжит өгүүллэг, Хулан хэрээ чоно гурав”, “Цуутын цагаагч гүү”, ”Эвтэй 4 амьтан” Дэлхийн шилдэг үлгэрийг сонгон уншиж өгсөн. Ном хөтөлбөрийн хүрээнд 2,4,12-р цэцэрлэгийн ахлах, дунд, бага ангиуд анги хамт олноороо ирж үлгэр сонслоо.

Дүгнэлт:

- Номын элч, номын хур, дугуйтай аяллыг айл өрх, албан газар, сургууль цэцэрлэгүүдэд хүрч ажилласнаар номын сангийн хүрээ өргөжин, шинэ ном мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэн, уншигч сурагчдыг номтой нөхөрлүүлэн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чухал ач холбогдол өгч уншигч ном олголт ирц өссөн.

-Үлгэрийн цагийг тогтмол явуулснаар хүүхдийн ирц нэмэгдэж, цэцэрлэгийн багш нар хүүхдүүддээ үлгэр сонсуулахаар анги хамт олноор ирдэг болж номын сангийн уншигч нэмэгдсэн.

-Дугуйтай аяллыг зохион байгуулснаар айл өрхүүдэд байгаа өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өвдсөн хүмүүс хүссэн номоо захиалан унших боломж нээгдсэн.

Хоёр . Номын сангийн үлгэрчилсэн дүрэм

Лавлагаа ном зүй: Урлаг /85/, шинжлэх ухааны 381 номоор санамж өгөх ном зүй гаргасан. Уншигчдын асуусан мэдээллийг амаар 229 хүнд, бичгээр 217, номын сангийн цахим программаас 478 хүнд лавлагаа өгч, сэдэвчилсэн үзэсгэлэн 13 удаа, шинэ номын үзэсгэлэнг 7 удаа гаргасан.

Халхголын ялалтын цом-2014

Залуу үеийг цэрэг, эх оронч үзлээр хүмүүжүүлэх, улс түмний найрамдал энхтайван, эв нэгдлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, Монгол улсын Дорнод аймаг, домогт Халхын гол нутгийн нэрээр нэрлэгдэх урлагийн шилдэг бүтээл туурвих явдлыг хөхүүлэн дэмжих зорилгоор Халхын голын тулалдааны түүхт ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан “Халхын голын ялалтын цом-2014” яруу найргийн бүтээлийн үндэсний хэмжээний наадмыг ССАЖЯ, БХЯ, МЗЭ ,Дорнод аймгийн ЗДТГ, Утга зохиол нэгдэл хамтран 2014 оны 03-р сарын 18-наас 05-р сарын 18-ныг дуустал зохиолч яруу найрагчдын дунд орон даяар

зохион байгууллаа. Нийт 77 зохиолч, яруу найрагчдын 84 бүтээл ирсэн бөгөөд эхний шалгаруулалтанд шилдэг 25 бүтээл шалгарсан. Эцсийн шалгаруулалтын яруу найргийн наадам 2014 оны 06-р сарын 27-ны 12.00 цагт ХДТеатрт болж Аймгийн засаг дарга С.Ганбат, Ардын уран зохиолч Т.Галсан нар Дорнод аймагт анх удаагаа яруу найргийн наадмыг зохион байгуулж байгаад талархан зохиолч яруу найрагчдадаа амжилт хүсэн наадмыг нээлээ. Наадмын ерөнхий шүүгчээр Ардын уран зохиолч Т.Галсан, Утга зохиол судлаач МЗЭ-ийн шагналт зохиолч шүүмжлэгч Л.Хэрээ, ДДС-ийн багш хэл бичгийн ухааны доктор С.Алтанцэцэг, ДДС-ийн багш магистр Д.Оюунгэрэл нар шүүн явуулж наадмын эзэд тодорлоо. Утга уянга, гүн гүнзгий санаа агуулсан яруу найргийн бүтээлүүдийн дотроос МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ж.Нэргүйн уран бүтээл шалгарч тэргүүн байр эзэлж Халх гол ялалтын цом, Батламж 3.000.000 төг, Дэд байр Яруу найрагч О.Цэнд-Аюуш Батламж 1.000.000 төг, Гутгаар байр Яруу найрагч Жа.Баяржаргал Батламж 500.000төг, Болор цомын эзэн А.Эрдэнэ-Очир, Н.Сүхдорж, М.Саруулдалай, Н.Төмөртогоо, МЗЭ-ийн шагналт Болор цом наадмын 2 удаагийн дэд байрын шагналт Б.Мягмаржав, яруу найрагч Б.Энхжаргал нар тусгай байруудыг эзэлж Батламж 300.000 төгрөг шагнагдлаа. МУСГЗүтгэлтэн С.Оюун, яруу найрагч С.Чулуун, МЗЭшагналт Ц.Цэнд МЗЭ-ийн шагналт, М.Уянсүх, М.Орхонтуяа ,Г.Ишхүү, Э.Гантулга, Д.Батжаргал, МЗЭ-ийн шагналт Д.Жүгдэрбарам нарт Талархал гардууллаа. Батлан хамгааллын сайдын гарын бэлгийг Аймгийн засаг дарга С.Ганбат бусад оролцсон зохиолч, яруу найрагчдад гардууллаа.

Халх голын ялалтын цом -2014 яруу найргийн наадамд шалгарсан 25 яруу

найрагчдын бүтээлүүдийг Халхголын 75-н жилийн ойд зориулан гаргах номонд оруулах юм.

Дорнын их яруу найрагч Данзангийн Нямсүрэнгийн шүлгэн хөшөөний тохижилтын нээлт 2014 оны 06-р сарын 27-нд боллоо. Шүлгэн хөшөөний тохижилтийг Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хурал ивээн тэтгэж тохижуулж, хөшөөний нээлтийг хэрлэн сумын засаг даргын тамгын газрын дарга Б.Хасархүү, Утга зохиол нэгдлийг эрхлэгч Ц.Жамбалгарав нар нээн үг хэллээ.

“Халхын голын цадиг хууч” Номын нээлт:

Залуу үеийг цэрэг, эх оронч үзлээр хүмүүжүүлэх улс түмний найрамдал, энхтайван, эв нэгдлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, Дорнод аймаг домогт Халхын гол нутгийн нэрээр нэрлэгдэх урлагийн шилдэг бүтээл туурвих явдлыг хөхүүлэн дэмжих зорилгоор Халхын голын тулалдааны түүхт ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан “Халхын голын ялалтын цом-2014” яруу найргийн бүтээлийн үндэсний хэмжээний наадмыг ССАЖЯ, БХЯ, МЗЭ, Дорнод аймгийн ЗДТГ, Утга зохиол нэгдэл хамтран зохион байгуулж, Монгол найрагчдын дунд зарласан “Халх голын ялалтын цом-2014” яруу найргийн наадмын шилдэг бүтээлүүд “Халхын голын цадиг хууч” нэртэй ном Монгол,Орос 2 хэл дээр хэвлэгдэн гарлаа.

Номын нээлтийг Утга зохиол нэгдлийг эрхлэгч Ц.Жамбалгарав, Аймгийн төв номын сангийн захирал Ж.Цагаан нар нээж, Яруу найрагч н.Батжаргал яруу найргийн дээж өргөлөө.

“Гэрээр эмчлэх энгийн аргууд номын нээлт”:

Гэрээр эмчлэх энгийн аргууд номын нээлт 2014 оны 11-р сарын 28-ны 14.00 цагт Аймгийн төв номын сангийн хурлын танхимд номын нээлтээ хийлээ. Нээлтийн арга хэмжээнд АЗДТГазрын дарга П.Бат-Өлзий, Соёл, спорт аялал жуулчлалын газрын дарга Б.Чимэддорж нар нээн үг хэллээ.

Гэрээр эмчлэх энгийн аргууд ном нь түүний анхны уран бүтээл бөгөөд энэ номондоо гэрээр эмчлэх энгийн аргуудын талаар 28 зөвлөмжийг ард иргэд үйлчлүүлэгчдийнхээ хүсэлтээр уншигч олондоо оюуны их хөрөнгө оруулалт хийгээд байна. Номын нээлтэнд хүрэлцэн ирсэн уншигч олондоо эрүүл мэндийн сонирхолтой лекцүүдийг уншилаа.

“Хувь заяагаа сонгох нь” уншигчдын бага хурал

Хувь заяагаа сонгох нь XX зууны алдартай либерал үзэлтэй зохиолуудын нэг Мильтон Фридман, Рөүз Фридман “Хувь заяагаа сонгох нь” номоор “Уншигчдын бага хурал”-ыг 2014 оны 04-р сарын 28-нд аймгийн төв номын сангийн хурлын танхимд АҮЭХолбоо, Дэлгэрэх хөрөнгө оруулалтын клуб, аймгийн төв номын сан хамтран зохион байгууллаа.

Энэхүү уншигчдын бага хуралд аймгийн 10 багийн ажилгүй болон, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, аймгийн байгууллагуудын үйлдвэрчний хорооны тэргүүлэгчид нийт 42 хүн хамрагдсан байна. Лекцэнд Хөдөлмөрчдийг хэн хамгаалах вэ? АҮЭхолбооны тэргүүлэгч, 12-р сургуулийн үйлдвэрчний хорооны дарга Я.Алтанцэцэг, Хүмүүс

хоорондын харилцаа ба уламжлал ёс заншил МУБТАжилтан

Дэлхий хүүхдийн номын баяр:

Дэлхийн үлгэрийн хаан Дани улсын их зохиолч Ханс Крестианс Андерсений мэндэлсэн өдөр 4 дүгээр сарын 2-ныг Дэлхий дахинаа олон улсын хүүхдийн номын баярын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэгтэй холбогдуулан Хэрлэн сумын цэцэрлэгүүдийн дунд “Дэлхийн шилдэг үлгэр”-ээр дүрийн тоглолтын уралдааныг 2014 оны 04 дүгээр сарын 02 нд төв номын сангийн соёл олон нийтийн танхимд зохион байгууллаа. Тус уралдааны шагналын санг ХААН Банк ивээн тэтгэж хамтран ажиллаа.

Энэхүү үйл ажиллагааг 6-р цэцэрлэгийн бяцхан багачууд “Ном” дуугаар эхэлж Аймгийн төв номын сангийн захирал Ж.Цагаан, ХААН Банкны харилцааны менежер

Ц.Тунгалаг нар мэндчилгээ дэвшүүлж үйл ажиллагааг нээлээ.

Дүрийн тоглолтонд Хэрлэн сумын 2,4,6,8,11,12,14 Сэргэлэн багачууд нийт 8 цэцэрлэгийн 144 хүүхэд амжилттай оролцож, 14-р цэцэрлэг Нурефшан Чаглигову зохиол “Эмч зөгий зэн зэн” үлгэр 53 оноогоор тэргүүн байранд шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал 150.000 төгрөг, Дэд байр 2-р цэцэрлэг Андерсены “Ямх охин” үлгэр 52 оноогоор Өргөмжлөл, мөнгөн шагнал 100.000 төгрөг, 3-р байр 12-р цэцэрлэг Орос ардын үлгэр “Туулайн байшин” үлгэр 48 оноогоор Өргөмжлөл, мөнгөн шагнал 70.000 төгрөгөөр тус тус шагнагдлаа.

Ерөнхий шүүгчээр Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Гантуяа, шүүгч ХДТеатрийн драм ангийн жүжигчин Л.Амарзаяа, Шүүгч ХДТеатрийн драм ангийн жүжигчин С.Мөнхтөр нар шүүн явуулж дүрийн тоглолтыг 3 үзүүлэлтээр дүгнэж шалгаруулсан.

Үндэсний бичиг үсгийн баяр, зүүн бүсийн номын санчдын ажил мэргэжлийн өдөрлөг

Жил бүрийн 5 дугаар сарын 2 дахь долоо хоногийг Үндэсний бичиг үсгийн баяр” болгон тэмдэглэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 тоот зарлигийн дагуу Үндэсний бичиг үсгийн баярыг зүүн бүсийн номын санчдын ажил мэргэжлийн өдөрлөгтэй хамтатган 2014 оны 05-р сарын15,16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Үндэсний бичиг үсгийн баярын нээлт төв номын сангийн соёл олон нийтийн танхимд эхэлж аймгийн Засаг Даргын орлогч М.Бадамсүрэн, ӨМӨЗО-ны шинэ барга

баруун хошууны утга зохиолын холбооны дарга Тэгшжаргал Аймгийн засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтсийн дарга Н.Алтанцэцэг, ССАЖГазрын дарга Б.Чимэддорж, нар тууз хайчилан үйл ажиллагааг нээлээ. Нээлтэнд Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын төвийн болон сумдын нийтийн номын санчид, ӨМӨЗО-ны Шинэ барга баруун хошууны Уран бичлэгийн нийгэмлэгийнхэн, Үндэсний номын сан, ЕБС, Их дээд сургуулийн нийт 73 номын санчид, иргэд, оюутай сурагчид оролцлоо. Баярын нээлтийн ёслолын үеэр Сүхбаатар аймгийн номын санч Чандмань “Соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр шагнуулж, тэргүүний уншигч “Нацагдорж” тэмдэгээр шагнагдсан хүүхдүүдийн төлөөлөл зочдоос тэмдгээ гардаж авсан юм. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээнд ӨМӨЗО-ны Шинэ барга баруун хошууны Уран бичлэгийн нийгэмлэгийнхэн Уран бичлэгийн гайхамшиг үзэсгэлэн болон үзүүлбэр тоглолт, уран бичлэгээр бичиж сонирхуулсан юм. Мөн Үндэсний номын сангийн ховор номын үзэсгэлэн, Хэнтий Сүхбаатар, Дорнод аймгаас төрөн гарсан зохиолчдын бүтээлийн үзэсгэлэн, уран хайчилбарын зэрэг төрөл бүрийн үзэсгэлэн гаргасан. Арга хэмжээнд аймгийн засаг дарга 380000 төгрөгийн дамжлэг үзүүлсэн.

“Уран жиргээ” хүрэл тулга наадам:

Өсвөр үеийнхнийг Монгол хэлний үгийн арвин баялаг сантай танилцуулж, үгийн урлагийн гайхамшигт ертөнцөөр аялуулах, санасан бодсоноо үгээр бүтээж туурвих урлагт сургах, сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Хүрэл тулга” наадам 2 насны ангиллаар зохион байгууллаа. Сургуулийн дунд насанд:1-р байранд Баян-Уулын сургууль Ц.Батхүрэл, 2-р байранд 12-р сургууль Х.Дашдаваа, 3-р байранд Шинэ хөгжил цогцолбор сургууль Э.Эрдэнэхүслэн, Тусгай байранд Цагаан-Овоо сумын сургуулийн сурагч Н.Маралмаа, Тусгай байранд 12-р сургууль Б.Нармандах, Сургуулийн ахлах насанд: 1-р байранд 12-р сургууль Э.Батцэцэг, 2-р байранд Цагаан-Овоо сумын сургууль Ч.Бүжин, 3-р байранд Чулуунхороот сумын сургуулийн Б.Биндэръяа, Тусгай байранд Баян –Уул сумын сургууль Э.Энхманлай, Тусгай байранд Цагаан-Овоо сумын сургуулийн Н. Баярцэцэг нар шалгарч **Дорнод сонины нэрэмжит Хэвлүүхэн найрагч” шагналаар** Цагаан-Овоо сумын сургуулийн суралцагч Б.Уранчимэг тодорлоо. Мөн “**Уран жиргээ”** наадам 4 насны ангиллаар зохион байгуулж дүнгээ гаргаж шалгарсан сурагчдыг насны ангиллаар шагнаж урамшууллаа. Боловсролын газар, Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит аймгийн төв номын сан, Дорнод дээд сургуулийн монгол хэлний тэнхим хамтран ажиллалаа. Уран жиргээ, хүрэл тулга наадамд аймгийн бүх сургууль, цэцэрлэгүүдээс шалгарсан авьяаслаг 133 хүүхдүүд оролцсон байна. Насны ангиллаар шалгаруулж дүнгээ шаргасан байна

“Үе, үеийн тэргүүний уншигчдын уулзалт”:

Үе, үеийн тэргүүний уншигчдын уулзалтыг анх удаа АЗДТГазар, Аймгийн төв номын сан хамтран 2014 оны 12-р сарын 10-ны 14.00 цагт аймгийн төв номын сангийн соёл олон нийтийн танхимд зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагааны зорилго нь Үе, үеийн Номын сайн нөхөр, Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн уншигчдыг алдаршуулах, хүүхэд багачуудад бахархан дууриах хүмүүжил олгох, номтой нөхөрлөж номын ач тусаар амжилтанд хүрсэн тэргүүний уншигчдын туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах зорилготой.

Уулзалтанд сумдыг төлөөлж Булган, Сэргэлэн сум, ЕБС-ийн тэргүүний уншигчид, Ахмад тэргүүний уншигч, бизнесмен, төрийн болон төрийн бус байгууллагат ажиллаж байгаа уншигчдын төлөөлөл номыг яаж уншдаг байсан номтой нөхөрлөснөөр хэрхэн амжилтанд хүрсэн тухайгаа хүүхэд залуустай сонирхолтой ярилцлага өрнүүллээ.Энэхүү үйл ажиллагааг Дорнод ТВ, Шинэ суваг телевизүүдээр сурталчиллаа. Ном хөтөлбөрийн хүрээнд 8,12,14-р Цэцэрлэг ,1,5,6,8,Хан-уул цогцолбор сургуулийн сурагчдын хийсэн том, жижиг ном, даавуун ном, баримлын шаваран ном, номын богц нийт 94ш гар бүтээлийн номын үзэсгэлэн гаргасан.1958 онд тэргүүний уншигч болж байсан БТА ахмад багш Г.Сэддаа багшийн ховор цуглуулгын үзэсгэлэн хүмүүсийн сонирхлыг их татаж байлаа.

Монгол бахархлын өдөр:

Монгол улсын түүхийг сурталчилах, Их эзэн Чингис хааны тухай таниулах, хойч үедээ түүх, зан заншлаа өвлүүлэн үлдээх зорилгоор хүүхдийн уншлагын танхимаас 11-р сарын 23-нд ЕБС-ийн 7-10 р ангийнханы дунд “Чингис хаан” илтгэлийн уралдааныг зохион байгууллаа. Илтгэлд “Старт” орос хэлний клубын хүүхдүүд болон нийт 25 уншигч идэвхтэй оролцон 1-р байр, 8-р сургуулийн 10а ангийн сурагч Б.Хүслэн 2-р байр Хан-уул сургуулийн 11в ангийн сурагч Март нар шалгарлаа. Мөн Чингис хаан комик номоор үзэсгэлэн гаргалаа.

“Цагаан сар” билэгдлийн баяр:

Уламжлалт цагаан сарын баярыг угтаж хүүхэд багачуудад ёс заншил, эх хэл, түүх соёлоо түгээн дэлгэрүүлэх, идэвхтэн уншигчаа урамшуулан дэмжиж зорилгоор ЕБС-ын бага, дунд, ахлах ангийн дунд **Цагаан сар**

Билэгдлийн баяр сэдэвт өдөрлөгийг 2014 оны 01 сарын 14 зохион байгууллаа. Бага ангийн дунд “ Шагай няслах наадаанд” Хэрлэн сумын 1,6-р сургуулийн $4^{а}$, $4^{б}$ ангийн нийт 68 сурагч оролцож 1-р байранд 6-р сургуулийн 4б ангийн сурагч Алтаншагай, 2-р байранд Мөнххүслэн нар шалгарч дурсгалын зүйлсээр шагнагдлаа. Мөн “Идэвхитэн уншигч”-аар 6-р сургуулийн 5а ангийн Баяржаргал шалгарч Сантайж ХХК ивээн тэтгэж Түмэн өлзий оёдлын газар монгол үндэсний хувцасаар мялаалаа.

Дунд болон ахлах ангийн дунд 01-р сарын 25 нд нийт дунд ангийн 24 сурагч, ахлах ангийн 11 сурагч оролцон, Цагаан сарын ёс заншил, мэндлэн хүндлэх ёсын талаар лекц уншин мэдээлэл хүргэлээ. Энэ үеэр дунд ангийханы дунд АХА асуулт хариултын тэмцээн зохион байгуулан 5-р сургуулийн 7а ангийн сурагч Тэмүүлэн тэргүүлэн дурсамж үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

“Бэлэг бэлгийн дээд” номын үзэсгэлэн худалдаа:

Сар шинийн баярыг тохиолдуулан бие биендээ оюунлаг бэлэг солилцох зорилготой Соёл, Спорт, Аялал жуулчлалын газартай хамтран “**БЭЛЭГ БЭЛГИЙН ДЭЭД НОМ**” үзэсгэлэн худалдааг 2014 оны 01-р сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд Аймгийн төв номын санд зохион байгууллаа. Дорнод аймгийн бүх FM радио телевизүүдээр сурталчилж таниулсны үр дүнд хүүхдийн цуврал үлгэр, сургамжит өгүүллэг, тууж, түүхэн роман, бизнесийн номнуудыг хүмүүс их сонирхож Оюунлаг бэлгийг бие биедээ бэлэглэж ард иргэд хүүхэд багачууд үзэсгэлэн худалдаанд идэвхтэй оролцлоо. Үзэсгэлэн худалдаанд нийт 85 төрлийн 418 ш 1.714.200 төгрөгний ном гаргаж, 154 ш 341.700 төгрөгний ном зарж номын фондын баяжилтанд 100 ш 690.900 төгрөгний ном авсан. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр буюу Мартын 8-ны өдөрт зориулан 2014 оны 03-р сарын 07, 08-ны өдрүүдэд **“ НОМ, ЦЭЦЭГ**,**БЯЛУУ“** үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан нь шинэлэг Дорнодчуудын сэтгэлд хүрсэн сайхан арга хэмжээ боллоо. Үзэсгэлэн худалдаанд нийт 26 төрлийн 66ш 845.000 төгрөгний ном үзэсгэлэнд гаргаж нийт 16ш 224.800 төгрөгний ном зарагдаж 47ш 592.500 төгрөгний номыг төв номын сангийн фонд баяжилтанд худалдан авсан.

Хэрлэн сумын 12-р сургуулийн багш, сурагчдын дунд олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтаж “Ээждээ бичих захидал”-ын уралдааныг зарлаж бага, дунд, ахлах, багш ажилчид гэсэн 4 бүлэгт ангилж дүнгээ гаргалаа. Нийт 75 бүтээл цугларсанаас Бага ангийн төрөлд 5а ангийн сурагч Баатарсүрэнгийн Энхжин, Дунд анги төрөлд $6^{а}$ ангийн сурагч Сүхзааны Батхонгор, Ахлах анги төрөлд $10^{б}$ ангийн сурагч Хүрэлбаатарын Тэчмаа, Багш ажилчдын дунд Бага ангийн багш Оюунтуяа түрүүлж өргөмжлөл үнэ бүхий зүйл, аймгийн төв номын сангаар 1 жил үнэгүй үйлчлүүлэх эрхээр шагналаа. Ээждээ бичсэн бүх захидлаар үзэсгэлэн гаргаж, түрүүлсэн захидлуудыг тэдний хайртай ээж нарт нь хүргүүллээ.

Дүгнэлт: Соёл олон түмний ажлыг нийтийн хүртээл болгон ажилласнаар зохион байгуулагдаж буй ажлуудад ЕБС, СӨБ-ын хүүхдүүд олноор хамрагдаж идэвхтэй оролцож, байгууллага аж ахуйн нэгжүүд явуулын үйлчилгээг талархан хүлээн авч байгаа нь онцлогтой.

Гурав. Ном хэвлэлийн байгууллагад мөрдөх үндэсний стандарт

Уншигчдын хэрэгцээт шинэ ном 339ш 3879200 төгрөг, орос ном 15, сонин, сэтгүүл өдөр тутмын хэвлэл, хандиваар 229 ширхэг 1976540 төгрөгийн номоор фондоо бүрдүүлэн сан хөмрөгөө баяжууллаа. Фондын эргэлт 178%

Ном солилцоо:

Ном солилцоогоор аймгийн Музей, Цагдаагийн газар, 0132р анги, ХЦ-ийн 0198-р анги,1,8,11, Политехникийн коллеж, Хөлөнбуйр, Цагаан-овоо сумын нийтийн номын сангуудтай ном солилцон авах гэрээг байгуулан 315 ш ном солилцоогоор олгосон. Гадаад номын фондыг шинээр үүсгэн үндсэн фондын Орос, Англи номыг гадаад номын фондруу зөөж байруулан ангилан ялгагч хийн байрлуулсан. Урагдаж гэмтсэн 850 номыг сэлбэн засаж, тогтмол хэвлэл, сэтгүүлийг улирал дугаараар нь үдэж хавтас хаяг хийж он дараалалд оруулж байрлуулсан.

Дөрөв. Аймгийн эдийн засгийн нийгмийг хөгжүүлэх бодлого төлөвлөлтийн хүрээнд:

БНХАУ-ын ӨМӨЗОрны Шинэ барга баруун хошууны номын сангуудтай тус номын сангийн 4 номын санч Хайлаар хот, Манжуур, Алтан-Эмээлийн номын сантай харилцан туршлага судлан, цаашид хамтран ажиллах, харилцан айлчлал, эх сурвалж материал солилцох эрдэм шинжилгээний солилцоо зэрэг ажлыг хэлэлцэн тохиролцож хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурж жил бүр 2 орны ном солилцох, 45 хоногийн хугацаатай 1 номын санчийг дадлагажуулан ажиллах талаар гэрээ хэлэлцээр хийлээ.

ОХУ-ын Чита хотод 9 дүгээр сардын 21- 24ны хооронд Соёлын харилцаан Номын сангийн чиг хандлага сэдэвт олон улсын бага хуралд тус номын сангаас 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцож захирал Ж.Цагаан “Номын сангийн хөгжлийн чиг хандлага сэдэвт” илтгэл тавьж оролцлоо. Олон улсын бага хуралд Орос, Хятад Монгол 3 орны номын сангийн төлөөллүүд оролцож илтгэл тавилаа. Бид ОХУ-ы Чита хотын А.С Пушкины нэрэмжит номын сантай цаашид хамтран ажиллах талаар гэрээ хэлэлцээр хийлээ.

Access тэтгэлэгт хөтөлбөр:

Access-6 хөтөлбөрт хамрагдсан 20 хүүхэд хичээлээ үрэгжлүүлэн явуулж байна. Хичээлийг англи багш Jack Nalor, Marcus Keely, Rae AnnDietlin, монгол багш Хэрлэнмөрөн нар хичээлийг зааж байна.

АНУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд хатагтай Пайпэр Энн Уинд Кэмбэлл болон дагалдан яваа албаны хүмүүсийн хамт тус төвд 2014 оны 06 дугаар сарын 27 нд Access сурагчидтай уулзаж чөлөөт ярилцлага хийлээ. Элчин сайд зүүн бүс нутагт анх удаа ирж байгаа бөгөөд access хүүхдүүдээс англи хэл сурах ямар байгаа талаар болон хөтөлбөрт хамрагдсанаар ямар өөрчлөлт орж англи хэлний мэдлэг хэрхэн дээшилсэн талаар асууж, АНУ-ын Их дээд сургуульд сурах болон боломжтой тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар ярилцлаа.Элчин сайд АНУ-н Дорнод аймагт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд үр өгөөжтэй байгаагаа дурдаад талархал илэрхийлсэн юм.

2014 оны 09 дүгээр сарын 16-19нд БЗМТ-ийн гүйцэтгэх захирал Д.Саямаа мэргэжилтэн Ариунаа нар тус төвийн үйл ажиллагаатай танилцан, access сурагчидтай уулзаж ярилцаж, аймгийн ЕБС-ийн 2,10, Хан-Уул цогцолбор сургууль, ДДСургуулийн оюутан сурагчдад тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар лекц уулзалт хийж гадаадын их дээд сургуульд хэрхэн элсэх англи хэлийг хэрхэн сурах талаар уулзалт лекц хийж зөвлөгөө өгч ажилласан. Мөн тус аймгийн сайн дурын багш нартай уулзаж access хөтөлбөрийн талаар ярилцаж англи, монгол багш нарыг хичээл заах багш нарыг сонгосон.

Сургалтын явцад англи багш нар Америкийн уламжлалт баяр Halloween, Thankisgiving, Access New year, баяруудыг сурагчдын хамт тэмдэглэн өнгөрүүллээ. БЗМТөвөөс баярын арга хэмжээний зардалд нийт 1036710 төгрөг.

Halloween баярыг Access-6 сурагчид, багш нарын дунд 2014 оны 10 сарын 25 нд зохион явууллаа. Сурагчдыг ирэхээс өмнө багш нар өрөө танхимаа засаж амттаны дээж бэлтгэн, хувцас баг зүүн сурагчдаа угтаж авч “Halloween” баярын тухай ярьж “ Trick or treat” чихэр, амттан цуглуулах, Mask-Making шар манжингаар дүрс хийх, Bobbing tor apple уснаас алим шүүрэх зэрэг уламжлалт тэмцээнийг зохион явуулж хүүхдүүдэд аймшгийн онигоо ярьж өгч тэмдэглэлээ.

12 дугаар сард зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөрүүдийг 8 сургуулийн англи хэлний багш нарт танилцуулан, хөтөлбөрт сурагчидаа хамруулах талаар зөвлөгө өгч, ажилласан.

Орос хэлний клуб:

Хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх Орос хэлний ”Старт” клуб нээгдэж 2014 оны 10 дугаар сарын 03-нд нээлтээ хийлээ. Нээлтийн арга хэмжээнд Хэрлэн сумын тамгын газрын дарга Н.Хасархүү, БГ-ын гадаад хэлний мэргэжилтэн Н.Мандах, Номын сангийн захирал Ж.Цагаан нар оролцож үг хэлж сурагчдад сурлагын амжилтыг хүслээ.

Нээлтэнд 12 дугаар сургуулийн найрал дууны ангийн хүүхдүүд орос дуугаар, Хан-Уул цогцолбор сургуулийн 6 [а] ангийн сурагч Чинхүслэн орос шүлэг уншиж ая дууны мэндчилгээ дэвшүүллээ. Арга хэмжээнд орос хэлний багш, сурагчид, эцэг эхчүүд анги удирдсан багш нар нийт 70 хүн оролцлоо.

Орос хэлний сургалтыг Хан-уул цогцолбор сургуулийн магистр багш

М.Отгонмандах удирдан бага, дунд, элсэлтийн шалгалтанд бэлтгэх ахлах анги гэсэн 3 бүлгийн 56 сурагчидтай сургалтыг эхлүүлсэн.

Аймгийн агентлаг байгууллагуудын ажилтан ажиллагсдыг цаг боломж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхэд залуучуудыг сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэн ажиллахыг нийт ард иргэд эцэг эх, багш, төрийн болон төрийн бус албан байгууллага, аж ахуйн нэгжид уриалж байгууллага сургууль албан газруудад уриалгыг хүргүүлсэн.

Арга зүйн зөвлөгөө:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор ЕБС-иудын номын сангийн үйл ажиллагаа, "Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил дутагдал гарч байгаа шалтгаан, нөхцөл байдлыг тогтоон мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж Ерөнхий боловсролын 1,2,5,8,11-р сургуулиудаар 2014 оны 10-р сарын 21-23-ныг дуустал ажиллалаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 30 дугаар тушаалын хавсралт ЕБС-ийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийг баримталж ЕБСургууль бүр номын сантай байна, Номын сан бол мэдээллийн төв болон ажиллах, Номын сангийн үлгэрчилсэн дүрмийг үндэслэн номын сан нь өөрийн сургуулийн онцлогийг тусгасан дүрэм, уншигчдад үйлчлэх үйлчилгээний дотоод журам боловсруулан ажиллах Сургуулийн захиргаа нь номын санг ном хэвлэлээр тогтмол баяжуулж, номын сангийн үйлчилгээний стандарт (MNS 5742:2007)-д нийцэх техник тоног төхөөрөмж, зориулалтын байраар хангана. Уншигчдад үйлчлэх тав тухтай орчинг номын сангийн үйлчилгээний стандарт (MNS 5742:2007)-д нийцүүлэн бүрдүүлнэ. Номын санч нь "Номын сангийн ажилтанд тавих шаардлага"-ыг (MNS 5742:2007-ын 9 дэх хэсэг) хангасан мэргэжлийн боловсон хүчин байна гэсэн дүрмийг баримтлан арга зүйн зөвлөгөөг өгч зөвлөн туслах үйлчилгээг өгч хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.

Номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалт:

ЕБС-ийн номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2014 оны 01 дүгээр сарын 23-24-нд зохион байгууллаа. Сургалтанд 13 номын санч хамрагдаж, номын сангийн

анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх аргачлал дадлага, соёл олон түмний ажлыг зохион байгуулах, номын сан ном зүйн ангилал, номын сангийн каталог зохион байгуулалт, ном тодорхойлох журам, номын фондын хадгалалт хамгаалалт зэрэг сэдвүүдээр төв номын сангийн номын санчид хичээл зааж, тулгамдаж байгаа асуудал болон сургалтын талаар сэтгэгдэл санал бодлыг сонсож дараагийн сургалтын чиглэл арга барилыг тодорхойллоо.

<u>Зүүн бүсийн номын санчдын сургалт:</u>

Зүүн бүсийн номын санчдын "Ажил мэргэжлийн өдөрлөг" 2014 оны 05-р сарын 15-нд аймгийн төв номын санд зохион байгуулагдлаа. "Ажил мэргэжлийн өдөрлөгт" Дорнод,

Сүхбаатар, Хэнтий аймгуудын номын санчид оролцож, ур чадварын тэмцээн, Волейбол, ширээний теннисний тэмцээн зохион байгуулагдлаа.

Сургалтын зорилго нь мэдлэг чадвартай хүний нөөц бий болгох, хамтын ажиллагааг сайжруулах,бүтээлч хамт олон бүрдүүлэх, харилцан ажлын туршлага солилцох, шинэлэг санааг дэвшүүлэх, мэргэжилтэнүүдийг чадавхжуулах зорилготой.

Зүүн бүсийн номын санчдын өдөрлөгт Үндэсний номын сангийн арга зүйч Б.Сарандэлгэр, каталогич Б.Цоггэрэл,ангилагч Ц.Гантулга, Юнескогийн номын санч

Г.Өлзийхутаг, мэдээллийн сан бүрдүүлэгч Х.Түмэнбаяр зэрэг 9 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож “Юнеско-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн олон улсын баримтат, Монгол улсын хосгүй үнэт өвүүд”, ”Монгол улсын үндэсний баримтат 108 өв” сэдвээр номын үзэсгэлэн гаргасан.Сургалтанд Үндэсний номын сангийн арга зүйч Б.Сарандэлгэр “Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөгдөж байгаа стандартууд”, ”Ном зүйн бичилт” MNS 5271:2012 стандарт, ”Соёл,танин мэдэхүйн ажил” зэрэг сэдвээр сургалт явууллаа. Номын санчдын ур чадварын тэмцээн номын санд хөтлөгддөг бүртгэлүүд, номын сангийн ангалал, номын сангийн Lib4U цахим програм дээр ажиллах, номын сангийн каталог зохион байгуулалт, ном зүйн бичилтийг хугацаатай гүйцэтгэж оноогоор дүгнэж багууд хоорондоо мэргэжлийн асуулт хариулт тэмцээн, мэргэжлийн онцлогийг харуулсан, шинэлэг санаа асуудал дэвшүүлсэн жүжигчилсэн тоглолт зохион байгууллаа.

Monbiblio цахим сургалт:

2014 оны 9-р сарын 11-нд Monbiblio цахим номын сангийн програмыг сумдын нийтийн номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Monbiblio програмыг хэрхэн суулгах, мэдээллийн сангийн нөөц бэлдэх түүнийгээ хадгалах, байгууллагын тухай мэдээллүүдийг засварлах, мэдээ мэдээлэл оруулах, Номын сангийн удирдлагын функцүүдтэй ажиллах, тайланг компьютертээ татаж аван флэш дискэндээ хадгалах, лавлагаа гаргах, тооллого

хийх, формуляр, номын шошго, уншигчын үнэмлэх, цаасан каталог хэвлэх, номын сангийн үйлчилгээ үзүүлэх хугацаа хэтрүүлсэн уншигчдын төлбөр тооцоог барагдуулах болон компьютертэй ажиллах анхан шатны мэдлэг олгосон сургалт боллоо

Мэдээллийн цагийг 37 удаа мягмар гариг бүр зохион байгуулан аймаг орны шуурхай хуралдааны талаар болон байгууллагын хийгдэх ажлуудыг тбайгуулагуудын болон хэрэгцээт мэдээ мэдээллийг

Номын сангийн тэргүүн шагнал

Дашнамжилийн нэрэмжит байгууллагын Хүндэт тэмдэг шагналыг олгох журмын дагуу номын санд олон жил үр бүтээлтэй ажиллаж тэргүүн туршлагатай ажилласан номын санч Л.Амаржаргал, байгууллага аж ахуйн нэгжээс тус номын санд Сэтгэхүйн хурд тэмцээнийг 4 жил ивээн тэтгэж номын сангийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон оюутан залуучуудын оюуны хөгжилд идэвхтэй хувь нэмэр оруулсан Бургатайн тал ХХК-ийн захирал н.Цэцэгмаа нарт гардуулсан.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 497 дугаар тушаал “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх тухай” стратиги, аймгийн Засаг даргын “Архигүй аймаг болох хөтөлбөрийн дагуу уриалгад нэгдэн оролцсон.

Аймгийн засаг даргын уриалгын дагуу ажилтан ажиллагсдыг хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх ажлын байрны дасгал хөдөлгөөний хийж хэвшээд байна. Ажилтан ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан байгууллагаас 250.000 төгрөг, ҮЭ-ийн хорооноос 250000 төгрөгөөр үзлэг шинжилгээнд хамруулсан.

Номын сангийн өргөтгөл

Номын сангийн барилгын өргөтгөлийн нээлтийн үйл ажиллагаа 2014 оны 02 дугаар сарын 24-ны 11.00 цагт ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн хөшөөнд цэцэг өргөх ёслолоор эхэлж төрийн дуулал эгшиглүүллээ.

Энэхүү ёслолын үйл ажиллагааг нээж Аймгийн тамгын газрын дарга П.Бат-Өлзий, УИХ гишүүн, Хууль зүйн дотоод хэргийн сайд, Аймгийн засаг дарга асан Д.Одбаяр,Төв номын сангийн захирал Ж.Цагаан нар нээн үг хэллээ.

Номын сангийн өргөтгөлийн барилгын ажлыг “ИГ” ХХК гүйцэтгэж шинэ өргөөний түлхүүр гардууллаа. Өргөтгөлийн туузыг УИХ гишүүн, хууль зүйн дотоод хэргийн сайд Аймгийн засаг дарга асан, Д.Одбаяр, Аймгийн засаг дарга асан Г.Сүхбаатар, Чойбалсан хотын захирагч, Хэрлэн сумын засаг дарга Ж.Энхцэцэг, Төв номын сангийн захирал Ж.Цагаан нар өргөтгөлийн өргөөний туузыг хайчилж шинэ өргөөндөө мориллоо.

Номын сангийн өргөтгөлийн барилгын нээлтэнд урилгаар Чойбалсан хотын захирагч, Хэрлэн сумын засаг дарга Ж.Энхцэцэг, Аймгийн засаг дарга асан Л.Сүхбаатар, ССАЖГазрын дарга, Б.Чимэддорж, МХГазрын зүүн бүсийн соёл хариуцсан байцаагч Б.Мангалжав, ССАЖГазрын соёл хариуцсан мэргэжилтэн Т.Оюунбат,

АЗДТГазрын соёл хариуцсан мэргэжилтэн Г.Одбилэг болон агентлагуудын дарга, сургууль, цэцэрлэгийн захирлууд, их дээд сургуулийн оюутнууд уншигч нийт 100 гаруй хүн оролцлоо.

Өргөтгөлийн барилгад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалтыг гарган ССАЖЯам, аймгийн ИТХурал болон Засаг даргад уламжлан явуулснаар ССАЖЯамнаас каталогийн шүүгээ, номын тавиур, сонингийн тавиур номын ялтас, соронзон хаалга, решепшин ширээ шийдвэрлэн өгсөн. Нийт 23.413.180 төгрөг.

ОБХ, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2014 оны 23 дугаар заавал биелүүлэх албан шаардлагын дагуу зөрчил дутагдлыг арилган, ааварын гарц тэмдэг тэмдэглэгээ байрлуулан, галын хэтийн төлөвлөгөөг гарган баталгаажуулан галын схем зураг, дүгнэлт гаргуулан гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар аймгийн онцгой байдлын хэлтсээс танхимын сургалт болон үзүүлэх сургалтыг хийлгүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулсан.

Ахмадын баяр, соёлын ажилтны өдрөөр байгууллагын ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйлсийг гардуулан байгууллагаас 685.000 төгрөгийг зарцуулсан. 4 ажилтанд тус бүр 60000 төгрөгийн түлээ нүүрс халаатын хөнгөлөлт үзүүлсэн. Нийт картны орлого 2347500 төгрөг, байрны түрээсийн төлбөрт 1960000, гэрээр ном олголт 94800.

Байгууллагын тохижилт:

Гадна талбайн хавтан шинэчлэн, модоо тэгшлүүлэн, гадна талбайн хавтанг зөөж талбайг томсгон, модыг шилжүүлэн, танхимуудад цэцэг тарьж ургуулан, гацуур мод-5 мөнх ногоон мод -8 тарьсан. Үүдний самбарыг шинэчлэн ажилтан ажиллагсдын зургийг шинэчлэсэн. Хувцасны өрөөг тохижуулсан.

Өргөтгөлийн барилгыг өрөөнүүдэд нүүж орж хүүхдийн уншлагын танхимын номын тек, танхимуудыг хаягжуулсан. Мөн цагийн бүртгэлийг хийж гадна байрлуулсан.

Тав. Архивын номын санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандарт зорилтын хүрээнд

Байгууллагын архивын Origams программыг, гурван нэмэлт үзүүлэлтийн хамт суулган, 2009 2010, 2011 оны захирлын тушаалыг эмхлэн цэгцлэж, хянан шалгаж хуудас дугаарлан баталгаа хуудас бичиж, сканердэж зурган файл үүсгэн фото шопт оруулж фолдер нээн цахим сан үүсгээд байна. Программ 200.0 мянган төгрөг.

Баримт бичгийг стандартын дагуу хөтлөн захирлын тушаалыг бүртгэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан оны эхнээс боловсон хүчний холбогдолтой 10, албан ажлын 16 тушаалыг эрх зүйн үндэслэл, найруулга зүйн хянан гаргалаа.

Байгууллагад ирсэн бичиг 60, явуулсан бичиг 110 бүртгэн хариутай 10 бичгийг тухай бүрт нь шийдвэрлэн ажиллаа.

Хамт олны 1, захиргааны зөвлөлийн 3, шагналд тодорхойлох-3, хяналтын камер-4 нийт 11 хурлын тэмдэглэл, долоо хоног бүрийн мягмар гаригт хийгддэг мэдээллийн цагийг 47 удаагийн мэдээлэл болон өгсөн үүрэг даалгаврыг тэмдэглэн хөтлөсөн.

Байгууллагын санал хүсэлтийн хайрцганд уншигчдаас ирсэн 7 хүсэлтийг хүлээн авч удирдлагад танилцуулан шийдвэрлүүллээ. Санал хүсэлтээр ирсэн 5 асуудал нь номын санчдын зан харьцаа, 1 асуудал нь нийтийн уншлагын танхимыг чөлөөт сонголттой болгох, 1 номын санчид утсаар чанга ярьдаг зэрэг санал гомдол ирснийг захиргааны зөвлөлөөр хэлэлцэн. 2 дугаар сард тогтмол хэвлэлийн танхимын номын санч Д.Энхчимэгт сануулга арга хэмжээ авч бусад номын санчдад ажлын цаг ашиглалт болон уншигчидтай соёлтой харьцах үүрэг өгсөн.

Ажилчдаас ирсэн 7 өргөдлийг хүлээн авч цалинтай чөлөөг 4 хүнд, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 2 хүнийг хүсэлтийн дагуу ажлаас чөлөөлж, ажлын хариуцлага сайжруулна гэсэн 1 өргөдлийг хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаа.

Даргын өдөр тутмын үйл ажиллагаанд туслан, байгууллагын хэмжээнд болж буй үйл ажиллагааны талаар болон удирдлагаас өгсөн цаг үеийн чанартай ажлыг шуурхай зохион байгуулан, хурал зөвлөгөөний тэмдэглэл 3 удаа бичлээ. Хэвлэл захиалгыг улирал бүр хийж хагас жилийн байдлаар 25 төрлийн 360000 төгрөгийн хэвлэл захиалсан.

Бусад ажлууд:

-Аймгийн цагдаагийн тасгийн албан мэдэгдлийн дагуу гаднах баруун талын хашаа, тарьсан мод суулгацыг наашлуулан татаж замын хөдөлгөөний үзэгдэх орчинг харагдахуйц болгосон.

-Аймгийн засаг даргын нэрэмжит “Өндөр бүтээлийн өдөр”-ийн хүрээнд байгууллагынхаа эргэн тойрны 50 м хүртэл хог хаягдал, зүүн тийш хотын ногоон байгууламжийг 17 ажилтан ажиллагсад 2 м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэж 26 шуудай хогийг ачуулсан.

Ерөнхийлөгчийн зарлиг, Чойбалсан хотоо ногоон хот болгох зорилтын хүрээнд мод тарилаа. Энэ ажлын хүрээнд хотын төв цэгт 20 шар хуайс, байгууллагынхаа хашаанд 5 гацуур, шар хуайс 20, шар цэцэгт мод 12 тарьж арчлан тордож ургуулж байна.

Сар шинийн баяраар захирал Ж.Цагаан “Алтангадас одон”-гоор, үйлчлэгч Х.Гантөмөр аймгийн “Тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр, бүртгэл мэдээллийн номын санч Д.Энхчимэг Чойбалсан хотын “Тэргүүний ажилтан, нягтлан бодогч Б.Майцэцэг Хэрлэн сумын “Жуух бичиг, хамт олноороо аймгийн тэргүүний хамт олон, жижүүр Б.Энхболд ҮЭ-ийн “Соёлын тэргүүний ажилтан” –аар тус тус шагнагдсан.

С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ХУУЛЬ, ТОГТООМЖ ШИЙДВЭРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

Төсвийн тухай хуулийн дагуу 2014 онд хийх ажил, нийлүүлэх бүтээгдэхүүний Үр дүнгийн гэрээг төсвийн Ерөнхий менежертэй хийлээ. Ажиллагсдын жилийн ажлын төлөвлөгөөг баталж, биелэлтийг хангуулах үүднээс гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр дүгнэж Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын дагуу ажлын амжилтаар урамшуулал, нэмэгдэл зэргийг олгож байна.

Соёлын сайд, Сангийн сайдын 2004 оны 83/97 тоот тушаалын "Номын сангийн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг худалдах, солилцох, данснаас хасах журам"-ын 3.3-т заасны дагуу актлахаар шийдвэрлэсэн 9881 ширхэг, 3902725.9 мөнгөний номын жагсаалтыг МҮНСангаар хянуулж актлах зөвшөөрлийг авч, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулахаар бэлэн болгоод байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 163 дугаар тогтоолын дагуу "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг Аймгийн Засаг Даргын Тамгын газар, Монголын Үндэсний Номын Сантай хамтран 11 дахь жилдээ амжилттай тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээнд Монголын Үндэсний Номын Санд хадгалагдаж буй үнэт ховор номын үзэсгэлэн, Аймгийн төв номын сангаас 2011, 2012, 2013 оны "Бичиг үсгийн баяр"-т оролцогчдын шилдэг бүтээлийн үзэсгэлэн гарлаа.

ССАЖЯам, Монголын Үндэсний номын сангаас зохион байгуулсан сургалт семинар болон "Үндэсний бичиг үсгийн баяр"-т оролцож 14 суманд 254 ширхэг номыг Улаанбаатар хотоос татан авчирч сумдад хүргүүлэх ажлыг хийлээ.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2012 оны 8 сарын 24-ний 158 дугаар зарлигийн дагуу "Номын баяр"- ыг жил бүр улс болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг бөгөөд уг арга хэмжээ 09 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд Улаанбаатар хотод МҮНСанд болсон бөгөөд орон нутгийн нийт номын сангийн захирал эрхлэгч нарын уулзалт, семинар, мэргэжил аргазүйн зөвлөлгөөнд оролцож яамнаас өгсөн 112 ширхэг номыг авчирч сумдын номын сангуудад тарааж өглөө.

Монгол улсын "Ахмад настны нийгмийн хамгааллын тухай" хуульд заасны байгууллагаас гавьяаны чөлөөнд гарсан өндөр настнуудад хүндэтгэл үзүүлж Цагаан сарын баяр, Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг хамгаалах өдөр, Ахмадын баярын өдрүүдийг тохиолдуулан байгууллагын хэмжээнд хүлээн авч уралдаан тэмцээн, уулзалт хийж гарын бэлэг гардууллаа.

Сумын соёлын төвийн номын сангийн автоматжуулалтын Monbiblio программын сургалтыг 2014.01.16-17-ны өдрүүдэд 14 сумын соёлын төвийн номын санч-мэдээллийн ажилтан нарт амжилттай зохион байгууллаа. Мөн ССАЖГ, АЗДТГазрын дэргэдэх НХХэлтэсээс зохион байгуулсан Соёлын байгууллагын удирдах ажилтны сургалт, семинар, Нийгмийн бодлогын ажилтны сургалт, семинарт Сумын соёлын төвийн номын сангийн автоматжуулалтын Monbiblio программын танилцуулга, ач холбогдлын талаар илтгэл тавилаа. Мөн Сумдын номын санч мэдээллийн ажилтан нартай байнгын холбоотой ажиллаж жил бүр сургалтыг зохион байгуулж зөвлөгөө өгч ажиллаж байна.

2014.08.05–2014.08.21-ны хооронд MONBIBLIO программыг эрчимжүүлэх зорилгоор сумдаа бүсчилэн 4 хэсэг болгон хуваан практик ажлын дадлагыг дэргэдээ явуулан номын санч нарт тулгамдаж буй асуудлыг тухай бүрд шийдвэрлэж байсан нь маш их үр дүнтэй болж өнгөрлөө.

Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт **“Алслагдсан хөдөөгийн иргэдэд иж бүрэн тоноглогдсон автомашинаар явуулын номын сангийн үйлчилгээг үзүүлэх”**, Дундговь Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт: “**Хөдөөгийн иргэдийн дунд явуулын номын сангаар үйлчлүүлэх иж бүрэн тоноглогдсон авто машинтай болж, уншигч үйлчлүүлэгчдийн тоог жил бүр 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх”** гэж тусгагдсаны дагуу аймгийн нийт 14 сумын төвийн иргэдэд болон алслагдсан малчин иргэдэд давхардсан тоогоор нийт 740 ширхэг номоор нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүлж ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчлэхээс гадна сумын нийтийн номын сангуудын үйл ажиллагаа болон Monbiblio программыг нэвтрүүлж байгаа явцтай танилцан, холбогдох хууль тогтоомж, стандартчилалын хэрэгжилтийг хянах зэрэг ажлуудыг хийлээ. Мөн зарим сумтай хамтран номын баярыг зохион явууллаа. Үүнд:

- Дэрэн суманд “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд МЗЭ-ийн шагналт,”Болор цом”-ын 2 удаагийн эзэн, МУСГЗүтгэлтэн нэрт яруу найрагч Цэндийн Чимэддоржийн нэрэмжит “Есөн намрын зээргэнэ” яруу найргийн наадмыг хамтран явуулж Дэрэн сумын номын санд шинэ ном хандивлан, яруу найрагчдын 73 ширхэг номоор үзэсгэлэн гаргалаа. Мөн Дэрэн сумын ЕБС-ийн сурагч О.Сайнсанаад “Тэргүүний уншигч Д.Нацагдорж” тэмдэгийг дурсгалын зүйлийн хамт гардууллаа.

- Эрдэнэдалай суманд уг баярын хүрээнд ажлын хүрээнд тус сумын залуу яруу найрагч , МУСТА С.Асарсайханы уран бүтээл “Хөх сайрын аялгуу” номыг сурталчилж ЕБС-ийн 8,9-р ангийн сурагчдын дунд С.Асарсайханы шүлгийг уран яруу унших уралдаан болон АХА тэмцээн, Хэл зүгшрүүлэх түргэн хэллэгийн тэмцээн зэргийг амжилттай зохион байгуулж байр эзэлсэн хүүхдүүдэд шагнал шардууллаа. Мөн нийтийн номын санд яамны 13 ширхэг шинэ ном хандивлан 60 гаруй номоор үзэсгэлэн гаргалаа.

- Цагаандэлгэр сумын Соёлын төвийн Номын сантай хамтран ЕБСургуулийн сурагчдын дунд АХА тэмцээн явуулж бяцхан номыг зүйр цэцэн үг, цээрлэх ёсоор хэрхэн үр бүтээлтэй хийсэн бүтээл болон хамгийн их ном уншсан шилдэг анги хамт олныг шалгаруулж шагнаж урамшууллаа. Яамнаас ирсэн 13 ширхэг шинэ ном хандивлан 60 гаруй номоор үзэсгэлэн гаргалаа.
- Өлзийт суманд Соёлын төвтэй хамтран яруу найрагч Ж.Бямбаа, яруу найрагч Ц.Хүүхэнхүү нар МУСТА цол, яруу найрагч С.Батлах, Л.Бархас нар Монгол Улсын Тэргүүний Ардын Авъастан цол авсныг тохиолдуулан яруу найргийн үдэшлэг цэнгүүн зохион явуулж яруу найргийн болон шинэ номын үзэсгэлэн гаргалаа.

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА, СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

Шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэнг 38 удаа 2037 номоор гаргаж иргэдэд үйлчиллээ. Үүнд:

-“Үндсэн хуулиа дээдлэе”

-“Уран бичвэр 2010-2013”
-“Дундговийн зохиолчид”
-“Монгол бичиг бидний өв, соёл”
-“Монголын түүх соёлын их өв”
-“Үлгэрийн орноор аялацгаая”
-“Инээвэл залуужина”
-“Цагаан уул”
-“Нарны дор С.Надмидыгаа дурсахуй”
-“Цэрэг, эх орон-ялалтын баяр”
-“Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт”
-“Эр цэргийн баяр”
-“Соёлын ажилтны өдөрт”
-“Номын санчдад тусламж”
-“Шилдэг, шинэ ном”
-“Дуртмал сайхан”
-“Төрийн шагнал хүртсэн зохиолууд”
-“Ном унших ашиг тусын 10 зөвлөмж”
-” Миний мэдэх залуу жанжин”
-“Соёл урлаг шинэ нөхцөлд”
-“Уран үгсийн чуулган”
-“Есөн намрын зээргэнэ”
-“Монгол ардын урлаг бидний өв, соёл”гэх мэт
-Номын санчдын шүүж эмхэтгэсэн номзүйн гарын авлагууд

- С.Надмидын 80 насны ойд зориулсан намтар номзүй болон түүний зохиол бүтээлээр номзүй
- Монголын Өгүүллэгийн нэрт мастеруудын “Утгын уянга”өгүүллэгийн ном зүй
- 2015 онд тэмдэглэгдэх зохиолчдын түүхэн ойнуудын мэдээллийн номзүй
- XX зууны манлай,алдарт гавъяат уртын дууч Ж.Дорждагва агсны мэндэлсний 110 жилийн ойд зориулж Ж.Дорждагва агсны намтар уран бүтээл, түүнтэй холбогдох мэдээллүүдийг агуулсан ном, хэвлэлийг шүүж номзүйн гарын авлагыг тус тус хийлээ.

Хуулийн картын санд 45 ширхэг картын сангаар шинээр баяжилт хийж, Соёл урлаг, эрүүл мэнд спортын талаар нийт 48 уншигчдад лавлагаа мэдээлэл өглөө.

Сайхан-Овоо суманд 8 сарын 15-17-ны өдрүүдэд болсон XX зууны манлай, алдарт гавъяат уртын дууч Ж.Дорждагва агсны мэндэлсний 110 жилийн ойн арга хэмжээнд оролцлоо. Уг арга хэмжээнд Ж.Дорждагва агсны уран бүтээлийн, түүнтэй холбогдох мэдээллүүдийг агуулсан ном болон уртын дуу, уртын дуу судлалын холбогдолтой 50 гаруй номоор үзэсгэлэн гаргаж оролцож, мөн түүний амьдрал уран бүтээлийн талаар хэвлэгдсэн ном хэвлэлийг шүүж номзүйг гаргалаа.

“Нээлттэй мэдээллийн өдөрлөг” – ийн 1 сарын аяны хүрээнд:

- ✓ ЭДЦС-тай хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг тэмдэглэлээ. Уг арга хэмжээнд Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 375 жилийн ойтой холбогдуулан ЭДЦС-ийн 9-р ангийн сурагчдын дунд Асуулт хариултын АХА уралдаант тэмцээн, Ахлах ангийн дунд “Монгол Улсын нийслэл хот” сэдэвт Эссе бичлэгийн уралдаан зарлаж уншигч хүүхдүүдийг шалгаруулж шагнаж урамшууллаа. Мөн уншигчдад үнэгүй карт нээж ном хэвлэлээр үйлчиллээ.

- ✓ 12 сарын 2–нд Сайнцагаан сумын III сургуулийн Номын сантай хамтран Багш, сурган хүмүүжүүлэгчдийн дунд “Уншлагийн семинар”–ыг зохион байгуулж, Зөөврийн номын сангийн 40 номоор үзэсгэлэн гаргаж зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд 14 хоногийн хугацаанд Шилдэг уншигч багшийг шалгаруулах уралдаан зарлаж, үнэгүй карт нээж, мөн ном олголт хийн үйлчиллээ.

“Уншигчийн шинэ жил”– ийг жил бүр уламжлал болгон зохион явуулахаар тогтож уг ажлын хүрээнд:

- ✓ Аймаг болон орон нутгийн ЕБСургуулийн сурагчдын дунд жил бүр зарладаг “С.Буяннэмэх тэмдэгтэн”-ий бүтээлүүдийг хурааж авж шалгаруулаа.

- ✓ Аймгийн төвийн ЕБСургуулийн сурагчдын дунд жил бүр зарладаг “Миний уншсан ном дүрслэх урлагт”, “Номын ертөнцөөр аялцгаая” 2 сарын аяны хүүхдийн бүтээлийн уралдаан зарлаж шилдэг бүтээлийг шалгаруулаа.

Энэхүү баярын арга хэмжээний үеэр “Тэргүүний уншигч хүүхэд”, “Тэргүүний уншигч анги”, “Тэргүүний уншигч сургууль”, “Шилдэг багш”, “С.Буяннэмэх тэмдэгтэн”, “Миний уншсан ном дүрслэх урлагт”, “Номын ертөнцөөр аялцгаая” 2 сарын аяны уралдааны шагналуудын тус тус гардууллаа.

ГУРАВ. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ТАЛААР

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө /жил/	Гүйцэтгэл	Хувь
1	Уншигч	20000	19845	99.2
3	Ном олголт	40000	36353	90.8
4	Ном сэлбэн засалт	2600	2670	102

ДӨРӨВ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР

- 2014 оны менежерийн үр дүнгийн гэрээ, ажлын төлөвлөгөөг гарган аймгийн ССАЖГазрын даргаар баталгаажуулан хэрэгжүүлж байна.

- Батлагдсан төсвөөр худалдаж авсан болон хандив бэлэгээр ирсэн 389 ширхэг 4,666,200 төгрөгний номыг ангилж, техник ажиллагааг хийж, программд оруулан үйлчилгээний 3 танхимуудад хуваариллаа.

- Нийт ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, чийрэгжилтийн сорилд хамруулж, 7 хоногийн 1 өдөр 2 цагаар спорт зааланд цаг авч тоглох, 11 цагт ажлын байрны дасгалыг хийж байна.

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг зохион байгуулж, хүүхдүүддээ бэлэг өгч тэмдэглэлээ. Мөн сурлага, урлагийн амжилт гаргасан ажилтан А.Эрдэнэтуяагийн охин Г.Ануг шагнаж урамшууллаа.

- Ц.Оюунжаргалаас Ц.Мөнхзаяад ажил хүлээлцэх тооллогоор дутагдсан номын жагсаалтыг гаргаж, данс давхардсан болон зарим асуудалтай номуудыг янзалж цэгцэллээ.
- Олон улсын Музейн 90 жилийн ойг угтан Аймгийн Музейгээс зохион явуулсан уралдаант, цэнгээнт танин мэдэхүйн ‘Дөрвөн бэрх‘ тэмцээнд хамт олноороо амжилттай оролцлоо.
- Хүүхдийн уншлагын танхимын 2000 номонд дохиолол хамгааллын ялтас байрлууллаа.

- 08 сарын 18-нд Гэрийн номын санч-мэдээллийн ажилтан Э.Биндэръяа жирэмсний болон эхийн амралтаа авж Б.Солонгод ажил хүлээлцэх тооллогыг комиссын бүрэлдэхүүнтэй тоолж хүлээлцүүллээ.

- 09 сарын 20, 21-ний өдрүүдэд зохиогдсон “Соёлын ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймаг, орон нутгийхаа нийт соёлын ажилчидтайгаа уулзаж, байгууллага хамт олоноороо зохиогдсон арга хэмжээ, тэмцээн уралдаанд амжилттай оролцлоо.

- 14 сумдын номын сангуудад ССАЖЯамнаас ирсэн нийт 366 ширхэг ном тарааж өглөө.

- Мөн ССАЖЯамнаас ирсэн тогтмол хэвлэлийн тавиурыг хүүхдийн уншлагын танхимд, каталогийн шүүгээг коридарт тус тус байрлуулж ашиглаж байна.

- 11 сард Үндсэн фондыг Д.Мөнхзулаас Т.Мөнхсаруулд хүлээлгэж өгөх тооллогыг хамт олноороо хийж дуусгалаа.

ТАВ. ДҮГНЭЛТ

2014 оны хагас жилд хийсэн ажил, арга хэмжээндээ дүгнэлт хийж. ажиллагсдыг хийсэн ажлын үр дүн, амжилт, ур чадвараар нь нэмэгдэл урамшил олгосон нь ажил эрчимтэй явах, шинээр төрөл бүрийн ажил, арга хэмжээ зохион байгуулагдах, бүтээлч ажлын өрсөлдөөн бий болох зэрэг ажлын ахиц, өөрчлөлт гарахад шууд нөлөөлж байгаа нь харагдаж байна. Нөгөө талаар ССАЖЯ-аас номын санчдын ур чадварыг дүгнэх шалгуур журам боловсруулж, мэргэжлийн зэрэглэл тогтоож өгөх нь зүйтэй байна. /Энэ тухай мөн урд онуудад ч санал болгож байсан/

Номын фондын хадгалалт хамгаалалтыг сайжруулж радио долгионы хаалга суулгаж, камержуулан хүүхдийн уншлагын танхимын номонд дохиоллын ялтас байрлуулснаар номын хадгалалт хамгаалалт сайжирч ном алдагдах, алдагдсан номыг илрүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Одоогоор хүүхдийн уншлагын танхимын 2000 ном буюу нийт номын фондын 3.6 хувьд дохиоллын ялтас байрлуулсан бөгөөд нэн даруй насанд хүрэгчдийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхимын номонд дохиоллын ялтас байрлуулах, шаардлагатай тодорхой хэсгүүдэд камер нэмж байрлуулах хэрэгтэй байна.

ДХШ-ын комиссыг тогтмол ажиллуулж байгууллагын үйл ажиллагаанд хяналт дүгнэлт хийж ололттой болон алдаа дутагдлыг тухай бүрд нь илрүүлж тодорхой үр дүнд хүрээд байна.

Санхүү төсвийн хүндрэл их байгаа ч дотоод хүчин чадлаа дайчлан ажиллаж, орон нутгийн мэдээллийн төв, цаашилбал сургалтын төв болох, үйлчилгээндээ орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, уншлага үйлчилгээний хүрээгээ улам өргөжүүлж ажиллах боломж байна гэж дүгнэж байна.

Манай байгууллага нь онцгой объектэд харъяалагддаг ба жил бүр Онцгой байдлын хэлтсийн үзлэг шалгалтаар цахилгаан монтаж муу, шаардлагад нийцэхгүй гэсэн үнэлгээгээр удаа дараа акт тавиулж, муу үнэлгээтэй гарч байгаа тул нэн даруй засварлах шаардлагатай байна. Иймээс зарцуулагдах төсвийг шийдвэрлэж өгнө үү.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй тоосжилттой, чийгшилт болон агааржуулалт муутай /байгалийн гэрэлтүүлэггүй/, хуурайшилттай орчинд ажилладаг учраас мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт ажиллагсдад хоолны /нормын сүү/ зардал, төсвийг тусгаж өгөх саналыг хүргүүлж байна.

Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ЗАВХАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Уншлага үйлчилгээний хүрээнд

- 1-9 сарын байдлаар нийт 4124 уншигч 29568 ирэгсдэд 49558 ном олгож үйлчиллээ.
- Албан байгууллагуудад зөөврийн номын сангийн гэрээг байгуулж зөөврийн номоор үйлчлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Завхан аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн сайн дурын 60 гаруй ажилтнууд номын сан дээр ирж карт нээлгүүлж үйлчлүүллээ.
- Номын сангаар үйлчлүүлж буй уншигчдын бүрэлдэхүүнд судалгаа хийж, санал гомдолыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

2. Фонд каталогийн ажлын хүрээнд

- Одоо 63,0 гаруй боть номтой, Монгол, Англи, Орос, Түвд хэл дээрх ном байдаг.

Орон нутгийн онцлог, уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна.

- 2014 оны фондын бүрдүүлэлтийг төсвийн санхүүжилтээр уншигчдад хэрэгцээ шаардлагатай байгаа 223 нэр төрлийн 460 ширхэг 5934690 төгрөгийн номоор фондоо баяжууллаа.
- Мөн хандив болон бэлгээр 189 нэр төрлийн 360 ширхэг 3723778 төгрөгийн номоор фонд баяжилт хийлээ.
- Бүрэн дунд 4-р сургуулийн номч клубын хүүхдүүдтэй хамтран 48 номыг сэлбэн засах ажлыг зохион байгууллаа.

- Нийт 820 ширхэг шинээр ирсэн номонд техник арга ажиллагаа хийж үндсэн фонд болон танхимуудад хүлээлгэж өгч уншлаганд гаргалаа.
- Шинэ номын мэдээ гаргаж номзүйн самбар болон уншлагын танхимд мөн байгууллагын фэйсбүүк группт байрлуулан ажиллаж байна.
- Уншигчдад электрон каталогоос хайлт хийх талаар мэдээллийг тогтмол хийж байна.
- Үндсэн фондноос актлах болон формуляргүй номыг ялган формуляр бичих ажлыг хийлээ.
- Орос номыг программд оруулах ажлыг хийж байна.

3. Дэвшилтэт шинэ үйлчилгээ, бүтээлч ажлын хүрээнд

Өөдлөх айл үүднээсээ

- ❖ Угтах, зөвлөх үйлчилгээг нээн ажиллуулж байна.

- ❖ Интернэт WIFI орчин бий болгож уншигчдын таатай үйлчлүүлэх нөхцөл боломжийг нээн өгч байна.
- ❖ Сургалтын номын санд уншигчдад зориулсан интернетийн 4ш компьютерийг байрлуулж интернет болон дотоод сүлжээнд холбон уншигчдад ашиглуулж байна.
- ❖ Дотоод хяналт шалгалт аюулгүй байдлыг хангах зорилгоор
    - Номын фондууд
    - Нийтийн уншлагын танхим
    - Хүүхдийн уншлагын танхим
    - Коридор хяналтын камер суурилууллаа.



❖ ***Ногоон орчинг дэмжигч байгууллага***

Хайсандаа цэцгийн мандал хийж чацаргана, шар хуайс, хайлаас, боролзгоно зэрэг мод тарилаа. Мөн тасалгааны цэцгүүдээ шинэчлэн нэр төрлийг нь олшрууллаа.

Хүүхдийн уншлагын танхимын шинэчлэлт

Нийтийн уншлагын танхимын номын тавиур, тогтмол хэвлэлийн тавиурыг шинэчлэлээ.

Нийтийн уншлагын танхимын тогтмол хэвлэлийн тавиурыг шинэчлэн солилоо.

Хөрөнгө оруулалтаар

- ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар төв номын сангийн 766700 төгрөгийн каталогийн шүүгээ, үзэсгэлэнгийн тавиурыг шинэчиллээ.
- ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар 23 суманд 60896341 төгрөгийн номын тавиур, каталогийн шүүгээ, тогтмол хэвлэлийн тавиурыг тус тус хуваарилан хүргүүлэх ажлыг хийлээ.
- Мөн 23 суманд 16 нэр төрлийн 3130760 төгрөгний ном хэвлэл хандиваар



4. *Ном зүйн ажлын хүрээнд*

Б.Явуухулангийн мэндэлсний 85 насны ойд зориулж “ **Дорнын их яруу найрагч**” намтар номзүйг хийж ном болгон хэвлэн гаргалаа. Мөн Завхан аймгаас төрөн гарсан эрдэмтэн, доктор,зохиолч яруу найрагчдын бүтээлээр орон нутгийн номзүй хийх ажлын хүрээнд тэдний бүтээлийн судалгааг гарган ном зүйн бичилтийг хийж байна.

* Явуу танаа* телевизийн нэвтрүүлгийг Шинэ Завхан телевизтэй хамтран бүтээлээ.

Шинэ номын мэдээллийг Шинэ Завхан телевизээр сурталчилж байна.

Мөн ном зүйн самбар болон байгууллагын Facebook хуудаснаа байрлуулж байна.

3-р улирлын шинэ номын үзэсгэлэнг хүүхдийн уншлагын танхимд гаргаж мөн шинэ номын мэдээг Шинэ Завхан телевизээр сурталчиллаа.





5. *Соёл олон нийтийн ажлын хүрээнд*

2014 онд Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, Дорны их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн мэндэлсэний 85 насны ой тохиож байгаа бөгөөд уг ойн арга хэмжээг орон нутгийнхаа ард иргэд, ЕБС-н суралцагчидтай хамтран тэмдэглэн өнгөрүүлэхээр зорьж доорхи ажлуудыг зохион байгууллаа.

“**Дорнын их яруу найрагч**” сэдэвт уншигчийн бага хурал зохион байгууллаа.

Уг арга хэмжээний үеэр Улиастай сумын ЕБС-дын 10-р ангийн суралцагчдын дунд танин

мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгууллаа.

- ✓ 2014 оны 3 сарын 14-ний өдөр Б.Явуухулангийн хөшөөнд цэцэг өргөх үйл ажиллагаа болсон бөгөөд уг үйл ажиллагаанд Завхан аймгийн Засаг даргын орлогч Ч.Пунцаг, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга М.Гүрсэд, Зэвсэгт хүчний 325-р ангийн орлогч дэд хурандаа Мэндбаяр, Аймгийн Музейн дарга Т.Ренчинванжил, ССАЖГ-ын соёлын мэргэжилтэн Б.Оюун, ЕБС-ийн номч клубын суралцагчид болон сургуулийн номын санч, багш нар оролцлоо.
  - ✓ ЕБС-дын номч клубуудын * **Бид бүтээж чадна** * сэдэвт уралдаан болон * **Би хаана төрөө вэ**?* дууны тэмцээнд оролцож буй байгууллагуудын Явуугийн төрсөн өдөрт зориулсан бүтээлүүдээр “**Явуудаа барих бидний бэлэг**” сэдэвт үзэсгэлэн гаргалаа.

- ✓ ЕБС-н ном клубын суралцагчидын дунд * Шилдэг номч клуб шалгаруулах уралдааныг зарлаж * **Шилдэг ном клуб** *-ээр Энхтуяа багштай бүрэн дунд 4-р сургуулийн номч клуб тэргүүн байр эзэллээ.

Улиастай суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, албан байгууллагуудын ажилтнуудын дунд **“Би хаана төрөө вэ**?“ Б.Явуухулангийн зохиосон шүлгээр бүтсэн дууны уралдаан зохион байгуулж нийт 15 байгууллага оролцлоо.

- ✓ 2014 оны 3 сарын 17-ний өдөр Зэвсэгт хүчний 325-р ангитай хамтран “**Би эх орны цэрэг**” уралдааныг амжилттай зохион байгуулан

1-р байрыг Э.Сарантуяа
2-р байрыг Ч.Ганбаатар
3-р байрыг Б.Гантулга нар тус тус эзэллээ.

- ✓ Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сан, Боловсролын газартай хамтран “Завханы нэвтэрхий толийг судлахуй” танин мэдэхүйн АХА тэмцээнийг 3 үе шаттайгаар зохион байгууллаа. 1-р үе шатыг анги дээрээ, 2- үе шатыг сургууль дээрээ зохион байгуулан анги тус бүрээс шалгарсан 6-11-р ангийн сурагчдын дунд Төв номын сан дээр танин мэдэхүйн тэмцээнийг анги тус бүрээр зохион байгуулан эхний 3 байрын буюу нийт 18 суралцагчдыг шагнаж урамшууллаа.

I-боть

II боть

- ✓ Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан, Хас банктай хамтран жил бүр уламжлал болгон зохион явуулдаг "**Би монгол хүүхэд**" сэдэвт ёс заншлын олимпиадыг зохион байгуулж 22 сум сургуулийн суралцагчид оролцсоноос

1-р байрыг Яруу сумын дунд сургуулийн 5а ангийн сурагч Б.Сайнзаяа 2-р байрыг Нөмрөг сумын дунд сургуулийн 5а ангийн сурагч А.Жавзандулам 3-р байрыг Дэвшил сургуулийн 5а ангийн сурагч Э.Өлзийхутаг Тусгай байрыг Цагаанчулуут сумын дунд сургуулийн 5а ангийн сурагч Б.Сарантуяа, Тосонцэнгэл сумын 2-р сургуулийн 5в ангийн сурагч С.Түвшинзаяа нар тус тус эзэллээ.

- ✓ Улиастай сумын цэцэрлэгүүдийн ахлах бүлгийн хүүхдүүдийг номын сантай танилцуулахын зэрэгцээ бяцхан уншигчдын сонирхсон үлгэрүүдээр чанга уншлага хийлээ.

- ✓ ХБК-ийн 8-10-р ангийн сурагчдын дунд “Завханыг танин мэдэхүй” АХА тэмцээн зохион байгуулж 10б ангийн сурагч У. Баасандаш түрүүлээ.

- ✓ Жинст багийн өрхийн эмнэлгийн эмч Банзрагчтай хамтран * Ханиад томуугаас урьдчилан сэргийлэх* ,*Шүдний өвчлөлийн талаар*, * Яагаад гараа угаах хэрэгтэй вэ*, *Хэзээ гараа угаах вэ*, *Хэрхэн гараа угаах вэ* гэсэн сэдвүүдээр уншигч хүүхдүүдтэй харилцан ярилцаж эрүүл мэндийн ярилцлага зохион байгууллаа. Ярилцлаганд 30 хүүхэд оролцлоо.

- ✓ Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сан, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран * **Үлгэрийн баатраа хэн сайн мэдэх вэ**? * гар зургийн уралдааныг 3

үе шаттайгаар зохион байгуулж 1-р шатанд 181 хүүхдийн бүтээл ирсэнээс 43 хүүхдийн бүтээл 2-р шатанд шалгаран оролцсон бөгөөд 3-р шатыг номын сан дээр зохион байгуулж үлгэрийн баатрын зураг сонгон зуруулла.

1-р байрыг ЧЭҮЛСургуулийн 4в ангийн сурагч Ч.Ням-Очир
2-р байрыг Дэвшил сургуулийн 4а ангийн сурагч Ч.Ариунаа
3-р байрыг ЧЭҮЛСургуулийн 4в ангийн сурагч Б.Өлзийсайхан нар тус тус эзэллээ.

- ✓ Уншигч, хүүхэд багачуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт

цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготойгоор

- Насанд хүрэгчдийн Adve-toefl class

- Оюутан залуучуудын дунд Pre-toefl class
- Хүүхэд багачуудын дунд Speaking club, Movie club, Writing club тогтмол хичээллүүлж байна.

- ✓ Англи хэлний эрчимжүүлсэн 1 сарын төлбөртэй сургалт хичээллүүлж сургалтын хүүхдүүдээр бяцхан ном хийлгэх, минутын уншлага үгийг галиглан уншуулах, асуулт хариултаар өгүүлбэр зохиолгох, багаар ажиллуулах чадвар эзэмшүүлэх тал дээр анхаарч сургалтыг зохион байгууллаа.

- ✓ Аймгийн Боловсролын газар болон гадаадын сайн дурын ажилтнуудтай хамтран Англи хэлний Эссэ бичлэгийн олимпиадыг зохион явууллаа

- ✓ Олон улсын театрын өдрийг тохиолдуулан 2014 оны 03 сарын 27-ны өдөр ХЖТ-т шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчиллаа.

- ✓ “**Б**

ид уншиж чадна” түргэн уншлагын уралдааныг ЕБС-ийн 1-р ангийн суралцагчдын дунд зохион байгууллаа.

Энэхүү уралдаанд сургууль бүрээс шалгарсан шилдэг 3 суралцагч нийт 15 суралцагч оролцсоноос
1-р байранд Дэвшил сургуулийн М.Мөнх-Ундрал
2-р байранд ЧЭҮЛСургуулийн Б.Ган-Эрдэнэ
3-р байранд Дэвшил сургуулийн Д.Лхагважаргал тус тус эзэллээ.

- ✓ Ерөнхийлөгчийн 2003 оны 105-р дугаар зарлигын дагуу “Үндэсний бичиг үсгийн баяр” тэмдэглэн өнгөрүүлэх болсонтой холбогдуулан “Үндэсний бичиг соёлоо хадгалцгаая” сэдэвт монгол бичгийн уралдааныг ЕБС-н 8-р ангийн суралцагчдын дунд зохион байгууллаа.

- ✓ СУИС-ийн харъяа Завхан аймгийн ХБК-н Монгол хэл, уран зохиолын багштай хамтран “**Хүрэл тулга-2014**” наадмыг зохион байгууллаа.

- ✓ Б.Явуухулангийн нэрэмжит аймгийн төв номын сан 2014 оны 05 сарын 26-ны өдөр "**Нээлттэй хаалганы өдөр**"-г зохион байгуулан явууллаа.

Тус өдөр хүүхдийн уншлагын заал болон Bookbridge сургалтын танхимд номын

үзэсгэлэн гаргахын зэрэгцээ 14-16 цагийн хооронд уншигч үйлчлүүлэгчиддээ үнэгүй карт нээн үйлчиллээ.

Нээлтэнд аймгийн засаг дарга Ж.Жамъянтив, аймгийн ССАЖГ-н дарга Д.Чойжилсүрэн, аймгийн БГ-ын мэргэжилтэн Ц.Дэлгэрмаа, Дэвшил сургуулийн захирал Д.Мягмардорж, Отгонтэнгэрийн УТХГ-н мэргэжилтэн Мөнхзул, Жавхлант цогцолбор сургуулийн сургалтын менежер Буяннэмэх болон бусад зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж нээлтэнд оролцохын зэрэгцээ шинэ номын үзэсгэлэнг үзэж сонирхлоо. Мөн номын сангийн захирал Ш.Болор-Эрдэнэ хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд номын сангийн үйл ажиллагаа болон хийж хэрэгжүүлж байгаа томоохон ажлуудынхаа талаар мэдээлэл хийлээ.

Уг арга хэмжээний үеэр Улиастай сумын II.IY.Y, YII цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн суралцагчид ирж номын сантай танилцан номын санчид хүүхдүүдийн сонирхсон үлгэрийн номоор чанга уншлага хийж өглөө .

- ✓ Bookbridge-ийн номын сангаас Англи номын үзэсгэлэн гарган, гадаадын сайн дурын ажилтан багш Bryan-тэй хамтран ‘’**Animal** ‘’ сэдэвт нээлттэй хичээл явуулж, Англи дуу , бүжиг заах ажлыг зохион явууллаа.

- ✓ 2014-2015 оны шинэ хичээлийн жилд зориулсан шинэ номын үзэсгэлэнг 2014 оны 09 сарын 01-05-ны өдрүүдэд хүүхдийн уншлагын танхимд гаргаж уншигч үйлчлүүлэгчиддээ танилцууллаа.

- ✓ 2014 оны 09 сарын 12-ны өдөр ССАЖГ-т “**Номын баяр 2014**” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Уг өдөрлөгт аймгийн удирдлагууд хүрэлцэн ирж оролцлоо.

- ✓ 2014 оны 09 сарын 04-ны өдөр номын сангийн дэргэдэх илтгэх урлаг , мэтгэлцээний **“Цэц мэргэний клуб”** нээгдлээ.Энэхүү клуб ерөнхий боловсролын 5 сургуулийн нийт 110 сурагчдын бүрэлдэхүүнтэй тэргүүлэгч 15 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

- ✓ Номын гүүр сургалтын номын сангаас “**Миний гэр бүл болон би**” сэдэвт гар зургийн уралдааныг ХБК-н 9-10-р ангийн суралцагчдын дунд зохион явууллаа.Уралдаанд нийт 200 гаруй хүүхэд оролцож манай сургалтын төвийн 6

хүүхдийн зураг шалгарч Герман улсаас зурсан зургаар нь календар болон хэвлэгдэж ирнэ.

- ✓ Боловсрол мэдээллийн төвийн хамт олон номын санд USAP хөтөлбөрт хэрхэн хамрагдах талаар сургалт зохион байгууллаа.

- ✓ Илтгэх эрдэм хүрээлэнгийн тэргүүн, уран илтгэгч доктор Б. Гэрэл номын сангийн дэргэдэх Цэц мэргэний клубын сурагчидтай уулзаж Амьдрах ухааны талаар лекц уншлаа. Мөн аймгийн төрийн байгууллагын албан хаагч, бизнесмэн, ард иргэд хөдөлмөрчдөд шат дараатай лекцүүдийг 2 өдрийг турш тавьж соён гэгээрүүллээ.

- ✓ Суралцагчдын танин мэдэхүйн мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлэх, багаар ажиллах арга барилыг хөгжүүлэх ,чөлөөтэй сэтгэж үзэл бодлоо илэрхийлэх чадварыг дээшлүүлэхэд зорилготойгоор ЕБС-дын 11-р ангийн суралцагчдын дунд танин мэдэхүйн “**Центавр**” тэмцээнийг 2014 оны 12 сарын 11-ны өдөр аймгийн төв номын сангийн нийтийн уншлагын заалανд зохион явууллаа.Тэмцээнд Улиастай хотод үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 5 сургуулийн 5 баг оролцосноос:
  1-р байр. Бүрэн дунд III сургуулийн “Таавар” баг
  2-р байр. Дэвшил сургуулийн “Ирээдүй” багууд эхний шагналт байранд шалгарлаа.

- ✓ Монгол улсын Анхны ерөнхийлөгч П. Очирбат манай номын сантай танилцаж уншигч хүүхэд багачуудад номын ач тусын тухай халуун яриа өрнүүлэн номын сангийн ажилчдад урмын үг хайрлалаа.

Мөн уншигч хэрэглэгчдийн буланг шинэ номын мэдээ болон онч мэргэн үгсээр байнга шинэчилж уншигчдад шинэ мэдээлэл өгч ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн иргэдийн заавал сурч мэдэх 4 дуу 1 найраглалийг 120 ширхэгийг гарын авлагаар бэлтгэн иргэд уншигчиддаа тараан үйлчиллээ.

2014 онд уншлагын танхим нь 11 төрлийн тогтмол хэвлэл 7 төрлийн сэтгүүлүүд захиалан улирал бүрээр нь үдэж хавтаслан фондонд хүлээлгэн өгч байна.

Уншлагын танхим нь гэрээр гарсан ном хэвлэлийг бүртгэх, өдөр тутам байнгын хийх шаардлагатай ажлуудыг хянахын тулд ээлж хүлээлцэх дэвтэрийг шинээр нээж хөтөлж байна.

Танхимын сонин сэтгүүлийн тавиурыг шинэчлэн уншигчид хэрэглэхэд хялбар шинэлэг орчин бүрдүүлэн ажилласан.

5.2. Соёл олон нийтийн ажил

Д/д	Зохион байгуулсан Соёл олон нийтийн ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хилийн 0101-р ангид “Номын өдөрлөг”	62
2	“Монгол ёс заншил” Номын үзэсгэлэн	48
3	“Хүний эрхийн тухай ерөнхий ойлголт” сэдэвт уулзалт ярилцлага	26
4	0243-р ангид “Шинэ номын үзэсгэлэн”	36
5	Ахмадын сувилалд “АХА” тэмцээн	28
6	Баянгол суманд Соёлын үйл ажиллагааны өдөрлөг”-т Шинэ номын үзэсгэлэн, худалдаа, АХА тэмцээн	65
7	“Гоо сайхан ертөнцийг аварна” уншигчдын уулзалт	28

8	“Гоо сайхан ертөнцийг аварна” ном сэтгүүлийн үзэсгэлэн	72
9	“Үндэсний бичиг үсгийн баяр” –аар “Монгол бичгээ эрхэмлэгч байгууллага”, “Алдаагүй зөв сайхан бичигтэн”, “Монгол бичгийн тэргүүний уншигч”, “Монгол бичгээ сурч түгээн дэлгэрүүлье” эдгээр ажлуудыг зохион байгуулав.	84
10	“ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” Үлгэрийн баатарын дүрд хувирч, Уран жиргээ, Аав Ээж Би уралдаан	68
11	“Эрдмийн баяр” өдөрлөгт АХА тэмцээн	46
12	“Номын баяр”-ын арга хэмжээнд “Тэргүүний уншигч сурагч”, “ Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн”, “Идэвхитэн уншигч”	158
13	“Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд” нээлттэй хаалганы өдөрлөгт шинэ номын үзэсгэлэн, худалдаа, lib4U программийн танилцуулга	99
14	“HALLOWEEN”-ы баярт идэвхитэй оролцов.	28
15	Сэлэнгэ аймгийн ЗДТГазрын ажилтан албан хаагчдад “Шинэ номын мэдээлэл” хийв.	26
	15	**874**

Хилийн 0101-р ангийн Хичээлийн шинэ жилийн баярыг тохиолдуулан тус ангийн нийт бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн албан хаагчдад номын сангийн үйл ажиллагааг сурталчилж, тэдний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор шинэ номын мэдээлэл хийж, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж, номын худалдаа зохион ажиллаа. Өдөрлөгт нийт бие бүрэлдэхүүн идэвхитэй оролцож АХА тэмцээнд хугацаат цэргийн албан хаагч байлдагч Б. Хүрэлсүх бусдыгаа хошуучлан тэргүүлж дурсгалын зүйлээр шагнагдлаа.Нийт 21 ажилтан албан хаагчид шинээр уншигчийн карт нээлгэв.

Монгол түмний уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг “Сар шинийн баяр”-ыг тохиолдуулан “Монгол ёс заншил” сэдэвт 24 нэр төрлийн номоор үзэсгэлэн гарган ажиллаж байна.

Мөн сүүлд шинээр ирсэн номоор санамж өгөх номзүйн мэдээ гаргаж аймгийн нийт төрийн болон төрийн бус байгууллагуудын мэдээллийн самбарт байрлуулан ажиллалаа.

Хүний эрхийн үндэсний комиссын Сэлэнгэ аймаг дахь салбарын төлөөлөгч Н. Гантулгатай хамтран нийт уншигчдийн дунд “Хүний эрхийн тухай ерөнхий ойлголт” сэдэвт уулзалт ярилцлага амжилттай зохион явагдлаа. Уулзалтанд нийт 26 хүн оролцож санал бодолоо чөлөөтэй илэрхийлж, идэвхитэй оролцлоо.

Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн харьяа Ахмадын сувилалд зочилж тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номын сангаа сурталчилан таниулах зорилгоор ном хэвлэлээр үйлчилж ахмадуудын дунд АХА тэмцээн болон цэнгээнт бүжгийн тэмцээн зохион явууллаа.

Тэмцээн ахмадууд маш идэвхитэй оролцож АХА тэмцээнд Сувилалын дарга Н.Оюунцэцэг тэргүүлсэн бол Цэнгээнт бүжгийн тэмцээнд амрагч Ц. Жавзмаа амжилттай оролцлоо.

Баянгол сумын иргэд болон ажилтан албан хаагчдад номын сангийн цахим үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор Баянголын нэг өдөр" соёлын арга хэмжээнд оролцож номын сангийн цахим үйлчилгээ, Шинэ номын үзэсгэлэн худалдаа, Танин мэдэхүйн АХА тэмцээн зэрэг олон үйл ажиллагаа зохион байгууллаа. Иргэд идэвхитэй оролцожАХА тэмцээний ялагчаар иргэн Н. Уянга тэргүүллээ.

Хаврын улирал ирж байгаатай холбогдуулан охид бүсгүйчүүддээ үс болон арьс арчилгааны талаар "Оюу" салоны гоо сайханч Уянгатай уулзалт хийж, зөвлөгөө авав.

Гоо сайханч хаврын улиралд арьсаа хэрхэн хамгаалах, үсээ хэрхэн эрүүл байлгах, өөрт тохирсон бүтээгдэхүүнээ сонгон авч хэрэглэхийг зааж сургаж, охид хөвгүүд хэрэгцээт мэдээллээ авч, сонирхсон асуултандаа хариулт авч, маш өндөр сэтгэгдэлтэй байлаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Иймээс бид үндэсний соёлын салшгүй нэг өв болох монгол бичиг үсгээ, бидний ирээдүй болсон хүүхэд залуучуудад өвлүүлэн таниулах сурталчилах хадгалан хамгаалах зорилгоор, төрийн болон төрийн бус байгууллагууд , сумдууд, Сүхбаатар сумын 6 сургуулийн хамт өргөн цар хүрээг хамарч зохион байгууллаа. Тус арга хэмжээнд "Монгол бичгээ эрхэмлэгч" байгууллага, ЕБС-уудийн дунд "Алдаагүй зөв сайхан бичигтэн" , "Монгол бичгийн тэргүүний уншигч", "Бичиг соёл мину" сумдаас ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргах, "Монгол бичгээ сурч түгээн дэлгэрүүлье" хэлэлцүүлэг ярилцлага зэрэг ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

"Эх үрсийн баяр"-ыг тохиолдуулан нийтийн номын сан нь хүүхэд багачууддаа баяр баясал бэлэглэх зорилгоор "Номын хотхон" байгуулж ажилтан ажиллагсад нь үлгэрийн баатрын дүрд хувирч бэлэг барьлаа. Сонирхсон хүүхэд

бүхэнтэй дурсгалын зураг авахуулж, хүүхэд багачуудын дунд “Уран жиргээ” шүлгийн уралдаан болон “Аав Ээж Би” тэмцээнүүдийг зохион байгууллаа. Номын хотхоноор зочилсон хүүхэд бүр азаа сорин сугалаа сугалж ном хожиж баяр хөөрөөр дүүрэн байлаа.

2014-2015 оны хичээлийн жилийн баярыг угтан “Эрдмийн баяр” өдөрлөгийг 6-р сургуулийн багш ажилчид, сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгт шинэ номын үзэсгэлэн болон худалдаа гаргаж сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж хүүхэд багачууд идэвхитэй оролцлоо. АХА тэмцээнд нийт 46 хүүхэд оролцсоноос тэргүүн байрыг 6-р сургуулийн 10а ангийн сурагч Б. Дөлгөөн бусдыгаа хошуучлан амжилттай оролцлоо.

Жил бүрийн 9-р сард улс орон даяар “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Аймгийн ССАЖГазар, Нийтийн номын сан хамтран “Номын баяр-2014”, “Ном бол оюун санааны тусгаар тогтнол” гэсэн уриан доор амжилттай зохион байгууллаа. Ажлын хүрээнд номын сангийн идэвхитэн уншигчидаа шагнаж урамшууллав.

“Тэргүүний уншигч” сурагчаар ЕБ-ийн 1-р сургуулийн 11а ангийн сурагч Э. Орхончимэг, “Тэргүүний уншигч-Нацагдорж” тэмдэгтэнээр ЕБ-ийн 2-р сургуулийн 11а ангийн сурагч Б. Уянга, М. Сувд , “Идэвхитэн уншигч” –аар Б. Хүлэг-Эрдэнэ, П. Баянжаргал нар шагналын эзэд болсон байна.

“Номын баяр”-аар ЕБС-иудын сурагчдад сурах бичгийн худалдаа гаргах болсонтой холбогдуулж Ерөө, Баруунбүрэн, Бугант, Мандал сумын 1,2-р сургуулийн сурагчдын сурах бичгийн хангалтын судалгааг номын санчидтай нь хамтран гаргасан.

Сэлэнгэ аймгийн ЗДТГазараас зохион байгуулсан “Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд” арга хэмжээнд үнэ төлбөргүй уншигчийн карт нээж, шинэ номын үзэсгэлэн худалдаа, номын сангийн lib4U программын танилцуулга болон цахим номын сурталчилгаа хийж амжилттай оролцлоо. Нийт 99 хүн хамрагдсанаас 12 иргэн номын сангийн уншигч болох эрхтэй боллоо.

Аймгийн ЗДТГазрын хамт олонд шинэ номын мэдээлэл хийн, 7 ажилтан албан хаагчдад номын сангийн уншигчийн карт нээн гэрээр ном олгох үйлчилгээ үзүүллэв.

Нийтийн номын сангаас зохиосон “Үндэсний бичиг үсгийн баяр”,” Хүүхдийн эрхийн хамгаалах өдөр”,“Эрдэмийн баяр”,“Ном бол оюун санааны тусгаар тогтнол”уриатай номын баярийн нэгдсэн арга хэмжээнд оролцон номын хотхон, үлгэрийн баатруудыг амилуулан нийтийн номын сангийн үйл ажиллагааг сурталчилан ажиллаа.

5.3. Хүүхдийн уншлагын танхимын ажлын хүрээнд

Хүүхдийн уншлагын танхим нь энэ жилийн хугацаанд хүүхэд багачууд, сурагчид болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаагаа өргөтгөсөн шинэ ажлуудыг зохион байгуулж, шинээр ирэгсэд болон уншигчдийнхаа цар хүрээг

нэмэгдүүлэхийн тулд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж ирлээ. “ Соёл олон нийтийн ажил ”-ын хүрээнд номын сангийнхаа үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийг хамарсан хүүхдийн оюуны хөгжлийг дэмжсэн ажлуудаас гадна, уншигч хүүхүүддээ номтой нөхөрлөх сонирхлыг өгч, номыг хэрхэн үр дүнтэй унших, түүнээс өөрт хэрэгтэй мэдээ мэдээлэлийг хэрхэн зөв олж авах ухаанд суралцуулах, мөн тэдний хичээлийн бус цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилготойгоор олон олон ажлуудыг хийлээ.

Хүүхдийн уншлагын танхимаар үйлчлүүлж байгаа сургуулийн өмнөх болон 1-7 ангийн уншигч хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, шинэ уншигч, ирэгсэд, ном олголтыг нэмэгдүүлэх, сайжруулах, мөн соёл олон нийтийн ажлыг өргөжүүлж ажлын хүртээмжийг сайжруулах зорилгоор, тэмдэглэлт өдрүүдийг өргөн цар хүрээтэй хийж, олон нийтийг хамарсан ажлуудыг зохион байгуулахад оршино.

5.3.1 Уншлага үйлчилгээ

Хүүхдийн уншлагын танхим нь 676 шинэ уншигч , 2885 ирэгсэд , 6508 ширхэг ном хэвлэл, сонин сэтгүүлээр үйлчилсэн.

Ном сэтгүүлийг жилийн хугацаанд сэлбэн засаж, урагдал гэмтэлгүй үйлчилсэн. Өдөр тутамд уншигчдын гар дээр уншигдаж байгаа номнуудыг гэмтсэн эсэхийг шалгаж сэлбэн засалтийн / номнуудыг нуруудах, хавтаслах, хуудасны бүрэн бүтэнг шалгах, шинээр хаяглах / ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Өдөр тутмын бичиг баримт хөтлөлтийг стандартын дагуу цэвэр нямбай хөтлөж, уншигчдын санал хүсэлт болон татгалзалын дэвтэрийг ажилуулж, санал хүсэлтийг хүлээн авч ажилдаа тусган ажиллаа.

1.3.2 Соёл олон нийтийн ажил

Д/д	2014 онд зохион явуулсан “Соёл олон нийтийн ажил”	Хэдэн удаа	Хамрагдсан иргэд болон хүүхдүүд
1.	“ Урилгат уншлага”	4	32
2.	“ Ой тогтоолтоо хөгжүүлцгээе” тэмцээн	2	32
3.	“ Үлгэрээр хүмүүжүүлье”уншлага	6	36
4.	“ Сонирхолтой уран зохиол”үзэсгэлэн	2	50гаруй
5.	“ Аха Аха Аха” танин мэдэхүйн уралдаант тэмцээн	5	200гаруй
6.	“ Миний үндсэн хууль, миний эрх чөлөө”ярилцлага мэтгэлцээн	1	31
7.	“ Үндэсний бичиг үсгийн баяр”	1	200гаруй
8.	“ Үндэсний бичиг үсгээ түгээн дэлгэрүүлье” хэлэлцүүлэг ЕБС-иудын дунд уралдаан тэмцээн	1	30
9.	“ Тэргүүний уншигч- Д. Нацагдорж тэмдэгтэн”шалгаруулах	2	4хүүхэд
10.	“ Заавал унших номнууд”	1	31
11.	“ Гоо сайхан ертөнцийг аварна”өсвөр үеийнхэнд зориулсан мэдээлэл	1	28

12.	“ 6-р сарын 1 буюу Эх үрсийн баяр”-ыг нийт хамт олноороо	1	----
13.	“ Эрдмийн баяр”-ын өдөрлөг	1	12 жилийн 6-р сургууль
14.	АТГазарт “ Шинэ номын мэдээлэл” үзэсгэлэн	1	20 гаруй
15.	“ Номын баяр-2014” “ Ном бол оюун санааны тусгаар тогтнол”	1	500 гаруй
16.	“ English Spelling”-ын уралдаан	1	----
17.	“ Hallyween” англи хэлээр шүлэг унших уралдаан	1	Сэлэнгэ аймгийн 6н сургуулийн дунд
	Нийт	**35**	**2304**

“ Аха Аха Аха” танин мэдэхүйн уралдаан

“Аха-Аха-Аха” уралдаант хөгжөөнт тэмцээнд СБ сумын Улсын Тэргүүний 12 жилийн 4-р сургуулийн Оюунцэцэг багштай 2а ангийн хамт олон оролцлоо. Нийт 37 сурагчид өөрсдийн авъяас билгээ сориж, идэвхи чармайлттай оролцсоноос сурагч Цэлмүүн тэргүүлж үлгэрийн сонирхолтой номуудын эзэн боллоо.

Анги хамт олны дунд:

- Номын сангийнхаа үйл ажиллагаа, ажиллах цагийн хуваарь танилцуулах
- Номын үзэсгэлэнг, номын товч мэдээлэл хийх
- “Сэлэнгийн дууг хэн сайн дуулах вэ” дууны уралдаан зарлах
- Номыг хэрхэн үр дүнтэй унших талаар хүүхдүүддээ бяцхан сургалт зөвөлгөө өгч
- шинээр карт нээж
- чөлөөт ярилцлага хийх, хүүхдүүдийн санал хүсэлтийг сонсох зэрэг ажлуудыг зохион явуулсан болно.

“ Үлгэрээр хүмүүжье” сэдэвт үлгэрийн уншлага

“Үлгэрээр хүмүүжье “сэдэвт ярилцлагыг 2014 оны 03-р сарын 04- ны 11 цагт СБ сумын Улсын тэргүүний 2-р цэцэрлэг дээр зохион явууллаа. Энэхүү өдөр Амгалан багштай бэлтгэл бүлгийнхэн оролцож “ АХА-АХА-АХА ”танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг зохион явуулж хүүхдүүдээ урамшуулж ангид нь ном бэлэглэлээ.

Мөн хүүхдүүдийнхээ дунд их зохиолч Б. Явуухулан гуайн “ Би хаана төрөө вэ? ” шүлгийг хэн уран яруу сайхан унших вэ уралдаан зарлалаа. Уг уралдаанд С. Тэнүүн хүү бусдаасаа уран яруу шүлгээ уншиж 1-р байранд шалгарсан.

Энэхүү өдөрлөгийн хүрээнд:

- Үлгэрийн номын үзэсгэлэн гаргаж, номын талаар товч мэдээлэл хийх
- Үлгэр уншиж өгч хүүхдүүд дээр ойлгосныг нь яриулах
- Чөлөөт сэдэвээр хүүхдүүдтэй ярилцлага зэрэг ажлуудыг зохион явууллаа.**“**

“Урилгат уншлага”

Урилгат уншлагыг 2014 оны 04-р сарын 27ны өдөр 12 цагт Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “ Нийтийн номын сан”, “ Хүүхдийн уншлагын танхим”-д зохион

явууллаа. Уншлаганд 12 жилийн 2-р сургуулийн 2/а/ ангийн хамт олон амжилттай оролцлоо.

Урилгат уншлагын үеэр зохиогдсон ажлууд:

- Хүүхдийн танхимын номын санд мөрдөх журамтай танилцуулах
- Номын тэмдэглэл хөтлөх тухай ярилцах
- Ном унших арга, уншлагын соёлын талаар зөвлөгөө өгөх
- Номын сангийн номтой хэрхэн харьцах талаар бяцхан зөвлөгөө өгөх
- Шинээр карт нээх
- Чөлөөт ярилцлага буюу хүүхдүүдийнхээ санаа бодлыг сонслоо.

“Номыг хэрхэн зөв унших вэ?” Сэдвээр багштай туршлага солилцов.

12 жилийн 2-р сургуулийн 2а ангийн багш Алтанцэцэг номыг оновчтой хурдан унших талаар бяцхан зааварчилгаа өглөө.

“ Гоо сайхан ертөнцийг аварна” танин мэдэхүйн сургалт

Урин дулаан хаврын улирал ирж байгаатай холбогдуулан охид бүсгүйчүүддээ болон өсвөр үеийнхэндээ үс болон арьс арчилгааны талаар ярилцлага лекцийг зохион байгууллаа.Мэргэжлийн гоо сайханчтай уулзуулж хэрхэн зөв гоо сайхандаа анхаарах , өөрт туламдаад байгаа асуудалдаа зөвлөгөө авч багахан ч гэсэн зөв ойлголттой болгох зорилгоор “Оюу” салоны гоо сайханч Уянгатай хамтран ажилалаа.

Өсвөр үеийн охид хөвгүүдийн дунд насны онцлогоос үүдэлтэй асуудал тулгардаг. Энэ үед зөвхөн өөрийн арьсны онцлогт тохирсон аргыг хэрэглэж мэргэжлийн гоо сайханчнаас зөвлөгөө авахад энэхүү ярилцлага, лекц чухал ач холбогдолтой байлаа.

“ Үндэсний бичиг үсгийн баяр”

Соёл олон нийтийн ажлын хүрээнд "Үндэсний Бичиг Үсгийн Баяр"-ыг энэ жил 05-р сарын 16 ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Партзианы талбай дээр аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүллээ. Энэхүү ажлын хүрээнд үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдлэх хойч үедээ сурталчилан түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх зорилготой олон ажлуудыг зохион явуулсан. Үүнд:

- "Үндэсний бичиг үсгээ эрхэмлэн дээдлэгч"шилдэг сум, байгууллага
- "Үндэсний бичиг үсгээ түгээн дэлгэрүүлье" хэлэлцүүлэг, ЕБС-иудын дунд уралдаан тэмцээн
- Сэлэнгэ аймгийн сумдуудын дунд " Үндэсний бичиг үсэг"-ийн үзэсгэлэн
- " Уран бичигтэн" шалгаруулах
- " Тэргүүний шилдэг уншигч" " Нацагдорж"тэмдэгээр шагнах гэх мэт олон сайхан ажлуудыг зохион тэмдэглэн өнгөрүүллээ.

" Илтгэл"-ийн уралдаан болон улиралд 1 удаа тавигддаг сургалт

Байгууллагын зүгээс ажилчдынхаа ур чадварыг хөгжүүлэх зорилгоор зохион явуулласан " Уран илтгэл "-ийн уралдаанд амжилттай оролцож " Хүүхдийн уншлагыг удирдахуй" сэдвээр илтгэл болон " Ном хүүхэд хоёр" сэдвээр сургалт явууллаа.

АЗДТ газраас жил бүр зохион явуулдаг " Нээлттэй хаалганы өдөр"

"Нээлттэй хаалганы өдөр"-т оролцож байгууллагынхаа үйл ажиллагаа, шинэ ажил үйлчилгээгээ ард иргэддээ сурталчилан танилцууллаа.

Өөрийгөө хөгжүүлэх:

- Өөрөө бие дааж номын сангийн хууль дүрэмтэй танилцаж, хүүхдийн тэнхимийн ажлын үйл явц, үйл ажиллагааг судалсаны үндсэн дээр хүүхдийн тэнхимд мөрдөх журамыг, уншлагын дэгийг боловсрууллаа.
- Lib4U праграмм-дээр ажиллаж, гэрээр ном олгох болон фондны номнуудыг системчлэн праграммчлан компьютер дээр ажиллах хэрэглээгээ нэмэгдүүлэв.
- Танин мэдэхүйн уралдаан тэмцээн болон уншигч хүүхдүүдийнхээ оюуны хөгжилд тохирсон мэдлэг чадварыг нь сайжруулах материал боловсруулах, бэлдэх ажлуудыг хийх нь хүүхэдтэй ажиллах чадварыг сайжруулсан.
- Байгууллагын зүгээс ажилчдынхаа ур чадварыг хөгжүүлэх зорилгоор зохион явуулласан " Уран илтгэл "-ийн уралдаанд амжилттай оролцож " Хүүхдийн уншлагыг удирдахуй" сэдвээр илтгэл тавьж 1-р байр эзэлсэн.
- " Ном хүүхэд хоёр" сэдэвт илтгэлийг байгууллагынхаа хүрээнд амжилттай тавьлаа.
- "Сибирийн боловсролын төв"-тэй хамран " Hallyween"-ны баярын арга хэмжээнд шүүгчээр ажиллав.
- Фонд болон Гэрээр ном олгох тасгийн номнуудыг өдөрт 30-аас дээш ширхэгээр Lid4U праграммд оруулав.
- Фонд болон Гэрээр ном олгох тасгийн номнуудыг ном зүйн ангилалын дахин шинэчилсэн ангилалаар ангилж, техник ажиллагаанд суралцан туршлага суув.

5.3.3. Тохижилт үйлчилгээ

- Хүүхдийн уншлагын тэнхимийнхээ уншигчдынхаа нэрсийн жагсаалтын ялгагчийг солив.
- Фонднoос хүүхдийн номнуудыг хайж, дахин тоолж тэнхимийн номнуудыг төрөлжүүлэн ангилав.
- Гарын доорхи зүйлсийг ашиглан сэтгэхүй хөгжүүлэх тоглоом хийж, уралдаан тэмцэээний материал цуглуулж, СОН-н ажлын хүрээнд хүүхдүүдэд зориулсан мэдээ мэдээлэлийг болосруулаcан.
- Хүүхдүүдийн бүтээлүүдээр багахан хэмжээний тохижилт хийв.
- Уншлагын ширээ бүр дээр сайн уншигчийн мөрдвөл зохих 10 дүрмийг наав.
- "Хүүхэд бүр уншигч " самбарыг байрлуулав.
- Зохиолчдын зургийг угаалгаж, байрлуулахад бэлэн болгов.

6.Зөөврийн номын сангийн үйлчилгээний ажлын хүрээнд

Зөөврийн номын сан нь номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах тэдний албан бус боловсролд дэмжлэг үзүүлэх зорилго тавин ажиллаа.

2014 онд нийт 330 нэр төрлийн шинэ, сонирхолтой номоор 8 байгууллагын 720 уншигчдад үйлчилэн 12 шинэ уншигчийг бүртгэн номын сангийн байнгын үйлчлүүлэгчээр бүртгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Сүхбаатар сумын алслагдсан 2 дүүрэг болох Корпус Хорооллын багт ажиллан алслагдсан сум дүүргийн иргэдэд үйлчилэн нийт 120 хүнд 180 ном олгон номын сангийн үйчилгээг үзүүллээ.

Нийт 12 уншигчийг номын сангийн уншигчаар бүртгэн авлаа.

Олгосон номын тоо	Нийт үйлчилсэн хүний тоо	Хамрагдсан байгууллагын тоо	Алслагдсан сум дүүрэг	Зохион байгуулсан ажил	Карт нээсэн хүний тоо
600	**760**	**8**	**3**	**5**	**12**

Нийгмийн зорилтот бүлгийн хүмүүст соёлын үйлчилгээг хүргэх зорилгоор нийгмийн халамж үйлчилгээний дэргэд "Ахмадын сувилал"-д 2 удаа ажиллаж Ахмадуудын дунд "АХА" тэмцээн, цэнгээнт бүжгийг тус тус зохион байгуулж дурсгалын зүйлээр урамшууллаа.

Мөн Сэлэнгэ аймгийн ОБГ, ШШГГ-2 удаа ажиллаж хүмүүжигч нартай ном унших ач холбогдолын талаар ярилцлага зохион байгуулж, 5:6-р ЕБС-иуд,зэрэг албан байгууллагуудаар явж үйлчиллээ.

4-р сард Уншлагын танхимын номын санч Ц.Гэрэлцэцэг, Мэдээллийн технологич Г.Батбаяр,Фондоч Б.Цолмонбаатар нартай хамтран Баянгол суманд "Баянголчуудын соёлын өдөрлөг"-т орлцож, номын худалдаа, шинэ номын үзэсгэлэн гарган цахим ном, номын сангийн автоматжуулалтын талаар сурталчилгаа хийж," АХА" тэмцээн зохион байгуулан Баянголчуудаас өндөр үнэлгээ авлаа.

5-р сард Үндэсний бичиг үсгийн баярын зохион байгуулалтын арга хэмжээнд идэвхтэй орлцлоо

Номын сангийн гадна талын зүлэгжүүлэлт, мод тарих ажилд идэвхи санаачлагатай оролцож санаачлан зохион байгуулав.

5-р сард Номын санч нарын илтгэлийн уралдаанд "Зөөврийн номын сангийн үйлчилгээ" сэдвээр илтгэл тавин оролцлоо.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй "Ногоон Сэлэнгэ" хөдөлгөөнд мод тарих ажилд оролцлоо

6 сарын 1нд эх үрсийн баяраар үлгэрийн баатар болж хүүхэд багачуудыг баярлуулж номын сангийн үйл ажиллагааг сурталчилан ажиллав.

9-р сарын 19: 20-нд Улаанбаатар хотод номын баярт оролцон Үндэсний номын санд "Номын сангуудын өнөөгийн байдал", Улаанбаатар хотын төв номын санд тэгш ой тохиосон номын сангуудын тайлан ярилцлага зэрэг үйл ажиллагаанд оролцон туршлага судаллаа. Мөн номын баяжилтанд интерномын дэлгүүрээс нийт 400.000 төгрөгийн 28 ширхэг номыг худалдан авлаа.

9-р сард Дархан хотын 50 жилийн ойн баярт оролцож Дархан хотын төв номын сан, Хүүхдийн номын ордон, Дархан хотын музейн үйл ажиллагаатай танилцлаа. Тус номын сангаас зохион байгуулсан "Ном бол оюун санааны тусгаар тогтнол" гэсэн уриатай явагдсан Номын баярын зохион байгуулалтанд оролцлоо.

Соёлын ажилтаны баярын хүрээнд зохион байгуулагдсан дардасны тэмцээнд оролцож 1-р байр эзлэн амжилттай оролцлоо..

Энэ хугацаанд нийт 5 соёл олон нийтийн ажлыг зохион байгуулан ажиллаа. Байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт семинар соёл олон нийтийн ажил, тохижилт бүтээн байгуулалтын ажилд идэвхтэй оролцож ажиллаа. Мөн байгууллагын сургалтын төлөвлөгөөний хүрээнд 10 дугаар сарын 22-ны өдөр Сэлэнгэ аймаг дахь "Ариусахуй" бясалгалын төвтэй хамтран стрессээс гарах, бясалгалын аргуудыг сурах сургалтыг зохион байгуулж нийт 14 ажилтан албан хаагчдыг хамрууллаа.

7. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан ажил

Онцгой байдлын газраас зохион явуулсан "Гамшгаас хамгаалах үзүүлэн таниулах сургалт" –нд хамт олноороо идэвхитэй оролцов.

Сэлэнгэ аймгийн ЗДТГазар, ССАЖГазраас хамтран төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан “Цасны баяр”-ын арга хэмжээнд баг хамт олноороо идэвхи санаачлагатай оролцож 3-р байр эзлэв.

2014 оныг Гэр бүл хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан Сэлэнгэ аймгийн ХГБХХэлтэсээс зохион байгуулсан чуулга уулзалтанд оролцов.танилцан туршлага солилцов.

Газрын албаны мэргэжилтэн Х. Болор-Эрдэнэ газар өмчлөлт, шинээр газар авахад ямар бичиг баримт бүрдүүлэх, хаана газар өгч байгаа талаар мэдээлэл авлаа.

Аймгийн засаг даргын нэрэмжит шилжин явах цомын төлөөх болон соёл урлагийн ажилчдын баярын өдрөөр зохион байгуулагдсан “Спортын наадам”-д Гар бөмбөг, Сагсан бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож, Дардсын тэмцээнд 1-р байр, гар бөмбөгөөр эмэгтэйчүүдийн баг 4-р байр эзэллээ.

Номын сангийн ажилтан ажиллагсдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг хөгжүүлэх илтгэх, ярих ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Шилдэг илтгэлийн уралдаан”-ыг зохион байгуулж номын санчид идэвхтэй оролцлоо.

Дархан уул аймгийн “Төв номын сан”-гийн 50 жил, “ Номын баяр”-ын үйл ажиллагаанд оролцож “Хүүхдийн номын ордон”, “ Төв номын сан”-гийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцов.

“Сибирийн боловсролын төв”-тэй хамтран мэргэжлийн ажилчидаа англи хэлний анхан шатны 5 сарын сургалтанд хамруулж, “ Hallyween”-ны баярыг байгуулагынхаа хүрээнд англи хэлнийхээ түвшинг дээшлүүлэх зорилгоор тэмдэглэв.

Номын сангийн ажилчидыг “Хөдөлгөөн бол амжилтын үндэс" уриан доор спортоор хичээлүүлэх захиаллагыг БТС газарт өгч, 11 сарын 1 эхлэн спортын зааланд 7 хоногт 1 удаа чөлөөт цагаа өнгөрөөх болов .

Уншигчдын ном унших таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сар бүрийн 25нд уншлагын танхимд их цэвэрлэгээ хийж байна.

2014 оны тоон үзүүлэлт

Уншигч ном олголт

Тасаг хэлтэс	Шинэ уншигч	Ном олголт	Ирц	Сэлбэн засалт	Татгалзал
ГНОТ,НУТ	346	9681	6021	500	62
ХУТ	676	6508	2885	500	22
ЗНС	12	600	760	100	35
ФОНД		1460	740	300	68
Нийт	**1034**		**10375**	**1400**	**187**

Зохион байгуулсан СОНА

Тасаг хэлтэс	СОНА тоо	Оролцсон хүний тоо
ГНОТ,НУТ	15	874
ХУТ	35	2304
ЗНС	5	235
ФОНД		
Нийт	**55**	**2539**

Нийт олгосон ном буюу номын үзэсгэлэн:

Д/д	ГНОТ	Явуулын н/санч	Мандал сум	Хушаат сум	Нийт	Фонд эргэлт
Ном олголт	**420**	**300**	**3**	**6**	**729**	**2%**

Д/д	Баянгол 1 өдөр өдөрлөг	ЗДТГазрын ажилчдын дунд шинэ номын мэдээлэл	Нээлттэй хаалганы өдөрлөг	Цагаан нуур сум	Үндэсний бичиг үсгийн баяр	Номын баяр	Эрдмийн баяр 6-р сургууль	Нийт
Номын үзэсгэлэн	**90**	**36**	**280**	**39**	**48**	**60**	**58**	**9 удаа**

Арга зүйн сургалтын тоон үзүүлэлт

Д/д	Сугалтын сэдэв	Хамрах хүрээ	Хамрагдсан хүний тоо
1	Номын санчийн мэргэжлийн ёс зүй	Нийтийн номын санчид мэргэжлийн ажилчид	6
2	Оновчтой уншлагыг удирдах тухай	Нийтийн номын санчид мэргэжлийн ажилчид	6
3	Солонгос улсын номын сангийн ёс зүйн тунхагын тухай	Нийтийн номын сангчид мэргэжлийн ажилчид	6
4	Номын сангийн үндсэн үйл ажиллагааны тухай	Зэлтэр бүсийн номын санчид	4
5	Оновчтой уншлагыг удирдах тухай	Цагааннуур сумын сургуулийн ахлах ангийн сурагчидын дунд	30
6	Номын сангийн үндсэн үйл ажиллагааны тухай	Хөтөл бүсийн номын санчид	4
7	Номын сангийн үндсэн үйл ажиллагааны тухай	Сэлэнгэ аймгийн ЕБС-ын номын санчид	30

8	Оновчтой уншлагыг удирдах тухай	Сүхбаатар сумын 3-р сургуулийн ахлах ангийн сурагчид	18
9	Номын санчийн мэргэжлийн ёс зүй	Сүхбаатар сумын ЕБС-ын номын санчид	6
10	Оновчтой уншлагыг удирдах тухай	Сүхбаатар сумын ЕБС-ын номын санчид	6
11	Номын сангийн үндсэн үйл ажиллагааны тухай	Сүхбаатар сумын ЕБС-ын номын санчид	6
	НИЙТ		122

Мэдээлэл технологийн сургалтын тоон үзүүлэлт

Д/д	Сургалтын нэрс	Хамрагдсан хүний тоо	Сургалтын тоо
1	Monbilio программын сургалт	35	5
2	Цахим номын сангийн сургалт	26	2
3	“Програм хангамж ба номын сан” сургалт	7	1
4	Номын сангийн цахим үйлчилгээ талаар	16	2
5	Анхан шатны англи хэлний сургалт	6	1
	Нийт	90	11

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Номын фонд баяжилт, хадгалалт, хамгаалалт, сэлбэн засах ажлын талаар:

Аймгийн Нийтийн номын сан нь 2014 оны байдлаар төсвөөр 298 ширхэг 11-н төрлийн 3.462.900 төгрөгний шинэ ном, хандиваар 102 ширхэг 7 төрлийн ном, 5-н төрлийн 140.000 төгрөгний тогтмол хэвлэл захиалан авч ангилал, техник ажиллагаа, электрон каталогийг бичин уншлагын танхимуудад хувиарлаж уншигчдын хүртээл болгож байна. Мөн “Шилдэг ном 2013”-т шалгарч яамны хөрөнгө оруулалтаар ирсэн 48 нэрийн 9 төрлийн 274 ш 2,775,460 төгрөгний номыг аймгийн Нийтийн номын сан болон сумдын соёлын төвийн номын сангуудад хувиарлан олгосон.

Он	Фонд баяжилт	Сэлбэн засалт	Лавлагаа ном зүй	Орлого
2013 он	5,097,800	470	557	272,000
2014 он	5,339,900	284	562	144,000

2. Байнгын уншигч, ирэгсэд, олгож уншуулсан номын тоог нэмэгдүүлсэн байдал

Танхимууд	2013 он /Бүтэн жил/			2014 он /Бүтэн жил/		
	Байнгын ушигч	Ирэгсэд	Олгож уншуулсан ном	Байнгын ушигч	Ирэгсэд	Олгож уншуулсан ном
Насанд хүрэгчдийн уншлагын танхим	1600	6154	15952	1600	6200	15970
Хүүхдийн уншлагын танхим	1600	6925	22578	1600	6236	20904
Гэрээр ном олгох танхим	606	1962	4349	664	1989	4482
Үндсэн фонд	-	557	-		562	
Бүгд	**3806**	**15598**	**42879**	**3864**	**14987**	**41356**
Интернэт канон компьютерийн үйлчилгээ	**-**	**885**	**-**	**-**	**903**	**-**
Зөөврийн номын сан	**-**	**1970**	**3080**	**-**	**2109**	**3464**
Нийт уншигч үйчлүүлэгч /байнгын уншигч + ирэгсэд + интернэт үйлчилгээ+зөөврийн номын сангийн үйлчилгээний нийт дүн/	**22259**		**45959**	**21863**		**44829**

Аймгийн Нийтийн номын сан нь 2014 оны байдлаар 3864-н байнгын уншигч, 14987 ирэгсэд нийт 18851 уншигчдад 41356 ш ном олгож уншуулсан нь 2013 онтой харьцуулахад байнгын уншигчдын тоо 1.5%-иар өсч, ирэгсэд 3.9%-иар буурсан үзүүлэлттэй байна.

3. Хөдөө орон нутагт явуулын номын сангийн үйлчилгээг хүргэсэн байдал

№	Байгууллага	Уншигч	Олгож уншуулсан ном
1.	ХЦ дотуур байр	160	220
2.	Боловсролын газар	16	38
3.	Цагдаагийн газар	86	190
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	80	160
5.	016-р цэргийн анги	200	260
6.	МСҮТ	224	286
7.	Нийгмийн даатгалын хэлтэс	66	116
8.	Цахилгаан холбоо ХХК	62	114
9.	4-р баг	60	80
Сумдууд			
1.	Мөнгөнморьт	120	210
2.	Баяндэлгэр	126	180
3.	Баянжаргалан	62	120
4.	Эрдэнэ	120	190
5.	Жаргалант	160	220
6.	Баянцогт	132	270
7.	Сүмбэр	126	260
8.	Лүн	123	200
9.	Эрдэнэсант	126	230
10.	Өндөрширээт	60	120
Нийт		**2109**	**3464**

4. 2014 оны ажлын үр дүн, зохион байгуулсан соёл, олон түмний ажил

➢ Аймгийн Нийтийн номын сан байгуулагдсаны 70 жилийн ойг угтаж Лавлагаа мэдээллийн өрөөг өргөжүүлж “Эрдэм шинжилгээ, лавлагаа ном зүйн танхим” болгож Статистик мэдээ мэдээлэл, харилцаат мужууд, лавлагаа мэдээлэл, орон нутаг зэрэг 4-н төрлийн булан ажиллуулж 562 иргэсэдэд үйлчилсэн. Мөн интернэт мэдээллийн өрөөг “Цахим мэдээллийн танхим” болгон өргөжүүлж нийт 903 үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Эрдэм шинжилгээ, лавлагаа, ном зүйн танхим

Цахим мэдээллийн танхим

➢ Аймгийн Нийтийн номын сан байгуулагдсаны 70 жилийн ойг угтаж орон нутагт бүтээлч ажлыг өрнүүлэх зорилгоор “Номын элч” амжилтын буухиа аяныг аймгийн хэмжээнд 2014.05.15-2014.08.15-ны хооронд зарлан 4-н бүс болгон зохион байгуулж оролцсоноос Мөнгөнморьт сумын соёлын төв тэргүүн байранд орж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

➢ Аймгийн Нийтийн номын сан, Ахмадын хороо хамтран жил бүрийн 04-р сарын 23 “Дэлхийн номын баяр” болон “Зохиогчийн эрхийн өдөр”-ийг тохиолдуулан Зуунмод суманд ажиллаж амьдардаг зохиолч яруу найрагчдын шинээр гаргасан бүтээлийг иргэд уншигчидад суртчилах уламжлалт зан заншлаа хөгжүүлж ном эрдмийг хүндэтгэн дээдлэх ард иргэд, хүүхэд, залуусыг номтой нөхөрлүүлэх, номыг унших идэвхийг өрнүүлэх суу сэтгэлгээний бүтээлүүдээ нандигнан хайрлаж ном дор мөргөхийг сүслэн, эрхэмлэн уншдаг ариун ёс уламжлалыг хөгжүүлэх, ахмад зохиолчдоос суралцаж тэдний сургамж туршлагыг судлах зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг “Эрдэм номоо дээдлэе” арга хэмжээг 2013-2014 онд гаргасан шинэ бүтээл шалгаруулах, ЕБС-ийн яруу найрагч сурагчдын дунд шүлгийн уралдаан тус тус зохион явууллаа. Энэхүү арга хэмжээнд нийт 70 гаруй уран бүтээлч зохиолч, яруу найрагч, үзэгч, сурагч хүүхэд багачууд оролцож зохиолчид өөрсдийн бүтээлүүдээр шинэ номын үзэсгэлэн гарган, 2013-2014 онд шинээр гаргасан бүтээлүүдийнхээ утга санаа үйл явдал агуулллагын талаарх товч мэдээллүүдийг хийж танилцууллаа. Энэ оны шилдэг бүтээлээр Төв аймгийн хүнс хөдөө аж ахуйн ассоциацийн захирал зохиолч Ч.Жадамбаагийн 2013 онд хэвлэгдэж гарсан хамгийн олон уншигчийн хэрэгцээг хангаж байгаа “Мал аж ахуй бизнесийн нууцад нэвтэрхүй” ном тэргүүн байранд шалгарлаа.

Шүлгийн уралдаанд ХЦС сургууль, 4-р сургууль, 5-р сургуулиудаас нийт 18 шүлэг яруу найраг сонирхдог хүүхэд багачууд өөрсдийн бичсэн шилдэг шүлгүүдээ уншиж өрсөлдсөнөөс ХЦ дунд сургуулийн 8д ангийн сурагч Хатантөмөр “Ээжийгээ би зүйрлэлээ” шүлгээрээ тэргүүн байр, ХЦС 9-р ангийн сурагч Далайцэрэн “Анд чамдаа” шүлгээрээ дэд байранд тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

➢ МУ-ын ерөнхилөгчийн зарлиг, МУ-ын засгийн газрын тогтоолоор батлагдсан, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II” хэрэгжүүлэх зорилгоор жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногт “Үндэсний бичиг үсгийн баяр” болгон өргөн дэлгэр арга хэмжээ зохион явуулдаг уламжлалтай. Зуунмод сум, аймгийн нийтийн номын сан хамтран “Үндэсний бичигтэн” арга хэмжээг зохион явууллаа. Энэ арга хэмжээ нь Монгол бичгийг хойч үедээ өвлүүлэх, сурталчлах үүднээс зохион байгуулж байна. “Үндэсний бичигтэн” арга хэмжээний энэ жилийн онцлог нь албан газар, аж ахуйн нэгж, багийн иргэд оролцож, монгол бичгээр цэвэр сайхан бичиж, монголоос крилл, криллээс монгол бичиг рүү хөрвүүлэн өрсөлдөж байгаагаараа онцлогтой. Энэ жил:

1. Сурагчдын дундах тэмцээн
2. Хөгжөөн дэмжигчдийн дундах тэмцээн
3. Албан газар, аж ахуйн нэгж, багуудын дундах тэмцээн
4. Бүтээлийн үзэсгэлэн гэсэн 4 төрлөөр уралдаж дүнгээ гаргалаа.

“Монгол бичигтэн” уралдааны албан байгууллага аж ахуйн нэгж, багуудын дунд зохиосон тэмцээнд:

1-байранд: 4-р Сургуулийн “Судар бичиг” баг
2-р байранд: ХЦДСургуулийн “Гэрэгэ” баг
3-р байранд: Хаан банкны “Босоо монгол” баг тус тус эзэллээ.

ЕБС-ийн Сурагчдын дунд багш сэдэвтэй зохион бичлэгийн уралдаанд:

1-р байр: ХЦДСургуулийн 9-р ангийн сурагч Мөнхбаясгалан
2-р байр: 5-р Сургуулийн 9-р ангийн сурагч Эмүжин
3-р байр: 4-р Сургуулийн 9-р ангийн сурагч Гантулга
Тусгай байр: ХЦДСургуулийн 9-р ангийн сурагч Далайцэрэн

Хөгжөөн дэмжигчдын дунд зохион байгуулсан “Аха” тэмцээнд 36-н хөгжөөн дэмжигч оролцон оюун ухаанаа сорьсоноос ХЦСургуулийн ажилтан Х.Ганхуяг тэргүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Бүтээлийн үзэсгэлэнд 4-н байгууллага оролцсоноос Аймгийн музейн хамт олны гаргасан бүтээлийн үзэсгэлэн тэргүүн байр эзэллээ.

➢ Монгол улсын Засгийн газрын 295 дугаар тогтоолоор батлагдсан “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн “Ном” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон аймгийн нийтийн номын сан байгууллагдсаны 70 жилийг угтсан бүтээлч ажлыг хүрээнд гэр бүлийг гэр бүлээр нь ном уншуулах, ном туурвин бүтээх шилдэг арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, энэ үйлсэд олон нийтийн татан оролцуулах зорилгоор “Оюунлаг гэр бүл” аяныг 2014 оны 3, 4-р сард Боловсролын газартай хамтран зохион байгуулсан. Аянд 26 сум хамрагдсанаас 13 сум амжилттай оролцож 1-р байрыг Баяндэлгэр сумын гэр бүл, 2-р байрыг Баянчандмань сумын гэр бүл, 3-р байрыг Лүн сумын гэр бүл тус тус эзэллээ.Тэдний арга туршлага амжилтыг орон нутгийн телевизээр сурталчилсан.

➢ “Номын сайн нөхөр-сургууль, хамт олон, сурагчдыг шалгаруулах уралдаан 3 дахь жилдээ амжилтай зохион байгууллагдлаа. Энэ хичээлийн жилд зохион байгууллагдсан уралдаанд Баянчандмань сумын сургууль 1-р байр, Борнуур сумын сургууль 2-р байр, Зуунмод сумын 5-р сргууль 3-р байранд орсон.

Анги хамт олноос: Баянчандмань -1а
Борнуур-2а
Зуунмод 5-р сургууль-3а
Баянчандмань-4-р анги
Баянчандмань-5-р анги
Алтанбулаг-6б анги
Баянчандмань-8в анги тус тус тэргүүн байр эзэлж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнагдлаа. Уралдааны үр дүнд нийт сурагчдын 86.4% нь номтой нөхөрлөсөн нь өмнөх жилээс 14.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

➢ “Ном” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон аймгийн нийтийн номын сан байгууллагдсаны 70 жилийг угтсан бүтээлч ажлыг хүрээнд “Ном унших арга зүй” сэдэвт илтгэлийн уралдааныг хүүхэд залуус, гэр бүлийн ном унших сэдэл тэмүүллийг төрүүлэх, бүтээлчээр унших арга болон ном унших соёлд суралцуулах, номыг эрхэмлэх үзэл санааг төлөвшүүлэх, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгууллаа. Уг уралдаан 10 илтгэгч оролцсоноос ХЦ ахлах сургуулийн багш Аминдаваа 1-р байр, Сүмбэр сумын багш Гомбосүрэн 2-р байр, Баянчандмань сумын багш Улаанхүү 3-р байранд шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

➢ Танин мэдэхүйн “Элсэн цаг” тэмцээнийг Монгол улсад орчин үеийн музей байгуулагдсаны 90 жил, төв аймагт нийтийн номын сан байгууллагдсаны 70 жилийн ойн хүрээнд төрөлх эх орныхоо болон төв аймгийн түүх соёлыг судлан хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан давдагдашгүй өв уламжлал, ёс заншлаа танин мэдэх, сурталчлах, ажилтан албан хаагчдын мэдлэгт зохих ёсны оюуны хөрөнгө оруулалт хийх, номтой нөхөрлүүлэх зорилгоор Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллагууд оролцлоо. Уг арга хэмжээнд 5 байгууллага оролцсоноос Аймгийн нэгтсэн эмнэлэгийн “Чу мэргэн” баг 1-р байр, Шийдвэр гүйцэтгэлийн албаны “Бүргэдийн дэвэлт” баг 2-р байр, Эрүүл мэндийн газарын “Тэмцэл” баг 3-р байр эзлэж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

➢ Аймгийн нийтийн номын сан нь 10-р сард аймгийн нийтийн номын сан байгууллагдсаны 70 жил, төв аймагт утга зохиолын салбар байгуулагдсаны 60

жилийн ойг тохиолдуулан Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр төв аймгаас төрсөн зохиолчдын “Уран үгсийн чуулган” уулзалт цэнгүүнийг зохион байгуулж нийт 40 гаруй зохиолч, яруу найрагч оролцсон. Мөн ой угтаж “утга зохиол” сонинд аймгаас төрсөн зохиолч, яруу найрагчдад төрөлх нутгийнхаа оюуны сан хөмрөгт ном хандивлах уриалга гаргаснаар 43 нэрийн 300 гаруй ном хандиваар ирсэн.

➢ Жил бүр уламжлал болгон аймгийн төвийн цэцэрлэгүүдийн дунд хүүхэд багачуудын хэл яриа, сэтгэн бодох, жүжиглэх чадварыг хөгжүүлэх замаар номтой нөхөрлүүлэн ирээдүйн уншигчийг бэлтгэхээр зохион явуулдаг “Үлгэрийн баатрууд амилсан нь” тэмцээнийг 2014.04.28- нд аймгийн нийтийн номын санд зохион явууллаа. Уг арга хэмжээнд 3 цогцолбор цэцэрлэгийн 7 баг оролцсоноос 1-р байранд Сувилгаа чийрэгжүүлэлтийн төвийн “Хөх толбот” баг, 2-р байрт Дэгдээхэй

цэцэрлэгийн “Б” байрны “Угсаатан” баг, 3-р байрт Дэгдээхэй цэцэрлэгийн “А” байрны “Их монгол” баг орж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

➢ Аймгийн Нийтийн номын сан байгууллагдсаны 70 жилийн ойг угтаж Зуунмод суманд шатрын спортыг сурталчилан дэлгэрүүлэх, хичээллэгсэд болон сонирхогчдын хүрээг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, хүүхэд, залуучуудын шатар тоглох ур чадварыг нэмэгдүүлэх, улс, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдөхүйц тамирчдыг төрүүлэн гаргах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор аймгийн Нийтийн номын сангийн 70-н жилийн ойн нэрэмжит өсвөрийн шатарчдын “Номын өргөө-2014” тэмцээнийг 4 насны */эрэгтэй, эмэгтэй/* ангиллаар зохион явууллаа. Уг тэмцээнд нийт 90 гаруй шатарчид оюун ухаан ур чадвараа сорьж оролцсон. Тэмцээн зохион байгуулсаны үр дүнд Зуунмодын баг бүрдүүлэн ААШТэмцээнд оролцож багаараа 3-р байранд орсон.

➢ Хүүхдийн номын санч нь 7 цэцэрлэгийн 21 ангид 34-н номоор чанга уншлага хийж давхардсан тоогоор 729 хүүхдүүдийг үлгэрийн ертөнцөөр аялуулсан.

➢ Олон улсын хүүхдийн номын баярын өдрийг тохиолдуулан номын сангийнхаа үйл ажиллагааг сурталчилах, хүүхэд залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор “Номын сангийн хишиг өдөр”-ийг зохион байгуулсан. Хишиг өдөрт ХЦСургуулийн 10г ангийн сурагч Номин-Эрдэнэ, 10в ангийн сурагч Лувсандэндэв, 5-р сургуулийн 10б ангийн сурагч Э.Цэрэндолгор, Б.Отгонлхагва, 4-р сургуулийн 10а ангийн сурагч Болоржаргал, Номин нар оролцож номын санч нартай хамтран нэг өдрийн үйл ажиллагааг явууллаа.

5. Интернэт болон цахим үйлчилгээ



➢ Аймгийн Нийтийн номын сангийн Интернэт мэдээллийн танхимаар 2014 байлаар 903 хүнд үйлчилж 144,000 төгрөгний орлоготой ажилласан.

➢ Байгууллагын танилцуулга, танхимуудийн танилцуулга, эрхэм зорилго, зорилт, иргэдэд хүргэж буй үйлчилгээ, шинээр ирсэн номын болон үйл явдлын мэдээ, санхүүгийн тайлангийн мэдээ, статистик мэдээллүүдийг иргэд уншигчдад ойлгомжтой байлаар өөрийн байгууллагын вэб сайт болох www.library.to.gov.mn сайтад байрлуулан иргэдэд цахим мэдээлэл хүргэхэд 2014 оны байдлаар 5064 хүн үзэж мэдээ мэдээлэл авсан байна.

➢ ССАЖЯ-ны санаачилгаар орон нутгийн номын сангийн үйл ажиллагааг автоматжуулах ажлыг орон нутагт амжилттай хэрэгжүүлж 2014 оны байдлаар соёлын төвийн номын сангуудын фондын нийт 116938ш номноос 105640ш номыг электрон каталогит оруулсан нь нийт номын 90,8%-г эзэлж байна.

Сумдын соёлын төвийн номын сангууд фондын ном электрон катологт оруулсан судалгаа

2014 оны 12-р сар

№	Сумдын нэр	Номын санчийн нэр	Фондын тоо /2014/	2014 оны 11 сар	
				тоо	хувь
1	Алтанбулаг	Эрдэнэцэцэг	5380	5370	99,8
2	Аргалант	Ү.Туул	3713	3718	100,0
3	Архуст	С.Цэнгэлмаа	5959	5546	93,1
4	Баян	Б.Оюунхайч	4917	3490	71,0
5	Баяндэлгэр	З.Долгор	4741	4770	100,0
6	Баянжаргалан	Г.Загдсүрэн	4783	4803	100,0
7	Баянхангай	Пүрэвсүрэн	4495	4424	98,4
8	Баянцагаан	Баасансүрэн	6206	3010	48,5
9	Баянцогт	Е.Эрдэнэчулуун	5648	5584	98,9
10	Баянчандмань	Д.Нарантуяа	1830	2026	100,0
11	Баян-өнжүүл	Сарантуяа	4113	4123	100,0
12	Батсүмбэр	Ц.Сувд-Эрдэнэ	3126	2651	84,8
13	Борнуур	Э.Эрдэнэцэцэг	3884	2160	55,6
14	Бүрэн	Нансалмаа	4749	4502	94,8
15	Дэлгэрхаан	Ө.Буд	3211	3246	100,0
16	Жаргалант	Ж.Энхтуяа	3870	2697	69,7
17	Заамар	Х.Нарантуяа	6468	5901	91,2
18	Лүн	Д.Алтанцаг	4320	4243	98,2
19	Мөнгөнморьт	Оюунжаргал	4945	4461	90,2
20	Сүмбэр	Ч.Шоовдор	3967	3975	100,0
21	Сэргэлэн	Г.Дулмаа	3243	2942	90,7
22	Угтаал	Я.Мөнхтуяа	5437	5359	98,6
23	Цээл	Б.Алтанцэцэг	5935	5958	100,0
24	Өндөрширээт	Отгон	3840	3132	81,6
25	Эрдэнэ	Оюунцэцэг	4141	4141	100,0
26	Эрдэнэсант	А.Саран	4017	3807	94,8
	Дүн		**116938**	**106039**	**90,8**

6. Сургалт, семинарт хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал.

➢ Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу номын санч нарын мэргэжлийг нь дээшлүүлэн чадавхижуулж, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанарт үр дүн, ахиц гаргах зорилгоор "Монбиблио программын шинэчлэл, ашиглалт, сургуулийн номын сангийн үйлчилгээг боловсронгуй болгох нь" сэдвийн дор Соёлын төв, ЕБС, МСҮТ-ийн номын санчдын сургалт семинарыг 2014 оны 03 сарын 03-04-ны өдрүүдэд ССАЖГазар, БГазар, Хүүхдийн номын ордонтой хамтран зохион байгууллаа. Сургалтанд ЕБС, МСҮТөвийн номын санчдын 88%, соёлын төвийн номын санчдын 92% нь тус тус хамрагдан нийт 90%-ийн ирцтэй оролцож мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалт

Сумдын номын санчдын сургалт

➢ ССАЖЯам, ҮНСангаас зохион явуулсан “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээнд Ү/ 2-4 нд Захирал, Фондоч- Номзүйч, Мэдээлэл технологийн ажилтан нар оролцож орон нутгийн номын санч нарт зориулсан болон Монбиблио программын шинэчлэл ашиглалт сургалтанд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

➢ Төв аймгийн сумдын соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор соёлын мэргэжлийн албан хаагчдын ур чадварын уралдааныг 2014.11.26-нд аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Соёлын төвийн номын санч нарын ур чадварын уралдааныг 5-н шалгуур үзүүлэлт бүхий сорилоор дүгнэж байр эзлүүлэхэд 1-р байрт Баяндэлгэр сумын номын санч З.Долгор, 2-р байрт Лүн сумын номын санч Д.Алтанцаг нар шалгарлаа. Ур чадварын уралдааны дараа СУИС-ийн харъяа СБСургуулийн багш Т.Хайдаваар “Монбиблио программ дээр гарах нийтлэг алдаа” сэдвээр 2 цагийн сургалт байгуулсан.

➢ Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт сумдуудын номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үнэлгээ хийхэд соёлын төвийн үйл ажиллагаа тогтмолжсон хэвийн ажиллаж байгаа боловч ЕБС-ийн номын сангуудын үйл ажиллагаа хангалтгүй түвшинд байгаа учир 2015 оны ажлын төлөвлөгөөнд тусган мэргэжлийн туслалцаа үзүүлэхээр шийдвэрлэсэн.

7. Хөрөнгө оруулалт

➢ ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар бүх сумдын соёлын төвийн номын сангуудад каталогийн шүүгээ, тогтмол хэвлэлийн тавиур, номын тавиур олгогдож стандартад нийцсэн номын сангийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Мөн аймгийн Нийтийн номын сан соронзон хаалга, каталогийн шүүгээ, тогтмол хэвлэлийн тавиур зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдсан.

8. 2014 онд шинээр хийсэн ажил





➢ Аймгийн нийтийн номын сангийн 70 жилийн ойг тохиолдуулан Зохиолч, яруу найрагч Ш.Цэрэндоотой хамтран аймгийн хэмжээний номын сангийн түүхэн товчоо болох “Ном дор мөргөмү” номыг хэвлэн гаргасан.

➢ Хүүхэд залуус, гэр бүлийн ном унших сэдэл тэмүүллийг төрүүлэх, бүтээлчээр унших арга болон ном унших соёлд суралцуулах, номыг эрхэмлэх үзэл санааг төлөвшүүлэх, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан илтгэлийг олны хүртээл болгохын тулд “Ном унших арга зүй” эмхэтгэлийг хэвлэн номын сангуудад олгосон.

➢ Аймгийн нийтийн номын сангийн 70 жилийн ойг тохиолдуулан “Номын заяатай эгэл бурхад” нэртэй номын санчийн шинэ дуутай болж клип хийлгэсэн.

➢ Аймгийн Нийтийн номын сангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх зорилгоор Лавлагаа мэдээллийн өрөөг өргөжүүлж “Эрдэм шинжилгээ, лавлагаа ном зүйн танхим” болгож Статистик мэдээ мэдээлэл, харилцаат мужууд, лавлагаа мэдээлэл, орон нутаг зэрэг 4-н төрлийн булан ажиллуулж 562 ирэгсдэд үйлчилсэн. Мөн интернэт мэдээллийн өрөөг “Цахим мэдээллийн танхим” болгон өргөжүүлж нийт 903 үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Манай хамт олон “**Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц хөгжлийн түвшинд хүрч, Номын санг иргэдэд үйлчлэх нээлттэй “*Мэдээллийн төв”*** болгон хөгжүүлэх эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагаагаа төрөөс баримтлах соёлын бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон түүнийг хэрэгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна
Манай байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө стратегийн 3 зорилт бүхий 14 ажил үйлчилгээ, 4 тусгай захиалгат бүтээгдэхүүнийг нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтийг үзэхэд:

Стратеги-1 “**Байгууллагын тогтвортой хөгжил, номын сангийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах”** зорилтын хүрээнд :

1. Номын сангийн уншлагын танхимуудад нийтдээ 5 камер суурилуулсан. Үүнд : “Оюуны ундарга” танхимд 2 ш , Хүүхдийн танхимд 2 ш, үүдний коридорт 1 ш камер суурилуулж хяналтын самбарыг жижүүрийн өрөөнд суурилуулав.
2. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 70 удаа гаргалаа. Тухайлбал: Шинэ номын үзэсгэлэнгүүд, Хичээлийн шинэ жилд, Багш нарын баярт, Түүхэн тэмдэглэлт өдрүүдэд, Хүүхдийн уран зохиол, Орчуулгын уран зохиол, Аман зохиол, Үлгэрийн орноор аялцгаая, Хүүхдийн хүмүүжил, Гэр бүлийн өдөрт, Олон улсын эх хэлний өдөрт гэх мэт сэдвүүдээр 70 удаа гаргаж уншигчдад суртачиллаа.
3. Интернет үйлчилгээгээр 10000 хүнд үйлчиллээ
4. 5000 ширхэг номонд сэлбэн засалт хийлээ.
5. “Номын сангийн үйл ажиллагааны талаар болон шинэ номын мэдээ мэдээллийг САМА телевизээр 7 хоног бүр нийтэд сурталчилж байна.
6. Хилийн цэргийн 0245-р анги , 2-р цэцэрлэг, МХГ, Эрүүл мэндийн газар зэрэгт зөөврийн номоор үйлчилж байна.
7. Бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан “**Монгол бичгээр сайхан бичигтэн “шалгаруулах** ээлжит уралдааныг зохион явуулж дүгнэлээ. Үүнд: Багш сонирхогчдын ангилад цогцолбор 1-р сургуулийн багш Сүрэнхорлоо түрүүлж удаах байрыг УГПК багш Батхишиг эзэлж, сурагч оюутнуудын ангилад ХДС-ийн оюутан Баттогтох түрүүлж ,УГПК оюутан Нямсүрэн нар эзэллээ. Уралдааныг 2 дахь жилдээ **BABY SHOP** дэлгүүр 270,000 төгрөгөөр ивээн тэтгэж оролцлоо.
8. 2014 оны эхний хагас жилийн Уншлагын танхимын рекорд номоор “**Чонон сүлд”** роман, Тэргүүний уншигчаар өндөр настан Рагчаа овогтой Чулуунбаатар шалгарлаа.
9. “Хөдөө аж ахуй –газар тариалан” ”, шинэ тосгоны номын үзэсгэлэн , Цогцолбор 2-р сургуулиас солилцоогоор ирсэн номын үзэсгэлэн, Түүхэн сэдвт үзэсгэлэн, Хүүхдийн уран зохиол, Амьдрах ухаан, гэх мэт шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 70 удаа гаргалаа.
10. Доктор Л. Лханямын **“**Тэнгэрлэг монгол хүн” номоор уншигчдын бага хурлыг зохион байгууллаа. 250 гаруй оюутан залуус оролцож , номын сэдвүүдээр илтгэгч нар тус тусынхаа илтгэлийг тавьлаа. Илтгэлүүдээр гарын авлага гарган уншигчдад үйлчилж байна.
11. ХДС-ийн 1-р курсын оюутнуудын дунд “Эх түүхээ хэн сайн мэдэх вэ” уралдааныг амжилттай зохион байгууллаа. 200 гаруй оюутан залуус оролцож авхаалж, оюунаа сорин уралдлаа. Уралдааны арга хэмжээг Ойрад ХДТ-т зохион байгууллаа**.** Нийтдээ 6 баг оролцсоноос оройн 1-р курсын “Хамаг монгол” баг түрүүлж, удаах байрыг “Чингисийн үр сад” баг 3-р байрыг “Хар сүлдний тахилга” баг эзэллээ.
12. Аймгийн ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгж болгон үдэж иргэдэд мэдээлж байна.
13. Нээлттэй хаалганы өдрийг байгууллага дээрээ зохион байгуулж Шинэ болон Уран зохиол, Хүүхдийн уран зохиол, Түүх , Монголын уран зохиол сэдэвүүдээр үзэсгэлэн гаргаж, нийтдээ 600 гаруй номоор чөлөөт сонголтын хэлбэрээр уншигчдад үйлчиллээ.
14. Баруунтуруун, Малчин, Наранбулаг сумдад зөөврийн номын сангаар үйлчилж 850 гаруй номоор давхардсан тоогоор 1000 уншигч үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүллээ.
15. Сумдын соёлын төвийн номын санчдад номын сангийн ажлын аргачлал, номын сангийн програмын талаар 2 өдрийн сургалтыг өглөө.

16. Цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны сурагчдын дунд АХА тэмцээнийг зохион байгуулж тэдэнд Шинэ тосгон холбооны номоор үзэсгэлэн гаргаж суртачиллаа.
17. Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс ажлын байрны гимнастикийг 10 цагт хийлгэж тогтмолжуулллаа. Мөн “Цусны даралт ихсэх өвчнөөс хэрхэн яаж сэргийлэх вэ” сэдвээр мэргэжлийн эмчээр сургалт зохион байгууллаа. Долоо хоног бүрийн 2 дахь өдөр заал авч тоглож байна .
18. 2-р цэцэрлэгийн ахлах, дунд , бэлтгэл бүлгийн 200 хүүхдийг номын сангийн орчин, үйл ажиллагаатай танилцуулж тэдэнд дуртай үлгэрийн номоор үйлчилгээ үзүүллээ.
19. Номын сангийн нэгдсэн катологт холбогдсон номын тоогоороо Увс аймаг ажлын үзүүлэлтээрээ 1-р байранд орлоо.
20. Номын сангийн fasbook хаягаар үйл ажиллагааныхаа талаар болон шинэ номынхоо талаар мэдээлж ажиллаа.
21. Фондын номнуудыг 100 хувь электрон катологт оруулж баркоджуулан , номнуудаа хайлтын компьютерт тавьж үйлчилж байна. Уншигчид хэрэгцээт ном хэвлэлээ хайлт хийх заврын дагуу хайлтын компьютерээс олох боломжтой болсон.
22. 22.Шинэ номын мэдээг Вэб сайт, номын сангийн fasbook хаягаар сурталчилхаас гадна хувь хүмүүсийн вэб хаяг руу номын мэдээг явуулж сурталчилж байна.
23. 23. Шилэн халаас хөтөлбөрийн хүрээнд явуулсан ү йл ажиллагаагаа болон санхүүгийн ил тод байдлаа өөрийн блог хаягандаа нээлттэй ил тодоор байршуулан ажиллаа.

Стратеги-2
“Фондын баяжилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах”

- Фондын номын хадгалалт хамгаалалт, орчин нөхцлийг нь сайжруулах талаар тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- 2014 онд фондын нийт номын ялгагч ба хаягжуулах ажлыг шинэчиллээ.
- Улирал тутам номыг стандартын дагуу ариутгах, хортон шавьжаас хамгаалах ажлыг тогтмолжууллаа.
- 300000 төгрөгийн тогтмол хэвлэлийг захиалж уншигчдад үйлчиллээ. Фондын нийт номын 100% ийг электрон катологт оруулаа.
- Шинээр ирсэн 658 ширхэг номнуудыг программд оруулж, баркод нааж үйлчилгээнд гаргалаа.
- Ховор, нандинд тооцогдох тод бичгийн ном, төвд судар, уйгаржин бичгийн дурсгалуудыг тусгай тавиурт байрлуулан бүртгэл мэдээллийн сан бий болголоо.
- Иргэдийн хүсэлтийн дагуу шаардлагатай 200 гаруй номын жагсаалт гаргаж фонд бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа.
- Фондын номын хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд улирал бүр их цэвэрлэгээ хийж, тоос соруулах ,хлорамины уусмалаар арчиж цэвэрлэх ажлыг тогтмолжууллаа.
- Шилдэг ном -2013 сонгон шалгаруулалтанд шалгарсан 55 нэр төрлийн 162 ширхэг 1913840 төгрөгний ном хөрөнгө оруулалтаар ирсэн.
- Мөн ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар номын тавиур 3ширхэг 1880967 төг, катологийн шүүгээ 1 ширхэг 396000 төг, тогтмол хэвлэлийн

тавиур 1 ширхэг 370700 төг нийтдээ 2647667 төгрөгний эд хөрөнгө хөрөнгө оруулалтаар ирлээ.

Стратеги:3

“Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах”

- Батлагдсан төсөв 181,774,6 төгрөгийг үр ашигтай зарцуулж ажиллаа**.**
- Өөрийн орлогоос 50,000 төгрөгийг оруулж ажиллаа.

Нийлүүлэх тусгай захиалгат бүтээгдэхүүний биелэлт:

- 2014 онд байнгын уншигчийн тоог 4280 нийт уншигчдын тоог 33500 –д хүргэн ажиллаа.
- 2014 онд 40100 ширхэг ном хэвлэлээр үйлчилж фондын эргэлтийг 53,1 %-д хүргэлээ.
- МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Номын баяр”-ыг Баруунтуруун суманд тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ үеэр хүүхэд багачуудын дунд уран уншлагын тэмцээн, Номын үзэсгэлэн, АХА тэмцээн гэх мэт тэмцээнүүдийг зохион явуулж шалгарсан хүүхэд багачуудыг шагнаж урамшууллаа. Давхардсан тоогоор 250 гаруй уншигчдад тэдний эрэлттэй ном хэвлэлээр газар дээр нь үйлчилгээ үзүүллээ.
- Бичил номын сан”-г шалгаруулах хувийн номын санг дэмжих үүднээс сургуулиудтай хамтран ажиллалаа. Анги бүр номын сантай боло хөдөлгөөн өрнүүллээ. Цогцолбор 2-р сургууль 10 бичил номын сантай 260 ширхэг номтой, Ахлах 3-р сургууль 25 номын сан 627 номтой, Чандмань эрдэм ахлах сургууль 9 номын сан 260 ширхэг номтой, Увс эрдэм ахлах сургууль 20 номын сан 740 ширхэг номтой, цогцолбор 1-р сургууль 28 номын сан 1734 ширхэг ном хэвлэлтэй болсон байна.

Байгууллага орчны тохижилтын талаар :

- Улаангом хотын ногоон байгууламжийн ажлын хүрээнд манай байгууллага Наадмын талбайд 10 мод тарилаа
- Мөн гудамжинд 10 метр газрыг цэцэгжүүллээ.
- Байгууллагын гадна талд мод тарьж цэцэгжүүлэхээс гадна өрөө тасалгаануудаа нэмж цэцэгжүүллээ
- Байгууллагын гадна гэрлэн хаягтай болоо.
- Уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхим, үүдний коридор зэрэгт нийтдээ 5 камер суурилуулж хяналтын самбарыг жижүүрийн өрөөнд байрлуулав.
- Хүүхдийн заалны хулдаасыг сольж шинэчиллээ.

Сахилга хариуцлагын талаар:

- Ажилчдын ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг цаг ямагт сайжруулахын тулд ажилчидтай үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, хариуцлагын гэрээ байгуулан улирал тутам дүгнэн ажиллаж байна.
- Байгууллагын дотоод хяналт шалгалтын хуваарийг гаргаж, хяналт шалгалт хийн шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллаа.
- Цаг ашиглалтын байдалд харуулууд өдөр тутам тэмдэглэл хөтлөж бүртгэж байгаа бөгөөд ня-бо хяналт тавин ажиллаж байна.

- Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг хавтас нээн эмхтгэн нийтэд сурталчилж байна.

Хяналт шинжилгээ, тайлан мэдээний байдал:

- Номын сан нь статистикийн СУ-3, СУ-10, СУ-15 гэсэн 3 төрлийн мэдээг гаргаж өгдөг. Үүнээс СУ-3 мэдээг улирал тутам, СУ-10 СУ-15 мэдээг жил эцсээр гаргаж аймгийн ССАЖГ, Статистикийн хэлтэс, ҮНС-д хүргүүлж хэвшсэн.
- Байгууллагын ажилчдаас болон үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагаандаа тусган ажиллаа.
- Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах стандарт, дүрэм, журам хөтлөгдөх бүртгэл тооцооны хөтлөлтийг улирал тутам шалган дүгнэж зааварчлагаа өгөн ажиллалаа.
- Сайн ажилласан ажилтанг алдаршуулах, жилийн эцэст ажлаа дүгнэж байгууллагын аварга, тэргүүнийг шалгаруулах, аймгийн болон яамны ,ЗГ-ын шагналд тодорхойлох зэрэг урамшууллын дэмжлэг үзүүллээ
-

ТӨВ НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрсэн үр дүн ,үр дагавар	Хувь
1	2	3	4
Нэг. Байгууллагын тогтвортой хөгжил, номын сангийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах			
Стратеги:1 **Байгууллагын тогтвортой хөгжил, номын сангийн үйлчилгээний**	2014 онд байнгын уншигчийн тоог 4210 нийт уншигчдын тоог 33000 –д хүргэн ажиллах	2014 онд байнгын уншигчийн тоог 4280 нийт уншигчдын тоог 33500 –д хүргэн ажиллаа.	**100%**
	2014 онд 40,000 ширхэг ном хэвлэлээр үйлчилж номын фондын эргэлтийг 53 %-д хүргэнэ,	2014 онд 40100 ширхэг ном хэвлэлээр үйлчилж фондын эргэлтийг 53,1 %-д хүргэлээ.	**100%**

хүртээмж чанарыг сайжруулах	-Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн 70 удаа гаргах	Уншигчдад Шинэ болон Сэдэвчилсэн үзэсгэлэнг 70 удаа гаргаж сурталчиллаа. Үүнд: Газар тариалан, Мал аж ахуй, Багш нарын баярын өдөрт, Дэлхийн яруу найргийн өдөрт, Цагаан сарын баярт, Хүүхдийн уран зохиол, Хүний эрхийн өдөрт, Амьдрах ухаан гэх мэт мөн Мөн САМА телевизээр 7 хоног бүр номын санчид ээлжээр шинэ номын сурталчилгааг байнгын хийж хэвшсэн. 	100%
	Интернет үйлчилгээнд 10000 хүн хамруулах	- Интернет үйлчилгээнд 10000 хүн хамруулж тэдэнд хэрэгтэй мэдээллээр нь үнэгүй үйлчиллээ.	100,%

	-5000 ширхэг номонд сэлбэн засалт хийх	Уншигч үйлчлүүлэгчдийн гар дээр эргэлтэнд гарсан, элэгдэж хуучирсан 5000 ш номонд сэлбэн засалтт хийлээ	100%
	Номын сангийн уншлагын танхимуудыг камержуулах	Номын сангийн уншлагын тахимуудад нийтдээ 5 камер суурилуулсан. Үүнд : “Оюуны ундарга” танхимд 2 ш , Хүүхдийн танхимад 2 ш, үүдний коридорт 1 ш камер суурилуулж хяналтын самбарыг жижүүрийн өрөөнд суурилуулав.	100%
	Гэрлэн хаягтай болох	Байгууллагын гадна талд гэрлэн хаягтай боллоо.	100%
	Соёл олон түмний ажил 6 удаа зохион байгуулах	Уншигчдын ном унших идэвх, тэдний чөлөөт цагийг зөв болосон өнгөрүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор соёл олон түмний ажлуудыг зохион байгуулаа. Үүнд: 1. ХДС-ийн 1-р курсын оюутнуудын дунд “Эх түүхээ хэн сайн мэдэх вэ” уралдааныг амжилттай зохион байгууллаа. 200 гаруй оюутан залуус оролцож авхаал. Оюунаа сорин уралдлаа. Уралдааны арга хэмжээг Ойрад ХДТ-т зохион байгууллаа. Нийтдээ 6 баг оролцсоноос оройн 1-р	100%

курсын “**Хамаг монгол**” баг түрүүлж, удаах байрыг “**Чингисийн үр сад**” баг 3-р байрыг “**Хар сүлдний тахилга**” баг эзэллээ.

2. “Монгол бичгээр хэн сайн бичих вэ “ээлжит уралдааны зохион байгууллаа. Уралдааныг 2 дахь жилдээ **BABY SHOP**

		дэлгүүр 270 000 төгрөгөөр ивээн тэтгэлээ. Уралдааныг багш, сонирхогч иргэд, оюутнууд сурагчид гэсэн 2 ангиллаар зохион явууллаа. Багш сонирхогчдын ангилалд цогцолбор 1-р сургуулийн багш Сүрэнхорлоо түрүүлж, удаах байранд УГПК-ийн багш Батхишиг, Сурагч оюутнуудын ангилалд ХДС-ийн оюутан Б. Баттогтох түрүүлж удаах байрыг УГПК-ийн сийлбэрийн ангийн оюутан Нямсүрэн эзэллээ. **3**. Доктор Л. Лханямын **“Тэнгэрлэг монгол хүн”** номоор уншигчдын бага хурлыг зохион байгууллаа. 250 гаруй оюутан залуус оролцож , номын сэдвүүдээр илтгэгч нар тус тусынхаа илтгэлийг тавьлаа. Илтгэлүүдээр гарын авлага гарган уншигчдад үйлчилж байна. 	

		 4. Дэвжээ тэмцээнийг ахлах 4-р сургуулийн 9-р ангиудын дунд зохион явууллаа. 5. ХЦ-ийн бие бүрэлдэхүүний дунд номын баярыг зохион явууллаа. 6. Танин мэдэхүйн АХА тэмцээнийг цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны сурагчдын дунд зохион байгуулсан 7. Б. Лхагвасүрэнгийн уран бүтээлээр уран бүтээлийн үдэшлэгийг ахлах 3-р сургуулийн 10 ангиудын дунд зохион явууллаа.	
	Зөөврийн номоор үйлчилэх	ХЦ-ийн 0245-р анги Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, 2-р цэцэрлэгт зөөвөр номоор үйлчилгээ үзүүлж ажиллаа. Мөн цогцолбор 2-р сургууль болон УГПК-той ном солилцоо хийлээ. Мөн Малчин Наранбулаг, Баруунтуруун суманд зөөврийн номын сангийн үйлчилгээг явууллаа. 	**100 %**

	Номын найз дугуйлан хийчээллүүлэх	Номын найз дугуйланд 1-10 ангийн 100 хүүхдийг хамруулан номын сангийн анхан шатны мэдлэг, данс бүртгэлүүд , номыг яаж эмчлэх , ном унших соёл, тэргүүний уншигч хэрхэн болох талаарх сургатуудыг зохион явуулж ажиллаа.	**100 %**
	Аймгийн ИТХ, тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгжлэн үйлчлэх	Аймгийн ИТХ, тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгжлэн авч иргэдэд мэдээлэн ажиллаа. 	**100%**
	“Бичил номын сан “ шалгаруулах	“Бичил номын сан”-г шалгаруулах хувийн номын санг дэмжих үүднээс сургуулиудтай хамтран ажиллаа. Анги бүр номын сантай боло хөдөлгөөн өрнүүллээ. Цогцолбор 2-р сургууль 10 бичил номын сантай 260 ширхэг номтой,	**100 %**

		Ахлах 3-р сургууль 25 номын сан 627 номтой, Чандмань эрдэм ахлах сургууль 9 номын сан 260 ширхэг номтой, Увс эрдэм ахлах сургууль 20 номын сан 740 ширхэг номтой, цогцолбор 1-р сургууль 28 номын сан 1734 ширхэг ном хэвлэлтэй болсон байна.	
	МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх	МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Номын баяр”-ыг Баруунтуруун суманд тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ үеэр хүүхэд багачуудын дунд уран уншлагын тэмцээн, Номын үзэсгэлэн, АХА тэмцээн гэх мэт тэмцээнүүдийг зохион явуулж шалгарсан хүүхэд багачуудыг шагнаж урамшууллаа. Давхардсан тоогоор 250 гаруй уншигчдад тэдний эрэлттэй ном хэвлэлээр газар дээр нь үйлчилгээ үзүүллээ.	**100 %**
	2014 оны эхний хагас жилийн тэргүүний уншигч, рекорд номыг шалгаруулан урамшуулж алдаршуулах		100%
	Хоёр: Фондын баяжилт, хадгалалт хамгаалалт		
	-5,550,000 төгрөгний номоор фонд баяжилт хийх	658 ширхэг 7529840 төгрөгний номоор фонд баяжилт хийгдлээ. Үүнээс бэлэг хандивын журмаар 201 ширхэг 2,241340 төгрөгний ном, худалдаагаар 169 ширхэг 4927500 төгрөгний ном хэвлэлээр, төлбөрт 43 ширхэг 355000 төгрөгний номоор фонд баяжилт хийгдлээ.	100%
	300,000 төгрөгний хэвлэл захиалж	Өдөр тутмын сонин болох Өдрийн сонин, Өглөөний сонин, Хүмүүн бичиг, Номын санч сэтгүүл Өрхийн үйлдвэрлэл сэтгүүл, Зууны мэдээ сонин, Утга зохиол	100 %

	уншигчдад үйлчилэх	урлаг сонин, Боловсрол судлал сэтгүүл, Увсын өнгө сонин зэргүүдийг захиалан уншигчдад үйлчиллээ.	
Стратеги:2 **Фондын баяжилт хадгалалт хамгаалалт:**	Номын фондонд тавигдах MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлж ажиллах	• Шинээр ирсэн 658 ш номыг программд оруулж ,баркод нааж үйлчилгээнд гаргалаа. • Фондын номын хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд улирал бүр их цэвэрлэгээ хийж, тоос соруулах ,хлорамины уусмалаар арчиж цэвэрлэх ажлыг тогтмолжууллаа. • Фондын нийт номын 100% ийг электрон катологт оруулсан	100%

ШИНЭ БОЛОН СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД



Бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан жил бүр уламжлан болгон зохиогддог “Монгол бичгээр хэн сайхан бичих вэ?” уралдаанд шалгарсан багш, оюутан сурагчид шагналаа гардаж байгаа нь

2014 оны эхний хагас жилийн Тэргүүний уншигч, рекорд ном

0245-р ангийн номын санчид зөөврийн ном олгож байгаа нь:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нээлттэй хаалганы өдөрт

“Эх түүхээ хэн сайн мэдэх вэ? Уралдаанаас

“Тэнгэрлэг монгол хүн” номоор хийсэн уншигчдын бага хурлаа*с*



Хүүхдийн уншлагын танхимыг камержуулсан



Уншлагын танхимыг камержуулсан.



Байгууллагын гадна талд гэрлэн хаягтай боллоо

Аймгийн ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийг нэгжлэн уншигчдад үйлчилж байна.



Байгууллагын цэцэгжүүлэлт , наадмын талбайд тарьсан мод, гудамжинд 10 м газрыг цэцэгжүүлсэн.

Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах талаар:

Цогцолбор 1- сургуулийн дотуур байрны сурагчдын дунд “АХА тэмцээн

Монгол бахархалын өдрөөр :

Фондын номнуудыг 100 хувь электрон катологт оруулж баркоджуулан , номнуудаа хайлтын компьютерт тавьж үйлчилж байна. Уншигчид хэрэгцээт ном хэвлэлээ хайлт хийх зааврын дагуу хайлтын компьютерээс олох боломжтой болсон

Номын сангийн fasebook хаягаар үйл ажиллагааныхаа талаар мэдээлж ажиллалаа.

Шинэ номын мэдээг Вэб сайт, номын сангийн fasebook хаягаар сурталчилхаас гадна хувь хүмүүсийн вэб хаяг руу номын мэдээг явуулж сурталчилж байна



Номын сангийн нэгдсэн катологт холбогдсон номын тоогоороо Увс аймаг ажлын үзүүүлэлтээрээ 1-р байранд орлоо.



Д/д	Аймаг	Сум	Номын нэр	Зохиогч	Хэвлэгдсэн он	Тоо ширхэг
1	Увс	Тэс	10 б-гийн тэнэг	ж.лхагва	0	1
2	Увс	Тэс	1984	жоорж оруэлл	0	1
3	Увс	Тэс	абдигийн адал явдал	мадонна	2009	1
4	Увс	Тэс	абсурд театр	антонин арто	0	1
5	Увс	Тэс	ажил ба сургуулийн зүйл	Б.Тогтохтөр	0	1
6	Увс	Тэс	айдас	А.Рыбаков	2009	1
7	Увс	Тэс	айл гэрийн аз жаргал	ж.мерфи	2006	1
8	Увс	Тэс	алтан асрын сум	мишима юкио	0	1
9	Увс	Тэс	алтан бөмбө дахь лишийн цэцэг	б.дашцэрэн	0	1
10	Увс	Тэс	алтан мэлхий минь уучлаарай	ц.буянзаяа	2006	1
11	Увс	Тэс	алтан товч	Лувсандандзан	1990	1
12	Увс	Тэс	алтан цох	эдгар аллан по	2009	1
13	Увс	Тэс	алтан эрих хэмээх оршив	б.түшинтөгс	2010	1
14	Увс	Тэс	амьтадын тухай өгүүллэг	э.сетон томпсон	2012	1
15	Увс	Тэс	амьтны ферм	жоорж орвэлл	2005	2

Нийт 45677 ширхэг ном байна.

Үйл ажиллагаагаа өөрийн блог хаягандаа нээлттэй ил тодоор байршуулан ажиллалаа.





Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр

- Мөн ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар номын тавиур 3ширхэг 1880967 төг, катологийн шүүгээ 1 ширхэг 396000 төг, тогтмол хэвлэлийн тавиур 1 ширхэг 370700 төг нийтдээ 2647667 төгрөгний эд хөрөнгө хөрөнгө оруулалтаар ирлээ.
- Шилдэг ном -2013 сонгон шалгаруулалтанд шалгарсан 55 нэр төрлийн 162 ширхэг 1913840 төгрөгний ном хөрөнгө оруулалтаар ирсэн.

Шилэн халаас хөтөлбөрийг хэрэгжүүлэн
санхүүгийн ил тод байдлыг хангаан ажилладаг





Байгууллага орчны тохижилтийн талаар :

Байгууллагын гадна нүүрний хэсгийг шохойдож будаж тохижуулллаа

УНШИГЧДЫН АЯ ТУХТАЙ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ ,СУУДЛЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР УНШЛАГЫН ЗААЛНЫ ТАСЛАВЧИЙГ НУРААЖ НЭГТГЭН ЗААЛНЫ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭН ЗАСАЖ ,ВАКУМ БОЛГОН ТОХИЖУУЛЛАА



Улсын дундажтай харьцуулсан байдал





ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2014.12.15.

2014 оны эхнээс эхлэн байгууллагын ажлын төлөвлөгөөг жилээр гаргаж батлуулан сар бүрийн ажлаа 7 хоногоор төлөвлөн биелэлтийг тооцон ажиллаж байна. Нийтийн номын сангийн уншлага үйлчилгээний чанарт ахиц гаргах, төлөвлөгөөт үзүүлэлтүүдээ жигд биелүүлэх, уншигчдын хүрэлцэхгүй болон байхгүй номыг татгалзлалын дэвтэрт бүртгэж, зайлшгүй авах шаардлагатай номуудын жагсаалт ном хэвлэлийн үйлдвэрийн компаниудад танилцуулж хэрэгцээтэй шинэ номоор бүрдүүлэлт хийж фондоо баяжуулаж, уншигчдын дунд соёл олон нийтийн ажлыг үр дүнтэй,чанартай зохион явуулах зорилт тавьж олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Номын фондыг 9167865 төгрөгийн 771 боть номоор баяжуулж үүнээс 445 ширхэг номыг 5661000 төгрөгөөр худалдан авч, 326 ширхэг 3506865 төгрөгийн номыг бэлэг хандиваар хүлээн авч бүрдүүлэлт хийв.

Статистик тоон мэдээллийг төлөвлөгөөтэй харьцуулбал:









Электрон каталогийн ажил бүрэн дуусаж үйлчлүүлэгчид хайлтын систем ашиглан хайлт хийх боломжтой боллоо. Мөн 2015 онд цахимаар номын хайлт хийх боломжийг иргэдэд олгох аргыг хэрэгжүүлэх гэж байна. ССАЖЯ-наас аймгийн төвийн болон сумдын номын сангуудад нийт 54,086,505 төгрөгний номын тавиур, каталогийн шүүгээ, тогтмол хэвлэлийн тавиуд ирсэнийг хүлээн авч сумдад хувиарлан өглөө.

Үүнээс Нийтийн номын санд Каталогийн шүүгээ, тогтмол хэвлэлийн тавиур зэрэг 8,172,945 төгрөгний хөрөнгө оруулалтыг хүлээн авлаа. Мөн АСЯ-наас Нийтийн номын сангийн хүсэлтийг үндэслэн16,029,600 тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 4 сая төгрөгний өртөг бүхий 200 ширхэг бариаль номыг авч үйлчилгээнд гаргав. Нийт 28,202,545 төгрөгний хөрөнгө оруулалт гаднаас хийгдсэн байна. АЭСЯ-наас Америкийн төвд 28,037,500 төгрөгний эд материалын олон оюуны хөрөнгө оруулалтыг хийжээ.

Байгууллагаа камержуулах ажил хийгдэв. 8 камертай боллоо.

Тасаг танхимуудаа камертай болгосноор үйлчлүүлэгчдийг хянах, ном алдагдахаас сэргийлэх ажлыг хийхэд хялбар боллоо.

ССАЖСалбарын 2014-2018 онд хөгжүүлэх салбарын хөтөлбөрын хэлэлцүүлэгт оролцож Нийтийн номын сангийн талаар авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүдийг оруулаа.

Уншигчдад зориулсан хүлээлгийн танхимтай боллоо. Ховд аймаг 2014 оныг Эрүүл мэндийг дэмжих жил болгосонтой холбоотойгоор уншигчдыйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор энэхүү ажил хийгдлээ.

Уншигчид тус танхимд ном сэтгүүлээс эрүүл мэндийн болон бусад сонирхолтой мэдээллийг хүлээн авч болохоор зохион байгууллаа.

Нийтийн номын сангийн сайтыг шинээр хийлээ:

Бичиг хэрэг:

2014 онд байгууллагын үйл ажилагаатай холбоотой А тушаал 57, ажилтануудтай холбоотой Б тушаал 20 гарлаа.

Албан байгуулагуудад Албан тоот 140 гаргаж хүргэж ажиллаа.Удирдах дээд байгууллага болон албан байгууллагуудаас 93 удаа хугацаатай болон хугацаагүй албан тоот ирж холбогдох хүмүүст хүргэж биелэлтийг тооцож ажиллаа.

2014 онд ажилтан ажилчид болон иргэдээс 19 өргөдөл хүлээн авч зохих шийдвэрүүдийг гаргуулан уламжиллаа.Тогтоол, захирамж 18 ирж холбогдох хүмүүст танилцуулан биелэлтийг тооцож хэрэгжүүлэн ажиллаа.Ажилчдын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн байгууллаа.

Номын сангийн тасаг танхимын үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор Гэрээр ном олгогч Б.Одопүрэв, Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхимын номын санч Г.Баяраа нартай хамтран Онцгой байдлын албаны 52 Аймгийн Прокурорын газрын 11, Аймгийн Шүүхийн Прокурор, Цагдаагийн газар-68 ,Газар хөдлөлт, ШШГ -75 хүнд тус тусын тасаг танхимын мэдээлэл өгөхөөс гадна “Угийн бичгийн” талаар

сургалтын зохион байгуулав.2014 онд нийтдээ 15 байгууллагаар явж мэдээлэлээ хүргэсэн байна.

2014 ОНЫ БАЙДЛААР ТАСАГ ТАНХИМУУДАД ШИЛДЭГЭЭР ШАЛГАРСАН НОМНУУД

Тасаг танхимууд өөрсдийн үйлчлүүлэгчдийн нас сэтгэлзүйн онцлогт тохирсон ном хэвлэлээр үйлчлэж ирсэн ба Тасаг танхимуудын оны шилдэгээр шалгарсан бүтээлүүдийг танилцуулж байна.

Хүүхдийн номын өргөө:



1-рт: “Чоно ба Долоон ишиг” ном 591 уншигчтайгаар тэргүүлсэн байна.

2-рт: “Гурван тоорой” ном 516 уншигчтайгаар хоёрдугаарт

3-рт: “Зальт үнэг ба Саарал чоно” ном 416 уншигчтайгаар гуравдугаарт орсон байна.

Гэрээр ном олгох тасаг:







1-рт: Ц.Оюунгэрэлийн “Ногоон нүдэн лам” роман38 уншигчтайгаар тэргүүлсэн байна

2-рт: Сарантуяа “Сорхугтанану” роман32 уншигчийн гарт очиж шалгарчээ.

3-рт: Зян Рун “Чонон сүлд” ном 29 уншигчтайгаар

Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын тахимын Шилдэг номоор:

1-рт: Ц.Оюунгэрлийн “Миний ажлын НОУ-ХАУ” ном 187 уншигчийн гарт очиж шалгарчээ.

2-рт: Бэртран Рассел “Өрнийн мэргэн ухааных” ном 126 уншигчтайгаар

3-рт: Шүүдэрцэцгийн “Чимээгүй хашгираан” ном 82 уншигчтайгаар тэргүүлсэн байна.

УНШЛАГЫН ИХ ТАНХИМЫН ШИЛДЭГ НОМООР:





1-рт: Монголын нууц товчоо зохиол 669 уншигчтайгаар тэргүүлсэн байна.

2-рт: Д.Нацагдоржийн "Шилдэг бүтээлүүд" ном 536 уншигчтайгаар хоёрдугаарт

3-рт: С.Эрдэнэ "Шилмэл өгүүллэгүүд" ном 488 уншигчтайгаар гуравдугаарт орсон байна.





1-рт: Англи хэлний хэл зүй 150 уншигчтайгаар тэргүүлсэн байна.
2-рт: "Toefl IBT" ном 96 уншигчтайгаар хоёрдугаарт
3-рт:Oxford Dictionary of English ном 68 уншигчтайгаар гуравдугаарт оржээ.

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

ССАЖЯ-ны сайд асан, "Ногоон нүдэн лам" зохиолын зохиогч Ц.Оюунгэрэлтэй онлайн уулзалт зохион байгууллаа. 2012, 2013 онуудад тус зохиол нь Нийтийн номын сангийн хамгийн их уншигчтай эрэлт ихтэй номоор шалгарсан. Уншигчдын хүсэлтээр тус арга хэмжээг зохион байгууласан ба ЕБС-ийн сурагчид,

оюутан залуус, ард иргэд оролцож өөрсдийн санал бодлоо солилцлоо.

Аймгийн халамж үйлчилгээний төвийн асрах газрын хамт олонтой уулзаж, тэнд амьдарч байгаа хүмүүсийн судалгаа авч, тэдний оюун ухаан хөгжүүлэх, чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор тус байгууллагын нийгмийн ажилтан Баасанжаргалд 250 ширхэг ном хандивлаж номын сан байгуулж өгөх санал тавихад байгууллагын удирдлагууд болон тэнд амьдарч буй хүмүүсийн талархал хүлээсэн сайхан ажил боллоо.

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан **“Үг аялгуу бийрээр урлаач”-**дын зөвлөгөөныг хамтран ажиллаж тус үйл ажиллагаанд зориулан Ховд аймгийн зохиолчдын номоор үзэсгэлэн гаргаж оролцлоо.

***Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд*:**

12 жилийн 2 дугаар сургууль дээр монгол улсын ерөнхийлөгчийн “Монголын нууц товчоо” зохиолыг айл өрх, албан байгууллага бүр эрхэмлэн залах тухай зарлигийн хүрээнд “Монголын нууц товчоо залах” үйл ажиллагааг “Үндэсний хувцасаараа гоёцгооё” сэдвийн дор зохион байгууллаа. Ном хөтөлбөрийг хэрэгжүүлэн хамтран ажиллахад тус арга хэмжээний гол зорилго оршиж байлаа.
2-р сургуулийн Багш, сурагчид МУ-ын төрийн дууллаа эгшиглүүлэн хүлээн авлаа.

Аймгийн захиргааны Иргэний танхимд 2014 оны 04 дүгээр сарын 17-нд Нээлттэй хаалганы өдөр-ийг зохион байгууллаа. Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Иргэний танхимд “Монголын нууц товчоо” хүндэтгэн залах, Эх түүхээ судалъя сэдэвт түүхэн үнэт ховор номоор үзэсгэлэн гаргаж аймгийн захиргааны ажилчдад ажлын байранд нь номоор үйлчилгээ үзүүлж хэрэгцээтэй болон сонирхосон номоо авч унших боломжоор хангаж ажиллаа. Номын сангийн фондод байгаа үнэт ховор ном зохиол болон түүхийн холбогдолтой номоор үзэсгэлэн гаргаж тасаг танхимууд үйл ажиллагаагаа

сурталчлахын зэрэгцээгээр гэрээр ном олгох тасаг, насанд хүрэгсэдийн уншлагын танхимууд уншигч үйлчлүүлэгчид ажилтан хаагчдад сонирхосон ном олгож үйлчиллээ.

Номын санд монголын түүхэн их судар Ганжуур , данжуур сударууд крилээр хэвлэгдэн гарсан бүтээлүүдээр үзэсгэлэн гарган сурталчилсан нь үйлчлүүлэгчдийн сонирхолыг татаж хаанаас яаж ямар хугацаатай ашиглах талаар зөвлөлгөө авлаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн 23 дугаар зарлигийн дагуу “Үндэсний бичиг үсгин баяр”-ын арга хэмжээг зохион байгууллаа. Тус үйл ажиллагааны хүрээнд Уран бичлэгийн уралдааныг БГ, ХГБХХ, ХИС-тай хамтран зохион байгуулж, амжилттай оролцсон оролцогчдын шагналыг гардуулав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу үндэсний бичиг үсгийн баярыг

тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хамтран ажилласан байгууллагуудын дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгууллаа. Нийт 45 бүтээлээс
Насанд хүрэгсдийн ангилалд: 1-р байр Э.Алтанчимэг /торго таталган бичиг/
2-р байр Ж.Батсайхан/угалзан бичиг/
3-р байр Б.Ариунболд /таталган бичиг/
4-р байр тусгай М.Эрдэнэчимэгт /таталган бичиг/ 5-р байр тусгай Г.Нямболд /хамаг монгол/ зэрэг бүтээлүүд шалгарсан.

Бичиг үсгийн баярт ирсэн бүтээлийг Монгол улсын гавьяагт багш Б.Баасанхүү мөн ХИС-н Дүрслэх урлаг дизайны багш Гантулга нар шалгаруулаа.

Бичиг үсгийн баярын үйл ажиллагаатай холбоотой УБ хотод зохион байгуулагдсан хот хөдөөгийн 32 баг оролцсон спортын тэмцээнд баг хамт олноо удирдан оролцож Мөнгөн медаль хүртэж амжилттай оролцоод ирлээ.

МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГИЙН ДАГУУ “ХОВДЧУУД УНШИЖ БАЙНА” 14 ХОНОГИЙН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МУ-ын ерөнхийлөгчийн Номын баярыг тэмдэглэх тухай 158-р зарлигийн хүрээнд Ховд аймгийн Нийтийн Номын сангаас “ХОВДЧУУД УНШИЖ БАЙНА” 14 хоногийн аяныг тусгай хөтөлбөрөр зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд эрдэмтэн багш нар, эцэг эх, уншигчдын “Уншигчдын онол практикийн бага хурал”, Орон нутгийн Зохиолч, судлаач, уншигчдийн уулзалт ярилцлага, Оюутан залуучуудын дунд “Номонд дурлагсадын клубыг байгуулан оюутан залуусыг идэвхижүүлэх, будад сайг үлгэр дуурайлал үзүүлэх зорилго бүхий манлайлагчдын клубтай боллоо.

Нээлтийн арга хэмжээг Ард-Аюушийн талбайд зохион байгуулан “Иргэдэд үйлчлэх өдөр”-ийн хүрээнд шинэ номын үзэсгэлэн, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, тасаг танхимуудын танилцуулгыг гаргаж энэ үеэр Д.Нацагдорж тэмдэгийн болзол хангасан сурагчдыг шагнах арга хэмжээг зохион байгуулж шилдэгүүдээ тодруулан аймгийн хэмжээнд 33 сурагчдын шагналыг гардуулан

өглөө. 1 дүгээр сургуулийн 11б ангийн сурагч Ц.Нарангэрэл, Д.Дэмидханд, Б.Сарнай/5б/, Прогресс сургуулийн 11а ангийн сурагч Э.Заяаболд, 5а Б.Бэлгүтэй,12а Н.Гончигдорж, /12а/ Ж.Зулцэцэг, 3 дугаар сургууль Э.Байгалмаа /6б/, Г.Өсөх-ирээдүй /4а/, Цаст-Алтай цогцолбор сургуулийн Б.Дэлгэрмөрөн /4в/, Д.Хишигбуян /12а/, 7 дугаар сургууль: Д.Ганчимэг /6б/, Э.Болор-эрдэнэ /11в/, 2 дугаар сургууль: Г.Ану /12б/, Э.Даниел /5г/, 6 дугаар сургуулийн /8б/ Б.Энххүлэг нар шагнагдлаа. 12 жилийн сургуулиудын дунд уншлагын уралдааныг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.

Орон нутгийн зохиолчид, судлаачдын уулзалтыг зохион байгуулж санал бодлоо солилцлоо. Мөн хувийн номын сантай, ховор гом зохиолтой иргэдийн номын үзэсгэлэнг гаргав. Ховор номтой иргэнээр А.Баасанхүү багш 1849, 1961 оны ном болон ховор судар номуудаар үзэсгэлэн гаргалаа. Баяжилт сайтай номын сантай иргэнээр Яруу найрагч Б.Баяраа нар шалгарч тус бүр өргөмжлөл, номын багцаар шагнагдлаа.

Ном хандивлах аяныг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага хувь хүмүүс, хүүхэд багачууд идэвхитэй оролцож төрөл бүрийн ном, сурах бичиг, судалгааны материалуудыг хандивлаж нийт 300 гаруй номыг хандиваар авч хандивлагчдыг талархалын дэвтэрт тэмдэглэн хадгаллаа.

Аяны хүрээнд 09-р сарын 09-нд ЕБС –ийн ахлах ангийн сурагчдын дунд “Ном ухаарахуйн үндэс“ сэдэвт

уншигчдын онол практикийн бага хурлыг хөтөлбөр гаргаж, амжилттай

зохион байгуулж явуулав. Уг арга хэмжээнд маш сонирхолтой, шилдэг илтгэлүүдийг ХИС –ийн МХУЗ –ын багш В.Янжиндулам, БОЭТ –ийн зөвлөх эмч, ШУ –ны доктор Ц.Даржаа, Прогресс сургуулийн 10-а ангийн сурагч Ч.Хурцболд, 6-р сургуулийн 9-б ангийн сурагч Б.Элбэгсайхан, Прогресс сургуулийн 11-а ангийн сурагч Амарсайхан, 6-р сургуулийн 9-б ангийн сурагч Н.Батцэцэг нар илтгэж олны талархлыг хүлээсэн чанартай хурал боллоо.

ССАЖГ–ТАЙ ХАМТАРЧ АРД АЮУШИЙН ТАЛБАЙД " НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР "ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАВ

Энэ өдөр манай номын сангийн бүх тасаг танхимууд өөрийн танхимын танилцуулага,хийсэн ажлын тайланг иргэдэд танилцуулахаас гадна шинэ номын үзэсгэлэн, ховор номын үзэсгэлэн,номын худалдаа, " Нэгийг өгч болно, нэгийг авч болно" уриан дор ном хандивласан иргэдэд үнэгүй ном бэлэглэх үйлчилгээ ,

"Явуулын номын сан" ажиллуулж иргэдэд нээлттэй ном унших зэрэг

үйлчилгээнүүд явууллаа. Энэ үеэр номын сангаар гэр бүлээрээ идэвхитэй ном уншдаг шилдэг гэр бүл шалгаруулж, " Шилдэг уншигч гэр бүл " –ээр Хаан банкны эдийн засагч н.Намдагийн гэр бүл шалгарч 50000 төгрөгийн үнэ бүхий ном,өргөмжлөлөөр шагнаж урамшуулав.

Өдөрлөгийн үеэр Үл мэдэх танхим, Уншлагын их танхимын номын санч М.Эрдэнэ, М.Чимгээ нар ЕБС-ийн сурагчдын дунд зохион явуулсан Соёл олон нийтийн ажлын тайланг зурган хэлбэрээр гаргаж иргэдэд сурталчилав.

Тус соёл олон нийтийн ажилд идэвхитэй оролцож уралдаан тэмцээнд шалгарсан сурагчдын шилдэг дүрийн тоглолт 7-р сургуулийн 5-б ангийн сурагчдын тоглосон “ Болдоггүй бор өвгөн “ үлгэрээр хийсэн тоглолт зэрэг шилдэг урлагийн тоглолтуудыг өдөрлөгт оролцогчдод үзүүлж сонирхуулав.

Иргэдийн дунд хөндлөнгийн судалгаа явуулав.Мөн Үндэсний бичиг үсгийн баяраар “ Уран бичлэг “ –ийн уралдаанд шалгарсан бүтээлүүдийн үзэсгэлэнг гаргаж сурталчилах зэрэг зохион байгуулж явуулсан ажил нь уншигчдын таашаал хүлээж,сонирхол төрүүлсэн сайхан үйл явдал болсон нь бидний цаашид хийх ажилд маш их урам өгсөн ажил болж өндөрлөлөө.

МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГИЙН ДАГУУ 10-р сарын 30-нд сумын номын санчдад өөрийн танхимаа танилцуулж, уншлагын танхимд чөлөөт уншлагын тавиуруудыг байрлуулав. 10-р сарын 31-нд Дарви сумын номын санчийн төсөл бичиж,номын сангаа өргөтгөсөн санаачлагатай танилцах, мөн тус сумын номын санд “Монголын нууц товчоо” зохиол залах арга хэмжээн зохион байгууллаа.

”Монголын нууц товчоо“ зохиолыг Дарви сумын Олхонууд хар баньди овогт Доржбалын Бальдаржамц мал зүйч мэргэжилтэй,улсад 32 жил ажилласан, ХАА –

тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медальт, тэргүүний уншигч ахмадад хүндэтгэлтэйгээр хүлээлгэн өгөв.

Энэ үйл ажиллагааны нээлтэнд Дарви сумын тэргүүний уншигчидаас гадна Соёлын төвийн дэргэд шинэ санаа – шинэ үйлчилгээг хүргэх зорилгоор байгуулсан

“Сэцэн оюут“ клубын эмэгтэйчүүд, аймгийн нийтийн номын сангийн номын санчид болон сумдын номын санчид оролцож, монгол ардын дуу “Үлэмжийн чанар“ дуугаар ая барьж хүлээн авлаа. Мөн манай хамт олон “Нээлттэй хаалганы өдөр“ өдөрлөг зохион байгуулж, байгууллагын танилцуулага, шинэ номын үзэсгэлэн гаргаж тус сумын иргэдэд сурталчилав. Уншлагын их танхимаас дэлхийн хүүхдийн шилдэг 50 ботиор болон 5 загварын Монголын нууц товчоо зохиолуудаар үзэсгэлэн гаргав.

Мөн дарви сумын “Өв эрдэнэ“, “Ном эрдэнэ“ –ийг дээдлэн эрдэмтэн мэргэдийн ирээдүй эгэлгүй авьяастны үргэлжлэлийг төрүүлэх зорилго тавьж уйгагүй хөдөлмөрлөж төсөл бичиж, хэрэгжүүлэн фонд баяжилтаа 90 хувьд хүргэсэн жишиг номын сангийн үйл ажиллагаатай болон сумын гэр музейн үзмэртэй сумдын номын санчдыг танилцуулаа. Мөн Манхан, Зэрэг, сумын номын сангийн үйл ажиллагаатай таницлаа.Маршал Чойбалсангийн гарын үсэг бүхий сайшаалын үнэмлэх, партизанд өгсөн жанжин малгай хүрэм, АЖ Д.Мяасүрэнгийн тулга, баатруудын даавуун хөрөг гээд ховор нандин үзмэрүүдтэй танилцлаа.
15 цагт номын санчид тус сумын соёлын төвийн ажилтнуудтай Дарви сумын байгальтай танилцаж “ Эко аялал “ зохион байгуулж, дурсгалын зураг авхуулах зэрэг хөтөлбөрийн дагуу сайхан арга хэмжээ болж өндөрлөлөө.

СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Номонд дурлагдсадын клуб болон Улаанбаатар хот дахь Ховд аймгийн оюутан залуучуудын холбооны Ном хандивлав.
Америкийн Монгол судлалын төвөөс 1573 ширхэг номыг авч 16 сумдад хувиарлан хүлээлгэн өглөө.

ЖАРГАЛАН СУМЫН ЕБС-ИЙН 2-Р АНГИУДЫН ДУНД “МИНУТАНД ХЭН ХАМГИЙН ХУРДАН ЗӨВ УНШИХ ВЭ” УРАЛДААНЫГ ЗОХИОН ЯВУУЛЛАА

Тус арга хэмжээнд7 сургуулийн 21 хүүхэд оролцов. Тус тэмцээнийг ахлах номын санч-арга зүйч Д.Саранцэцэг. номын санч –фондч Б.Алимаа , 3-р сургуулийн бага ангийн багш Түвшинтөлөв нар удирдамжийн дагуу шүүж байр эзлүүлэв: Үнд: М.Энхмэнд /прогресс-2а/ -94 үг, Б.Энхжаргал /прогресс-2а/ - 92 үг, Р.Пүрэвжав /1-р сургууль -2б/ -86 үг

уншиж өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, Х.Батэрдэнэ /3-р сургууль-2б/ 84 үг уншиж тусгай байр эзэлж өргөмжлөл номоор шагнаж урамшуулав.

ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ ДЭЭР АЖИЛЛАСАН ”ОЮУНЫГ ОЮУТНЫ БАЙРНААС” СЭДЭВТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЛАА

Хөтөлбөрийн дагуу мэргэжлийн ном,лавалгааны ном, англи номуудаар үзэсгэлэнгээ гаргаж эхэллээ.

Зохиолч, яруу найрагч

Төрмөнхтэй оюутан залуусаа уулзуулсан нь маш сонирхолтой, үр өгөөжтэй, халуун дотно яриа өрнүүлж, зохиолчийнхоо уран бүтээлийн дээжээс сонссон нь сайхан байв.

Гэрээр ном олгогч Б.Одонпүрэв угийн бичгийг хэрхэн хөтлөх талаар лекц уншсан нь оюутнуудад маш их сонирхолтой байсан ба оюутнууд нээлттэйгээр энэ сэдвээр ярилцсан нь лекц үр дүнгээ өгч байгаа нь мэдэгдэж байсан.

Номзүйч Ц.Мөнхжаргал номын сангийн үйл ажиллагааны талаар мөн шинэ номын мэдээлэл хийлээ.

Америкийн соёл мэдээллийн төвийн номын санч Г.Баяраа төвийнхөө үйл ажиллагаа мөн зарлагдаж байгаа хөтөлбөрүүдээ нэг бүрчлэн танилцуулж мэдээлэл өгсөн.

Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүдтэй уулзалт зохион байгуулав.

МЗЭ-ийн гишүүд Ховд аймагт ажиллах үеэр ЗДТГ-т номын үзэсгэлэн гаргаж зохиолчдыг хүлээн авав.

Ардын уран зохиолч Тангадын Галсан, Орчуулагч шүүмжлэгч Явуухулангийн Одонтөр нарын хамт Дөргөн, Чандмань, Дарви, Зэрэг сумуудад ажиллаж нийт 3000 орчим ард иргэд, хүүхэд багчуудтай уулзалт зохиог байгууллаа.

Чандмань сум, Дөргөн суманд ажилласан байдлыг зургаар харуулав.

Нийтийн номын сангийн идэвхитэй уншигчид зохиолчидтой уулзалт хийв. Мөн зохиолчид Номын сангийн дотоод үйл ажиллагаатай танилцав.

12 Жилийн 2, 3 дугаар сургуульд орчуулагч Чинбаяр,зохиолч Баяржаргал нарын хамт сурагчидын уулзалтыг хийв.

Орчуулагч багш Одонтөр Чинбат нар “Орчуулга хийх арга” сэдвээр Access хөтөлбөрийн сурагчдад мэдээлэл зөвлөгөө өгч сурагчдын асуултанд хариуллаа.

АЙМГУУДЫН НОМЫН САНГУУД АЖЛЫН АРГА ТУРШЛАГАА ЯРИЛЦЛАА....

Чингисийн талбайд Номын баярыг зохион байгуулсан арга хэмжээнд оролцож үнэт ховор номын болон хэвлэлийн газруудаас ирсэн номтой танилцлаа. Төрийн соёрхолт зохиолчидтой уулзалт зохион байгуулж УЛААН ХИВСНИЙ баярын арга хэмжээг үзэж сонирхлоо.





ЖИЛ БҮР УЛАМЖЛАЛ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ “ГАН ҮЗЭГ ЯРУУ НАЙРАГ -2014” ТЭМЦЭЭН

Яруу найргийн тэмцээн 2014 оны 10 сарын 24-нд нийтийн номын сан дээр зохион байгуулагдлаа. Уг тэмцээнд төв хөдөөгийн 80 сурагч, 10 оюутан оролцлоо. Тэмцээний шүүгчээр Болор цомын эзэн яруу найрагч Х.Эрдэнэбаатар, Зохиолч, яруу найрагч н.Баяраа нар шүүн явууллаа. 4 насны ангилал тус бүрт эхний 3 байр, тусгай байр 2-ийг шалгаруулсан ба шилдэгийн шилдэг оролцогчы шүлгийг бид видео хэлбэрт оруулж өөрийн FACEBOOK хуудсанд байршуулж хамгийн олон лайк авсан хүний тоогоор шалгарууллаа.

"ГАН-ҮЗЭГ 2014" наадмыншилдэгийншилдэгГранпришагналынэзнээр Ховд аймгийн Буянт сумын 12 жилийн сургуулийн сурагч Б. Куралай 273 хүний талархал хүлээн шалгарлаа.

ГАН ҮЗЭГ-2014 уралдааны дүн:

БАГА НАСНЫ АНГИЛАЛ /4-6 анги/			
М.Анхцэцэг	Прогресс сургууль	$4^{б}$ анги	1-р байр
Э.Гоомарал	7-р сургууль	$6^{б}$- анги	2-р байр
Б.Чинболор	1-р сургууль	$4^{г}$ анги	3-р анги
Б.Цэцэгчулуун	Цаст-Алтай цогцолбор сургууль	$6^{в}$ анги	тусгай
Даваажаргал	1-р сургууль	$4^{г}$- анги	тусгай
ДУНД НАС /7-9 анги/			
Б. Хуралай	Буянт сум	$9^{в}$	1-р байр
Н.Ариун-Эрдэнэ	Буянт сум	$7^{а}$	2-р байр
Э.Мөнхзаяа	6-р сургууль	$9^{а}$	3-р байр
М. Сэлэнгэ	Цаст-Алтай	$9^{г}$	тусгай
Энхтунгалаг	3-р сургууль	$9^{а}$	тусгай

АХЛАХ НАС / 10-12 анги/			
Д.Дэмэдханд	1-р сургууль	$11^{г}$	1-р байр
Н.Энхзаяа	1-р сургууль	$12^{б}$	2-р байр
Г.Жавхланбаяр	1-р сургууль	$11^{д}$	3-р байр
Б.Цэлмэгсайхан	Дуут сум	$11^{а}$	тусгай
П.Амаржаргал	2-р сургууль	$12^{а}$	тусгай
НАСАНД ХҮРЭГСЭД			
Лхагва-Очир	Жаргалант сум	ажилгүй	1-р байр
Оюун-Эрдэнэ	Польтехник	оюутан	2-р байр
Солонго	ХИС	оюутан	3- байр

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ “ШУВУУН СААРАЛ -2014” БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН УРАН УНШЛАГЫН НААДАМЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2014 оны 11–р сарын 21–нд Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч

их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит “ Шувуун саарал “ богино өгүүллэгийн уран уншлагын 18 дахь удаагийн наадамыг зохион байгуулж явуулав. Аймгийн төвийн болон сумдын ЕБС – ийн нийт 130 сурагч насанд хүрэгсэд 10 оролцлоо. Тус тэмцээний шүүгчээр МУАЖ Сэнгэ-дорж, зохиолч орчуулагч А.Оюунчимэг нар шүүн явууллаа.

Тэмцээнд нийт 140 оролцогч оролцсон нь тус тэмцээн нь хамрагдах хүрээ жил ирэх бүр хүрээгээ тэлж оролцогчдын тоо нэмэгдсээр байна.

Нэгдсэн оноо:

БАГА НАСНЫ АНГИЛАЛ /1-6 анги/			
Н.Цэнд-Аюуш	7-р сургууль	$2^{г}$ анги	1-р байр
Б.Амарзаяа	7-р сургууль	$3^{а}$ анги	2-р байр
Н.Хосбуян	3-р сургууль	$6^{г}$ анги	3-р анги
А. Буянзаяах	6-р сургууль	$4^{в}$ анги	Тусгай
А.Мөнхцэцэг	Буянт сум	$1^{а}$ анги	Тусгай
ДУНД НАС /7-9 анги/			
М. Одчимэг	Цаст-Алтай	$7^{а}$	1-р байр
Агерке	2-р сургууль	$9^{г}$	2-р байр
Ч,Баярмаа	Манхан	$9^{в}$	3-р байр
Б. Хуралай	Буянт	$9^{а}$	Тусгай
Одонцэцэг	7-р сургууль	$7^{а}$	Тусгай
АХЛАХ НАС / 10-12 анги/			
Б.Бямбасүндэл	7-р сургууль	$10^{б}$	1-р байр
Б.Амарзаяа	Манхан	$12^{б}$	2-р байр
Т.Эрдэнэ-Оюун	дуут	$12^{а}$	3-р байр
Н. Баярхишиг	прогресс	$10^{а}$	Тусгай
О.Тамир	Буяит	$11^{а}$	Тусгай
НАСАНД ХҮРЭГСЭД			
Пүрэвдорж	Мөнххайрхан сум	Дуу хөгжмийн багш	1-р байр
П.Пүрэвсүрэн	Дуут сум	СТ ажилтан	2-р байр
Ихбаяр	Жаргалант сум	Ажилгүй	3- байр
Энхцэцэг	ХИС МХУЗ-4	Оюутан	Тусгай байр
Н.Отгон-Эрдэнэ	Польтехник 2-р	Оюутан	Тусгай

Шалгарч Алт Мөнгө, Хүрэл медаль,өргөмжлөл, мөнгөн шагнал дурсгалын зүйлээр шагнагдлаа.

Эхний 3 байранд шалгарсан оролцогчидоос Онлайн шалгаруулалт хийхэд Манхан сумын 12 жилийн сургуулийн 12 дугаар ангийн сурагч М.Амарзаяа 527 хүний саналаар тэргүүлэн “Шилдэгийн шилдэг оролцогч” болж гранпри шагналын эзэн боллоо.

МОНГОЛ УЛС НҮБ-ИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН КОНВЕНЦЭД НЭГДЭН ОРСНЫ 25 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД НЭГ ӨДРИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Тус арга хэмжээг тохиолдуулан уншигчдыг номын сангийн үйл ажиллагаатай танилцуулж, үнэгүй карт нээн өгч, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх ном хэрхэн унших, номын ач тусыг хэрхэн ашиглах талаар тасаг танхимууд мэдээлэл хийж, уншигчдад үнэгүй карт /28 уншигч/ нээж үйлчлэв.Хүүхдийн эрхийн конвенцийн 25 жилийн баярт зориулж, Хүүхдийн ордонд зохион байгуулагдсан ТВ нэвтрүүлэгт “Номын сангийн үйлчилгээг хүүхэд бүрт тэгш хүртээх арга зам“ сэдвээр ярилцлага өгөв.

Аймгийн засаг даргын захирамжаар “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хүүхдийн парк дээр очиж номын үзэсгэлэн гаргаж ажиллав.

2014 оны 02 дугаар сарын 21-22 нд болсон **“Мөнгөлөг шагшуурга”** мөсний баярт оролцлоо. Мөн Соёл, Спорт, Аялал жуулчлалын сайд Оюунгэрэлийн уулзалтанд оролцож тасаг танхимын ажлыг танилцууллаа. 03дугаар сарын 24 нд болсон “Том төрөөс ухаалаг төр” хэлэлцүүлэгт оролцож өөрийн бодол санал хуваалцлаа.

12 ЖИЛИЙН НЭГДҮГЭЭР СУРГУУЛЬД “УЛАМЖЛАЛТ ЁС ЗАНШИЛ-ЗАН ҮЙЛЭЭС СУРАЛЦЪЯ” СЭДЭВТ НОМЫН 1 САРЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

1-р сургуулийн номын сан, сургалтын менежерүүдтэй хамтран “Нээлттэй хаалганы өдөр” хийж, сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, байгууллагын үйл ажиллагаа, тасаг танхимуудын талаарх мэдээлэл хийж, Монголын уламжлалт цагаан сарын баярыг тохиолдуулан “Уламжлалт ёс заншил-зан үйлээс суралцъя” сэдэвт номын аяныг хөтөлбөр удирдамжийн хүрээнд зохион байгуулан явуулж бүлэг тус бүрээс идэвхитэй оролцсон анги хамт олныг шалгаруулан урамшуулав.Үүнд:

- “Ардын аман зохиолыг хэн сайн мэдэх вэ” тэмцээнд 3-р ангийн 4 бүлгийн 100 гаруй уншигч оролцож асуулт тус бүрийг 0-5 оноогоор дүгнэж байр эзлүүлэхэд С.Болормаа багштай 3Г анги 22 оноогоор 1-р байр

- “Дөрвөн бэрх” тэмцээнд 4-р ангийн 4 бүлгийн 12 гишүүнтэй 4 баг оролцож, тэмцээнийг багууд бэлдсэн асуултаа бие биенээсээ асуух хэлбэрээр явуулж, 4 бод, 2 богоор “Тэмээчин” баг түрүүлж, Маасүрэн багштай 4Г анги 35 оноогоор 1-р байр эзэллээ.

БРАИЛ НОМ ХАНДИВЛАВ

Ховд аймгийн нийтийн номын сан гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр “Нэг байгууллага нэг иргэн“ аяны хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдрөөр аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн гэрээр ном олгох тасгийн номын санч, фондоч, нягтлан бодогч нартай хамтран зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэн шинэ номын талаар тойм яриа, мэдээлэл хийлээ. Энэ арга хэмжээнд 40 гаруй номоор үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

Хараангы бэрхшээлтэй иргэдэд зориулан Хүүхдийн уран зохиолын болон уран зохиолын, хөгжмийн урлагийн БРАИЛ ном өгч цаашид хамтран ажиллаж олон салбарын номоор үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах талаар ярилцаж тохиролцлоо.

БРАИЛ ном гардуулж өглөө

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эцэг эхийн холбоотой хамтран ажиллах талаар ярилцаж байгаа нь

“Дөрвөн бэрх” тэмцээнд түрүүлсэн М.Маасүрэн багштай “Тэмээчин” баг

- “Ардын уламжлалт ёс заншлыг хэн сайн мэдэх вэ” АХА тэмцээн

Тус тэмцээнд 5-6-р ангийн 84 уншигч оролцож, оюун ухаан, авьяас билгээ сорьж 5в ангийн сурагч О.Номин тэргүүлэв.Мөн 5-р ангиудыг номын аянд оролцсон байдлаар 0-5 оноогоор дүгнэхэд 35 оноогоор Гэрэлзул багштай5А анги 1-р байр эзэлж тус анги бүлгүүдийг өргөмжлал мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

“Ном дор хамтдаа” сэдэвт “Аав, ээж, би” тэмцээнийг уншигчдын аав ээжүүдтэй хамтран 12 жилийн 2 дугаар сургуульд зохион байгуулж явуулсан нь уншигчдын сонирхолд татсан эцэг эхчүүдийн талархал хүлээсэн тэмцээн боллоо.Тус тэмцээнд 8-р ангийн сурагч М.Акерге ахлагчтай “ би чадна-бид ялна” баг түрүүлэв.

- 6-р сургуулийн 2-5-р ангийн сурагчдын эцэг эхчүүдэд “хүүхдүүдээ ном унших дуртай болгоё” сэдэвт сургалтыг “Хүүхдийг бүтээлчээр уншуулах арг зүй”, “Номын амтыг багаас нь мэдрүүлэх нь” зэрэг сэдвүүдээр сургалт явуулж ,эцэг эхчүүдтэй харилцан ярилцаж санал бодлыг нь сонсож “”Ярих урлаг” олимпиадаас медаль авсан сурагчдын уншсан өгүүллэг, шүлгүүдээс сонирхууллаа

Казак үндэсний эд зүйлийг тайлбарлаж байгаа нь

Казакын үндэсний “Наурыз”-ын баяр буюу “Нарны баяр”-ыг тохиолдуулан “Казак ёс заншилаас суралцъя” сэдэвт өдөрлөг зохион явуулав.Өдөрлөгт уншигчдын эцэг эхчүүд оролцож казак үндэсний ёс заншилын талаар уншигчдад ярьж өгөв.

АСМТ болон Насанд хүрэгсэдийн уншлагын т… …аад иргэдийн дунд “Монгол ёс заншилыг хэн сайн м… …ион байгууллаа.

Уншигчид сонирхсон номоо сонгон уншиж

12 жилийн 3-р дунд сургуулийн хичээлийн байранд “Нээлттэй хаалганы өдөр" хийж байгууллагынхаа тасаг танхимуудын үйл ажиллагааны талаарх мэдээлэлийг уншигчдад хүргэж, уншлага үйлчилгээний цагийн хуваарийг танилцуулав.

Ховд телевизийн сурвалжлагчид Нээлттэй хаалганы өдрийн талаар

Шинэ номын үзэсгэлэн сурвалжлагчын дуранд

- ДЗОУБайгууллагын хүүхдийн эрхийг хамгаалах албатай хамтран “Уншихаа боливол сэтгэхээ болино” сэдэвт АХА тэмцээнд 3, 6, 7-р сургуулийн 5-р ангиудын 52 уншигч оролцож, Монголын болон Дэлхийн хүүхдийн шилдэг зохиолууд, шилдэг үлгэрүүд,Ардын аман зохиолуудаас бэлдсэн 182 асуултаас 123 асуултыг бүрэн хариулж бусдыгаа хошуучилсан 3-р сургуулийн 5в ангийн сурагч М.Ганбаатар, тус сургуулийн 5Г ангийн сурагч Н.Хосбуян нарыг ДЗОУБайгууллагын өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав.

АХА тэмцээний явцаас

М.Ганбаатар, 2-р байр Н.Хосбуян

Мөн тус аяны хүрээнд 4-р ангиудын дунд зохион явуулсан “Үлгэрийн баатрууд амилсан нь” сэдэвт дүрийн тоглолтонд 7-р сургуулийн Мөнхтуяа багштай 4В ангийн сурагчдын МАҮлгэр “Болдоггүй бор өвгөн” үлгэрээр бэлдсэн дүрийн тоглолт 1-р байр, мөн Отгончимэг багштай 4Б ангийн сурагчдын МАҮлгэр “Эрхий мэргэн” үлгэрээр бэлдсэн дүрийн тоглолт 2-р байр эзэлснийг ДЗОУБайгуулллагын өргөмжлөл үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшуулав

“ГЭГЭЭН ҮДШИЙН УНШЛАГА” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурагчдын ном унших сэдэл тэмүүллийг нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зорилгоор 2014 оны 11-р сарын 27-ны өдөр Цаст-Алтай цогцолбор сургуулийн Э.Эрдэнэ-оюун багштай 5в ангитай хамтран зохион байгуулж телевизийн нэвтрүүлэг хийж бэлтгэв.

Байгууллага бүр тус бүртээ өөрсдийн хариуцах ажил үүргээ хувиарлан харилцан үүрэг хүлээж ажиллав. Дээрх ажил нь сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон

өнгөрүүлэхээс гадна анги хамт олны нэгдэл нягтрал, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоо хэрэгжүүлж чадсан ажил болов.

Сурагчдын зүгээс:

1. Сурагчид өөрсийн оройн хоол, аяга халбагатайгаа бэлтгэж ирнэ.
2. Сурагчид өөрсдийн мишоктой ирнэ.
3. Ариун цэврийн хэрэгсэлүүдтэйгээ ирнэ.
4. Ирэхдээ чөлөөт хувцастай / тамирын хувцас, пүүз, кеттэй/ ирэх ба хичээлийн дүрэмт хувцасаа авч ирнэ.

Эцэг эхийн зүгээс:

1. Оройн хоол, мишок, ариун цэврийн хэрэглэл бэлтгэж өгөх.
2. Хүүхдээ цагт нь авч ирж хүлээлгэж өгнө.
3. Хүлээн зөвшөөрсөн талаар гарын үсэг зурж харицан тохиролцсон байна.

Сургуулийн зүгээс:

1. Оройн тараг өгөх.
2. Цайны завсарлага хариуцах.
3. Зохион байгуулалтын арга хэмжээнд анги удирдсан багш болон холбогдох хүмүүсийг / эцэг эхийн төлөөлөл, нийгмийн ажилтан, номын санч, эмч/ хамруулах.

4. Сурагчдын аюулгүй байдлыг хангаж ажиллана.
5. Мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах /хамтарна/
6. Явуулын эмийн сантай байх.

Номын сангийн зүгээс:

1. Өглөөний цай бэлтгэх / сүүтэй будаа, цай, маслотай талх өгөх/
2. Буцалсан ус байнга байна.
3. Номын санчид, хамтран ажиллах холбогдох хүмүүс хариуцлагатай оролцох.
4. Өрөө тасалгааны цэвэр цэмцгэр байдлыг хариуцна.
5. Аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Сурагчидтай хамт хонох багш, ажилтнуудын нэрс:

1. АУБ Э.Эрдэнэ-Оюун
2. Нийгмийн ажилтан Ж.Баторших
3. Эцэг эхийн төлөөлөл Лхамхүү
4. Номын санч М.Чимгээ
5. Мэдээллийн ажилтан Д.Отгонбилэг
6. Номын сангийн Харуул Х.Буджав

“ШИЛДЭГ ОНИГООЧ -2014” УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Инээдмийн баярт зориулан ард иргэд нийт уншигч үйлчлүүлэгчдийн дунд “Шилдэг онигооч -2014” тэмцээнийг 2014 оны 04 сарын- 02 нд аймгийн Залуучуудын холбоотой хамтран зохин байгуулагдлаа. Тэмцээнд 22 онигоочид оролцлоо. Уг арга хэмжээний тэргүүн байрыг 12 жилийн 7-р сургуулийн бага ангийн багш С. Хоролсүрэн, дэд байрыг ХИС-ийн оюутан С. Ихбаяр, гутгаар байрыг Б.Сүхбат, тусгай байрыг Мөнххайрхан сумын өндөр настан С.Бүрнээ нар тус тус эзэлж

өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 6-10-р ангийн сурагчдын дунд “Сайн аав” сэдэвт зохион бичлэгийн уралдаан 1 сарын хугацаанд зарлагдаж Жаргалант сум, Эрдэнэбүрэн, Манхан сумаас сурагчдын эссэ бичлэг ирж нийтдээ 52 зохион бичлэг ирсэнээс 10 шилдэг зохион бичлэгийг шалгаруулллаа. Энэхүү уралдааныг орон даяар ЭТКорпусын Сайн дурын мэргэжилтнүүд Америкийн төв, сургуулийн нийгмийн ажилтнууд хамтран зохион байгуулав. Уг уралдаанд Эрдэнэбүрэн сумын 6а ангийн сурагч Ариунзаяа, Дэмидханд, Буянзаяа нар идэвхтэй сайн оролцлоо. Шалгарсан сурагчдаас гадна 3 аав ирж хүүхдүүд өөрсдийн бичсэн эссэг уншиж танилцуулж аав бүрт Алтан медаль сурагчдад сертификат дурсгалын зүйл гардуулав.

Энхтайвны корпусын сайн дурын ажилтан Девон Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд эссэ хэрхэн бичих талаар 3 долоо хоногийн үнэгүй сургалт явууллаа. Нийтдээ 16 сурагч хамрагдав.

“Архи өсвөр насныханд нөлөөлөх нь” сэдвийн дор Access сурагчдын дунд баримтат кино хийх уралдаан зарлагдаж нийтдээ 5 баг болж оролцсоноос 1-р байрт Буянхишигийн баг тэргүүлж тус материал улсын уралдаанд оролцохоор боллоо.

Тоглоомын тойрог

Цаст Алтай сургуулийн 7а ангийн сурагчдад тоглоом хэрхэн тоглох англи үг цээжлэх, Ipad ашиглан цахим ном унших аргачлал зааж өгөв.

Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 180 гаруй сурагчдыг хамруулсан номын өдөрлөг зохион байгууллаа.

Номтой нөхөрлөе сэдэвт номын өдөрлөгт оролцсон 180 гаруй сурагчдад ном хэрхэн унших, номын ач тусын талаар мэдээлэл хийж чөлөөт сонголтоор дуртай номыг уншуууллаа.

Номын өдөрлөгийн арга хэмжээнд оролцсон 180 сурагчдын дунд танин мэдэхүйн "Алтан хонх" тэмцээн зохион байгуулав.

Танин мэдэхүйн "Алтан хонх" тэмцээний тэргүүн байрын шагналтнуудыг тодруууллаа.

"Halloween" баярыг тэмдэглэн өнгөрүүлэв

Америкийн тэмдэглэлт баяр болох Аймшгийн баярыг Access -6 сурагчид болон америк багш нарын дунд зохион байгуулав. Сурагчдыг 4 бүлэг болгон хуваах, энэ баяртай холбоотой дуу шүлэг багийн мэндчилгээ, 5 төрлийн хөгжөөнт тоглоом тоглуулж байр эзлүүллээ. Мөн сурагчдын дунд "**Halloween**" сэдэв гар зургийн уралдаан зарлаж сурагч Өнөболд тэргүүлж, багийн дүнгээр Сүхочир ахлагчтай баг тэргүүлж гарын бэлэг дурсгалын зүйлээр шагнагдав.

Олон Улсын бүтээлч эссэ бичлэгийн уралдаан

Жил бүр уламжлал болгон явагддаг Олон Улсын бүтээлч Эссэ бичлэгийн уралдаанд манай аймгаас 183 сурагч оюутан оролцож 60 минутын зохион бичлэг бичлээ. Эссэний гол сэдвүүд тухайн хүний сэтгэн бодох чадвар бүтээлчээр сэтгэхэд чиглэсэн бөгөөд мэргэжлийн багш нар оюутнууд бас мэдлэг оюунаа сорьлоо. Уг тэмцээнийг Энхтайвны корпусын сайн дурын ажилтнууд Боловсролын газрын арга зүйч Бердигүль нар удирдан явууллаа. Багш нарын дунд болсон эссэ бичлэгийн уралдаанд Прогресс сургуулийн Лхамзаяа тэргүүлж 25 байр эзэлсэнээс 20 сурагч Прогресс сургуулийн сурагчид байлаа. Мөн 10-р ангийнхны эссэ бичлэгийн уралдаанд Access хөтөлбөрийн Хосбилэг Буянзаяа нар 2,3-р байр эзэлж амжилттай сайн оролцлоо.

Good fatherзохион бичлэгийн уралдаан

Ерөнхий боловсролын сургуулийн 6-10-р ангийн сурагчдын дунд “Сайн аав” сэдэвт зохион бичлэгийн уралдаан 1 сарын хугацаанд зарлагдаж Жаргалант сум, Эрдэнэбүрэн, Манхан сумаас сурагчдын эссэ бичлэг ирж нийтдээ 52 зохион бичлэг ирсэнээс 10 шилдэг зохион бичлэгийг шалгаруууллаа. Энэхүү уралдааныг орон даяар ЭТКорпусын Сайн дурын мэргэжилтнүүд Америкийн төв, сургуулийн нийгмийн ажилтнууд хамтран зохион байгуулав. Уг уралдаанд Эрдэнэбүрэн сумын 6а ангийн сурагч Ариунзаяа, Дэмидханд, Буянзаяа нар идэвхтэй сайн оролцлоо. Шалгарсан сурагчдаас гадна 3 аав ирж хүүхдүүд өөрсдийн бичсэн эссэг уншиж танилцуулж аав бүрт Алтан медаль сурагчдад сертификат дурсгалын зүйл гардуулав.

Эх дэлхийгээ хайрлая сэдэвт гар зургийн уралдаан

Access сурагчдын дунд “Эх дэлхийгээ хайрлая” гар зургийн уралдаан болов. Сурагчдын бүтээлээр зургийн үзэсгэлэн гаргав. Уралдаанд Прогресс сургуулийн

10 а ангийн сурагч Балжинням түрүүлж алтан медаль, дурсгалын зүйлээр шагнагдав.

6-р дунд сургуулийн 11 а ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг англи хэлний асуултаар явагдаж нийтдээ 28 сурагч оролцсоноос сурагч Ууганэрдэнэ тэргүүлж Тунгалаг удааллаа. Түрүүлсэн сурагчдад өргөмжлөл, ном, дурсгалын зүйлсээр шагнаж урамшуулав.

I have dream эссэбичлэгийн уралдаанд 35 сурагч зохион бичлэгээ өгч Прогресс сургуулийн 11 ангийн сурагч Д.Сүхочир тэргүүлж дурсгалын зүйлээр шагнагдлаа.

Ховд аймгийн Засаг дарга Д. Цэвээнравдан Нийтийн номын сангаар зочилж электрон номын сан, цахим номын талаар мэдээлэл авч, Ipad kindle төхөөрөмжийн ашиглалт хэрэгцээг асууж англи номын тоо, үйлчлүүлэгчдийн талаар асууж тодруууллаа. Тэрээр бүх тасаг танхим, фондтой танилцаж өөрийн бодол санаа, шинэ санаа, зөвлөгөөг номын санчдад хүргэлээ. Мөн нийтийн номын сангийн вэб хуудастай танилцаж, мэдээлэлтэй танилцав.

Пирамид танин мэдэхүйн тэмцээн

ЕБС-н 9-р ангиудын дунд уламжлал болгон явагддаг танин мэдэхүйн Пирамид тэмцээнийг амжилттай явууллаа. Уг тэмцээнд 6 сургуулийн 18 сурагч оролцсоноос 1-р сургуулийн Од баг 1-р байр, 2-р байрыг Прогресс сургуулийн таван эрдэнэ баг, 3-р байрыг 2-р сургуулийн Нөхөрлөл баг тус тус байр эзэллээ.

Англи хэлээр хэн сайн дуулах вэ? тэмцээнийг ЕБС-иудын сурагчдын дунд зохион байгуулав. Тус арга хэмжээнд 12 жилийн 6 сургуулийн сурагчид багш нарын хамт оролцлоо.

Эцэг эх уншигчдын хамтарсан “Ном уншиг нэг өдөр” арга хэмжээг зохион байгууллаа

7–р ангийн сурагчдыг эцэг эхтэйгээ “Ном унших нэг өдөр“ өдөрлөгийг амралтын өдрөөр зохион байгуулж явуулсан нь эцэг эхчүүдэд маш их таалагдаж,

санал хүсэлт, талархал бичиж, энэ ажлыг хойшид байнга 7 хоногт 1 удаа явуулж байх хүсэлтийг хүлээж авлаа.

“Цэцэрлэгийн ахлах ангийн хүүхдүүдэд номын сангийн үйл ажиллагаа болон үйлчилгээг танилцуулах арга хэмжээ болов

Жаргалан сумын 5–р цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдийг урьж номын сангийн үйл ажиллагаатай танилцуулж, тэдэнд

зурагтай ном үзүүлж, тайлбарлан ярилцаж, үлгэр уншиж өгөөд ойлгосныг нь яриулж, оньсого, зүйр цэцэн үг таалгаж, зөв тааж ярьсан болон оролцсон хүүхдүүдийг урамшуулан шагнаж, хөгжилтэй сайхан өглөөлөг зохион байгуулж явууллаа.

БАЙГУУЛЛАГА ОРЧИНОО ЦЭЦЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Байгууллагынхаа гадна болон дотор талд цэцэгжүүлэх ажлыг хийж дуусав.

Цэвэр орчин миний оролцоо бүх Мод тарих ажилд оролцов нийтийн цэвэрлэгээнд оролцлоо.

СУРГАЛТ СЕМИНАР:
Сумдын номын санчдад Номыг электрон каталогт оруулах тухай дадлагажих 3 хоногийн сургалтыг 03 сарын 13-15 өдрүүдэд мэдээлэл технологийн ажилтантай хамтран зохион байгууллаа.



Сумдын соёлын төвийн удирдлагуудын сургалт 2 өдрийн зохион байгуулагдав. Энэ үеэр удирдлагуудад номын сангийн үйл ажиллагаа, соёлын төвийн номыг электрон каталогт хэрхэн

оруулох,энэ ажлыг хийх боломжоор хангах, хэрэгцээ шаардлага хангахгүй номыг хэрхэн аклах талаарх тогтоол журам зааварыг танилцуулж акталсан номын жагсаалт гаргах, үнэ тогтоох зэрэг арга зүйн зөвлөгөөг өглөө.Мөн номын сангийн захирал Т. Эрдэнэтуяа "Номын сангийн автоматжуулалт" сэдвээр сургалт хийж удирдлагуудын санал асуултанд хариулт өглөө.

Аймгийн МҮЭ-ийн Холбооны даргын албан тоотын хүрээнд УБ хотруу 7 хоног ажлын туршлага судлах, сургалтанд Д.Саранцэцэг хамрагдлаа.

Англи хэлний багш нарын сургалт

Англи хэлний багш нарын сургалтыг 1 сард 3 удаа зохион байгууллаа. Хичээлийг Боловсролын газрын мэргэжилтнүүд Боб Хазел нар зааж нийтдээ 29 багш хамрагдлаа. Энэ багш нарт USAP хөтөлбөрийн танилцуулга, өргөдөл хэрхэн бөглөх талаар мэдээлэл өгч танилцуулах материал тараалаа.

"Тамхины эсрэг тэмцье" сэдэвт сургалт явуулж хүүхдүүдэд энэ талаар мэдээлэл хүргэж хууль сурталчлав. Уг үйл ажиллагаанд 35 сурагч 5 багш оролцож мэдээллийн төвийн танилцуулах материал тарааж, оюутан сурагчдын асуусан асуултад хариулав.

Ассесс хөтөлбөрийн сурагчид Батламжаа гардан авлаа

АНУ ЭСЯ-ны 10-р ангийн сурагчдад зориулсан Access хөтөлбөрт нийтдээ 20 сурагч хамрагдаж улмаар Батламжаа гардан авч эцэг эхийн төлөөлөл хүүхдүүдийнхээ юу сурч мэдэж байгаа талаар мэдээлэл хийж багш нарын танилцуулга хичээлийн хуваарь ирцийн талаар мэдээллээ. Энэ үеэр телевизийн бичлэг хийлгэж сурагчид болон эцэг эхчүүдийн сэтгэгдлийг сонслоо.

УЛААНБААТАР ХОТЫН БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЛИЙН ТӨВТЭЙ SKYPE УУЛЗАЛТАНД ОРОЛЦЛОО



Захирал Эрдэнэтуяа, багш Жереми бид БЗМТ-н ажилчид Саямаа Гантөмөр нартай дүрсээ харж харилцан ажлаа тайлагнаж, цаашдын ажлын талаар ярилцаж санал бодлоо солилцлоо.

Америкийн элчин сайдын яамны ажилтнууд 2014 оны 11-нээс13 ны хооронд Америкийн соёл мэдээллийн төвд ирж ажиллалаа. Энэ үеэр АНУ-ын Бээжин дэх

төлөөлөгч Peg Walter олон нийтэд “Макдональдс болон Америкийн Нийтийн номын сангуудын харьцуулалт” сэдвээр лекц уншиж нийтдээ 78 хүн оролцлоо. Лекцийн дараа хүмүүс асуулт тавьж асуултанд Олон нийттэй харилцах албаны дарга Alyson Algeo хариулж тэдний санал сэтгэгдэлийг сонслоо.
Ерөнхий боловсролын сургуулийн 10-11-р ангийн сурагчдад “Цагийн менежмент” “Жендер” сэдвээр сургалт явуулж сургалтанд цагаа хэрхэн зөв зохистой өнгөрүүлэх, цагийн хуваарь хэрхэн хөтлөх талаар слайдаар хичээл зааж англи монгол хэл дээр орчуулан танилцуулав. Цагийн менежмент сургалтын дараа хүүхэд бүр 7 хоногийн хуваарь гаргаж өгөв. /2014. 05.13, 05,14/

АНУ ЭСЯ наас зохион байгуулж буй Англи хэлний багш нарын 2 өдрийн сургалтыг амжилттай зохион явууллаа.

АНУ ЭСЯ наас зохион байгуулж буй “Summer camp” англи хэлний сургалт 30 хүүхдийг 8 өдрийн сургалтанд хамрууллаа.

Насанд хүрэгчдэд зориулж англи хэлний “Mongolish night” хөтөлбөрийг зохион байгуулав. Уг хөтөлбөрийг Энхтайвны корпусын сайн дурын ажилтан Mishel Reneeтэй хамтран зохион байгуулж олон нийтийг өргөнөөр хамруулж байна. Энэхүү клубт Аймгийн захиргааны ажилчид, Ховд Их сургуулийн багш нар байгуулагуудын удирдах ажилтнууд сурагч багш нар оролцов. Уг ярианы клубаар хүмүүсийн ярих, сонсох чадварыг сайжруулах, Америкийн төвийн үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилготой.

“Угийн бичиг хэрхэн хөтлөх тухай“ сургалтыг аймгийн Прокурор болон аймгийн давж заалдах 6-р шүүх, сум дундын шүүх, Онцгой байдлын алба, Цагдаагийн газар, Цаг уур орчний шинжилгээний газар, Газар хөдлөлийг бүртгэх ховд станц, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, 2, 3, 4, 5-р цэцэрлэг Политехник коллежи зэрэг 18 байгууллагуудаар хийж 453 хүн хамрагдлаа. Сургалтаас гадна номын сангийн үйлчилгээний мэдээлэл сурталчилгаа явууллаа.

Шүүхийн Шийдвэрийг гүйцэтгэх газар дээр очиж 56 хүнд мэдээлэл өгч Америкийн төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, танилцуулах материал тараав. Насанд хүрэгсэдийн уншлагын танхим, гэрээр ном олгох тасгийн номын санч нартай хамтран Угийн бичиг хөтлөлтийн сургалтыг зохион байгууллаа. Мөн энэ үеэр тус байгууллагад 500,000 төгрөгийн номыг номын санд хандивлав.

Хүнс хөдөө аж ахуйн газарт зохион байгуулж шинэ номын үзэсгэлэн гаргаж байгууллага тасаг танхимуудаа суртчилаж ажиллаа.Үүнд 22 ажилтан хамрагдлаа.

Мөн политехник коллеж дээр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж архи тамхи хорт зуршилын талаар нээлттэй хэлэцүүлэг хийж мэдээлэл хийлээ.
Идэвхтэн уншигч хүүхдүүдийн байраар орж танилцлаа.

Прогресс сургуулийн 11 а ангийн сурагч Билгүүнтөгс USAP тэтгэлэгт хөтөлбөрт өргөдөл гаргаж эхний шалгаруулалтандаа тэнцэж тухайн хүүхдээс Toefl–н шалгалтыг амжилттай авч материалыг Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн ажилтан Ариунаа руу электрон шуудангаар явууллаа.

4-р сарын 9, 10 нд Зүүн Өмнөд Азийн бүсийн зохицулагч Кристина Чандлер болон Улаанбаатар хотын Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн захирал Д.Саямаа нар тус төв дээр 2 хоногийн турш ажиллалаа. Ирсэн гол зорилго нь Америкийн боловсролын талар ард игэд оюутан сурагчдад мэдээлэл хийх, Америкийн төвийн үйл ажиллагаатай танилцав. “Америкийн боловсрол” сэдвээр Ховд их сургуулийн 450 багш оюутан, Политехникийн Их сургуулийн 210 сурагчид, Уншлагын их танхимд 120 гаруй хүнд лекц хийж, тараах материал тараав. Энэ үеэр мөн Америкийн мэдээллийн үйл ажилагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ.

Ховд аймагт авилгатай тэмцэх байгууллагаас аймгийн хэмжээнд үйл жиллагаа явуулж буй байгууллага Агентлагуудын ажилчидад сургалт зохион байгуулж Ахлах номын санч Д.Саранцэцэгтэй сургалтанд хамрагдлаа.

“ХУУЛЬ ДҮРЭМ БОДИТ АМЬДРАЛД-2” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Хууль дүрэм бодит амьдралд-2” аяны хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Аяны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сургалтуудыг амжилттай зохион байгууллаа. Мөн тасаг танхимуудаар дамжуулан уншигч үйлчлүүлэгчдэд Эрүүл мэндийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулиудаар сургалт

зохион байгуулж мэдээлэл байршуулсан. Энэ үеэр УИХ-ын гишүүн ССАЖЯ-ны сайд ирж уг арга хэмжээг сайшаан дүгнэсэн.

Явагдсан сургалтуудын үр дүнг хэрэгжүүлэх, ойлголтыг нэгтгэх үүднээс бага хэмжээний шалгалтыг авахаар төлөвлөөд байна. Бид сургалт явуулахдаа өөрийн нөөц бололцоог ашиглаад зогсохгүй мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтнүүдийг урьж харилцан ярилцаж мэдээлэл солилцож байгаа нь илүү ач холбогдолтой байлаа. Мөн тагнуулын газар, Цагдаагийн газартай хамтран сургалт хийв.

“МУ-ын Үндсэн хуулийн сургалт”   “Хүний эрхийн тухай ойлголт”-ын Сургалт





Тагнуулын газраас зохион байгуулж буй “Террорист халдлагаас сэргийлэх” сургалтанд Музей, Номын сангийн ажилчид хамрагдаж мөн Аймгийн цагдаагийн газрын хошууч н.Оюунсүрэн байгуулага нийтээрээ хулгайд эд зүйлсээ алдахаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийлээ. Нийтдээ 32 хүн уг сургалтанд хамрагдав.

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай ойлголт”

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2013 оны А/106 дугаар захирамжийн дагуу “Гамшгийн аюулын зарлан мэдээлэх дохио”-ны арга хэмжээнд хамт олноо зохион байгуулан 2014 оны 03-р

сарын 27-ны өдрийн Пүрэв гарагт нийт ажилтан албан хаагчид тус өдрийн 15^{00} цагт Ард-Аюушийн талбайд бүрэн цугларч, үйл ажиллагаанд идэвхитэй оролцлоо.



Өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу холбогдох зүйлсийн жагсаалтын дагуу бэлтгэлээ бүрэн хангасан. Дотоод хяналтыг сайжруулахын тулд арга зүйч Д.Саранцэцэгт үүрэг чиглэл өгч холбогдох бичиг баримт, бүртгэлийн хуудсыг бүрдүүлэн, захирал байгууллагын тамга тэмдэг, гэрчилгээг авч оролцлоо.

“Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль” сургалт мэдээлэл

Авлигтай тэмцэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаарх сургалтын Аймгийн Хууль Зүйн Хэлтэсийн мэргэжилтэн Л.Оюунцэцэгтэй хамтран зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл авч хамтран ажиллав. Мөн түүнчлэн үйлчлүүлэгч, уншигчдад зориулан

“Нэг хууль нэг сар” аяныг зохион байгуулж хууль сурталчилах ажлыг зохион байгуулав.

БУСАД:

Зэрэг, Дарви, Манхан, Буянт, Мянгад, Дөргөн, Мөст, Цэцэг сумдын Номын сангийн үйл ажиллагаатай5,7 дугаар саруудад танилцаж үнэлэлт,зөвлөгөө өглөө.

2014 оны 11 сард Бүх сумдын соёл төвд хийгдсэн групп шалгалтаар номын сангийн дотоод үйл ажиллагаа болон монбиблио програмд оруулж байгаа номнуудын тоо, нөхцөл байдалтай танилцаж үнэлэлт, дүгнэлт өглөө.

СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН НОМЫН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛЭВ

Нэг: Байр эзэлсэн байдал:

Д/д	Сумын нэр	Монбиблиод Орсон ном	Монбиблио байр Эзэлсэн байдал	100 оноогоор дүгнэхэд байр эзэлсэн байдал	Үнэлгээ Байр
1	Àëòàé	0	14	77	9

2	Áóëãàí	150	12	46	13
3	Áóÿí ò	1253	7	78	8
4	Äàðâè	884	8	93	2
5	Äº ðãº í	1663	5	82	5
6	Äóóò	0	16	33	15
7	Çýðýã	2700	2	91	3
8	Ì àí õàí	180	15	63	12
9	Ì º ñò	800	9	80	6
10	Ì º í õõàéðõàí	2700	3	90	4
11	Ì ÿí ãàä	1500	6		
12	Öýöýã	306	10	66	10
13	×àí äì àí ü	1800	4	64	11
14	Õî âä	208	11	44	14
15	¯åí ÷	0	13	79	7
16	Ýðäýí ýá¿ðýí	4739	1	97	1

Ном хадгалалт, хамгаалалтын стандартын дагуу мэрэгч амьтад болон хортон шавьжний эсрэг хорыг цацаж ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийв.



Ажилчдын гэр бүлийн дунд спортын 3 төрлийн тэмцээнийг бооцоотой зохион байгуулан явуулж медаль мөнгөн шагналаар шагналаа

✓ 2014 оны 04 сарын 21-нээс 26ны өдрүүдэд Улаанбаатар хот явж номын сангуудын дунд зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд амжилттай оролцож мөнгөн медаль хүртлээ.

✓ Байгууллагын ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх үүднээс Монгол бичгийн сургалтыг бие даан зохион байгуулж байна.





2014 ОНЫ ШИЛДЭГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА:

Оны төгсгөлд шилдэгүүдээ шалгаруулдаг уламжлалтай. Манай байгууллага өөрийн тасаг танхим бүрийн шилдэгүүдээ шалгаруулсан талаарх мэдээллийг хүргэж байна.

Уншлагын их танхим:
Шилдэг менежер: 3-р сургуулийн Энхтүвшин
Шилдэг номын санч: 2-р сургуулийн номын санч Наранжаргал
Шилдэг анги:
1. 6-р сургууль 7а анги
2. 1-р сургуулийн 7в анги
3. 3-р сургуулийн 11б анги
4. 2-р сургууль 8а анги

Хүүхдийн номын өргөө:
Тэргүүний сургууль: Гантөмөр захиралтай 6 дугаар сургууль,
Шилдэг менежер: 6 сургуулийн багын менежер Мөнхдалай
Тэргүүний уншигч хамт олон: Цаст-Алтай 5б Э.Эрдэнэ-оюун, 6-р сургууль Мерзэдхан 5б, 1-р сургууль 4г Маасүрэн, 2-р сургууль 5г Цэцэгсүрэн,

Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхим:
Шилдэг тэргүүний хамт олон:Политехник коллежийн Отгон багштай 2 дугаар байр.
Шилдэг уншигч:
1. ХИС-МХУЗ-2 дугаар курсын оюутан Г.Өсөхжаргал
2. Политехникийн Малын бага эмчийн 3 дугаар курсын оюутан Б.Бурмаа.

Тэргүүний уншигч:

1. ХИС Түүхийн 3 дугаар курс З.Байгальмаа
2. ХИС Бизнесийн удирдлагын 1-р курс Усны-эх

Шилдэг Номын санч: Политехник коллежийн Номын санч Эрдэнэчимэг
Шилдэг багш: Политехник коллежийн 2 дугаар байрны багш Отгон.

Гэрээр ном олгох тасаг:Хамгийн олон уншигчтай шилдэг байгууллагыг шалгаруулан цом мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Америкийн мэдээллийн төв:
Шилдэг идэвхтэн багш: БСГ-ын мэргэжилтэн Hezil
Шилдэг идэвхтэн багш: 3-р сургуулийн багш Цэрэнлхам
Тэргүүний уншигч: Прогресс сургуулийн 9б ангийн сурагч Б.Дэлгэрмаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. Уншлага үйлчилгээний талаар

Гурван уншлагын танхим 9-20 цагийн хооронд 2 ээлжээр ажиллан 6277 уншигчийг номын сангийн уншигчаар шинээр бүртгэж, 39656 ирэгсдэд 59972 ш ном хэвлэл олгож, интернэт уншлага үйлчилгээг 950 уншигчдад хүргэжээ. Энэ нь уншигч, ирэгсэд, ном олголтын төлөвлөгөөт ажлыг 101,5-104,2%-иар биелүүлсэн нь өнгөрсөн оны биелэлтээс ирэгсэд 633-аар, ном олголт 140 номоор, интернэт үйлчилгээ 150 хүнээр илүү буюу нийт 0,2-19%-иар өссөн байна.

ХОЁР. Фонд баяжилт, фондын ажил

Уншигчдын хэрэгцээ шаардлага, татгалзлын дэвтэрт бүртгэгдсэн захиалгын дагуу 788 ном хэвлэлийн захиалга хийж өгөгдсөн төсвийн дагуу 6405598 төгрөгийн 524 ш ном хэвлэл, хандив тусламжаар 1587000 төгрөгийн 183 ш ном тохимол авлаа. Нийт 7992598 төгрөгийн 707 ш ном хэвлэлээр фонд баяжилт хийлээ.

Шинэ ирсэн номуудыг дагалдах баримтын хамт хүлээн авч номын сангийн фонд уншлагын танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд гаргалаа.

Уншлаганд гаргасан, шинээр авсан, электрон каталогт оруулсан, захиалгаар гаргасан зэрэг 74641 ш ном хэвлэлийг төрөл ангийн байрлалтаар ойрын фондын болон үндсэн фондын номын тавиурт байрлуулсан.

Уншлагын танхимуудын захиалгаар 1745 ш ном хэвлэл фондоос гаргаж, захиалгаар гаргасан 1813 ш ном хэвлэлийн ашиглалтыг шалгаж буцаан авч байрлуулав.

Ахуйн чийгшүүлэгч болон савтай ус ашиглан фондын өрөөний агаарын чийгшлийн хэмжээг хэвийн байлгах талаас нь анхаарч өдөр бүр чийгшил дулааны тэмдэглэгээ хийж байна.

Сумдын номын сангуудад хуваарилагдан ирсэн “Шилдэг ном 2013”, “Амеркийн Монгол Судлалын Төв”-өөс олгогдсон номуудыг дагалдах баримттай нь тулган хүлээн авч нийт 1293 ширхэг, 7752380 төгрөгийн номыг 23 сумдад хуваарилан баримт бичгийн хамт хүлээлгэн өгч тооцоо хийв.

Ойрын ба үндсэн фондын урагдаж гэмтсэн нийт 131 ш ном хэвлэлд засан сэлбэх ажил хийж номын эдэлгээг уртасгав.

ГУРАВ. Ном хэвлэлд хийх техник ажиллагаа

Эхний хагас жилд 4000 ном ангилахаар төлөвлөж 4004 ном төрөлжүүлэн ангилав.
707 ном данслаж номонд дансны дугаар, тамга тэмдэг тавьж, формулярын уут наах, формуляр бөглөх, бар код хэвлэх, наах зэрэг техник ажиллагаануудыг хийж гүйцээв.

ДӨРӨВ. Каталог зохион байгуулалтын ажил

Электрон каталогийн санд 9010 ш ном хэвлэлийн бүтээгдэхүүн оруулахаар төлөвлөснийг 9064 ш ном оруулж 100,5 %-аар биелүүллээ.
Мэдээллийн электрон каталогийн санд орсон номуудаас /ангилал, түлхүүр үг, гарчиг, товч агуулгад/ 3015 номыг нэг бүрчлэн тулгалт хийж алдааг засаж орхигдсон мэдээллүүдийг нэмж оруулан баазыг цоожлохоор төлөвлөж 5983 ш номонд редактор хийж 790 нэрийн 1511 номын ангилалд засвар хийв.
Үсэг дарааллын каталогт байрлуулах 3325 ш картыг хэвлэн гаргаж, зүсэж, ялган үсэг дараалалын каталогт байрлуулав. Үсэг дарааллын каталогт 2 удаа редактор хийж байрлалын алдааг засав.
625 ш номын хавтасны зургийг скайнердаж каталогт оруулаа.

ТАВ. Мэдээлэл сурталчилгаа соёл олон нийтийн ажил

Цаг үеийн үйл явдал, тэмдэглэлт, түүхэн үйл явдал, номын санд шинээр ирж байгаа ном хэвлэл, номын сангийн фондонд хадгалагдаж байгаа ном хэвлэлийг нийтэд сурталчлан мэдээлэх, уншигчдыг бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах, номын сангийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн тулд СОНА-ыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж байна.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

35 сэдвээр 54 удаа 1786 ш номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргав.

№	Үзэсгэлэнгийн сэдэв	Хугацаа	Номын тоо
1	Хамгийн олон удаа уншигдсан номууд	4/I	17
2	Жанжин Д.Сүхбаатар	24/I	75
3	Монголын уламжлалт цагаан сар	27/I	38
4	Хөвсгөлийн ястангууд /Халх/	2/II	45
5	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт	3/III	97
6	Монгол цэргийн өдөрт	15/III	83
7	Хүүхдийн зохиолчид /намтар уран бүтээл/		41
8	Дэлхийн усны өдөр	22/III	36
9	“Пунцагийн Бадарч” уран бүтээлийн үзэсгэлэн	3р сард	11
10	Дэлхийн эрүүл мэндийн өдөрт	1/IV	90
11	Дэлхийн номын өдөр	23/IV	300
12	Үндэсний бичиг үсгийн баяр	5р сар	92
13	Мэргэжил сонголт	5р сар	25
14	Хүүхдийн эрхийн өдөр	1/VI	108
15	Хүрээлэн байгаа орчныг хамгаалах дэлхий өдөрт	5/VI	28
16	Мод тарьж сурцгаая	5р сар	17
17	Олон улсын хүүхдийн номын өдөр	4р сар	149
18	Дөнгөтийн Цоодолын намтар, уран бүтээлээс	5р сар	36
19	Ардын уран зохиолч Шагдарын Дулмаагийн уран бүтээлээс	6р сар	17
20	Монголчуудын баяр наадам	04/VII	12
21	Хичээлийн шинэ жилд	30/VIII	47
22	Цэгмидийн Гайтавын уран бүтээлээс	25/VIII	35
23	Монголчуудын цайны соёл	24/VII	14
24	Дэлхийн сонгодог зохиолууд /Монгол орчуулгын анхны хэвлэл/	9р сар	51
25	Монгол ардын аман зохиолоос	9р сар	17
26	Хөвсгөл нутгийнхан	10р сар	31
27	Хөвсгөлийн халх ястны аж ахуй	03/X	32
28	Ш.Гаадамбын намтар уран бүтээлээс	27/X	34
29		05/XI	
30	Хүүхдийн номын үзэсгэлэн	18/XI	60
31	Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн намтар уран бүтээлээс	10, 11-р сар	35
32	Монгол бахархлын өдөрт	14/XI	12
33	Монгол улс тунхагласны өдөрт	26/XI	35
34	Ардын уран зохиолч С.Эрдэнийн мэндэлсний 85 жилийн ойд	02/XII	25

35	Хүний эрх-Миний эрх	10/XII	41

Шинэ номын үзэсгэлэн

Шинэ номын үзэсгэлэнг 21 удаа 482 ш номоор гаргаж шинэ номын сурталчилгаа хийв.

№	Гаргасан үзэсгэлэн	Хугацаа	Номын тоо
1	Шинэ номын үзэсгэлэн /Нийтийн уншлагын танхим/	7/I	38
2	Шинэ ном /Үндсэн фондоос/	8/II	72
3	Шинэ номын үзэсгэлэн /Хүүхдийн уншлагын танхимаас/	2р сар	23
4	Шинэ номын үзэсгэлэн /Хүүхдийн уншлагын танхим/	3р сар	12
5	Шинэ номын үзэсгэлэн /Хүүхдийн уншлагын танхим/	4р сар	19
6	Шинэ номын үзэсгэлэн /Гэрээр ном олгох танхимаас/	1р сар	18
7	Шинэ номын үзэсгэлэн /Гэрээр ном олгох танхимаас/		20
8	Шинэ номын үзэсгэлэн /Нийтийн уншлагын танхим/	14/IV	48
9	Шинэ номын үзэсгэлэн /Үндсэн фондоос/	13/VI	66
10	Шинэ номын үзэсгэлэн /Нийтийн уншлагын танхим/	18/IV	48
11	Шинэ номын үзэсгэлэн /Нийтийн уншлагын танхим/	25/VI	48
12	Шинэ номын үзэсгэлэн /Үндсэн фондоос/	10/IX	56
13	Шинэ номын үзэсгэлэн /нийтийн уншлагын танхим/	30/VIII	42
14	Шинэ номын үзэсгэлэн /Хүүхдийн уншлагын танхим/	9-р сар	40
15	Шинэ номын үзэсгэлэн /Хүүхдийн уншлагын танхим/	9р сар	110
16	Шинэ номын үзэсгэлэн /Нийтийн уншлагын танхим/	24/XI	100
17	Шинэ номын үзэсгэлэн /Нийтийн уншлагын танхим/	02/XII	36
18	Шинэ номын үзэсгэлэн /Гэрээр ном олгох танхимаас/	10р сар	22
19	Шинэ номын үзэсгэлэн /Гэрээр ном олгох танхимаас/	11р сар	24
21	Шинэ номын үзэсгэлэн /Гэрээр ном олгох танхимаас/	12р сар	24

Олон улсын хүүхдийн номын өдөр. Жил бүрийн 4-р сарын 2-нд Олон улсын Хүүхдийн номын өдрийг тэмдэглэдэг. Уг өдрийг тохиолдуулан аймгийн нийтийн номын сангаас хүүхдийн номын үзэсгэлэн, номын тойм яриа, чанга уншлага, танин мэдэхүйн АХА тэмцээн, үлгэрийн сэдэвт хүүхэлдэйн тоглолт зэрэг ажлуудыг зохион байгуулав.

Тус номын сангийн ойрын болон үндсэн фонд байгаа хүүхдийн зохиолуудаар үзэсгэлэн гаргав. Үзэсгэлэнг орон орны зохиолчдын 149 ширхэг номоор бүрдүүлэв.

Х.К.Андерсений үлгэрүүдийг сурталчлах уншигчдад агуулга, үзэл санааг нь ойлгуулах зорилгоор “Нугасны муухай дэгдээхий”, “Зэрлэг хунгууд”, “Тэвнэ”, “Замын хань”, “Балжингарма”, “Эрэлхэг тугалган цэрэг”, “Чүдэнзтэй охин” гэсэн үлгэрүүдээр тойм яриа хийж, “Нугасны муухай дэгдээхий” үлгэрээр чанга уншлага хийв.

“Дуслыг хураавал далай, дуулсныг хураавал эрдэм” уриан дор бага, дунд ангийнханы насны ангилал тус бүрээр АХА тэмцээн явуулав. Бага ангийнханы АХА тэмцээнд ДМЦС-ийн 4а ангийн сурагч Ч.Батхүү, дунд ангийнханы АХА тэмцээнд ДМЦС-ийн 6г ангийн сурагч О.Буянчуулган нар тэргүүлэв.

Бага дунд ангийн сурагчдыг уншлагын соёлд сургах, ном хэвлэл унших сонирхол таашаал төрүүлэх, уншсан зүйлээ ухамсартайгаар үнэлж сурах, авьяас чадварыг нээн илрүүлэх зорилгоор явуулсан “Өнхрүүшхэн” үлгэрээр сэдэвлэн хуруун хүүхэлдэйн жүжигчилсэн тоглолт хийв. Уг хүүхэлдэйн жүжигт өнхрүүш, чоно, үнэг, өвгөн, эмгэн, баавгай, туулай гэсэн долоон дүр тус бүрд 1-7р ангийн сурагчид тоглов. Энэхүү хүүхэлдэйн жүжигчилсэн тоглолтыг Аймгийн хүүхдийн ордны жүжгийн дугуйлангийн багш н.Даваацэрэн удирдан явуулав.

Зохиолч Юмино Шихогийн “Цаасан шувууны аялал” буюу Садакогийн залбирал хэмээх номын орчуулагч М.Сарангэрэлийг урьж уулзалт зохион байгууллаа.

Уулзалтанд 40 гаруй хүүхэд оролцсон бөгөөд хүүхдүүдэд “Цаасан шувууны аялал” номоор чанга уншлага зохион байгуулж, номын тухай харилцан ярилцав.

Мөн орчуулагч М.Сарангэрэл хүүхдүүдэд номын тухай, Япон улсын хүүхдүүдийн чөлөөт цаг, сурч боловсордог арга барилын тухай ярьж зөвлөгөө өгөв. Уншигчдын “яагаад заавал энэ номыг сонгон орчуулах болсон бэ?” гэсэн асуултанд орчуулагч гүн гүнзгий хариулт өгсөн бөгөөд энэ нь хүүхдүүдийг өөрсдийгөө бага гэлтгүй санал бодлоо илэрхийлж, нийгмийн оролцоо, идэвхээ сайжруулж, өөрсдийн ирээдүйн талаар “тэмцэж” байх ёстой гэдгийг ойлгуулав.

Уулзалтанд оролцож буй орчуулагчийн зүгээс уншигчдын дунд асуулт тавьж “Азтай уншигч”-ийг шалгаруулсан бөгөөд өөрийн энэхүү номоо гарын үсэг, талархлын үгтэйгээр дурсгав.
“Азтай уншигч”-аар ДМЦСургуулийн $6^{г}$ ангийн сурагч н.Хатантуул тодорсон.
Мөн энэ үеэр тус хүүхдийн танхимд “Цаасан шувууны аялал” хэмээх 6 ш номоо бэлэглэв.
Олон улсын хүүхдийн номын өдрөөр насны ангилалаар АХА тэмцээн хоёр удаа явуулсан.

Дунд болон ахлах насны ангилалаар явагдсан АХА тэмцээний асуултыг “АХА” хэмээх номноос явуулав. Харин бага насны хүүхдүүдийн хувьд тэдний нас сэтгэхүйн онцлогт тохируулан асуулт болон хариултыг бэлтгэж зохион байгуулав.

Дэлхийн номын баяр. Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг Дэлхийн номын өдрийг тохиолдуулан аймгийн нийтийн номын сан 2013-2014 îíä фонд баяжилт õèéñýí шинэ номуудаар ¿çýñãýëýí ãàðãàæ нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулëàà.
Íèéò 800 ãàðóé íîì õýâëýëèéã äýëãýí ãàðãàæ óíøèã÷ õýðýãëýã÷äèéã íîìûí ñàí ãèéí ñàí õºìðºãò áàéãàà íîì õýâëýëòýé òàíèëöàõàä ýíý àæëûí çîðèëãî îðøèæ áàéëàà.

Дэлхийн номын баярын өдрийг тохиолдуулан аймгийн нийтийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимаас “Миний хайртай үлгэрийн баатар” гар зургийн болон оюуны зураглалын уралдааныг зарласан. Уг уралдаанд ЭДЦС-ийн 3б ангийнхан, Ирдээүй XI зуун цогцолбор сургуулийн 2б ангийнхан, ЭДЦС-ийн 5-р ангийнхан идэвхтэй оролцож нийт 70 гаруй бүтээл ирүүлсэн.

Уг өдрийг тус номын сангаас “Нээлттэй хаалганы өдөр” болгон зарласан бөгөөд энэ өдөр уншигчдын бүтээлийн үзэсгэлэн, 2013-2014 онд номын санд ирсэн

60 гаруй хүүхдийн зохиолуудаар үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлахын зэрэгцээ уг уралдаанд тэргүүлсэн хүүхдүүд, анги хамт олонд шагнал урамшил гардуулсан.

Уг уралдаанд оролцсон уншигч хүүхдүүд өөрсдийн уншсан “Өнхрүүш”, “Зүрхэн гүнж”, “Өнгө өнгийн цэцэг”, “Үнэг чоно хоёр”, “Хулан хэрээ, чоно гурав”, “Муур тахиа үнэг гурав”, “Наран хааны туяа гүнж”, “Өвгөн хүү хоёр”, “Нойрсож буй гүнж”, “Могжоохон даагатай жогжоохон хүү”, “Туулай”, “Үнсгэлжин”, “Муурын байшин”, “Ах дүү гурав”, “Тэмүүжин“, “Зөрүүд зантан”, “Тэнэг хүү”, “Мэргэн галуу ба тэнэг мэлхий”, “Жинхэнэ найзууд”, “Алмаазан титэм”, “Цагаан нил цэцэг”, “Баатар банхар хоёр”, “Өүжин дэлдэн хоёр”, “Хатагтай ба тэнүүлчин”, “Эгч дүү хоёр” , “Гурван баавгай”, “Азарган тахиа вандуйн үр”, “Долоон одой ба цасан гоо” зэрэг үлгэр, өгүүллэгүүдээсээ сэдэвлэн өөрсдийн хайртай, сэтгэлд хоногшсон зохиолын баатараа, мөн тухайн зохиолд анализ дүгнэлт хийн тухайн зохиолын үйл явдал, агуулга, сайн муу дүрийг оюуны зураглалаар гаргаж өгсөн байсан.

Мөн тус үйл ажиллагааны үеэр Ирээдүй сургуулийн багш О.Дулмаа сурагчид, эцэг эхчүүдтэйгээ хамтран боловсролын стандартын дагуу бүтээсэн “Долоон өндөгтэй шаазгай” хэмээх 4 хуудас бүхий том хэмжээний номоо хүүхдийн уншлагын танхимд бэлэглэсэн бөгөөд номынхоо утга учир, зорилго, ач холбогдлын талаар тайлбарлаж өгөв.

Мөн энэ үеэр тус танхимын уншигчдын эцэг эхчүүдийн төлөөлөл болох иргэн Б.Гантуяа өөрийн өвөө Гэндэнгийн Аюурсэдийн бичсэн “Өвчин яагаад эдгэдэггүй юм бэ?” Мөрөн, 2001 он, “Хөвсгөлийн цаа буга” Мөрөн, 1996 он, “Зүрхний яс эврийн шүтэлцээ” гэсэн нийт 81 ш номоор хандив өргөсөн.

Мөн “Шинэ ном” “Дэлхийн номын өдөр” “Шилдэг ном” мэдээллүүдийг гаргаж сурталчиëãàà õèéâ.
Í ýýëòòýé õààëãàí û àæëûí õ¿ðýýí ä óí øèã÷äûí äóí ä çóðãèéí óðàëäààí , ðî éì ÿðèà, ÷àí ãà óí ø ëàãà, ÀÕÀ òýì öýýí çýðýã ààæëóóäû ãçî õèî í ÿâóóëлаа.
Дэлхийн номын өдрийг тохиолдуулан уншигчдын дунд “Номыг хэн сайн уншдаг вэ?” АХА тэмцээнийг явууллаа. Танин мэдэхүйн АХА тэмцээнд 25 хүүхэд оролцсоноос 2-р сургуулийн 9^{б} ангийн сурагч Лхагвадаваагийн Баахүү тэргүүн байр эзэлсэн. Тэргүүн байранд орсон уншигчдад цэцэг, ном дурсгалын зүйл гардуулав. Энэ өдөр ирсэн 402 шинэ уншигчäàä карт нээæ¿éë÷ëýâ. Í èéò 800 гаруй õ¿í õàì ðàãäëàà. Î ðî í í óòãèéí õýâëýë ì ýäýýëëèéí õýðýãñë¿¿äýýð çàð ñóðòàë÷èëãàà áî ëî í ì ýäýý ì ýäýýëýë ÿâóóëëàà.

Үндэсний бичиг үсгийн өдөр. Жил бүрийн 5-р сарын 6-ны өдрийг “Үндэсний бичиг үсгийн өдөр” болгон тэмдэглэдэг бөгөөд уг өдрийг тохиолдуулан ННС-аас дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:
Үндэсний бичиг үсгийн түүх соёлоос сэдэвт үзэсгэлэн
/Уншлагын танхимууд болон үндсэн фондоос 96 ном бүхий 4 үзэсгэлэн/
Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг номын сантай танилцуулах аялалыг Мөрөн сумын 1-р цэцэрлэгийн багш Ж.Оюунцэцэг, Оюун-Эрдэнэ нартай хамтран зохион байгуулсан бөгөөд номын сангийн тухай, номын сангаар хэрхэн үйлчлүүлдэг, номын сангийн үүрэг, зорилго, ач холбогдлын талаар 10 минутын мэдээлэл хийв. Энэхүү үйл ажиллагаанд тус цэцэрлэгийн ахлах А, Б бүлгийн нийт 88 хүүхэд хамрагдсан бөгөөд тус цэцэрлэгийн хүүхдүүдэд уншигчийн карт нээж үйлчлэв.
Мөн тус цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдэд “Шоргоолж царцаа” хоёр монголын ардын үлгэрээр чанга уншлага явуулж, тус үлгэрээс ойлгосноо зургаар илэрхийлж харилцан ярилцав.

Мөн тус цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд тэдний нас сэтгэхүйн онцлогт тохируулан боловсруулсан асуултуудын дагуу АХА тэмцээн явуулсан. АХА тэмцээнд тус цэцэрлэгийн ахлах бүлгийн Б.Дөлгөөн, А.Тэмүүжин нар идэвхтэй оролцсон.
Бага ангийнхны дунд зарласан С.Дуламын "Хүмүүн бичиг" шүлгийг хэн уран яруу унших вэ? уралдаанд нийт 5 хүүхэд оролцсон бөгөөд хүүхдүүд шүлгээ уншиж, уг шүлгэнд юуны тухай өгүүлсэн тухай ярилцав. Энэ уралдаан Ирээдүй 21-р зуун цогцолбор сургуулийн 2б ангийн сурагч Х.Пүрэвбаяр тэргүүлэв.
Бага дунд ангийнхны дунд ардын аман зохиолоос суралцах зорилгоор явуулсан "Хэн хамгийн олон оньсого таах вэ?", "Зүйр цэцэн үгийн утгыг хэн оновчтой зөв тайлбарлах вэ?" гэсэн тэмцээнүүдэд нийт 32 хүүхэд оролцсон бөгөөд авхаалжтай байж, хамгийн олон оньсого тааж, зүйр цэцэн үгсийн утгыг хамгийн оновчтой тайлбарлаж, хамгийн олон үсэг цуглуулсан уншигчаар 2-р сургуулийн 6а ангийн сурагч Б.Маналсүрэн, 2-рсургуулийн 6а ангийн сурагч Б.Оюунжаргал нар шалгарч

урамшуулал олгов.ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад зориулан явуулдаг ажил, мэргэжлийн тухай "Амьдралын анхны гишгүүр" уламжлалт сэдэвт ажлаар Нийтийн номын сангаас Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэстэй хамтран Ахлах ангийн сурагчдын дунд мэргэжил сонголт сэдвүүдээр лекц зохион байгууллаа.

Үнэхүү лекцэнд Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэсийн дарга Ч. Дашбаяр, Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Х. Рагчаа Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эмч н. Уранчимэг нар уригдан оролцож номын сангийн уншигч хүүхдүүдэд "Хүүхэд нэг бүрийн үүрэг, оролцоог дэмжих нь", "Алсын хараа" сэдэвт лекц уншёàà.
Ѓг лекцèéã Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн зааланд зохион явууллаа. Òóñ ¿éë àæèëëàãààí ä í èéò 72 óí ø èã÷ õ¿¿õä¿¿ä õàì ðàãààæ Ñî í èðõîî í àñóóëòàí äàà õàðèóëò àâëàà.



МУСГЗ зохиолч Д.Сүрэнжавын уран бүтээлийн үзэсгэлэн

Аймгийн Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсээс Хүрэл тулга яруу найргын наадмыг Хөвсгөл аймгийн харьяат МУСГЗ Д. Сүрэнжав найрагчийн нэрэмжит болгон явуулж байгаа тус наадамд зориулж аймгийн номын сангаас МУСГЗ Д.Сүрэнжав зохиолчийн намтар уран бүтээлээр сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж уншигчдад танилцуулав.

Үзэсгэлэнгийн нээлтэнд Аймгийн хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн дарга Ч.Дашбаяр Аймгийн нийтийн номын сангийн захирал Н. Оюунтуяа, Хүрэл тулга наадамд оролцогч хүүхдүүд, уншигчид, номын санч нар оролцлоо.

Үзэсгэлэнгийн нээлтэнд оролцогчдод номын сангийн уншигч нараас Д.Сүрэнжав зохиолчийн "Хөвсгөл" найраглалыг уншиж сонирхуулсан.

"МОНГОЛ БӨХ" НОМЫН НЭЭЛТ

Номын сан зохиолч уран бүтээлчидтэй хамтран, тэдний шинэ номын баяр, номын нээлтийг хийдэг билээ. Энэ жил хувцас зохион бүтээгч, судлаач Б.Цогзолмаа багштай хамтран "Монгол бөх" номын нээлт, зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгуулав. Энэ уулзалтанд аймгийн удирдлагууд, бөх сонирхогч иргэд, аймгийн зохиолч сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, бөхийн холбоо, бөхчүүд, уншигчид оролцлоо.

Уулзалтанд оролцогчид “Монгол бөх судлал”-ын талаар өөр өөрсдийн санаа бодлоо хуваалцаж ярилцлаа. Бөх сонирхогчид бөхчүүд сонин содон дурсамжуудаа ярьж сонирхуулав.

Энэ үер судлаач Б. Цогзолмаа багш өөрийн судалсан “монгол бөх” хөвсгөлын бренд эрдэм судлалын тайламжаа тавьсан.

ХДТ дуучид хөгжимчид ая дуугаа өргөв.

“ХИШИГ ӨДӨР”. Аймгийн нийтийн номын сангаас Монголын зохиолчдын эвлэлийн хөвсгөл аймаг дахь салбартай хамтран “Хишиг өдөр”-ийг зохион явууллаа. Энэ ажилд МЗЭ-ийн шагналт зохиолч Б.Бат-Эрдэнэ, зохиолч Ц.Ганболд, зохиолч сэтгүүлч Ш.Хатанбүүвэйбаатар нар оролцож номын сангийн уншлагын танхимуудад нэг өдөр ажиллан уншигчдад үйлчлэв. Энэ өдөр Аймгийн нийтийн номын сангаас МЗЭ-ийн салбартай хамтарч “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгууллаа.



Уулзалтанд “Хишиг өдөр”-т оролцож байгаа уран бүтээлчид, мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн зохиол яруу найрагт сонирхолтой нийт 60 гаруй номын сангийн уншигчид хамрагдсан. Энэ уулзалтаар аймгийн нийтийн номын сан тэргүүний уншигч хүүхдүүдээ тодруулж “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шагнал гардууллаа. Нийт энэ

хагас жилээр 12 сурагч “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” боллоо.

“Номын баяр”

Номын баяр тэмдэглэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 сарын 24 – ны өдрийн 158-р зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу номын баяр, ном унших уламжлалт 2 сарын аяны нээлтийн үйл ажиллагааг хийлээ. Энэ удаагийн аяныг “Хамтдаа уншья” сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

Уламжлалт зан заншлаа хөгжүүлж, ард иргэд, хүүхэд залуусын ном эрдэмд шамдан нөхөрлөх хандлагыг улам бүр дэмжих, тэргүүний уншигчдыг шалгаруулах тэдний оюуны хөдөлмөрийг дэмжих урамшуулах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготойгоор номын сангаас төрөл бүрийн СОНА-ыг зохион байгуулахаар төлөвлөлөө.

Номын баярын нээлтийг Аймгийн нийтийн номын сан уншигч, ирэгсэдийнхээ дунд 2014 оны 09 сарын 24 өдөр зохион байгуулж аяныхаа хүрээнд хийгдэх ажиллуудаа танилцууллав. Энэхүү аяны нээлтийн үйл ажиллагаанд урилгаар Аймгийн ЗДТГ-ын НХХ-ийн соёл хариуцсан мэргэжилтэн Нарангэрэл, Аймгийн

ССАЖГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн Л.Батцэцэг, Аймгийн ХГБХХ-ын мэргэжилтэн Санжсүрэн, болон аймгийн нийтийн номын сангийн нийт номын санчид оролцлоо.

Тус аяны нээлтэнд урилгаар ирсэн удирдах байгууллагын хүмүүс тус аянд амжилт хүсэж мэндчилгээ дэвшүүлж, Авьяас 8 сургууль, Далай ван сургууль, Гавъяат багш Батсуурийн нэрэмжит Мөрөн 2-р сургуулийн авьяаслаг сурагчид ая дуугаа өргөж мэндчилгээ дэвшүүлэв.

Энэ өдөр аймгийн нийтийн номын сангаас хүүхдийн уншлагын танхимд “Дэлхийн сонгодгууд монголд анх удаа” номын үзэсгэлэн, 2014 онд ирсэн шинэ номоор “Шинэ ном” үзэсгэлэнг нийт 135 ш номуудаар гаргаж, чөлөөт уншлага зохион байгууллаа. Мөн 200 гаруй шинээр ирэгсдийг номын сангийн уншигчаар бүртгэж нийт 620 гаруй хүнд номын сангийн үйлчилгээ үзүүлэв.

Ардын аман зохиол сурталчлах өдөрлөг. “Хамтдаа уншъя” аяны хүрээнд зохион байгуулсан Ардын аман зохиол сурталчлах өдөрлөгийг Хүүхдийн уншлагын танхим, эцэг эхчүүдтэй хамтран бага насныхны дунд зохион багууллаа.

Өдөрлөгийн үйл ажиллагаанд оролцсон эцэг эхчүүд номын тухай тойм яриа, чанга уншлага хийв.

“Ухаант туулай” монгол ардын үлгэрээр чанга уншлага эцэг эхийн төлөөлөл болох н.Очирхуяг хийсэн бөгөөд уншигчдаас 3-р ангийн сурагч У.Туяа, Д.Амаржаргал, У.Төгсбаяр нар уг үлгэрийг сонсоод юу ойлгосноо бусад хүүхдүүдэд ярьж өгөв.

2014 онд хүүхдийн уншлагын танхимд шинээр ирсэн номнуудаас “Чингис хаан” комик цуврал номыг сонгон авч тойм яриа хийв. Уг ном нь 13 цуврал бөгөөд цуврал тус бүрийг нэг хүүхэд сонгон авч энэхүү номонд юуны тухай өгүүлсэн болох талаар уншигчдад мэдээлэл хийв. Энэхүү тойм арианд 4-р ангийн сурагчдаас Б.Мягмардорж, Ч.Анхбаяр, Ц.Мөнхбат, 3-р ангийн сурагчдаас Г.Дагвадорж, Д.Болдхүү, Ц.Мөнх-Итгэл, Г.Золжаргал, 7-р ангийн сурагчдаас Г.Цэрэн-Очир, Б.Замилан, 6-р ангийн сурагчдаас М.Хишиг-Эрдэнэ, Г.Бодоръя нар оролцов.
Энэ үеэр Чингис хаан цувралыг бүгдийг уншсан хүүхдүүдийг тодруулж, товч агуулгыг нь ариулсан бөгөөд ЭДЦС-ийн 7в ангийн сурагч Э.Бямбадорж идэвхтэй оролцож, урамшуулал хүртэв.

Бага, дунд ангийнханы дунд “Цоорхой хувин” сургамжит өгүүллэгээр эцэг эхийн төлөөлөл н.Уранбаяртай хамтран чанга уншлага явуулав. Чанга уншлагын дараа уншигчид юу ойлгосноо харилцан ярилцахад 2-р сургуулийн 5в ангийн сурагч С.Халиунаа энэхүү өгүүллэгийн товч агуулга, гол санааг оновчтой илэрхийлж урамшуулал хүртэв.

Бага, дунд ангийнханы дунд тус уншлагын танхимд байгаа ардын аман зохиолын номуудаар тойм яриа хийв. Энэхүү тойм яриагаар ардын аман зохиол гэж юу болох, ардын аман зохиолын ямар ямар төрлүүд байдаг талаар ярилцаж, оролцогч хүүхэд тус бүр өөр өөрсдийн мэддэг оньсого, ерөөл, магтаал, зүйр цэцэн үгс, мэргэн үгсийг

хэлж харилцан ярилцав. Үүнд Ч.Анхбаяр, Ц.Мөнхбат, Н.Мичидмаа нар амжилттай оролцов.
Мөн дээрх сэдвийн хүрээнд хэвлэгдсэн тайлбар толиудыг хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгөв.
“Зарим зүйр цэцэн үгсийн тайлбар толь”, “Зүйр цэцэн үг”, “Монгол ардын оньсого”, “Монгол ардын ерөөл магтаал”, “Орчин үеийн аман зохиол”, “Монгол ардын үлгэр”, “Монгол ардын тууль”, “Монгол ардын домог”, “Монгол ардын дуу”, “Монгол домог”, “Ерөөл магтаалууд”, “Мэргэн ардын үг”, “Ажил хөдөлмөрийн тухай ардын цэцэн үгс” зэрэг 13 ширхэг номоор тойм яриа хийв.Хүүхдийн уншлагын заланд хамгийн сүүлд ирсэн 42 ширхэг шинэ номоор үзэсгэлэн гаргав.

Аймгийн Ахмадын асрамж үйлчилгээний
төвд зохион байгуулсан өдөрлөг.

Хөвсгөл аймгийн нийтийн номын сангаас зарласан “Хамтдаа уншья” аяны хүрээнд Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Аймгийн ахмадын асрамж үйлчилгээний төв дээр нэг өдрийг ном сурталчлах, тэдний нэг өдрийг үр ашигтай өнгөрөөх зорилготой Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн дэргэдэх драмын дугуйлантай хамтран өдөрлөг зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд тухайн байгууллагын үйлчлүүлэгч нарт нүүдлийн номын санг 7 хоногийн хугацаатай аялуулж тэндэх нийт үйлчлүүлэгч ажилчдад номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Мөн тус төвийн номын санд нь номын хандив өргөв.

Өдөрлөгөөр Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн дэргэдэх драмын дугуйлангийн сурагчдын урлагийн номерийг сонирхуулж, зохиолч сэтгүүлч Б.Бат-Эрдэнэтэй “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгуулж өөрийн орон нутгийнхаа уран бүтээлчийн амьдрал, уран бүтээлийг сурталчилан танилцууллаа. Тус

уулзалтаар номын дүр, ном хэрхэн бүтдэг, зохиол бичих болсон талаар зохиолч уншигчдын дунд харилцан ярилцав.

Тус төвийн үйлчлүүлэгч нарын хийсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гарган, нэг өдрийг хэрхэн өнгөрүүлдэг талаар харилцан ярилцаж сэтгэл санааг нь хуваалцаж сэтгэлийн дэм өгч цаашид хамтран ажиллах талаар ярилцлаа.

Хөгжөөнт тэмцээн. Хүүхдийн уншлагын танхимаас “Оньсого тааж оюун ухаанаа хөгжүүлье” уриан дор “Хэн олон оньсого таах вэ?” тэмцээн уншигчдын дунд явуулав. Энэхүү тэмцээнд 2-р сургуулийн Дашзэвэг ахлагчтай баг, ЭДЦС-ийн Тэгшзаяа ахлагчтай баг, Гурван-Эрдэнэ сургуулийн Оюумаа ахлагчтай багууд тус тус оролцсон бөгөөд нийт 15 хүүхэд хамрагдав. Тэмцээний үеэр урьдчилан сонгон авч бэлтгэсэн 20 оньсогоноос 7 оньсогыг сугалааны журмаар авч баг тус бүр уралдан таасан бөгөөд мөн багийн ахлагч нар, хөгжөөн дэмжигчдийн дунд мөн тэмцээн явуулав.

Энэхүү тэмцээнд хамгийн олон оньсого тааж нийт 4 үсэг цуглуулсанаар 2-р сургуулийн Дашзэвэг ахлагчтай баг тэргүүлж 5ш номын бүрдэл бүхий цуглуулга, өргөмжлөл гардан авав.

Хөгжөөн дэмжигчдийн дундах тэмцээнд ЭДЦС-ийн 4б ангийн сурагч П.Баасансүрэн тэргүүлж номоор урамшуулав.

“Хүүхдийн асуудлаар” хэлэлцүүлэг

“Хамтдаа уншъя” аяны хүрээнд зохион байгуулж буй “Хүүхдийн асуудлаар” хэлэлцүүлгийг 4 үе шаттай явуулах бөгөөд 1-р үе шат болох “Хүүхэд - Мэргэжилтэн” хэлэлцүүлгийг Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан.

Энэхүү хэлэлцүүлгийн гол зорилго нь хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг бүх түвшинд сонсож, тэдний язгуур эрх ашгийг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, багш, эцэг эхчүүдийн оролцооны түвшинг тогтоох, дээд удирдах байгууллагуудад хүргэж хүүхдийн асуудлыг үе шаттайгаар шийдэхэд чиглэгдэнэ.

Энэ хэлэлцүүлгээр Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтний төлөөлөл хүмүүс нийт Аймгийн Иргэдийн Хурлын ажлын албаны сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, Аймгийн ЗДТГ-ын НХХ-ын ахлах мэргэжилтэн ЭМГ-ын мэргэжилтэн, Хөдөлмөрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Боловсролын газрын мэргэжилтэн, ССАЖГ-ын мэргэжилтэн аймгийн цагдаагийн газрын хүүхдийн байцаагч, АХГБХХ-ын мэргэжилтэн нийт 8 мэргэжилтэн, Мөрөн сумын ЕБ-ын 10 сургуулийн нийт 26 хүүхэд оролцсон. Хэлэлцүүлгээр дараах асуудлуудыг хэлэлцэв.

1) “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд тухайн байгууллага хүүхдийн төлөө ямар ажил зохион байгуулсан.
2) Мэргэжилтний сурч байсан тухайн үеийн нийгмийн байдал буюу ямар хүүхэд байсан.
3) Хүчирхийлэл буюу хүчирхийлэлд хаана ямар нөхцөлд өртөж болзошгүй вэ?
4) Хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хаана хаана байж болох вэ?
5) Багш нарын харилцаа хандлага хүүхдэд хэрхэн нөлөөлөх вэ?

6) Мэргэжил сонголт
7) Хүүхдэд ээлгүй зүйл
8) Мэдлэгээсээ хоцорсон хүүхдийг яах вэ?
9) Сэтгэл зүйч хэрэгтэй юу?

Цаашдаа хамтарч ажиллах тал дээр хүүхдийн оролцооны мэргэжилтэнгүүд өөрсдийн санал бодлоо хуваалцлаа.

“АЛТАН ХОНХ” ТЭМЦЭЭН

Хөвсгөл аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулж байгаа **“Хамтдаа уншъя”** аяны хүрээнд танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг Хөвсгөл аймгийн залуучуудын холбоотой хамтран зохион явууллаа.

Уг ажлын зорилго нь уншигчдад орон нутгийнхаа түүх, соёл, уламжлалт зан заншлыг судлуулах, мэдүүлэх, мэдлэгийнх нь цар хүрээг нэмэгдүүлэх, номын сан уншигч 2-ын уялдаа холбоог бий болгох зорилгоор уншигчдынхаа оролцоон дээр тулгуурлан тэдний чөлөөт цагийг зөв өнгөрөөхөд орших байлаа.

“Алтан хонх” тэмцээний бэлтгэл ажлын хүрээнд “Хөвсгөл нутгийнхан”, “Орон нутгаа судалцгаая”, “Хөвсгөлийн халх ястан” сэдэвт номын үзэсгэлэнг 111 ш номоор

гаргаж нутаг орны түүх, соёл, зан заншил, уламжлал бусад холбогдох зүйлийн тухай мэдээллүүдийг бүрдүүлж сурталчилгаа хийв.
Удирдамж гаргаж Мөрөн сумын ЕБС-дад тарааж удирдамжаас лавлах, тодруулах, асуудлыг тухай бүрт нь бичгээр болон амаар тайлбарлаж таниулж байлаа.
Ивээн тэтгэгч байгууллага олж, хамтарч ажиллан Тэмцээнд түрүүлэгчийн шагнал, Телевизийн бичлэг хийх зэрэг ажлыг шийдвэрлэлээ.
Асуулт хариултыг бэлтгэж хянуулан дэлгэцээр харуулахад бэлэн болгож, самбар болон бичих хэрэгсэл, хэрэглэгдэх техник хэрэгсэл, байр танхимын чимэглэл зэргийг зохих журмын дагуу бэлтгэлээ.
Алтан хонх тэмцээнийг “Хөвсгөл нутгаа судалъя” сэдвийн хүрээнд зарлан явуулав. Тэмцээнд нийт 9 сургуулийн 60 гаруй сурагчид бүртгүүлэн оролцсон.

Мөн тэмцээнээс хасагдсан хүүхдүүдийн дунд боломж олгох зорилгоор бүжгийн тэмцээн зохион байгуулж түүнээс шалгаруулж дахин тоглох эрх олгосон. Энэхүү тэмцээнээс 5 байр эзлүүлж шагнал олгов. 1 – р байранд орсон уншигчийг Хөвсгөл аймгийн залуучуудын холбооноос EDU book-ээр урамшууллаа.

1 –р байранд ЭДЦС –ын 12б ангийн сурагч Г. Батзориг

2 –р байранд ЭДЦС –ын 11г ангийн сурагч Б. Сумьяа

3 –р байранд Мөрөн 2 – р сургуулийн 11 а ангийн сурагч Л. Нэргүй

4 –р байранд ДМЦС –ын 10б ангийн сурагч Ө. Урангуа

5 –р байранд ЭДЦС –ын 11г ангийн сурагч Э. Мөнхжаргал нар шалгарч шагналыг Хөвсгөл аймгийн залуучуудын холбооны тэргүүн Б. Мөнгөн-Эрдэнэ болон аймгийн нийтийн номын сангийн хамт олон гардуулж баяр хүргэж мэдээлэлийн ерөнхий спонсор байгууллагаар “**Чандмань**” телевиз ажиллалаа.
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158-р зарлиг, Монгол Улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт орсны дагуу аймгийн нийтийн номын сангаас “Хамтдаа уншъя” сэдэвт 2 сарын аяныг зарлаж 2014 оны 11 сарын 24 –нд Д.Нацагдоржийн уран бүтээлийг сурталчлах өдөрлөгөөр аяны турш явуулсан ажлуудыг дүгнэн тайлагнах ажлыг зохион байгууллаа.

Энэхүү хаалтын үйл ажиллагаанд Аймгийн нийтийн номын сангийн захирал Н. Оюунтуяа, АЗДТГ-ын НХХ-ийн соёл урлаг хариуцсан мэргэжилтэн Г. Нарангэрэл, Хөвсгөл аймгийн залуучуудын холбооны тэргүүн Б. Мөнгөн-Эрдэнэ нар оролцож уншигч нарт мэндчилгээ дэвшүүллээ.

Энэ өдөрлөгөөр дараах ажлуудыг зохион байгуулсан.

Үүнд:

- Д. Нацагдоржийн намтар уран бүтээлээс номын үзэсгэлэн /27 номоор, холбогдох гэрэл зураг, мэдээллүүдийг оруулав/
- “Шинэ ном- 2014“ номын үзэсгэлэн /2014 оны 2р хагас жилд фонд баяжилтаар авсан 100 номоор товч тайлбарын хамт/
- Д. Нацагдоржийн намтар уран бүтээлээр ахлах ангийн сурагчдын дунд АХА тэмцээн
- 2014 оны шилдэг уншигчдыг шалгаруулж “Тэргүүний уншигч- Д.Нацагдорж тэмдэгтэн” шагнал гардуулах
- Уншигчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж нийтэд сурталчлах
- Тэргүүний уншигчдын танилцуулга, амжилт, бүтээлийн үзэсгэлэн гаргаж алдаршуулах ажлууд явагдлаа.

“Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж” сэдээр танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион явуулав. Энэхүү тэмцээнийг Хөвсгөл аймгийн Залуучуудын холбоотой хамтран зохион байгууллаа.

Бэлтгэл ажлын хүрээнд “АХА” тэмцээний удирдамжийг гаргаж Мөрөн сумын ЕБС-дад хүргүүлж, нийтэд төрөл бүрийн мэдээллийн сувгаар зар сурталчилгаа хийж, лавлагааг тухай бүрт нь бичгээр болон амаар тайлбарлаж таниулж байлаа. Хамтран зохион байгуулах байгууллагуудыг сурвалжлан олж ажлаа танилцуулан санхүүгийн асуудлыг шийдвэрлэв.

Тэмцээнд нийт 5 сургуулийн 60 гаруй сурагчид бүртгүүлэн оролцсон.

Монголын залуучуудын холбооноос жил бүрийн 11 сарыг “Амьдралын алтан босго” 16 настангуудын сар хэмээн зарласан байсан. АХА тэмцээнээ 16 настай сурагчдын дунд зохиосноороо онцлог болсон.
Уг тэмцээнийг “Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж” сэдвийн хүрээнд уншигчдынхаа IQ, сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэх, их зохиолчийн амьдрал уран бүтээлийг судлуулах, тэдний мэдлэгийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор асуултыг бэлтгэн зохион байгуулсан. Мөн тэмцээнийг үндсэн дүрмийн дагуу нэг хүүхдэд 3 боломж олгох журмаар явуулж, 1-3-р байр эзлүүлж урамшууллаа.
АХА тэмцээнд түрүүлсэн уншигчийг ивээн тэтгэгчээр оролцсон Хөвсгөл аймгийн залуучуудын холбооноос EDU book-ээр урамшууллаа.

- 1 –р байранд Авьяас 8-р сургуулийн 11^{а} ангийн сурагч Б. Идэрмөрөн
- 2 –р байранд Мөрөн 2-р сургуулийн 9^{б} ангийн сурагч С. Цээлээ
- 3 –р байранд ДМЦС-ийн 11^{б} ангийн сурагч Г. Тэлмүүн нар шалгарч

Шагналыг Хөвсгөл аймгийн залуучуудын холбооны тэргүүн Б. Мөнгөн-Эрдэнэ болон аймгийн нийтийн номын сангийн хамт олон гардуулж баяр хүргэв.
Өдөрлөгийн үеэр Авьяас 8-р сургуулийн морин хуур ангийн сурагч Түвшинтөгс, Содцэцэг нар “Икэлийн эгшигт нутаг” морин хуурын аялгуу, МУГБагш Д.Батсуурийн нэрэмжит 2-р сургуулийн 4в ангийн сурагч М.Ануужин “Үерхэл чамайгаа нандигнана” дуугаар, Ирээдүй 21-р зуун ахлах цогцолбор сургуулийн О.Дулмаа багштай 3б

ангийн “Цоглог хөвгүүд” бүжгийн хамтлаг бүжгээр, уншигчид их зохиолч Д. Нацагдоржийн “Хуучин хүү” өгүүллэгээр дүрийн тоглолт, Ирээдүй сургуулийн 3б ангийн сурагч Г.Эрдэнэбаатар “Гэрийн ерөөл” уншиж мэндчилгээ дэвшүүлэв.

Аймгийн нийтийн номын сангаас “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” –ий болзол хангасан нийт 12 уншигчийг “Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгтэн” цол тэмдгээр шагнуулсаныг Аймгийн нийтийн номын сангийн захирал Н. Оюунтуяа, АЗДТГ-ын НХХ-ийн Соёл урлаг хариуцсан мэргэжилтэн Г. Нарангэрэл, аймгийн нийтийн номын сангийн ахлах номын санч Г.Энхтайван, Хөвсгөл аймгийн залуучуудын холбооны тэргүүн Б. Мөнгөн-Эрдэнэ нар гардуулж амжилт хүслээ.

Бүтээлч уншлага.

Бага насны уншигчдын дунд “Бүтээлч уншлага”, “Урилгат уншлага” “Захиалгат уншлага” зэрэг уншлагыг сонирхолтой хэлбэрүүдээр зохион байгуулж тэднийг бага наснаас нь эхлэн номын сангаар үйлчлүүлж сурах, ном унших чиг хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2014 онд бага насны уншигчдын дунд “Монгол ардын оньсого таавар”, СГЗ, зохиолч, сэтгүүлч Д.Сүрэнжавын хүүхдийн зохиолууд, Х.К.Андерсений “Шүдэнз зардаг охин”, Монгол ардын үлгэрүүд зэрэг сэдвүүдээр бүтээлч уншлага явуулж уншигчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж байв.

Бүтээлч уншлагын үеэр бяцхан уншигчид бусаддаа уншсан номоо ярих, өөрсдийн сонирхсон номыг сонгон авч уншин, ойлгосноо зургаар илэрхийлэх, оньсого таавар таалцах, тэмцээн наадам зохион байгуулах зэрэг ажлуудыг эцэг эх, багш нартай хамтран зохион байгуулж байлаа.

Уншигчид, эцэг эхийн төлөөллийн дунд Р.Гомбосүрэн. “Ном эзэмших соёл” номоор бүтээлч уншлага хийж, номоо хэрхэн сэлбэн засах, ямар ямар багаж хэрэгслүүд орох, хэрхэн ашиглах гэх мэтийн талаар товч мэдээлэл хийв. Энэ үеэр уншигчдад зориулж 8 хуудас үзүүлэн таниулах материал бэлтгэн тавив. Бүтээлч уншлагын үеэр эцэг эхчүүд, хүүхдүүд, багш нар хамтран 17 ширхэг номыг сэлбэн засав.

Хүүхдийн уншлагын танхимаас анги хамт олны дунд “Завгүй зөгий” номоор бүтээлч уншлагын аян зохион байгуулсан бөгөөд Д.Сувд-Эрдэнэ багштай ЭДЦС-ийн 3б анги /64 бүтээл/, Ирээдүй сургуулийн 3б анги /23 бүтээл/ -ийнхан идэвхтэй оролцсон бөгөөд бүтээлүүдээр үзэсгэлэн гаргав.

Н.Түмэнцагаан багштай 2-р сургуулийн 5в ангийнхан бүтээлч уншлага

Ирээдүй сургуулийн О.Дулмаа багштай 2б ангийнхан
Бүтээлч уншлага, чанга уншлагад идэвхтэй оролцсон Ирээдүй сургуулийн 2б ангийн сурагч.

Урилгат уншлага

Ирээдүй сургуулийн О.Дулмаа багштай $2^{б}$ ангийнхан, Л.Нэргүй багштай ДМЦС-ийн $7^{б}$ анги, Гурван-Эрдэнэ сургуулийн Ш.Нарантуяа багштай 4д ангийнхан, 2-р сургуулийн Алимаа багштай 6а анги, ЭДЦС-ийн 3д анги, Мөрөн сумын улсын тэргүүний 1-р цэцэрлэгийн ахлах бүлэг, барилгын цэцэрлэг, Улсын тэргүүний “Хөх сувд” цэцэрлэгийн хүүхдүүдэд урилгат уншлага зохион байгуулж хамт олноор нь номын сангийн уншигчаар бүртгэн номын сантай танилцах аялал зохион байгуулж, номын сангаар үйлчлүүлэх, номын сангийн эрх үүрэг, уншигчийн эрх үүргийн талаар нас, сэтгэхүйн онцлогт нь тохируулан танилцуулж байв.

Урилгат, захиалгат, чанга уншлага, бүтээлч уншлага /Хүснэгтээр/

д/д	Явуулсан ажил	Агуулга	Он сар өдөр	Хамрагдсан, хамтран явуулсан байгууллага, хамт олон	Хамрагдсан уншигчийн тоо
1.	Бүтээлч уншлага	Уншигчид өөрсдийн уншсан, хамгийн сайн ойлгосон номоо сонгон авч агуулга утга санааг нь илэрхийлсэн зураг зурцгааж, харилцан ярилцав.	2/24	Уншигчид болон Ирээдүй сургуулийн 2б ангийнхан	46
2	Бүтээлч уншлага	Х.К.Андерсений “Шүдэнз зардаг охин” үлгэрээр бүтээлч уншлага явуулж зурсан зургаар үзэсгэлэн гаргав.	3/10	Ирээдүй сургуулийн 2б ангийн сурагчид	25
3	Чанга уншлага	“Эмзэгхэн гүнжийн үлгэр”	1/16	Уншигчид	29
4.	Чанга уншлага	“Гурван өндөг”	2/17	Уншигчид	23
5	Чанга уншлага	“Цаасан шувууны аялал”	2/28	Уншигчид	25
6	Урилгат уншлага	Өөрсдийн сонирхсон ном	3/25	О.Дулмаа багштай 2б ангийнхан	29
7	Урилгат уншлага	Өөрсдийн сонирхсон ном	3/12	Б.Нэргүй багштай ДМЦС-ийн 7б ангийнхан	42
8	Чанга уншлага	МУСГЗ Д.Сүрэнжавын “Молиго гайхал” номноос	4/29	Д.Сувд-Эрдэнэ багштай ЭДЦС-ийн 3б ангийнхан	41
9	Чанга уншлага	“Царцаа шоргоолж хоёр” үлгэрээр	5/6	Мөрөн сумын 1-р цэцэрлэгийн Ж.Оюунцэцэг багштай ахлах А.Б бүлгийн хүүхдүүд	88
10	Тойм яриа	15 ш шинэ номоор	1/12	уншигчдад	22
11	Тойм яриа	10 ш шинэ номоор	2/21	уншигчид	36
12	Тойм яриа	Заавал унших номоор /Сургуулийн бага насныханд зориулсан номоор/	3/10	уншигчид	21
13	Тойм яриа хийв.	“Яагаад” лавлагааны булангаас “Багачуудын нэвтэрхий толь” цувралыг сонгон авч тойм яриа хийв.	4/10	Уншигчид	23
14	Тойм яриа	2014 онд шинээр ирсэн номуудаар тойм яриа хийв.	4/25	Уншигчид	45
15	Тойм яриа	Хүүхдийн зохиолчдын номоор Хүүхдийн зохиолчдын намтар уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж, манай номын санд байгаа	4/1	Уншигчид	38

		номуудаар нь тойм яриа хийв.			
16	Тойм яриа	“Супер найзууд” комик цуврал	11/18	Уншигчид	32
17	Тойм яриа	“Чингис хаан” комик цуврал	9/100	Уншигчид	33
18	Тойм яриа	“Гайхамшигт нүд” комик цуврал	11/19	Уншигчид	29
19	Тойм яриа	Тус заланд ирсэн шинэ номуудаар тойм яриа хийв	5/1	Уншигчид	45
20	Тойм яриа	Хүүхэд бүрийн заавар унших номуудаар тойм яриа хийв.	5/5	Уншигчид	23
21	Тойм яриа	Хүүхэд бүрийн заавал унших номуудаар тойм яриа хийв.	6/2	Уншигчид	21
22	Тойм яриа	Ардын аман зохиолын сэдэвтэй номуудаар тойм яриа хийв.	9/12	Уншигчид	24
23	Чанга уншлага	Ухаант туулай монгол ардын үлгэр	10/3	Уншигчид	21
24	Чанга уншлага	“Цоорхой хувин” сургамжит өгүүллэг	9/15	Уншигчид	21
25	Чанга уншлага	Х.К.Андерсен. Ямх охин	9/22	Уншигчид	20
26	Чанга уншлага	Х.К.Андерсен. Эхийн тухай үлгэр	9/18	Уншигчид	29
27	Чанга уншлага	Хөвсгөлийн түүхт хүмүүсээс Монгол улсын баатар Л.Даваадорж, Л.Гэлэгбаатар	10/21	Уншигчид	26
28	Чанга уншлага	Хөвсгөлийн түүхт хүмүүсээс Б.Чингүнжав, Х.Гэлэнхүү	10/2	Уншигчид	30
29	Чанга уншлага	Хөвсгөлийн түүхт хүмүүсээс Агваанлхасүрэн шанзав, Агваанлувсанчойжирдондув	10/6	Уншигчид	22
30	Чанга уншлага	Хөвсгөлийн түүхт хүмүүс Пүрэвийн Гонгор	11/3	Уншигчид	21
31	Чанга уншлага	Хөвсгөлийн түүхт хүмүүс Монгол улсын баатар Дугарын Гунгаа, Монгол улсын гурав дахь ерөнхий сайд асан Жалханз хутагт Дамдинбазар	11/4	Уншигчид	20
32	Чанга уншлага	Цаасан шувууны үлгэр	10/6		22
33	Чанга уншлага	Морь, баавгай, чоно гурвын үлгэр	11/19	ЭДЦС-ийн 3д ангийн сурагчид	35
34	Чанга уншлага	Эрхий мэргэн монгол ардын үлгэр	6/2	“Хөх сувд” цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүд	82
35	Чанга уншлага	Могжоохон даагатай жогжоохон хүү	12/5	Мөрөн сумын УТ-ний 1-р цэцэрлэгийн 4 настай ангийн хүүхдүүд	45
36	Чанга уншлага	Үнэг чоно хоёр	12/5	Мөрөн сумын УТ-ний 1-р	45

				цэцэрлэгийн 4 настай ангийн хүүхдүүд	
35	Урилгат уншлага	Номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, сурагчдын сонирхсон асуултанд хариулав. Сурагчид өөрсдийн сонирхсон номоо уншицгаав	11/5	Гурван-Эрдэнэ сургуулийн Ш.Нарантуяа багштай 4д ангийнхан	41
36	Урилгат уншлага	Номын сангийн талаар мэдээлэл хийв. Сонирхсон номоо уншихын зэрэгцээ монгол ардын үлгэрээр чанга уншлага явуулав.	11/21	ЭДЦС-ийн 3д ангийнханд	38
37	Урилгат уншлага	Мөрөн сумын улсын тэргүүний 1-р цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдэд урилгат уншлага явуулав	12/5	Мөрөн сумын УТ-ний 1-р цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд	45
38	Урилгат уншлага	Мөрөн сумын барилгын цэцэрлэгийн хүүхдүүдэд урилгат уншлага явуулав.	5/21	Багш нар номын санч	82
39	Урилгат уншлага	Улсын тэргүүний “Хөх сувд” цэцэрлэгийн хүүхдүүдэд урилгат уншлага явуулав.	6/2	Багш нар номын санч	88
40	Урилгат уншлага	Мөрөн сумын УТ-ний 1-р цэцэрлэгийн 4 настай ангийн хүүхдүүд	12/5		45
41	Бүтээлч уншлага	Уншигчид, эцэг эхийн төлөөллийн дунд Р.Гомбосүрэн. “Ном эзэмших соёл” номоор бүтээлч уншлага хийж, номоо хэрхэн сэлбэн засах, ямар ямар багаж хэрэгслүүд орох, хэрхэн ашиглах гэх мэтийн талаар товч мэдээлэл хийв. Энэ үеэр уншигчдад зориулж 8 хуудас үзүүлэн таниулах материал бэлтгэн тавив. Бүтээлч уншлагын үеэр эцэг эхчүүд, хүүхдүүд, багш нар хамтран 17 ширхэг номыг сэлбэн засав.	11/10	Ирээдүй сургуулийн 3б ангийн сурагчид болон эцэг эхчүүд багш нар	28
42	Бүтээлч уншлага	Хүүхдийн уншлагын танхимаас анги хамт олны дунд “Завгүй зөгий” номоор бүтээлч уншлагын аян зохион байгуулсан	9/25-11/25	ЭДЦС-ийн 4б ангийнхан, Ирээдүй сургуулийн 3б ангийнхан	110
43	Бүтээлч уншлага	Уншигчид өөрсдийн сонирхсон номыг сонгон авч уншицгаасан бөгөөд	9/25	2-р сургуулийн Н.Түмэнцагаан багштай 5в	33

		агуулга, утга санааг нь зургаар илэрхийлэв.		ангийнхан	
		нийт	43		1689

Мэдээлэл. Тэмдэглэлт өдөр, түүхэн үйл явдал, цаг үеийн асуудал, уншигчдад хэрэгцээтэй мэдээллүүдийг мэдээллийн самбаруудаар тухай бүрд нь хүргэж байв.

№	Сэдэв	Хэмжээ	Хугацаа	Мэдээлэл гаргасан ажилтан
1	Монголын уламжлалт цагаан сарын тухай	10 хуудас мэдээлэл	2/7	Ч.Учралтбаясгалан
2	Өвлийн олимпийн тухай	10 хуудас мэдээлэл бэлтгэж тавив.	2-р сард	——,,——
3	Олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдрийн тухай	8 хуудас материал бэлтгэж тавив.	3-р сард	——,,——
4	Дэлхийн эрүүл мэндийн өдөрт зориулж	“Миний гар цэвэрхэн” 8х материал бэлтгэж тавив.	3-р сард	Ч.Учралтбаясгалан
5	Дэлхийн байгаль хамгаалах өдөрт	“Орчноо зүлэгжүүлье” 10х материал бэлтгэж тавив.	4-р сард	——,,——
6	Дэлхийн номын өдөрт	10х хуудас бэлтгэж тавив.	4-р сард	——,,——
7	Дэлхийн усны өдрийн тухай Усны тухай бидний мэддэггүй 30 баримт		22/III	Оюунбилэг Алтантуяа
8	Дэлхийн номын болон зохиогчийн эрхийн өдөр Дэлхийн хамгийн өндөр үнээр зарагдсан арван ном Шилдэг борлуулалттай номууд		23/IV	——,,——
9	Заавал унших номын жагсаалт		10/II	——,,——
10	Шинжлэх ухаан, танин мэдэхүй			——,,——
11	Хувь хүний хөгжил			——,,——
12	Философи, сэтгэлгээ			——,,——
13	Түүх			——,,——
14	Уран зохиол, яруу найраг			——,,——
15	Мэргэжлээ сонгохдоо анхаарах хэдэн зүйлээс Мэргэжил бүхэн сайхан Мэргэжлийн үнэ цэн	20/V		——,,——

	Өөрийгөө таних Сургуулиа биш мэргэжлээ урьтаж сонго Сонирхлоо дага			
16	Дэлхийн байгаль орчны өдөрт	22/IV		___,,___
17	Интернэт хэрэглэж байгаа уншигчдад зориулсан төрөл бүрийн зурагт санамжууд			___,,___
18	Уншлагын тахимын танилцуулга, Эрхэм зорилго			___,,___
19	Уншигчийн эрх үүрэг			___,,___
20	Шинэ номын мэдээ			___,,___
21	Хүрээлэн байгаа орчныг хамгаалах дэлхийн өдөрт	27 х.	5/VI	___,,___
22	Уншлага үйлчилгээний танхимын мэдээлэл	1	Сар бүрийн 25	Базар, Дуламсүрэн
23	Монгол хүн сансарт ниссэн өдрийн мэдээлэл	16	1IV	___,,___
24	Мод тарьж сурцгаая	24	28/IV	___,,___
25	Үндэсний бөх	15	1/VII	___,,___
26	Аймгийн наадамд түрүүлж үзүүрлэсэн бөхчүүдийн товчоон	9	___,,___	___,,___
27	Цэцгийн ерөнхий утгын толь, цэцэг юуг илэрхийлдэг вэ	25	3/III	Туул
28	Эмэгтэй хүний тухай тухай онч мэргэн үгс	1	___,,___	_____,,_____
29	Эрүүл мэндийн зөвлөмж	22 х.	01/IV	Туул
30	Д.Сүрэнжавын намтар уран бүтээлийн тухай	32 х.	5р сар	Энхтайван
31	Дэлхийн номын өдрийн тухай, дэлхийн шилдэг номын сангууд, дэлхийн шилдэг номууд	30х.	18/IV	Туул
32	Үндэсний бичиг үсгийн тухай	25 х.	5/V	___,,___
33	Хүүхдийн эрхийн конвенцийн тухай	8 х.	26/V	___,,___
34	Үндэсний их баяр наадам зориулсан мэдээ мэдээлэл	26 х.	04/VII	Алтантуяа
	Монголчуудын цайны соёл Монголчуудын бичиг үсгийн соёл	40 х.	24/VII	Алтантуяа
	Цэгмидийн Гайтав	2 х.	25/VIII	___,,___
	“Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”шалгаруулах удирдамж	1 х.	26/VIII	___,,___
	Хичээлийн шинэ жилтэй холбогдуулан “Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014-	1х.	25/VIII	Учралтбаясгалан

	2015 оны хичээлийн шинэ жилийн мэндчилгээ”			
	“Шинэчлэгчдсэн сурагчийн дүрэмт хувцасны тухай”	2		Учралтбаясгалан
	“I-IV ангийн сурах бичиг 100% шинэчлэгдсэн”, “Дунд, ахлах ангийн сурах бичгийг түрээсээр ашиглуулна”	7		___,,___
	Олон улсын ахмадын өдөрт	3 х.	30/IX	
	Д.Нацагдоржийн намтар, уран бүтээл	3	10-р сар	___,,___
	“Хөвсгөлийн халх ястны аж ахуй”	19х.		___,,___
	“Хөвсгөлийн түүхт хүмүүс”	14 х.		___,,___
	“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-үүд			Алтантуяа Базар Учралтбаясгалан Дуламжав
	Ханиад томуунаас хэрхэн урьдчилан сэргийлэх, эмийн бус аргаар ханиад томууг хэрхэн эмчлэх талаар	10 х.		Учралтбаясгалан
	Дэлхий нийтээр ядууралтай тэмцэх өдөрт мэдээлэл	1 х.	17/X	Алтантуяа
	Ш.Гаадамбын намтар, уран бүтээлээс	3 х.	27/X	Алтантуяа
	Д.Нацагдоржийн намтар уран бүтээлээс	16 х.	10р сар	___,,___
	Монгол бахархалын өдөрт	18 х.	14/XI	Алтантуяа
	Сэнгийн Эрдэнийн 85 насны ойд	3 х.	02/XII	Алтантуяа

ЗУРГАА. Лавлагаа номзүйн ажил

Уншлагын танхим дахь лавлагааны булангуудыг уншигчдын мэдээ баримтын лавлагааг үндэслэн өөрчлөн баяжуулж 327 ном, хуудас материалууд бүхий лавлагааны материалаар бүрдүүлж уншлага үйлчилгээнд ашиглаж байна.

Уламжлалт каталогийн 3325 ш картыг шинэчлэн хэвлэж байрлуулав. Цаасан каталогийн эдэлгээг уртасгах зорилгоор скочоор наалт хийж байна.

762 ш номоор санамж өгөх ном зүй, 358 номонд бүртгэн мэдээлэх номзүй, 1852 номоор сэдэвчилсэн номын жагсаалт хийж уншигчдад фондын ном хэвлэлийн сурталчилгаа мэдээлэл хийв.

126 уншигчдад аман лавлагаа өгсөн байна.

Долоо. Нүүдлийн номын сан, номын сан хоорондын номын солилцоо

Ахмадын асрамж үйлчилгээний төв, ШШГА-ны номын сан, Мөрөн Гурван Эрдэнэ ахлах сургууль, Хилийн цэргийн номын сангууд дээр ажиллуулах зөөврийн номын сангийн гэрээг шинэчлэн байгуулж 205 төрлийн номоор номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн нийтийн номын сангийн Нийтийн уншлагын танхимаас Номын баярын хүрээнд Нүүдлийн номын сан ажиллуулж Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй Гурван-Эрдэнэ ахлах сургуулийн 35 хүүхдэд 70ш номоор үйлчиллээ.

Гурван-Эрдэнэ ахлах сургуулийн Д.Хишигдүүрэн багштай 8^{а} ангийн 35 хүүхэд 70ш номоор үйлчилгээ үзүүлэн 35 хүүхдэд карт нээж номын сангийн уншигч болгосон.

Сурагчдад нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийж, хэрхэн уншигч болох, номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, номоо хэрхэн сонгох, ном унших арга хэлбэрийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, БСШУЯ-ын сайдын 2011 оны 06 сарын 20-ны өдрийн 228 дугаар тушаалаар “Хүүхдэд уран сайхан гоо зүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээл”-ийн жагсаалтанд орсон номнуудыг танилцуулж 2014 онд ирсэн шинэ ном болон Номын санд ямар ямар сонин сэтгүүл захиалдаг талаар мэдээлэл өгсөн. Нүүдлийн номын сангаар уншуулах номнуудаа танилцууллаа. Мөн Уран зохиолын хичээлд даалгавар өгсөн С.Эрдэнийн “Хайрын нарсан төгөл” өгүүллэгээр уншлага явуулж, сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн явуулав. АХА тэмцээнд нэгдүгээр байранд Ч.Юүжон, удаах байранд Б.Эрдэнэбат нар тэргүүллээ.

1-р байр Ч.Юүжон шагналд / Хуан Согён Бари ном, цэцэг/
2- байр Б.Эрдэнэбат/Математикийн тестын эмхэтгэл ном, цэцэг/

ДМЦС, Ирээдүй 21р зуун цогцолбор сургууль, 2р сургуулийн номын сангуудтай номын солилцоо хийж уншигчдын захиалсан 81 ш ном авч уншлаганд гаргав.

Аймгийн Ахмадын асрамж үйлчилгээний төвийн үйлчлүүлэгч, ажилчдад нүүдлийн номын санг ажиллуулж зөөврийн номын сангийн үйлчилгээг тогтмол явуулж байна. Мөн номын санд нь номын хандив өгч арга зүйн зөвлөмж туслалцаа үзүүлж байлаа.

Найм. Ном хэвлэлийн сэлбэн засалт
Урагдаж гэмтсэн 131 ш номыг нааж, үдэж сэлбэн засалт хийсэн.

Бүтээлч уншлагын үеэр эцэг эхчүүд, хүүхдүүд, багш нар хамтран 17 ширхэг номыг сэлбэн засав.

Ес. Мэргэжил арга зүйн ажлын талаар
Орон нутгийн номын санчдад 2удаа сургалт зохион байгуулж 22 номын санчид хамрагдав. Сургалтаар Монбиблио програмын хэрэгжилтэнд хяналт хийж номын санчдын гаргасан алдааг засаж, заавар зөвлөгөө өгч, дадлага хийлгэв.
Номын санчдад 36 сэдвээр 45 удаа 23 сумын номын санчдад арга зүйн зөвлөгөө тусламж үзүүлэв.
Арга зүйн ажлын хүрээнд орон нутгийн 22 номын сангийн ажил байдалтай биечлэн танилцаж, зөвлөгөө өгч практик туслалцаа үзүүллээ.
Хөвсгөл аймаг нь нийт 23 сумын Соёлын төвд 23 Нийтийн номын сан ажиллаж үүнд 23 номын санч ажиллаж буйгаас номын сангийн мэргэжилтэй 7 номын санч, мэргэжилийн бус 16 номын санчид ажиллаж байна.
Сумдын 23 номын сан нь нийт 129059 мянган ш номтой ба 2013 оны 5 сарын 25-с 2014 оны байдлаар 19075 номыг Monbiblio програмд оруулаад уншлага үйлчилгээндээ гаргаж байна. Аймгийн Нийтийн Номын Сан нь 2013 онд номын сангийн програм хэргэжиж эхэлснээс хойш 2014 онд 22 сумдын номын сангуудад очиж мэргэжлийн зөвлөлгөө өгч, ажил байдалтай нь танилцахад програмын хэрэгжилт хангалтгүй номын санчдын ажиллах идэвхи сул, техник хэрэгсэл дээрээ ажиллах чадваргүй байсан учраас бүх сумдын номын санчдыг 2 удаа давтан сургалтанд бүсчилэн хамруулж сургаж, дадлагжуулсан. Сургалт явуулсан хөтөлбөр, дадлагжих үед электрон каталогт оруулсан номын тоо, графикыг хавсаргав.
Сумдын номын сангуудыг Monbiblio програмд оруулсанаар номын санчдын ажлыг хөнгөвчилж, уншигчдад ном хэвлэл, хэрэгцээт мэдээллээ авахад хялбар болох, олон уншигч үйлчлүүлэгчдэд үйлчлэх боломжтой болгосон ба номын санч нарыг мэргэжилдээ сайн мэргэших, ажиллах сонирхолтой болгосон сайн талтай.
Мөн 2014 онд орон нутгийн номын сангийн ажил байдалтай танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх төлөвлөгөө, график гарган 22 суманд ажиллан ажил байдалтай нь танилцаж зөвлөлгөө өгөхөд урд оныхоос номын санчдын ажиллах

чадвар өссөн, фондын номоо Monbiblio програмд оруулаад үйлчилгээндээ гаргадаг болсон боловч номын санч нарын идэвхи, чадвар харилцан адилгүй байна.
Монбиблио програм хангамжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл

- Хөдөө сумдын номын сангуудад жилдээ фонд бүрдүүлэлтийн төсвөөс гадна бичиг хэрэгслийн зардал төсөвлөгдөж байх шаардлагатай байна.
- Номын санчдын идэвхи сул
- Мэргэжилдээ чадварлаг бус
- Номын санд мэргэжлийн чадварлаг ажилтан цөөн байгаа
- Зарим сумдад ажиллах орчин муу
- Номын санчийн ажилд сумын удирдлага, соёлын төвийн захирлуудын дэмжлэг муу

Сумдын номын санчдын санал хүсэлт:

- Хөдөө сумын ННС-гуудад ажиллаж буй номын санчдын мэргэжил олголт, давтан сургалтыг явуулахдаа мэргэжилтэй, мэргэжлийн бусаар нь ялгаж сургалт явуулж байхыг суманд ажиллаж буй мэргэжилтнүүд санал тавьж байсан.
- Мэргэжил олгох сургалтыг ажиллаж буй номын санчддаа 2,5 жилээр эчнээ сургалт авмаар байна гэж мэргэжлийн бус номын санчид санал оруулж байсан.
- Monbiblio програмын уншигч бүртгэл нь дараа ондоо шинээр бүртгэх өгөгдөлгүй байнгын уншигч урд оныхоо уншигч дээр өссөн дүнгээр бүртгэгддэг зэргийг анхаарна уу
- Бар кодын хэмжээг богиносгох

Эдгээр санал хүсэлтийг ССАЖЯ-д уламжилснаар СУИС-ийн Соёлын Боловсролын сургуулийн Номын сан мэдээллийн ажилтны ангид онлайнаар 2 номын санч, эчнээгээр 3 номын санч суралцаж мэргэжил боловсролоо дээшлүүлэх болсон.

“Монбиблио” програмд номын санчдын саналыг үндэслэн дэвшилтэт өөрчлөлтүүдийг оруулсан байна.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СУМДЫН НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН MONBIBLIO ПРОГРАМЫН ХЭРЭГЖИЛТ.

2014 он

Ñóì äû í í ýðñ / ¯ç¿¿ëýëò¿¿ä		Àëàã-Ýðäýíý	Àðáóëàã	Áàÿí ç¿ðõ	Á¿ðýíòîãòîõ	Ãàëò	Æàðãàëàíò	Èõ-Óóë	Òàðèàëàí	Òîñîíöýíãýë	Òºìºðáóëàã	Ò¿íýë	Ðàøààíò	Ðåí÷èíëõ¿ìáý	Óëààí-Óóë	Õàíõ	Öàãààí-Нуур	Öàãààí-Óóë	Öàãààí-¯¿ð	×àíäìàíü-ºíäºð	Øèíý-Èäýð	Öýöýðëýã	Ýðäýíýáóëàí	Õàòãàë	Нийт дүн
Ñóóäëûí òîî		25	20	20	20	25	15	16	55	16	40	50	12	12	40	12	0	36	10	30	20	72	12	20	578
Íîìûí ôîíä	òîãòîîð	7700	1091	7681	10176	8008	7100	1227	12209	5600	4722	5937	6810	3476	***1700***	1070	919	13323	823	1596	1847	1591	1535	21810	127951

Mon bibliod оруулсан номын тоо	2014 оны 9 сарын байдлаар	520	51	1192	650	790	567	690	1100	1270	411	1752	1244	218	605	757	0	1703	312	1382	920	1141	1300	500	19075
Хувь		0,7%	4,7%	15%	6,4%	9,5%	8%	55%	9%	22,6%	8,8%	12,5%	18%	6,3%	36%	70,5%	0	13%	38%	86%	49,5%	70%	82,4%	0,3%	14.9%

Арав: Удирдлага зохион байгуулалт

Тайлангийн хугацаанд 16 ажилтантайгаар, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ хийж улирал жилээр дүгнэн байр эзлүүлж шагнал урамшил олгож ажиллагсдын идэвхийг өрнүүлэн ажиллаж байна.

Байгууллага дээрээ ажилтнуудынхаа хүүхдүүдэд үйлчлэх зорилгоор “Хүүхэд хамгаалах” зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, зөвлөлийн ажиллах төлөвлөгөө батлан зөвлөл Хүүхдүүдийн нас сэтгэцийн онцлогт тохируулан баяр наадам, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан тусгай арга

Долоо хоног бүр шуурхай цуглаан хийж, тулгамдаж байгаа асуудал, жил улирал сарын ажлыг дүгнэн ярилцаж, цаашид хийх зүйлээ төлөвлөн, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, өөрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажиллав.

Нийтийн номын сан нь 2014 онд ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, түүнийг сурталчлан уншигчдад хүргэх, номын сангийн үйлчилгээнд шинэлэг арга барил нэвтрүүлэх, уншигчдад үйлчлэх таатай орчин бүрдүүлэх, орон нутгийн номын сангийн үйл ажиллагааг автоматжуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн, байгууллагт дотоод хяналтын төлөвлөгөө гарган, нийт 11 заалтын биелэлтэнд нь хяналт тавин гарсан зөрчлийг тухай бүрд нь холбогдох нэгж, ажилтанд үүрэг даалгавар өгөн арилгуулж, ажлыг сайжруулан ажиллав.

Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын санхүүгийн тайланг хугацаанд нь өгч, бусад СУ-5, СУ-10, СУ-17 мэдээг цаг тухай бүрд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж , орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад өөрийн байгууллагын үйл ажиллагааг 34 удаа суртачилан, Төсөв, санхүү, үйл ажиллагааны ил тод, нээлттэй самбар байнга ажиллуулан, байгууллагын веб хуудастай **web:khs.gov.mn/web-library/** болж байгууллагаа сурталчлан ажиллав.

Улсын төсвөөс 168095.8 сая төгрөгийн санхүүжилт аван, 168095.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, өр авлагагүй санхүүгийн үзүүлэлттэй ажиллаж, номын фондын сан хөмрөгийг татгалзлалын дагуу бүрдүүлэн, шинэ ном хэвлэлийг төсвийн санхүүжилт болон, ТББ болон хувь хүмүүсийн хандив, төслийн санхүүжилтээр 8 068.6 сая төгрөгийн ном хэвлэлээр номын фондын сан хөмрөгөө баяжуулан, Олон улсын байгууллагын санхүүжилтээр 24,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдан олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр сурталчилж ажиллав.

2015 оны аймгийн ИТХ-д оруулах санал, 2013-2016 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Номын сангийн талаар:

1. Сумдын номын санд ССАЖЯ-ны төслөөр хэрэгжсэн “Монбиблио” программ хангамжийг бүрэн ашигладаг болох

2. Сумдын номын санг стандартад нийцсэн байртай болгох
3. Сумдын номын санд мэргэжилтэй боловсон хүчин ажиллуулах
4. Номын сангийн нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай болох боломж нөхцөлөөр хангаж \орчин үеийн шаардлагад нийцсэн техник хэрэгслэлээр хангах\
5. Номын сангуудын номын фонд баяжилтыг уншигчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тогтмол баяжуулж, аймаг орон нутгийн түүхэн тэмдэглэлт өдөр ойн баяруудаар зориулж гаргадаг ном, зургийн цомог, дурсгалын зүйлс зэрэг материалуудыг аймаг, орон нутгийн номын сан, орон нутгийг судлах музейн фондонд албан ёсоор хадгалуулж олон нийтийн хүртээл болгодог болох

   Сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөөг аймгийн БСГ-тай хамтран хийдэг байх.

Байгууллагын өмчийн тайланг хуулийн дагуу гаргаж өгч, нийт ажилтнуудтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, галын аюулгүй байдлыг хanган онцгой байдлын албатай хамтран сургалт зохион байгуулан, Галын аюулгүй байлыг хангах гэрээ байгуулан ажиллав.

Номонд хэвлэл, зарим эд хогшилд сэлбэн засалт хийн номын хэвлэл, эд хогшлын эдэлгээг уртасган Ойрын фондуудын номын тавиуруудыг сольж чөлөөт сонголттой болгов. Уншлагын 2 танхимд номын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор тус бүрд нь орчин үеийн шаардлагад нийцүүлэн соронзон хаалга, ойрын фондын номуудад мэдрэгч ялтас байрлуулав. Номын сангийн танхим бүрд утаа мэдрэгч байрлуулж галын аюулгүй байдлын шаардлагад нийцүүллээ.

Монбиблио програм дээр ажиллах, дадлагажих сургалтыг сумдын номын санч нарын дунд хуваарь гарган 10 сарын 14-өөс 11р сарын 9-ий хооронд 5 хоногийн хугацаатайгаар, 12-р сард 24 цагийн сургалт зохион байгуулсан, давхардсан тоогоор нийт 81 номын санч хамрагдсан. Сургалтын үеэр орон нутгийн номын сангуудын үйл ажиллагаа автоматжуулах ажлын үр дүн явцтай танилцаж ололт, алдаа дутагдлыг хэлж зааж зөвлөж байлаа.

“Номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх нь” төсөл бичиж “Швейцарийн ЭСЯ-ны хамтын ажиллагааны газартай” хамтран 38,254.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлэхээр 2014 онд ШХА-ны газраас 29,700.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж аван номын санд “Чөлөөт сонголттой уншлагын танхим”, “Уншъя, урлая” танхим ажиллуулж уншигчдад номын сангийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн номын сангаар үйлчлүүлэх иргэдийн тоог нэмэдүүлэн, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг сайжруулан ажиллаа.

Номын санчдын санал хүсэлтийг ССАЖЯ-д уламжилснаар СУИС-ийн Соёлын Боловсролын сургуулийн Номын сан мэдээллийн ажилтны ангид онлайнаар 2 номын санч, эчнээгээр 3 номын санч суралцаж мэргэжил боловсролоо дээшлүүлэх болсон.

ТӨРИЙН ШАГНАЛТ ЯРУУ НАЙРАГЧ Р. ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Удирдлага зохион байгуулалт

Монгол Улсын Соёлын тухай хууль, төрөөс баримтлах соёлын бодлого бусад хууль эрх зүй, Монгол Улсын Засгийн газар, Аймгийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрүүд, төсвийн ерөнхийлөн захирагч соёл, спорт, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг даргын хооронд засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ, номын санг 2013-2018 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө болон дэвшүүлсэн зорилго зорилтоо биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3.2.3.2 дахь заалт Аймгийн нийтийн номын сангийн барилгад өргөтгөл хийж, номын сангийн орчны MNS5742:2007 стандартын шаардлагын дагуу ажиллах нөхцлөөр хангаж, цэвэр бохир усны системд холбох

Аймгийн нийтийн номын сангийн барилга нь 1972 онд аж ахуйн аргаар баригдсан бөгөөд түүнээс хойш засвар үйлчилгээ огт хийгдээгүй энэ байдлыг харгалзан үзэж Аймгийн Мэргэжлийн Хяналтын Улсын байцаагчаар барилга байгууламжийн ашиглалтыг шалгах хяналтын хуудсаар дүгнүүлж, засварын ажлыг яаралтай хийх хэрэгтэй гэсэн дүгнэлт гаргасан.

Уг дүгнэлтийг ССАЖ Яам, Аймгийн ЗДТГазар, ССАЖ Газарт холбогдох дүгнэлт болон барилгын засварын төсвийг хүргүүлснээр 40,0 сая төгрөгийн засварын төсвийг батлуулан ажиллаа. Хэнтий аймгийн нийтийн номын сангийн засварын ажил худалдан авах тендерт Итгэл найдвар ХХКомпани гүйцэтгэгчээр шалгаран засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Засварын ажлаар номын сангийн бороо гоожиж байгаа барилгад шувуун нуруу хийж дээвэрлэх, өмхөрч муудсан цонхнуудыг вакум цонхоор шинэчлэх, мөн цэвэр бохирын шугаманд холбогдож, эрэгтэй эмэгтэй орчин үеийн ОО-ыг суурилуулж ажилласнаас гадна байгууллагын нөөц бололцоог ашиглан өрөө танхимуудыг засварлаж тохижуулах, ном хэвлэлийг чөлөөт сонголтонд оруулж ажиллалаа. Барилгын засвараар барилгын дээврийг шувуун нуруутай дээвэр болгож, бороо ус гоожихгүй болголоо.

Мөн засварын хугацаанд цэвэр бохирын шугам татан, халуун хүйтэн устай болсон нь хүүхэд багачууд, уншигчдын эрүүл ахуйн шаардлага хангасан, тав тухтай орчинд үйлчлүүлэх, нэг том дэвшилт боломж юм.

Цэвэр бохирын шугам татуулж байгаа байдал

Номын сангийн дотор хананд байрлаж байсан шатыг голлуулж, эрэгтэй эмэгтэй хоёр ОО-той болох нөхцөл бүрдсэн бөгөөд, номын сангийн танилцуулга мэдээллийн самбарыг байрлуулж ажиллаа.

Аймгийн ИТХурал, ССАЖ Газарт номын санг камержуулах төсөл, дохиолол хамгаалалт галын хяналтын системд холбогдох төсвийг хийж хүргүүлсэн. Аймгийн цагдаагийн газраас зохион байгуулсан камержуулах мэдээлэлд оролцсон. Номын санг камержуулах төсвийг PC Маркет ХХК-иар хийлгэн 50 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

ССАЖЯамнаас 2013 оны ажлын үзүүлэлт, хийсэн ажлын тайлангаар 21 аймгийн номын сангуудын ажлыг дүгнэхэд манай байгууллага эхний таван байрт шалгарсан тул соронзон хаалга 3866,0 мянган төгрөг, ресепшиний ширээ 769,0 мянган төгрөг, ном уншигч 721,5 мянган төгрөг, номын ялтас 1000 ширхэг 150,0 мянган төгрөг нийт 5506,5 мянган төгрөгийн эд хогшлыг олгосон байна. Энэхүү соронзон хаалгын тусламжтайгаар уншлагын танхимуудын ном алга болох явдал багассан.

Уншлага үйлчилгээний талаар

№	үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	Уншигч	1350	1387	108.2
2	Ирэгсэд	13750	16015	117.2

3	Олгосон ном	33500	37141	120.4

Манай байгууллагын 2014 оны уншлага үйлчилгээг өмнөх онтай харьцуулахад 108,0-117,2%-иар, олгосон ном 120,4%-иар өссөн үзүүлэлттэй байна

Номын сангийн үйл ажиллагаанд шинэлэг арга барилыг нэвтрүүлж, байгууллагаа олон нийтэд сурталчлах, уншигчдын ном унших идэвхийг өрнүүлэх, уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ССАЖ Яамнаас "Шилдэг ном 2013"-т шалгарсан 154 ширхэг 957,4 мянган төгрөгийн номыг 22 сумын номын санд хувиарласан /1 суманд 7 ширхэг 67200 мянган төгрөгийн ном/ 18 нэр төрлийн 543,7 мянган төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад ашиглуулж байна. Энэ оны фонд баяжилтыг өмнөх оныхтой харьцуулбал төсвийн хөрөнгөөр авсан ном 111,9%-иар өссөн байна. Үүнд:

- Байгууллагын 70 жилийн ойтой холбогдуулан Р. Чойномын өвийг хамгаалах "Өд" сантай хамтран ажилласан

-Оюухай-2014" наадамд оролцсон зохиолч яруу найрагчид өөрсдийн уран бүтээлүүдийг хандивласан

-Хэнтийн зохиолчдын дунд ном хандивлах аян зохион байгуулсан /300 гаруй/

-Байгууллагын ойтой холбогдуулан ажиллаж байсан захирал, ахмад номын санч нарын дунд ном хандивлах аян зохион байгуулсанаар фондын баяжилт өссөн байна.

"Ном коллектор" ХХК, "Жиком" хэвлэлийн газруудтай ном худалдан авах гэрээ байгуулан тэмдэглэлт өдрүүд болон Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, Хүүхдийн баяр, Дархан суманд болсон "Оюухай-2014" наадам, Дадал суманд зохион байгуулагдсан "Алтаргана" наадмын үеэр шинэ номын үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Номын худалдаанд 189 нэр төрлийн 294 ширхэг 5000,0 сая төгрөгийн ном борлуулахаар татан авалт хийсэнээс 3520,0 мянган төгрөгийн номыг борлуулаад байна.

Манай номын сан бүх насныханд мэдээлэлийг хүртээмжтэй хүргэх зорилгоор сургуулийн өмнөх насны хүүхдийн насны онцлогт тохируулсан номын фондтой болох зорилгоор өөрсдийн ажилчид болон уншигчдаараа нийт 137 ширхэг монголын болон гадаадын үлгэрүүдээр "Зурагт бяцхан ном" хийлгэж цэцэрлэгийн хүүхдүүдэд сурталчилж байгаас гадна уралдаан тэмцээн шагнал урамшилж ашиглаж байна

Энэ онд шинээр ирсэн номоор 8 удаа үзэсгэлэнг 675 номоор 2227 хүнд, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 13 удаа 623 номоор 1547 уншигчдад нийт 1298 номоор 3774 уншигдыг хамарсан байна.

Үзүүлэлт	2013 он	2014 он	Хувь
Хэдэн удаа	17	20	117.6
Номын тоо	755	1298	171.9
Уншигчдад	2219	3774	170.0

Хэнтий, Өндөрхаан ТҮ-үүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, шинэ номын худалдаа, шинэ номын үзэсгэлэн худалдаа болон номын сангаас зохион байгуулсан соёл мэдээллийн ажлыг сар бүр сурталчилан ажиллаж байна.

2014 онд шинээр ирсэн ном хэвлэлийг интернэт, пэйсбүүк ашиглан сурталчилж ажилласанаас гадна Дадал суманд зохион байгуулагдсан "Алтаргана" наадмын үеэр МУ-ын зохиолчдын эвлэлийн гишүүн яруу найрагч Б. Энхжаргалтай хамтран Хэнтий нутгийн яруу найрагчдын номын үзэсгэлэнг гаргаж бусад орны зохиолчдод суртачилсан.

Шинэ ном хэвлэлийг сурталчлах ажлын хүрээнд Хэнтий ТҮ-ийн “Утга зохиол”-ын цаг нэвтрүүлгээр Л. Сарантуяагийн “Өв залгамжлагч” номын тухай идэвхтэн уншигч Алтансарнай уншсан ном зохиолын сэтгэгдлээ уншигч иргэдэд ярьж номыг сурталчилсан.
Шинэ номыг суртачлах ажлын хүрээнд “Бид Хан Хэнтийн ирээдүйн манлайлагч эмэгтэйчүүд” охидын клуб, Номонд дурлагсадын клубынхэн уншсан зохиол бүтээлээ бусдадаа ярьж, суртачилж байна.
Хэнтий ТҮ-ийн Уран зохиолын цаг нэвтрүүлэгт Хэнтий нутгийн зохиолчид МЗЭ-ийн шагналт Л. Нямаа, Д. Гансүрэн, Б. Энхжаргал, А. Түмэнбаяр нарыг оролцуулж шинээр эрхлэн гаргасан номуудын тухай ярилцлага хийсэн.
Хэнтий аймгийн Засаг даргын захирамжаар “АЛТАРГАНА-2014” олон улсын наадмын урлагийн номинац болох “ҮЛГЭРЧ, ТУУЛЬЧ, ЕРӨӨЛЧ, МАГТААЛЧИД”, “БУРИАДЫН ЯРУУ НАЙРАГ” уралдааныг зохион байгуулахаар Нийтийн Номын сангийн Г.Алтанцэцэг захиралтай хамт олон болон Баян-Адарга сумын Соёлын төвийн Эрхлэгч Д. Баатарцогт, хөгжмийн багш Алтанцэцэг, Бужгийн багш Алтангэрэл нар томилогдон ажиллаа.

Хэнтий аймгийн төрийн соёрхолт яруу найрагч Р.Чойномын нэрэмжит нийтийн номын сангийн түүхт 70 жилийн ойгоор аймгийн төв болон 18 сумын дунд 5-р сараас эхлэн 9-р сарын 10-ны хооронд “Шилдэг номын сантай айл өрх шалгаруулах”, “Шилдэг баримтад өвийг хадгалагч”, “Шилдэг ховор, үнэт ном”, “Шилдэг уншигч”, “Шилдэг уншигч албан байгууллага”хамт олон, “Шилдэг уншигч гэр бүл” ЕБС-ийн сурагчдын дунд “Нацагдорж тэмдэгтэн”шалгаруулах уралдааныг зарласан.

Манай байгууллагын 70 жилийн ойн арга хэмжээнд ССАЖЯамны соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б. Баяраа, МУ-ын Боловсролын их сургуулийн номын сангийн захирал Ж. Баатарсүрэн, Үндэсний номын сангийн мэдээлэл аргазүй эрдэм шинжилгээний хэлтсийн ахлах арга зүйч Г. Гүнжинлхам, ”, Хүүхдийн номын ордоны аж ахуйн хэлтсийн дарга С. Тунгалаг, Үндэсний номын сангийн захирал Нансалмаа, фонд бүрдүүлэлтийн хэлтсийн дарга Б. Цогжаргал, Р. Чойномын өвийг хамгаалах өд сангийн тэргүүн Д. Ганболд, Монголын Зохиолчдын Эвлэлийн болон Р. Чойномын шагналт, Оны шилдэг бүтээлийн “Алтан-Өд” шагналт Жигжидсүрэнгийн Нэргүй, Чойномын гэр музейн эрхлэгч Мишиг, МЗЭ-ийн шагналт зохиолч Л. Нямаа, Д. Гансүрэн, Б. Энхжаргал, А. Түмэнбаяр, Ж. Батцэцэг зэрэг зохиолчид, номын сангийн үе үеийн захирлууд,ахмад номын санч, соёлын төвийн эрхлэгч, номын санч нар оролцлоо.

Зохиолч уншигчдын уулзалт

2014 оны шилдэг номын санч Ц. Батчулуун

Сонин содон баримт цуглуулагч Ж. Даваасүрэн

Зохион байгуулсан соёл олон нийтийн ажил

1. “Номонд дурлагсдын клуб”

2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ном унших дуртай 14 төрийн байгууллагын 26 уншигчдаас бүрдсэн “Номонд дурлагсадын клуб”–ыг байгуулж, Аймгийн ИТХурлын ажилтан С. Бат-Эрдэнэ тэргүүлэгчээр сонгогдлоо. “Номонд дурлагсадын клуб”-ын гишүүд 3 баг болон аймгийн иргэдийг номонд дуртай болгох, ном уншиж мэдлэг, сэтгэл, оюуны цараагаа тэлдэг, номыг сэтгэлээсээ хайрлан уншдаг, ном уншсан сэтгэгдлээсээ бусадтай хуваалцах хүсэлтэй ном уншигч иргэдийг нэгтгэх, танилцуулах, номын ертөнцөөр аялах, хүүхэд залуусд ном уншихын ач тусыг ойлгуулахаар нэгдлээ. Клубын 26 гишүүн, өөрөө хэрхэн ном уншиж эхэлсэн, хамгийн сүүлдшсан номынхоо сэтгэгдлийг бусадтайгаа хуваалцаж, цаашид илүү ихийг уншихыг хүсэж байгаагаа бусадтайгаа хуваалцсан сайхан ажил боллоо

2. Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт

Аймгийн “Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-ыг 2014 оны 06 дугаар сарын 09-ны өдөр аймгийн төв Чингис хотод амжилттай зохион байгуулж, 18 сум, 4 тосгоны 275 малчин эмэгтэйчүүдийн төлөөллийг хамруулллаа. Уг чуулга уулзалтыг манай номын сан хамтран зохион байгуулж, уран бичлэгийн үзэсгэлэн, шинэ номын үзэсгэлэн худалдаа, эмэгтэйчүүдэд зориулсан гарын авлагаар мэдээлэл хийж түгээсэн бөгөөд онч мэргэн үгсээр оюуны чихэр хийж, 4 азтанг шагнаж урамшууллаа. Алслагдсан сум суурин отрын малчдад нүүдлийн номын сангаар үйлчлэн ажилладаг бөгөөд малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үеэр Норовлин сумын уншигч Г. Бурмаа “Тэргүүний уншигч Д. Нацагдорж” тэмдэгтэнээр шагнагдлаа.

3. “Ээжийн бүүвэйтэй хорвоо” хүүхдийн яруу найргийн наадам

“Ээжийн бүүвэйтэй хорвоо” яруу найргийн наадмыг 2014 оны 05-р сарын 30-нд Нутгийн зохиолч Баавайтай хамтран зохион байгууллаа. Уг тэмцээнд 6-11-р ангийн сурагчид оролцсон бөгөөд тэмцээний тэргүүн байрын шагналд Тэмүүжин цогцолбор сургуулийн Г. Хулан, 2-р байр Хан Хэнтий цогцолбор сургуулийн Номин-Эрдэнэ, 3-р байрыг Хэрлэн 4-р сургуулийн Чаминцэцэг, 4-р байрыг Хан Хэнтий цогцолбор сургуулийн Нямсүрэн, 5-р байрыг Хэрлэн 4-р сургуулийн Эрдэнэцэцэг нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

4. “Бүгдээрээ уншицгаая” Номын аян

“Бүгдээрээ уншицгаая” аяны хүрээнд Аймгийн ЗДТГ, Боловсролын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн ажлын алба, Нийгмийн Хөгжлийн хэлтэс, Зам засварын “Харгүй” ХХК, Өндөрхаан ТҮ, Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагуудад 21 номыг хүргэхдээ тухайн байгууллагын урьчилсан санал, номын захиалгыг авч 21 хоногийн хугацаатай аялуулан уншуулж, уншсан номын тэмдэглэл, номын сангийн үйл ажиллагааны талаар санал сэтгэгдлийг аван ажиллаж байна. Энэхүү аяны хүрээнд 8 байгууллагад 280 гаруй ном хэвлэлийг уншуулж уншигчдын тоог нэмэгдүүлэн ажиллаж байна.

“Архигүй Хан Хэнтийд номын сангийн оролцоо”:

5. **“Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдаан /”Архигүй Хэнтий” хөтөлбөрийн хүрээнд/**

Хэрлэн сумын ИТХурал, Өндөрхаан ТҮ-тэй хамтран “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдааныг насанд хүрэгчид болон хүүхдийн 2 насны ангилалаар зохион байгуулж нийт 229 захидал ирүүлсэнээс нас насны ангилалд эхний 3 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, ээжүүдэд нь бэлэг барьж телевизийн нэвтрүүлэг хийсэн.

6. **“Аавдаа захидал бичээрэй” Захидлын уралдаан /Архигүй Хэнтий хөтөлбөрийн хүрээнд/**

Зэвсэгт хүчний 93 жилийн ойг тохиолдуулан “Аавдаа захидал бичээрэй” уралдааныг насанд хүрэгчид, ЕБСургуулийн ахлах болон дунд гэсэн насны ангилалаар зохион байгуулж нийт 333 захидал хүлээн авч шалгаруулснаар Насанд хүрэгчдийн ангилалд 1-р байр 3-р багийн иргэн Ц. Долгормаа, 2-р байр 5-р багийн иргэн Отгонбаяр, 3-р байр АДБ-ийн Хан Хэнтий чуулгын хөгжимчин Батзаяа, 7-9-р ангийн ангилалд 1-р байрыг 1-р сургуулийн Мөнхбаатар, 2-р байр Хан Хэнтий цогцолбор сургууль С. Мөнхцэцэг, 3-р байр Э. Анхзаяа, 10-11-р ангийн сурагчдаас1-р байр М. Тамир, 2-р байр 4-р сургуулийн Г. Болортунгалаг, 3-р байр О. Чулуунчимэг нар шалгарч, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

7. **“Гэгээн хүсэл” уран уншлагын уралдаан /Архигүй Хэнтий хөтөлбөрийн хүрээнд/**

Архигүй Хэнтийчүүд хөтөлбөрийн хүрээнд “Гэгээн хүсэл-2014” уран уншлагын тэмцээнийг 5-6 ангийн төрөлд нийт 30 хүүхэд, 7-8-р ангийн төрөлд нийт 25 хүүхэд өрсөлдөж “Маргааш орой эрүүл ирээрэй”, “Ээждээ би согтуу очихгүй”, “Хүүдээ унших шүлэг”-үүдээр уран уншлага явуулж, хүмүүсд архины хор хөнөөлийн талаар болон хүүхдүүдийн хүсэл сонирхлыг илэрхийлсэн ажил зохион байгууллаа.

“Гэгээн хүсэл-2014” уран уншлагын тэмцээнд Хэрлэнгийн цэнхэр алс ТББ-ын тэргүүн Л. Энхбаатар, багш Б. Цогтбаяр болон архинаас татгалзаж амьдралаа өөрчлөн яваа 18 хүмүүс оролцлоо. “Гэгээн хүсэл-2014” уран уншлагын тэмцээнд 2 насны ангилал тус бүрээс 5 хүүхдийг өргөмжлөл үнэ мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Зохион байгуулсан ажлынхаа үеэр “Архи тамхи шинэ үеийнхний сонголт биш”, Архи удамд хортой” гэх зэрэг мэдээлэлүүдийг боршур хэлбэрээр гаргаж, нийт ирсэн уншигч иргэдэд архи тамхины хор хөнөөлийн талаар ухуулга сурталчилгаа хийн ажиллаж байна.

8. “Архи бидний амьдралд” гар зургийн уралдаан

ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Архи бидний амьдралд” сэдэвт гар зургийн уралдаан зарлаж, нийт 60 бүтээл ирсэнээс Тэмүүжин цогцолбор сургуулийн 11б ангийн сурагч Э. Оюунтунгалаг тэргүүн байр, ЕБ-ын 1-р сургуулийн 11в ангийн сурагч Х. Уугантөгс дэд байр, Хан Хэнтий цогцолбор сургуулийн 9а ангийн сурагч С. Энхбаяр гутгаар баярыг эзэлж мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Уг шагналыг Хэрлэнгийн цэнхэр алс ТББ, Солонго худалдааны төв

болон манай байгууллага ивээн тэтгэж оролцсон.

9. “Зорилтот бүлэг”-ийн хүүхдүүдэд хандсан хандлага

Цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 5-6 насны гэрээр хүмүүжигч 25 хүүхдүүдийг хамруулан, СӨБ-ыг бага ч гэсэн эзэмшүүлэх зорилгоор гар дасгал болох бичих, зурах, тоглох, гэрийн даалгавар болгох зүйр үг, оньсого, шүлэг, жороо үг, түргэн хэллэг цээжлүүлэх үйл ажиллагаатай 2013 оны 12-р сарын 20-ноос эхлэн 2014 оны 1-5 сарын хооронд Баасан гариг болгоны 14-17 цагийн хооронд Хүүхдийн танхимд хичээллэж байна.

Хамрагдсан хүүхдийн хичээлийн хэрэгсэл, чөлөөт цагийн зөв боловсон өнгөрөөх оюуны тоглоомнууд, шинэ жилийн баяртай холбогдуулан, хүүхэд бүрийн бэлгийг ДЗОУБ 361150 төгрөгийн материалаар ивээн тэтгэж оролцож байна.

10. “Оюухай” яруу найргийн наадам

“Оюухай 2014”наадам 2014.06.14-16 хооронд өөрийн төрсөн нутаг болох Дархан суманд зохион байгуулагдлаа. Нийт 90 зохиолчын 300-аад бүтээлээс 2-р шатанд 32 зохиолч өрсөлдлөө. “Оюухай 2014” наадамд Р.Чойном агсаны дотны найзууд болох Ш.Дулмаа, Д.Цоодол тэргүүтэй зохиолчид оролцлоо. Төрийн соёрхолт яруу найрагч Р. Чойномын нэрэмжит Хэнтий аймгийн нийтийн номын хамт олон “Хан Хэнтийн зохиолчид” номын үзэсгэлэн, “Шинэ номын үзэсгэлэн худалдаа” ажилуулсан.Наадмын үеэр Батноров сумын харъяат залуу яруу найрагч Б. Алтанхуягт номын сангийн нэрэмжит шагналыг гардуулсан.

11. Сумдын соёлын төвийн номын сангуудыг мэргэжил арга зүйгээр хангах хүрээнд:

2014 оны 01-р сарын 08-наас 01-р сарын 10-ны хооронд Баянхутаг, Галшар, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх сумд, 2014 оны 01-р сарын 14-нөөс 01-р сарын 18-ны хооронд Бэрх, Батноров, Норовлин, Баян-Адрага, Дадал, Биндэр, Батширээт сумдын Соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь үчиж танилцаж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа. Сумдын номын санчдын тайланг сар бүр авч тэдний ажил үйлчилгээнд дүгнэлт хийх, тайланг дэлгэн танилцуулах, Монбиблио програмын үйл ажиллагааг эрчимжүүлэх түүнд нь хяналт тавих, шинэ шинэлэг ажлуудыг тусган ажилуулахаар болсон ба одоогийн байдлаар 22 сумын номын санчдын 11 сарын 220 гаруй тайлан ирээд байна.



Нийтийн номын сангийн 70 жилийн ойн хүрээнд:

12. “Эрдэм шинжилгээний бага хурал”

Хан Хэнтий нутагт номын өргөө байгуулагдсаны түүхт 70 жилийн ой, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” зарлигийн хүрээнд ***“Нийгэм дэх номын сангийн оролцоо”*** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа.

Хуралд ССАЖ Яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Бат-Эрдэнийн Баяраа
“Номын сан ба хөгжил”
Урлагийн гавьяат зүтгэлтэн Балжиннямын Дуламжав
“Нийгэмд номын сангийн оролцоо”
Монгол Улсын Боловсролын их сургуулийн номын сангийн захирал магистр Ж. Баатарсүрэн
“Монголын номын сангуудын хөгжлийн чиг хандлага, хамтын ажиллагаа”
Монголын Үндэсний номын сангийн Мэдээлэл арга зүй эрдэм шинжилгээний хэлтсийн ахлах арга зүйч магистр Г. Гүнжинлхам
“Монголын Үндэсний номын сан мэргэжил аргазүйн төв болох нь”
Хүүхдийн номын ордоны захиргаа аж ахуйн хэлтсийн дарга магистр С.Тунгалаг
“Хүүхдийн уншлагыг удирдах нь” сэдвээр илтгэл тавилаа

Эрдэм шинжилгээний хуралд 5 хүн илтгэл тавьж, төгсгөлд нь хэлэлцүүлэг өрнүүлж дурсгалын зураг татууллаа.

13. Р.Чойномын “Өд” сантай хамтран 70 жилийн ойд

Монгол улсын төрийн шагналт Ринчиний Чойномын намтар, уран бүтээлийн гэр музейг анх удаа аймгийн төвд нийтийн номын сангийн 70 жилийн ойд зориулагдан иргэд уншигч, олон нийтэд тавигдлаа. Монгол улсын төрийн шагналт Ринчиний Чойномын уран бүтээлийн үзэсгэлэн анх удаа гарч байгаа гэдгээрээ онцлог байж улаан тууз хайчлан үзэсгэлэнг нээлээ. Нээлтэнд Аймгийн Нийтийн номын сангийн захирал Г.Алтанцэцэг, ССАЖЯамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Баяраа, Ринчиний Чойномын өвийг хамгаалах Өд сангийн тэргүүн Д.Ганболд, МЗЭ-ийн шагналт яруу найрагч, орчуулагч, Төрийн хэлний зөвлөлийн албаны дарга Ж.Нэргүй, Чойномын гэр музейн эрхлэгч Боловсролын тэргүүний ажилтан Ч.Мишиг нар байлаа. Намтар

уран бүтээлийн үзэсгэлэнд Р.Чойномын 80 гаруй бүтээл тавигдсан ба яруу найрагчийн өөрийн зурсан хөрөг зургууд болон фото зургууд байлаа. Монгол улсын төрийн шагналт Ринчиний Чойномын намтар уран бүтээлийн талаар Чойномын өвийг хамгаалах Өд сангийн тэргүүн Д.Ганболд, Гэр музейг хариуцагч Ч.Мишиг, МЗЭ-ийн болон Чойномын шагналт, оны шилдэг бүтээлийн Алтан өд шагналт Яруу найрагч, орчуулагч Ж.Нэргүй нар танилцууллаа. Мөн яруу найрагчийн тухай Гэрээслэл буюу Чойномын нүүрний хэв баримтат киног толилууллаа. Хан хэнтийн зохиолчид уншигчидтай уулзалт хийлээ

Хэнтий аймгийн төрийн соёрхолт яруу найрагч Р.Чойномын нэрэмжит нийтийн номын сангийн түүхт 70 жилийн ойгоор аймгийн төв болон 18 сумын дунд 5-р сараас эхлэн 9-р сарын 10-ны хооронд “Шилдэг номын сантай айл өрх шалгаруулах”, “Шилдэг баримтад өвийг хадгалагч”, “Шилдэг ховор, үнэт ном”, “Шилдэг уншигч”, “Шилдэг уншигч албан байгууллага”хамт олон, “Шилдэг уншигч гэр бүл” ЕБС-ийн сурагчдын дунд “Нацагдорж тэмдэгтэн”шалгаруулах уралдааныг зарласан.

Манай байгууллагын 70 жилийн ойн арга хэмжээнд ССАЖЯамны соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б. Баяраа, МУ-ын Боловсролын их сургуулийн номын сангийн захирал Ж. Баатарсүрэн, Үндэсний номын сангийн мэдээлэл аргазүй эрдэм шинжилгээний хэлтсийн ахлах арга зүйч Г. Гүнжинлхам, ”, Хүүхдийн номын ордоны аж ахуйн хэлтсийн дарга С. Тунгалаг, Үндэсний номын сангийн захирал Нансалмаа, фонд бүрдүүлэлтийн хэлтсийн дарга Б. Цогжаргал, Р. Чойномын өвийг хамгаалах өд сангийн тэргүүн Д. Ганболд, Монголын Зохиолчдын Эвлэлийн болон Р. Чойномын шагналт,
Оны шилдэг бүтээлийн “Алтан-Өд” шагналт Жигжидсүрэнгийн Нэргүй, Чойномын гэр музейн эрхлэгч Мишиг, МЗЭ-ийн шагналт зохиолч Л. Нямаа, Д. Гансүрэн, Б. Энхжаргал, А. Түмэнбаяр, Ж. Батцэцэг зэрэг зохиолчид, номын сангийн үе үеийн захирлууд,ахмад номын санч, соёлын төвийн эрхлэгч, номын санч нар оролцлоо.

Зохиолч уншигчдын уулзалт

2014оны шилдэг номын санч Ц. Батчулуун

Сонин содон баримт цуглуулагч Ж. Даваасүрэн

“Бид Хан Хэнтийн ирээдүйн манлайлагч эмэгтэйчүүд” дугуйлан зохион байгуулах удирдамж боловсруулан, 4 сургуулийн 50 гаруй хүүхэд хамрагдсан. бөгөөд “Манлайлагч эмэгтэйчүүд” төрийн бус байгууллагын нээлтэнд оролцсон. Дугуйлангийн хүүхдүүдэд Уламжлалт анагаар ухааны төвийн дарга М. Ариунаа, захирал Г. Алтанцэцэг нар лекц уншиж, шилдэг манлай эмэгтэйчүүдийн амьдралын хэвшил, гоо сайханы талаар охидууд мэдээлэл хүргэж ажилласан.
Энэхүү дугуйлангаар шинэ номын танилцуулга хийх, номонд сэлбэн засалт хийх, дэлхийн суут удирдагч эмэгтэйчүүдийн намтар уран бүтээлийг уншиж бие биедээ лекц тавьжярианы чадвараа дээшлүүлэх, номын сангийн олон нийтийн ажилд туслах, эрүүл мэндийн зөвлөгөө авах зэрэг ажлуудыг хийж байна.
Манай байгууллага дугуйлан ажиллуулахаас гадна хөдөө сумдын номын сангуудын дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дугуйлан байгуулах талаар мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Бэрх сумын номын сангуудын дугуйлан сайн ажиллаж байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх ажлын хүрээнд, цэцэрлэгийн арга зүйч нартай уулзалт зохион байгуулан сургуулийн өмнөх боловсролд заавал зааж сургасан байх шаардлагатай сэдвүүдээр зохион байгуулсан бөгөөд 2015 онд хамтран ажиллах тухай ярилцлаа.
Энэ онд аймгийн төвийн 8 цэцэрлэгийн 215 хүүхэд номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, 15 анги урилгат уншлагад оролцож номын сангийн уншигч болсон байна.

Хэрлэн сумын соёлын төвд "Үлгэрийн баатрууд амилсан нь-2014" дүрийн тоглолтын уралдааныг зохион байгуулж нийт 6 цэцэрлэгийн 7 баг нийт 120 хүүхэд оролцсоноос Хэрлэн 7-р цэцэрлэгийн "Болдоггүй бор өвгөн" үлгэр 1-р байр,

Хэрлэн 4-р цэцэрлэгийн "Чоно ба долоон ишиг" үлгэр 2-р, 1-р цэцэрлэгийн "Хамартай бин" 3-р байруудыг эзэллээ. Шүүгчийн нэрэмжит шагналаар 5-р цэцэрлэгийн Г. Тэлмэн, 1-р цэцэрлэгийн М. Ирмүүнтөгөлдөр, Шилдэг эрэгтэй дүрээр 4-р цэцэрлэгийн М. Энхжин, Шилдэг эмэгтэй дүрээр 8-р цэцэрлэгийн Б. Эрдэнэчимэг, Шилдэг тайлбарлагчаар 7-р цэцэрлэг М. Нарангоо нар шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа. Энэхүү тэмцээнд оролцсон цэцэрлэгийн хүүхдүүдийн тоо, авьяас чадвар, уран хэллэг, жүжигчилэл зэрэг нь өмнөх оныхтой харьцуулахад эрс нэмэгдсэн байна. Үүнээс гадна цэцэрлэгийн танилцуулах, номонд дуртай болгох, ном унших сонирхолыг нэмэгдүүлсэн ажил

“2020- Номын сан” сэдэвт хэлэлцүүлэгийг ЕБСургуулийн 9-12-р ангийн сурагчдын дунд зохион явуулж, нийт хэлэлцүүлэгт 18 сурагчид оролцож, өөрсдийн санаа, санаачлага, хүсэл мөрөөдлөө илтгэлдээ тусгасан байна.
Хэлэлцүүлэгт ЕБСургуулийн 1-р сургуулийн 12 ангийн сурагч Б. Хулан, 10-р ангийн сурагч Т. Ханцэцэг, Ундармаа, Тэмүүжин цогцолбор сургуулийн 11-р ангийн сурагч Түмэнбаяр, 11-р ангийн Г. Хулан нарын илтгэлийг шалгаруулж, хэлэлцүүлэгээ явууллаа. Энэхүү хэлэлцүүлгээр
-Хүүхдийн номын ордонтой болох,
-Байгууллагын гадна талбайд Чойномын хөшөөг босгох,
-Уншигчдад үйлчлэх тохилог орчин бүрдүүлэх / дулаан/
-Гаднах талбайг цэцэрлэгжүүлэх
-Шүлгийн уралдаан, гар зургийн уралдаан, номын тэмдэглэл хөтлөх
-Монгол бичгээр хэрхэн зөв бичих уралдаан
- Номын тухай мэдээллийг хүүхдэд хүүхдүүдээр нь дамжуулах зэрэг саналуудыг хэлэлцүүлэгт тусгасан байна.

14. **“Сумдын соёлын төвийн номын санчдын ажил мэргэжлийн өдөрлөг”**

Сумдын Соёлын төвийн номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, номын сангийн үйлчилгээг автоматжуулах, монбиблио програмын үйл ажиллагааг эрчимжүүлэх, номын санч мэргэжилтэнгүүдийг чадавхжуулах зорилгоор “Номын санчдын Ажил мэргэжлийн өдөрлөг” 2014 оны 11-р сарын 14-17ны хооронд Нийтийн номын санд амжилттай болж өндөрлөө. Уг өдөрлөгт сумдын соёлын төвийн 15 Номын санчид дөрвөн баг болж идэвхтэй сайн оролцлоо. Номын санчид Мэргэжлийн онцлогоо харуулсан мэндчилгээгээр эхэлсэн ба номын санд хөтлөгддөг бүртгэлүүд /нэгдсэн бүртгэл, нэг бүрчилсэн бүртгэл, өдөр тутмын бүртгэл/, Номын сангийн ББК ангилалаар ном ангилах, Номын сангийн каталоги зохион байгуулалтыг багаараа хамтарч ажилсан бол Монбиблио програмд багийн гишүүд тус бүртээ програмд ном оруулах ажлуудыг минутын дагуу хийж гүйцэтгэлээ. Хамгийн шийдвэрлэх дүнг багуудын хооронд тавигдсан мэргэжлийн холбогдолтой асуулт хариултын тэмцээн байлаа.

Тэргүүн байранд “Номч мэргэн” баг

Багийн ахлагч: М.Заурыш /Өлзийт сумын номын санч/
Гишүүд: Н.Энхтунгалаг /Жаргалтхаан номын санч/
Д.Шинэтуяа /Өмнөдэлгэр номын санч/ Дэд байранд Багийн ахлагч:
Ч.Дэлгэрсүрэн /Баянмөнх номын санч Гишүүд: Ц.Батчулуун /Дархан сумын номын санч/ Д.Пүрэвдолгор /Баянхутаг сумын номын санч/
Я.Энхцэцэг /Мөрөн сумын номын санч/
Сумдын Соёлын төвийн номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, номын сангийн үйлчилгээг автоматжуулах, монбиблио програмын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор төлөвлөгөөт сургалтын үйл ажиллагааг зохион явууллаа.



“Зүүн бүсийн номын санчдын Ажил мэргэжлийн өдөрлөг”
Зүүн бүсийн номын санчдын “Ажил мэргэжлийн өдөрлөг” 2014 оны 05-р сарын 15-20-ны хооронд Дорнод аймагт зохион байгуулагдлаа. Уг ажил мэргэжлийн өдөрлөгт Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын номын санчид оролцож, ур чадварын тэмцээн, волейбол, ширээний теннисний тэмцээн зохион байгууллаа.

Зүүн бүсийн номын санчдын өдөрлөг нь мэдлэг чадвартай хүний нөөц бий болгох, хамтын ажиллагааг сайжруулах, чадварлаг бүтээлч хамт олон бүрдүүлэх, харилцан ажлын туршлага солилцох, шинэлэг санааг дэвшүүлэх, мэргэжилтэнүүдийг чадавхжуулах зорилготой зохион байгуулагдлаа.
Манай аймгийн төвийн номын сангийн Номын санч Ц.Одонтуяа, Т.Отгонтуяа, Э.Цэрэн-Од, Баянмөнх сумын соёлын төвийн номын санч Ч.Дэлгэрсүрэн, Цэнхэрмандал сумын соёлын төвийн номын санч Л.Энхнас, Баян-Адарга сумын соёлын төвийн номын санч Л.Янжиндулам, Дадал сумын ЕБ Сургуулийн номын санч Б.Сансархүү нар оролцлоо.

Зүүн бүсийн номын санчдын өдөрлөгт Үндэсний номын сангийн каталогич Б. Цогжаргал, номын сан номзүйн ангилалын ахлах ангилагч Ц. Гантулга, арга зүйч Сарандэлгэр, ЮНЕСКО-ийн танхимын номын санч Өлзий зэрэг 9 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож, “ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн олон улсын баримтат, Монгол улсын хосгүй үнэт өвүүд”, “Монгол Улсын үндэсний баримтат 108 өв” сэдвээр номын үзэсгэлэн гаргасан.

“Хан Хэнтийн зохиолчид” номын үзэсгэлэнг 59 номооор гаргасан.

“Монгол бичиг, уран бичлэгийн гайхамшиг” үзүүлбэр тоглолтыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шинэ барга хошууны Уран бичлэгийн нийгэмлэгийн гишүүд ирж, уншигч, номын санчдад монгол бичгээр уран бичлэг хийж хадгалуулж байлаа.

Зүүн бүсийн номын санчдын өдөрлөгийн үеэр Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн төвийн болон сумын номын санчдад Үндэсний номын сангийн арга зүйч Сарандалгэр “Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөгдөж байгаа стандартын эмхэлтгэл”-ээс 2012 онд Үндэсний номын сангийн хэлтсийн дарга Д. Энхтунгалаг тэргүүтэй ажлын хэсэг шинэчлэн боловсруулж, Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор баталсан

“НОМ ЗҮЙН БИЧИЛТ” MNS 5271:2012 стандартыг талаар сургалт явуулсанаас гадна Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангийн захирал Энэбиш мэдээллийн хэрэгсэл facebook-ыг ашиглан номын сангаа сурталчилсан талаар, Хэнтий аймгийн нийтийн номын сангийн захирал Г. Алтанцэцэг өөрийн байгууллагаас зохион явуулсан соёл танин мэдэхүйн ажил “Аавдаа захидал бичээрэй”, “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг хэрхэн явуулах, цаашид аймгийнхаа нийт иргэдийг хэрхэн хамруулж болох талаар туршлагаа хуваалцлаа.

Мэргэжлийн ур чадварын тэмцээнд: Хэнтий аймгийн нийтийн номын сангийн “Оюуны ундарга” баг, сумдын номын сангуудын “Эрдмийн хөтөч” баг нийт 7 баг ур чадварын тэмцээнд оролцсоноос Аймгийн нийтийн номын сангийн “Оюуны ундарга” баг ТЭРГҮҮН БАЙР эзэллээ.

Багууд өөрийн нэртэй байх бөгөөд нэрний утга санааг илэрхийлсэн эмблем жигд хувцасласан байх ёстой бөгөөд бусад багууддаа мэндчилгээ дэвшүүлсэн
Мэргэжлийн талаасаа номын санд хөтлөгддөг бүртгэл, номын сангийн ангилал, номын сангийн LiB4U цахим програм дээр ажиллах, номын сангийн каталоги зохион байгуулалт, ном зүйн бичилтийг минутаар гүйцэтгэж оноогоор дүгнэсэн
Мөн багууд хоорондоо мэргэжлийн асуулт тавьж хариулсан баг бүрт оноо өгөх замаар явуулсан.
Мэргэжлийн ур чадварын тэмцээний нэг хэсэг жүжигчилсэн тоглолтын хэсэгт мэргэжлийн онцлогийг харуулсан, шинэлэг санаа, асуудал дэвшүүлсэн байх хэсэгт манай “Оюуны ундарга” багийнхан Аймгийнхаа номын санд нээгдээд байгаа “Номонд дурлагсадын клуб”, номын сангаар үйлчлүүлэх эрх “Алтан карт”-ны тухай оруулж олны талархалыг хүлээсэн билээ.

Нийт 7 баг мэргэжлийн ур чадварын тэмцээнд оролцсоноос
“Тэргүүн байр” Хэнтий аймгийн нийтийн номын сангийн “Оюуны ундарга” баг

Гар бөмбөг, ширээний теннисний тэмцээнд:
Ширээний теннисний тэмцээнд
Хэнтий аймгийн “Оюуны ундарга” багийн ахлагч Г. Алтанцэцэг “ТЭРГҮҮН БАЙР”, багийн гишүүн Ц. Одонтуяа “ДЭД БАЙР”-уудыг эзэлж оролцлоо.

Хөрөнгө оруулалт

ССАЖ Яамнаас “Шилдэг ном 2013”-т шалгарсан 154 ширхэг 957,4 мянган төгрөгийн номыг 22 сумын номын санд хувиарласан /1 суманд 7 ширхэг 67200 мянган төгрөгийн ном/

ССАЖ Яамнаас 2014 онд аймгийн төвийн болон хөдөөгийн 11 суманд номын тавиур 33ширхэг, каталогийн шүүгээ 12 ширхэг, тогтмол хэвлэлийн тавиур 12 ширхэг, нийт 40,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж /1 суманд 3497,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж/, аймгийн нийтийн номын санд соронзон хаалга, ном уншигч, ресепшиний ширээ, номын ялтас зэрэг 5506,5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар олгосон байна.